

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
БАГШИЙН СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ, НИЙГМИЙН УХААНЫ ТЭНХИМ

Хүүхдийн уран зохиолын унших бичиг

(Багшийн сургуулийн ХУЗ хичээлийг судалж буй оюутнуудад
зориулав.)

Багш, бага ангийн боловсрол хөтөлбөрийн мэргэжлийн
заавал судлах хичээл.

2020 он

ННА 82,3 (5Мон)
ДАА 398,27
А-515

Хүүхдийн уран зохиолын унших бичиг

Эмхэтгэсэн: А.Амардалай, Б.Нанжид, О.Сундуй
(МУБИС-ийн Багшийн сургуулийн багш нар)
Хянан тохиолдуулсан: Г.Бямбацэрэн доктор, дэд профессор
Д.Хүү судлаач, шүүмжлэгч
Н.Даваасүрэн БС -ийн Монгол хэл, нийгмийн ухааны тэнхимийн багш
Дизайнер: Ч. Майдар
Хэвлэлийн хуудас: 20.5

ISBN:78-99978-1-813-3

“Тоонотпринт” ХХК-д хэвлэв.
Утас: 70187616, 99093235
И-мэйл:

.

Ном нээх үг

Өнөөдрийн оюутнууд бол маргаашийн сэхээтэн багш нар төдийгүй ирээдүйн ээж аавууд билээ. Тиймээс тэдэнд шавь нартаа, үр хүүхдэдээ хүүхдэд зориулсан хамгийн шилдэг уран зохиолыг сонгон уншуулах хэрэгцээ зайлшгүй тулгарна. Тийм ч учраас бид уран зохиолын уран дүр, дүрслэл, зохиомжийн талаар ярилцаж, хэлэлцэж зохиол бүтээлийн утгын болоод дүрслэлийн нууцад нэвтрэхийг хичээдэг билээ.

Энэ талаар оюутнууд зөвхөн онолын мэдлэгтэй байх нь хангалттай биш бөгөөд хамгийн шилдэг зохиолуудыг сонгон унших хэрэгтэй болно. Бид тийм эрэлт хэрэгцээний улмаас “ХҮҮХДИЙН УРАН ЗОХИОЛЫН УНШИХ БИЧИГ”-ийг толилуулж байна. Учир нь бидний уншуулахыг хүссэн зохиолууд тийм ч амар олдохгүй. Олдлоо ч бүгдээрээ нэгэн хавтсанд яахан манцуйлагдсан байхах билээ. Иймийн тул сургалтанд зориулан “ХҮҮХДИЙН УРАН ЗОХИОЛЫН УНШИХ БИЧИГ”-ийг бүтээх нь нь зүйтэй хэмээн үзлээ.

Энэхүү “ХҮҮХДИЙН УРАН ЗОХИОЛЫН УНШИХ БИЧИГ” маань:

-Монголын эртний уран зохиол

-Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол:

А. Шүлэг

В. Өгүүллэг

С. Тууж гэсэн агуулгатай юм. Уншигчид дээрх агуулгаар Монголын эртний уран зохиолоос хүүхдийн уншлагад хамааралтай бүтээлүүдийг унших болно. Мөн шинэ үеийн уран зохиолын эхэн үеэс өнөөдрийг хүртэлх хүүхдэд зориулсан зохиолуудаас агуулгын ач холбогдол, уран дүр , дүрслэлээрээ хамгийн шилдгийг нь сонгон эмхэтгэхийг эрмэлзсэн юм. Та бүхний таалал орших болтугай.

Эмхэтгэгчид

2020 он. Урвуулагч хэмээх шороон гахай жилийн өвлийн дунд сар

Редакторын үг

Хүүхдийг балчир багад нь “бүүвэйн дуу” –г сонсгож, мэдээ сууж үг хэлж, ярих үед нь үлгэр, оньсого болон ардын аман зохиолын жижиг төрөл зүйлийн зохиолууд хэлж, сонсгох зэргээр эцэг эх, гэр бүлийн хүрээнд хөгжүүлдэг аман уншлагын эртний уламжлалтай ард түмэн юм.

Тийм жишээний нэг нь “Монголын нууц товчоо” болно. Уг ном бүтэц онцлогийн хувьд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч хамтран сууж уншдаг. Энэ “Уран зохиолын унших бичиг” –т сонгогдсон “Чингисийн есөн өрлөгтэй, өнчин хүүгийн цэцэлсэн шаштир” нэртэй зохиол бас холимог хамтын үйлдлээс нь, насанд хүрэгчид хийгээд, бага насны хүүхэд хэрхэн ялгарч байгааг ажиглаж болно.

Монголын эртний зохиолуудын нэг “Хар үхэрт хөвгүүний тууж” бол нэр болоод доторх дүр, дүрийн үйлдэл зэрэгт бага насны хүүхдийн оролцоо илүүтэй, тэд дангаараа уншиж сонирхож, хоорондоо ярих боломжтой. Тиймээс хамтран унших хэлбэртэй зохиол биш хүүхдийн унших ном зохиол тусдаа салж эхлэх үеийн зохиол юм.

Хүүхэд настны уншлагын онцлог бол тухайн уншсан эсвэл сонссоноороо шинэ мэдлэг бүтээж түүнийгээ бусад уншигч багачуудтай санал солилцож, ярилцах мэтгэх, маргаан өрнүүлдэг явдал болно. Жишээлбэл, Монгол ардын аман зохиолын шидэт үлгэрийн нэг “Эрхий мэргэн” –д гардаг “мэргэн харваач” олон нарыг харваж байгаа үйлдлийг тэдгээр оногдсон нар нэг бол газарт унасан эсвэл оногдсон нар нэгдэн нийлж томорсон гэх мэт олон тайлбарыг үүсгэнэ. Сургуулийн өмнөх, болон бага сургуулийн хүүхдүүд нь багш сурган хүмүүжүүлэгчдийн сургалтын хөтөлбөрт сонгосон ном зохиолыг уншиж, түүгээрээ хүүхдийн ном, хэвлэл, сурах бичигтэй ажиллах арга барил эзэмшдэг байна.

Сургалтын үндсэн хэрэглэгдэхүүний нэг нь орчин үед гадаадын болоод дотоодын зохиолчдын зохиол бүтээлүүдийн уран уншлага юм.

Сурагч Та нарын уншиж байгаа “Уран зохиолын унших бичиг” нэртэй энэ ном бол сургуулийн бага насныханд зориулсан тул хичээлийн үед эсвэл анги хүмүүжлийн ажлыг гадуур үргэлжлүүлэн чөлөөлт цагтаа уншихад туслах зорилготойгоор МУБИС –ийн Багшийн сургуулиас эмхэтгэсэн гарын авалга болно.

Унших бичигт бага сургуулийн сурагчдын хэл яриа, нас биеийн онцлогт тохируулан заасан уншлагын ажлын цөм хөтөлбөр болон сурагчдаас заавал унших ном, зохиолын бүртгэлд байгаа зохиолоос төрөл жанр, сэдэв онол түүхийн үечлэлийг илэрхийлсэн цөөн бүтээлийг сонгон оруулав.

Уншигч хүүхдүүдийн ухаан цэлмэг, хараа нь мэргэн байх болтугай.

Данзаннорвын Хүү

(МЗЭ –ийн болон МҮЭ –ийн шагналт судлаач шүүмлэгч МУБИС –ийн Багшийн сургуулийн ахлах багш профессор)

I бүлэг. Монголын эртний уран зохиол

Алан гоо эхийн домог

Хаврын нэгэн өдөр хонины хатсан мах чанаж Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буха хатаги, бухату салжи, Бодончар мунхаг таван хөвүүндээ идүүлээд тэднийг зэрэгцүүлэн суулгаж, хүн бүрд нэжээд мөс (сум буюу нарийн мод)-ийг хугал гэж өгвөл амархан хугачиж орхив. Бас таван мөсийг нийлүүлж баглаад хугал гэж өгвөл тавуулаа дараалан оролдож, хугалж чадсангүй.

Үүнд Алан гоо эх нь өгүүлрүүн: “Бэлгүнүтэй, Бүгүнүтэй та хоёр намайг энэ гурван хөвүүнийг яахин төрүүлэв, хэний хөвүүд бол гэж сэжиглэн хэлэлцэнэ. Сэжиглэх тань зөв.

Гэвч, та нар учрыг мэдэхгүй байн. Шөнө бүр цагаан шар хүн, гэрийн өрх тотгоор гийгүүлэн орж ирээд миний хэвлийг илэхэд, түүний гэрэл миний хэвэлд шингэх бүлгээ. Тэр хүн, гарах нар сарны хилээр шар нохой мэт шарвалзсаар гарч одно. Дэмий яахин өгүүлнэ та. Түүнээс үзвэл тэнгэрийн хөвүүд биз. Хар тэргүүт хүнтэй адилтгаж яахин болно. Хамгийн хаад болох цагт харц хүн сая учрыг мэднэ” гэв.

Бас Алан гоо таван хөвүүнээ сургаж өгүүрүүн: “Та таван хөвүүн, миний нэгэн хэвлээс төрсөн биш үү. Та нар ганц ганцаар салбал нэжээд сум мэт хүнд хялбархан дийлэгдэнэ. Та нар эв эеэ нэгтгэвэл тэр багласан таван сум мэт бэх болж, хэнд ч хялбар дийлэгдэхгүй болно” гэв. Тэгж байтал Алан гоо эх нь үгүй болов.

Асуулт даалгавар:

1. Монголын нууц товчоо зохиолын туурвил зүйн онцлогийг тодорхойлон бичнэ үү?
2. Алан гоо эхийн домгийн дүрүүдийн онцлогийг тодорхойлон бичнэ үү?

Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний цэцэлсэн шастир

Чингис хаан Хэрлэн мөрөнд нутаглаж бүхийд зуны тэргүүн сард түшмэддээ зарлиг болруун:

Манай Монголын тэжээсэн мал нь хэдэн зүйл буй боловч өшт дайсан лугаа байлдахад нөхрийн дээд, үлдэх дайсныг даруй түргэн гүйцэгч үл алдагч хавт баатруудын жигүүр, өсөх залуусын биеийн чимэг болсон эрдэнэ, морины шим сүүний дээжийг эрхт тэнгэр дэлхийд өргөн тахиад үүнээс эхлэн сайтар тогтоож бүрэн энэ Монгол улсад хууль болгосугай хэмээгээд, есөн өрлөг, таван тайж тэргүүлэн ер таван өнгө, дөрвөн харь улсаа хурааж, их хурим хийхэд суут богдод сүлдүсүний Сорхон шар хэлэв:

Дээд хаан эзэн минь айлдан соёрх

Дэлхий их хурал чуулганд

Унд дарс үгүй болбол

Үтэл цулгуй болмуй гэв.

Заяат эзнээ Сорхон шар өгүүлбэл, Жалайрын гоо Мухулай угтаж аваад хэлэв:

Барилдсан үгсийг минь байлгадаг бишүү

Бардам дээрэнгүй сэтгэлийг төрүүлдэг бишүү

Чуулсан үгсийг минь цуцалдаг бишүү

Олигт муу унд дарсыг тэвчвэл

Үг минь бэх бие минь сайн буй за гэв.

Цогт төрсөн богдод гоо Мухулай хэлбэл, Зүрчидийн Чуу мэргэн угтаж аваад хэлэв:

Санасан үгийг минь илрүүлдэг бишүү
Сайн муу хоёрыг минь мэдүүлдэг бишүү
Доторх үгсийг минь гаргадаг бишүү
Доор, дээр хоёрыг минь ялгадаг бишүү
Эртнээс нааш рашаан бишүү
Энэ ертөнцөд жаргал бишүү
Үүнээс хойш дургал бишүү
Эдүгээ үүнийг тэвчвэл

Энэ хурим цулгуй бишүү зөв буюу гэв.

Ачит төрсөн эзнээ Чуу мэргэн айлдвал, Арлудын хөлөг Боорчи угтаж аваад хэлэв:

Аманд орохдоо алтан шумуул мэт
Амнаас гарахдаа арслан, заан боссон мэт
Хэлэнд амсахад хэдгэнэ, шумуул мэт
Хэлнээс гарахад хэдэр заан боссон мэт
Оюун билиг хоёрыг минь мартуулдаг бишүү
Олсон зөөсөн хоёрыг минь баруулдаг бишүү
Биеийн сүлдийг минь бууруулдаг бишүү
Бэлхэн хэлэлцсэн үгсийг минь мартуулдаг бишүү
Сархдад бүү шамдан согтёё л
Сайн муу хоёрыг ялган хэлэлцье л
Архинд бүү амтшин согтёё л
Алив үйлсээ хэлэлцэн таръя л гэв.

Ухаант хаан эзнээ хөлөг Боорчи өгүүлбэл, Урианхайн Зэлмэ угтаж аваад хэлэв:

Бор дарсны зориг буюу
Богд эзний манай засаг үгүй буюу
Хар архины дур билүү
Хаан эзний манай цааз үгүй буюу
Унд дарсыг хураая л
Унага, даага мэт цэнгэе л
Урьд хожид согтёё л
Унатал бостол хэвтёе л
Архи дарсыг хураая л
Ангир, галуу мэт цэнгэе л
Амраг сайхан нөхдөө
Аван жаргая л

Алив хүслээ ханалцан тархъя л

Билигт төрсөн эзнээ Зэлмэ өгүүлбэл, Бэсүүдийн Зэв угтаж аваад хэлэв:

Унд дарс үгүй болбол ураг үгүй буюу
Учирсан энэ бие минь жаргал үгүй буюу
Архи үгүй бол амраг үгүй буюу
Амраглан суугч энэ бие минь жаргал үгүй буюу
Хар архийг тэвчье л

Хаан эзнийхээ өмнө зүтгэе л
Хас их төрийнхөө үйлийг зөвлөе л
Харшлах дайсны үйлийг батлая л гэв
Онц төрсөн эзнээ Зэв өгүүлбэл, Ойрадын Хар Хиру угтаж хэлэв:
Хурсан бүгд ууваас жаргал бишүү
Хол ойр сонсвол хүсэл бишүү
Амлан ядах үгэнд чимэг нэмдэг бишүү
Алалдах дайсанд зүрхийг минь хатгадаг бишүү
Богд эзний өмнө бор дарсыг хураагаад
Бага, ихгүй зэргээр ууж
Баясгалант их хүрийг үзье л гэв
Богд эзнээ Хар Хиру өгүүлбэл, Борохул угтаж аваад хэлэв:
Амраг нөхрөөс алгасуулдаг бишүү
Алиа муу сэтгэлийг төрүүлдэг бишүү
Ханилсан нөхрөөс хагацуулдаг бишүү
Харгис дээрэнгүй сэтгэлийг төрүүлдэг бишүү
Бор дарсны эрдэм минь ер чухаг биз
Буцаж эвдэх гэм нь олон биз гэв
Шилдэг дээд Борохул өгүүлбэл, Шихи хутат угтаж аваад хэлэв:
Хутагт төрсөн богд эзний энэ хишгийг
Хун, галуу мэт дуугаа нэгтгэж
Хулан чихтэй мэт зүсээ нийлүүлж
Хурсан бүгд жаргалдан цэнгэе л
Ачит төрсөн хаан эзний энэ хишгийг
Ангир, галуу мэт дуугаа нэгтгэж
Аргаль, марал мэт зүсээ нийлүүлж
Амраг сайхан нөхдөө аван жаргая л гэв
Эзэн богд Чингис хаандаа эрхт есөн өрлөг үг өчвөл үүдэнд суусан өнчин
хөвгүүн өндийж ирээд хэлэв:
Ихсийн зэрэгт орсон болоосой би
Ер үгээ хэлээсэй би
Сайдын зэрэгт орсон болоосой би
Санасан үгээ хэлээсэй би гэж байв
Богд эзэн тэр үгийг сонсоод, бодолгүй өчүүхэн хүү юу өгүүлнэ чи гэв. Тэр
хөвгүүн хэлэв:
Эзэн богд минь гэгээн сүртэй аж
Энэ хурсны дотор үг хэлэх нь бэрх аж
Хаан эзэн минь гэгээн сүртэй аж
Хамаг хурсны дотор үг өгүүлэх нь бэрх аж
Ойнд минь үг бий боловч
Онож хэлэх нь бэрх болов уу гэнэм би
Богд эзэн зарлиг болов:
Үгтэй бол өч чи
Хошоотой болбол холбо чи, гайгүй хэл гэв
Өв тэгш дээд эзний зарлигийг сонсоод
Өчүүхэн хөвгүүн баясаж

Өөрийн оюун чинээгээр
Унд дарсны гэм, эрдэм хоёрыг хэлэв.
Балай их ууваас өвчин бишүү
Бага зэрэг ууваас жаргал бишүү
Бахархаж шунаваас эргүү бишүү
Балмад их согтвоос галзуу бишүү
Үргэлж ууваас үлэг бишүү
Өсөд үүнийг тэвчвээс билиг бишүү
Учиртай сайхан ууваас жаргал бишүү
Унатал их согтвоос мунхаг бусуу
Хун, галуу мэт цуглаад
Хурсан бүгд цэнгэлдэн жаргаасай
Худалч хүний үгийг бүү ажиглан согтоосой, Та
Хутгалцах дайсанд биеэ бүү тэвчээсэй
Цэн шувуу мэт цуглаж
Цэцэд мэргэдээ аван жаргаасай
Чалчаа хүний үгийг бүү ажиглан согтоосой, Та
Цавчилдах дайсанд зэргээр ороосой
Ангир шувуу мэт амаар авалцаасай
Амраг сайн нөхдөө аван жаргаасай
Алиа хүний үгийг бүү ажиглан согтоосой, Та
Аливаа хүслээ ханалцан цэнгээсэй
Алалдах дайсанд нэгэн цэгнээ бүү орхиосой
Өлөн хутуур мэт эрүүгээр авалцаасай
Өсөх өтлөхөө аван жаргаасай
Өөдөм муу хүний үгийг бүү ажиглан согтоосой, Та
Өшөөт дайсанд мятрашгүй ороосой гэв.
Чингис хаанаа цэцэн хөвгүүн үг айлдвал, Чандага сэцэн ховшуур угтаж аваад
өгүүлэв:
Есөн өрлөгийн үгийг буруу гэж
Ер чи үг өгүүлэх буюу
Хамаг хурагдад цэцэн үгүй гэж
Хаан эзэнд чи үг айлтгах буюу
Өнчин хөвгүүнд үг бий билүү
Өргөдөг моринд гүйдэл буй билүү
Нугасан мэт жимс цөлмөөсэй чи
Нохой мэт яс булаалдаасай чи гэв.
Тэр хөвгүүн өгүүлрүүн:
Чандага сэцэн, тэр чинь биш
Чанар муу сэтгэл бизээ
Есөн өрлөгийн үгийг буруу гэв үү би
Ер миний үг зөв гэв үү би
Хамаг хурагдад цэцэн үгүй гэвүү би
Хаан эзний зарлигаас даван ядаж хэллээ би
Өчүүхэн хүнийг өргөж хайрлавал
Өсдөггүй буюу

Өргөдөг морийг өргөж тэжээвэл таргалдаггүй буюу гэв.

Чандага сэцэн ховшуур хилэгнэж өгүүлрүүн:

Холбож хэлэх үгтэй аж, чи

Хошоолж хэлэх цээжтэй аж, чи

Хулгана мэт биеийг чинь хугачнам, би

Хурсан бүгдэд инээдэм болгоном, би

Цучил мэт биеийг чинь цуучнам, би

Цугласан бүгдэд элэг болгоном, би

Муу хөвгүүн үгээ тат

Муухай их эвдүүзэй, чи

Багахан хөвгүүн үгээ цэглэ, чи

Балай их эвдүүзэй чи гэв.

Чандага сэцэн чамд хэлсэн биш билээ

Чингис хаан эзэндээ айлтгалаа

Ховшуур сэцэн чиний үгийг булаасан биш билээ

Хувьд өөрийн санаагаа хэллээ

Буруу зөвийг ялгадаггүй буюу, чи

Булинггаргүй далайг харамладаг буюу, чи

Богд эзний хайрыг өмчирхдөг буюу, чи

Бололгүй над лугаа тэмцдэг буюу, чи

Хас их далайг харамладаг буюу, чи

Хаан эзний минь хайрыг өмчирхдөг буюу

Хариугүй муу над лугаа тэмцдэг буюу

Хамгийн урьд уурладаг буюу

Онон мөрнийг ховоогоор ширгээдэг буюу

Огторгуйн солонгыг гараар барьдаг буюу

Идэр мөрнийг элсээр боодог буюу

Эрдэмт хүнийг санаагаар цэнэдэг буюу

Зөөлөн сэтгэлийг бариасай, чи

Зөв үгэнд минь баясаасай, чи

Бузар муу сэтгэлээ тэвчээсэй, чи

Буруу үгийг сэлбэж өгөөсэй, чи

Чингис хаан Чандага сэцэнд зарлиг болруун:

Худгийн усыг засаж ариутгавч

Хургаж дээш үл давлан

Мөн савандаа байх аж.

Ховоогоор хутгаж авбаас

Хоромхон зуур ширгээд

Гутамшиг муу булинггар нь

Ёроолоос гарах аж

Давлан гарах булгийн усыг

Дээрээс нь булавч боогдохгүй

Оргилон гарах булгийн усыг

Ховоогоор хутгавч ширгэхгүй

Булинггаргүй сайхан ус нь

Бургилан урссаар байх аж

Харавтар шувууг тэжээж
Харцага шувуунд тавибал
Харин түүнээс айж далдираад
Газарт бууж хулганы нүхийг сахих ажгуу
Харцага шувууг тэжээж
Харугана шувуунд тавибал
Харин дээш хальж
Хацар зулайд халдах ажгуу хэмээн зарлиг болоод:
Бадрангуй цагаан тэнгэрийн хөвгүүн эзэн богд
Бас тэр хөвгүүнийг дэргэдээ суулгаж
Бал рашааны хишгээ өгч
Баясгалант царайгаар үзэн өршөөж өргөв.
Эзэн богд тэргүүлэн есөн өрлөгийн
Эсрэг тэсрэг хэлэлцсэн үгсийг
Эртний их түүхээ болгон шүтэж
Үүнийг дуунд авав
Арван нэгэн цэцдийн үгс төгсөв.
Арван нэгэн цэцдийн үгс түгэв.

Асууулт даалгавар:

1. Өнчин хөвүүний дүрийн онцлогийг тодорхойлон бичнэ үү?
2. Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвүүний сэцэлсэн шаштир зохиолын уран дүрслэлийн онцлогийг тодорхойлон бичнэ үү?
3. Уг бүтээл бичигдэх болсон түүхэн үндэс юу болохыг тайлбарлан бичнэ үү?
4. Зохиолын дотроос өөрийн мэдэхгүй үгсийг түүвэрлэн бичиж, товь бичиг ашиглан тайлбарлаарай.

Чингисийн эр хоёр загалын тууж оршив

Эрт урьд цагт
Сод богд Чингис хааны
Эрмэг цагаагч гүүнээс
Эр хоёр загал унага
Төрсөн ажгуу,
Тэр онд
Арван гүүнээ тэлж,
Арга хийж, онд оруулав гэлээ.
Эзэндээ дааган ахуйн цагт унуулж,
Үрээн ахуйн цагт хуяглаж,
Тэр хоёр загалыг унаж,
Алтай ханыг арлан авлаж,
Хөхүй ханыг хөвчлөн авлаж,
Их загалыг унаж,
Алтан ханыг авлан талбив
Аргал угалзыг алж,
Аргагүй бардаж ирэхэд
Арван түмэн

Авын хүн
Нэгээхэн бээр эс гайхав.
Бага загалыг унаж
Хөхүй хааныг хөвчлөн талбиж
Хүйлэн хөх чоныг хядан алав.
Өвсний оройгоор
Өрвөлзүүлэн ирэхэд
Хэдэн түмэн авын хүн
Нэгээхэн бээр эс гайхав.
Хэнтий ханыг
Хэрэн авлан
Хэдэн түмэн амьтныг
Гүйцэж явахад
Хэн ч хүн
Хэрэглэн эс гайхав.
Онон хатны
Ой талыг авлаж,
Олон амьтныг гүйцэж,

Ойр хол бүгдэд
Адил боловч
Олон бүгд эс гайхав.
Тэр дээр учрах сэтгэл төрж,
Дааган цагт минь давтсан бол
Үрээн цагт минь орсон болж,
Хязаалан цагт минь хянасан болж,
Соёолон цагт минь орсон болж,
Хэмээн бага загал нь их загалдаа хэлэв
Ээ авгай минь явъя
Алтай ханыг авлахад
Арван түмэн улс эс мастав.
Ай хайран дур минь.
Хөхүй ханыг авлахад
Хүй олон улс эс магтав.
Хөвчин хайран санаа минь.
Хэнтий ханыг авлахад
Хэдэн түмэн улс эс магтсан
Хайран дур минь.
Энэ бүхнийг маань
Үл магтах юу болов.
Ээ, авгай минь ер явъя.
Манай одсоны хойно
Хаан эзэн минь
Нэг хоёр дурдваас
Нэрийн алдар биш буюу
Ээ авгай минь
Алтай гэгч газар
Агь, шавын өвстэй гэнэм.
Аялан хүрч амарч хэвтье
Авгай минь.
Хөхүй хан гэгч газар
Хөвөг шаваг өвстэй гэнэм
Хөөрөм цөөрөм нууртай гэнэм билээ.
Хөдлөн хүрч хөлбөрч барьж, хэвтье
Авгай минь бүр явъя.
Хэнтий хан гэгч газар
Гэмгүй таргатай гэнэм
Хий хуй болон хүрч
Хэжийлэн хэвтье
Авгай минь үтэр явъя.
Онон хатан гэгч газар
Урт сайхан устай гэнэм билээ.
Ой тал олон гэнэм
Үдлэн хүрч
Ундаагүй хэвтье

Авгай минь бүр явъя.
Ээ авгай минь
Ах мэт санагч
Алцал бор нь буй заа
Хөвүүн мэт санагч
Хөгшин шарга нь буй заа
Гөжин ширүүн аашлагч
Чи бид хоёр буй заа.
Хатнаа мэт санагч
Хар хул нь буй заа
Харь дайсан мэт санагч
Авгай чи бид хоёр буй заа
Бүр явъя.
Хүйтэн өдөр барин
Хөндлөн хөх төмөр үмхүүлэн
Хөрзөнт тохмыг
Хөлстэй талбин
Хүйтэн төмөр үмхэж,
Авгай бүр явъя.
Халуун өдөр барин
Хатгал уян
Халуун наранд шаран
Хайр шороо үмхүүлэм.
Авгай бүр явъя.
Бага загал нь
Их загалдаа
Газар газарлая гэж хэлэв.
Авай бор тоором минь
Юу гэмнэм чи
Эзэн гэж эзэнд адил
Эзэн олодох буюу
Эх гэж эрмэг цагаагч ижийд адил
Эх олодох буюу
Ер эр хүн баярлах гэж
Магнай үл хагарах гэлээ
Агт морь таргалж,
Арьс үл хагарах гэлээ
Авай бор тоором минь
Юу гэнэм чи
Ээ авгай минь
Сайн хүнд нөхөр олон биш үү.
Сайн моринд эзэн олон биш үү.
Өнөр хүнд нөхөр олон биш үү.
Өнчин хүнд ноён олон биш үү.
Санаат хүнд сэжиг олон биш үү.
Сайн моринд газар ойр биш үү

Авгай минь явъя.
Авай бор тоором минь
Эетэй хүнд нөхөр олон гэлээ
Ороо моринд уурга олон гэлээ
Эегүй хүнд өстөн олон гэлээ
Эцсэн моринд ташуур олон гэлээ.
Хүний гэж
Хөвчин бүгдээр үлдэм зээ
Дайсан гэж даяар үлдэм зээ
Зэрлэг гэж зэвийн үзүүрээ унаганам заа
Авай бор тоором минь
Юу гэнэм чи.
Хадны өвс хагд идье.
Бутны өвс бугдай идье.
Өсгөн төрүүлсэн
Өл буурал ахай юугаан
Яаж мартъя гэнэм чи.
Өргөн төрсөн
Эрмэг цагаагч ижий юүгээн
Яаж мартъя гэнэм чи
Арван хоёр сар
Нуруугаа чилтэл өргөсөн
Ангир шар уургаа шимүүлсэн
Ачит цагаан сүүгээ хөхүүлсэн
Амраг эх юүгээн
Яаж мартъя гэнэм чи
Авай бор тоором минь.
Юу гэнэм чи.
Омгоо дараагүйд
Уушгиа цэрдээгүйд
Яанам болов уу чи минь.
Хайрлан хадгалсан
Хаан эзэн минь
Ханилан өссөн
Хайран харь олон
Эд бүгдийг
Яахин орхин газарлая гэнэм чи.
Өөдгүйг өсгөн хурааваас
Тусгүй гэлээ
Байг хэмээн хэлэв.
Сайн хүнд нөхөр олон гэлээ
Сайн моринд газар ойр гэлээ
Бүр явъя гэж
Бага загал гагцаар явсуу хэмээн санаж
Их загалаа орхиж
Гурван цавчуурын зүгт явав.

Ах минь нэхэх болов уу хэмээн санаж
Түргэн зуураа алтан улиасны сүүдэрт
Хүлээж байн атал
Дөрвөн зүгт нь
Дөрвөн өнгийн шувуу
Нэгэн эгшгээр донгодов,
Бага загал чихээ сэртийж
Сүүлээ өргөж чагнан байв.
Алтан гургалдай шувуу
Алтан улиасны дээр суун жиргэв,
Ах дүү хоёр загал
Салан газарлав гэж жиргэв.
Дахин аялгуулан жиргэв.
Хөхөө нэрт шувуу донгодов.
Хөөрхий бага загал
Урван газарлав гэж жиргэв.
Богширго шувуу босон жиргэв.
Богд эзний хайран хоёр загал
Салан газарлав гэж жиргэв.
Хайргана шувуу
Хадны дээр суун жиргэв.
Хаан эзний хайран хоёр загал
Хагацан газарлав гэж жиргэв.
Тэр дөрвөн өнгийн шувууны
Дууг сонсоод
Бага загал тэсэлгүй явав.
Түргэн түргэн явахад
Түнгэрцгийн чинээ чулуу хөдөлгөж,
Аргаар аргаар явахад
Аягын чинээ чулуу хөдөлгөж,
Гурван цавчуурыг зорьсуу
Авгай минь нэхэх болов уу хэмээн санаж,
Хөх өндрийн өвөрт
Өвс таталж байв.
Их загал нь
Өглөө наранд нэхэж,
Үдийн наранд
Хамраа хавчиж,
Хар хөлсөө асгарч,
Амиа тэмцэн гүйцэж ирэв.
Ээ бор тоором минь
Хүний гэж хавчин үлдэж,
Дайн гэж даяар хөөх
Зэрлэг гэж зэвийн үзүүрээ унагах буй заа гэж
Их загал нь бага загалдаа хэлэв.
Хоёр загалын одсоны хойно

Нэг шөнө Сод богд эзэн зүүд зүүдлэв.
Эрхт тэнгэр эцгээс заяатай
Эрмэг цагаагч гүүнээс төрсөн
Эр хоёр загал минь
Эйлэн газарлав гэнэм би
Богд эрхт тэнгэрээс заяатай
Буянт цагаагч гүүнээс төрсөн
Бууралтгүй хайран хоёр загал минь
Буруулан газарлав гэнэм.
Хаан эрхт тэнгэрээс заяатай
Хас цагаагч гүүнээс төрсөн
Хайран хоёр загал минь
Гаран газарлав гэнэм би.
Хазаараа эгэлдэрч
Явган яавнам гэж зүүдлэв би.
Энэ зүүд минь үнэн буюу худал буюу гэж
Шивэгчнээ зарлиг болов:
Адуунд орж үз!
Худал болбоос дуугүй ир!
Үнэн болбоос дүрвэн харь!
Есөн өнгийн улсыг минь
Эрт цуглуулж ир! хэмээн зарлиг болов
Боол Бичин адуунд орвоос
Өл буурал азарга нь
Өрвөлзөн өрвөлзөн ийш тийш харж
Унгалдаж байх аж.
Эрмэг цагаагч гүү эх нь
Ийш тийш харж
Нүднээс нулимс гаргаж байхыг үзэв.
Боол Бичин яарч,
Дөрвөн харь, есөн өнгийн улсаа
Манагар (маргааш) эрт цуглуулж ирэв.
Сод богд
Алцал бор морио унаж
Алтан хороо (хоромсоо) авч
Зэл цагаан нумаа дүрэн
Аргасун хорчийг хөтөч хийж,
Алжин харцгай юугаа барьж,
Эхдээ эргэх болов уу хэмээн санаж,
Эрмэг цагаагч гүүг хөтлөв,
Төдий морион явахдаа
Хаан ноён Сод богд зарлиг болов.
Хөхүй ханы өврөөр цувъя.
Алтан ханы араар авлая.
Отын хүн урьд яв!
Тахилзуурын хүн тасралгүй яв!

Тэр хоёр загалыг минь
Хэн гүйцсэн хүн бүү харва!
Барьж үз!
Барьсан хүнд дөрвөл хошуу малаа
Тэгшхэн хуваах би хэмээн зарлиг болов.
Даруй хоёр загал
Хойт нэхсэн авын барааг
Харж үзээд
Их загал нь бага загалдаа хэлэв
Тоором минь
Би эс хэлэв үү
Хүний гэж хөвчин үлдэх буй заа
Зэрлэг гэж зэвийн үзүүрээ унагах буй заа гэж
Эс хэллүү би.
Энэ биш үү гэв.
Бага загал нь хэлэв:
Ээ авгай минь
Эр хүн хэлсэн үгэндээ хүрэх биш үү
Агт морь зорьсон газартаа хүрэх биш үү явъя.
Яасан эм мэт охорхон санаатай билээ чи
Манийг гүйцэх мориноос болох
Барааг маань харах буюу гэв.
Алтай хааны ар ороход
Аргал угалзыг алхлан бууя.
Хөхүй хааныг өвөрлөн явахад
Хөх алаг бугыг гишиглэн гаръя
Төвийн хүнд тоосоо үзэгдье.
Бүр гурван цавчуурыг зорьё гэв.
Бага загал өргөн хөдлөв.
Их загал шогшин хөдлөв!.
Бага загал их загалдаа хэлэв:
Авгай минь
Ах мэт санагч
Алцал бор морь яанам болов гэж хэлэв.
Даруй түргэн барьсангүй
Гурван цавчуур газрыг зорин хүрэв.
Их загал нь хоёр санааг санаж,
Хайран хаан эзэн минь
Хайран хас цагаагчин эх минь гэж
Нүднээс нулимс гаргаж,
Өр элгээ өмөрч,
Өвдгөө сөгдөж явав.
Сод богд эзэн нь
Хөх өндөр дээр гарч
Барааг нь харж,
Шаналан уярав.

Болдогийн бор толгойд гарч,
Хаан эзэн нь хайлав.
Эрийн сайнаар
Эзэн эс боллоо би
Эрхт тэнгэр эцгийн заяагаар
Эзэн боллоо би
Эрмэг цагаагч гүүнээс төрсөн
Эр хоёр загал минь
Эйлэн газарлав уу чи.
Эвий минь.
Эмээлээ барьж яахин харъя.
Эргэж ирэх болов уу чи.
Эвий минь.
Булаан авч эзэн эс боллоо би
Богд тэнгэр эцгийн заяагаар
Эзэн боллоо би.
Буянт цагаагч гүүнээс төрсөн
Хайран эр хоёр загал минь.
Буруулан газарлав уу чи.
Эвий минь
Хайрлан авч
Эзэн эс боллоо би
Хаан тэнгэр эцгийн хайраар
Эзэн боллоо би.
Хас цагаагчин гүүнээс төрсөн
Хайран хоёр загал минь
Хагацан газарлав уу чи,
Эвий минь
Харьж ирэх болов уу чи.
Эвий минь
Учиртай их
Уралдаан болоход
Юугаан хагсаая.
Учирт их авын болоход
Юугаан уная.
Хайран хоёр загал минь
Харь олон дайсан болоход
Юугаан хуяглая.
Хайран хоёр загал минь хэмээгээд
Төдий Сод богд эзэн
Орд харшдаа харьж ирэв.
Хоёр загал
Гурван цавчуурт зорин хүрч
Дөрвөн он нутаглав
Бага загал нь
Арьсаа язартал таргалав.

Их загал нь
Зун зуссан морь мэт хатайртаад
Өвөл болоход хацарт нь
Аягын чинээ мөс хөрөв.
Уй гашууд уярах сэтгэлий нь мэдээд
Бага загал нь асуув:
Ээ авгай минь
Өвсийг эрүүгээр иддэг атал
Усыг уруулаар уун атал
Авгай арьстай, шөрмөстэй хатах чинь
Юу буй хэмээн асуув
Их загал хэлэв:
Авай бор тоором минь
Юу гэж үл мэднэм чи
Хайрлан өсгөсөн хаан эзнээ
Ханилан учирсан хайран нөхдөө
Хайран төрсөн эх юүгээ санахул
Хайрт газар туруугаа
Хомоолт газар эрүүгээ хүргэж ядав
Өсөн төрсөн эх юүгээ санахул
Өвсөнд эрүүгээ
Усанд уруулаа хүргэж ядав
Эвий бор тоором минь
Яаж үл мэднэм чи
Эвий минь гэв!
Тэр цагт бага загал нь
Зөв харж, инээн
Буруу харж, уйлан
Их загалд хэлэв:
Ээ авгай минь
Арьс, шөрмөстэй чинь хатаан алж,
Арьсыг чинь өмсмүү би
Махыг чинь идмүү би
Ачит авгай минь
Одоо харья хэмээн хэлэв.
Их загал гурав дахин шилгээгээд
Нэг хоёр өвс татлан байв.
Их загал өргөн хөдлөв.
Бага загал шогшин хөдлөв.
Гурван сарын газар
Гурван гурав хоногт хүрье гэв.
Тэр хоёр загалын
Хүрч ирэхийн шөнө дунд
Сод богд эзэн нь
Нэгэн зүүд зүүдлэв.
Эрхт тэнгэр эцгээс заяатай

Эрмэг цагаагчин гүүнээс төрсөн
Эр хоёр загал минь
Эйлэн газарлаж билээ
Эргэж ирэх болов уу
Эмээлээ тохож байнам гэж зүүдлэв! би гэв.
Энэ зүүд минь үнэн буюу худал буюу
Боол Бичинийг адуунд орж үз гэж.
Хаан эзэн Сод богдын зарлигаар
Адуунд орвоос
Хоёр загал харьж ирсэн ажгуу.
Өл буурал азарга нь үүрсэн байж,
Үүрд хагацав гэж билээ би
Эдүгээ өдөр ирэв үү та хэмээн
Баярлан байж эвшээн байв.
Эрмэг цагаагчин гүү эх нь
Хоёр нүднээс нулимс гаргаж,
Уйлан баярлаж байхыг үзэв.
Эр хоёр загал нь
Эхийнхээ энд тэндээс нь харж байхыг үзэв.
Боол Бичин үзээд
Хоёр загалыг барина гэв.
Хоёр загал эс баригдав.
Хоёр загал ирж
Өл буурал азаргатай авч ирэв гэж
Хаан эзэн Сод богдод айлтгав.
Сод богд хаан эзэн нь
Нэг ханцуйгаа түргэн өмсөн гарав.
Ээ хоёр загал минь
Мэнд буюу та гэв.
Бага загал нь
Зэв онтудахын төдий газраа байж хэлэв.
Гурван цавчуур зорьсон хойно
Хоёр загалд юу буй
Гучин түмэн улсыг эзлэн суусан
Хаан эзэн минь харин мэнд буюу та
Алтай ханыг зорьсон
Алиа муу хоёр загалд юу билээ
Арван түмэн улсыг эзлэн суусан
Хаан эзэн минь харин мэнд буюу чи
Хөхүй ханыг зорьсон
Хөөрхөн аалт хоёр загалд юу билээ
Хүй олон улсыг эзлэн суусан
Хаан эзэн минь харин мэнд буюу чи гэв.
Сод богд зарлиг болж:
Ээ хоёр загал минь
Та юуны тул ямар учиртай

Газарлав та гэж асуув.
Их загал дуу эс гарав
Бага загал Сод богд эзэндээ хэлэв:
Ээ хаан эзэн минь
Хоёр загалыг хайрлах болоосой
Дааган цагт минь давтах билээ та
Үрээ цагт минь
Эрэн санах билээ та
Хязаалан цагт минь
Хяхан унах билээ та
Соёолон цагт минь
Сорин унах билээ та,
Алтай ханыг авлах цагт
Аргал угалзыг гүйцэн алав.
Арван түмэн авын хүн үл магтав.
Хөхүй ханыг хөвчлөн авлах цагт
Хүйлэн хөх чоныг гүйцэн алав.
Хэдэн түмэн хүн чинь үл магтав.
Хэнтий ханыг хэрэн авлах цагт
Хэдэн түмэн хүн чинь эс магтав.
Онон хатны ой талыг авлахад
Ойр хол адил боловч
Олон түмэн чинь эс магтав.
Тиймийн тулд газарлав бид
Аймаг шувуу донгодлоо
Хүний хөвүүн газартаа суув.
Хөлгийн хөвүүн газраа санав.
Хаан эзэн Сод богд минь гэв.
Тэгэхэд их загал хэлэв:
Бор тоором байг гэв.
Хаан эзэн минь намайг уна гэв.
Тэр үгийг зөвшөөж,
Бага загалыг найман жил хурлав.
Найман жил хагсаав.
Намрын тэргүүн сард
Авд мордъё гэж,
Ав мөрдөн
Алтай ханыг арлан авсав.
Арван түмэн хүн магтан гайхав.
Хөхүй ханыг хөвчлөн авлав.
Хэдэн олон амьтныг гүйцэн авлав.
Хэлэхүй авын хүн гайхан магтав.
Хэнтий ханыг хэрэн авлав.
Хэдэн олон амьтныг гүйцэн авав.
Хэлэхүй авын хүн гайхан магтав.
Онон хатан мөрний ой талыг авлав.

Олон түмэн амьтныг
Хядан авлав.
Хэмжээгүй гайхан магтав.
Хоёр загалын санаа нь амархан жаргав.

Сод богд Чингис хаан
Бага загалд хив татаж сэтэрлэв гэлээ
Хив татахын ёсон бага загалаас болов гэлээ

Эзэн богд Чиигис хааны
Эр хоёр загалын тууж төгсөв.

Асууулт даалгавар:

1. “Эр хоёр загалын” дүрийн зан чанарын онцлогийг харьцуулан тайлбарлана уу?
2. “Чингисийн эр хоёр загал” зохиолын уран дүрслэлийн онцлогийг тодорхойлон бичнэ үү?
3. “Чингисийн эр хоёр загал” зохиолын агуулга, үзэл санааг тайлбарлана уу?
4. Уг бүтээл бичигдэх болсон түүхэн үндэс юу болохыг тайлбарлан бичнэ үү?
5. Бага ангийн сурагчдад ойлгогдохуйцаар хураагуулан үргэлжилсэн үгийн хэлбэрээр найруулна уу?

Оюун түлхүүр

Дээд лам гурван эрдэнэд итгэмой.
Эртний богд Чингисийн зохиосон шастирыг өчүүхэн
сануулахын учир.

Аугаа хүчээ ихэтгэе гэвэл
Цэргээ асар
Уудам сул жаргая гэвэл
Эеэ хичээ
Өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн
Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун
Олны дотор үгээ бэхэл
Ганцаар суухдаа сэтгэлээ шинж
Олон хүмүүнтэй найран зохилдож
Ер авах гээхийн ялгалыг шинжлэн мэд
Муу хүний үгэнд орох
Сайн хүний үгийг үл итгэх
Ширүүн үгээр дайсныг хураах
Хорт сэтгэлээр хамгийг хашраахыг тэвчтүгэй
Тойн хүмүүний хамаг эрдмийн дотор
Нигүүлсэх эрдэм нэн эрхэм
Хаан хүний гучин таван эрдмийн дотор
Хайрлах сэтгэл нэн эрхэм
Хатан хүний арван таван эрдмийн дотор
Сайхан ааль нэн эрхэм
Түшмэл хүний есөн эрдмийн дотор
Төвшин сэтгэл нэн эрхэм
Арслан мэт ноёныг
Барс мэт түшмэл дагах

Барс мэт ноёныг
Ирвэс мэт түшмэл дагах
Ирвэс мэт ноёныг
Чоно мэт түшмэл дагах тул
Хамагт зовлон болмой
Өнчин хүний жаргалыг хөнөөвөөс
Өөрийн хишиг эвдрэх
Үнэн тус хүргэгчдийг муулваас
Тэнгэр үл таалах
Үнэхээр зүтгэсэн ардын урмыг
Өчүүхэн юманд бүү шантал
Үзмэгц яаран магтаад
Учралдан ханилж, гайхуулаад
Удал үгүй хэрэлдэн салаад
Даруй буцаж, инээдэм наадам
хийн явагч хүмүүн
Үзтэл муу ард мөний тул
Үтэр түүнээс зайл
Дэмий муу биеэ гайхуулан
Дээдсийн ёсоор загнагч
Танхай ард ичих мэт
Түүнээс түргэн зайл
Хилэн ихтийг аргаар өнгөрүүл

Хилэнц ихтийг номоор тэтгэ
Төрөл төрөгсдөө тэтгэж явбаас
Бөх их хүчтэй болох
Төр ёсыг төв шударга дагаж явбаас
Хүнд их нэртэй болох
Түүнийг, үүнийг ялгалгүй асарваас
Олон нөхөдтэй болох
Харийн газар арга чадлаа бэхэл
Халуун зуураа эв эеэ хичээ
Үнэхээр ханилсан сайн нөхрийн үгсийг
Үхтэл бүү март
Хагацашгүй хань нөхөрт
Марташгүй муу үгийг бүү хэл
Харин улиг болмой
Үг үл мэдэх мунхаг хүнтэй
Үг хэл бүү тэмц харин ичгүүр болмой
Өчүүхэн номч хүмүүн омгоор
Үргэлж их мэдэх мэргэдэд халдваас
Үтэр шантрахын тэмдэг
Арслангийн омог баатар
Мөн арсландаа зохих
Үнэгний уран арга
Мөн үнэгэндээ зохих
Арслангийн баатар омог үнэгэнд тусгүй
Үнэгний уран арга арсланд тусгүй
Арслан үнэг мэт явбаас түргэн гутах
Үнэг арслан мэт явбаас түргэн үхэх
гэсэн үлгэрийг хэн хүн хянан үзэж,
Хэр хэрээ мэдэж,
Чинээ чинээгээ бодож явбаас сайн
Ер хоёр хүмүүн эвтэй болбоос
Төмөр хүрээ мэт бэх
Хорин хүн эвгүй болбоос
Эвдэрхий хүрээ мэт хэврэг
Өнөр хүмүүн эвгүй болбоос
Өнчин хүний элэг болох
Олон хүмүүн эвгүй болбоос
Оорцог хүмүүний идэш болох
Цувж явсан барсаас
Цуглаж суусан шаазгай дээр гэлээ
Тиймийн тул эв эеэ нэн бэхлэгтүн
Амраг ханилсан нөхөрт

Асуулт даалгавар:

1. Уг зохиолыг агуулгаар нь ангилан хэдэн зүйлийн явдлыг сургасан болохыг жишээгээр тайлбарлаарай.

Аливаа хүмүүний үгээр бүү уурла
Ажиглан онож мэдээд
Харин биеэ шүүгтүн
Үлэмж сайн ханилсан хүмүүсийг
Үнэхээр муу сэтгэлтэй хүмүүс
Үзэн ядаж хуурмаг аргаар эвдрүүлээд
Элэглэе гэх мэдэшгүй
Өнгөц зусар аргатай хүмүүн
Зөөлөн худал үгээр хууран байж
Үнэн санааг аваад
Үймтэл муутган хэлэхүй нь олон буй
Үзэж таньж ханил
Олзонд шунал үгүй
Нэгэн зоригоо хугалал үгүй
Ер уйдах чилэхийг санал үгүй
Хэв хэзээд цөхрөл үгүй
Зовох цагт зайлалгүй
Жаргах цагт хэтрэлгүй
Хайрлах цагт дасалгүй
Халдах цагт гуталгүй
Насан үргэлжид нэгэн зангаар явбаас
Улам хойчдоо хөгжил болох
Алтыг арчваас улам сайн өнгө гарах
Нүүрсийг угааваас улам харлах
Мэргэдийг хорсогоос улам эрдэм гарах
Мунхгуудыг хорсогоос баас гарах
Муу хүмүүн нэг ч эрдэм үгүй болбоос
Дээрээ шүдтэйгээс бус үхэр лүгээ адил
Сургаал үл сонсох бөгөөд
Гагцхүү цадахыг санагч хүмүүн
Үс үгүйгээс бус гахай лугаа адил
Авах идэхэд шунагч өнгөц зусарч хүмүүн
Сүүл үгүйгээс бус нохой лугаа адил...
... Үнэн эрдэм алт адил
Алтыг түлвээс улам өнгө гарах
Занданг түлвээс улам сайхан үнэр гарах
Галыг руу хандуулваас
Харин гар өөд шатмой
Эрдэмтэй болбоос олноо хүндлэгдэх
Эрдэмгүй болбоос доромжлогдохын үлгэр нь
Өлссөн барсын дэмий хүрхэрсэн дуунд
Өндөр модны орой дээр хэвтсэн бичин
Өөрөө хөсөр унаж идэгдэв гэх.

2. Сургаалын зохиолын агуулгын онцлогийг тайлбарлана уу?
3. “Чингисийн билиг” зохиолтой агуулга, үзэл санаа нь харьцуулан бичнэ үү?
4. “Чингисийн билиг”, “Оюунтүлхүүр” сургаалын зохиолын ялгаатай ба төсөөтэй талыг тодорхойлно уу?

Чингисийн билиг сургаал

Чингис хаан айлдруун:	Гэмтэн бус
Алд биеэ засахуйн эрдэмд	Нөхөр буюу.
Аги балчираасаа хичээгтүн	Гэм бурууг
Алд биеэ засахуйн билиг	Зөвшөөн дагагч
Ахас ихсээ хүндлэхээс эхэлмүй	Нөхөр бус
Эцгээ хүндэлж	Хорлогч буюу.
Эхээ ачилж	Өлсөхөөс өрсөж,
Эрхийг цээрлэн	Хүнсээ базаа
Эрдэмд хичээж	Өгүүлэхээс өрсөж,
Биеэ засагтун.	Үгээ сонж.
Аргал түүж хурга хариулах	Ухвар сайн хүмүүн
Алд биеэ засахуйн нэгэн билиг	Уужуу гүн ухаант аж.
Агт манаж, ан авд мордох	Ухвар мөчид хүмүүн
Аж төрөн хатуужихуйн эрдэм	Уйтан охор ухаант аж.
Балчир бага наснаас	Өөрийн алдас гэмийг
Биеэ засан хүмүүнжигтүн.	Бусдаас асуун мэдтүгэй.
Хүмүүнжиж эс чадваас	Төр засах ёсонг
Хүмүүн болж үл чадмуй.	Сэцдээс асуун суртугай.
Хойчис мину	Биеийн бөхөөр
Нойронд сэргэг	Нэгийг дийлмүй
Нөхөрт үнэнч	Билгийн бөхөөр
Үг мэргэн	Мянгыг дагуулмуй.
Үйлс шударгуу	Хөх Монголын
Хүмүүн болтугай.	Гагц оор (язгуур) хүмүүн
Биеэ мэдвэл	Харь аравтай
Хүмүүн болмуй	Хайнцах (тэнцэх) ахул
Би-гээн танивал	Хаана ч үл цөөдмүй.
Ухаан суумуй.	Бие баатар бөгөөс
Өөрийн зөвийг	Нэгэн үеийн баатар буюу
Нотолуюу гэвэл	Билиг баатар бөгөөс
Өрөөлийн зөвтэй	Түмэн оны баатар буюу.
Жишин шинжигтүн.	Эр хүмүүн биеэ
Өөрийн гэмийг	Эдээр чимснээс
Мэдсү гэвэл	Эрдмээр чимэх дээр
Өрөөлийн үгийг	Эхнэр хүмүүн биеэ
Хүлцэн сонсогтун.	Эрдэнэсээр чимснээс
Гэм бурууг	Эрхэм ёсоор чимэх дээр.
Зэмлэн хэлэгч	Нас нэмэвч
	Ухаан эс сууваас

Бие өсөвч
Билиг эс сурваас
Хөхрөхүй дор гутамшиг
Хөрст дээр шившиг.
Хүмүүнжин биеэ засахад
Хэзээ ч үл эртэдмүй
Ухаантан эрдэм сурахад
Хэзээ ч үл балчирдмуй.
Төрөлхийн тэнэг хүмүүн
Төгсөглөө үл засармуй
Эрхийн тэнэг бэрх хэдүй ч
Эртнээс хичээвэл засармуй.
Бэрхээс шантрах хүмүүн
Зориг мохоогийнх буй за
Сурахаас халширах хүмүүн
Билиг мохоогийнх буй за.
Хөвүүн хэдүй
Шил сайтай ч
Эрхэм ёсон үгүй бол
Хүмүүн эс болмуй.
Хүмүүн хэдүй
Сэцэн төрөвч
Сурахаас ангид
Мэргэн үл болмуй.

Сумны мөс хэдүй
Шулуун боловч
Онъ өднөөс ангид
Харваж үл болмуй.
Эрдэм сураад
Эс хэрэглэх ахул
Их ёсыг мэдээд
Өөрөө эс дагавал
Хөсөр хэвтэх
Өгөр яс мэт буюу:
Хүмүүн хэдүй олон боловч
Сэцэн мэргэн ганц хоёр
Хүлэг хэдүй олон боловч
Хурдан шандаст нэн ховор.
Ухаан уйтан хэмээн
Биеэ бүү чамла
Ухаант мэргэдээс сурвал
Билиг ухаан саруусмуй.
Эрдэх бягдах
Баатар бусыг мэдэгтүн
Эрхлэх цэнгэх
Жаргал бусыг санагтун.

Асууулт даалгавар:

1. Сургаалийн зохиолын туурвил зүйн онцлогийг тайлбарлана уу?
2. Сургаалийн зохиолын агуулгын онцлогийг тайлбарлана уу?
3. Сургаалийн агуулга, сэдвийг задлан шинжлээрэй. Шүлгийн толгой, сүүл, дотоод холбоцыг онцлогийг тодорхойлон бичнэ үү?

Мандухай цэцэн хатны домог

Мандуул хаан Баянмөнх болох жонон хоёр эх захаа нэгдэн зургаан түмнийг мэдэж явав. Мандуул хаан хоёр хатантай ажээ. Их хатан нь Ойрадын Бэгэрсүн тайжийн охин их хамарт Юнгэн, бага хатан нь Энгүд Цоросбай төмөр Чинсангийн охин Мандухай цэцэн хатан билээ. Тэндээс Мандуул хаан таван он **болох 42 гахай** жил халив. (1467 он)

Баянмөнх болох жонон хутагт Дэрстэй гэдэг газар Шихир тайхуугаас Даян хааныг хөвгүүлэв. Даян хааныг Балгагчны Багай нэрт хүнд өгөв. Түүний хойно Ойрадын Исман тайж довтолж, Шихир тайхууг аваад мөн Исман тайж асрав. Жонон Борбугийн газар Булудай хоёулаа зугатааж явтал Еншөөвийн захын улсад хүрч, жонон хээр байж Булудайг үг ав гэж илгээв. Булудайн эгч нь золгож дүүгээ барьж эс тавив.

Жонон ундаасаж хүлцэн ядаад айлд бууж, айраг уухад нэгэн баяд охин жононгийн унасан цагаан шаргал морь, өмссөн хэрмэн дотортой магниг дээл алтан бүс тэр бүгдийг ажиглан суув. Жонон мордож явсны

хойно тэр охин усны дэргэд олон хүн байхыг үзээд очиж хэлэв. Тийм атаатай нэг хүн үзэв гэв. Эншөөвийн таван отгийн Хэрэй Цагаан хоёр, Төмөр, Мөнх, хар Бадай эд бүгдээр гүйцэж жононгоос «Чи юун хүн бэ» гэж асуув. Жуулчин гэв. Алтан бүсээ ац гэв. Эс өгөв. Эншөөвийн хэдэн хүн Баянмөнх болох жононг цулбуурдаж бариад хороож, барс жил тэнгэр болов. Эншөөвийн нэг гэм нь тэр гэх.

Даян хааныг муухан тэжээхийн дор Тангуудын төлөгчийн долоон хөвгүүн Төмөрхадаг ирж, Багайд өгүүлрүүн: Энэ хөвгүүнийг сайн хүнд өг. Эсвэл надад өг гэж гуйхад эс өгөв. Түүний хойно Төмөрхадаг ах дүү долуулаа сайн улаан морио унаж ирээд булааж авч ирэв. Өчүүхнээсээ эцэг эхээсээ хагацсанаар Даян хаан бэтэг өвчтэй болсон ажээ. Тэр өвчнийг Төмөрхадагийн эм Сайхан хэмээх нь есөн түм цагаан тэмээний сүүгээр тэжээж гурван мөнгөн аяга цоортол илэн эмнэв. Тэр эмнэлэгт замаг мэт долоон хэсэг өвчин унаж сайн болов. Даян хааны нэг зовсон нь тэр болов. Түүний хойно Даян хааныг тангуудын Төмөрхадаг аваачиж Мандухай цэцэн хатны гарт хүргэв. Мандухай цэцэн хатан эртний хаадын өшөөг дурдаж, үхэр жил цэрэг мордуулан явган цэргийг явуулж гурав хоносны хойно морь цэрэг авч мордов.

Мандухай цэцэн хатан

Сайвраар саадаглаж

Садарсан үсээ хурааж

Эр хүн шиг зэвсэглэн

Сайн Даян хааныг үхэг тэргэнд суулгаж мордов. Даян хаан балчир байв. Хишигтэний Алайдунгаар газарчлуулж дөрвөн түмэн Ойрадыг довтолоход Цэцэн хатны малгай нь унаж, хүзүүнд нь эгэлдэрлэж явахад Ойрадын хүн үзээд өөрийн малгайгаа өгөв. Хатан аваад, хориглож давшуулж дөрвөн түмэн Ойрадыг дагуулав. Тэс бүр дээр довтолж, тэгэдүнэ дээр байрлалдаж, тэнхрүүлэлгүй **тэсийн талга** авч тэвчүүлэв. Зургаан түмэн улс Ойрадын нэг төрийг эндүүлэв. Түүний хойно Мандухай цэцэн хатанд Хорчины Ноёнболд:

Галыг чинь цахиж

Нутгийг чинь зааж өгсүү гэв

Мандухай цэцэн зарлиг болруун:

“Хааны минь өвийг

Хасарын үр чи идэх буюу

Хасарын үр чиний өвийг

Бид идэх билүү

Өргөж үл болох үүдтэй билээ

Алхаж үл гарах босготой билээ

Хааны минь үр байтал

Чамд үл эчим” гэв. Түүнээс Хойно Алагчуудын Сатай доголонгоос үг асууруун: “Ноёнболд унгийн үг зөв буюу буруу буюу” гэж асуув. Сатай доголон “зөв байнам чи” гэв. Хойно, хорлодын Мэнд өрлөгийн гэргий Жиган агаас урьдах үгийг асуув. Жиган ага хэлэв.

Хасарын үрд эчихүл

Хар мөр удирдан

Хамаг улсаасаа хагацаж
Хатан нэрээ алдьюу
Хааны үрд очвол
Хаан тэнгэрт ивээгдэж
Хамаг улсаа эзлэн
Хатан нэрээ алдаршьюу
Цагаа хөвгүүнд (цагаат хүн) эчихүл
Цагаан мөр таталж
Цахар түмнийг эзэлж
Цаглашгүй нэр алдаршюу

Жиган ага энэ үгийг айлтгав. Мандухай Жиган агагийн үгийг зөвшөөрч Сатай доголонгийн үгийг буруушаав.

Хааны үрийг өчүүхэн гэж
Хамаг улсаа эзэнгүй гэж
Хатан биеийг минь бэлбэсэн гэж
Хасарын үрийг их гэж
Хааш үг өгүүлмүй хэмээгээд
Халуун цайг тэргүүн рүү нь асгав.

Мандухай цэцэн хатан Даян хаанд гурван давхар ултай гутлыг өмсгөж, Алагчуудын үнэгийн алаг лонхот архийг авч найман цагаан ордны өмнө очиж, гэрийн ноён Мэнгэн Ниругу бээр суут хаан хатны сүлдэнд сацал сацуулж, эш хатан өөрөө ийн өгүүлэв.

Хар цагааны зүс ялгагдахгүй
Хол газар бэрлэдэг билээ
Хаан чиний үрийг балчир гэж
Хасарын үр авъя гэхэд
Хайрлан тэтгэх өршөөлийг эрж
Хааны ордны дэргэд ирэв би.
Харах нүд минь далдирч
байна
Харайх хөл минь сөхөрч байна
Алаг морины зүс ялгарахгүй
Алс газраа бэрлэдэг билээ.
Ач үрийг чинь өчүүхэн гэж

Алсын авга авъя гэхэд
Арчлан тэтгэх өршөөлийг
эрж
Алтан ордны чинь дэргэд ирэв
би.
Айх амь минь алдарч байна.
Арчих нүүр минь улайж байна.
Өргөн их үүдийг чинь хөнгөн
гэж
Өндөр их босгыг чинь нам
гэж

Өөр хүнд эчвээс өөдгүй нэр
над хоцормуй.
Балчир үрийг чинь бага гэж
Басаж доромжлохгүй би
Болд унгийг их гэж
Богтлогдож очихгүй би
Уурга чинь урт биш үү
Уургалж ав, өчүүхэн намайг
Хуйв чинь агуу биш үү
Хурааж ав өчүүхэн намайг
Хав хүч бүрдсэн
Хаан хөвгүүн төрж билээ.
Хаан хөвгүүний чинь халив гэж
Хар биеэ мэдэж эчвээс
Хаа гуяасаа хагацсу би.
Эзэн богдоос минь
Эрхэм хөвүүн төрж бүлгээ
Эрхэм хөвгүүнийг чинь алдав гэж
Эм хүн биеэ мэдэж эчвээс
Эзэн хаан хатны өмнө
Эвдүүлсү би гэж
Үнэн үгсээ өгүүлж
Үүрдийн тангараг өргөөд
Хувь заяаг соёрхон

Хутгийг гуйж залбирсан нь
Энэ үгийг минь зөвшөөх болбоос
Эмэгтэй намайг өршөөх болбоос

Эрхт хаан эцэг минь
Эш хатан эх минь
Дотоод энгэрт минь
Долоон хөвгүүн төрүүл
Гадаад энгэрт минь
Ганц охин төрүүл
Доорд хатан над
Долоон нуган заяаваас
Долуулд Болд нэр өгч
Гал голомтыг чинь сахиулья

Газар нутгийг чинь эвлүүлье гэж залбираад харив. Хатны тэр зарлигийг сонсоод Ноёнболд ун урд үгээ байв.

Даян хааныг Холуурын голд долоон насандаа усанд унасанд шумбаж явсан Тангадын Айн Төмөр нэрт хүн авсан гэх. Түүний хойно Батмөнх даян хааныг арван долоон насанд нь Мандухай цэцэн хатан биеэ залгуулж, мөн он гахай жилд хаан ор суулгав.

Тэр хутаг гуйсны хүчээр Мандухай цэцэн хатнаас долоон нуган ганц охин төрөв.

Түүний хойно сайн хатан Очирболд, Алчболд хоёр хөл хүнд, есөн сартайд Ойрад довтлов. Түүнд сайн хатан мориноос шилжсэнд Мирахан нь сайн хонгор моринд Барагуу нутгийн Сайн сайхан бөглөж, Балхачны Баян бөх, Асудын Батболд бөх тэр хоёр, хатныг өргөж моринд мордуулаад зугтааж гарав. Нэгэн сар болоод Очирболд, Алчболд хоёр төгс үзэгдэв (ихэр төрөв). Түүний хойно Ал Богура үзэгдэв гэх. Тэдний хойно долуул бүрийг Болд нэр өгвэй.

Асууулт даалгавар:

1. Зохиолын агуулга, үзэл санааг тодорхойлно уу?
2. Мандухай эцэн хатны дүрийг тодорхойлон бичнэ үү?
3. Тангарагийн шүлгийн үзэл санааг тодорхойлон бичнэ үү?
4. Уг бүтээл бичигдэх болсон түүхэн үндэс юу болохыг тайлбарлан бичнэ үү?

Хув нагваралын тууж

... Түүнээс хойно Халхын ХатанБүүвэй баатар бээл баригдаад төр эвдэж, тэрхүү Ядаг ноёны боолд очив. Гэтэл хүүхэн Содном гэгч Халх хүнийг харахтай зэрэг хар бууж, муужран унаж, нэлээд удаад дахин сэхэж Хатан баатрыг харвал хоёр нүдээ буруу хоёр ирэмсэнд хайр дотроо, хал гаднаа гэж мэдээд, түүнээс хойш Хүүхэн Содном тэр хүнд тун ч муу янзтай байтлаа хоол ундны аль сайхныг шилэн өгч байв гэнэ.

Он жил эргэж ижил дасал болж, Хатанбаатар тэр айлын нэгэн зарц хүүхэнтэй ханилсан нэртэй боловч чухамхүү голын хайртай амраг нь хүүхэн Содном байжээ. Хайр дотроо, хал гаднаа гэж санасан хоёр хүн огт мэдэгдсэнгүй байв гэнэ.

Нэг өдөр Хатан баатар хүүхэн Содномд хэлэв гэнэ:

“Чиний заяаны үр энэ зарц хүүхнээс гарна. Тэр юуны тул гэвэл чамд тогтсон хүү бузартай, гэдсэн дотроо солигдов. Тэр хүүг чи авбал чиний заяаны

үр тэр” гэж захив. “Энэ хүүхэн бид хоёрыг ханилсан гэдгийг амьтан бүгд мэднэ. Чи бид хоёрыг үйлийн үрээс өөр мэдэх юм үгүй шүү. Энэ хүүхнээс эр гарвал эд ална. Чамаас гарвал алахгүй нь лавтай. Түүнийг мэдтүгэй” гэж захив.

Түүнээс хойно хоёр хүүхэн зэргээр бие муутай болсонд нэгэн өдөр тэр омгийн баахан улс найрлаж байгаад хэлэлцэх нь: “Энэ зарц хүүхнээс гарсан хүнийг алалгүй болохгүй шүү” гэж нэг хүн хэлсэнд бас нэг нь: “Эр хүн гарвал алах нь зүй мөн. Эм хүн гарвал алах хэрэггүй. Эм хүн сайн ч гэсэн эр цэргийн зэрэгт үл хүрнэ. Эрмэг гүү сайн ч бол эр морины гүйдэлд үл хүрнэ” гэж хэлэлцэж байхыг хүүхэн Содном сонсоод зарц хүүхэнд хэлж гэнэ. “Эд чамаас эр хүн гарвал алах гэж хэлэлцэж байна. Бид хоёрын сар нэг учир Хөнгөрөх цагт чамаас хүү, надаас хүүхэн гарвал солилгүй болохгүй болов гэгчийг мэдэв үү?” гэж захив.

Хойно нэг өдөр Ядаг ноёныг анд мордсон завсарт хоёр хүүхэн зэрэг мэндлэв. Зарц хүүхнээс хүү гарахдаа Үржих Өөлдийн үрийг тасална” гэж гарав. Хүүхэн Содномоос хүүхэн гарав. Хоёр хүүхэн хүүхдээ солин авч хөхүүлэн.

Ядаг ноён хээр газар явж байтал, гэв гэнэт муу совин татаж, яаран гэртээ ирвэл зарц хүүхэн тосон ирж, “Хатан мэндлэв. Их баяр” гэсэнд “Хүү юу? хүүхэн үү? Юу хэлж гарав” гэж асуухад “Үхэр Халхын үрийг тасална” гэж гарах юм байна. Хүү, хүүхний алин болохыг огт мэдсэнгүй” гэхэд яаран орж үзээд: “Хаашаа нүдэнд хүйтэн тархи вэ? Халхын хув харуудтай яасан адилхан юм бэ? Авдарны араас саран зэвтэй сум аваад аль. Хүнсний нь нүхээр хатгаж алья” гэсэнд хүүхэн Содном хэлэв: Та Халх уу, би Халх уу? Өнөөх цэцэн саруул чинь яасан билээ. Хүн өөрийн үрийг хүсдэгийг бүү хэл, хүний үрий, ч хүсдэг билээ. Өөрийн үрийг өөрөө алахад тэнгэр дэлхий зөв бурууг ялгах үгүй юу? Ер эхээ алаад, махыг чанаж суусан хүн газар цөмрөөд далд орог гэдэг. Тэнгэр газар гэдэг юун айхавтар юм бэ? Би айж байна гэж хэлснээ мартав уу?” гэж асуухад “Харин тийм ч юм байна. Хэлж гарсан үгийг нь санавал хувьтай үр заяасан байгаа. Ай Нагварал гэж нэр өгье гэсэнд Хув Нагварал нэртэй хүүтэй болоод байв гэнэ.

Хатан баатрыг үзсэнээс хойш хүүхэн Содном туж асгартал уйлаад байх болов.

Нэгэн өдөр гэрийн эзэн Ядаг ноён, хүүхэн Содномоос ийн асуув: “Чи энэ баригдаж ирсэн муу хүнийг үзсэн цагаас хойш үргэлж уйлсан мэт байх нь сэтгэлд чинь юу орсон билээ. Тэр шалтгаанаа над нуулгүй хэлэх хэрэгтэй. Чи бид, хоёрын эр эм болсон нь эртний заяа биш үү?” гэсэнд хүүхэн Содном маш их инээгээд “Харин миний ойлд орсон үг нэгийг хэлэв. Та юун цэцэн сайхан ухаантай билээ. Үрж болшгүй үнэн амраг, хагацаж болшгүй хайртай таныгаа, утсан чинээ улаан голы чинь тасравч хайртай тэргүүний чинь нэгэн хоёр илж тавина. Харин энэ ирсэн хүн чинь аль газрын юун муухай хүн бэ? Та бол эр хүн, ан гөрөө, ажил төрөл тэргүүтэн эр хүнд элдэв явдал байдаг, үүрд эхнэрээ сахин сууж болохгүй учраас эзгүйд чинь эм хүн намайг элэг доор барьж, элдэв зан гаргах магадгүй гэж санасандаа айж хоол, ундны аль амттай сайныг өгдөг учир тэр билээ” гэсэнд: “Ээ хөөрхий миний хүүхэн учрыг мэдэхгүй байна. Би нарийн хэлж өгье.

Энэ бол зүүн зүгт Халхчууд гэж ийм муухай улс байдаг, түүнээс баригдаж ирсэн хүн. Энэ газарт гурван удаа дайтаж эрийн сайныг шилэн алж явсан хүн. Эр хүний эндэл болж баригдсанаас биш эрийн чадал гачигдаж баригдсан хүн биш. Эрийн чадал тэмцье гэвэл манай таван омгийн улс эмс хүүхэдтэйгээ мордовч энэ хүний эрхийд үл хүрнэ. Өнөөх манай омгийн Хасбаатар хуурч бариад, дээс олсоор ногтолж, төмөр гинжээр гинжлээд, эхнэр хүний дээл өмсгөөд, дэлэм хэртэй төмөр гадас шааж, түүнээс уяад байж байтал, эдний Халхын Шархүү бүргэд гэгч хурдан шарга морьтой хуй шиг дайраад шүүрсэн нь хайш хайшаа хотын буйрын хэр газартай ховх татан аваад дутаасанд энэ өөрөө хэлж гэнэ билээ:

“Чи намайг авах хэрэггүй энд орхи. Эд намайг алахгүй биз. Их бодож нэг ноёны боолд өгөх биз. Би энд зүтгэж яваад үхвэл хойтын хүнд хэрэгтэй. Эр хүн нэгэн санаатай явж байвал эрийн чадал сайжирч, эрдэм билиг нэмэх, элдэв олон санаатай явж байвал эрдэм билиг мохож, элдэв явдалд зориггүй болно” гэж хэлээд өөрөө баригдсан хүн гэнэ билээ. Тиймийг үзвэл энэ сайн эр биш үү. Эмс охидоор үл оролдоно. Үүнээс хойш эмээх хэрэггүй. Харин чи үүнд унд хоолны амттай сайныг өгөх нь ямар санаатайгаар тэгж байгаа билээ хэл” гэсэнд Хүүхэн Содном хэлэв: “Та ийм сайхан сэргэлэн ухаантай хүн атлаа доорд муу эм хүнээс ийм үг асууж болох уу? Эм хүн сайн ч бол эр хүний чадалд үл хүрнэ. Эрмэг гүү сайн ч бол эр морины гүйдэлд үл хүрнэ гэгч хуучин үг бий. Тиймийн тул энэ мэтийн бэрхээс айж, арга бодож ая тал засаж ажил төрлөө хийлгэхэд аль сайн хоол ундаар аргадан хуурч байвал түүнд урамшин баясах бөгөөд аливаа үйлс бүтэмжтэй сайн болох болов уу? гэж унд хоолны аль сайн, сайхныг өгөх учир тэр билээ” гэсэнд: “Энэ чинь мөн. Харин чиний нас бага атал яаж санав. Чи одоо үүнээс хойш аль сайн унд, хоол өгч байгаарай” гэж хэлэв.

Түүнээс хойно нэгэн өдөр Ядаг ноёныг гөрөөлсний завсарт Хүүхэн Содном Хатанбаатарт ийн айлтгав.

“Ай Халх дахины наран адил асралт тэнгэр эзэн ноён таны алтан өлмийн дор сөгдөн мөргөж, энэхэн чөлөөнд хэдэн зүйлийн гомдлоо айлтгая. Тэнгэр эзэн ноён анхааран өршөөн толилж, сонсон соёрх” гэсэнд “За чи хэл, би нарийн дуулъя” гэхэд хүүхэн Содном хэлэв:

Миний эх үхээд өчүүхэн би арван настай өнчин хүүхэд өвгөн эцэгтэйгээ хоёул Халх, Харчин хоёр нутгийн цав болох Өлөн зовхистой гэдэг газар нутаглан сууж байтал гэнэт нэгэн өглөө эрт Өөлдийн айх мэт хэдэн хүн ирээд өвгөн эцгийг минь өрлөн алж, өнчин намайг хүлэн авчирч, арван настай, ертөнцийн явдал огт мэдэхгүйн дээр эцэг эх, ах дүү, амраг садангүй харь ганцаар хариугүй нялх намайг эмээ хийхээр авчирсан гээд эмээ болгон доромжилж, өдөр шөнө хоёр огт ухаангүй муужран хэвтээд арай үхсэнгүй нэг сэхвээс “Чи намайг ганцхан тачаахад башир гаргаж өдөр шөнөөр хэвтэв, эм хүн эр хүний эрхэнд байдгийг мэдэхгүй юун мунхаг эм бэ?” гэж уурлан өргөстэй хар модоор толгой дундуур олон удаа жанчиж байхад айх, өвдөх тэргүүтэн цаглашгүй бөгөөд арга буюу муу эм тийм зовлон эдлэх заяатай юм гэж боддог байв.

Хойно нэгэн өдөр ганцаараа сууж дотроо ийн санав: “Халхын хүний үр агсан билээ би. Тийм байтал энэ муу Өөлдийн гарт орж, өвгөн эцгээ өрлүүлж

алуулаад, өөрийн биеийг хэтэртэл доромжлуулж байгаагаас үзэхэд энэ хүн намайг хайх мөргүй, хамгаалах садангүй хариугүй өнчин гэж тавлаж байна. Ай халаг хухай минь ийм орхисон заяа бол” гэж санаад би Халхын нэгэн хүний барааг харах цагийг энэ амьд насандаа үзэх болов уу? гээд мэлмэртэл уйлан суутал, гэнэт нэгэн бадарчин орж ирээд “Ай идэр залуухан настан охин чи ийм жаргалтай сайхан оронд сууж байгаад аяндаа асгартал уйлах учир юу вэ? Би энэ нэгэн насыг барагдтал гуйлинчлан явган тэнэж явна. Надтай адил зовлон үзсэн биш, эрх дураар сууж уйлах хэрэггүй” гэсэнд миний хэлсэн үг:

“Ах та намайг зовлон үзсэнгүйг яаж мэдэв. Та хэдий явган тэнэсэн боловч өөрийн дураар явсан биз. Бусдад албадуулж яваагүй биз дээ. Та сонс, би нэгэн үг хэлье. Зовлон зовлонгийн дотроос сэтгэлийн зовлон хэцүү гэдгийг та мэдэх буй заа. Бусдын эрхээр жаргааар өөрийн дураар зов гэдэг юу гэсэн үг вэ? Үнэн үг үү? Худал үг үү? Та олон газар явж их, бага хүнтэй учирч, элдэв жаргал зовлонг үзэж сонссон хүн байна. Надтай адил гэрийн боол мунхаг эм бус гэхээр үл барам ах их хүн та өчүүхэн миний асуусан үгний чигийг зааж, хариуг тайлж хайрла” гэхэд тэр бадарчин хэлэв: “Ай чи юун цэцэн саруул ухаантай охин бэ? Би их олон газар явж, олон хүнтэй уулзсан боловч ийм үгийг эс сонслоо. Чиний энэ үгний хариуг би хэлж огт мэдэхгүй. Аймгийн ховыг бадарчин, айлын ховыг хүүхдүүд зөөх гэгчээр би чамд нэгэн хов хэлье.

Халхын Хатанбаатар бээл гэгч дайнд баригдаад танай энэ ноёны боолоор ирэх нь гэж би сонслоо. Чиний энэ үгний хариу ба чигийг тэр хүн тайлж, замыг зааж өгөх биз дээ. Түүнийг ирсэн хойно Халх зүгийн үг туршиж үл болно. Хэрэв туршвал та хоёрын гэм болно. Олны дотор дайсан мэт, онц ганцаар байхад зэндмэнэ мэт хүндэлж байвал чиний заяа тэр тэнгэр мөн болно. Тэр хүний хүчээр Ар Халх нутагт хааны суудлаар жаргах цаг ирнэ. Тэр цагт их баяраар уулзъя. Би Амдо газрын нэгэн бадарчин. Миний явсан газарт Ар Халхаас тэгш сайхан газар үгүй байна. Ер яасан их шашин дэлгэрэх бол. Ямар их хувьтан улс тэнд суух бол. Одоо би явган хүн тул миний үг олдов. Би явъя” гэхэд Хүүхэн Содном их өргөл өргөж, унд хоол ханатал цадтал өгч “Өршөөлт бурхан тантай энэ өдөр учирч ийм их баяр болдог аж” хэмээн мөргөөд “Хожим шажин их дэлгэрсэн оронд шар магнаг олбог дээр заларч байх цагт чинь уулзахын ерөөлийг тавья. Сайн яваарай” гээд хол үдэж өгөөд буцах гэтэл тэр бадарчин хэлэв:

“За одоо буц? Намайг хол дагах хэрэггүй. Чиний гэрийн эзэн чамайг дахин зовоох явдлыг хийж чадахгүй. Чи бэрхшээх явдал олоо үгүй биш үү” гээд явав гэж яриу.

Түүнээс хойно нэгэн өдөр Хатанбаатар Хүүхэн Содномд хэлэв:

“За хурц мэргэн ухаантай хатан суудалтай чамдаа гэрээс болгон хэдхэн үг захьсугай” гэсэнд Хүүхэн Содном “Тэнгэр ноён таныхаа зарлигийг орой дээрээ хичээж хадгалсугай” гэсэнд Хатанбаатар ийн хэлэв:

Энэ хүүгээ есөн нас хүрэхтэй зэрэг бичиг сургуульд өгч сайтар сурган болвсруулаад арван гурван насан дээр нь энэ бичгийг гаргаж үзүүлээрэй. Түүнээс хойш та хоёрын жаргах цаг ойр болно. Зовж уйдах хэрэггүй” гээд нэгэн хуудас бичгийг өгөөд удалгүй Хатанбаатар тэнгэр дэвшив.

Хүүхэн Содном маш ихэд гашуудан уйлах бөгөөд хүүгээ хайрлан янаглаж, Хатанбаатарыг санан мөрөөдөж, хэдэн жил болсон хойно хүү нь

өсөж, бичиг эрдэм сурав.

Тэр хүү эцэгтээ Ядаг ноёнд үнэн амраг сайн бөгөөд эхдээ үнэн муу янзтай байх учир түүнд Ядаг ноён маш хайртай болж, “Энэ хүүхэд чухам миний заяаны үр ёстой мөн байна” гээд эрийн эрдмийг үнэхээр маш сайнаар сурган боловсруулж байв. Хүү харвал намнал эрдэмд онц үлэмжхэн сурч гайхагдан “Ядаг ноёны эрхэм сайн заяаны үр магад мөн Эх нь Халхын хүн бөгөөд үр нь ч бол эхээ уг муутай Халх гэж мэдээд тийм муу байдаг байна” гэж хэлэлцэн байв гэнэ.

Хойно нэг өдөр хүү арван гурван нас хүрч аль бүрийн эрдэм тэгш эр хүний зэрэгт орж явах болов. Бас нэг өдөр Ядаг ноёны эзгүйд Хүүхэн Содном гэрт ганцаар сууж байгаад “Би амьд насандаа Халхын нутагт очих заяа буй буюу, үгүй буюу. Чухам тэнгэр эзэн ноёнтон минь хайрласан үр ч бол надад ийм муу байх нь орхисон заяа бол” гээд уйлж суутал, хүү нь гаднаас орж ирээд асуув: “Ачит ээж минь юунд уйлав. Би өстнийг өвөр дээрээ суулгаж ачтаныг ардаа суулгаж явсаар өнөө арван гурван нас хүрлээ. Одоо өстний өсийг хариулж өрлөдөг, ачтаны ачийг хариулж аврах цаг тулгарав. Ээж минь юу санаж байна” гэж асуувал Ээж нь: “Энэ зэргийн үгийг санах ч байтугай энэ Өөлдийн гараас мултарч гарах цаг амьд насанд байх болов уу? хэмээн санадаг билээ. Харин тэнгэр эзэн ноён чинь чиний арван гурван насан дээр авч өгөөрэй гэсэн нэгэн хуудас бичиг бий билээ. Түүнийг авч үзүүлье” гээд авдраа нээж алтан хайрцаг дотроос тэрхүү бичгийг авч өгөв.

Тэр бичгийг үзвээс үг нь:

Зээрэн чихтэй цавьдар чинь зэгс болно
Зэвэн чихтэй бор чинь дэрс болно
Бүдүүн нарийн адил
Цавьдар морь чинээтэй
Бор морь чимэгтэй
Өдөр балар
Шөнө тодорхой
Их хар, бага цавч
Салхины зөв бурууг сар ялгадаг гэж мэд
Арван таванд үйлдэв” гэжээ.

Үүнийг хүү үзээд “Юун сайхан зарлиг билээ. Юутай жигтэй сайхан юм бэ? Одоо миний сэтгэл сэргэв” гэхэд эх нь бичгийн үг юу гэсэн зарлигийг ээждээ тодорхой хэл гэсэнд:

“Зэгс, дэрс гэгч гүйцэд сайн хагсаа гэжээ.
Бүдүүн нарийн адил гэгч унд хоол хоёрыг тэнцүүл
Цавьдар морь чинээтэй гэдэг нь өөрөө уна
Бор морь чимэгтэй гэдэг нь эхдээ унуул гэжээ
Өдөр балар гэдэг нь өдөр бүү яв
Шөнө тодорхой гэдэг нь шөнө яв
Их хар, бага цавч гэдэг нь битгий унт
Салхины зөв бурууг сар ялгадаг гэсэн нь
Саран зэвтэй сум сайн эрд нөхөр болно гэжээ
Арван таванд үйлдэв гэдэг нь арван таван насан дээрээ
Орон нутагтаа харьцгаа гэсэн утга гэжээ

Ай юун сайхан зарлиг вэ? Энэ өдөр миний их баяр болдог аж. Сэтгэл минь сэргэв. Одоо та бид хоёрын муугийн сүүл, сайны эх ойртсон гэдгийг ээж, минь мэдэв үү? гэсэнд эх нь: “Ачит сайн үрийн минь алтан зарлиг бат орштугай” гээд мэлмэртэл уйлав.

Хүү “Ээж минь уйлах хэрэггүй. Тэнгэр эцэг ноёны буян сүлдээр Халхын нутагт очиж жаргах нэгэн цаг бий. Одоо их уйлах хэрэггүй. Үүнээс хойш хоёр жил болох тун ч холгүй биш үү” гэхэд эх нь: “Ер нь тийм ч хэрэг биз. Зоволтгүй юм байна” гэв.

Түүнээс хойш хүү нь арван таван нас хүрэх цаг ойр болохын хэрд цавьдар, бор хоёр морио бусдаас нуун уяж, хоёр сар шахам хагсааж, чухам амьтанд гүйцэгдэхгүй болохын хэрд нэг өдөр эцэг Ядаг ноёнд хэлэв:

“Өчүүхэн хүү чинь арван таван нас хүртэл алиа найдангуй зангаар наргиж, архи дарс ууж үзсэнгүй билээ. Энэ өдөр ойр, хавийн улсыг урин авчирч бяцхан найрлавал болох уу?” гэж эцэг Ядаг ноёнд хэлсэнд “болно” гэв.

Нэгэн хүнийг зарж бяцхан улсыг урин ирүүлж, нэгэн өдрийн ихэнх хагас хүртэл найрлахад эх хүү хоёр уусан мэт хуурмаглан байж, бүгд улсыг согтоож, унахын хэрд хүү эхийгээ, урьдаар мордуулж, газар болзож явуулаад өөрөө сүүлд нь нум, сумаа агсаж мордоод, саран зэвтэй сумыг онилон татаж хөндөлдөн зогсоод ийн хэлэв:

Ай Ядаг ноён!

Хүний хүү газар нутагтаа харьдаг

Хөлгийн хүү газраа таньдаг

Халхын хоёр ч харьдаг

Хар дотортой Өөлдүүд ч хоцордог болж

Сайхан хөлөг морины дээр сайн эр мордоод

Саран зэвтэй сумыг сарвайтал онилон татахад

Санаа муут Өөлд чамд сарвайх чадал байна уу?

Хөлөг сайхан морин дээр хүний хүү мордоод

Хүчит сайхан нум сумыг хүчлэн татахад

Хүйтэн санаат Өөлд чамд хүрч ирэх чадал байна уу?

Санамсаргүй алдаж хоцрох гэгч энэ биш үү?

Эр хүний санаа энэ адил гэгчийг эгнэгт санаарай

Үржих муу Өөлдийн үрийг үүрд тасална бий вий

Өвгөн эцгийн өсийг хариулна бий вий

Өөрийн эхийн тавыг хангана бий вий

Өдөр шөнөгүй сайн сэргийлж байгаарай

Би ч хичээж ирэх магадгүй гэж бодоорой

Халхын хоёр хүнийг

Харах мөргүй хайх бараагүй алдах гэгч нь энэ гэж мэдэв үү? гэж хэлээд хангинатал дуулж, жингэнэтэл исгэрээд хатируулсанд Ядаг ноён нөхдөдөө хэлэв: “Энэ хэрэг тэр чөтгөр эмээс үүсэж гарсан хэрэг биш үү? Энэ гайхлыг урьд гарахад нь үзвэл даанч нүдэнд хүйтэн толгой цусдах шинжийн тархи харагдсан тул алах гэхэд тэр галзуу тулам эм элдэвлэж байгаад эр хүний зоригийг эвдэж, алуулсангүй билээ. Одоо санавал Хатанбаатарын хүү холиогүй мөн санж. Үхэр Халх өмхий санаатай болоод, он жил удавч огт мэдэгдсэнгүй. Нөхцөсөн гайхлууд санж. Халх гэж хаана ямар улс байдаг юм

бэ? гэж надаас асууж байсан чөтгөр биш үү? Эм хүний дотор тогооны хөө хоёр адилхан гэж үүнээс хойш мэдье. Арван настай байхад нь алахын зай байсан юм сан. Тэр чөтгөр эмд хамаг учир байсан хэрэг байна. Тэр эмийн арга баширт хууртаж, энэ хэдэн омгийн улсыг Халхын гарт сөнөөхийн хэмжээ болов” гэж хэлээд толгойгоо салаавчлан гэдэргээ хэвтэв.

Тэндээс хүүхэн Содном, Хув Нагварал хоёр өдөр бүгээд шөнө довтолгосоор явж, Халхын нутгийн захад наран гарахын сацуу орж явтал, баруун хойт этгээдэд нь нэгэн баян байдалтай айл харагдахад хүү хэлэв: “Ээж минь энэ айлд буух юм сан. Мэдэлгүй өнгөрлөө” гэсэнд эх нь хэлэв: “Буцаж очоод бууя. Халхын айл байх магадгүй. Харин наран гарах зүгээс очвол бэлгэтэй сайн байгаа” гэж хэлэлцээд очиж явтал, тэр айлаас цал буурал толгойтой цагаан сахал үстэй, цаглашгүй их настай өвгөн гараад, цайны дээжийг өмнөөс нь өргөөд орвол эх нь хэлэв. “За хүү минь, одоо бид хоёрын явдал сааталгүй бүтэх болов. Таван зүйлээр бүтсэн тансаг идээний дээжийг өмнөөс цацав” гэлцээд, тэдний гадаа очоод “нохой хорь” гэсэнд шар торгон ханжаартай, цэнхэр торгон дээлтэй, тэгшхэн сайхан нуруутай жаалхан охин гарч ирээд нохой хорьж өгвөл гэрт орохын завсарт Хүүхэн Содном тэр жаалхан охины нэрийг асуувал Нэмэхбаяр гэдэг гээд инээмсэглэв. Гэрт нь орвол эхнэр хүүхэд голлож, олон хүн сууцгааж байв.

Бүгдийн мэндийг мэдээд суувал өвгөн нь “Ай бүсгүй таны нутаг хаана вэ?” гэсэнд хүүхэн Содном: “Уг нутаг Өлөн зовхистойд бий. Одоогийн нутаг Онгийн цагаан нуураар байна” гэсэнд өвгөн хэлэв гэнэ: “За хө, Өлөн зовхистой гэдэг бол Халх, Харчин хоёрын нутгийн цав болох газар. Онгийн цагаан нуур гэдэг бол Өөлдийн гол нутаг. Чи хаанахын хүн хаачиж яваа вэ?” гэсэнд хүүхэн Содном хэлэв:

Би угтаа Халхын хүн билээ. Арван насандаа Өөлдөд баригдаж очоод байтал, арван гурван насан дээр манай Халхын Хатанбаатар бээл ноён дайнд баригдаж, миний байсан Ядаг ноён нэртэй айлын боолд очиж, муу эм над хайр өршөөлийг хүртээж хүсэвч олоход бэрх энэ сайн үрийг хайрлаад тэнгэрт дэвшсэн билээ. Өчүүхэн би тэр хүний хайр өршөөлөөр энэ хүүг дагаж, Халх нутгийн захыг өнөө өглөө үзэж байна” гэхэд өвгөн ийн хэлэв гэнэ:

“Ай Халхын Хатанбаатар бээл гэгч чухам ямар янзын байдалтай хүн явсныг чи нарийн тодорхой хэлтүгэй” гэвэл хүүхэн Содном: “Чухам энэ мэт гэж ил тодорхой адилшаах хүн энэ гэрт үгүй тул далдын тэмдгийг адилтгахад ард нь “Ха” үсэг хүйсэндээ “тан” үсэгтэй ноён байсан билээ” гэхэд тэр өвгөний царай хувьсан, нулимс гаргатал тэр гэрий дотор байсан улс цөм уйлан. Хүүхэн Содном ч уйлав. Хун Награвал ганцаараа эс уйлав, Өвгөн “Өдий улс уйлахад, энэ хүү ганцаараа уйлахгүйг үзвэл чухам сайн эр байна. Хатанбаатарын хүү мөн. Сайн эр байна. Ай хөөрхий манай тэр ноён “Ха”, “Тан” хоёр үсэгтэй байсан нь лав үнэн. Тиймийн тул Хатанбаатар гэсэн учиртай билээ, Энэ бүсгүй тэнгэр эзэн ноёны минь алтан жолоог түшиж явсан нь үнэн байна. Одоо энэ хүүд тэмдэг байна уу” гэсэнд тэр хүү дээлээ бэлхэгнэж үзүүлбэл ард нь “Ван” үсэг байжээ. Харин чухам Хатанбаатарын хүү дамжиггүй мөн байна. “Таны нэр хэн гэдэг билээ” гэсэнд “Хув Нагварал гэдэг билээ” гэв. Өвгөн “Ай тэндэхийн үл бүтэх Өөлдийн өгсөн муу ёрын нэрийг энд орхи. Би нэр өгье гээд “Түн ухаант гүнзгий сэтгэлт, чин бат

Ванчин алдар өргөө” гэв. Манай зүүн Боржигинд арван үед төрийн бээл болон үе тасалдалгүй тэнгэр язгуурд суух байна гэж шинжье.

Би Халхын хэрсүү Цэвэг гэгч хэдэн үе ноёдын шинжээнд бараалхаж явав. Чухам төрийг төмөрлөгч өсөх үйзэн цэцэн баатар бээл болох хүн гэж шинжье” гээд түүнээс хойш хүүхэн Содномоос Өөлдийн аж ахуй явдлыг асууж ярилцан хорин хэдэн хоног болтол хэрсүү Цэвэгийн байж байв.

Халхын боржигин бээлийн хошууны түшмэд ардууд манай ноёны хүү гэгч Өөлдөөс босоод Халх нутгийн захад хэрсүү Цэвэгийн ирээд байгаа гэж дам сонсоод нэг түшмэл тэргүүнтэй хоёр баатар удаатай, хорин хэдэн цэрэгтэй мордож тэднийд ирвэл цал буурал сахалтай цаггүй их настай өвгөнөөс эхлэн бүгдээрийн мэндийг асуугаад суувал өвгөн “За хүүхдүүд нутаг хаана вэ? Хайчиж яваа вэ?” гэсэнд нутаг Оцол сансар ууланд байна. Хэрэг зориг энд. Дам сонсвол танайд манай боржигин бээлийн хүү гэж Өөлдөөс босож ирсэн хүү, хүүхэн хоёр байна гэж сонсоод, манай ноёны хүү магад мөн бол залж аваачих, биш бол алах гэж цэрэглэж ирэв. Тэр хоёр хүн хаа байна” гэсэнд өвгөн “Айлд орсон болов уу? Энэ хэр эзгүй байна. Танай ноёны хүү мөн бишийг таньсангүй. Тав хийсэн жаалхан сайхан хүү дагуулсан, тас хийсэн үгтэй гуалаг янзын охин Өөлдөөс боссон гэж ирээд байгаа. Хорин хэд хоноход хоёр этгээдийн явдлыг хэлэлцэж дуусаагүй билээ” гэтэл Ванчин хүү орж ирсэнд түшмэл тэргүүтэй бүгдээрээ босон харайж, сөгдөн амар мэндийг мэдэлцэж, аливаа зүйлийн явдлыг хэлэлцэн “Манай ноёны хүү магад мөн” гээд их баяр болцгоож, ноён боолын ёсоор ёслоод бас Хүүхэн Содномыг авчирч хатан ёсоор ёслон бүгдээр их баяр болж, хамтаар нутагтаа ирж боржигин бүгдээр цугларч ил баярын наадам үйлдэж, манай ноёны хүү, манийг эзлэгч хүн магад мөн хэмээн хэлэлцэж, баяр гомдол хоёрыг хэдэн сар болтол ярьцгааж гүйцсэн тухайд, хотол хошуугаар есөн цагаан бэлэг барьж ёслолыг гүйцээгээд олноор амар тайвнаар жарган суув.

Түүний хойт жил зуны эхэн сард зэрэг залгамжлахаар нийслэл Бээжин хотод очиж, Богд эзэн хаанд бараалхаж, Өөлдийн дайнд эцэг нь баригдсан, эх хүүгийн хамт босож ирсэн явдлыг нэг нэгэнгүй тодорхойлон айлтгасанд богд эзнээс сайшаан шагнаж, төрийг төмөрлөгч өсөх үйзэн цэцэн баатар хэмээн үе улиран тасралтгүй залгамжлах цол хүртээгээд, найман зуун лан цалинтай бээлийн хэргэмээр шагнаж, эхэд нь төрийн үндсийг дэлгэрүүлэгч Тэгш номон Дар гэж цол хүртээж, тэнгэрийн бэр хэмээн хөх нөмрөг, магнаг олбог, зуун тавин лангийн цалин, дай гүн жинс хэргэмээр өршөөн шагнав. Ванчин бээл арван зургаан насандаа бээлийн хэргэм залгамжилж, нутагтаа буцаж ирсний дараа Шинэхэн, Сонихон хоёр баатар тэргүүтэй, шилсэн баахан цэрэгтэй эцгийн өсийг хариулахаар Өөлдийн зүгт мордож, дайтахаар явж очтол Өөлд мэдээд Манхан Манса, Мэлзэн, Молиху гэж гурван омгийн Өөлд Мангас, шуламсыг ч бол дайлан чадах эхлэн алдаг эвлэй баатар, олныг алдаг Онзол баатар, сүүлийг алдаг Сүрьеэ баатар тэргүүтэй гурван омгийн олон Өөлд өдөр шөнөгүй сэргийлж, гурван мянган цэрэгтэй сууж байтал, гэнэт нэгэн өдөр хуучны таних Хув Нагварал тэргүүнтэй, Шннэхэн Сонихон хоёр баатартай шилсэн жанжны цөөн цэрэгтэй очиж. “Өвгөн эцгийн өсийг хариулахаар ирлээ би, хар дотортой муу Өөлдөд хариу чадал байна уу?” гээд хашхиран дайрч хамаг цэргийг бараг үгүй болгон байтал, Өөлдийн гурван баатар дийлдэх

төлөвөө мэдээд, гучин шилсэн цэргийг аван зутвал хойноос нь хөөж бариад Онзол баатрыг олонд цээрлэлийг үзүүлж, олон агтны сүүлнээс уяж, олон хэсэг тасдан алаад, Сүрьеэ баатрыг сүлбэж шорлон алав.

Эзлэн баатрыг энэ Халхад боол хийхээр бариад, цалгих далайн амсарт аваачиж, цавчих мэсний ирэнд тулгаж, “энэ насыг бартал. Эвлэй нэрийг балартал, энэ Халхад хүчин зүтгэе” гэж ам тангарагийг нь авч барин аваад, цааш явж гурван омгийн Өөлдийг шүүрдэж, дагахыг дагуулж, дагахгүйг алаад, хот балгад тэргүүтнийг эзлэн, алив санасан санаа, зорьсон зоригоо цөмийг гүйцэтгээд буцаж ирэх замдаа Энх ноёныд бууж, алив явсан явдлаа бүрэн айлтгасанд Энх ноён “Эвлэйг энд орхи, би хүнд хүчир ажилд зарж байя. Манай ар Халхад маш их авралт Дарнатын гэгээн байгаа болсон хойно Манхан Өөлдийн энэ зэргийн хүү яана аж” гээд авав...

Асууулт даалгавар:

1. Зохиолын агуулга, үзэл санааг тодорхойлно уу?
2. Зохиолын уран дүр, дүрслэлийн онцлогийг тодорхойлон бичнэ үү?
3. Уг бүтээл бичигдэх болсон түүхэн үндэс юү болохыг тайлбарлан бичнэ үү?

Монголын Убаши хун тайжийн тууж

Монголын Убаши хун тайж, уулын хар барс болсон Урианхан сайн Мажиг хоёулаа хангайн Хар булгаас харь дөрвөн Ойрадыг дайлья гэж найман түмэн цэрэг мордож ирэхдээ Налах үхрийн даваа давж, Нал хар бөрөгт найман түмэн цэрэг хүрч ирж, дөрвөн Ойрадын нутагт дөрвөн анги (туршуул) тавьж олж ядаад Монголын Убаши хун тайж, сайн, муу, дунд гурвуулан чуулган чуулаад Урианхан сайн Мажиг эхлэн олон сайдуудад Убаши хун тайж зарлиг болов.

- За залуус сонсогтун!

Дөрвөн Ойрадын зах нь нутагтаа ирсэн дайсанд холч морь, хоточ нохой мэт тарамдаж үл олддог биш үү? Дөрвөн Ойрадод хэлүүлээд харивал ямар вэ? Та залуус минь. Санасан санаа энэ байна. Үүнийг зөвшөөрвөл харья. Буруушаавал явъя гэж хэлэв.

Убаши хун тайжын энэ зарлигийн хариуг уулын хар барс болсон Урианхан сайн Мажиг урагшлан суугаад, Убаши хун тайжид мэдүүлжээ: Ноёны зарлиг зөв боловч Монголын Убаши, Урианхан Мажиг хоёул, Хангайн Хар булгаас харь дөрвөн Ойрадыг үзье гэж цэрэг мордож ирэв гэхийг харь халуун, ойр хол цөм сонссон билээ. Одоо малын барааг үзээд айж зулж харивал үрийн үрд муу нэр сонсдох биз ээ ноёд гэв. Монголын сайн, муу, дунд гурвуулаа үүнийг зөвшөөгөөд Убаши хун тайж зарлиг болгов. Дөрвөн Ойрадын нутаг өмнө ч байна, хойно ч байна, хаана гэж явна та? гэв.

Урианхан сайн Мажиг: Ноёны зарлиг зөв. Дөрвөн Ойрадын нутаг их боловч нэг тивд хамт байдаг. Найм хоногоор больё, нарийнаар хайлгая, нааш цааш явах газрыг би заая гэв. Найман түмэн хүнээс даяар мэддэг хоёр зуун залууг гаргая, бум зургаан түмэн агтнаас дөрвөн зуун морь гаргая, миний заасан газраар явж хайтугай. Оловч эс оловч найм хоноод иртүгэй гэв. Цугаараа үүнийг зөвшөөгөөд хоёр зуун туршуулыг уулын хар барс

болсон Урианхан сайн Мажиг дагуулж гараад цэргийн захад Хар уулын оргил дээр гарч хоёр зуун туршуулдаа Дөрвөн Ойрадын нутгийн зүгийг зааж өгөв. Энэ зүгт явагтун. Өмнө чинь Эрчис мөрөн харгана (тааралдана). Эрчисийг уруудагтун. Дээд бие нь хар мод, доод бие нь шар хулс, тэр хоёрын завсарт Маань гэдэг гатлага бий түүгээр гатлагтун. Тэр талаар нь өөд уруу хайгтун. Түүнд юм эс олдмогц түүнээс өөдлөс гээд эгцдээ гарагтун. Маргааш асгандаа (орой нь) ус ууж амрагтун. Эмээлийн адаг, Шар хулс гэдэг намаг булагтай хар уул болно. Түүгээр явж хайгтун. Түүнд юм эс олдмогц тэр ууланд шадархан ирж тасардаг Бачи, Гинжил хоёр голын эхэн ирдэг, түүгээр хайгтун. Энэ гурвууланд юм эс олдвол харьж ирэгтүн. Чадвал та хэл барьж ир. Ядвал үзэж ир.

Оловч, эс оловч найм хоногт бүтээгээд маньд ирэгтүн. Би цэрэгтээ харья гээд харив. Тэгээд Мажигийн захисан ёсоор Монголын туршуул Эрчисийн Мань гатлагаар гатлаад тэр талаар нь өөд уруу хайвч нутаг эс олов. Эмээлийн адаг, Шар хулсаар хайвч нутаг эс олов. Бач хинцэлийн эхээр хайж явтал хэв бүстэй, хилэн оймстой долоон настай, гунан халтар морьтой хүү тааралдав. Тэр хөвгүүнийг өглөө хөөгөөд үдэш гүйцэж барив. Хоёр зуун туршуул дундаа авч суулгаад учрыг асуув.

- Хэний хүү вэ чи? Юу хийж явна чи? хэл! Хөвгүүн гэв

- Би Байбугас хааны албат билээ. Есөн цагаан тэмээ хайж явлаа би гэв.

- Дөрвөн Ойрад цэрэгтэй юу, цэрэггүй юу? Нутаг нь хаана байна гэв.

Хүү хэлэв:

- Таныг сурж ир гэсэн биш барьж ир гэсэн биш үү? Үгийг ахмадад нь хэлдэг, дээлийг захаар нь өмсдөг биш үү. Амьд хүргэгтүн намайг. Амаараа хүрч мэдүүлье гэв. Хөвгүүний үг энэ.

Засаж дуу гаргаж ядаад

Зандаж үг сурч ядаад

Айлгаж ч ядаад

Аргадаж ч ядаад зөвшилдөв. Биднийг сурч ир гэсэн биш барьж ир гэсэн билээ. Үүнийг амьд хүргэе гээд аваад харив. Дөрвөн Ойрадын занг мэдүүл гэж хоёр хүн илгээв. Дөрвөн Ойрадын газраас долоон настай хүү барив. Мэдээ нь энэ гэв.

Монголын Убаши хун тайж эхлэн олон сайн муу, зунд гурвууланд үүнийг хэлж байтал хүүг авч ирэв. Хөвгүүнийг хатуу үгтэй хүү гэхийг сонсоод найман хөлтэй зандан ширээн дээр илд сугалаад тавив. Убаши хун тайж найман тэрэмтэй, барсын арьсаар бүрхсэн хош өргөөнд долоон настай хөвгүүнийг авч ирэв. Хоёр гарыг нь ард нь хүлж, найман хөлтэй зандан ширээн дор сөгдүүлж суулгаад, баруун өвдгийг нь уулын хар барс болсон Урианхан сайн Мажиг дарж, зүүн өвдгийг нь Баахан цэцэн дарж суув. Убаши хун тайж хөвгүүний үгийг сурахдаа:

- За исэл хөвгүүн үгээ хэл гэв.

- Дөрвөн Ойрад цэрэгтэй юу, үгүй юу тэд юу хийж байна хэл гэв.

Тэгмэгц хөвгүүн Убаши хун тайжид мэдүүлжээ.

Ноёд айлгалгүй сурагтун

Алдал үгүй мэдүүлье

Хохимнол үгүй асуугтун

Хоцрол үгүй мэдүүлье
Дөрвөн Ойрад зарааны ус хөрөөний шүд болж
Бат дөрвөлжин болж
Байнга цуг байдаг
Мэдсэнээ мэдүүлье
Эс мэдсэнийг мэдүүлж болохгүй гэв.

Убаши хун тайж хөвгүүний тэр үгэнд боогдоод Ойрадын наад захад хэн байна. Цэрэг нутаг алиныг ч хэл гэв.

Хөвгүүн мэдүүлэх нь:

Ойрадын наад захад
Тож мөнгөн дуулгатай
Товруут улаан хуягтай
Торгон сайхан хүрэмтэй
Толбот цоохор морьтой
Мангуудын хөвгүүн сайн Сэртэнг
Хоёр мянган залуугаа дагуулж
Хоёр мянган жадаа хатгаж

Хоёр мянган морио сойж
Дайрах гөрөөс хаана байна
Дайлалдах дайсан хаана байна
гэж
Шүдээ хавирч шүлсээ залгиж
сууна

Ноёд түүнд дур чинь ямар байна.

- Исэл тэр чинь гайгүй түүний цаана хэн байдаг вэ хэл гэв.
Эрчис голын эхэнд буугаад
Эрчин Харчин хоёр нутгаа цуглуулж
Хар нумын цагаан илэг мэт
Хамгаас илэрч хойт Исэлбайн сайн Хиа
Дөрвөн мянган залуугаа дагуулж
Дөрвөн мянган жадаа хатгаж
Дөрвөн мянган морио сойж
Үхэлдэх дайсан бий билүү
Үгцэх залуу бий билүү гэж
Шүдээ хавирч, шүлсээ залгиж сууна

Ноёд түүнд дур чинь ямар байна гэв.

- Исэл тэр чинь гайгүй түүний цаана хэн байдаг вэ хэл гэв.
Олон сүрэг хонинд довтолсон
Оготор хөх чонын хэвтэй
Өнжин юм идээгүй
Өлөн бүргэдийн нүдтэй
Зүүн гар Хотгойдын ноён Хар хул
Зургаан мянган хүнтэй тэр хэвээр байдаг

Ноёд түүнд дур чинь ямар байна гэв.

- Исэл тэр чинь гайгүй түүнээс цааш хэн байдаг вэ хэл гэв.
Нарийн голын эхэнд нарийхан шарга морьтой
Найман мянган цэрэгтэй
Урд голын бэлчирт
Ойрадын сайн Тамна баатар
Тэр хэвээр байдаг

Ноёд түүнд дур чинь ямар байна гэв.

-Тэр чинь гайгүй түүний цаана хэн байдаг вэ хэл гэв.

Алах булаахдаа дуртай
Арван барсын дуутай
Айхавтар таван барсын ах
Хошоод Байбугас хаан
Түмэн зургаан мянган залуугаа дагуулж
Арван таван тэрэмтэй
Алаг байван өргөөндөө
Дөрвөн Ойрадын
Төр шашин хоёрын хөөнөж
Дөрвөн зүг надтай адилтгах хүмүүн үгүй буй за гэж
Амаа ангайж
Алгаа сарвайж сууна гэдэг
Бие минь муу хүний хөвгүүн би
Нас минь долоо
Дөрвөн Ойрадыг эргэсэнгүй би
Ойрадын хөвгүүд дөрвөн зүгт бий
Миний мэдэх энэ гэв

Тэгээд Убаши хун тайж тэр хөвгүүнийг авч гарч туг тахь гэв.
Хоёр хүмүүн авч гартал, ноёдод үг мэдүүлнэ гэв. Дахин суугаад исэл
хөвгүүн үгээ хэл гэв. Хөвгүүн хэлэв:

Монголын сайн Лайхар хан, Дөрвөн Ойрадын Сайн ноён хоёр
Эмээлийн адаг, Шар хулсанд байр хийгээд эвлэж эелдээд харихдаа
хөөрөлдөв гэж эс хэллүү. Хэл барьсан хүнийг хэлүүлэн байж алдаг
болж хэмээнэ хэл тасарч хоцоръё гэж андгайлалцсан бишүү?

Хэлэлцсэн үгээ мартаж
Хийсэн сайн андгайгаа зөрчиж
Намайг юунд үхүүлнэ та
Нас минь долоо
Муу хүний хөвгүүн билээ би
Амийг минь хайрлагтун ноёд оо гэв

Убаши хун тайж хариу зарлиг эс болж басам хөвгүүнийг хоёр хүн
авч гартал, Ойрадын занг мэдүүлнэ гэв. Хэл хөвгүүн гэв.

Алах булаахад дуртай
Айхавтар таван барсын ах
Хошоод Байбугас хаан хэлнэ гэдэг билээ
Убаши хун тайжийн харцага ясыг дэрлүүлэн
Хар цусыг нь асгаруулж
Хар тугыг нь хамгийн өмнө хугачин орхиод
Урин хайрладаг Дарь хатантай нь нийлж
Цусан улаан хацрыг нь үнсэж
Цуутай цагаан биеийг нь тэвэрч
Ардай цагаан арвинд нь
Арван хар савраа хүргэж
Будмал улаан хацарт нь
Буянт сайхан сахлаа хүргэж
Буян хишиг хоёрыг нь эзлэв

Эрт бамбадаас авсан гянт болд илдээрээ

Хатааж хийсэн хар болд тулгаа

Гал гартал цавчив тэр үгийг та санахгүй байна уу? гэв. Тэгээд хөвгүүнийг авч гараад туг тахих болов. Монголын дотроос туг ерөөх хүн эс гарч, тугийн эзэн би болов, би ерөөвөл ямар вэ гэж хүү хэлэв. Хүү сайтар ерөө гэв. Би ч сайтар ерөөе та ч сайтар сонс гэв.

Хайрхан дайчин тэнгэр идэж уугтун

Убаши хун тайжийн хар цусыг асгаруулав

Харцага ясыг дэрлүүлэв

Хар тугийг нь хамгийн хаалганд хугачин хаяв

Хайрладаг Дарь хатныг нь

Хамгийн эзэн Байбагус авав

Урт хар туг нь Ойрадын хөлд хугаран хоцров

Унадаг орог шаргал морь нь

Улаан торгон цулбуураа

Унжуулаад явсныг

Ойрадын нэг хөвгүүн жалганаас

Жадаараа өлгөж аваад унаж явах болтугай

Бачи голд балбартал цохиулаад

Хөдөө талд хөмөртөл чичүүлээд

Эмээлийн олон толгойтод

Элэг бөөрөө авагтун

Хадай голын эхэнд хайр яйр цохиулагтун

Булагт хөндийн адагт

Бут няц чичүүлэгтүн

Буян хишиг хоёрыг чинь

Ойрадын хөвгүүд авах болтугай

Өндөр ууланд хүрээд

Өнхөрч унах болтугай гээд хөвгүүний амь тасрав. Тэгээд Монголын цэрэг тэр хөвгүүний үг үнэн, худал ямар боловч муу ёр болов, энэ юу болов гэж их зовов. Тэгэвч Монголын сайн Убаши хун тайж дайнаас зулж харив гэх муу нэр сонсохын оронд сайдах муудах алин боловч яван байж хэрээ мэдье гээд явав. Эрчис гол гатлаад, Эмээлийн адаг, Шар хулсаар яваад Бачи Хинцэлийн эхэнд очиж тэнд найман түмэн цэрэг бууж байгаад арван гуравтайгаасаа гучин долоо хүртлээ дайны хөлд эндүүрч үзээгүй баахан Боловсоныг начин халтар морьтой нь Дөрвөн Ойрадад хоёр хоногоор болзоод туршуул тавив. Убаши хун тайж хуш ачсан худан цагаан тэмээгээ үхүүлээд залуусаа ирүүлээд магтаалын үг хэлж өгөв. За, усанд ордог сэрхийн эвэр болсон

Уулгалан дайрдаг

Улаан морины минь чих болсон залуус минь сонс!

Хар мөртэй хөвгүүний хараал тэр бишүү

Харь дөрвөн Ойрадын занги тэр бишүү

Хар хөлсөө бүү хайрлагтун гэв

Залуус ноёндoo мэдүүлэв

Хэзээ ч асгах цус байна

Хээр хэвтэх яс нэг
Ноёны үйлээс урвахгүй бид гэж
Хүрчигнэсээр гарч одов

Тэгээд баахан Боловсон эргээд Дөрвөн Ойрадын зангийг Убаши хун тайжид мэдүүлжээ.

Дөрвөн Ойрад зарааны үс болж
Хөрөөний шүд болж
Дөрвөлжлөн хамт байна

Манийг айсуй хэмээгээд сэргийлж байсныг мэдсэнгүй би. Ойрадын занги энэ гэв. Убаши хун тайж зарлиг болгов.

Дөрвөн түмээр уулгач хийгээд
Дөрвөн түмээр их хийгээд
Ойрад руу явбал ямар вэ хэл чи гэв
Баахан Боловсон мэдүүлэв:

Дөрвөн Ойрадтай байлдаад өглөө зугатаавал хөл гарах бид, үдэш зугатаавал толгой тасрах бид гэсэнд Убаши хун тайж цухалдаад үнэн худал боловч чи хайран залуусын минь зүрхийг шантруулах үгийг хэлэв гэж урьдах хөвгүүний ёсоор болго гэв. Баахан Боловсон начин халтар мориор арайхийн зугатааж гарав.

Тэгээд Убаши хун тайж, Урианхан сайн Мажиг хоёр хойт нэрийн төлөө явахыг зөвлөөд уулгыг өглөө тавья гэж байгаад Убаши хун тайж уулгын хүмүүсийг урьдаар тавьж явуулав. Урианхан сайн Мажиг түүнд нь зэвүүцэн Убаши хун тайжид очиж мэдүүлэв.

Гэрээс гарч явснаас хойш та олон муу үйл хийв. Одоо энэ бурууг чинь дагахгүй би. Хэл барьсан хөвгүүний хэлэх үгийг сонсоод үхүүлсэн нэг муу ёр чинь тэр. Зандан ширээнийхээ хөлийг хугачиж хаясан хоёр муу ёр чинь тэр. Хутаг цагаан тэмээгээ тайлгат идүүлсэн гурван муу ёр чинь тэр. Одоо надаас дайсны мал харамлаад уулгын хүмүүс урьдаар явуулсан дөрвөн муу ёр чинь тэр. Хөтөч явсан сайн нөхрөөсөө дайсны мал харамласан учир чинь хар нохойн цус харамласнаас ялгаагүй байна. Харина би гээд түм таван мянган уулгачаа аваад харив. Убаши хун тайж дөрвөн Ойрадыг зорин явав.

Урианхан сайн Мажиг хүн бүр дөрвөн морьтой, хоёр мянган хүнийг тавьж баахан Боловсон захиж, бөөрөөр хүрч довтолгоод хэлтгийгээр харьж ир. Хэл барьж дөрвөн Ойрадад мэдээ оруул. Нутаг минь хангайн хар булагт байна. Харь дөрвөн Ойрад таныг үзье гэж ирлээ бид. Одоо дөрвөн түмэн хүнээ аваад харив. Наанаас чинь Убаши хун тайж цувсан сүрэг мэт одов. Түүнийг яахаа өөрөө мэд гэж хэл оруул гээд илгээв.

Сайн Мажигийн захисан ёсоор баахан Боловсон урьдчилан хүрээд урт хөлтийг олзолж аваад ардаа хэл оруулжээ.

Убаши хун тайжийн уулгач үхэр, хонь олзлоод зогсчээ. Тэгээд дөрвөн Ойрадын цэрэг цуглаж ирээд Убаши хун тайжийг гэдрэг гаргалгүй, урагш явуулалгүй мөн доор нь буулгаад гурав хоног дайлав. Монголын цэрэг нийтээр муудаж ирэхээр нь Убаши хун тайж хар тугаа чирээд хайрладаг залуусаа аваад гарч явтал, Ойрадын сайн Сэртэнг олон цэргээс онцлон ороод Убаши хун тайжид жад өргөхдөө хэлсэн үг нь:

За ноён, заарт хувцаснаас чинь өмсөж явлаа би. Давст шүүнээс чинь хүртэж явлаа би. Тэгэвч одоо дөрвөн Ойрадын нэрийн төлөө бор бөөрт чинь болд жад хүргэе, хажуу сүвээнд чинь хатан илд хүргэе гээд чичив. Тэгээд Убаши хун тайж тэр шархандаа үхэхийн урьд «Орог шаргалыг минь тавигтун. Нутагт мэдээ оруултугай. Залуус та нар ч харихгүй буюу хайран нэрээ санаж халшралгүй байлдаж, харьж няцалгүй нэг нэгнээ дэрлэн орогтун» гээд орог шаргалын буруу биеэр хийсэн одов. Убаши хун тайжийн хайрладаг залуус ноёныхоо ясан дээр мориныхоо мордох талын дөрөөний сурыг огтолж дөрвөн Ойрадын цэрэгтэй мөн тэнд цавчилдан байж үхсэн билээ.

Дөрвөн Ойрад Монголыг дарсан тууж энэ. Ойрадын сахиус долоон настай хүүд хувилж, Монголд цэлиг орхисон нь тэр болно.

Энэ дайн гал гахай жилд (1587) болов.

Асуулт даалгавар:

1. Зохиолын агуулга, үзэл санааг тодорхойлно уу?
2. Убаши хун тайж, 7 настай хөвгүүн хоёрын дүрийг харьцуулан бичнэ үү?
3. Уг бүтээл бичигдэх болсон түүхэн үндэс юү болохыг тайлбарлан бичнэ үү?
4. Уг зохиолын түүхэн сургамж юу болох талаар эргэцүүлэмж бичээрэй.

Цогт тайжийн хадны бичиг

Цагаан тахиа жилийн намрын эхэн сарын хорин. Цогт тайж Хангай хааны цэцэрлэгийн хойт ууланд авлан, хуягт халтраа унаад өндөр дээр гарч байхдаа зүүн зүг харан сэтгэл маш уярч Халуут авга эгч юүгээ санаж ийн өгүүлээд уйллаа.

Дээд тэнгэр ханы ахуй хийгээд
Дэлхий дахь хан богдсын аху газар
Дээр доордын ялгал үгүй болбоос бээр
Жаргал, хайрлал хоёрын агаар нэгэн буй
Агинастайн агуй дахь бодьсад нар хийгээд
Атан дэлхий дэх бодь сэтгэлтэн хоёрын
Ахуй газар ангид боловч
Асрах, нигүүлсэхийн агаар нэгэн буй

Энд хан богдсын сайн түшмэд хийгээд
Эргүүлэгч эрлэг хааны их ноён хоёрын
Ёс өнгө өөр боловч
Зөв, бурууг ялгахуйн агаар нэгэн буй
Олз идэш олон ядагч хүн хийгээд
Уулын модонд явагч араатан хоёрын
Аху бие ангид боловч
Алан идэхийн агаар нэгэн буй
Хол ойроос хулгай хийгч хүн хийгээд
Хотыг эргэн гэтэгч чоно хоёрын
Илт бие дүр өөр боловч
Идэхийн хүсэл сэтгэлийн агаар нэгэн буй

Онон мөрөнд буй Халуут эгч хийгээд
Орхон Туулд агч өвчит бид хоёр
Халх Онигуудын газар хол боловч
Хайрлан, санахын агаар нэгэн буй

Энэ биендээ эс золголдовч

Үүнээс хойт төрөл тутам төрөх

Эх нь ганц хүүхнээ хайрлах мэт

Элдэв үйлээр туслалцах болтугай хэмээн хайлан өгүүлснийг нь
хамт байсан Эрх хиа тогтоож, сударлан авсны хойно дөрвөн жил болоод
мөн хулгана жилийн нэгэн сарын арван наймнаа Дайчин хиа, Гүен баатар
хоёр хаданд бичвэй.

Асууулт даалгавар:

1. Уг зохиолын зохиогчийн намтар, яруу найрагчийн үзэл санааны онцлогийг тодорхойлон бичнэ үү?
2. Зохиолыг цээжилж, урнаар уншина уу?
3. Зохиолын уран дүрслэлийн онцлогийг тайлбарлана уу?

Цагийн жамын тодруулагч Цаасан шувууны сургаал

Гурван эрдэнэд итгэнэ.

Хязгаар газрын нэгэн хүн (төр гэрэлтийн) тавдугаар оны барс сарын
арван наймны шөнө зүүдэлсэн нь:

Нэгэн хүн цаасан шувуу нисгэж байна.

Тэр цагт өөр нэг хүн ирээд нисгэгч хүнээс ийн асуув.

Энэ шувууг хийхэд хямд буюу? хэмээвэл

- Хямд гэв.

Бас өөр хийхэд хямд юу байна? гэвэл

- Муу үйл хямд гэв.

Ямар юм цөөн бэ? гэвэл

- Өөрийн биеийг үл өмөөрөгч хүн цөөн гэв.

Ямар юм олон бэ? гэвэл

- Сэрэмжгүй муу заяатан олон гэв.

Юу сайхан бэ? гэвэл

Энэ цагийн хүний жам ямар вэ?

- Аяа хөөрхий, энэ цагийн хүний явдлыг санах тутам ертөнц лүгээ
нөхцөхийн чагтага тасран, зүрх догдлох мэт бөлгөө.

Бурхныг тахисаар сууж тээршаана

Номыг сонссоор сууж уйдана.

Хуваргатай ханилсаар сууж боолоо хийнэ

Өөрийн бол нохойг ч болов өмөөрнө.

Бусдын бол бурхныг ч болов огоорно.

Баялаг бол дайсныг ч болов аргадана.

Гуйрамч бол эцэг эхийг ч болов орхино.

Олзтой бол биеэ ч болов үнэлнэ.

Зохилдвол адтай ч болов нөхцөнө...

Аяа бас

Зарим мэргэд номыг мэдлэг гээд алдрыг эрнэ.

- Саруул ухаан сайхан гэв

Юу хортой вэ? гэвэл

- Өст сэтгэл хортой гэв

Юу муу вэ? гэхэд

- Хүний номгүй нь муу гэв.

Юу сайн бэ? гэхэд

- Чин зориг сайн гэв.

Зарим ноёд эрхийг олоод дайсныг хураана.

Зарим баяд эдийн төлөө өөрөө сүйднэ.

Зарим эр атаа заргаар юмаа барна.

Зарим эм өөрийн өнгө царайгаар зовно.

Аяа бас,

Шавь хүн багшийг үл ойшооно.

Хөвгүүн нь эцгийн үгийг үл сонсоно.

Хүүхэн нь эхийн сургаалыг үл дагана.

Шавь хүн багшаас илүү ноёдыг хүндэлнэ.

Хүүхэн хүн эцэг эхээс илүү эрийг хүндэлнэ.

Залуу нь хөгшнөө басна.

Хөгшин нь залуугаа үл тооно.
Идрүүд нь хал барина.
Мунагсад нь далд орохыг хүснэ.
Аяа бас,
Үйлийн үр мэт үл нягтална.
Номыг самуун үг мэт үл дурсана.
Үхэхийг унтахын төдий үл санана.
Рашааныг ундааны төдий үл хэрэглэнэ.
Судрыг мөнгө мэт үл хадгална.
Сайн үгийг сонсовч мартана.
Муу үгийг алба мэт зарлана.
Авах бол уул мэт боловч чамлана.
Өгөх бол нэг цэн боловч харамлана.
Буяныг худалдааны төдий үл хэрэглэнэ.
Хилэнцэт үйлэнд аяндаа мэргэшнэ.
Итгэсэн саднаас уурлавч салж үл чадна.
Энэрэгч багшийг дуудавч зайлна.
Бусдын гэмийг намрын үүл мэт элбэг үзнэ.
Өөрийн гэмийг нарийн тоосны төдийн үл
шинжилнэ...
Үнэн үгтэн омогтны тоонд орно.
Башир үгтэн цэцний суудалд сууна.
Эд эвдрэхийг хайрлана.
Салалцаад гаслалцана.
Учралдаад хууралцана.
Хүнийг муу хэлэхээс айна.
Сүнс зовохоос үл айна.
Аяа бас,
Тусын хариуд хорлох хүн олон.
Ачийн хариуг мэдэх хүн цөөн.
Хилэнцийг мэдэвч хийх хүн олон.
Номыг мэдэвч бүтээх хүн цөөн.
Зовлонг танивч үл сэхээрэх хүн олон.
Жаргалыг хүсэвч сайн явах хүн цөөн.
Зусар үг хэлэвч баярлагчид олон.
Гэмийг хэлбэл үл гомдогчид цөөн.
Эрхэлж муу үгээр тогловол хадгалагчид олон.
Энэрч харамгүй сургавал авагчид цөөн.
Аяа бас,
Сүжиглэхийн хамт сэжиг төрнө.
Эрдмийг эрэхийн хамт гэмийг эрнэ.
Саданд учрахын хамт дайсныг даллана.
Амгаланг бүтээхийн хамт зовлонг үүсгэнэ.
Үнэн үг хэлэхтэй хамт худлаар чимнэ.
Нэг зөв явахтай хамт хэдэн буруу явна.
Аяа бас,

Хариугүй өглөг үл өгнө.
Харгүй сайхан сэтгэлийг үл санана.
Атхаггүй амар сууж үл чадна.
Алагчлалгүй шударга явж үл мэднэ.
Муу үйл үйлдээд үл гэмшигчид олон
Сайн явдлаар яваад баярлагч хүн цөөн.
Аяа бас,
Хүндлэлийг ямба гэнэ.
Ёсыг алба гэнэ.
Ихэстэй учирвал зусардахыг бодно.
Энгийн нөхөртэй учирвал хуурахыг бодно.
Энэ цагийн хүний зовлон гэвэл,
Цайруу явбал хүний гарт орно.
Хардаж явбал муу үйл арвидна.
Шударга явбал олонтой үл таарна.
Башраар явбал номтой үл таарна.
Чанга хурц явбал өстөн олон болно.
Дуугүй номхон суувал толгой дээр гарна.
Дундуур зэрэн явбал тэнэг гэж сонжлогчид олон.
Гуйж хэлбэл эрэмшинэ.
Ширүүн хэлбэл дордоно.
Үнэн хэлбэл ойшоохгүй болно.
Худал хэлбэл хүндгүй болно.
Олноо зөвшвөл санаагаа үл хэлнэ.
Ганцаар шийдвэл зөрүүд болно.
Ойр суувал явдлаас зайлна.
Хол явбал орхив гэж тунина.
Олон үг хэлбэл чалчаа гэнэ.
Дуугай суувал ихэмсэг болно.
Хянаж хэлбэл хартай хэмээнэ.
Гэмтэй нь гэмгүйдээ ноцно.
Гэмгүй нь гэмтнийг өмөөрнө.
Эвлэвэл хардана.
Эвдэрвэл гомдоно.
Аяа бас,
Өөрөө муу яваад бусдыг жишээ татна
Хүний хүчээр сайн яваад гэдрэг эрэмшинэ.
Дээр явбал атаархана.
Доор явбал дарлана.
Энэ цагийн
Алаглагч ноёд,
Авилгач түшмэд,
Хариу бодогч өглөгийн эзэд,
Тэмцэлдэгч ардаас эхлэн
Суудлын төлөө олох нэр,
Эдийн төлөө номлох ном,

Алдрын төлөө үйлдэх буян,
Омгийн төлөө шүтэх шавь тэргүүтэн
Муу явдлыг өөрөөр үйлдээд
Цагийг муу хэлнэ.
Товчилбол:
Сансрын гянданд үйлээр хүлэгдэж
Мунхгийн харанхуйд тачаангуйгаар согтож,
Урины мэсийг барин,
Омгоор түлэгдэж,
Атаагаар агсамнаж,
Зовлонгийн эвэршээлд эмгэнэх
Амьтад бүгд хөөрхий.
Зүрхэн үгүй энэ насны хавцгайд
Авралын чагтага тасраад,

Авах гээхийн нүд тэсэрсэн
Амьтан бүгд хөөрхий.
Ихсээс мятрах,
Багад дээрэлхэх
Ичгүүргүй амьтад хөөрхий.
Даарвал хувцас,
Халууцвал сүүдэр,
Өлсвөл хоол,
Цангавал унд,
Зүдэрвэл нойрын төдий,
Өнөө маргаашийн төдий,

Туйлбаргүй сэтгэлтэн хөөрхий.
Гаслант муу заяанаас гараад,
Гайхамшигт хүмүүний биеийг олчхоод
Энэ мэт үйлийн үрийг
Эдлэгч амьтад даанч хөөрхий хэмээв.
Тэр цагт нөгөө хүн бас ийн асуув:

Аяа, энэ мэт муу цагт
Үнэнийг санагч хүн
Ямраар явбал болох вэ? гэсэнд
Нисгэгч хүн өгүүлрүүн:
Аяа, нөхрийн дээд сэрэмж мөн боловч
Лам, эцэг, эх гурван ачтанаа бүү хард.
Эрдмийн дээд эв мөн боловч
Хилэнцэт нөхөртэй бүү нөхөц.
Учраад хэлэлцдэг жам мөн боловч
Хэмжээгүй үг бүү хэл.
Бурхнаас илүү аврал үгүй тул
Сүжиглээд дамжиг бүү үйлд.
Номоос илүү эрдэм үгүй тул
Суралцаад омог бүү үүсгэ хэмээв.
Тэр хүн бас ийн асуув:
Сургаал хэрэгтэй хүн ямар вэ?
Хэрэггүй хүн ямар вэ? гэсэнд
Нисгэгч хүн өгүүлрүүн:

Үл мэдэгч мунхаг, ухаангүй хүнд сургаал хэрэггүй.
Өөрийн биеийг тоосон омогтой хүнд сургаал хэрэггүй.
Өгүүлсэн үгийг үл авагч хүнд сургаал хэрэггүй.
Үзсэний дараагаар мартагч хүнд сургаал хэрэггүй.
Эгэл хэрэггүй хүсэлд шунагч хүнд сургаал хэрэггүй.
Ихэс дээдсээс дутагч хүнд сургаал хэрэггүй.
Илт үзтэл гангалагч хүнд сургаал хэрэггүй
Элдэв башир нөхөдтэй ханилагч хүнд сургаал хэрэггүй.
Энгийн гэмгүй нөхөртэй атаархагч хүнд сургаал хэрэггүй
Их суудлыг хүсэж нэрэлхэгч хүнд сургаал хэрэггүй.
Энэ хойт хоёр явдлын сүүлийг үл бодогч хүнд сургаал хэрэггүй гэв.
Учрыг ухах саруул ухаантай хүнд сургаал хэрэгтэй.
Үнэнийг баригч шударга хүнд сургаал хэрэгтэй.
Үхэх, өвдөхийн зовлонг сэхээрэгч хүнд сургаал хэрэгтэй.
Үлэмж дээдийн номыг эдлэгч хүнд сургаал хэрэгтэй.
Өвгөд эмгэдийг өргөгч хүнд сургаал хэрэгтэй

Сургагч нь:

Зоргоор бус үнэнээр болвол сургаж болно
Зориуд бус халамжлах сэтгэлээр болвол сургаж болно

Зовлонт үйлээс зайлуулагч болвол сургаж болно
Өөрөө эс мэдэвч дээдийн зарлигтай бол сургаж болно.

Үлэмж мэргэн биш ч омог сэтгэлгүй бол сургаж болно гэв

Тэр хүн:	Хоцорч нөхөр үгүй бүү суу хэмээв.
- Тийм бөгөөс надад	Сэтгэлийг чиг гэвэл:
Мэдэхэд хямд	Шинжлэлгүй бүү сэтгэ.
Хийхэд хялбар	Сэрэмжгүй бүү зальхайр.
Явахад амар	Гэнэт нөхрийг бүү итгэ.
Санахад томьёотой	Гэндэж хүнээс бүү урьт.
Нэгэн сургаал айлдаж хайрлана уу?	Буруу юмыг бүү өмөөр.
Гадна биеийн явдал	Бусдын юманд бүү шуна.
Дотоод хэлний үг	Бузгай дээрэнгүй бүү загна.
Нууц сэтгэлийн чиг	Бузар хилэнцийг бүү үүсгэ.
Гурвуулны ерөнхий байдлыг ямар мэт явах вэ?	Чөлөөгүй гэж бүү алгас.
Гадаад амины аж төрөх	Чадал үгүй байж бусдыг бүү дуурай.
Дотоод их, бага төрийн нууц явдал	Магад дээдсийг олж нөхөрлө.
Дээдийн номыг бүтээх зэргийг ямар мэт явах?	Муу явдалтнаас насад дутаа.
Жаргах цагт санах санаа	Санасан бүрийг бүү хөөцөлд.
Зовох цагт хатамжлах сэтгэлийг	Салах учрахад бүү гомд
Надад айлдаж хайрла? хэмээсэнд	Буянтай санаанаас бүү холд
Нисгэгч хүн өгүүлрүүн:	Бодь сэтгэлийг бүү март.
- Гадаад биеийн явдал гэвэл:	Нийтийг товчилбол:
Ёстныг хүндэл.	Самуун хүнтэй бүү учир
Настныг баярлуул.	Санасан бүрийг бүү ярь
Ачтанаа өргө.	Тэр энэ гэж бүү эрэлх
Бачтанаас зайл.	Тэгэх ингэх гэж бүү зарла
Сайнаас бүү сал.	Сонжилбол бүү уурла
Садныг бүү эр.	Сонирхож бүү урва
Олон бүү арилж.	Өгвөл эд мөн.
Огт бүү харамла.	Хүлцвэл хуяг мөн.
Олон дараагаар хэрэггүй явдлыг бүү арвитга	Хичээвэл мөр мөн.
Онц зөрүүлхэж дээдсээс бүү сал	Эс мартвал бясалгал мөн.
Муу нөхөртэй бүү нөгц	Мэдвэл билиг мөн.
Зүйл бүрийн хувцас бүү өмс.	Мунхаг хүнтэй оролдвол
Зүг тал үгүй бүү гайхуул.	Үйлийн үрийг үл мэдэх тул өөрөө гутна.
Хэлний өгүүлэх хэмээвэл:	Хүсэлтэй хүнийг чанга хоригловол
Хэрцгийлж хэрүүл бүү үүсгэ.	Гансрах тул аргаар номхотго.
Хэгжүүрхэж омог бүү үүсгэ.	Ууртай хүнийг ширүүн хэлбэл
Хэлбийж олон янз бүү урва.	Аюул болох тул урмаар ухуул.
Саваагүй тохуун үг бүү хэлэлц.	Омогтой хүнийг дарлавал
Санамсаргүй үг бүү хэл.	Хорсох тул нэр цолоор баясга.
Эвлэж муу санаатантай бүү зөвш	Дээрэнгүй хүнийг хөгжөөвөл
Эвдэрч олон зан бүү гарга	Хэрэг гарах тул их битгий хэрэгс.
Хордож бусдын гэмийг бүү малт.	Атаач хүнд нүүр эс өгвөл
Ховсорч хэрэггүй үг бүү зөө.	Гомдох тул сайхан загна.
Хуурч элдэв башир бүү хэл.	Харамч хүн ширхэг утсыг ч болов

Харамлах тул арилжаа бүү хий.
Зусарч хүнтэй нөхөрлөвөл
Зоргоор болох тул дорд суудлыг барьж
Ховч хүнтэй хэлэлцвэл
Бусдын гэмийг сонсох тул бүү итгэ.
Их хүнийг эс нүүрдвэл
Өмөг үгүй болох тул ёсын төдий сайхан хүндэл.
Боол хүнийг эс баярлуулбал
Явдал хождох тул бага сага юм өг.
Өр бүү хий.
Өглөг бүү тасал.
Хулгай бүү хий.
Ховсоргон бүү загна.
Олноос зөвш.
Онц өөрийн санааг сүүлд гарга.
Хэлбэл бүү буц.
Санавал бүү март.
Хүнийг нүүрчилж
Хэргийг буруу бүү болго.
Хүнд чиг үгүй загнаж
Сайхан зан үгүй бүү суу.
Эд хэмээвэл, ертөнцийн ёсны сургаал болой.
Эдүгээ номын ёсны сургаал хэмээвэл:
Биеийг тороос алдуулсан шувуу мэт
Аглагийг шүт.
Хэлний үгийг хивийн зангиа мэт
Алдралт үгүй боо.
Урьдын хийсэн хилэнцээс
Хор уусан хүн мэт хашир.
Магад гарах буянт сэтгэлийг
Амь мэт энхрийл.

Хилэнцэт нөхрөөс
Аварга могой үзсэн мэт зайл.
Буяны саданг
Өөрийн толгой мэт өргө.
Сэтгэлийн эрдмийг
Яст мэлхийн гишүүн мэт нуу.
Усгал зөөлөн занг
Мөрний урсгал мэт ундраа.
Чин зориг, хичээнгүйг буугийн сум мэт чиглэ.
Гурван эрдэнийн үйлст морь, нохой мэт зүтгэ.
Олон хамаг амьтанд сал онгоц мэт
Боол сэтгэлийг барь.
Тангараг цааз хоёрыг
Шил толь мэт хайрла.
Өөрийн гэмийг салхи мэт алдаршуул.
Зөв болвол бүхэнд дайсан боловч үйлд.
Буруу бол хааны суудалд суулгавч зайл.
Буян болох бол хилэнц мэт боловч үйлд.
Хилэнц болох бол буян мэт боловч тэвч.
Үлгэрлэвэл: Хүнтэй адил боловч
Ороолон бол бүү учир.
Галзуутай адил загнавч
Дээдэс төрөлхтөн бол шүт.
Түүнчлэн, билиг буй бөгөөс
Эрдэм үл болох юм нэг ч үгүй.
Сүсэг буй бөгөөс
Адис үл гарах юм нэг ч үгүй.
Хичээнгүй буй бөгөөс
Үл бүтэх юм нэг ч үгүй.
Бодь сэтгэл буй бол
Нөхөр үл болох амьтан нэг ч үгүй хэмээв

Тэр цагт, билигтэй бол юм бүгд эрдэм болох учир юу вэ? хэмээсэнд
Үлгэрлэвэл:

Чулуун хор эмч хүнд эм
Таарах өвчинд рашаан
Зүгээр хүнд хор болсон мэт
Шимийг нь авбал өчүүхэн юм ч
Их эрдэм болох нь олон буй.
Хорхой тэжээж авсан шүлс
Магнаг болохыг үз.
Өвчин бага боловч үхлийн шалтгаан.
Будаг бага боловч өнгө
урвуулахын шалтгаан.

Асууулт даалгавар:

Буян бага ч болов туслахын шалтгаан.
Гал бага ч болов түлэхийн шалтгаан.
Үзэл бүгдийн товч үнэн үзэл мөн.
Санаа бүгдийн товч мөнх бус мөн.
Ном бүгдийн товч сэтгэлийг номхотгох мөн.

Сайн, муу, үнэн, худал үгсийг
Наадмын төдий бичсэн
Цагийн жамыг тодруулагч
Цаасан шувуу хэмээгдэх нэжгээд үе төгсөв

1. Уг зохиолын зохиогчийн намтар, уран бүтээлийн төрөл зүйл, уран чадварын онцлогийг тодорхойлон бичнэ үү?
2. Зохиолд хүмүүний явдал мөрийг хэрхэн өгүүлснийг тодорхойлно уу?
3. Зохиолоос өөрт таалагдсан хэсгийг эшлэж, эргэцүүлэмж бичнэ үү?
 4. Зохиолчийн намтрыг дэлгэрүүлэн уншиж, өөр ямар бүтээлүүд туурвисан тухай олж мэдсэнээ бусадтайгаа хуваалцаарай.

II бүлэг. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол –Яруу найраг

Д. Нацагдорж “Миний ээж”

Монгол үзэсгэлэнт саран гуа, намайг төрүүлсэн ээж
Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн ээж
Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн ээж
Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн ээж.

Д. Нацагдорж “Миний хэнз хурга”

Миний хэнз хурга	Төрсөн хот дотроон
Магнай халзан зурвастай	Тэр бид хоёр тоглодог
Мянган хонины дундаас	Өвдөг юугаа сөгдөөд
Би хармагц таньдаг	Өөрийнхөөн ээжийг хөхдөг
Мярс мярс майлж	Өвөр дээр минь гараад
Намайг чиглэсээр ирдэг	Өхөөрдмөөр өхөөрдмөөр эрхэлдэг
Дун цагаан үстэй	Нааш цааш дэгдэн
Дуран хар нүдтэй	Малчин хүнийг баясгадаг
Түмэн хонины дунд	
Түүнээс хөөрхөн амьтангүй	1933 он

Асууулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Шүлгүүдийг цээжилж, урнаар уншина уу?
3. Шүлэг тус бүрийн уран дүр, дүрслэлийг харьцуулан бичнэ үү?

“Жигмэд, Тогмид хоёр”

Д. Содномдорж

Жигмэд Тогмид хоёр	Том савтай Тогмид нь
Жимсэнд хамт явжээ	Сүүлдэнэ гэж сүрджээ
Уулын модонд очоод	Түүсээр байгаад Тогмидын
Уралдаж түүхээр болжээ	Сав нь дүүрээд иржээ
Жижиг савтай Жигмэд нь	Идсээр байгаад Жигмэдийн
Түрүүлнэ гэж барджээ	Гэдэс нь цадаад иржээ

Асууулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Шүлгийг цээжилж, урнаар уншина уу?
3. Шүлгийн уран дүр, дүрслэлийг тодорхойлон бичнэ үү?

Норовын намтар

Норовын сонин намтраас
Эхэлж ярихаас өмнө
Номынх нь савны тухай
Хэдэн үг хэлэх үү би
Эдэлж эзэмшиж явдаг
Эзэндээ их гомдсон
Номын сав, нэг өдөр
Норовын эзгүй хойгуур
“Хол газар оргож явъя
Холдож нэг санаа амаръя” гэж
Гэнэт шийдэж зориглоод
Гэрээс гараад зугтаажээ.
Яагаад зугтаасныг
Би ч бүү мэд, чи ч бүү мэд
Ямар ч гэсэн нэг учир
Бий л байлгүй дээ, түүнд
Норовыг гэртээ ирэхэд
Номын сав нь алга байж
Хаашаа яагаад явчихсныг
Хаанахын хэн ч мэдээгүй байж
Онигор нүдтэй дүү нь л
Олж харсан юм байж
Онгорхой хаалгаар тэр сав
Оргож гарсан юм байж
Онц ихээр гайхаад
Норовын нүд бүлтгэнэжээ.
Огло харайгаад гарчээ.
Үзэж заалгадаг олон номтой
Үзэг харандаа цөм бүрэнгэй
Үүрч явдаг номын сав минь
Үүдээр гараад зугтаажээ.
Хаашаа яагаад явсны нь
Харсан хүн байна уу? гэж
Хашхирах шахам сураглахад
Хажуу дахь улс нь гайхжээ
Гудамжинд явсан хүмүүс
Түүнийг ердөө ч харсангүй
Гурван хүүхэд л харин
Түүний сургийг гаргажээ.
Явсаар байгаад номын сав
Ядарсан ч юм уу? бүү мэд
Нэг газар хүрч ирүүтээ
Нээж үүдээ дэлгэчхээд
За Та нар цөмөөрөө гарцгаа

Д. Содномдорж

Замаа олоод цугаараа тарцгаа
Хаашаа л явбал дураараа болцгоо
Харин битгий эргэж ирцгээ
Үзэг эхлээд одоо гараарай
Үүний хойноос дэвтрүүд цуваарай
Номууд дараа нь бэлтгэж
байгаарай
Норов, аягүй бол хүрээд ирнэ шүү
Будган харандаанууд яваарай
Бушуу бушуухан гүйгээрэй гэж
Номын савыг хэлэхэд тэд
Цугаараа сандран яарцгаажээ.
Норовыг ирэхээс урьтана гэж
Цөмөөрөө цуван гарцгаажээ.
Гүйсээр байгаад Норов маань
Гүйцээд иржээ, тэднийгээ
Оволзсон амьсгаагаа дараад
Омогтой ширүүн дуугаар
Та нар чинь яагаад манайхаас
Яваад өгч байгаа юм бэ?
Тавьсан газар байж байхгүй
Яасан задарсан сав бэ, чи
Одоо та нар бултаараа
Орцгоо наад савандаа
Олж авсных та нарыг
Аваад явна гэхэд нь
Яагаад зугтаасныг та мэдэхгүй ч
Явахыгаа бид бас мэднэ
Яавч бид буцаж орохгүй
Яасан ч бид эргэж очихгүй гэж
Үзэг, харандаа, ном, дэвтэр
Ам амандаа шуугилджээ.
Үүнийг дуулаад Норов маань ч
Айхавтар ихээр гайхжээ.
Бушуул савандаа орцгоо
Булты чинь аваад явна гэж
Хамаг тэнхээгээрээ хашхирахад нь
Хажууд нь байсан нэг үзэг:
Үзүүрий минь мохоосон та
Бас шүдээрээ үргэлж мэрг
Иший минь хонхойлсон та
Тэгээд бас намайг
Хайрлан хамгаалахыг мэддэггүй
Тэгэхээр одоо би танд

Эргэж очихгүй гэжээ.
Дэргэд нь хэвтсэн дэвтрүүд
Дэлгэсэн хуудсаа эргүүлээд
Дээл болсон хавтсы минь
Дэндүү муухай урдаг та
Дээр минь бас элдвийн юм
Дэмий баахан эрээчдэг та
Тэгээд бас үргэлж л
Хоёрын тоо тавиулдаг
Тэгэхээр одоо бид танд
Эргэж очихгүй гэжээ.
Ноорхой болсон хавтастай
Номууд дараа нь залгаад
Хувцас болсон хавтсы минь
Хугалдаг шүү дээ та
Хуруугаа норгож эргүүлээд
Харуулдаг шүү дээ та
Тэгээд бас үргэлж
Сөхөж уншдаггүй шүү дээ
Тэгэхээр одоо бид танд
Эргэж очихгүй гэжээ
Урт богино болсон
Өнгийн будган харандаанууд
Хойно урдаа оролцон
Өндийн босож зогсоод:
Дэмий баахан зороод л
Биеий минь хороодоггүй гэж үү
Дэндүү урт шовхлоод л
Үзүүрий минь хугалдаггүй гэж үү
Тэгээд бас биднийг
Саванд минь ердөө хийдэггүй
Тэгэхээр одоо бид танд
Яасан ч очихгүй гэжээ
Хамгийн сүүлд номын сав
Хандаж Норовт хэлэв:
Түлхүүрий минь та гээж
Түгжээгий минь хэмхэлсэн
Оосры минь та тасалж
Оёдлы минь ч ханзалсан
Хичээлээсээ ирээд та
Гэртээ авч ирээд хаячихдаг
Үүд хаалгыг минь ч нээдэггүй
Үнэнч нөхдийг минь ч гаргадаггүй
Бөндийтөл намайг үлдээчхээд
Бөмбөг өшиглөөд явчихдаг.
Тэгээд бас надаар

Хүүхэд багачууд зоддог
Тэгэхээр одоо би танд
Буцаж очихгүй гэжээ.
Бид одоо бүгдээрээ
Тал тал тийшээ явлаа даа
Биднийг хайрладаггүй эзэн минь
Баяртай, баяртай гэхэд:
Ногоон иштэй үзэг минь
Номын хайртай сав минь
Бусад болон дэвтэр минь
Бултаараа одоо хүлээгээч
Миний хэлэхийг сонсооч
Үүнээс хойш та нарыг би
Үргэлж хайрлаж явъя даа
Савандаа оосры нь хийе дээ
Сайхан дэвтрээ хавтаслая
Тэгээд би үргэлж л
Тавын дүн тавиулъя даа
Тэгэхийн төлөө дандаа л
Онц сурж байя даа
Харандаагаа би аятайхан
Үзүүрлэж байя даа
Хамаагүй дэмий зорохоо
Үүнээс хойш больё доо
Та нар минь одоо намайг
Бүү орхиод яваа ч дээ
Тарж бутарч зугтаагаад
Битгий намайг зовоо доо гэхэд
Намайг та яаж
Хайрлаж байхаа хэлсэнгүй гэж
Наана нь байсан номууд
Гомдол үзүүлж гарлаа.
За би, одоо та нарынхаа
Хавтсы нь сайхан наана
Замбараагүй баахан юм
Хамаагүй эрээчхээ болино
Үргэлж би таныгаа
Үзэж уншиж байна
Үеийн бусад нөхдөдөө
Тайлбарлан ярьж байна гэж
Норов тэндээс гуйгаад
Нулимсаа арчин уйлж гэнэ.
Учирлаж гуйсны нь бодоод
Уйлж орлисны нь үзээд
Эргэж очих уу яахав гэж
Эд цөм зөвлөлджээ.

Би л яасан очихгүй дэг
 Биеэ тэгж зовоохгүй дэг гэж
 Хамгийн богинохон улаан
 харандаа
 Хариулж тэдэндээ хэлж гэнэ.
 Хэлсэн үгэндээ эзэн болоод
 Хэрвээ биднийг хайрлаж байвал
 Одоо бид эргэж очно
 Онц сурахад чинь тусалж чадна
 гэж
 Номын сав тэргүүтнийг хэлэхэд
 Норов баярлаад нүд нь сэргэжээ
 Үргэлж би та нарыг хайрлана гэж
 Үнэн үгээ дахин мэдүүлжээ.

Эзэн маань биднийг энэнээс хойш
 Энхрийлж хайрлана гэсэн тул
 Бултаараа одоо та нар
 Буцаад орцгоо гэж савыг хэлэхэд
 Будган харандаанууд дургүй байж
 Буцаж гарах гээд тэмүүлж байж
 Эд нар ингээд цөмөөрөө
 Эргэж савандаа ороод
 Эзнийхээ суганд хавчуулагдаад
 Гэрийн зүг явжээ
 Суганд байгаа ном дэвтрээ
 Суганаас мултраад зугтах бий гэж
 Байн байн болгоомжлоод
 Байдаг тэнхээгээрээ хавчжээ.

1957 он

Асуулт даалгавар:

1. Норовын намтар зохиолын агуулгын ач холбогдлыг тодорхойлон бичнэ үү?
2. Шүлгийн уран дүр, дүрслэлийг тодорхойлон бичнэ үү?

Аав

Миний аав
 Айлын
 Жаалын
 Ааваас өндөр
 Миний аав
 Хүний
 Хүүхдийн
 Ааваас өндөр
 Аав намайг
 Мөрөн дээрээ
 Өргөн гаргав.
 Аав намайг
 Өөрөөсөө
 Өндөр болгов.
 Аавын мөрөн дээрээс

Талын бараа
 Алган дээр тавьсан мэт
 Илхэн байлаа.
 Цэцэгт тал
 Цэнхэр гол
 Тэртээд
 Тэмээ мал
 Тэгээд
 Хэдэн айл
 Хоолойд
 Хонин сүрэг
 Хойно нь
 Морьтой хүн
 Алсад
 Ачааны тэрэг

Ж. Дашдондог

Ард нь
 Алтан тоос
 Ааваас би
 Асуулаа:
 -Аав аа,
 Аав аа?
 Өөрөө яагаад ийм
 Өндөр болсон юм бэ?
 Аав надад
 Хариуллаа:
 -Алсын
 Алсын барааг
 Аав нь хүүдээ харуулах
 гэж
 Өндөр болсон юм даа!

Ээж

Ээж минь
 Эрээн алчууртай
 Ногоон дээлтэй
 Ээжийгээ

Эрээн алчууртай нь
 Ногоон дээлтэй нь
 Зурчихлаа, би
 Будчихлаа, би

Ээж минь
 Хувин дүүрэн ус
 Худгаас барьдаг
 Ээжийгээ

Худгаас татсан
Хувинтай устай нь
Зурчихлаа, би
Будчихлаа, би

Ээж минь
Найрсаг зантай
Наддаа хайртай
Ээжийнхээ

Найрсаг зантайг нь
Наддаа хайртайг нь
Хэрхэн зурах вэ, би?
Хэлж өгнө үү, та!

Би

Би
БИ
Би чадна
Юуны төлөө
Гартай билээ
Зурж чадна
Байнга ажилтай баруун гартаа
Зургаан хуруу зурж орхилоо
Бага ажилтай зүүн гартаа
Дөрвөн хуруу зурж орхилоо
Энэ гар
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!
Би
Би
Би чадна
Юуны төлөө
Хөлтэй билээ
Гүйж чадна
Хүний бага нь дэгдээрэй! гэхээр
Хөл минь аяндаа хөнгөрөөд ирдэг
Дэмжлэг тус хэрэгтэй газар луу
Дэлхийг тойрч гүймээр байдаг
Энэ хөл
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!
Би
Би
Би чадна
Юуны төлөө
Нүдтэй билээ
Харж чадна
Хурдан морь болгож хараад
Хусан шилбүүрийг уралдуулж
чадна

Хүчит бөх болгож хараад
Хөндийн шивээг барилдуулж
чадна
Энэ нүд
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!
Би
Би
Би чадна
Юуны төлөө
Чихтэй билээ
Сонсож чадна
Ингэ тэг! гээд үглээд байхаар
Энэхэн чих минь багасаад ирдэг
Эрт цагт гээд үлгэр эхэлхээр
Эргээд дорхноо томроод ирдэг
Энэ чих
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!
Би
Би
Би чадна
Юуны төлөө
Амтай билээ
Ярьж чадна
Асуултын хариуг хоёрхон үгний
Алинаар нь хэлхээ мэдэлгүй яахав
Анд найз болох уу? За, за!
Алаг цэцэг таслах уу? Үгүй, үгүй!
Энэ ам
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!
Би

Би
Би чадна
Юуны төлөө
Хамартай билээ
Үнэртэж чадна
Талын тармаг өвсөн дундаас
Таанын хурц үнэрийг ялгана
Шөнийн олон үнэр дундаас
Өөрийн гэрийн утааг ялгана
Энэ хамар
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!
Би

Би
Би чадна
Юуны төлөө
Толгойтой билээ
Сэтгэж чадна
Бийр будгаар өөрийгөө зуртал
Биеэс толгой нь томдож орхив
Элдэв бодол багтахгүй байхад
Ингэж зурахаас өөр аргагүй
Энэ толгой
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!

Асууулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Шүлгүүдийг цээжилж, урнаар уншина уу?
3. Шүлэг тус бүрийн уран дүр, дүрслэлийг харьцуулан бичнэ үү?

Аранзал Зээрд

Аранзал зээрд мориороо
Алхуулан шогшууллаа
Шогшуулснаа хатирууллаа
Хатируулснаа ергүүллээ
Ергүүлснээ цогииуллаа
Цогииулснаа давхиуллаа
Талаар талаар
Ташуур өгөн
Довтолгов
Замаар замаар
Тоос босгон
Хурдалгав.
Хатан дэлхийг
Дөрвөн туурай
Дөрвөн туурай
Бөмбөрдөнө
Хайр чулуу
Арван зүгтээ
Арван зүгтээ
Цацагдана

Хөрст дэлхий
Хөлийн дор
Хөлийн дор
Жирэлзэнэ
Хөтөл гүвээ
Холын холд
Холын холд
Торолзоно
Сумын бараа
Тодорлоо
Тодорлоо
Сургуулийн байшин
Ойртлоо
Ойртлоо
Аранзал зээрд мориныхоо
Амыг татан цогииуллаа
Цогииулснаа ергүүллээ
Ергүүлснээ хатирууллаа
Хатируулснаа шогшууллаа
Шогшуулснаа алхууллаа

Асууулт даалгавар:

1. Шүлгийг цээжилж, урнаар уншина уу?
2. Шүлгийн уран дүр, дүрслэлийг тайлбарлан бичнэ үү?

Хаан хуруу

Д. Батжаргал

Таван хуруу нэг удаа
Тавтайхан бөөгнөрч суугаад
Хаан хуруугаа сонгох
Халуухан хурал хийжээ
Өндөр алдрын төлөө
Өрсөлдөж эхэллээ
Өөр өөрсдийнхөө нэрийг
Өргөж дэвшүүлээ
Эрхий:
-Эрдэм ном бүтээдэг
Эрдэнийн үзэг түшилцдэг
Эрхий мэргэн хэмээн
Эртнээс нааш алдаршсан
Энэ удаа би
Эзэн болох бодолтой байна
Долоовор:
-Домч эмч хэмээн
Домог хуучинд бичигдсэн
Дохио зангааны түрүүнд
Доош дээш чичилсэн
Долоовор хуруу надад
Дотор бодол их байна
Хаан хуруу болоход
Харшлах зүйл алга
Дунд хуруу:
-Долооврыг хаан болгоход
Доожоо муутай юм даа
Хамгийн өндрийгөө ер нь
Хаан болговол яасан юм.
Ядам:
-Эрдэнийн мөнгөн бүс хэнд байнав
Энэ л хаан болох ёстой
Тэргүүн нанчдыг хэн эхэлж
Тэнгэр газарт хүртээдэг билээ
Тэр л хаан болох учиртай
Чигчий:
-Хаан болоход дургүй хуруу
Хаанаас бидэнд байхав
Бие жижиг гэхгүй бол
Би ч гэсэн хаанчилж чадна
Элдвийн үгээр яахав
Эрдэм чадлаараа уралдая
Эзэн хүнийхээ тэргүүнийг

Эрхэм сайн цэвэрлээ
Энэ тэмцээнд түрүүлсэн нь
Эзэн хаан болно
Долоовор:
-Урд ургасан чихнээс
Хойно ургасан эвэр гэгчээр
Ухаант чигчийн саналыг
Уухайн гас зөвшөөрч байна
Дунд ядам хурууд
Дуртай гэгч дэмжлээ
Эрхий харин тээнэгэлзэвч
Эрхбиш ганцаардлаа
Аяга дүүрэн усанд
Ар өвөргүй норж
Анхилуун үнэрт саванг
Алаг цооггүй түрхэж
Эзний тэргүүнийг цэвэрлэх
Эрхэм ажил эхэллээ
Тэр энэ гэж ялгалгүй
Тэгш сайн оролцов
Чи би гэж хэлэлгүй
Чин шударга зүтгэв
Яг дуусахын даваан дээр
Янзын юм болов
Сонорын нүхэнд хэсэг хулхи
Сонины тасархай шиг үлдэв
Агуйд орсон хярс шиг
Автаж өгөхгүй зовоов
Дунд хуруу ухаж ухаж
Дурамжхан буцаж ирэв
Эрхий дараа нь очоод
Эвээр оролдоод ч дийлсэнгүй
Долоовор наанаас нь довтлоод
Дорвитой амжилт олсонгүй
Ядам хуруу очиход
Яргаж цааш зугтлаа.
-Би яваад нэмэргүй гэж
Бяцхан чигчий татгалзлаа –
Эрээн зөгий орсон шиг
Ирвэгнүүлэн загатнуулаад
Эзний биеийг ер нь
Эвгүй болгож байна
Тиймээс үүнийг авсан нь

Тэргүүн хаан болно гэж
Ядам хуруу тэндээс
Яггүй санал гаргалаа
Чигчий үүнийг сонсоод
Чих рүү гүйгээд орчхов
Удаж удаж, ухаж ухаж

Уран хумсныхаа завсарт
Цагаан хулхи үүрсээр
Цаанаа баяртай гарч ирэв
Ингээд чигчий хуруу
Их хаан болов оо.

1990. 10. 08

Асуулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Зохиолын туурвил зүйн онцлогийг тайлбарлан бичнэ үү?
3. Зохиолын уран дүр, дүрслэлийг тодорхойлон бичнэ үү?

Хүрэн морь

**Намайг төрүүлээд
Нас барсан
Эхээ дурсаж
Энэ шүлгийг бичив.**

Оройн улаан нар
Онц туяа татуулаад
Сунаж хөвсөн үүлсийн
Сугаар нэвт шагайж
Урваж хөрвөж байгаа
Хурын бараан үүлийг
Улбар шар өнгөөр
Хувиргаж сайхан чимлээ.
Сүрэг олон адуу
Суурь бэлчээрээ солиход
Сүүлдэж явсан хүрэн
Сугарч хойно нь хоцроод
Сургаж өгсөн эзнийхээ
Сургийг сонсох гэсэн шиг
Сухай улаан өнгөөр
Суниаж байгаа нарыг
Эгцэлж нэг хараад
Эргэж нэг унгалдав.
Дасаж байсан сүргээсээ
Тасарч үлдсэн хүрэн
Талын зөөлөн хөрсөн дээр
Тавтай хэд хөрвөөгөөд
Танхил биеийнхээ шороог
Дахин шилгээж унагаад
Өргөн замаа үнэрлэж
Өтгөн сүүлээ сөхөж
Үүлтэй тэнгэрийн доогуур

Харван нисэх адил
Үзүүртэй модны дээгүүр
Харайн дэгдэх адил
Хур дэлээ хийсгэж
Хурдан шөрөмсөө чангалж
Тоосоороо тоглон бусгаж
Торойтол ганцаараа тасарчээ.
Ганц хүрэн морь
Гарсан оройгоос эхлэн
Зүйргүй санасан нутгийнхаа
Зүг чигийг алдалгүй
Зүсэрч орсон бороог
Зүсэж сөрөн явахдаа
Байцат өндөр хэцийг
Бардаж даваад гарахдаа
Бартаат талын арвиныг
Бахдаж давхин өнгөрөхдөө
Өдрийн халуун наранд
Өл залган амарсаар
Шөнийн бор хоногт
Сүүдрээ дагуулан гүйсээр
Бүтэн гурван өдөр амарч
Бүхэл гурван шөнө явжээ.
Дөрөв дэх шөнөдөө тэр
Дөхөх гүйдэлдээ ороод
Дөт замаа дагасаар
Дөрвөлжин шар гүвээг

Дөнгөж даваад иртэл
Дөхмийн чоно тааралдав.
Хонгор нутгаа үгүйлж
Хол өнцгөөс гүйсэн
Хүрэн морины урдуур
Хөндий цөлийн араатан
Зэвхий муухай чононууд
Зэллэн хошуурч ирэв.
Хээрийн зэрлэг араатан
Хэдий тааралдсан боловч
Хэтийн их зорилгоос
Хэрхэвч хойш ухарсангүй
“Өнгө бүрийн тотгороос
Өөрийн эрхгүй салсан сан.
Өвч тураг бие минь
Өстөн хортонд бариулах нь уу?
Өлөн чононд хөөгдсөн ч
Өлгий нутагтаа дөхье.
Өлсгөлөн махчинд ээрэгдсэн ч
Өнөр ижилдээ ойртъё
Хурдан сайн удамтай билээ
Хурц дөрвөн туурайтай билээ
Хуй шиг хийсээд гаръя.
Хулан шиг дайраад үзье”
Хүрэн морь ч ухасхийв.
Хөөсөн “ноход” ч өртөөлөв.
Халдаад ирсний нь
Хавиргыг өшиглөж
Дайраад ирсний нь
Дагзыг чавчилсаар
Хүрэн морь ч
Сугарахаараа сугарав.
Хөнөөлт саарлууд ч
Сунахаараа сунав.
Эгцэлсэн санааны хүчээр
Эрсэлсэн хөлийн хурдаар
Хоол эрж гуринхалсан
Ховдог муухай араатны
Хомхой аманд оролгүй
Хорт соёонд өртөлгүй,
Байдаг чадлаа шавхаж
Баахан хэсэг явтал
Холын ус шуугьж
Хоточ нохой хуцлаа.
Аргалын утаа үнэртэж
Айлын бараа харагдлаа.

Нохойн чимээ аваад
Ноцсон гал үзээд
Хөндийн бузар араатан
Хөөхөө болиод хоцров.
Харагдсан айлыг чиглэж
Хар эрчээрээ давхисаар
Тооноороо оч үсэргэсэн
Том гэрийн гадаа
Хөөгдөж туйлдсан хүрэн
Хүрч ирээд зогсов.
Гэнэтийн энэ чимээгээр
Гэрийн эзэн гарвал
Уяатай морины нь дэргэд
Урт өтгөн сүүлтэй
Уужим өргөн хондлойтой
Уран ганган толгойтой
Хүрэн зээрд зүстэй
Хүч тэвээрэг муутай
Хүлэг сайхан морь
Хөлс нь дуслaad зогсжээ.
Атар хээр газар
Аюулт дайсантай тулгараад
Бүрхэг шөнийн хэцүүд
Бүдрэн сандран давхисаар
Айлын гадаа ирээд
Амьсгаа дарж байхдаа
Гэрийн эзний бүтэлгүйг
Гэнэдсэн хүрэн мэдсэнгүй.
Хүрэн морийг илбэсээр
Хөлд нь эвтэйхэн суугаад
Гурамсан хар чөдрөөр
Гурван хөлий нь баглав.
Ургаа хадны дундаас
Ундрах булгийн эхнээс
Урсаж байгаа голыг
Уулын чулуугаар боох шиг
Уйтгарт бэрхийн дундаас
Урьхан нутгаа санасан
Унаган зүст хүрний
Урт замыг таслаад
Барьж унасан хүн
Бачилж эдлэх талаар
Бадарч ламын зовоохоос
Багагүй илүү болжээ.
Эмээллэж унадаг морьдын
Ээлж солиог хийе.

Энгүй хол газраас
Эх нутагтаа гүйсэн
Энэ морины хойноос
Эзэн ирж магадгүй
Эрэлцэн суралцан ирээд
Эрхэм морио авбал
Олзонд дуртай надад
Онц ашиг болохгүй.
Хэд хоног боловч
Хэрэг ажлаа бүтээе гэж.
Шинэхэн тэр эзэн
Шийдэж дотроо бодоод
Хошуу нутаг дамжиж
Худалдаа наймаа хийхээр
Хол ойргүй хэсэж
Хонжоо олз олохоор
Хүрэн морийг унаад
Хөрш хошуунд явжээ.

□

Мөнх Алтайн оройгоор
Мөнгөн цас цайравч
Мөрөн голын хөвөөгөөр
Мөчирт мод ургавч
Урт арвин хангайд минь
Уйлах дуу цуурайтуулж
Уудам Монгол нутгий минь
Уулгалсан дайсан түйвээгээд
Дайн тэмцлийн утаа манарсан
Дажин самууны хөл үймсэн
Хүнд бэрх үе байлаа.
Гүжир хатуу цаг байлаа.
Хүйс тэмтрэхийг зорьсон
Хүй олон дайсныг
Хүчирхэг Монгол хүмүүс
Хүчээ гарган тэмцээд
Ган сэлмийн ирээр
Гал оч үсэргэж
Гайхамшигт их нэгдлээр
Гарамгай зоригтой тулахад
Галзуу харгис цэрэг
Газар сайгүй бужигнаж
Замд тохиолдсон бүхнийг
Зандалчин ёсоор сүйтгэж
Өмнөө уулзсан бүгдийг
Өөрийн дураар дарлаж байв.

□

Хүсэл нь ханадаггүй панзчин
Хүрэн морийг унаж
Хүрээ хөдөөгүй тэнэж
Хүн ардыг шулаад
Аймаг хошуу сүлжиж
Ашиг хайж явсаар
Хорт санаат дайсны
Хоморгонд орж баригдаад
Харийн хэрцгий ноёны
Хажууд нь очиж мөргөв.
- Утсан улаан амийг минь
Уучилж хайрла ноён минь
Унасан морио эмээлтэй нь
Урд чинь авчирч өгье.
Авч яваа юмаа би
Айлтгаж танд барья гэж
Дахин дахин гуйгаад
Дальдарч мөргөн уйлаад
Хүүрийн төдий биеэ
Хүрэн мориор авруулав.
Халх Монгол нутагт
Хатуу тэмцэлтэй байхад
Гараас минь сүрддэг хүн
Ганц энэ л байж гэж
- Авилгачин ноён бодоод
Аймхай мууд хэлсэн нь:
- Ар Монгол нутаг
Алган доор минь байна.
Алтан дэлхийн шороо
Хөл доор минь байна.
Адгийн муу чамайг
Алаад би яах вэ,
Хэлсэн үгий минь дагаж
Хэрэг ажилд минь оролц!
Зовлого арьс болсон ч
Золбоотой морь байна.
Тарга хүч муутай ч
Тал туулах хүлэг байна гэв.
Ихэмсэг ламд булаагдаж
Ижил ханиасаа хөндийрөөд
Жороо хүрэн морь
Зохистой заяа үзсэнгүй.
Хэн нэгний гар дамжсан
Хиртэй халтар хадаг шиг
Хүрэн зээрд морь
Хүйтэн гарыг дамжсаар

Хүний амины золио болж
Хөнөөлт дайсны унаа болов.
Хартан хортны гарт
Хамрагдан орсон боловч
Ган дөрвөн туурайгаар
Хөрст газрыг онгилж
Гааршгүй их хүчээрээ
Хөнөөлт дайсанд тусалж
Буруу элэгтний зоргоор
Буурал нутгаа бусниулж
Буман олноо сөнөөх
Бузар хэрэгт оролцсонгүй.
Хүн хүний мэдэлд
Хүлээстэй зовлон эдэлсээр
Залуу хүрэн морины
Зан ааш нь хувирч
Хавьтаж талхисан хүн
Хамаагүй ширүүн оролдвол
Хайрч өшиглөдөг болж
Хажиглаж хаздаг болж
Морь эдэлж сураагүй
Онгироо сагсуу ноён
Мулгуу тэнэг хүчээр
Олмы нь гэнэт чангалтал
Танхай балмад түүний
Тарган махлаг мөрийг
Тавхийтэл үмхээд
Тасхийтэл шувтрав.
Хүүршсэн хувцасны цаанаас
Хүрэн цус нь нэвтрээд
Яс махандаа хадтал
Янгинаж сүрхий өвдөхөд
Харааж орилсон гамин
Хаалга хутгаа сугалаад
Хүрэн морины гуя руу
Хүчтэй гэгч нь дүрэв.
Хутга шаалгасан морь
Гуяа өвдөхийн эрхэнд
Зөрүүлж нэг хазаад
Зөрж нэг өшиглөөд
Шудран дайрч алдуураад
Шууд давхиад оджээ.
Завсрын дайсанд эдлэгдээд
Замын шороонд дарагдаад
Зан ааш нь хувираад
Завхарч явсан морь

Яагаад ийм болсныг
Ярьж өгөх үү? би.
Ардын хүүгийн зориг хурц
Адуун сүргийн туурай хурц
Эр хүний намтар элбэг
Эмээлт морины домог баялаг
Элбэг домгийн нэгээс
Эвлүүлж та нартаа хэлье
Баялаг намтрын нэгнээс
Бахдуулж та нартаа хэлье.
Ардын засаг мандах
Сайн цагийн түрүүнд
Аюулт дайсан сөнөх
Самуун цагийн эцэст
Баруун нэгэн хошууны
Баян ноёны зарц хүү
Ачит эхтэйгээ хамт
Амьдран суудаг байжээ.
Нарны гэрэл нэвтэрсэн
Навсгар хар бүрээстэй
Сарны туяа орсон
Салбагар уранхай үүдтэй
Ширүүн салхинд тэсдэггүй
Шидэмсэн муу бүслүүртэй
Ийм нэгэн гэрээс өөр
Илүү гарах хогшилгүй
Айлын хонь дагасан
Арван ямаанаас өөр
Ахиад тоолох малгүй
Хүний адуу бараадсан
Хүрэн мориноос өөр
Хүлэглэж унах унаагүй
Хөл нүцгэн ядуу байжээ.
Гар хоосон зүдүү байжээ.
Унадаг хүрэн морины нь
Уг байдлыг дурдвал
Ширээ сайхан нуруутай
Ширүүн цацган сүүлтэй
Шингэн мяндсан дэлтэй
Шигшмэл хүрэн зүстэй
Хурц дөрвөн туурайдаа
Хурдны удам хадгалсан
Соргог алхан толгойдoo
Эрдэнийн чанар бадруулж
Содон цагаан сарандаа
Эгэл тэмдэг тодруулжээ.

Энгүй өргөн нуруунд нь
Эмээл тохоод мордоход
Уул шиг өндөр зоотой
Усан тэлмэн жороотой
Адуун сүргийн манлай болсон
Аавын хүүгийн нөхөр болсон
Алдартай сайн морь байжээ.
Аагтай хурдан хүлэг болжээ.
Зузаан үүлний хур
Зуур зуур ороод
Зулзаган нялх мод
Зуун тийшээ дэлгэрээд
Навч цэцэг дэлгэрдэг
Нарны илч халаадаг
Зугаа цэнгэл бадарсан
Зуны эхэн сард
Ардын ядуу хүүгийн
Амраг хайртай ээжийн
Ариун нандин биед
Аюулт өвчин хүрчээ.
Харц бор хүү
Хайрт залуу эхийнхээ
Янтай өвчний уршгийг
Яавал арилгах вэ? гэж
Янз бүрээр бодовч
Ямар ч тусыг олсонгүй
Дэмий гайхаш тасрахдаа
Дэргэдэх айлдаа ороод
Баян эзэндээ бараалхаж
Байдал учраа гаргаад
Төрүүлсэн ганц эхийг минь
Түргэн эдгэрүүлж болох
Арга чарга байна уу? гэж
Арай ядан хэлж гэнэ.
Ноёд, тайж баян гэхдээ
Өнчнийг хэзээ тэтгэдэг байлаа
Номтой лам буянтай гэхдээ
Өвчнийг хэзээ эмнэдэг байлаа.
Харц зарцын үгийг
Харгис ноён сонсоод
Авралт бурхны зарлигаар
Анх эхээс төрөвч
Ад чөтгөрийн хүчээр
Адаг сүүлдээ үхдэг нь
Орчлон ертөнцийн тавилан юм
Олон амьтны лай юм.

Би одоо яах вэ,
Битгий чи сандар
Нялх бага наснаас чинь
Нярайлж өсгөсөн эх чинь
Үсээ буурал болтол
Насаа гүйцэд эдлээд
Хорвоогийн уух ус
Хувь заяа дутуу байжээ.
Гучин хоёр шүднээс нь
Ховхорч ер унаагүй
Шинэхэн хар гээгнээс нь
Ширхэг ч үс цайгаагүй
Ийм залуу насандаа
Ингэж өвдөнө гэдэг чинь
Эргэл мөргөл хийдэггүй
Эрхэм дээдэст залбирдаггүйн
Хар нүгэл нь болж байна.
Харин чи эхээ үхвэл
Бурхан тэнгэрийн оронд
Буцалтгүй төрөөсэй гэж
Буян номыг сайтар хийж
Буруу бүхнийг сайн тэвч гэж
Буурлын үнэт сургаалыг
Бузгай хэлж байвч
Өөхөөр хавагнасан нүүрт нь
Өрөвдөн тэтгэхийн шинжгүй
байв.
Өөдгүй улцан нүдэнд нь
Өглөгч бэлэгтний харцгүй байв.
Хэрцгий ноёны үгэнд
Гэмгүй зарц бухимдаж
Хэн юү хэлэх бол гэж
Гэр доторх хүмүүсийг харав.
Ханагар сайхан жороо хүрний нь
Хагацаахыг боддог ноёны хүү
Хар нохойн минь хөл доголжээ
Харц чи зодсон уу? гээд
Элдвээр дайрч доромжлоод
Эхийн тухай юу ч хэлсэнгүй.
Халуун элэгт ээжий нь
Хараан загнаж зоддог
Хатан зантай эхнэр
Хавьгүй муухай загнаад
Шавартай сайран хөлдөө
Шавхай наалдуулж ирээд
Ширмэл том ширдгий минь

Шинэхэн өнгийг гутаав.
Хэн чамайг дуудав гээд
Хэгжүүн дүртэй хялайв.
Эзэн дээдээ царайчлаад
Элбэрэл хүсээд орсон хүү
Зовлон дээрээ зовлон нэмээд
Золбоот нүднээ нулимс дүүргээд
Хөндлөн босгын дээгүүр
Хөлөө өргөөд гарахдаа
Дэргэдэх ардын зовлонг
Дэвсгэрээсээ доор үздэг
Тэнэг ухаантны хатны
Дээрэнгүй үгэнд гомджээ.
Номхон ардын амийг
Нохойноос доор санадаг
Ноёны хүүгийн хэлсэнд
Ноцтой хорсол хадгалжээ.

□

- Сүмбэр уулын оронд
Сүглэгэр үүл хураад
Сүрт цахилгаан цахилж
Сүрхий дуу нижигнээд
Азарган борооны түрүүч
Айхавтар ширүүн оров.
- Шүршин орох чимээг чагнавал
Шөнөжинөө шаагих бороо байна
 - Шүтээний өмнөх зулаа сэргээж
Сүүжээ амрааж унт хүү минь гэж
Шүүрс алдаж эх нь хэлээд
Шүлэг маанийг шивнэн уншив.
Зүгээр, ээжээ нойр хүрээгүй
Зүсэрсэн бороонд малаа алдвал
Зүүрмэглэж хэвтсэнээс долоон
дор
Зүдэг муухай хэрэг болно гэж
Өвчтэй байгаа эхийнхээ дэргэд
Өдөржин шөнөжин сахиж
суусаар
Унтах нойроо мартаж орхисон
Ухаалаг хүү ээждээ хэлээд
Зулайнхаа хөлсийг нэг арчаад
Зуландаа тос нэмж сэргээв.
Хур бороо ширүүсэж
Хурц цахилгаан цацраад
Бод мал үргэж
Ботго тугал шуугилдав.

Бог мал уруудаж
Болохоо ер нь байлаа.
Архи дарсанд цохигдон
Алмайрч согтон хэвтээд
Торгон хөнжил дотроо
Тохитой унтаж байгаа
Эзэн ноёны байдлыг
Эргэцүүлж хүү бодохдоо
Өнөө шөнө хонь уруудвал
Өглөө босоод би зүдэрнэ
Маш сайн хичээж байгаад
Малы нь алдахгүй хоноё гээд
Хөдсөн дээлийн танагаар
Хөөрхий эхээ хучаад
Тохмын шар эсгий
Толгой дээрээ тавиад
Хурдан хөлийн гүйлтээр
Хуйвт шилбүүрээ эргүүлээд
Уруудаж байсан малыг
Уул байранд нь тогтоов.
Бусад зарц нар шуугилдаж
Бухимдаж малтай хөөцөлдсөөр
Цаглашгүй зүдэрсэн хүүг
Цахилгааны гэрэлд хараад
Ор ор, ээжээ асар
Одоо бид малаа алдахгүй гэж
Ноёны амнаас гараагүй
Нот сэтгэлийн үгийг
Норж нэвтэрсэн ядуучууд
Ноорхой хүүд хэлжээ.
Нүх шиг шөнийн харанхуйд
Нүцгэн хөлөөр чулуу өшиглөж
Саарьтсан арьсы нь шалбалаад
Сандарсан хүү гэртээ оров.
Өргөсөн зулы нь эрвээхэй
цохиод
Өөхөн дэнгий нь салхи цохиод
Харанхуйн дунд дусаал дуулдаад
Хайрт эх нь чимээ ч үгүй байв.
Ихэд сандарсаар хүү
Ээжээ гэж дуудаад
Өөхөн дэнгээ асаатал
Өөв гэж дуугарав.
Сандарч тэвдсэн хүүгийн
Санаа сэтгэл тавигдаж
Бурхны өмнөх зулаа

Бушуухан гэгч өргөөд
Халамжит эхийнхээ нүүрийг
Харан харан зогсоход
Хоёр алаг нүд нь
Хонхойж баахан ядарсан
Хувирдаггүй хөрслөг царай нь
Хундан цагаан болсон
Хосгүй энэрэлт ээж нь
Гоц эгцэлж ширтээд
Хорвоо ертөнцийн жамыг
Хол ойргүй сэтгэж
Хоцорч үлдэх хүүгээ
Хонгор сэтгэлдээ бодохдоо
Дээрээс буусан дусаал
Дээл хучлагыг нэвтлэвч
Дороос тунасан чийг
Тохой нурууг хайравч
Биенд туссан өвчин
Бэрх хэцүү зовоовч
Уранхай хувцастай хүүдээ
Уул байдлаа хэлсэнгүй.
Өвчний хүндээс болж
Өнгө царай алдсан
Өнөр залуу эхээ
Өрөвдөж хайрласан хүү
Чулуу өшиглөснөө хэлсэнгүй
Цус гарснаа үзүүлсэнгүй
Дээлийн хормойд хөлөө нуугаад
Дэнгийн цөгцөнд тос нэмлээ.
Жижигхэн цагаан шүдтэй
Жигд тэгшхэн нуруутай
Хөгжүүн шударга зантай
Хөөрхий бор хүүгий минь
Инээж хөдөлж байгаа нь
Ээжийгээ дуурайсан гэж
Саахалт айлын чавганц
Сайшааж магтсаныг санаад
Энхрий танхил үрээ
Эвийлэн өхөөрдөн бодоод
Тооноо ширтсэн эх нь
Толгойгоо зовууртай хөдөлгөөд
- Хүү минь ээждээ ир гэж
Хүнд гүнзгий амьсгаа татав.
Дэнгийн хажуугаас хүүгээ
Дэргэдээ хүрээд ирэхэд
Дэрэн дээр нь ус дусаад

Дээлэн дээр нь дусаал тогтож
байв.
Шаагьсан борооны усыг
Цоорхой гэр яаж тогтоох билээ.
Шүүрсэн хурын дусаалыг
Цочирдсон хүү яаж тогтоож
билээ.
Дэмий л нэг гайхаж
Дээлий нь усыг шавхтал
- Сайхан хурын усыг
Саатуулж битгий асга гэж
Үрийнхээ сэтгэлийг тайтгаруулж
Үг сургамжаа захисан нь:
- Бүрээсний доор төрөөд
Булшны доор хэвтдэг нь
Бүхэл бүтэн хорвоогийн
Бодит нэгэн ёс юм.
Хананы дэргэд төрөөд
Хадны дэргэд хэвтдэг нь
Хамаг олон амьтны
Хазайж зайлдаггүй жам юм.
Нас чинь бага боловч
Цус чинь шингэн боловч
Хөл чинь дөрөөнд хүрч
Гар чинь ганзаганд хүрчээ.
Хүн амьд явахдаа
Эгэл олондоо зүтгэдэг,
Хүлэг замд явахдаа
Эзэн хүндээ зүтгэдэг,
Эр хүн эзгүй хээр
Эмээлт мориноосоо бүү сал
Эрэлхэг баатар эрхэм цагт
Эгэл олноос бүү хөндийр гэдэг,
Ямбат ноёдын хүүхдийг
Ямар ч байсан битгий түш!
Ядуу айлын хүүхдээс
Яльгүй ч гэсэн битгий холд!
Ядрах цагт ард чинь тусална,
Ярах цагт морь чинь тусална
гэлээ.
Арван сар тээж гаргаад
Ангир уургаа шимүүлж өсгөсөн
Асралт эхийнхээ үгийг сонсоод
Айх тэвдэх нь улам нэмэгдэж
- Ээж минь та юу хэлж байна?
Энэ гэрээсээ битгий холдооч?

Нарт өргөн дэлхий дээрээ
Надтай хамт байгаач? гээд
Бор хүү нулимсаа унагааж
Борооны дусалтай нийлүүлэв.
Зогсолтгүй орсон бороо
Жалган дундуур үерлэхэд
Зовлонт хүүгийн шаналал
Зүрхэн дундуур үерлэв.

□

Үүлээ цааш нь нуусан шиг
Өндөр тэнгэр цэлмээд
Үдшийн орсон бороо
Өглөө болоход арилжээ.
Хурмаст тэнгэрийн нар
Хөдөө хээрийг гийгүүлж
Хурын тунгалаг ус
Хөрст дэлхийг ундлавч
Шар эсгий гэрт
Ядарсан бүсгүй ёолсоор...
Шаналсан хүүгийн нүүрэнд
Ядуугийн нулимс бөмбөрсөөр...
Нойргүй хоносон хүүхэд
Норсон дэвсгэрээ аваад
Наранд ээж хатаахаар
Навтгар гэрээсээ гартал
Гурвалжин үүрэг үүрсэн
Гурван шоо өвөртөлсөн
Хавчиг үүрэг үүрсэн
Хар аяга өвөртөлсөн
Хорвоогийн уужим зайд
Хойш урагшаа хэрсэн
Хот айлын нохойг
Хоёр модоор тоншсон
Бардам сагсуу зантай
Бадарч айсуй харагдлаа.
Тэвдсэн хүү хурдаараа гүйгээд
Тэр бадарчийн өмнө нь очоод
Халуун энэрлээр тэжээж өсгөсөн
Хангай дэлхий шиг түшиг
болсон
Хайрт ганц эхийн минь биед
Ханиад хүрээд хэцүү байна.
Бодь хутагт лам минь та
Болгоож хайрлаж өгнө үү? гэж
Бор өвдгөө сөхөрч суугаад,
Бодсон хүслээ айлтгаж гэнэ.

Ховдог махчин шувуу
Хүүрийн үнэрт дуртай байдаг.
Хорт санаат ламтан
Хүний зовлонд дуртай байдаг.
Балмагдсан хүүгийн үгийг
сонсож
Бадарч лам гэрт нь ирээд
Маань уншаад судсы нь барьж
Магтаал уншаад адис өгчээ.
Өнөр түшиг эх чинь
Өвчин гамшиг ихтэй байна.
Амь насы нь сүйтгэх
Ад чөтгөр шүглэсэн байна.
Аврал буян сайн хийвэл
Амьд гарахын заяа байна гэж
Эрдэнийн гурван шоод минь
Ил тодорхой буулаа гэв.
Зандан шоо буруу таасныг
Жаал хүү яаж мэдэх вэ?
Зальт лам хууран мэхэлснийг
Залбирсан бүсгүй яаж мэдэх вэ?

□

Явган энэ үлгэрийг
Ярьж хэлж байхдаа
Даахийн чинь ширэлдээ гараагүй
Давхар нүдний чинь хараа
гүйцээгүй
Гурван настай нялх цагт
Гунигт өвчний уршгаар
Гаргасан эх чинь эцэслээд
Ганцаараа чи үлдсэн гэж
Өвгөн эцэг Чойжилжавын
Өрөвдөж хэлснийг санадаг би
Завхарч ярихаа зогсёё.
Залгаж үлгэрээ хэлье.
Галуу шувуу дуугарсан
Хавтай дулаан улиралд
Галт нар ээсэн
Халуун гэгчийн өдөр
Зовлонт өвчин нь хүндэрсээр
Зовхит нүд нь буурсаар
Ачит хонгор эх нь
Амьсгаагаа гүйцэд хураагаад
Амин халуун судас нь
Ахиад цохихоо болив.
Залуу эхээ үхүүлсэн

Зарц бор хүү
Заяа зовлондоо гомдож
Зангирсан нулимсаа урсгахад
Хүний үхэл олныг үзсэн
Хомхой тэр гэлэн
Хүрэн морины сургаар
Хорхойтох сэтгэл нь хөдлөв.
Элэгдсэн шар эрхээ
Эргүүлэн тоолон байж
Элэнц хуланцын буян нүгэл
Энэ тэр, сайн муу
Элдэв янзын цэцэн үгээр
Эрдэмт гэгдсэн тэр бадарч,
Эхэр татан уйлж байгаа
Эгэл хүүд ингэж хэлэв.
- За хүү минь битгий уйл
Залуу хөгшин хэн нь ч
Зайлшгүй нас бардаг нь
Заяасан ертөнцийн зохиол юм.
Нөхцөсний хойноос уйлбал
Нүгэл хилэнц арвижаад
Үүрдийн оронд тонилох
Үхсэн сүнсний нь замд
Үер болж саатуулдаг
Үнэн номын ёс бий.
Хорвоо өнгөрсөн эхийн чинь
Хойтохыг би хийнэ гээд
Хонх дамраа дуугаргаж
Хоёр ерөөл уншжээ.
Нарт амьдралаас салж
Нас барсан эхний нь
Хүйтэн болсон биеийг
Хүнд хөх чулуутай
Тэнцүүлэн хүлж байгаад
Тэмээнд тэгнэж ачаад
Бэлчээр нутгийн цаана
Бэл чулуу дэрлүүлж
Огцом жижиг талбайд
Оршуулж орхиж ирээд
Хүндэтгэл буян хийсэн гэж
Хүж зул асааж гэнэ.
Хүүрийн яс барьсан гэж
Хүрэн морий нь авч гэнэ.
Өрөвдөж хайрладаг ээжээсээ
салж
Өөр хүний хөл болоод

Төрсөн нутгаас холдож
Түмний газар чиглэхдээ
Хань ижилдээ тэмүүлж
Хазаар даран булаалдавч
Харц эзэндээ хоргодож
Ханаран эргэн хөндөлдөвч
Хатан төмрийн хүчинд
Халуун амаа мэдүүлсээр
Хатуу модон ташуурт
Хаа гуяа нүдүүлсээр
Жороо хүрэн морь
Жолоо цулбууртаа захирагдав.
Жолоо цулбуур хоёр нь
Зодоч ламд хумигдав.
Ааг сайтай хүлэг минь
Амар мэнд яваарай
Аз завшаан таарвал
Ахиад хоёулаа уулзана гэж
Хүү дотроо бодоод
Хүрэн морио харсаар
Нулимс гоожсон нүдээ
Нухлан арчин үлдэв.
Ядарч өнчирсөн хүү
Яахаа мэдэхгүй хаягдахад
Явган ирсэн бадарч
Явдалтай мориор буцжээ.

□

Өөрийн эзнээсээ хагацаж
Өнөр ижлээсээ тасарч
Өргөн нутгаасаа алслагд
Өлөн бадарчид унуулсаар
Хүрэн жороо морь
Хүний газар ирэв.
Амгай зуузай дуу гаргасаар
Алс хол ирэв.
Эх нутгаас гарахад
Ээлтэй зөөлөн зун байжээ.
Энэ газар ирэхэд
Эрс хатуу өвөл болжээ.
Хоосон сурталт ламтай
Холын тэртээгээс ирээд
Хүрэн морины ядарсныг
Хөөрхийлж огт бодолгүй
Хүйтэн жаварт өвлийн
Хүй хунгар цасанд
Хөлстэй тохмоор хайрч

Хөлдүү амгай зуулгаж
Өл тэжээл өгөлгүй
Өдөр болгон унаж байв.
Сөл хазуулах төдийгөөр
Шөнө болгон чөдөрлөж байв.
Өвлийн бэрх улирлын
Өдөр шөнө хоёрыг
Аль муу зовлонгоор
Арай чарай өнгөрөөгөөд
Хаврын сар гарч
Хамаг амьтан тэнийхэд
Яндан хүрэн морь
Яс арьс болжээ.
Хөтлийн цас хайлж
Хөх ногоо цухуйлаа.
Хөхөө өвлийн хүйтэнд
Хөрч ядарсан мал
Тамир чадлаа олбол
Дахиад унахад тустай гэж
Тэнэмэл тэр бадарч
Тэнэг ухаандаа бодоод
Ногт чөдрөөс нь салгаж
Ногоо хэд хазуулья
Хээрийн бэлчээрт гаргаж
Хэд хоног амрааа гээд
Алжааж турсан хүрэнг
Айлын адуунд тавьжээ.
Ижилдэж дасаагүй сүрэгтэй
Итгэж хамт явахад
Өнгө удам нэг боловч
Өшиглөж, хазах нь олон байв.
Энэрэлгүй муу эзний
Эмээл хазаараас салсан ч
Идээшилж дасаагүй нутагт
Их л уйтгартай байв.
Тууш нуруу нь халцарч
Дөрвөн туурай нь эмтрээд
Туг сүүл нь ширэлдсэн
Туранхай хүрэн морь
Шинэхэн ногооны шимийг
Чөдөргүй идэж
Шингэн булгийн усыг
Чөлөөтэй ууж
Шаналсан бие тэнийж
Шар үс нь унав.
Санаа сэтгэл нь хөдөлж

Саруул нутгаа бодов.
Навч цэцэг дэлгэрч
Нарны илч дулаараад
Уул тал ногоорч
Ус гол шуугиад
Хурын тунгалаг рашаан
Тэнгэрийн үүлнээс буугаад
Хун цагаан шувуу
Тэнд эндгүй ганганаад
Хөхөө гургалдай хоёр
Ээлж дараагаар донгодож
Хөвчийн өндөр ууланд
Эгшигт дуугаа дамжуулахад
Нутгийн сайхан байгаль
Нүдний өмнө үзэгдээд
Хань ижлийн дуу
Халуун чихэнд сонсдов.
Хөнгөн төмрийн үртсийг
Хүдэр соронзон татдаг шиг
Хүрэн морины сэтгэлийг
Хүсэлт нутаг нь дуудав.
Унаган бага наснаасаа
Усы нь ууж өссөн
Дааган бага цагаасаа
Даваа гүвээгий нь хэссэн
Өнө тавиун бэлчээрээ
Өөрийн эрхгүй санаж
Хэт нутагтаа гүйх гэж
Хэд хоногоос зөгнөөд
Задгай бэлчсэн адууны
Захад нь явдаг болжээ.
Үлгэрийн эхэнд үзэгдсэн
Үгийн үзүүрт яригдсан
Идэр хүрэн морь
Ингээд гүйсэн байжээ.
Яриан дунд орхигдсон
Ядуу өнчин хүү
Яаж амьдарч байгаагийн
Явдал төрхийг хэлэх үү?
Дотроос буцалсан уур хилэн
Гаднаас нөмөрсөн гашуун зовлон
Өргөн түмэн Монголыг
Үер мэт дайрч байхад
Өнчин ганц хүүг бас.
Үүл мэт бүрхэж байв.
Алтай их дэлхийн

Адал явдлыг бодоогүй ч
Ард Монгол хүмүүсийн
Аймшигт зовлонг бодож
Алс хэтийн жаргалыг
Ариун зүрхэндээ хүсээд
Энхрийлж өсгөсөн эхийнхээ
Эрхэм шарилыг тавьсан
Өөгүй бяцхан талбай дээр
Өнчин хүүхэд ирэв.
Намуухан зөөлөн салхи
Наалинхай янзаар илэхэд
Урсаж байсан хөлс нь
Урьхан салхинд эвэрнэ.
Давхар алаг нүдээр
Тал хөндийг ширтэхэд
Тэмээн сүргийн бараа
Тэртээ баруунаас сүүмэлзээд
Жирийн хоосон зэрэглээ
Жирэлзэн торолзож харагдав.
Хүн малаас буйдхан
Хөдөө хээрийн бэлчээрт
Хүүрийн газар ирсэн
Хүүгийн сэтгэл үймрээд
Орчлон хорвоогийн амьдрал
Олон зүйлийн бодол
Оюун ухаан дотор нь
Орон гаран байлаа.
Уран авьяас бүрдсэн
Төвшин сайхан хуруу нь
Уяруун сэтгэл тодорсон
Дөлгөөн харцат нүд нь
Хөдөө хөхөрч явахдаа
Хүйтэнд даарч байхдаа
Хөлдөж ер үзээгүй
Хөрслөг бор хацар нь,
Үр минь, хүү минь гэж
Үг хэлэхийнхээ эхэнд
Үргэлж дандаа энхрийлдэг
Үнэн хайрын чанар нь,
Тэнгийн хүндийг өргөж
Тэмээнд ачиж байхдаа
Эр хүнээс дутуугүй
Эрдүү чийрэг тэнхээтэй нь
Ноднин жилийн зун
Ноёны үнээ саагаад
Ууртай хатанд загнуулж

Уйлж байсан дүрс нь
Өөрийн бор гэртээ
Өвдөж шаналж байхдаа
Үр ганц хүүдээ
Үгээ захиж хэвтсэн нь
Харах нүдэнд үзэгдэж
Халуун санаанд бодогдов.
Эцэс болсон эхий нь
Эмзэг цогцос арилаад
Ээрэм цагаан яс нь
Энд тэнд сарниад
Сайхан хар гээг нь
Салхинд хийсэн үрэгдээд
Дэрийн улаан чулуу л
Тэр хэвээрээ үлджээ.
Эхийн сүүж нь хүрсэн
Эрдэнийн шороон дундаас
Цэлмэг тэнгэрийн өнгөтэй
Цэцэг ургасан байлаа.
Урин салхинд ургасан
Удвал цэцгийн өнгийг
Удтал ширтэн хараад
Уйлж суусан хүү
Алиа хонгор ээжээ
Аргагүй дуудмаар ч болов.
Ардын гунигт дууг
Аялан дуулмаар ч болов.
Хуучин цагийн үлгэрийг
Хуурдаж уншмаар ч санагдав.
Хурдан хүрэн морио
Хурайлан далламаар ч бодогдов.
Оргил хайрхан нь сүндэрлэж
Огторгуй нам гүм байтал
Үр ачаа дагуулан
Үелэн нисэж яваа
Тогоруу шувуу шуугилдаад
Толгой дээгүүр өнгөрөв.
Ачит залуу эх минь
Амар мэнд байсан бол
Алаг үрээ дагуулсан
Аянч шувууны адил
Асарч өсгөсөн намайгаа
Ариун гартаа хөтлөөд
Алхаж явах байсандаа гэж
Амьсгаа даран бодоод
Хошууран нисэж байгаа

Хун цагаан тогорууг
Сайхан харцаараа ширтэж
Санаа алдан суутал
Чимэгт ариун талын
Чимээгүй байдлыг доргиож
Цохиот өндөр уулсын
Цууриаг цочоон хөгжөөгөөд
Унгалдан янцгаах дуу
Уянгалан гэнэт хангинав.
Зүүд нойрын дүрс үү?
Зүй ёсны тэмдэг үү?
Зөн бэлгийн ёр уу?
Зүгээр жирийн чимээ юү? гэж
Олон шувууны хойноос
Онцолж харахаа болиод
Өргөн тэнүүн талын
Өнцөг буланг ширтлээ.
Торомгор хар нүдний
Тодхон соргог хараанд
Хурдан жороо морь нь
Хуй тоос босгоод
Хангинатал унгалдаж
Хатиран айсуй харагдав.
Жингэнэтэл янцгааж
Жирийтэл хурдалж үзэгдэв.
Баярын халуун амьсгал
Байж тогтон үймэх шиг
Бат цагаан цээжээс
Багтаж ядан гараад
Уйлаад хавдсан нүдий нь
Угааж өгөх гэсэн шиг
Уярлын зөөлөн нулимс
Улам улам асгараад
Сайхан хүрэн зүстэй
Сайн морь минь ирлээ гэж
Энгүй баяртай хэлээд
Ээжийгээ дуудах шахлаа.
Гуалиг хүрэн морио
Гурий гурий дуудаад
Гунын суран ногтоор
Гурав дөрөв даллав.
Энэ нутгаа бараадаж
Эзэн хүнээ харсан
Хүрэн жороо морь
Хүүгийн дууг таньж
Хатиран хатиран давхисаар

Хажууд нь хүрч ирээд
Алхан толгойгоо нааж
Ариухан хошуугаа шөргөөж
Үнэрлэн үнэрлэн тайвшрав.
Үүрсэн үүрсэн талархав.
Арван давхар аюулаас
Арай гэж зугтаж ирсэн
Алдарт сайн морио
Ажиглан тойрон харвал
Дааган согсоо нь ширэлдэж
Ташаан толгой нь ёрдойгоод
Суман дэл нь хийсэж
Сунах хөл нь чичрээд
Урт иштэй хутга
Улаан гуянд нь шигдээд
Ухаа ягаан цус
Урсаж гарсан байлаа.
Хөх төмөр хутгыг
Хөхсөн махнаас сугалж
Халуун бүлээн шархыг
Хангайн цэцгээр эмнэж
Хайрт хүлгийнхээ гуяыг
Харзын усаар угааж
Хатааж хийсэн хутгыг
Хайрган билүүгээр билүүдэв.
Хутга хэдий моховч
Гуранзан билүүгээр хурцалдаг,
Эмзэг шарх гаравч
Эмийн хүчээр эдгээдэг.
Морины чадал ч сэргэлээ.
Мохоо хутга ч ирлэгдлээ.
Эхээ үхүүлж өнчирсөн
Эгэл ардын хүү
Эрийн цээнд хүрээгүй ч
Эрхэм үйлсэд зүтгэхээр
Элэг нь харлаж хатсан ч
Эрх чөлөөгөө олохоор
Хэргийн эзэн бадарчаас
Хэрмэл муухай дайснаас
Өшөө хорслоо авах
Өвтэгш зорилго тавиад
Эрэлхэг хүрэн мориндоо
Эмээл тохож мордоод
Иртэй том хутгаа
Иший нь чанга атгаад
Ардын партизан цэргийн

Ариун жагсаалд нийлэхээр
Алтан шар замдаа
Аялан дуулсаар оров.
Өнөр хүрэн морь

Өнчин хүү хоёрын
Үнэн учир ийм байна.
Үлгэр одоо төгслөө.

1947 он

Асууулт даалгавар:

4. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
5. Зохиолын уран дүр, дүрслэлийг тодорхойлон бичнэ үү?
6. Зохиолын агуулга, үзэл санааг тодорхойлон бичнэ үү?
7. Зохиолд зохиомжийн задлал хийнэ үү?
8. Зохиолын хэсгээс цээжилж, урнаар уншина уу?

“Дайны жилийн алим буюу сургуулийн зээрд”

С. Дашдооров

Манай сургууль нэг өдөр даагатай
болсон юм.
Магнай дээрээ сартай
Нээрэн өхөөрдөм амьтан байсан юм.
Сумын төвийхөн түүнийг
Сургуулийн зээрд гэлцэнэ.
Хэрэв манай нутгаар
Айлчилж очиж гэмээ нь
Хэн нэг малчнаас
Асууж сураглаж гэмээ нь
Сургуулийн зээрдийн тухай
Домог хууч сонсох ч гэлээ
Унаган дуугий нь андахгүй
Асарч тэжээж явсан болохоор
Уран толгойгий нь илбэж
Өхөөрдөж хайрлаж явсан болохоор
Яруу сайхан намтры нь
Ярих хүн нь гэж бодлоо
Явдал учры нь тайлж
Хуучлах эзэн нь гэж саналаа.

Хөөрхөн зээрдийн түүхийг
Хөөрье гэж санатал
Хөвөрч бодогдоод байх юм.
Хөгжөөнт багын явдлаа
Хүүрнэе гэж бодохоор
Хөөрхөн зээрдийн төрх
Хөвөрч үзэгдээд байх юм.
Цагийн урсгалд элэгдэмгүй
Үйл явдлаар баян
Цаашлах дутам мартамгүй
Элдэв учралаар дүүрэн
Зүүд нойронд үзэгдэх
Өсвөр багын паян
Зүрх цээжинд хадаатай
Хэчнээн ч дотно байдаг гэхэв!
Хар нүдэнд буух
Тэр цагийн явдал
Халуун сэтгэлд уяатай
Хэчнээн ээнэг санагддаг гэхэв!

Хорин жил

Бараагий нь хараагүй ч гэлээ
Хонгор зээрд минь
Давхиад ир, хүрээд ир!
Холбоо шүлгийн мөрөнд
Сүүлээ хатган цахилаад ир!
Хорин жилийн чанадаас
Тоосоо босгон цогиод ир!
Унаган цагийн дуугаараа

Хангинтал үүрсээд ир!
Уянга найргийн мөрөнд
Цангинтал янцгаагаад ир!
Торомгор нүдий чинь
Хүүхэд багачууд үзэг!
Толин сары чинь
Хөвүүд охид хараг!

Манай сумын төв

Хөхөмдөг өндрийн оройд
Хадсан юм шиг ярайх

Хөх-Овооны суганд
Ургасан юм шиг торойх

Хоор хоорондоо ижилхэн
Долоо найман байшин
Хоёр гурван газар
Гуч дөчөөд гэр
Сумын маань бяцхан төв
Хар нүдэнд тодорхой
Суурин газар гэвч
Хөл хөгжөөн авсаархан
Улсын далбаа
Дээрээ залсан
Сумын захиргааны байшин
Утасны шон нь
Гадаа нь өндөрлөсөн
Улаан булангийн барилга
Унаа морьд
Шонд нь тасрахгүй
Дээд доод хоёр хоршоо
Угаасан даавуу
Хэцэнд нь дэрвэлзэх
Цэмцгэр эмнэлгийн хашаа
Хэв янз нь
Ав адилхан ч гэлээ
Яваад үзвэл ондоо
Хэзээ барьсан нь
Бүүр түүр ч гэлээ
Ёотон шиг цав цагаан.
Өндрөөс өндөр
Тэр харшуудын дунд
Өнгөлөгөөс өнгөлөг
Тэр барилгуудын дэргэд
Сургуулийн маань байшин л
Онцгой гэмээр санагддаг сан

Манай сургууль

Манай сургуулийг улс
Магтаж бахтагдаа дуртай байдаг
юм.
Аглаг говьд байгуулагдсан
Анхны танхим гэж ярилцдаг юм.
Өндрөөс өндөр харагдах
Манай сумын харш дунд
Өнгөлөгөөс өнгөлөг яралзах
Манай сумын байшингуудын
дэргэд
Сургуулийн маань барилга
Онцгой өндөр санагддаг сан
Суурин төвдөө л ганцаараа

Сумын төвдөө л ганцаараа
Оргил гэмээр харагддаг сан.
Манай сумыг зорьсон,
Алсын харгуй дөрвөн зүгээс
Манай сумаас гарсан
Алтан зам найман зовхист
Умрыг зорьсон замаар
Жингийн цуваа одно
Удаж, удаж нэг л өдөр
Жирийтэл цуваад ирнэ.
Арын замаар дорно зүг
Улаач өртөөчид довтолгоно.
Аймгийн төв, цаашаа хот
Алба ажлын улс зорчино.
Бусад зам нь яахав
Бууц өвөлжөө рүү одно.
Ус худаг, малын бэлчээрт,
Уусан шингэтлээ зурайн хөвөрнө.
Манай сумын төвөөр, харин
Машин л ховорхон ирдэг сэн
Хааяа нэг ирвэл ч
Харааны газраас тосдог сон.
Хүнгэнээд ирэх
Дуу нь хүртэл сонин байдаг сан
Хүврээд үлдэх
Мөр нь хартал гоёхон байдаг сан.
Дээр нь зүтгэж гарсан бол
Дээд тэнгэрт гарсан мэт баясдаг
сан
Ойр зуур сууж үзсэн бол
Огторгуйд ниссэн мэт баярладаг
сан.

Оргил гэмээр байдаг сан.
Өгсөж орох шат нь
Өндөр болоод сүрлэг
Өрөө тасалгаа нь бүр
Өег болоод уужим.
Гэгээвч цонх нь ч олон
Наранд гялалазах нь янзтай
Гэрэл дэнлүү нь содон
Найман зовхист хүртэцтэй.
Тэр сайхан ордон руу
Сүрдэн сүрдэн дөхөж
Тэнгэрт ойрхон дээврий нь
Өлийн өлийн дөтөлж

Худгийн асгар арилаагүй
Гутал юугаа цэмцгэрхэн гишгэж
Хурганы бэлчээрээс холдоогүй
Сэтгэл юугаа цээжиндээ тээсээр
Анх түүний босгыг
Татаж орсноо марташгүй
Алаг зүрх гирэвшүү
Ойртож очсоноо ч умарташгүй.
Ардын сургууль гэдэг
Алдрыг хүртсэн тэр байшинд
Арвин эрдмийн талбар гэж
Ачаа дуудуулсан тэр газарт
Оюун сэтгэлээ нээсэн
Олон аавын үрс бий
Эрдэм номд шамдсан
Ээжийн олон хөвгүүд бий.
Дөчин хэдэн оны намар
Энэ сургуульд орсон бүхэн
Дөрөө юугаа мялайлган
Сүргийн бэлчээрээс ирсэн болгон
Дэлгэж урдаа тавьсан
Дэвтрээсээ хүртэл сүрдэж
Хуруу гартаа барьсан
Харандаа юундаа түүртэж
Эрднийн цагаан толгой
Эхэлж нүдэлснээ санаж яваа

Манай ангийхан

Нэг ангийн хүүхэд
Гучин тавуулаа байлаа
Нэгэн нуурын шувуу шиг
Шуугьж тоглож явлаа.
Нэмээд хэлэхэд бид
Гучин тавуулаа нэг морьтой байлаа
Нэр овог шигээ бас
Гучин таван хочтой байлаа.
Өглөөний нартай уралдан
Өргөө танхимдаа цугларна.
Багшийн заасан хичээлээр
Балчир оюунаа гийгүүлнэ
Завсарлагаанаар бид
Хөөцөлдөж хөгжиж тоглоно.
Заримдаа, хүний нүднээс далд
Барилдаж, чадлаа үзэлцэнэ.
Хоч нэрээрээ дуудалцаж
Хоорондоо ялимгүй муудалцана
Бачимдаж гомдсон нэг нь

Эрдэм номын үрийг
Эрхэмлэж ухаарснаа бодож яваа
Бие нас найм хүрч
Би тэгэхэд найм хүрч билээ
Бичгийн ширээ тохойлдон
Бид гучин тавуулаа сууж билээ.
Сургуулийнхаа танхимд бид
Дөрвөн намар цугларч
Сурлагынхаа дүнг бид
Арван зургаан удаа дуулж
Балчир насаа орхин
Сурах бичигтэй ижилдсэн юм.
Бага сургуулиа дүүргэн
Цаашаа бид замнасан юм.
Гэвч энэ сургуульдаа
Гэр шигээ хайртай байдаг юм.
Гэгээн эрдэмд замнуулсан
Гэрэл дэнлүү гэж биширдэг юм.
Манай сургуулийг улс
Магтаж ярихдаа дуртай байдаг юм
Аглаг говьд байгуулагдсан
Анхны танхим гэж ярьдаг юм.
Унаган багын сэтгэлээрээ
Дурсаж бахдаж явахдаа
Ууган ийм сургуулийн
Сурагч байсандаа бахархдаг юм.

Багшид мэдүүлж “хов” зөөнө.
Захирал багш нараас
Зэмлэл шийтгэл ч хүртэнэ.
Залхаж хашрахгүй тэгснээ
Зарим нэгнээ шоглож орхино.
Гэхдээ бид эвтэй
Гэр гэртээ тусархуу
Шинэ ном нийлж уншдаг
Ширхэг чихэр хувааж амтархдаг
Нэг ангийн хүүхэд бид
Гойд дотно байсан юм.
Нэгэн нуурын шувуу шиг шуугьж
наргиж дассан юм.
Дасаж зөндөө ижилдсэнээ
Дамай дотно болсноо
Нэг л өдөр, тэр өдөр
Нээрэн сайн мэдсэн юм.
Дэврүүн бага насаа
Сургуулийнхаа танхимд орхиж

Дэндүү гэнэн зангаа
 Сурагчийнхаа ширээнд үлдээж
 Анги танхимдаа, хуучин янзаараа
 Ахиад цугларахгүйгээ ухаарч
 Муудаж сайдаж явсан ч гэлээ
 Мундахгүй дотно болсноо анзаарч
 Налгар хаврын тэр нэг өдөр
 Гэр гэр лүүгээ зорьсон сон
 Найман зовхист зурайсан
 Зам замаар орсоон.
 Салж одсон тэр мөч
 Санаа сэтгэл донслуулсан юм
 Сарвалзаж далласан гарууд
 Сац бас уяруулсан юм.
 Аймгийн төв бараадаж хэд нь
 Дунд сургуульд орж
 Ах эгч нараа түшиж, хэсэг нь
 Улсын нийслэл зорьж
 Адуу малаа дагаж, зарим нь
 Ус нутагтаа үлдээд
 Алба ажил залгуулж нөгөө нь
 Төв сууринд суугаад
 Бүл халуун амиараа, түүнээс хойш
 Цугларч бид уулзсангүй
 Бүлээн гараа атгалцан “Албан хүрээцэж”
 тоглосонгүй.
 Бүлэг салаадынхаа
 Туган дор жигдэрч жагссангүй
 “Бүхий олон багачуудаа”
 Хоолой нийлүүлж дуулсангүй.
 Нэг ангийхаа багачуудын

Нэрсий нь жагсаан бичээд
 Хаана, хэн одоо юу хийж байгааг
 Хаяг ажлаар нь сураглахад
 Аймгийн дарга, нэгдлийн ня-бо
 Авьяастай дуучин, хүний эмч
 Нэртэй сэтгүүлч, сургуулийн багш
 Нэхмэлийн инженер, ерийн малчин
 Тээврийн жолооч, цэргийн дарга
 Тэр ч байтугай дэлгүүрийн худалдагч
 Уурхайн өрөмдөгч, барилгын даамал
 Уурын зуухны галч, уран зураач
 Янз янзын ажил мэргэжилтэй
 Явж байна аа, амьдарч явна аа
 Яруу найрагт магтаж дуулмаар
 Яриа хөгжүүн, сэтгэл хангалуун явна аа!
 Хармсалтай нь нэг маань ослоор
 Хан хорвоогоос халин оджээ.
 Бас нэг үеийн найз маань
 Балагт өвчнөөр өөд болжээ.
 Наргиж тоглож байхдаа бид
 Найз тэднээ гомдоогоогүй байгаа!
 Хэрвээ тэгсэн бол тэднээсээ
 Хэзээ ч уучлал эрэх аргагүй болжээ!
 Тэгэвч, бид тэр л жилийн төрхөөр нь
 Тэднийгээ бид дурсдаг билээ л
 Том хүний сэтгэлээр, одоо
 Тоотойхон насы нь харуусдаг билээ л.
 Ангийн минь багачууд, аавын үрс
 Аз заяа дүүрэн явтугай!
 Эхний минь танил, ээжийн олон үрс
 Эсэн энх байтугай!

Миний найз Өлзий

Миний найз Өлзийг
 Мэддэг хүн олон болов уу
 Мэрийж санаж явдгий нь
 Сонссон хүн хэд бол?
 Өлзий бид хоёр
 Өө зайгүй үерхэнэ
 Ижий аавын хишгийг
 Ижил тэнцүү амтархана.
 Үеийн хоёр аргагүй гэж
 Хөгшид настан өхөөрдөнө
 Үерхэж тоглож өссөн юм гэж
 Хөөршөөж биднийг магтана.
 Уг нь бид хоёр
 Ус нутаг нэгтэй

Айл саахалт байж
 Аргагүй дотно болсон юм.
 Галуу шувуу шиг, бид
 Гангар гунгар гэлцэн
 Ангир шувуу шиг бид
 Аан уун гэлцэнэ
 Ишиг хурганы бэлчээрт
 Ижил дасал болсон юм
 Ээрэм талын дунд
 Эрээн чулуу түүсэн юм.
 Нутаг бүхэн дээр
 Чулуун гэр барьж
 Нуга хаданд гарвал
 Нуугдаж зөндөө тоглож явсан юм.

Бургасан шилбүүрээ бид
 Булаалдаж ч явсан үе бий.
 Баривч дээлээ бас
 Уралцаж байсан цаг ч бий.
 Эвлэрэхдээ бид хоёр
 Тун амархан явж.
 Эвдрэлцэхдээ ч бид хоёр
 Тулгуу эмзэг байж.
 Өлзийн барааг харахгүй бол
 Өр зүрх зөндөө уйддаг сан
 Намайг байхгүй бол бас
 Найз маань зөндөө санадаг сан.
 Санаандгүй хөөцөлдөж яваад
 Шаазан аяга хагалах ч юм уу
 Амттай сайхан чихэр
 Авдар савнаас авах ч юм уу
 Аав ижийд зэмлүүлэх
 Хэрэг төвөг гаргахдаа
 Ах эгч нарт загнуулах
 Явдал уршиг тарихдаа
 Хоёр биеийнхээ нууцыг
 Гойд сайн хадгалдаг
 Хоёр зүрхнийхээ зовлонг
 Хосгүй сайн мэддэг.
 Эвтэйгээс эвтэй
 Эрхэлж өссөн юм.
 Элэгсгээс элэгсэг
 Ээнэгшиж дассан юм.
 Эндээ гэхэд Өлзийн маань
 Эмээдээ баахан эрх
 Эмээ нь ч гэсэн Өлзийг
 Эрхлүүлнэ гэдэг бэрх.

“Миний найзын яриа”

Миний найз Өлзийг
 Мэддэг улс гэвэл, манай ангийнхан
 Мэрийж санаж явдгий нь
 Дуулсан хүн гэвэл, ганцхан би.
 Нэг жил, бид хоёр
 Сургуулийн босго алхав аа
 Нимгэн даавуун цүнхтэй
 Сурагч нэртэй болов оо.
 Танихгүй хүүхдүүдээс бишүүрхэж
 Нэг ширээнээ суув аа
 Танхимын самбар ширтэж
 Эрдэм номд шамдав аа.
 Өглөө болгон цуг

Өөгүй сайн хүү гэж
 Өлзий найзаа нэрлэж чадахгүй
 Адайр зан нь хөдөлбөл
 Амархан тайтгарна гэж үгүй.
 Холдсон ботго эргүүлэхдээ
 Хойрго гэдэг яриагүй
 Хонь малд явахдаа
 Хоргодоо гэж аргагүй.
 Өөрийнхөө дургүй юманд
 Намайг л зарах гэдэг сэн
 Өвчин хууч хөдөллөө гээд
 Шалтаг тоочоод суучихдаг сан.
 Тэглээ гэхдээ найздаа би
 Муу юм санаагүй
 Тэр зангий нь мэддэг болохоор
 Гомдож их гонсойгоогүй.
 Харин манай найз
 Адуунд хачин дуртай
 Хангал догшин унаж
 Азаа үзэх хүсэлтэй.
 Эмнэг даага сургана гэж
 Эмээл хазаар ч зэхүүлсэн юм
 Харсаар байтал зургаатайдаа
 Гурван даага унаашруулсан юм.
 Моринд гарамгай хүнд
 Монгол хүн дуртай хойно
 Адуунд шалмаг хүнийг
 Ам амандаа магтдаг хойно
 Би ч гэсэн найзаа
 Биширч бахдаж явдаг болсон юм.
 Аргамаг хүлэг эдлэх
 Азтай хүн гэж боддог болсон юм.

Хичээл номдоо ирнэ.
 Өдөр нь аанай л хамт
 Гэр гэртээ харина.
 Гэр сургуулийн хооронд
 Ам хурай явна гэж үгүй
 Хэтдээ хоёулаа
 Ямар хүн болохоо ярина гэж тоймгүй.
 Дайн болбол, найз минь
 Хамгийн түрүүнд явна гэдэг юм.
 Дандар баатар шиг
 Алаг морьтой болно гэдэг юм.
 Зэвхий дайсныг цавчих
 Хурц сэлэм зүүнэ гэдэг юм

Зэгэл араатан намнах
Хурдан буу үүрнэ гэдэг юм.
Энгэр цээжээрээ дүүрэн
Гавьяаны одон зүүнэ гэдэг юм
Аягүй бол “шилэн-портоор”
Айлчилж ирэх ч магадгүй гэдэг юм
Намайг тэгвэл машиндаа суулгаж
Нааш цаашаа давхина гэдэг юм.
Тэгснээ найз минь
Тээврийн тэрэг барина гэдэг юм
Сумын төвөөр заавал ирж
Сургуулийн хүүхдийг суулгана гэдэг
юм

“Миний өдрийн тэмдэглэл”

Өөрийгөө би
Та бүхэнтэй танилцуулъя.
Өдрийн тэмдэглэлдээ
Юу бичиж явдгаа ярья
Заагдсан хичээлдээ овоо
Заримдаа дунд, голцуу сайн авна
Захирлын тушаалаар
Шагнал урамшуулал ч хүртэнэ.
Сурлагатаа овоо юм гэж
Аав минь намайг
магтана.
Сурах юм эрдэм л гэж
Ижий минь надад сургана
Уг нь би дотроо
Уран зураач болох сон гэж бодно
Уул, ус хүн амьтныг
Урлаж сайхан зурах сан гэж бодно
Илүү дэвтэр олдвол
Ид хаваа заавал сорино
Харсан санасаа болгоно оо
Хараа, гараа чилтэл зурна.
Суудаг ширээгээ зурна
Сургуулийнхаа байшинг зурна
Ууган гэрээ зурна
Унаган морьдоо зурна.
Эрх цэнхэр ишгээ зурна
Ээж, аав хоёроо зурна
Хот айлыг уяа шонотой нь зурна
Хот малы нь бэлчээртэй зурна.
Нуур, ус зурна
Нугас шувууды нь ч зурна
Машин тэрэг ч зурна

Хажиг зангүй жолооч болох нь гэж
Харин би боддог байсан юм
Аав ээжийгээ суулгаж аваад
Алс явна гэхэд нь айдаг байсан юм.
Сайн найзаасаа холдох нь гэж
Санаа сүрхий зовдог байсан юм
Өөр би хэнтэй үерхэх билээ гэж
Өр зүрхэндээ шаналдаг байсан юм.
Харин найз маань хичээлдээ
Хайхрамж муухан явдаг л байсан юм
Дэн дун дээсэн дөрөөтэй
Дэвшиж л явсан юм ангиа!

Манарсан тоосын ч зурна.
Уул, хад зурна
Ургаа хады нь ч зурна
Магнаг тэнгэр зурна
Мандаж байгаа нар ч зурна
Хээ, угалз зурна
Хээрийн сайхан цэцэг ч зурна
Таван хошуу зурна
Танк, онгоц ч зурна.
Буу барьсан цэцэг зурна
Бууж өгч байгаа дайсныг ч зурна
Хөө хуягтай баатар зурна
Хөлд нь бөхийсөн мангасыг ч зурна
Дэлгэрхангай уулыг ч зурна
Дээр нь улаан туг мандуулж зурна
Харш орд, хот зурна
Хаалга болгон дээр нь урай лоозон зурна
Өөрийнхөө зурсан болгоныг
Өлзий найздаа аминчлан үзүүлнэ.
Гоё зурсан юм алга... гэж
Голж өөлөхөд нь гомдосхийнэ.
Машин тэргийг өнгөөр нь
Мал сүргийг зүсээр нь
Өнгийн цэцгийг ёсоор нь
Өндөр уулыг янзаар нь
Гойд сайхан зуръя гэж
Гол зүрхнээсээ мэрийнэ
Амь оруулам будаггүй болохоор
Арга цөхрөн бодолд дарагдана.
Өнгийн будагтай болох сон гэж
Өдрийн бодол шөнийн зүүд болно
Хэний ч сэтгэлийг татахаар

Хээнцэрхэн зураг зурах сан гэж бодно.

“Нууц яриа”

Аав маань, байн байн
Даалимбан даавуу ховордлоо гэнэ
Аюулт хар дайны
Гай гамшиг гэлцэнэ.
Ээжий маань, үе үехэн
Амтат чихэр алга боллоо гэнэ
Эрлэг хар дайны
Гай гамшиг гэлцэнэ
Айл саахалтынхан бас
Гурил будаа дууслаа гэнэ
Аймшигт хар дайны
Гай гамшиг гэлцэнэ
Багш захирал үргэлж
Дэвтэр харандаа үгүй боллоо гэнэ
Балагт хар дайны
Гай гамшиг гэлцэнэ.
Тийм ээ, тэр жил
Дайн болж байсан юм
Тэртээ өрнө зүгт
Дарийн утаа манарч байсан юм.
Тэр дайны сүүдэр
Биднийг дайран харлаж байсан юм.
Тэр дайны савар
Аз жаргалаас хумсалж байсан юм.
Өгөр тэр дайнаас болж
Өнгийн будаг ч олддоггүй болсон юм.
Өнгийн будаг олдохгүй болохоор
Өөрөө би олигтой зураг зураагүй юм
Хар дайныг зайлуулах сан гэж
Бяцхан зүрхэндээ боддог болов оо.
Харгис дайныг даралцах сан гэж
Багахан цээжиндээ боддог болов оо
Тэгээд ч зогссонгүй,
Өлзий хоёулаа
Аян дайнд явъя гэж ярилцав
Тэрслүү дайсныг дарах
Зэр зэвсэг зэхье гэж ярилцав
Баттай хэлэлцэж энэ тохирсноо
Хэнд ч хэлэхгүй гэж тангаргалав.
Баруун гараа атгалцан байж
Нууцаа хадгална гэж андгайлцав
Тонгорог хутга мохоон байж
Хавчаахай нум хийж авав
Торхны бүслүүр давтан байж

Илд сэлэм базааж авав.
Хувцас дээлээ ч яахав
Өмссөн зүүснээрээ дөнгөнө гэж
ярилцав
Хүнс хоол ч яахав
Өөрсдөө бэлдэж авна гэж ярилцав
Умрыг зорьсон замаар
Улаанбаатар хот орно гэж ярилцав
Улаанбаатараас цаашаа
Унаа машинд дайгдана гэж ярилцав.
Дайны талбарт очоод
Тагнуул туршуул хийнэ гэж ярилцав
Дайсны том даргыг нь
Тамдаж анаж барина гэж ярилцав.
Отож гэтэж байгаад
Орон байры нь мэдэн гэж ярилцав
Харуул манаагий нь мадалж байгаад
Халуун үүрэнд нь орно гэж ярилцав
Өшөөт тэр дайсныг
Өрөө юүнд нь хүлж барина гэж ярилцав
Халаас өврий нь нэгжиж
Хамаг түлхүүрий нь авна гэж ярилцав
Ширээний шүүгээгий нь уудлан
Нууц зургуудыг нь авна гэж ярилцав
Ширэн цүнхийг нь онгичиж
Бичиг баримты нь авна гэж ярилцав.
Өөрөө би
Гар буугы нь авна гэж ярилцав
Өлзий найздаа
Автомат буугы нь өгнө гэж ярилцав
Амьд хэл болгож
Тэр дайсныг тууж буцна гэж ярилцав
Ангийнхаа даргад
Тэвэр дүүрэн олзоо гардуулна гэж
ярилцав
Дайсны төлөвлөгөөг мэдсэн хойно
Давших тулаанд манайхан орно гэж
ярилцав
Улайрсан дайсныг бут цохиж
Улс олныг жаргуулна гэж ярилцав.
Магадгүй бид хоёртой
Маршал Будённый уулзана гэж ярилцав
Онц сайн байлдагчид гэж
Одон тэмдэг гардуулж ч мэднэ гэж

ярилцав
Тэгвэл, бид хоёрыг
Улаан Москвад хүргэнэ гэж ярилцав
Тэнд яриа байхгүй
Их Сталинтай уулзана гэж ярилцав
Дайнаас харин буцаж ирэхдээ
Дэвтэр харандаа зөндөө авчирна гэж
ярилцав.
Даахынхаа хэрээр бас
Чихэр жимс өвөртөлж ирнэ гэж ярилцав
Хамгийн түрүүнд, дэвтэр чихрээ

“Өлзий бид хоёр дайнд явлаа”

Балагт дайныг зайлуулж
Амгалан тайвныг авчрахаар
Багачууд найз нараа баясуулж
Аль дуртайгий нь авчрахаар
Хамаг зэвсгээ агсаж
Харгуй замд гарахдаа
Хэлэлцэж, тохирсон ёсоороо
Хээр талыг чиглэхдээ
Томчууд багачууд мэдчих вий гэж
Тун ч их болгоомжилсхийж
Багачуул хүүхдүүд харчих вий гэж
Бас хэрхэндээ нуугдасхийж
Сургууль танхимынхаа хажуугаар
Уван цуван өнгөрч
Сумын төвөөс хойшоо
Урам зоригтой алхав.
Намар оройн нар
Араас төөнөн халаана
Намуун талын салхи
Урдаас үлээн үнсэнэ
Ташаа, ташаандаа хоёул
Ирт сэлэм зүүчихсэн
Тавь тавин сумтай
Хавчаахай нум агсчихсан
Ар өвөр хоёртоо
Ааруул боорцог өвөртөлчихсөн
Атаат дайсныг дарна гэж
Алаг зүрх тэмүүлчихсэн
Зоригтой золбоотой
Хагас цаг алхлаа
Золтой, баяртай
Хадат ухааг давлаа.
Ингэж явна гэж бид хоёр
Хэчнээн ч их хэлэлцлээ дээ

Ангийнхандаа тараана гэлцэв
Хажууд нь илүү гарвал
Сургуулийнхаа хүүхдэд түгээнэ гэлцэв
Өнгийн будаг олдвол харин
Өөрөө би хэдийг авна гэв
Харсан санаснаа ёсоор нь
Ханатлаа нэг зуръя гэв
Итгэл найдвар дүүрэн
Ингэж бид хоёр ярьдаг байлаа.
Уг яриандаа халж орхиод
Үнэхээр ч сэтгэл хөдлөм явдаг байлаа.

Эргэж буцахгүй гэж бид хоёр
Хэчнээн ч их батлалцлаа даа
Хагас сайн өдөр
Түргэн болоосой гэж
Харгуй замдаа
Бушуухан гарахсан гэж
Хуруу даран
Хүлээж ядан байсныг яана
Хувь хувийнхаа бэлтгэлийг
Шахаж шаардаж байсныг яана
Сумын төв ард
Яаралзан алаглан холдлоо
Сургуулийн маань ч байшин
Цайран дүнхийн хоцорлоо
Алсын их замаа
Хоёр саахалтаар хороож
Аяны жаахан хүнснээсээ
Хориод боорцог хүртэж
Анхны амралтаа хийж
Налайж саатаж байтал
Аз жаргалаа эдлэж
Баясаж тарваадаж байтал
Газраас ургах шиг
Унаатай хүний бараа тодров.
Гарцаагүй бидэнтэй уулзахаар
Урдаас тосон давхиулав.
Ил цагаан талд
Нуугдах газар ч олдсонгүй
Ирж яваа хүнээс
Зайлах аргаа ч мэдсэнгүй.
Чиглээд ирсэн тэр хүн
Манай ангийн Дэжээ байлаа
Чөдрийн морь барилаа гээд
Бидний өмнө хөндөлдлөө

Илд хавчаахай агсаад
Хаачиж яваа юм бэ? гэв.
Идэж уух юм базаагаад ...
Юу хийж яваа юм? гэв
Эрхэм нууцаа хадгалж
Бид хоёр дуугарсангүй
Илүү юманд дуртай юм гэж
Эрсэлж арай хэлсэнгүй.
Уг нь манай Дэжээ
Хичээл номдоо онц
Уран шүлэг уншихдаа
Сургууль хавьдаа гоц.
Аавдаа бол өдөр болгон
Унаа морий нь ойртуулж
Айлынхаа эмээд бол
Ундны нь усыг дөхүүлж
Ажил үйлэнд залхуугүй
Айхавтар сэргэлэн охин
Ихэмсэг дээрэнгүй зангүй
Инээмсэглэл дүүрэн хүүхэд.
Ооно гөрөөс авлах нь уу гэж
Тэр биднийг сонжив.
Олз аваасаа амсуулаарай гэж
Дэжээ биднийг даажигнав.
Оргож босож явна уу гэж
Сэрдэж бас өгүүлэв
Одоохон багшид хэлнэ гэж
Сэтгэл бас түгшүүлэв.
Дайнд яваа хүмүүсийг
Ингэж хэлж ч болох уу даа
Дайчин цэргийн эрчүүдийг
Ингэж басах ч гэж байх уу даа?
Хэрэг зоригоо хэлмээр
Хэл нэгэнтээ загтнав.
Оргилсон хүслээ яримаар
Омог гэнэт хөдлөв.
Самуун дайсныг дарах гэж явна аа гэж
Санаа бодлоо уудлан хэлэв
Сайн сууж байгаарай! гэж
Сац бас ерөөл дэвшүүлэв.
Дэвхрэг унагаах шандасгүй
Хавчаахай нум барьчаад
Дэрс даах тэнхээгүй
Оготор сэлэм зүүчхээд
Олон дайсан устгах байх даа гэж
Дэжээ биднийг басав.

Орой болохоос өмнө
Харьвал дээр... гэж сургав.
Эр хүн зорьсондоо
Эмээлт морь хариасандаа
Бууж түүнд ч өгсөнгүй
Буцах хүсэл ч төрсөнгүй. “Цэрэг дуулж
бай” гэж
Өлзийдээ би анхааруулав
Чигээрээ алхаад марш гэж
Өлзий тавин алхлав.
Шогтой гэгч нь инээчхээд
Дэжээ морио давирав
Шороо чулуу үсчүүлэн
Дэнж даван холдов.
Эргэж харсан ч үгүй
Энэ тэрийг ярьсан ч үгүй
Хандсан зүгтээ алхалж гарав
Харгуй замаа хороож эхлэв.
Нэг гүвээ давав
Нэр төр гэж бий хэмээн бодов
Хоёр гүвээ давав
Хор шар бий хэмээн бодов.
Дөрвөн гүвээ давав
Дөхөж байгаа, фронт... гэж бодов.
Сэтгэл гэдэг өрнүүн
Сэв сэв алхалж явлаа.
Итгэл гэдэг өндөр
Ирмүүн цогтой урагшилж явлаа.
Тэгтэл,
Ар талд морин туурай тачигнав
Тэгнэ чинээ санасангүй
Ангийн маань багш айсуу харагдав.
Дэжээ л очиж хэлснээс гарсангүй,
Одоо яах вэ гэж бодов
Дэмий л түүнд байдгаа тоочлоо гэж
Охорхон зуур гэмшив.
“За ингээд баригдав аа” гэж
Зүрх гэнэтхэн палхийв.
Загнах л байх даа ... гэж
Зүйлийн юм бодов.
Аагтай хөлсөө ханхлуулан
Багшийн морь урд хөндөлдөв
Алагхан нүдээрээ инээмсэглэн
Багш маань ч биднийг харав.
“Ингэж ч явах гэж дээ” гэснээ
Инээд алдан мориноосоо буув.

“Томоогүй ч юм бол доо” гэснээ
 Толгой сэгсрэн мишээв.
 Дайтах гэсэн бодлы маань
 Даажигнаж ер зэмлэсэнгүй
 “Даан ч балчир байна даа л ... гэж
 Даацтай гэгч нь өгүүлэв.
 Сайн нөхдөдөө туслах гэсэн
 Санаа бодлы маань зэмлэсэнгүй.
 Баахан бодолхийлж зогссоноо
 “Балчир байна даа... гэж дуугарав.
 Дайтаж байлдах гэсэн
 Давилуун явдлы маань ч зэмлэсэнгүй
 Өхөөрдсөн янзтай харснаа “Өдий л
 байна даа гэж шивнэв.
 Урд маань багш явган сууснаа
 Онц дотноор биднийг тэврэв.
 Уярсан янзтай хэсэг байснаа “Одоо
 ингээд харьцгаая!... гэв.
 Эхлээд Өлзийг өргөж
 Эмээл дээрээ тавив.
 Ахиад намайг өргөж

Адууны бэлчээрээс холдоогүй
 Багачууд бидэнд мишээж
 Айл саахалтаасаа хэтрээгүй
 Балчир биднийг халамжилж
 Гэрэл дүүрэн танхимын
 Босго анх алхуулсан
 Гэгээн саруул эрдмийн
 Амтанд анх оруулсан
 Багш нараараа бид
 Бахархан дурсаж явдаг аа
 Өлзий дүүрэн ачий нь
 Өнөө болтол санасаар байдаг аа.
 Тэр намар, манай сургуульд
 Шинэ багш хотоос ирсэн юм
 Тэгш цагаан шүдтэй
 Шижгэнэсэн сайхан залуу ирсэн юм.
 Босго өртөөчний улаачтай
 Хүрэлцэж ирэхийг нь би харсан юм.
 Богц дүүрэн номтой
 Бууж байхы нь би үзсэн юм.
 Ааш зан нь ямар бол гэж
 Хэд хэдээрээ нийлэн шивнэлдэж
 байтал
 Аль анги дааж авах бол гэж

Араар нь сундлуулав.
 Ингээд багш маань
 Ирсэн замаараа хөтлөн алхав
 Аюулт дайсныг дарах гэсэн
 Аян зам үүгээр төгсөв.
 Буцаад ирэхэд юу болсон гэж
 Бужигнасан хүүхэд тосоод ирлээ
 “Замдаа сайн явав уу гэж
 Зарим нь бүр доогтой асуув.
 “Олон дайсан дарав уу гэж
 Ам ч асууж дуулдав
 “Одон тэмдгээ яагаав” гэж
 Алиа нэг нь дуугарав.
 “Чимээгүй хүүхдүүд ээ” гэж
 Багш маань тэдэнд хэлэв.
 “ Чин санаа нь зөв!
 Дооглох хэрэггүй гэж өмөөрөв.
 Хартал, эд нар одоохондоо
 Бага байна гэж тайлбарлав
 Харж л байгаарай, хожим
 Баатар болно гэж нэмэв.

Багш

Амь амьхандаа хэлцэж байтал
 Манай ангид багшлах гэнэ гэж
 Магад эсэхий нь лавлах гэж
 Тогооч, галч руу бид гүйлдсэн юм.
 Залуу сайхан багштай боллоо гэж
 Захирал баяртай байна гэнэм
 Мэдлэг чадалтай хүн ирлээ гэж
 Мишээж баясаж сууна гэнэм.
 Хөвсгөл нуурын тэртээ
 Төрж өссөн хүн гэнэ гэлцэв.
 Хөлөө дөрөөнд хүрүүтээ
 Эрдэм соёл хөөсөн хүү гэнэ гэлцэв.
 Алс газрын хүн ирж дээ гэж
 Хөгшид настан хөөрхийлөв.
 Алаг говьд идээших болов уу гэж
 Аав эжий нар хүүрнэлдэв.
 Ургах наран мандав уу, үгүй юу
 Даавуун цүнхээ шүүрэн авч
 Унд цайгаа уув уу, үгүй юу
 Сургууль руугаа зорин ирж
 Дэврүүн сэтгэлээр дүүрэн
 Ширээ ширээндээ сууж
 Дэвтэр номоо үзэлцэн
 Шуугьж шагширч байтал

Эхний хичээлийн хонх
Эгзэгтэй чанга цангинах шиг дуугарав.
Анги танхимын хаалга ч
Асар жавхлантай нээгдэх шиг болов.
Нүүр дүүрэн мишээсээр
Шинэ багш орж ирэв.
Нүд дүүрэн баяртай
Бид нар ч босож хүндлэв.
Алдар нэрээ багш маань
Ишгэн гэж танилцуулсан юм
Анхны маань шавь
Та нар боллоо гэж хэлсэн юм.
Нээрэн манай багш
Эрдэм чадалтай хүн байлаа
Нэг л мэдэхэд бидний
Хайр татсан хүн боллоо.
Өнгөрсөн зуунуудад өөрөө
Амьдарч явсан юм уу гэлтэй
Өнө холын нээлтүүдэд
Оролцож байсан ч юм уу гэлтэй
Хүрэх сайхан ирээдүйд
Очоод ирсэн ч юм уу гэлтэй
Хүсэл бодлын далайд
Хүрээд үзсэн ч юм уу гэлтэй
Балчир бидний оюуныг
Өдөр өдрөөр нээж
Багачууд бидний сэтгэлийг
Цаг цагаар бадруулж
Нээрэн манай багш
Итгэл булаасан хүн юм
Аливаа юмыг багш шигээ
Сурч мэдэхэд бидний
Хайр татсан юм.
Аливаа юмыг багш шигээ
Сурч мэдэх сэн гэж
Арга эвий нь олоод, багш шигээ
Гоёхон бичдэг болох сон гэж
Хэний ч шаардаагүй байтал
Хичээж бид мэрийсэн юм.
Хэнхдэг цээжийнхээ гүнд
Хичээл зүтгэл өрнөөсөн юм.
Дэрсэн толгой ганхтал
Хулсан лимбэ үлээхэд нь
Дэврүүн сэтгэл уяртал
Хуур хөглөн татахад нь
Хөгшид настныг шагштал нь

Хөөрхөн хоолойгоор дуулахад нь
Хүүхэд биднээ жагсаан
Бүрээ үлээн алхлахад нь
Авьяас эрдэм хосолсон
Аргагүй сайн багш гэж
Энэ багш шигээ хүүхэд минь
Эрдэм номд шамд гэж
Буурлууд таашаан бахдаж
Бууж мордохдоо сургадаг болов оо
Багшаараа бид, хөрш ангийханд
Бардах хүсэл бадардаг болов оо.
Улаанбуланд концерт гарвал
Манай багш голлон оролцоно
Урт өндрийн харайтал гүйвэл
Манай багш түрүү авна.
Баг сумын дарга нар ч
Манай багшийг урьж яриа хийлгэнэ.
Багачууд байтугай, томчууд
Манай багшаар шүлэг, дуу заалгана.
Багшаа бид дуурайж, бас заалгаж
Багагүй юм сурч эхэллээ
Магад, хамгийн эхлээд л бид
Магадгүй гоё бичдэг боллоо.
Сампил, Хорлоо багшийг дуурайж
Савлуурт сэнс шиг эргэдэг боллоо
Дондог, Тунсаг багшаар залгаж
Дориун гэгч нь дуулдаг боллоо.
Тогооч, Дулмаа хоёр гэнэт цоорч
Тоондоо гаргууд болов
Уртаа, Цэрэн хоёр золбоо орж
Уншихдаа бузгай болов.
Дэжээ бас, багшаар заалган байж
Дэгжин гэгч нь хөгжимддөг болов
Өлзий найз маань хүртэл, багш шиг
Өндөрт элгээрээ хөмрөн харайдаг
болов.
Өдөр өдрөөрөө манай ангийнхан
Ингээд л мандаж эхэлсэн юм.
Өөр өөрсдий минь авьяас чадлыг
Ишгэн багш нээж эхэлсэн юм.
Өөрөө би харин
Нэг бодол өвөрлөж явдаг болов
Өр зүрхнийхээ гүнд
Нэн ихээр тунгаадаг болов.
Ишгэн багш шигээ
Арван долоохон настайдаа

Ижий ааваасаа хол
Ажиллаж үзэх сэн гэж боддог болов.
Тэгээд л би нэг хэсэг
Хавийн жаалыг цуглуулж
Тэр ч байтугай
Хавтас ном дэлгэн суулгаж
Томоогүй зарим шавиа
Мундахгүй зэмлэж
Тогтоож цээжлэхгүй нэгэнд нь
Муу дүн тавьж
Бичсэн зурсны нь шалган
Улаан харандаагаар цохож
Биеийн тамирын хичээл... хэмээн
Тэднийгээ бас жагсааж
Багш болж
Тоглодог болов оо
Багшаа дуурайн
Алхалдаг болов оо .
Үнэхээр тэгж байхдаа
Багш болсон юм шиг санагддаг сан
Үзсэн харсан хүмүүс ч намайг
Багш болж магадгүй гэдэг сэн.
Анхны цаснаар
Үүрийн хяраанаар
Бударсан цас
Үзтэл ер нь
Тогтох янзгүй.
Үүлэн чанад
Нуугдсан наран
Хартал мөддөө
Гарах шинжгүй.
Тэр өдөр Хагас сайнд
Тэнгэр бүрхэг
Цас лавсав.
Өвлийн түрүү
Гадаа буулаа гэж
Өвгөд настан
Галаа базаав.
Өнгөрсөн хавраар
Бараагий нь хараагүй
Өнгөлөг цаснаар
Болжмор чуулж,
Бид нар ч гэсэн
Цаснаар шидэлцэн
Бишгүйдээ нэг
Цэнгэн наадав.

Анхны цас
Нээрэн содон,
Алс өвлийн
Үнэр сэнгэнэнэ.
Атгаад авахад
Нэн зөөлхөн ч
Адтай хүйтний
Жавар сэнгэнэнэ.
Хөхөө өвлийн
Мөрөөсөл болсон юм шиг
Хүүхдийн шуугиан
Оройжин болов.
Хөлд өмссөнөө
Хөлдөөж норгон
Гэртээ орцгоов.
Хувцас хунараа
Хайрласангүй гэж
Хөгшид эмээ
Гэр гэртээ хангинав.
Хунгар цаснаас
Уйдамгүй гэж
Хүүхэд бүхний
Зүрх цохиллов.
Бүтэн сайны
Өглөө нь харин
Бүрхсэн тэнгэр
Мэлтийн цэлмэжээ.
Орсон цас
Сааран саарсаар
Ойндоо хүрч
Налайн тогтжээ.
Тал хөндий
Зах хязгааргүй
Индүүдсэн даавуу шиг
Цайран тэнийж,
Тахилт өндөр
Өргөн талтай
Ижилдсэн юм шиг
Гүймээр ч юм шиг,
Үүрийн гэгээнээр
Олз хайсан
Үнэг туулай
Нүд гялбуулах
Цасан далай
Сэтгэл татаад гоёхон харагдана.
Нүүр шүргэх

Салхины үзүүр
Сэрүү татаад
Сайхан санагдана.
Гэвч
Гараад явчхаж чадахгүй
Гэр зуураа холхин байтал
Булан нь сэмэрсэн дэвтэр номоо
Буцаан үзэн
Саатан байтал
Өлзий найз
Дуу алдсаар
Өнөө л зангаараа
Ороод ирэв.
Адтай сонин үзсэн бололтой
Амьсгаа дээхэн
Харайж ирэв.
“Хойд энгэрт Ишгэн багш
Хоёр таягтай Гулгаж байна” гэв.
Урт мөр
Ардаа үлдээн
Уруу газар
Хурдалж явна гэв.
Малгай юугаа
Шүүрэн авуугаа
Үүд тийшээ
Үсэрч очив.
Мань хүний
Хэлж ирснийг
Магадалж үзэхээр
Гадаа гарав.
Сумын хойт ухаа овоо өөд
Шув шулуухан гүйж хүрэв
Баахан хүүхдийн дунд зогсоо
Багшийнхаа барааг олж харав.
Өлзийн хэлснээр, багш маань нээрэн
Урт хоёр таяг тулжээ
Өлмий нь махир хос мод
Ул юундаа бэхлэн жийжээ.
Таягаа тулуут, багш маань тэгтэл
Танан цас манарган хурдлав.
Харахын зуур, мөрөө үлдээн
Хамар даван, холдон одов.
Багшаа даган багачууд бид
Баясан шуугьж зөндөө гүйв.
Энгүүн хэрнээ этгээд энэ унааг
Эзэмшиж үзэх сэн гэж бид бодов.

Хүсэл болгоныг гулгуулж үзэв
Уруу өөдөө яаж явдгийг
Учирлаж сайхан зааж өгөв.
Анх ингэж цана гэдгийг
Бие зүсээр нь үзэж
Ая таарч олдож гэмээ нь
Эдэлж үзмээр унаа юм гэж
Ижил нөхөд бүгдээрээ
Дор дороо бодох бололтой
Ид хаваа гайхуулж
Наадах сан гэж тунгаах бололтой.
Ангийнхаа найз нарт шоолуулж
Базаахгүй харьсан ч гэлээ
Арга эвий нь олохдоо
Гавихгүй буцсан ч гэлээ
Олон нөхдөөс түрүүлээд
Цанатай болчх санаатай
Одоохон л Өлзий хоёул
Цас манарган хурдлах бодолтой
Айл айлын гадуур эргэлдэж
Тэнцэж тохирмоор мод хайлаа
Алба, амины байшин тойрч
Айхавтар их эрэлд гарлаа.
Эрсэн хүн олдог гэгчээр
Эгээ ч гар хоосон буцсангүй
Эзний нь мэдэхгүй хагссан торх
Эвдэж авахаас хулчийсангүй.
Ач тусы нь хариулна гэж
Равжаа дарханд очиж
Аргал түлший нь дөхүүлнэ гэж
Ам амандаа буян амалж
Өө сэвий нь даруулан
Хоёр догь цанатай болов
Өлмий хөлдөө зүүгээд харахад
Хурдлаад явах унаатай болов
Бодсон санасандаа хүрч
Баярласан ч гэдэг жигтэйхэн
Болсон эсэхий нь үзэж
Гулгасан ч гэдэг хэмжээгүй.
Хавийн хүүхэд бид хоёрын
Арга самбаатайг шагшиж гарав
Харж бахдаад ч зогссонгүй
Өөрсдөө бас гулгаж наадав.
Харин, манай Өлзийн эмээ
Намайг баахан зэмлэж үглэв
“Хачин этгээд юм хийж,

Хүүхэд уруу татлаа. . гэв.
Эрүүл чийрэг явахад
Тустай гэж багш хэлсэн юм чинь!
Эр чадал бүрдэхэд
Ачтай... гэж бас ярьсан юм чинь!

Эмээгийн тэр зэмлэлд
Гомдож их ч гонсойсон ч үгүй
Эрэг ганга руу унахдаа ч
Өвдөж шалбарснаа хайхарсан ч үгүй.

Ялимгүй гомдол

Хөл болж
Зэхсэн цанаасаа
Хөгжүүн сэтгэл
Уйдаагүй байтал
Шимтэн байж
Гулгаж сурсныхаа
Шидий нь үзэж
Амжаагүй байтал
Цасны нөгөөдөр
Тэнгэр дулаарч
Цагаан тал
Бараан боллоо.
Эхний цас
Биднийг тэгж баясгаад
Энд тэндээсээ сэмрэн
Хайлж уусан шингэв.
Өвлийн цас
Буухдаа л бууна гэж
Өр зүрхэндээ
Итгэл алдсангүй.
Гэр гэртээ зэхсэн
Торхны модон цанаа
Хээр хөдөө гаргаад ч хаясангүй.
Уул уулсын шилд
Алгын чинээхэн цас
Уранхай тохом шиг
Алагланхан үлдэхэд
Даамай алсад
Уулсын чинээ үүлс
Даажигнасан юм шиг
Цаашланхан нуугдахад
Би л болсон хойно
Харандаа цаас нийлүүлж
Битүү цагаан цасыг
Хар балаар урлаж
Ижил олон цанатан
Гулсаж шуугьж байгаа зураг зурлаа
Ишгэн багшаа бас
Хурдалж түрүүлж яваа зураг зурлаа.
Цанатай болохын хүслээ

Энэ зургандаа зурсан юм.
Цаашаа аялах бодлоо
Эндээ бас шингээсэн юм.
Харин тэгтэл, манай ангийнхан
Хачин ихээр дургүйцэв
Харсан дороо, зургий маань
Хамаа намаагүй шүүмжлэв.
Өмсдөг дээлий нь янзаар нь
Өндөр нам нуруугаар нь
Өвдөг тохойнх нь цоорхойг хэвээр нь
Өө сэвгүй зурлаа гэсэн чинь
Хамар чихий минь том зуржээ гэж
Нэг хэсэг нь зэмлэдэг байгаа
Хацар амы нь муруй зуржээ гэж
Нөгөө хэд нь гомддог байгаа
Хөөрхөн зурсангүй, намайг гэж
Зарим охид уруул унжуулдаг байгаа
Хөмсгий маань мартчихаж гэж
Бага Цэдэв уйлдаг байгаа.
Хүүхэд болгон өөрсдийгөө
Хөөрхөн гэж боддог юмсанж
Хүүхэд болгон өөрийгөө
Хөгжилтэй гэж санадаг юмсанж.
Хариуд нь харин, Сампил
Ханын сонинд гаргав
“Найз нөхдөө доромжилдог” гэж
Намайг шоглож зурав.
Цамба зааны хагссан торх
Цасан дээгүүр өнхрүүлж байгааг
Цагариг бүснээс нь салсан модоор
Цана хийгээд харайлгаж явааг
Элэглэж шоолж зурсан бол
Эндээ гэхэд гомдохгүй сан
Хошигнож шүүмжилж бичсэн бол
Хойшдоо ч гэсэн бодох сон
Өөрөөсөө бусад хүүхдийг
Үүнээс хойш зурахаа больё гэж бодов
Өлзий найз маань дэмжиж
Үнэхээр зүйтэй гэж зөвлөв.

Бидний бэлэг

Анхны цаснаар шуугьсан
Баясал хөөр намжиж байтал
Айлын торх эвдсэн
Зэмлэл яриа мартагнаж байтал
Улаан армид бэлэг хүргэгсдийг
Үдэж гаргах цуглаан болов
Урай лоозон барьсаар
Сурагч бид жагсаж очив.
Элэг зүрхээрээ
Улаан галын өөдөөс сөрж яваа
Энх амьдралын төлөө
Тулаан дунд ялж яваа
Эзэрхэг дайсны омгийг
Унтраан унтраан тэмцэж байгаа
Эгэл бидний жаргалын төлөө
Эцсийн цусаа асгаруулж байгаа
Алдарт улаан армийнханд
Захидал хүртэл бичиж
Аав ээжийнхээ бэлэг дээр
Амь аминыхыгаа бид өгсөн юм.
“Ялгуусан арми
Ялан мандтугай”
“Яргачин фашистууд
Яйран сөнөтүгэй!”
Ийм үгтэй яриа
Бид дээрээ өргөж байлаа
Итгэлийн үгтэй түүнийхээ
Иший нь бат атгаж байлаа.
Индрийн талбайд цугларсан
Хүмүүс нэг л хөгжилтэй
Ижил ижил ачаатай
Тэмээд нэг л жавхаатай.
Аяны даамлын гарт
Улаан туг намирна
Ачаа бүхний бөөрөн дээр
Форонтод гэсэн бичиг дурайна.
Энэ л олон ачааны
Аль нэг буланд нь
Эгэл миний өгсөн
Дулаан бээлий яваа даа
Энэ л олон тэмээний
Аль нэгийн нуруун дээр
Эгэл миний бэлэглэсэн
Аравтын төгрөг байгаа даа
Баясал хөөр болон

Багачууд бид ингэж ярилцав
Хаяг нэргүй илгээсэн захидлынхаа
Хариу ирэх болов уу гэж хүүрнэлдэв.
Тэгтэл, индэр дээр
Сумын дарга нар гарлаа
Тэдэнд хүндэтгэл илэрхийлж
Сурагч бид гар өргөн ёсоллоо.
Манай нутгийн Цээ эгч
Тэдний дунд зогсож харагдана
Малчны тэмдэг, одон медаль
Энгэр дээр нь гялалзаж харагдана.
Дэргэд нь бас, манай галч Доо
Дээгүүр харан мишээж харагдана.
Отряд малгай хулгавчилчихсан
Онц албархуу зогсож харагдана.
Байр танхимын маань
Дулаан халуун байлгах гэж
Багачууд биднийг хичээлдээ
Тухтай аятай суулгах гэж
Үүрийн шар гэгээнээр
Тоос шороо цэвэрлэж байдаг
Гавшгай шалмаг алхаатай
Энэ хүнийг бид нар
“Галч багш” алдраар
Нэрий нь хүртэл цээрлэсэн юм.
Сандал ширээгий нь маань
Цэмбийтэл засаж янзална
Саруул танхимыг маань
Цэмцийтэл арчиж цэвэрлэнэ.
Тэгээд ч зогсохгүй, биднийг
Цэвэр явахыг сануулна
Тэрлэг дээлээ хүртэл
Цэмцгэр өмсөхийг шаардана.
Байшин саравчны араар
Барилдаж байгаад баригдвал
Хэн нэгэндээ гоморхоод
Хэрэлдэж байгаад тааралдвал
Захирал багш шигээ л бид
Хүндэлж ёсолж байдаг юм.
Загнах ч үгүй өнгөрөхөд нь
Эмээж айж явдаг юм.
Монхор цагаан магнайтай
Хар атаа тохошлож
Модон төрх баглаатай
Тэргээ тэр хөллөж

Гурван саахалт зайтай
 Худаг тийшээ явна
 Гулс гулс алхуулсаар дуу аялсаар ирнэ
 Галч Доогийн явсан мөр
 Газар дэлхий дээр тодхон
 Сунайж зурайсан зам нь
 Сургууль худгийн хооронд содхон.
 Манай галч фронтод
 Бидний бэлгийг хүргэлцэх ажээ.
 Магад сараас наашгүй
 Холын аянд явах ажээ.
 Ялгуулсан арми урагшаа
 Давшиж явах тухай
 Яргачин дайсан урд нь
 Яйрч байгаа тухай
 Сумын дарга, өндөр дуугаар
 Индэр дээрээс илтгэв.
 Сүүлд нь бас, бэлэг хүргэгчдэд
 Аян замын өлзий ерөөв.
 Халуун найрамдлын тэмдэг
 Хайр сэтгэлийн бэлэг
 Жингийн олон цуваа
 Жирийтэл хойшоо алхлав.
 Өлзийн эмээ үглээ ч гэлээ
 Өрөвч зөөлөн сэтгэлтэй
 Өргөн түмний үйлсийг
 Ерөөж байдаг зантай.
 Аяны цуваа хөдлөхөд
 Хүн хүнээс түрүүлж, тэр
 Алтан замы нь мялаан
 Цагаан сүү өргөв.
 Галч Доо, багш нартай
 Салах ёс гүйцэтгэж
 Ганган улаан тэмээн дээр
 Дах тохон мордоход

Олон нийтэд очих сайхан

Тоо, хэлний зүй, түмэн бодис
 Түүх газар зүй, мал аж ахуй
 Бичгийн ажил, унших, үг хөгжил
 Биеийн тамир зураг...
 Үзэх хичээл олон ч гэлээ
 Үдэш, олон нийтэд очих сайхан
 Үлгэр шүлэг, дуу хөгжим сонсох
 Үнэхээр нэг зугаатай сайхан.
 Шинэ цээжилсэн шүлгээ, тэнд
 Дэжээ цангинтал уншина

Улсын чухал албанд
 Ингээд нэг явахсан гэж сэтгэл хөдлөв
 Улаан туг, улаан лоозонтой
 Үдүүлж байх сан гэж бодов.
 Саадгүй сайн явахыг
 Галчдаа бид ерөөлөө
 Сааргүй сайн суухыг
 Галч маань бидэндээ ерөөлөө.
 Урт урт алхаатай
 Бэлгийн олон цуваа
 Умрыг чиглэн жирийсээр
 Далд ортол нь харуулдаж
 Уярал баясал хослуулан
 Бид баахан дагасан юм
 Улаанбаатар орох сон гэж
 Битүүдээ бас санааширсан юм.
 Өөрсдөө бид дайнд яваагүй ч
 Өглөг бэлгээ явууллаа
 Тулаан дунд биеэр ороогүй ч
 Тусламж юугаа илгээлээ.
 Жижигхэн байна даа бид
 Даанч балчирхан байна!
 Жингийн тэн даадаг сан бол
 Доо гуайн оронд явах сан!
 Өлзий бид хоёр
 Ингэж бас ярьсан юм
 Өнөө л дэврүүн сэтгэлээрээ
 Итгэл дүүрэн хөөрөлдсөн юм.
 Тэр оройгоо би
 Тэмдэглэл зургаа зурлаа
 Тэмээн жин хөтөлж яваа
 Тэнхээтэй эр болгож өөрийгөө зурлаа.
 Урт урт жингийн цуваа
 Уул даван цуварч яваа зурлаа
 “Ах дүүгийн бэлэг” гэж бичлээ.

Шилж тогтоосон үлгэрээ, тэнд
 Дондог дуржганатал ярина.
 Манай багш ч гэсэн
 Мандолин хөгжмөө хангинуулна
 Хоёр талцан сууж
 Хожтолоо харилцан дуулна.
 Өлзий найздаа би
 Өр зүрхний үгээ хэллээ
 Бусдын чадлыг гайхан
 Буланд суухаа больё гэлээ.

Ураа гаргаж зурсны маань
 Үзсэн улс тоохгүй болохоор
 Ухаан зарж урласны маань
 Үеийн нөхөд анзаарахгүй болохоор
 Уянга дууны тавцан дээр
 Дуугаа өргөө гэж бодлоо
 Улс оронд шагшигдсан
 Дуучин больё гэж бодлоо
 Дэврүүн хүсэлдээ хөтлөгдөн
 Дууны бүлгэмд ч орлоо
 Дэрсийн нөхөдтэйгээ цуг
 Баярын концертонд дуулья гэж
 бодлоо.
 Гоцлон дуулна гэж багшаасаа
 Хэчнээн гуйсан гэх вэ?
 Гоёхон дуулна гэж
 Хэчнээн бэлхэн амласан гэх вэ!
 Олны өмнө, нэг удаа
 Омог төгөлдөр гарсан юм
 Хөгшид багачуудын урд
 Хөгөө нэг тарьсан юм.
 Ганц сайхан дуулья гэж
 Дотроо би бодлоо
 Гардаг л юм бол гаргая гэж
 Хоолой юугаа заслаа.
 “Цэнхэр хөх яргүй” гээд
 Цээж дүүрэн амьсгаа авлаа
 “Цэлмэг тэнгэрийг дуурайгаад... “ гэтэл
 Цээлхэн дуу маань тасарчихлаа.
 Дэндүү чанга дуулах гэсэн нь
 Дэмий юм болдог байна
 Хоолой гэдэг бөглөрсөн юм шиг
 Хорсож тагжраад таг болдог юм байна.
 Инээд шуугиан хосолж
 Үзэгчдийн танхим дүнгэнэх нь тэр
 Ичиж сандралдаа би ч

Гал улаан танк

Өвлийн толгой шовойн
 Цасан хяруу унаад л
 Өглөөний жавар ширүүсэн
 Цаанаа л эрч нь чангараал л
 Өдрийн нар доошлон
 Цагаан гэгээ богиносоод л
 Өдөр хоног улиран
 Цаг цаашаа цахилаад л
 Айлууд өвөлжөө бууцандаа бууж

Хөшигний араар зугатах нь тэр.
 Түймэрт ойртсон юм шиг
 Нүүр хэчнээн халсан гэх вэ
 Түргэн жагсаалд яарсан юм шиг
 Зүрх хэчнээн түгшсэн гэх вэ!
 Түүнээс хойш би
 Дуулья гэхээ больсон юм.
 Түмэн олонд гайхагдсан
 Дуучин болохгүйгээ мэдсэн юм
 Чанга дуулдаг болгон
 Чадалтай дуучин болдоггүйг мэдсэн
 юм.
 Олон алдартай дуучинд
 Онцгой авьяас байдгийг ухаарсан юм.
 Харин, хааяа ганцаараа
 Хөдөө гадаа явахдаа
 Харуй бүрийн цагаар
 Тэмээ хурааж ирэхдээ
 Айх ичихийг мартан
 Зөндөө л нэг дуулдаг байлаа
 Анир чимээгүй талд
 Зүрхээ баясаан явдаг байлаа.
 Хоолой мэдэн тэгж дуулахад минь
 Холын одод анивалзан тодордог сон
 Цэлмэг тэнгэрийг дүүртэл
 Цэгцрэн түгж гялалздаг сан.
 Миний дууг сонирхож
 Мичид од олшров уу гэлтэй байдаг сан
 Дуулим тал ч гэсэн
 Дуугий минь чагнав уу гэлтэй
 налайдаг сан.
 Гэвч, өнөө зургаа
 Гээж орхиж чадаагүй юм.
 Өөртөө л сайхан санагдсанаа
 Өврийн дэвтэртээ зурсаар байлаа.

Адуу мал оторт гараад
 Аян жин, бэлгийн цуваа
 Алс замдаа гарч одоод.
 Сумын төвөөр хөл татраад
 Чимээ аниргүй эзэгнэн байтал
 Сургууль хавийн дуу шуугиан
 Чихэнд дасаад ээнэгшин байтал
 Хөдөө нутагт ховор машин дуу
 Хөтлийн чанадаас хүнгэнэн цочоов

Хүүхэд бид тэр дуунаар
Хөврөх замы нь тосон гүйлдэв.
Тодроод ирэх бараа нь ч тэр
Тос бензиний нь үнэр ч тэр
Машин гэдэг үнэхээр
Магад гайхамшиг байлаа.
Бараагий нь хараад бид
Баярлах гэдэг жигтэйхэн
Ойртож сууж үзсэн бол
Онгирах гэдэг ч жигтэйхэн
Ойртож сууж үзсэн бол
Онгирах гэдэг ч жигтэйхэн.
Дүүрэн ачаатай машин, тэгтэл
Дүүрэн ачаатай гараад ирлээ
Тосож гүйсэн биднийг тэр
Тоолгүй өнгөрч, сургууль чиглэлээ.
Бие биентэйгээ уралдан
Бид тийшээ харайлаа
Өлзий бид хоёр ялгаагүй
Өмнө хойноо орон жирийлээ.
Тэгсэн нь, манай галч
Тэр машинаар ирсэн юмсанж
Атан тэмээгээр явсан хүн
Ачааны машинаар ирсэн юмсанж.
Улаан армийн сонин дуулах гэж
Улс амьтан тэдний рүү цував
Хот орсон хүний барааг харах гэж
Хойгуур урдуур нь бид шавав.
Өнөө л өмссөн зүүснээрээ
Өөрчлөгдсөн юмгүй харагдана
Малгай дээр нь л таван хошуу
Магадгүй харин нэмэгдсэн харагдана.
Бид яахав машин тойрч
Бензин тосы нь үнэртэж саатав
Өнхрөөд гарсан мөрий нь хүртэл
Өр зүрхэндээ бахархан шохоорхов.
Хойт өддөр нь манай галч
Холын бэлэг, зурагт сэтгүүл тараалаа
Хүүхэд болгонд, тал харандаа
Хүндэт шагнал шиг гардуулж өглөө.
Сураг сонсвол, манай галч
Сургуульдаа баахан дэвтэр авчирсан
гэнэ.
Сумын хоршоонд гурил будаа
Шуудай шуудайгаар нь буулгасан гэнэ.
Олноо гэдэг хүн

Ондоо юм гэж томцуул бахдав
Тарчиг цагт харандаа өгсөн ачий нь
Талаас нь өргөн гэж бид шагшив.
Хол яваад ирсэн Доо гуай
Хорвоог тойроод ирсэн юм шиг
санагдана
Хоолой дуугий нь ч гэсэн
Холоос сонсох аятайхан бодогдоно.
Бэлгий маань фронтод хүргэсэн
болохоор
Би ч тэгж боддог болсон юм уу
Дайн дуусгаал ирсэн юм шиг, Доо гуай
Даанч сайхан харагддаг боллоо.
Машинд суугаад ирэхий нь
Харсан болохоор ч тэгсэн юм уу
Манай галч шиг хүндтэй хүн
Магад энд үгүй шиг бодогддог боллоо.
Харин тэгэхдээ манай галч
Олон сонин юм бидэнд ярьсан юм
Хаа хол, алтан Москвад
Очсон үзсэнээ өгүүлсэн юм.
Ялгуусан армийнхантай
Уулзаж учирснаа хүүрнэсэн юм
Яргачин дайснууд
Яйрч сөнөж байгаа тухай хуучилсан юм.
Өөрөө дайны зүг
Их буугаар буудсанаа бас ярьсан юм.
Өдий төдий фашистууд,
Өртөж сөнөсөн тухай хэлсэн юм.
Та нарын явуулсан бэлгээр
Танк хийсэн гэж ярьсан юм
Хажуу дээрээ, “Пионер” гэсэн үгтэй!
Харгис дайсныг элдэж яваа... гэв.
Алаг зүрх баясан
Бидний сэтгэл хөдөлж
Атаатны араас хөөж яваа
Тэр танкны барааг харах шиг болсон юм.
Утаа манарсан тулааны талбарт
Бидний бичсэн захидлыг
Улаан армийн дайчин
Уншиж суугаа нь үзэгдэх шиг болсон юм
Галч Доо-гийн ярьсныг бодон байж
Гайгүй сонин зураг зуръя гэж шийдлээ
Тэр шөнө би өнөө л зангаараа
Тэмдэглэлийн дэвтэртээ нэг зураг
нэмлээ.

Утаа манарсан тулааны талбарт
Урагшаа, ганцхан урагшаа давшиж яваа
Улаан армийн дайчин эр
Урам зоригтой жолоодон давшиж яваа
Гал улаан танкийг
Гараа гаргаж зурлаа
Гараа өргөн зугтааж яваа
Гамшигт дайсны цэргийг зурлаа.
Тэр танкны болд биенд
Бидний сэтгэл цутгагдсныг санаж

Тэнхээт түүний ган цогцост
Бидний итгэл цуглан хурсныг бодож
Хатуу хөтүү замын бартаад
Сааран буурашгүй хүчтэй
Хажуу бөөрөн дээрээ, тодоос тод
“Пионер” гэсэн үгтэй
Гал улаан танкийг
Гараа гаргаж зурлаа
Зэвхий дайсан урд нь
Зэвсгээ хаян бууж өгч байгааг зурлаа.

Шинэ мөр

Талын жавар сөрөн, адуучин эр
Хөлгийн хурдаар давшиж явжээ
Танан цас бужигнуулан
Сүргийн зүг тэмүүлж явжээ.
Тэгснээ, жолоо цулбуураа татаж
Газар шагайн нэгийг ажжээ.
Тэнүүн талын малчин хүний
Гярхай нүдээр мөр мөшгөжээ.
Машиных гэтэл нарийхан юм гэж
Малчин эр гайхан боджээ
Дугуйных гэтэл өргөн юм гэж
Дурайсан мөрийг нэхэн дагажээ.
Дуу чимээ нь дуулдаж магадгүй гэж
Дулаан лоовуузаа сөхөн чих тавьжээ
Бараа нь бас харагдах магадгүй гэж
Баруун зүүнгүй өндийн саравчилжээ.
Хөдөөний хүнд гайхал төрүүлсэн тэр мөр
Хөгжөөнт бидний аяллын зам байсан юм.
Багшийн зааснаар галч Доо гуай
Баахан цана авчирсан юм
Баглаа хүлээсий нь тайлан
Бидэнд тарааж өгсөн юм.
Ес эхлээд удаагүй байтал
Ер бусын их цас орсон юм
Ертөнц дэлхий хөмрөв үү гэлтэй
Өдөржин шөнөжин шуурга тавьсан юм.
Хүсэл болсон цас уналаа гэж
Хүүхэд бид дотроо баяссан юм
Өвгөд томчууд харин толгой сэгсэрч
Өтгөн сүрэгтээ санаа зовнисон юм.
Хоёр шөнө, нэг өдрийн цас арилж
Хорвоо дэлхий дун цагаан болов.
Гэрэлт наран тэртээд мишээж
Гэгээ тэнгэр хөв хөхөртөн цэлмэв.
Олон жил гарсныг ч хэлэх үү

Онц сайн сурсныг ч ярих уу
Өвлийн амралт эхэлснийг ч хэлэх үү
Өнгөт цасан орсныг ч ярих уу
Айл айлын хот бууц
Хунгар цасанд дарагдсан тухай
Адуу мал сүрэг сүргээрээ
Шуурга салхинд уруудсан тухай
Тэвдэж сандарсан томчуудын яриаг
Тэгтлээ бид хайхарсан ч үгүй
Адгаж яарсан эрэлчдийн барааг
Анзаарч бид харсан ч үгүй.
Хөр цасанд гулган наадаж
Хөлийнхөө чилээг гаргана гэж байтал
Шинэ цанынхаа шидийг үзэж
Шил талыг туулна гэж байтал
Ишгэн багш бид дөрвийг
Ир гэж дуудуулсан байлаа
Цанаар л гулгах хүүхэд болгоныг
Цуглар гэж зарласан байлаа.
Өндрөөс буухдаа
Өлзий бид хоёр овоо
Холын зайнд явахдаа
Хорлоо, Тунсаг хоёр цовоо.
Сурагч дундаа бид
Цасны хэнээтэн нэртэй болсон юм.
Сургууль хавьдаа бид
“Цанын дөрөв” алдартай болсон юм.
Хулсан цанын нуруун дээр
Хурдалъя гэсэн хүүхдүүд цуглартал
Жийх хөлийн чадлаар
Жирийе гэсэн хорхойтнууд бөөгнөртөл
Ишгэн багш яаруухан ирж:
-Бүгд цугларсан уу?
Гэлээ Ийш тийшээ сэлгүүцэн харж,
Нүдээрээ бүртгэн авав бололтой.

Өнгөрсөн цас хааяагүй,
 Хот бэлчээр даран буужээ
 Өвөлжөө бууц ч ялгаагүй
 Хунгар цасанд автжээ.
 Мал сүрэг,хороо хашаагаа ... гээд
 Малчин олон маань тэвдэж байна.
 Хүйтэн өвлийн жавар салхитай
 Хүч чадлаараа үзэлцэж байна.
 Бүл чадлаар тааруухан
 Айл гэрт тусалъя
 Бүжиг, дуу шүлгээр ч гэлээ
 Сэтгэл зүрхий нь хөдөлгөө!
 Сумын төвийнхөн бүгдээрээ
 Зуд эсэргүүцэхээр мордож байна
 Сурагч пионер бид, тэгэхээр
 Зүгээр сууж болохгүй байна!...
 Багш маань ингэж хэлээд
 Багачууд бидэн рүү харлаа
 “Би явъя, би явъя. . “ гэж
 Бид зэрэг зэрэг шуугилдлаа.
 Хөр цас ховхлох
 Хүрз зээтүү буу шиг мөрөвчилж
 Хөл тээн хурдлах
 Цана юугаа морь шиг хөлөглөж
 Ишгэн багшаа дагаж
 Аялалд тэгж гарсан юм
 Идэр есийн жавар сөрж
 Алсад зоригтой хөдөлсөн юм.
 Хотлоор цанын дөрөв гэгдсэн
 Бид хэд манлайлж
 Хожуу, чармайж мэрийж сурсан
 Хөрш ангийн тав дараалж
 Цэлийсэн хөндий чиглээд
 Мөрөө үлдээгээд урагшлах
 Хэчнээн таатай байсан гээ

Бойтогтой зээрд

Манай сургууль угаасаа
 Мал гэх юм байхгүй
 Усны хар атнаас өөр
 Унах эдлэх юмгүй.
 Хар атаа, галч Доо
 Хайрлана гэдэг тоймгүй
 Эвгүй харсан хүнд ч
 Эгдүүцэж явахаас буцахгүй.
 Нөмөр дулаан хороо
 Гараа гаргаж тэр барьсан юм.

Цэвцийсэн цас зүсэн
 Зам гарган явахдаа бид
 Цэлийсэн хөндий туулан
 Мөрөө үлдээн урагшлахдаа бид
 Хүзүүвчийн бууц хүрч
 Өвгөн Будынд очсон юм
 Хүрз зээтүүгээ хангинуулан байж
 Чулуун хороогий нь өндөрлөлөө.
 Нурамтын өвөлжөөнд очиж
 Цамба зааныд хоноглолоо
 Нуугисан өтөг бууцных нь
 Цасыг арилгаж өглөө.
 Тэндээсээ, Нүхт орж
 Хөр ховхолж хороо айл нүүлгэж
 Энд буулгаж тусаллаа.
 Унь цохиотоос өвс зөөж
 Айл айлд түгээж тараалаа
 Урагшаа, Ухаа овоо хүрч
 Дамба гуайнханд концерт тоглолоо.
 Хүний л хийдгийг хийж
 Хүүхэд биеийнхээ тусыг хүргэлээ
 Гартаа л өртөхийг амжуулж
 Гаргууд их магтаал хүртлээ.
 Айл гэрт тусалсан
 Өрнүүн сайхан сэтгэлтэй
 Аялал жуулчлал хийж яваа
 Өөрсдийн нэгэн баяртай
 Халзан Тээгийн ар хормойгоор
 Харгуй даган жирийлгэж явахдаа
 Харих замдаа ороод
 Оройн жавар сөрж явахдаа
 Сүрэг ижлээсээ гээгдсэн
 Ганц сарваатай дайралдсан юм
 Сөх хунгарт шигдсэн
 Зээрд даагатай тааралдсан юм

Нөгөө талд нь бас
 Өвсний хашаа түгжсэн юм.
 Хар атандаа бид нар
 Хадлан хураах гэж явна
 Өргөн талл гарч
 Өвс ногоо түүнэ.
 Цахилдаг, таана, хөмүүл
 Шарилж, ерхөг, хамхуул...
 Гарт л өртсөн бүхнийг
 Мал иддэг болгоныг

Сургуулиараа, бид гарч
Шуудай шуудайгаар түүнэ.
Өвсний нь хашаанд авчирч
Өндөрлөж сайхан хураана.
Тэсгэм жавар тачигнасан
Шуурга цастай өдөр
Тэр өвснөөс Доо гуай
Хар атаа тэжээнэ.
Тэнүүн дулаан өдөр бол
Хар ат нь ганцаараа
Тэнэгэр сайхан бэлчээрт
Өөрөө явж идээшилнэ.
Замаас олсон сарваагаа
Тэр хооронд нь авчирч
Залгаа хашааны нь өвснөөс
Тэвэр тэврээр өгтөл
Хар ат анхандаа
Хажиглаж сүрхий бишүүрхэв
Хамар амаа шүүрхийлж
Хачин ихээр зэвүүрхэв.
Адайр муухай ааштай юм гэж
Аман амандаа шуугьж байтал
Амиа бодсон амьтан юм гэж
Алиалж биднийг ажиж байтал
Хар аты маань зовоолоо гэж
Галч Доо гуай уурсаж ирсэн юм
Хажуудах сарваагийг нь харснаа
Гайгүй түргэн тайтгарсан юм.
Дорой ч гэсэн зээрд сарвааг
Дотнотчилж сүрхий үзэв
Эр даага учиртай. . гэв
Эргүүлэг юугий нь шинжив.

Эмнэг зээрдийн эзэн ирлээ

Цагаан сар гарч
Өдөр хоног улиран байтал
Цагийн урь бууж
Өглөө үдэш ээлжлэн байтал
Хөөрхөн зээрд омгорхож
Хөвсөн бойтогоо тийрэн давхихад
Эмнэг зээрд аагирхаж
Эсгий нэмнээгээ голон булгихад
Харсан бид өхөөрдөж
Ханатлаа нэг хөхрөлдөв
Хөгшид настан ч хараад
Хөгжилдөн шуугилдав.
Гэхдээ, тэр биднээс салахгүй

Манай галчийн хороонд ингээд
Тэмээ, адуу хоёр байдаг боллоо
Манай сургууль ч ингээд
Ат, сарваа хоёртой боллоо.
Ижлийнхээ хойноос зүтгэж
Ид чадлаа барсан
Шинэ цасанд цамнан
Шилбэний үсээ зулгалсан
Хөөрхий сарваа, дулаан хороонд
Санаснаас түргэн тэнхэрлээ
Хөх өвс амтархан идээшилж
Бодсоноос амархан гаршлаа.
Тэглээ ч гэсэн бид
Тэнхээ чадлаараа тордсон юм.
Өглөө болгон ирж
Өхөөрдөж хайрладаг боллоо
Хөр цасанд зулгарсан шилбэнд нь
Хөдсөн ороолт ороов
Эцэж турсан зоонд нь
Эсгий нэмнээ ч өмсгөв.
Анх хэнээс гарсан юм
Хэлж чухам мэдэхгүй.
Алиалж хэн нь нэрлэсэн юм
Цохолж нэрлэж чадахгүй
Тэжээвэр зээрдий маань тэгтэл
“Бойтогтой” гэж дооглодог болов
Тэр ч байтугай зарим нь
“Дээлтэй” гэж шоолдог болов.
Эсгий нэмнээн дороос хөлөг гэж...
Галч Доо гуай бахархана
Эсрэгэн хавар сургана гэж
Өлзий найз маань бас шохоорхоно.

Гэр хашаанаас холдохгүй
Эрүү чихээ маажуулж
Сэрвээ зоогоо илбүүлэх гэнэ.
Худгийн онгож тоохгүй
Хувин савнаас ундлах гэнэ
Газрын өвс голж
Гар тэжээл амтархах гэнэ
Багачууд биднийг харчихвал
Барааны газраас цогин ирнэ
Сүрэг адуу харчихвал
Сүүлээ агсан цахилан одно
Орхиод биднийг явчхав уу гэтэл
Оодрон оодрон давхин ирнэ

Буцаад тийш нь хөөх гэтэл
 Бултан бултан даган эрхэлнэ.
 Өдрөөс өдөрт зээрд даага
 Өхөөрдөж хайрлам загнана
 Өөрсдөө ч бид тэрнийхээ аашийг
 Өвөр хоорондоо гайхуулна.
 Толгойгоороо тоглож явахы нь харвал
 Нэгэндээ харуулах гэж шамдана.
 Тоосноосоо бусгаж явахы нь үзвэл
 Нөгөөдөө дуулгах гэж шимтэнэ.
 Сүүлээрээ тоглож явахы нь харвал
 Сүр болгож найздаа гайхуулна
 Сүүдрээсээ бусгаж явахы нь үзвэл
 Сонин болгож нөгөөдөө сайрхана.
 Болгоон болгоон ажихад
 Бойтогтой зээрдийн ааш хувирч
 Нэхэн нэхэн бодоход
 Нэмнээтэй зээрдийн зан хувьсаж
 Мал болжээ... гэж галч Доо
 Магтаал үг хэлдэг болтол
 Адуу болжээ... гэж томчуул
 Ая зангий нь шагшиж байтал
 Хос мориор унаалсан
 Эрлийн хүн ирлээ гэлцлээ
 Хонгор зээрдийн эзэн гэж
 Гэрт гадаа хэлцлээ.
 Эрх зээрдээсээ холдох
 Үнэхээр бид дургүй байлаа
 Эзний нь тухай дуулах
 Эндээ гэхэд бүр ч дургүй байлаа.
 Хөдөө талын салхинд
 Хөрслөг царай нь борлосон
 Дээд тэнгэрийн наранд
 Дээлий нь мөр гандсан
 Тал нутгийн малчин эр
 Биднийг чиглэн ирлээ
 Тана шүдээ яралзуулан
 Таньдаг хүн шиг мишээлээ.
 Хөөрхөн зээрдийг авна гэвэл яах вэ гэж
 Хүүхэд болгон бишүүрхүү угтлаа
 Хөдөөгөөс олоогүй бол, яанам гэж
 Хүдэр эртэй гэрэвшүү уулзлаа.

Дайны жилийн алим

Дайны жилийн алим
 Даанч амттай байсан юм уу
 Өдрийн од шиг ховор болохоор

Холын тэр хүн бидэнтэй
 Тун ч найрсаг мэндэллээ.
 Хонгор зээрдийг гурийлан дуудаж
 Толгой магнайгий нь илбэн эрхлүүлээ.
 Малд хайртай хүүхэд та нарт
 Малчин ах нь баярлаж байна гэлээ
 Адуунд хайртай багачуул та нарт
 Ариун сэтгэлээсээ биширч байна гэлээ
 Хичээл номд чинь амжилт ерөөж
 Энэ даагаа бэлэглээ гэлээ
 Хэтийн үйлсэд чинь сайныг хүсэж
 Унаган зээрдээ орхиё гэлээ
 Баярласандаа болоод би
 Бахиралдан хөөрч дэвхэцлээ
 Алаг зүрхнийхээ талархлыг
 Алга ташиж дэвшүүллээ
 Эрх даагаа сургах
 Эршүүд хэцүү байдаг юм
 Эмээл тохож мордоход
 Этгээд хашин загнадаг юм.
 Хэнэггүй зангий нь мартуулж
 Хээрийн бэлчээр дагуул
 Айлсаг ааший нь залруулж
 Адуу мал бараадуул!
 Удамтай сүргийн унага даа
 Унан байж мэдээрэй!
 Сайн гүүний үр дээ
 Санаж байж эдлээрэй!
 Адууч эр ингэж
 Сургаал үгээ хэлэхэд
 Адтай чангаар исгэрч
 “Суман зээрдийг” гилэхэд
 Уужим талд давхиж яваа
 Унаган зээрд
 Хэчнээн өхөөдөм байсан
 Улаан нарны наагуур дэгдэж байгаа
 Ухаа тоос нь
 Хэчнээн бахархам харагдсан гээ!
 Агтын манлайд хурдалж яваа
 Аранзал зээрд харагдах шиг болж билээ
 Унасан хүүхдий нь хүзүүнд дэрвэж байгаа
 Улаан бүч нь дэрвэлзэх шиг болж билээ.

Өөрсдөд маань тэгж санагдсан юм уу
 Таван ес өнгөрч
 Талын жавар харьдаг үеэр

Нөмрийн цас сиймийж
 Нөөлөг салхи урьсдаг цагаар
 Сумын улаан буланд
 Нэг хурал боллоо
 Сургуулийн хүүхэд, эцэг эх
 Нийтээрээ л тэнд цугларлаа.
 Тэр хурал дээр, сумын дарга
 Ишгэн багшийн нэрийг дурьдаж
 Тэгээд ч зогссонгүй
 Бид хэдийн аяллыг ярьж
 Өвөлжөө бууц зассаны маань
 Өлзийтэй үйлс ... гэлээ
 Малчин олонд тусалсны маань
 Магадын сайн хэрэг... гэлээ
 Өнчин даага тэжээж
 Өсгөж торниулж байгаа... гэв
 Өөрсдөө бас сурлагатаа
 Өөдрөг сайн яваа... гэв
 Цанын спорт дэлгэрүүлсэн гэж
 Ишгэн багшийг магтлаа
 Цастай талаар аялсан гэж
 Багачууд биднийг бахадлаа.
 Сурагч багш нарт
 Шагнал гардуулна гэлээ
 Сумын захиргааны өмнөөс
 Баяр хүргэе... гэлээ.
 Дээлийн даалимба, үнэмлэхтэй
 Багшийн маань шагналаа.
 Тэр шагналын алим
 Амттай байсныг яанам!
 Тэнхээ сорин хийсэн
 Ажлын маань өгөөж болоод ч тэр үү
 Тэмүүлж шимтэж явсан
 Аяллын маань хишиг болоод ч тэр үү
 Дайны жилийн тэр алим
 Даамай амттай байсан юм.
 Амссан хүүхэд болгон баясаж
 Ам амандаа шагшиж явсан юм.

Төгсгөл

...Дэврүүн бага насаа бид
 Сургуулийнхаа танхимд орхин
 Дэндүү гэнэн зангаа бид,
 Сурагчийнхаа ширээнд үлдээж
 Налгар хаврын тэр нэг өдөр
 Гэр гэр лүүгээ зорьсон
 Найман зовхист зурайсан

Арван ширхэг алимаа би
 Айхавтар олон хуваасан юм.
 Ангийн найз, аав ижийдээ
 Адилхан түгээж амсуулсан юм.
 Өлзийн эмээ хүртэл, намайг
 Өглөгч хүү гэж магтсан юм
 Өргөө гэрийнхээ тоононд тултал гараа
 “Өндөр болоорой!” гэж өргөн ерөөсөн юм.
 Хүн бүхний нүдэнд ахиад амтархах
 Хүсэл сэтгэл гялалзаж байсан юм
 Гэрийн чинээ алим байлаа гэхэд, би
 Гэдийж буцахааргүй идмээр санагдсан юм.
 Тэгээд ч зогсоогүй өнөө дэвтэртээ
 Тэврээд багтамгүй алим зурсан юм.
 Дайны жилийн алим
 Гашуун ч байсан байж мэднэ
 Даанч ховорхон болохоор
 Амттай ч санагдсан байж болно.
 Харин, би амт шимтий нь
 Харагдахаар зурж чадаагүй
 Хамар цоргисон үнэрий нь
 Ханхлуулж бас дийлээгүй!
 Дайны жилийн алим
 Даанч ховор байж дээ
 Дааган насны минь хүсэл
 Даамай өрнүүн байж дээ!
 Удаа ч үгүй, тэр хавар
 Дайн хэрвээ дуусаагүй бол
 Улаан армийн дайчдад
 Эрх зээрдээ бэлэглэнэ гэж
 Сургуулийн зээрд гэсэн
 Учир явдлы нь захидалдаа бичиж
 Сурагч болгон
 Гарынхаа үсэг зурна гэж
 Хурал цуглаанаар ярилцаагүй ч
 Хувь хувьдаа хэлэлцсэн юм
 Анги сургуулиараа ярилцаагүй ч
 Амь амьхандаа тохиролцсон юм.

Зам замаар орсон
 Салж явсан тэр цаг
 Саяхан мэт тодхон байна
 Сарвалзаж далласан гарууд ч
 Санаанд бас содхон байна.
 Бүл халуун амиараа
 Цугларч бид уулзсангүй, гэвч

Бүлээн гараа атгалцаж
“Алтан хүрээцэж” тоглосонгүй, гэвч
Дайн дууссан тэр зун
Сумын наадмын дэвжээн дээр
Дааган зээрд, үрээ болчихсон
Цолоо дуудуулж байхыг харсаан би!
Миний найз Өлзий
Хусуур сойз хавчуулаастай
Мишээл баясал тодруулан
Зогсож байхад нь уулзсаан би!
Сургуулийн зээрдийн
Ид шид нь гарчээ... гэж
Сумын наадмынхан
Бахдаж байхы нь сонссоон би
Олны юм одтой байдаг... гэж
Өвгөд настан өхөөрдөж
Омог хийморь нь өндөр яваг... гэж

Ерөөл дэмбэрэл тавьж
Сурагч биднийг дурсан, зээрд үрээг
Хадаг сүүгээр мялайж байсан юм
Сургууль танхимы маань нэрлэн
Халуун сэтгэлээ дэвшүүлж байсан юм
Удамт хурдан төржээ... гээд сумын дарга
Унасан хүүхдий нь байг гардуулж байсан юм
Улс олны сэтгэлийг улам баясаан
Унаган зээрд янцгааж байсан юм.
Аранзал гэж ахайлсан нэрэндээ
Эрх зээрд маань хүрлээ гэж
Адуунд гарамгай гэсэн нэрэндээн ч
Манай Өлзий ч бас хүрлээ гэж
Ишгэн багш маань нүүр магнайдаа
Инээд мишээл тодруулан ярьж байсан юм
Багшийн хажууд галч Доо гуай
Баярын нулимсаа арчиж зогссон юм!

1975 оны зургаадугаар сар Улаанбаатар

Асууулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Зохиол бичигдэх болсон түүхэн үндсийг тодорхойлон бичнэ үү?
3. Зохиолын туурвил зүй, агуулга, үзэл санааны онцлогийг тодорхойлон бичнэ үү?
4. Зохиол дахь багшийн дүрийг тодорхойлон бичнэ үү?
5. Зохиолын сургуулийн зээрдийн дүрийн онцлогийг тодруулан бичнэ үү?

III БҮЛЭГ. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол - Уран сайхны болон танин мэдэхүйн зохиолууд

Бор бор болжмор

С. Буяннэмэх

Тэр нэгэн өдөр сургуулийн чөлөө тавихад ах дүү хоёр Сэлэнгэ мөрний хөвөөгөөр сэлгүүцэн наадаж явсаар нэгэн төгөл модны захад дөрвөлжин хар чулуу байхыг үзэж ах нь хэлэв.

Дүү минь хоёулаа энд сууж амаръя гэхэд дүү нь ахынхаа үгийг дуртайяа зөвшөөрч хоёулаа суув.

Дүү минь чи, түүнийг хараач. Тээр тэнд завин дээр хоёр хүн суугаад, тунгалаг сайхан усны дунд, ийш тийш хэлбэлзэн дайвалзан цэнгэлдэн явах нь үнэхээр сайхан бус буюу гэхэд ахын үгийг тосож аваад дүү нь ийн хэлэв.

Үнэхээр сайхан байна. та бид хоёр төгөл модны дэргэд суугаад уудам дэлхийн саруул тунгалгийг харж байгаатай адил байна гэхчилэн ах дүү хоёр ингэж, энэ тэрийг ярилцаж, суух сацуу хоёр бяцхан болжмор нэсн ирж хажуугийн модноо суугаад жийг жийг гэж жиргэж гэнэ.

Дүү нь тэднийг оч мэт хоёр нүдээ гялалзуулан ширтсэнээ өт мэт хөөрхөн хуруугаараа зааж, “Тишш, шш” гэсэн дуу гарган:

Ахаа ахаа Тэр бяцхан болжморыг хараач гэхэд ах нь сэтгэл баясан дүүгийн зүг харвал хоёр бяцхан бялзуухай хошуу холбон жийг жийг гэх нь ах дүү хоёрын тухай үг хэлэлцэж буй мэтийг үзээд:

Дүү нь битгий дуугар. Хоёр бялзуухай бидний тухай хэлцэж байгаа бололтой.

Тэд та бидний адил төрсөн байтал манийг юунд хэлцэх билээ? Харин тэдэнтэй наадах уу, хоёул? гэж дүүгээ асуухад нь:

Бяцхан бялзуухай биднийг жигших болно гэж ах нь хариулав.

Яалаа гэж биднийг жигших вэ? Тэднийг бие бага тул биднийг том хэмээн жигшихгүй юу?

Бид л мөн бага байхад юунд том гэх билээ гэхэд ах нь дуугарсангүй.

Дүү нь бяцхан гараа болжморын зүг тосож, Нөхөд минь, Нааш ирцгээ, Бидэнтэй тоглооч гэж хэлэхэд нь:

Үгүй, бид та нартай тоглохгүй гэж болжмор хариу өчив.

Юунд бидэнтэй наадахыг үл хүснэ вэ? гэж хүүг асуухад:

Та нарын бие том, бид өчүүхэн тул үл тэнцэнэ гэж болжмор хариулав.

Бидний бие бас бяцхан байтал та нар юунд том гэж бодно вэ? Бид бас та нарыг шоглохгүй тоглож чадна гэж хүүг хэлэхэд хоёр болжмор ихэд инээлдэн байж,

Тийм бол чи энэ модны мөчир дээр гарч ирээд наад л даа гэв.

Бяцхан хүү сайхь үгийг сонсоод ихэд баярлаж босон харйгаад гүйж одов. Модонд хүрч, чадан ядан мөчирт гарахаар авиран оролдоход хоёр болжмор ихэд инээлдэж гэнэ. Хүү бүр ядаад:

Нөхөд минь та нар намайг өөрсдөө, аваачин наадахгүй юу? гэж хашхирчээ. Тэгэхэд нь бялзуухайнууд:

Чи яагаад байна вэ? гэхэд

Миний бие хүнд тул модны мөчир даахгүй байна гэж хүүг хэлэхэд:

Чиний биеийг том гэж хэлэхэд чи өөрөө итгэхгүй байсан шүү дээ. Одоо том байна уу?, бага байна уу? гэж хэлэх үгийг сонсоод ихэд ичжээ.

Түүнээс хойш бялзуухайтай тоглох гэж мод чулуу өөд авирах нь буруу юм байна гэж мэдсэн юм гэнэ билээ.

Асууулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Зохиолын дүр дүрслэлийн онцлогийг тайлбарлан бичнэ үү?
3. Зохиолын агуулгын ач холбогдлыг тайлбарлан бичнэ үү?

Алт, мөнгө хоёр

П. Хорлоо

Эрт цагт нэгэн эцгийн хоёр хүүхэд, холын уулнаас мод түүж ирэхээр явах болжээ. Явахад нь ээж нь хоёр хүүхэддээ замдаа “идэж яв” гэж нэг нэг боодолтой ааруул эзэгий өгөөд “хоорондоо эвтэй, ах нь дүүгээ асарч яв!” гэж захьжээ. Ингээд хоёр хүү алсын аяны замд гарчээ. Энэ хоёр хүүгийн ах нь Алт, дүү нь Мөнгө гэ-дэг нэртэй юм байжээ. Алт, Мөнгө хоёр замдаа их хүйтэн шуургатай. шөнө хээр унтах болжээ. Мөнгө нь хэлж гэнэ: Ахаа! Энэ хүйтэн шуургатай шөнө их даарна шүү! Хоёулаа хадны агуй олж унтахыг бодъё гэж хэлэв. Алт нь:

Миний дүүгийн үг зөв. Хоёулаа хоёр тийшээ явж агуй эрье. Чи энэ уулын өвөр лүү яв! Би уул өөд явъя, аль түрүүн агуй олсон нь бие биеэ дуудъя гэв. Дүү нь “за тэгье” гэж зөвшөөрөөд хоёр тийшээ салаад, хоргодож унтах хадны агуй эрхээр явцгаажээ. Мөнгөд хадны агуй ер олдсонгүй, унтахаар нөмөртэй газар олоод ахыгаа дууджээ. Юу ч дуугарсангүй. Алт нь уулын оройд гараад, нэг дулаахан агуй олжээ. Хэвтээд үзсэн чинь хоёр хүн арай багтахгүй болохоор би өөрөө дулаан унтвал, бусад хүн хамаагүй гэж бодоод дүүгээ дуудсангүй агуйн мухарт тавтай орж унтаж гэнэ.

Мөнгө нь ахыгаа хэзээ дуудах бол гэж чагнасаар суутал тас харанхуй шөнө болж цасан шуурга улам ширүүсчээ. Өвлийн хүйтэн шуурган дунд нимгэн хөдсөн дээлтэй Мөнгө тачигнатал чичирч, айх даарахын эрхэнд ахыгаа олон удаа дуудсан боловч огт чимээ гарсангүй. Мөнгө хүүгийн гар хуруу чимчигнэж, хөлдөж үхэх шахаад байтал, адуу эрж явсан өвгөн дайралдаж, арваад настай бяцхан Мөнгө хүүг дулаан дээлэндээ хучиж, хөлдөж үхэх аюулаас аварчээ. Тэр ууланд чоно элбэгтэй юм байжээ. Хоёр чоно үдэш агуйнаас босож шөнө айлуудын хот руу ан хийж яваад юу ч олсонгүй өлсгөлөндөө гутсаар үүрлэдэг агуйдаа иртэл, агуйд унтаж байгаа бяцхан хүүхдийг хараад тоймгүй баярлаж, хэл, амаа долоож идэхээр завдаж, хэн нь эхэлж барих вэ? гэж ярилцаж байжээ.

Мөнгө хүү өвгөн адуучны хүчээр дааралгүй хоносон боловч ахыгаа харанхуйд төөрөөд хөлдөж үхсэн болов уу гэж бодсоор байгаад үүрийн цагаан гэгээгээр босож ахыгаа эрээд хадны агуйн дэргэд ирээд, агуй руу мөлхөж яваа

хоёр чоныг үзээд чанга дуугаар хашхиртал цогтой хүүгийн дуугаар чоно зугатаад явчлав. Алт арай гэж сэрээд чонын барааг хараад айсандаа уушиг зүрх нь дэлбэрэх шахжээ. Ингэж ах дүү Алт, Мөнгө хоёр үүрээр уулзжээ. Хэрэв Мөнгө эрж олоогүй бол Алтыг чоно яах байсан бэ? Та нар сайн бод! Энэ юунаас болов?

Асуулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Зохиолын дүрүүдийн зан чанарын онцлогийг харьцуулан бичнэ үү?
3. Зохиолын агуулгын ач холбогдлын тайлбарлан бичнэ үү?

Хос тогоруу

Д. Цэвэгмид

Нэг

Довын энгэрт агь нүдэлж, нөмөр газар хөх яргуй товчилсон цаг, хүйтэн холдож дулаан ойртсон хаврын нэгэн өглөө, уудам талыг хөндлөн огтолсон урт сайхан замын дэргэд хос тогоруу нисэн ирж буулаа. Тэд нарын өнгө зүс нь ч ижилхэн, том жижиг нь ч адилхан, бодвол эгч дүү байлтай. Эсхүл анд нөхөд ч байж болзошгүй. Амраг хоёр ч байж магадгүй. Ямар боловч энэ хоёр, алс холын аян замын бартааг хамт туулж, анх төрсөн газар өндөг байхаас эхлэн өсөж бойжсон өлгий нутагтаа иржээ.

Үүрийн цагаан гэгээ тусаж буй өргөн талаас тэнүүн юу байх билээ. Алсын бараа тодрох нь соньхон, сэтгэл тэнийм уудам сайхан. Тэртээ нүдний үзүүрт уул үүл уулзан золгоно. Түүнээс нааш бууралтан должилж, дуугүй дүнсийн цэлэлзэх их хөндийн айлуудаас хөх утаа суунаглана. Замын дэргэд саяхан буугаад орчин тойрныг сонирхон ажиг хос тогорууг үхэр оготно үзмэгцээ хөөсөн дээрээ гарч час час исгэрэх нь “Хүүе, нөхөд өө! Яасан инээдэмтэй амьтад вэ? Хүзүү нь тохигор, хөл нь дэнжгэр юм. Хараач, үзээч, та минь” гэх шиг.

Холын дорнод зүгт, эхлээд дээд хүрээ нь, дараа нь тал бие нь аажимхан цухуйсаар өглөөний наран мандаж улбар шар туяагаараа Орхоны их хөндийг гийгүүлэх үес, салхи сэвэлзэн хөдөлж, өвлийн турш бутны ёроолд унтсан бужгар хазаар өвсийг сэрүүлэв.

Өнгөрсөн намрын хөгшин хазаар өвс өнхрөн тонгорон ирэхэд хос тогоруу “Юу болох нь энэ вэ?” гэсэн шиг хирдхийн цочиж, ийш тийшээ харуулдавч өвсөн толгой шамалзан хийсэх их талын уудмыг өмнө газар олон дахин үзсэн далайн давалгаа лугаа адилтгаж, хэдэнтээ бие биеэ дуудалцаад нам тайван алхлав.

Удалгүй айлын хонин сүрэг бэлчээрлэж, хоньчин хүүхэд түүнийг даган гарахыг мань хоёр үзэхдээ “Ноднин зуны дэрчгэр чихт биш байгаа даа” гэж бодовч “Одоо бид нисэж чадна, чамд дахин баригдахгүй” гэсэн шиг жигүүрээ дэлгэн сэгсэрч дэгэн догон цамнана.

Өглөөний наран өндийн өндийсөөр нэлээд дээр гарахын чацуу морьтой хүмүүс, хөсөгтэй анчид ойрх замаар цувж эхлэвч тэрхүү хос тогоруу ер тайван “За даа, ийм хүмүүс явдаг л юм” гэсэн байдалтай нахис бөхөс алхлан өвсний үр буурцаг тоншино.

Эх нутагтаа ирснээс хойш энэ мэтээр өдөр хоног олныг өнгөрүүлэв. Тэрэгтэй, тэмээтэй аянчдаас айх, сэжиглэх нь огт үгүй, харин замын дагуу улаан тоос хадаасан, учир дүрсгүй хурдан, дөрвөлжин хар юм хааяа давхин өнгөрөхөд баахан зэвүүцэж, толгой өргөн удтал ажиглах бөгөөд хэрэв тэр гайхал хэтэрхий ойртох буюу гэнэт зогсоход хүрвэл шуурхайлан цааш алхах зуураа гэдэргээ эргэн харсаар нэлээд холдоод нэгэн хэсэг сээтэгнэн ажиж зогсовч машин далд орохын чацуу аймшгийг мартаж, хэвийн байдлаар тонгос, тонгос алхлан газраас юухан хээхнийг түүнэ. Тэр хоёр үргэлж хамт явна. Нэг нь нөгөөгөөс өчүүхэн л тасарвал гурруу гурруу гэж биеэ дуудна.

Эд, эх нутгийнхаа хүн мал, эргэн тойрны үзэгдэл бүхнийг таних учир айх юмгүй амар жимрээр шар наран, бор хоногийг өнгөрөөнө. Өдрийн бэлчээрт олсон бүхнээ хуваана. Шөнийн хэвтэрт ээлжлэн манаанд гарна. Ингэж үргэлж хамт амьдардаг, салшгүй хос, сааршгүй анд нөхөд байжээ.

Тэр хоёр, хаврын хатуу улирлыг эсэн мэнд өнгөрөөн, зуны сайхан цагийн босгыг алхав. Өргөн тал өнгийн цэцгүүдээр хучигдаж, болжмор шувуухайнууд бутны ёроолоор үүр засаж эхлэв.

Мөнхүү хоёр тогоруу ч гэдэн гэдэн алхаж дэмий хэсүүчлэхээ зогсон, эрээн цахиур элбэгтэй, элсэрхэг нэгэн дэнж хавьд тогтуухан байдаг болсон бөгөөд түүний нэг нь зөөлөн элсийг хонхойлон засаж, сав л хийвэл хэвтэж байх нь үзэгдэнэ.

Анхилам цэцгүүд найгасан аялуун зуны нэгэн өдөр байлаа. Орхоны их тал дээр ногооны цэнхэр униар татаж, алсын бараа зэргэлгээнд сүүмэлзэнэ.

Алсад яваа тэмээн хөсөг уултай чацуу өндөр болон шовойгоод бас дундуураа тасалдан дэнжигнэнэ. Бага үд болохын хэр, замын тоос бужигнан дэгдэж, түүний дундаас нэгэн машин гарч ирээд, хос тогорууны зэргэлдээ утаа хаялуулан урагш хойш ухасхийн тар түр зогссоны дотроос хэдэн хүн гарч ирлээ.

Тэдний нэг нь хэвтээ тогорууны зүг хэд алхаж оцойн суухад босоо байсан тогоруу нь “Яах гээд байгаа юм бэ?” гэж сэжиглэсэн янзтай цаашаа холдох зуураа ижил тийшээ хандаж, “Босох юм биш үү! Цаадуул чинь ямархан л улс бол доо” гэсэн дохио өгсөн боловч хэмтэж буй нь “Тэмгүй биднийг яана л гэж дээ” гэсэн байдалтай, итгэл дүүрэн, санаанд үгүй хэвтсээр байв.

Бутны ёроолоос болжмор шувуухай эрвэсхийн нисэж, агаарт тогтохыг хүсэх мэт дэрвэн байж тайван цагийн уяхан дуугаа дуулан жиргэнэ. Тэр дуундаа:

Эвий хөөрхий ангаахайнууд минь

Ээж нь удахгүй мөдхөн очно

Эрээн дальт эрвээхийнүүдийг

Элбэг дэлбэгээр түүгээд очно гэж дуулна. Гэнэт “Чив”, “Фус” гэсэн чимээ гарч дарийн муухай үнэр ханхлав.

Хэвтээ байсан тогоруу ухасхийн босож нисэхийг завдан гүйсэн боловч газраас хөөрч чадсангүй, өрөөсөн жигүүрээ хэд дэвээд ойчив.

Энэ үе өндөр дээрээс болжмор шувуухай жиргэн жиргэсээр л боловч дууны өнгийг өөрчилж,

Хөөрхөн бор ангаахайнууд минь

Хүзүүгээ дарж хөдлөлгүй хэвт,

Алаг бор ангаахайнууд минь

Амаа хумхиж чимээгүй нуугд! гэж түгшүүр зарлан жиргэв.

Машины дэргэд сүүдтгэнэх хүмүүс тогоруу унаж үзэгдэх бараа тасрахад “Мэргэн буу байна”, “За явъя” гэлцэх нь сонстоод удалгүй гаж буруу тэр машин газар дэлхийг доргитол хажигнаж пажигнасаар далд оров.

Хоёр

Бууны дуугаар нисэн холдсон тогоруу ижлийнхээ дэргэд эргэж буумагц ийш тийш харуулдаж, аюул сэрэмжрэх байдлаар нэгэн хэсэг зогсоод, “Бос, эндээс холдъя” гэсэн шиг цааш алхахад нөгөө нь арайхан хөл дээрээ өндийвч өрөөсөн далавч нь салбайтал унжсан өвчүүн талын өд ноолуур нь цусанд зууралдсан байв.

Энэ хоёр юу болтугай ч замаас холдохыг шийджээ.

Эрүүл нь “Намайг дагаад яв” гэж байгаа бололтой хэд хэд алхаад, гэдрэг эргэн харна. Шархтай нь түүний хойноос өрөөсөн жигүүрээ чирсээр гэлдрэх боловч байн байн хэвтэнэ. Хэвтэх үед нь түрүүчийн тогоруу эргэж түүний дэргэд ирээд, нэгийг ятган хэлэх мэт толгой гудайн зогсоно. Тэгээд тэр хоёр дахин цаашаа гэлдэрнэ.

Эрүүл өвчтэй энэ хоёр тогоруу ингэж явсаар замаас нэлээд зайдуу байгаа өтгөн дэрсэнд хүрч үзэгдэх бараа тасрав.

Тогорууны хүч жигүүртээ байдаг. Хүч чадал бүрэн үед салхийг урууддаггүй, харин сөрөн нисэж уулыг ч давдаг, үүлийг ч нэвтэлдэг. Хүч чадал бүрэн үед чийг ханхалсан бөглүү газар ойртдоггүй, харин холын бараа ил харагдах аль өндөр дэнжийг зорьдог билээ.

Гэтэл ижил энэ хоёрын нэгэнд үнэхээр гай тохиолджээ. Жигүүр хугархай шувуу явлаа гээд хаана хүрэх вэ, зугтаалаа гээд юу базаах ажээ. Арга буюу нэг мөч ч болсон амьд явахын тэмүүллээр далд газар нуугдсан хэрэг биз. Ижлээ дэрсэнд хэвтүүлээд, эрүүл нь ийш тийш явж идэш тэжээл түүнэ. Олсон олзоо хошуундаа зуун авчирч, ханийнхаа аманд хийж өгнө.

Аз тохиолдвол амьдралаа үүрд холбосон энэ минь эдгэрч юу магад гэсэн итгэлээр аль амттай зүйл, шинэ ургамлын үндэс, үр буурцаг олохыг хичээнэ.

Орой бүрий нөмрөн ирж, сэрүү татах үес шархтай тогоруу өндийж ижлээ даган нааш гэлдрэв. Бодвол харанхуйд халхлагдаж газар дөхөхийг хичээсэн хэрэг биз.

Чухам хаана хүрэхээр зорьсныг бүү мэд. Жигүүртэй үед хэдхэн гуагалаад, уулыг давдаг билээ. Жигүүргүй болсон шувуунд уулыг давах байтугай урдах хотгорыг ч гатлах нь хэцүү даваа болжээ.

Эхлээд нэг, дараа нь хоёр гурваар тодрон тодорсоор тэнгэрийн мандалд түг түмэн одон мичид мяралзан түгэв. Одны олонд огторгуйн уудам нь уйтан мэт, газар тэнгэрийн уулзварт хүртэл өдий төдий одод гялалзаж орчлон дэлхийг ширтэх боловч зовлонд нэрвэгдэгсдийг опхон ч хайхрахгүй нь харамсалтай.

Тэр хоёр, гэлдэрсээр яваад бяцхан цөөрмийн эргэнд хүрч, зэгсэнд шурган дахин хэвтэв. Ядарсан амьтдад унд болох ус олдсон нь яамай даа.

Өндөр тэнгэрийн уудам зайд багтаж ядсан мянга мянган од мичид өчүүхэн цөөрмийн усанд цөмөөр, бүгдээр багтан тусаж, түүний гүнд гялалзах нь соньхон энэхэн эгшинд цөөрмийн ус ёроолгүй гүнзгий юм шиг харагдана.

Эрүүл нь өвчтэйнхөө биеийг шөнийн хар чийгээс халхлан, халуун далавчаараа нөмөрч хэвтэв.

Шөнө урт, уйтгарлан гонсойж олныг бодох цаг их, уй гашууны нь хэмжээгээр түүний нүднээс нулимс гардаг сан бол тэрхэн цөөрмөөс багагүй усан цүнхээл тогтохсон. Гагцхүү түүний ус нь амсамгүй шорвог болох нь давсных биш, эмгэнлийн гашууных байх биз.

Хүн гэдэг уужим сэтгэлтэй, огторгуйн бүх оддыг багтаасан энэ цөөрмөөс ч гүнзгий ухаантай байх ёстой. Гэтэл даанч яав даа. Бид хүнд ямар хор хүргэсэн билээ. Харин малын бэлчээрийг нь ургамлын хортныг түүж, баян дэлгэр нутгийнх нь бараа чимэг болон явдаг биш билүү? Махыг маань иддэггүй, арьсыг маань ашигладаггүй атлаа юунд буудав. Буудах бай мундаа юу, зугаацах цэнгэл ховордоо юу, энэрэх өрөвдөх, халамжилж хайрлахыг яагаа вэ дээ гэж гомдоно. Байн байн халаглана.

Монгол газрын зуны шөнө богинохон байдаг. Гэтэл энэ нэгэн шөнө нь зовлонд учирсан тогорууны бодолд маш урт амьдралдаа өнгөрүүлсэн бүх шөнөөс нь ч урт юм шиг санагдлаа. Хамгийг халхалсан харанхуй, өдрийн гэгээнд уусан арилах үед хөөрхий энэ минь тэнхрэх болов уу гэж горьдоно. Нарыг хүлээнэ, өдрийг хүлээнэ. Энэ зуур эрт эдүгээг эргэцүүлэн саналаа. Туулж өнгөрүүлсэн зам нь нүдний нь өмнө дурайн шиг болов.

Гурав

Өнгөрсөн жил билээ. Намрын сэрүү татаж өвсний толгой шарлах үес олон газрын тогоруу Орхоны хөндийд цугларч баян гэрийн хониноос ч хавьгүй олноор сүрэглэв. Ишээ ганхуулсан тариан түрүү намилзан халиурч, салхины аясаар давалгаалан долгиолно. Амттай будаа газар бүр, өдөржин шөнөжин идэвч барагдашгүй элбэг, үнэхээр тогоруу бүхэн цэнгэлийн далайд умбах ажээ. Гэтэл хашир тогоруу “Одоо явалгүй горьгүй, цаг оройтох нь” гээд ниснэ. Энэ сайхан нутгаас илүү ямар газар нүүх гэсэн юм гээд үр төл нь хойш сууна. Зарим залуу тогорууд, хөгшдөө даган нисэвч уул давахын үес гэдрэг буцна. Тэдний хойноос аав ээж нь хөөн ирж “Явъя” гэж аргадна. Энэ мэтээр олон дахин нисэж, олон дахин буцаж урагш хойшоо холхисны эцэст намрын эхэн цаснаар сая өмнө зүг бүгдээр ниссэнээ саналаа.

Өвөлжин өл хоолгүй, амар тайван амсхийх аятай оронгүй, үргэлж ийш тийшээ хөөгдөж байсны харгаагаар арьс, яс болтлоо эцэж цуцсан учир их говийг, туулахад үнэхээр хэцүү байлаа. Гэвч төрсөн нутгийнхаа захыг эрхбиш үзээд ойчно гэж жигүүрийн хүчээ хөвчлөн зүтгэсний ачаар санасандаа хүрч номин хөхийн говьд орж чадлаа. Тэгээд бяцхан цайдмын эрэгт буув. Тэнд баахан зуур амсхийгээд хөдлөх гэсэн нь хөл нь хөх шаварт шигдчихсэн байв. Хөхүүл хөх шавартай тэмцэлдэж хүч чадлаа барсны эцэст улам ундаасан өлсөж, ядралын туйлд хүрч үхлээ хүлээж байтал нь морьтой хоёр хүн айсуй. Тэд нараас зугтан амь гарах арга алга, дэмий л хүзүү дохин мөргөж хэвтэв.

Тэр хүмүүс мориноос буун ойртож ирээд харж зогссоныхоо дараа, тэднийг шавраас гаргаж, хуурай дэнж дээр тавиад давхин одсон билээ. Энэ нэгэн учралыг санахдаа, өндөг байхаас эхлэн өсөж бойжсон өлгий нутгийнхан

шиг ивээлтэй сайн хүмүүс хаана ч байдаггүй юм байна. Гэмгүй биднийг хорлох хүсэлтэй хүн Монгол нутагт л лав байхгүй. Харин ижлийн минь жигүүрийг гэмтээсэн тэр этгээд эндүүрэн буудсанаас зайлахгүй. Хэвтээ хөх тогорууг ургаа хөх чулуу гэж ташааран харж болох юм.

Хүний хараа тогорууныхаас муу учир давхар шилэн нүд хийдэг байх нь л дээ.

Иймээс хэрэв хүн ойр үзэгдвэл их зан гарган хэвтэж өнгөрүүлэх нь хүндэтгэлгүй хэрэг болох нь, даруйхан босож олонтоо бөхөсхийн амрыг нь эрж, тогоруу гэдгээ таниулах нь чухал юм гэх зэргээр урьдах, хойтох элдвийг бодон хэвтгэл нь тэнгэрийн зүйдэл эргэж, огторгуйн од мичид ов тов болон харагдах нь үүр цайхын эхний тэмдэг байв.

Үүрийн туяа татавч наран цухуйхгүй удах нь Монгол орны баялгийн далай Орхоны их хөндийн тэнүүн цэлгэрийг хөндлөн гулд гийгүүлэхээс зүрхшээж байгаа мэт.

Удаж, удаж уулын оройд улаан наран сая нэг тусаж, өвчтэй ханиа өөрийн биеэр жигнэн дулаацуулж хэвтэх хөөрхий амьтны хүслийг хангав. Энэ тогоруу эрүүл боловч сэтгэлийн шархтай, ижлийнхээ төлөө элэг эмтэрнэ. Шөнө ч шанална. Өдөр ч шанална. Гэвч зовлонг минь нар, уул, цэцэг хуваалцах болов уу гэсэн шиг гэрэлт өдрийг хүсэн хүлээжээ.

Урьд адил цэлмэг өдөр болов. Наран нэлээд дээр гарах үес, хүнд биетэй том амьтны хөлийн чимээ ойрхон сонстож нисэхийн зав өгөлгүй нэг юм дэргэд нь ирэхийг ажиглавал: Хуучивтар хөх тэрлэгнийхээ хормойг шуусан, томдуу гуталтай, толгой нүцгэн, дэрчгэр чихтэй дүрсгүй янзын боловч сэргэлэн хурц нүдтэй нэгэн хүүхэд ажээ. Түүний барьж яваа шилбүүрийг үзмэгцээ өнөөх тогоруу ухасхийн босож, хэдэн алхмын цаана зайлан очоод олонтоо бөхөсхийх нь хоньчны мэндийг асуун, хутаг өршөөл гуйж байгаа мэт.

Өнчин өрөөсөн, үгээгүү ядуу, өлбөрсөн ядарсан бүхнийг өрөвдөж үздэг, тэтгэж тэнхрүүлдэг угийн удам сайтай малчин ардын хүү хоньчин хүүхэд тэр шархтай тогорууг нэрвэхийг огтхон ч бодсонгүй. Харин явал түүнийг бүтэн далавчтай болгож, нисэх чадал олгох аргыг сүвэгчлэхдээ хурганы хугарсан хөлийг рашааны шавраар эмнэж эдгэрүүлснээ гэнэт санав.

Дөрөв

Орхоны саруул хөндийд алтан тариа намилзан цэцэг дэлгэрсэн, эргэх улирал ээлжит намрын нэгэн өдөр байлаа.

Танан цагаан хонин сүрэг шаргалтан харагдах ухааг бүрхжээ. Сүргийн дэргэдээс хоньчин хүүхэд холын барааг саравчилна. Түүний хурц нүдэнд хярын оройн адуу, голын захын үхэр, цайдмын хөндийд бэлчээрлэх тэмээд, цаадах давааг өшсөх морьтой хүмүүс илхэн харагдана.

Түүний сонор чихэнд Номтын хөтлийн цаанаас машины чимээ, Номгоны талын дундаас тракторын дуу хүнгэнэх нь тодхон сонстоно.

Хонь, бэлчээрийн хязгаарт хүрч тогтоход хоньчин хүүхэд чулуугаар хот гэр барьж тоглов. Эхлээд өөрийн, дараагаар нь өвгөн аавынх, эцэст нь ахын гэж гурван гэрийн буйрыг өнгийн сайхан чулуугаар өрөв. Тэдгээрийн дунд хонины хашааг ногоон цахиураар дүгрэглэн барив. Өөрийн гэр болгож хүрмэн чулуугаар зассан хүрээний хойморт хадан цагааны хэсгийг тавиад “Энэ авдар” түүний дээр хүрэн гантигны хэлтэрхийг өрөөд “Энэ хүлээн авагч” гэж өөрөө

өөртэйгөө ярилцаар ор дэр, аяганы шүүгээ, айргийн хөхүүр, тулга, тогоо зэрэг гэр доторх эд хогшлоо цөмийг янз бүрийн чулуугаар дүрслэн байрлуулав. Энэ мэтчилэн бусад гэрүүдийн дотоод засал, гүүн зэл, морины уяа зэргийг зүг чиг тоо байгаар нь бүрэн дүрслээд, эхэлсэн ажлаа дуусаж санаа амарсан байдалтай цэлмэг өдрийн цэвэр агаарыг цээж дүүрэн амьсгаалж сууна, босно, эргэн тойрныг ажиглана. Хөх огторгуйн мандал өндөрт мянга, түм, сая бээрийн хол газар сая саяын цаадах тоогоор хэмжигдэх алс цэнхэрлэн хараа булаах нь хоньчин хүүхдийн ирээдүйг зөгнөх сониуч оюунт огторгуйн нисэгч Гагарины аяллыг санагдуулна. Бас одон гарагт чухам хэзээ очих болоо гэж бодохын хамт сургууль эхлэх цаг ойртсоныг санаж сэтгэл баярлана.

Намрын бэлчээрийн соргог ногоонд ирсэн учир хонь нь тогтвортой ажээ. Гагцхүү зүгийн муугаас урьж үлээсэн зэвүүн салхитай, үүл бөөн бөөнөөр хойшоо нүүх нь ойрын өдрүүдэд хур орохын тэмдэг цас ч орж магад. Энэ нутагт намрын сарууд өнтэй тарган. Намар удтал үргэлжилдэг боловч тэнгэрийг итгэхэд хэцүү, урьж салхилсны эцэст хүйтэн бороо заримдаа цас ч хаях нь тохиолдоно.

Ойрхон газар, хоньчны бүр дэргэд гэнэт тогоруу дуугарав тогоруу ингэвэл тэнгэр яахыг зөгнөв гэдэг билээ, орохыг уу? аль цэлмэхийг үү? гэж бодсоор хоньчин хүүхэд өндийн харвал хоёр хөх тогоруу явгалан гүйж, тэд нарын хойноос сүүлээ хавчиж, амаа ангайн, шүлсээ гойжуулсан муухайгаас муухай нэвсгэр даахитай хөглөгөр хөх чоно харайж явах ажээ. Тогтуун байсан хоньд үргэж хуйлрах чимээгээр чоно тэр зүг ухасхийтэл өнөө хоёр тогоруу яаран нисэж өмнө нь буугаад араатны анхаарлыг өөрсөд тийшээ хандуулав. Чонын хөөж гүйцэх үес нисэн холдоно. Ингэсээр яваад тэр хоёр өнөөх муухай чоныг дагуулан холдуулж далд оруулав.

Хос тогорууны нэгний далавчийн байдал, тэмдгээр саяхан эмчилж эдгээгээд ижилдэн нийлүүлсэн тогоруу маань мөн гэж хоньчин хүүхэд таньсан бөгөөд гэртээ ирэхэд нь тогоруу хөөж явсан галзуу чоно Лүн толгойн ард саяхан хороогдсон тухай мэдээг тэндээс ирсэн нэгэн хүн ярьж суув.

Эргэх улирлын нэг ээлжит намрын туйл боллоо. Аялуун сайхан намрын аясын зөөлөн салхинд, алтан тарианы залаа ахин намилзан хийсэв. Орхоны саруул хөндийд давалгаалан долгиолсон ургацын баян далай дээгүүр нисэн өнгөрч буй жигүүртний сүргээс хос тогоруу цойлон гарч, өндөр огторгуйн гүнд удтал элин хальж, эргэн тойрон нисэх нь эх нутгаас салж ядсаны тэмдэг ажээ. Тэр хоёр цөөрмийн эрэгт, тариан талбайд, төрсөн дэнж дээрээ дахин дахин бууж өдөр хоногоор удаж түдсээр нүүдлийн шувуудын хамгийн сүүлд өмнө зүгийг барьж нисэхдээ өвлийн хүйтнийг өнгөрүүлээд үүрд энхийн орон, баян дэлгэр нутагтаа бас л дахиад ирье.

Энэрлийн далай болсон эх Монгол газрын маань сүр сүлд нь улам бадарч сүү шиг цагаан сэтгэлтний хийморь цог заль нь улам мандаг гэж ерөөлийн дуугаа дуулснаас үзвэл ухвар мөчид буюу нүдний хараа муутай ганц нэг анчны алдаа гэмийг ойлгож мэдсэн нь зайлшгүй.

Цаг цагаар, цахилдаг хөхөөр байдаггүй, эргэх улирлын ээжит хавар дахин ирлээ. Довын энгэрт шар цэцэг цухуйх үес нүүдлийн шувуудын түрүү ч нь үзэгдэвч тэдний дунд, дэрчгэр чихт хүүхдийн хуучин танилууд байсангүй. Хамгаас түрүүнд ирэх ёстой. Тэр хоёр тогоруунд чухам ямар саад учирсныг

бүү мэд. Ямарч саад тотгортой тааралдаж болох алсын газар одсон билээ. Хэрэв замдаа эцэж цуцаад ойчиход хүрвэл тэд нарт хэн нэгэн туслах болов уу?

Чухам хаана газардсанаас хамаг хэрэг шийдэгдэх буй за.

1968 он Улаанбаатар

Асууулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Зохиолын уран дүр, дүрслэлийн онцлогийг тайлбарлан бичнэ үү?
3. Зохиолд зохиомжийн задлал хийнэ үү?

Номын сангийн ном

3. Түмэнжаргал

Бяцхан Төгсжаргал багачуудын зусланд очиж амрахаар маргааш явах болсондоо сэтгэл нь хачин их догдолж “олон шинэ танилуудтай болно. Хуучин найз нартайгаа уулзаж, хичээл сургуульдаа ямар дүнтэй суралцсанаа ярилцана” гэж санахаас зуслангийн **гэндэх** гоёмсог сайхан байгалийн үзмэр дотно танил байшингууд нүдэнд нь харагдах шиг болж байлаа.

Тэнд үеийн олон нөхөдтэйгөө нэг сар хамт байж амран цэнгэж, тоглон наадна гэдэг чинь юутай сайхан бэ?

Эцэг, эхийн адил асрамжилдаг зуслангийн үйлчлэгч хүмүүс ялангуяа сайхан хоол хийдэг шигээ мөн” сайхан дуулдаг тогооч авгай юу юунаас илүү дотно бодогдож байлаа. Төгсжаргал авч явах юм хумаа жин тан болгосон боловч нэгэн зүйл дутуу байлаа. Тэр нь чухам юу вэ гэвэл авч явах номууд нь байжээ. Аяныхаа хайрцгийг нээж, хувцас хунар ариун цэврийн хэрэглэлээ хийгээд үлдсэн зайд нь номуудаа хийхээр номын сангийнхаа шүүгээг онгойлготол ярайтал өрсөн номууд нь өмнөөс нь тосон харагдаж байна. Шилэн дээрээ нэртэй номууд нь ч яах вэ ямар ном болох нь таньж болохоор байж тиймгүй, номуудаа цөмий нь гаргаж үзэхээс биш болохгүй бэрхшээлтэй байлаа.

Хэвлэх үйлдвэр ном болгоныг ялангуяа зузаан номуудыг шилэн дээрээ нэртэй хавтаслаж баймаар юмдаа гэж бодоод номоо нэг нэгээр нь гаргаж нэрий нь үзэж эхлэв.

Өнгөрсөн үдэш эцэг, эхийн хуралд суугаад ирсэн эх нь Төгсжаргалыгаа энэ жил 3-р ангийг онц дүнтэй төгсөж 4 дүгээр ангид дэвшин суралцах болсонд нь баярлаад хүүдээ бэлэг болгож өгсөн 4 дүгээр ангид үзэх сурах бичгүүдээс бусад энэ шүүгээнд байгаа ном болгоныг хоёроос доошгүй уншсан болохоор тэр номууд түүнд цөм дотно танил болсон байлаа. Номоо онгичиж байтал “Алтан гургалдай” гэдэг жижиг ном дайралдав. Түүний хуудсуудыг санамсаргүй эргүүлтэл “Үүрийн туяа нэгдлийн номын сан” гэсэн гурвалжин тэмдэг дарсан нь тодхон харагдлаа. Төгсжаргал тэр номоо чанга атгачиж чулуун хөшөө шиг хөдлөхгүй зогсов. Түүнийг хоёр жилийн өмнө аавыгаа нэгдэлд ажилтай байх үед нэгдлийн дэргэдэх сургуулийн нэгдүгээр ангид суралцаж байхдаа номын сангаас авч үзэж байгаад эргүүлж өгсөнгүй мартаж өнгөрсөн хэрэг байжээ.

Номын сангийн ном одоо яадаг билээ. Ийм муухай юм байх гэж гэмшээд номын үнийг үзэв. Далан мөнгөний үнэтэй ном байлаа. Өнгөрсөн хоёр жил энэ номыг хэчнээн олон хүн унших ёстой байсан билээ гэж бодоод

санаа алдав. Та нар улс олон нийтийнхээ ганц мөнгийг ч хайрладат хүмүүс болон хүмүүжих ёстой гэж үргэлж сануулж байдаг эмэгтэй багш Сарантуяа нүдэнд нь харагдах шиг боллоо. Өөрийгөө бодохоос илүү нөхдийгөө хайрладаг байх хэрэгтэй гэж ээж нь үргэлж сануулдаг байжээ. Ноднин жил нэг хүн Төгсжаргалын ирээд аавтай нь элдвийг ярилцаж байгаад:

Ном хулгай хийхэд ямар ч хууль байхгүй гэхэд аав нь:

Тэр чинь юу гэсэц үг вэ? ном бол арынхаа хуудсан дээр заавал ямар нэгэн үнийн тоотой байдаг. Тэр бол уг Номын үнэ нь юм. Тэгэхээр ном хулгай хийсэн хүн гэдэг нэгдүгээрт үнэ бүхий зүйлийг хулгайлж хоёрдугаарт хүмүүсийн боловсролд хор саадыг учруулж байгаа гэмт хэрэг юм. Миний бодоход ер нь тэр талаар эрүүгийн хуульд тусгай нэгэн зүйл болгон оруулбал таарна гэж хэлж байсан нь санагдав.

Би хэдийгээр хулгай хийгээгүй боловч мөн л адил төсөөтэй хэрэг хийжээ гэж бодохоос тэсэж сууж байж болшгүй болов. Тэгээд номоо барьсан чигээр явж цонхны дэргэд очиж хэсэг зогссоноо сандал дээр очиж лаг хийтэл суугаад шанаагаа тулж нүсэр хүнд бодолд дарагдав. За одоо яавал таарах вэ гэж бодсоор л байлаа. “Үүрийн туяа” нэгдэл рүү шалавхан очиж түмэн буруугаа хүлээж номын сангийн энэ номы нь өгөхөөс нааш сэтгэл нь ер яасан ч гэсэн амрахгүй... Тэгвэл маргааш зусланд явахыгаа яадаг билээ гэж бодов.

Төгсжаргал энэ явдлаа аавдаа яасан ч гэсэн элж болохгүй гэж бодов. Аавдаа алдаагаа хэлэхэд нь сүйд болтол загнадаг байжээ. Харин ээж нь бол тийм биш, харин нуувал загнадаг байжээ. Бага байхдаа осолдоод нэг шаазан ваар хагалсныгаа аавдаа үнэнээр нь хэлсэн чинь зөндөө загнажээ. Тэгэхээр нь болдоггүй юм байх гэж бодоод ээжээсээ нуусан чинь бүр сүйд болтол загнуулжээ. Түүнээс хойш юмыг ааваасаа нууж ээждээ бүгдий нь ярьдаг болжээ. Тэгвэл одоо аавдаа юу гэж хэлэх вэ? “Үүрийн туяа” нэгдэлд ажилтай байдаг өвөг аав, эмэг ээж хоёртоо айлчлан очъё, зусланд очихыгоо дараагийн сард болгуулъя гэж хэлэхээр шийдэхдээ ааваасаа бусад хүмүүст ээждээ, багшдаа ялангуяа нөхдөдөө хамаг үнэнээ хэлж сэтгэлдээ сэвгүй болохоос нааш санаа нь бас л амаршгүй санагдаж байлаа. Тэгээд ээжийнхээ ажлын газар очихоор явахдаа нөгөө номоо барьсан чигээр бараг гүйх шахам явж байлаа.

“Үүрийн туяа” нэгдэл тийш хурдлан яваа ачааны машинд суусан арваад хүний дунд сууж яваа бяцхан Төгсжаргал зүй нь өнөөдөр зусланд очихоор явж байх байсан ажээ. Гэтэл тийм биш, нэгдэл рүү явж байна. Тэгж явахдаа зуслангийн тухай ч бодохгүй аавдаа худал хэлж ээж багш хоёртоо хамаг учраа үнэнээр нь ярьсныгаа ч санахгүй, замын хажууд чухам юу юу өнгөрч байгааг ч анзаарахгүй ганцхан нөгөө авч яваа номын сангийн номоо, түүний тухай хамаг буруугаа яаж хүлээвэл зохих тухай бодоод тэнгэрийн хаяа ширтэн явлаа. Хамт яваа хүмүүс:

Хүү минь чи өвөг аав, эмэг ээж хоёртойгоо уулзахаар явж байна уу даа? гэхэд Төгсжаргал: Тиймдээ гэж хэлэхдээ хэл нь ер нугарч өгөхгүй шахам байлаа. Тэгж явсаар нэлээд болсны дараа хэн нэгэн хүн “за нэгдэл маань харагдлаа” гэв. Хүмүүс өндөлзөв:

- Бид санаснаас овоо эрт ирлээ шүү.
- Зургаахан сар болоод ирэхэд яасан олон байшин нэмчихээ вэ?
- Тэр чинь үнээний байр...

- Тэр наагуур байгаа чинь шинээр нэмсэн ажилчдын байр.
- Тэр зүүн талын том цагаан байшин юуных вэ?
- Лувсан гуайнх хаана бол мэдэх үү? гэх зэргээр шуугилдав. Төгсжаргал бараг босох шахам өндийсөнд хүмүүс:

- Хүү минь ойчно, суу суу гэж ам амандаа хэлэв. Номын сангийн байшинг олж харах гэж чармайсан боловч танигдахаа больжээ.

Төгсжаргалын өвөг аав, эмэг ээж хоёр нь баярлан угтаж том болсны нь гайхалдан үнсэж таалав. Төгсжаргал яаран байж дөнгөж унд уугаад номын санд очихоор гүйн гүйсээр үүдэн дээр нь хүрээд амьсгаагаа дарах гэж оролдсон боловч хүлээж чадсангүй хаалгы нь тогшсонд номын сангийн эрхлэгч танил өвгөн Дугар гуайн баргиа бүдүүн дуу сонсогдохын оронд эмэгтэй хүн:

- За ор гэх нь дуулдав. Тасалгаанд орлоо. Өвгөн алга, ор танихгүй нэг эмэгтэй эзэн хүний ёсоор бичгийн ширээний ард суугаад ямар нэгэн зузаан ном уншиж байлаа.

Төгсжаргал мэндлээд ширээний өмнө хэсэг дуугүй зогсов. Тэр эмэгтэй хариу мэндэлсэн боловч уншиж байгаа номондоо ухаангүй татагдсан бололтой салж ядан үргэлжлүүлэн уншсаар байснаа өгүүлбэр дууссан газар хуруугаараа дараад:

- Хүү чи! ном унших гэж яваа бол хэрэгтэй номоо захиалаад тэр уншлагын тасалгаанд орно уу! гэсэнд Төгсжаргал:

- Үгүй ээ! Би энэ номын санд ажиллаж байсан өвгөн Дугар гуайтай уулзах хэрэгтэй яваа юмсан гэсэнд эмэгтэй гайхсан бололтой хэсэг харж байснаа:

- Тэр хүн одоо энд байхгүй гэсэнд Төгсжаргал
- Одоо хаа байгаа бол? Би яаралтай уулзах маш чухал хэрэгтэй яваа юмсан гэсэнд эмэгтэй:

- Чи хамаатан нь юм уу? гэж асуув. Төгсжаргал:
- Бишээ, би зүгээр өөртэй нь уулзах л хэрэгтэй юмсан гэсэнд эмэгтэй:
- Тэр хүн чинь нас бараад жил гаран болж байна гэсэнд Төгсжаргал хариу юу ч хэлж чадсангүй хэдэн давхар сонинд нандигнан боосон нөгөө “Алтан гургалдай” гэдэг номоо гаргаж өгөөд:

- Энэ ном... би... танай... тэр хүн... гэж хэлээд өөр юу ч хэлэлгүй, эргэж ч харалгүй шууд гараад явчлаа. Номын сангийн эрхлэгч эмэгтэй юу ч асууж завдсангүй аль ч учры нь ололгүй номоо гартаа бариад дэмий гайхан хоцорлоо.

- Төгсжаргал сумын шуудангийн газраас урамгүйхэн алхаж явав. Энэ нь нэгдлийн төвд ирээд энэ өдөр арван гурав дахь хоногоо өнгөрүүлж байгаа хэрэг ажээ. Шуудан ирэх болгонд л пионерын сонин ирэх л юм, гэвч миний бичсэн зүйл яагаад ирдэггүй юм бол гэж цухалдан бодсоор явж байна. Эмэг ээж, өвөг аав хоёр нь ач хүүгээ аль болох сайхнаар л амруулахыг хичээдэг боловч тэр нь шуудан ирэхийн чимээнээр ухаан жолоогүй гүйдэг, өдөр болгон удтал юм бодон ганцаараа суудаг болсны нь үзээд өвгөн эмгэн хоёрын сэтгэл ихэд зовниж янз янзаар оролдоод ач хүүгээ тайтгаруулан авч чадсангүй байжээ.

- Тэр шуудан гэдэг нь хүссэн юмы нь аваад ирдэг болоосой гэдэг байжээ. Төгсжаргалыг явж байтал номын сангийн эрхлэгч эмэгтэй маш сандрангуй байдалтай даллан дуудаж байгаа харагдлаа. Төгсжаргал юу болоо юм бол гэж бодсоор буцаж очлоо. Эмэгтэй сэтгэл нь маш догдлон:

- Дүү минь чамд баярыг хүргэе. Тун сая радиогоор чиний бичсэн зүйлийг нэвтрүүлэв. Чи тун их сайхан бичсэн байна шүү. Түүнийг сонсоход манай номын сан, талийгаач өвгөн Дугар гуай цөм нүдэнд харагдах шиг хачин сайхан санагдлаа. Ялангуяа чиний ариун журамтайд чинь хязгааргүй их баярлав. Манай багачууд, цөм л ийм үнэнч байгаасай. Чамд баярлалаа! гэж хэлээд баяртайгаар гары нь барив.

- Эгч ээ! Харин миний төлөө сэтгэл зовж байсан танд би хэмжээ хязгааргүй баярлалаа. Надад хүн баярлах юм алга гэж под хийтэл том хүн шиг хэлээд өвөг аав, эмэг ээж хоёр дээрээ очихоор жаргаж байгаа нарны туяан дор гүйх шахам явж байгаа Төгсжаргал ямар нэгэн хүнд юм үүрч явснаа авч орхисон шиг сэтгэл нь амарч дотор нь онгойгоод алсад байгаа аав, ээж хоёроо санаж хүслэн болсон багачуудын зуслангаа гуйлгүй мөрөөдөж байгаагаа сая мэдлээ.

Цэцэрлэг хот 1956 он

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураингуйлан бичнэ үү?
2. Зохиолын агуулгын ач холбогдлыг тайлбарлана уу?
3. Зохиолыг уншаад хүүхдийн сайн, муу чанарыг илэрхийлсэн эсээ бинэ үү? /үгийн тоо 250 хүртэл/

Голын жараахай

3. Түмэнжаргал

Нэг удаа би хаяандаа суугаад Сонинхангай уулыг харж байлаа. Цэлмэг сайхан өдөр гэрийнхээ сүүдэрт адасга дэвсчхээд дээр нь хөл нүцгэн сууж, цэцгийн үнэртэй агаар залгилан уул харж байна гэдэг ямар сайхан гэж санана. Яг тэгж байтал манай айлын Тулгаа хүрээд ирлээ. Тэр:

- Чи юу хийж байгаа юм бэ? гэж асуув. Би:
- Уул харж байна гэлээ.
- Өө хөө, уул хараад яадаг юм бэ?
- Сайхан л байдаг юм даа.
- Тулгаа миний хажууд сууж,
- Хүүш, би чамд нэг гоё юм үзүүлэх үү?
- Юу юм бэ?
- Ёстой нэг гоё юм ... гэсээр босон гүйж гэрээсээ жимсний шилтэй юм аваад ирлээ. Ус. Усан дотор гурван хөөрхөн жараахай байна.
- Чи үүнийг хаанаас олсон юм?
- Урд голоос барьсан юм.
- Яах нь вэ?
- Тэжээхгүй юу?
- Болдоггүй юм аа: ...
- Болдог юм мэдэв үү? Түдэвдорж ахынд зөндөө олон жараахай бий.

- Тэр чинь загас байхгүй юу? жижигхэн загас. Москвагаас авч ирдэг юм. Шилэн хоргонд байх ёстой амьтан. Энэ чинь Нүдэнгийн голд л амьдарна. Гэрт болохгүй.

- Худлаа
- Нээрээн

Тулгаа гомдоод надаас дөлж суув. Бид хоёрын дунд, жимсний шилэн дотор гурван алтанхан жараахай цовхчино... . Би жаахан бодож байгаад,

- Чи үүнийгээ надад өгчих гэв. Тулгаа:
- Чи яах нь вэ? гэж асуулаа.
- Хэрэг байна. Чи өгчих л дөө. Би чамд оронд нэг хар чавга, хоёр боорцог өгье.
- Хар чавга, жараахай хоёр тэнцэнэ гэж бодож байна уу?
- За яахав, будгийн харандаагаа өгье. Бүр өгнө шүү. Тэгэх үү? Тэр жаахан бодолхийлснээ,
- Болох л юм гэлээ. Харин чи энэ гурван жараахайг яг хаанаас барьснаа заагаад өгчих
- Чи дахиад нэмж баримаар байна уу?
- Юу ч л гэсэн заагаад өг...

Тулгаа бид хоёр Нүдэнгийн гол дээр очлоо. Тэр нэгэн чулууны ёроол руу хуруугаараа заан,

- “Яг л эндээс юм даа” гэж байна. Би тэр чулууны нь ёроол руу өнөөх шилтэй усыг хийчихлээ. Жараахайнууд алтран, гялтганан сэлж одов. Тулгаа ухасхийн усанд гараа дүрснээ уйлаа. Бас,

- Чи яагаад жараахайг тавьчхав аа? гэж үглэнэ. Би юу ч ярих билээ дээ. Ус руу л жараахайнуудын араас харж зогслоо. Удаан харав. Гурван жараахай үзэгдэхгүй болжээ... Тулгаа маань аяархан санаа алдав.

Тэгээд бид хоёр дуу шуу ч үгүй, гэр лүүгээ явлаа. Би юу ч ярих билээ дээ. Энэ чинь сургуульд ороогүй жаахан хүүхэд шүү дээ. Одоо ч нулимс нь хатаагүй л явна. Хөөрхий минь жараахайны хойноос харамсаж л байгаа гэж би бодов. Нэлээн явсан хойно. Тулгаа:

Отгон оо. Чи жараахайнуудыг яагаад заавал тэр чулууны тэнд тавьж байгаа юм бэ? гэж асуулаа. Би,

- “Тэр нь тэр хавьд л байдаг байлгүй. Өөр газар тавьчихвал төөрнө шүү дээ” гэлээ.
- Бид явсаар хаяандаа ирэв. Тулгаа:
- За яахав, жарайхайнууд нээрэн гэртээ хариг. Тийм ээ. Би чамаас будгийн харандаагий чинь авахаа больё доо ... гэж аяархан хэллээ.

Асуулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Зохиолын агуулгын ач холбогдлын тайлбарлан бичнэ үү?
3. Тулга, Отгон нарын дүрийг харьцуулан бичнэ үү?

Бордоотой бороо
(Уран зөгнөлт өгүүллэг)

С. Надмид

Мандах, ахаасаа ирсэн захидлыг ангийнхаа найз нарын дунд санамсаргүй задалсны улмаас бараг жил шахжээ. Ахынх нь захидал ердөө ганц өгүүлбэр тэгэхдээ дэндүү томоор бичигдсэн болохоор тойрон зогссон хүүхдүүд дор нь гүйлгэн уншиж амжсан аж.

- Юу вэ? Юун бордоотой бороо вэ? Алив, яриач? гэж Мандахын тал, талаас гайхсан харцнууд шалж гарав. Тэр хэрхэн хариулахаа сэдэхгүй, хэсэг зогссоноо нэг мэргэн арга олжээ. Тэгээд халаасандаа хумхин хийсэн захидлаа гаргаж, өөрөө учрыг олоогүй байгаа дүр үзүүлэн, хоёр алаг нүдээр эргэлдүүлж “Миний дүү энэ зун ахындаа ирж, нөгөө бордоотой борооныхоо учрыг олоорой” хэмээн бүр өндөр дуугаар уншив.

- Яриад өгөөч дээ?

- Би яаж мэдэх вэ

- Яагаад мэдэхгүй гэж?

- Нууц нь олдоогүй юм байна шүү дээ гэж Мандах тайван өгүүлэв. Чингэтэл ч хонх дуугарч, хичээлдээ орох боллоо.

Энэ нэг удаагийн хичээл дээр Мандах өнгөрсөн зуныхаа амралтаар үзэж, харсан бүхнийг ил тод дүрслэн боджээ.

1

- Анхаараарай! “Их-Уул” нэгдлийн радио станцаас ярьж байна. Ирэх бямба гаргийн... цагт, тус нэгдлийн... хөндий дагуу хүчтэй мөндөр хаяна. Хүйтэн бороо, хүчтэй мөндрөөс урьдчилан сэргийлэх төхөөрөмжөө бэлэн байлгахыг сануулъя!

Мандахыг хагас дутуу зүүрмэглэж байх хооронд энэ мэдээг нэвтрүүлсэн учир цөмийг сонсож чадсангүй. Гэлээ ч нойр нь нэгмөсөн хулжжээ.

Маргааш өглөө нь ахыгаа хоргоож:

- Мөндөр хэзээ, хаана орох юм бэ? гэж асуусанд ах нь:

- Бямба гарагт Ээрэмийн хөндий дагуу гэж хариулаад гарч одов.

Ах нь тус нэгдлийн агрономич юм.

Мандах мөндрийн тухай үерхдэг хүүхдүүдээсээ асууж лавтай мэдэхээр гадагш гарлаа.

2

Бямба гаргийн өглөө нэгдлийн хүүхдүүдийн хүсэлтээр “Их-Уул”-ын радио станцаас мөндөр буух цаг мөчийг зарласан боловч хүүхдүүд аль хэдийнээ тус бүрийн сууцны тагт буюу өндөрлөг газар гарцгаасан байв.

Тэдний зарим нь “Пуужинт толгой” тийш, зарим нь умар зүгийн тэнгэрийн хаяа ширтэн хэсэг бөөн цагаан үүлний дөхөн ирэхийг тэсэж ядан хүлээж байлаа.

Энэ өдөр тэнгэр цэлмэг, салхи намдуухан байсан болохоор үүл хэтэрхий удаан, бас арвигүй жаахан шиг санагдана. Гэвч удсангүй, үүл дөглөн, ойртох бүрий хормой бие нь харлаж, өөр дотроо үймэн, сүрдмээр их сүр бараатай болоод ирлээ.

Хүүхдүүдийн шуугиан нэг үе нам жимхэн болов. Салхи, догшин аадрын өмнөх мөчид басхүү гайхалтай намдах нь нэгийг баярлан хүлээцгээх хүүхдүүдийн зүрхний цохиог чагнах мэт бөлгөө. Тэгтэл “Пуужинт толгой” гэж нэрлэгддэг, ойролцоох модот өндөрлөг дээрээс гал, утаа манасхийн, газар

дэлхий донслон их дуун гарч, эхний пуужин үүлний эгц элгэн бие рүү цойлон одох нь тэр. Үүл бут цохиулах мэт хачин их үймэрч, цэвцгэр цагаан мөндрийн голомт зад үсрэх шиг боллоо.

Хүүхдүүд ура хашхиралдана.

- Хоёр дахь пуу-жин !

- Гурав дахь нь! Ура!

- Ямар гоё вэ?

Тэр зуур хүүхдүүд “Энэ удаагийнх шиг олон пуужин урьд өмнө харваагүй” гэлцэх бөгөөд анх үзэж буй хотын хүү Мандах учрыг шалгаасанд:

- Мөндрийн голомт олон байсан хэрэг гэгцгээв.

Үнэндээ тийм бус байлаа. Нууц хадгалах талаараа хамгийн мууд тооцогддог хүүхдүүд байтугай, нэгдлийн настан хашрууд ч олон пуужингийн учрыг мэдээгүй бөгөөд тоолбол хоёр гуравхан хүний тархинд, тэгэхдээ хамгийн нууц нугалаасанд нь төвлөрсөн зүйл байжээ.

3

Мандахыг гэртээ гүйн ирэхэд ах нь нэгдлийн даргатай хамт Ээрэмийн хөндий тийш явахаар завдаж байлаа. Аз болоход тэд, Мандахыг машиндаа суусныг анзаарсангүй юм уу, явбал яваг гэсэн юм уу, юу ч хэлсэнгүй.

Ээрэмийн хөндий бол идэшний ногооны их талбай бөгөөд мөндөр буух ёстой зурвас гэдгийг Мандах сайн мэдэж байв.

Тэд, хурд мэдэн давхисны хүчээр үүл нөмрөн ирэхээс урьтаж, мөнөөхөн талбайн захад хүрч ирэв. Ирэх замдаа Мандахын ах, нэгдлийн дарга хоёр “Саруул тал” нэгдлээс уралдаанаа заавал авах тухай ярилцаж байснаа, чухам үл ойлгогдох нэг зүйлийг хүүрнэлдсэн нь.

- Мөндөр бутлагч пуужинг ашиглаж, үүлэнд бордоо цацсан туршлага хаа ч гараагүй

- Тиймээ. Бордоо маань борооны дусал бүрд шингээд, удахгүй эргэж, эх газартаа жигдээр буух болно. Сонин санаа шүү!

- Саруул талынхнаас урьтаж санасан минь их хожлоо. Ингэхэд ногоо маань иш навчаараа ялигүй бордоо аваад орхивол овоо ургац өгмөөр байгаа юм...

Мандах, мөндөр бутлагч ерийн пуужин бус, бордоотой пуужин харвасан болохыг дээрх ярианаас ойлгожээ.

Тэднийг талбайн захад хүрсэн хойно нэг их удаагүй байтал борооны хар үүл Ээрэмийн хөндий дээгүүр нүүгэлтэн ирэв.

Мандахын ах, дарга хоёр машинаас гарч нэлээд холдон явснаа байн байн дээш харж алгаа тосон ямар нэгэн юм ярилцах бололтой гараа зангах нь харагдана.

Мандах “Мөндөр хайлаад сайхан дулаан зүс болж ордог” гэж хүүхдүүдийн хэлснийг бодон, зөвхөн бороо орохыг хүлээж машин дотроо суусаар байтал, үүлний ихэнх Ээрэмийн хөндийн идэшний ногооны тайлбайгаас хэтэрч, холгүй орших урд уулын арыг барин цайрч эхэллээ.

Мандах, машинаас үсрэн гарч ах, нэгдлийн дарга хоёр дээр гүйн ирвэл, тэдний царай хачин баргар байх агаад өнгөрч хөллөсөн борооны хойноос ширтсээр байв.

- Хайран бодоо!

- “Саруул талынхны” талбайд аваачаад хаячихлаа.

Мандах энэ яриаг сонссод “Саруул тал” гэдэг чинь нөгөө уралдаантай нэгдэл нь шүү дээ гэж бодов

4

Тэд, Ээрэмийн хөндийгөөс бараг хурд саалгүй “Пуужинт толгой” дээр давхин ирэв.

Нэгдлийн дарга замдаа “техникт эрхээ мэдүүлэгсэд! Алив, цаг уурыг хазаарлаж, дуртай зүгтээ залах чадал бий гэж тэдний ярьдаг нь хаа байна” гэхчилэн хязгааргүй бухимдан үглэж, Мандахын ах руу байн байн хялалзан явжээ.

Дарга, лагс том биеэрээ хачин эвгүй харайн буув. Даргыг угтагсад, аавынхаа өмнө буруутай хэрэг хийсэн хүүхэд шиг таг дуугүй зогсоцгооно. Эднийг нэгдлийн дарга лав загнах биз хэмээн Мандах бодож байлаа. Тэдгээр хүмүүсийн дотор хүүхдүүдийн ярианаас сайн мэдэх болсон цаг уурын шинжээч эмэгтэй, пуужингийн ахлах инженер нар харагдана.

Ахлах инженер:

- Даргад болох уу? Яг энэ үед салхины урсгалын хурд өөрчлөгдчихлөө. Нөгөө талаар бид мөндрийн бороожсоноос үүлний салхинд туугдах хурд хэрхэн өөрчлөгдөхийг нарийн тооцоолсонгүй

- Тооцоолсонгүй гэнэ шүү. Та нарын ганц найдвар болсон нөгөө локатор чинь яасан бэ?

- Локаторт гажиг орсон бол энэ ялигүй өөрчлөлтийг ч мэдэхгүй байсан. Бид зөвхөн түүний тусламжаар үүлний өндөр, салхины урсгалын хурдыг хэд дахин хэмжсэн билээ!

- Тэгээд?

- Тэгээд яах вэ дээ. Хожимдож орхилоо. Тогтоосон газраасаа 1,5 км-ээр хэтэрч, ихэнх бордоогоо “Саруул тал” нэгдлийн талбайд асгачихлаа

Дарга, нэгэнгээ цэлмэн гийсэн хөх огторгуйн гүн рүү хараа тавив. Түүний царайг үзэхүл хачин тайван болжээ.

“За яах вэ. Анхны туршилт бүхэн үр дүнтэй өнгөрдөггүй нь үнэн. Бордоотой борооны ид шидийг өөрийн талбайгаас үздэггүй юм гэхэд “Саруул талынхны” талбайгаас харах болно. Харамсалтай нь гагцхүү уралдаан байна даа” гэхчилэн бодож буйг Мандах яахин мэдэх билээ.

5

Мандахын хүслэн нэг талаар биелж, пуужин харвахыг харсан авч, тайлагдашгүй зүйл их үлджээ. Харин нэгдлийн бусад бүх хүүхдийн хувьд “Санаа амар” байлаа. Юу гэвэл тэд “мөндөр буталсан” гэдэг анхныхаа төсөөллөөр л хязгаарлагдан үлджээ.

Харин Мандах учрыг бүрэн ойлгож эс чадах боловч эхээсээ элдвийг шохоорохон асуусаар “бороо Ээрэмийн хөндийд орно” гэсэн атлаа яагаад өнгөрч цайрсан, үүл рүү цацсан бордоо гэгч чухам юу олох, бордоотой борооноос хойш “Саруул тал”-ын талбай дахь ургац хэр байгаа” зэргийг мэдэж авчээ.

Ах нь ерийн нэгэн пуужингийн загвар зурж, мөндөрт үйлчлэгч бодисыг тайлбарлаад, тэрхүү бодисыг бордооны нимгэн давхраар хучсан тухайгаа, дотроо гашуун боловч гаднаа амтлаг үрлэн чихрээр жишээ болгон ярьж өгчээ.

Бас түүний хэлснээр “Саруул тал” нэгдлийнхэн бордоотой борооны учрыг одоо болтол тайлбарлаж чадаагүй байгаа бөгөөд хаа нэгэн газар томоохон агуулах хүчтэй салхинд эвдэрч, бордоо нь үүлнээ тарсан байх гэсэн таамаглалтай байгаа аж.

Борооны дараа ургац ер бусын ихэссэнд “Саруул тал” нэгдлийн дарга гайхахдаа өөрийн агрономич, хөрс шинжээч нараа дуудан хөрсний химийн найрлага, хүчиллэг чанарыг тодорхойлох яаралтай даалгавар өгсөн байна. Үүнд нэг сонин зүйл мэдэгдсэн нь хөрснөөс урьд өмнө тохиолдож байгаагүй бичил язгуур махбод олдсон, нөгөө талаар борооны уснаас тосон авч уушинд хэрэглэсэн нэг эмгэний биед таагүй байдал мэдэгдсэн зэргийг тогтоожээ.

Энэ бүгдийг Мандах мэдэж авсан авч ахынхаа хатуу сануулснаар хэнд ч үг алдсангүй билээ. Тэгтэл ч сургуульдаа буцах цаг болжээ.

6

Хичээл эхлээд сар илүү өнгөрөв. “Их-Уул” нэгдлийнхний зоригтой туршилт, “Саруул талынхны” санамсаргүй олзны тухай орон даяар шуугих байх гэсэн нь таг чиг,

Мандах арга буюу ахдаа захидал бичиж “Саруул тал”-ын ногооны талбайн ургац ямар байгаа, аль нэгдэл уралдаанаа авсан тухай асуусанд ашгүй хариу ирлээ.

Захидалд өгүүлсэн нь “... Манайх уралдаанаа алдчихсан. “Саруул тал” нэг га-гаас хоёр дахин илүү их хүнсний ногоо хурааж авсан боловч хохирол бас үзсэн. Тэдний зарим хөрс манайхтай адилгүй юм. Бороо дайран өнгөрсөн тэрхүү өөр чанартай хөрс бүхий талбайн ногоо нэлээд сүйджээ.

Юу ч атугай туршилт маань үр дүнтэй болохоо харууллаа. Энэ тухай хэнд ч бүү хэл! Шинжлэх ухааны алив оролдлого амьдралд нэвтрүүлэх найдвартай болтлоо нууц байдаг юм.

... Хойтон, түүний цаад жилээс бүгд илэрхий болно. Тэр цагт танай сургуулийн түмэн бодис зүйн танхимд, магадгүй аргийн чинээ байцай, дур булаам сайхан үнэр өнгөтэй, мухар тохой хэрийн урт улаан лууван, тарвас, өргөст хэмх тавигдаж болох биш үү?” гэжээ.

Мандах ахынхаа захидлыг хүлээн авснаас хойш “ургамлын судлал”, “хөрсний бүтэц, химийн найрлага”, бичил бордоо” гэхчилэн өдий төдий номыг хичээлээсээ гадуур уншсан боловч “бороо бордсон” тухайд юу ч олж үзсэнгүй. Харин ургамлыг иш навч зэрэг ил эрхтнээр нь шүрших замаар бордох арга, эхлээд газраа бордож, үндсээр нь тэжээхээс илүү ач холбогдолтой болохыг ойлгожээ. Гэлээ ч үл мэдэх зүйлч хэчнээн их байсныг өгүүлэх юун.

Ингэснээр хүү энэ өдөртэй золгожээ.

7

Мандах хүү эдүгээ Улаанбаатар хотын нэгэн арван жилийн дунд сургуулийн ... дугаар ангид сурч байгаа бөгөөд нийслэлийн дээгүүр умраас өмнө зүг нүүдэллэн өнгөрөх үүлсийг харах бүрийд сайхан эх орны маань газрын зураг дээр шаргалтан байдаг хязгааргүй их говь, тал нутаг дүрслэгддэг болжээ.

Ах шигээ агрономич, эсвэл мөндөрт бутлагч пуужингийн инженер болоод тэнэмэл зэрлэг үүлсийг эрхэндээ оруулсан ус, ургамал ховор урд

зүгийн эх нутагтаа хангайн хар хүрэн “хөрсийг” үүлний тусламжтайгаар нүүлгэн аваачих урнаас уран санаа түүнд үе үе төрнө.

Өгүүлэхэд Мандах, ахынхаа хүссэнээр энэ зун “Их-уул” нэгдэлд лав очиж амарна биз ээ!

1965 он

Асуулт, даалгавар:

4. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хурайнгуйлан бичнэ үү?
5. Зохиолын туурвил зүйн онцлогийг тайлбарлана уу?
6. Уран зөгнөлт зохиол, түүний ач холбогдлыг тайлбарлана уу?
Уран зөгнөлт зохиол, уран сайхны өгүүллэгийн ижил ба төсөөтэй талыг 3. Түмэнжаргалын “Голын жараахай” зохиолтой харьцуулан тодорхойлон бичнэ үү?

Шарга даага

О. Сундуй

Зулзаган ногоо дэлгэрсэн зуны эхэн сарын нэгэн үдэш. Унаган дэлтэй шарга даага ганц нэг өвс хазлан, үе үе холын бараа харж сортолзон ижил сүргээсээ захиална. Хур дэлтэй шарга гүү бөн бөн шогшсоор ирж шарга даагаа аргадах мэт үнэрлэн, аашлан зөвлөх лугаа хулмалзана. Дэл сүүл нь намирч үснийх нь сор гялталзсан өндөр хар азарга хангинатал үүрсэн давхиж ирээд хулмайн довтолж шарга гүүг сүргийн зүг элдэнэ.

Одод түгж, сар манджээ. Эхийгээ бараадан идээшилж асан шарга даага шөнө дөлөөр хэзээ ч очиж үзээгүй атлаа очихыг хүсэн зүүдэлдэг тэр л нутгаа зүүдэллээ.

Газарт буусан ганц алтан од мэт шарга унага сүүл хатган чавхдаж цангинатал янцгаана. Цэнхэрлэн харагдах уулсын тэртээгээс сэнгэнэтэл үнэртдэг тэр л өвс ногооны танил үнэр хамар цоргиж, хэдийнээс эрхлэн өссөн мэт дотнохон уул ус түүнийг тосно. Тоосонд нь тоглож өссөн мэт ижил дасал санагдах адуун сүрэг тосож янцгаалдана. Шарга унага угтан дэгдэх бараан зүсмийн олон унага даагануудтай ижилдэн тоглож, тоос босгон хурдална. Газар үнэрлэн дэгдэхэд цээжний гүнээс анхилан байдаг нөгөө л танил сайхан үнэр салхи хөлөглөн хамар цоргино.

Эх нь бүлээн хошуугаараа нудрахад сая сэрлээ. Одод шуугдан үүр хаяарч байлаа. Тал нутгийн бяцхан сэрвэн дээр адуун сүрэг зогсоогоороо унтах ажгуу. Шарга даага нэгэнтээ сунаснаа эхийнхээ хэнхдэг рүү хошуугаараа зөөлөн ёворлоо. Тэгснээ газар үнэрлэн эргэцээд баруун хойд зүгийг чиглэн шогшлоо. Шарга гүү даган шогшсоноо хар азарганы үүрсэх дуунаар зог тусан үлдлээ.

*** **

Дорнын их талаас наран мандаж ертөнц дахиныг гийгүүлнэ. Ганц шарга адуу газар үнэрлэн хатирна. Тэртээд алаг голдуутай адуу идээшлэнэ. Овоон дээр суугаа хоёр эр дуран сунгаж шарга адууг дурандана.

-Ганц бага адуу гүйж явна. Сайхан аргамаг болох шинжтэй юм. Адуундаа ижилсүүлээд авбал яасан бэ?

-Явдал нь газар үнэрлээд нэг л өөр байна. Нутаг гүйж яваа адуу байх. Дэмий биз ээ. Адууны тэнгэр хаяна.

-Ийм бага адуу гүйх нь ховор доо хө.

-Бага гэлтгүй их хурдан ажнай ч юм бил үү. Шандас сайтай адуу л нутаг руугаа гүйнэ дээ.

-За за чи ч адууг өөрөөсөө илүү мэдэх юмаа. Гүү барих цаг ойртлоо. Мордьё.

Адуучдыг мордоход холын цэнхэр уулс зүглэн ганц шарга адуу хатирсаар авай.

Өвсөн толгой үнэрлэхэд нутгийнх нь үнэр сэнгэнэсээр. Өдөр шөнийг үл ялган шарга адуу хатирсаар.

Хангай нутгийн дов сондуул, бут бургас ард хоцорсоор байлаа.

*** **

Бадам гуайнх ургах нарнаар адуугаа хурааж, хурдны морьдоо барьж байлаа. Өнөөдөр зуны эхэн сарын билэгт сайн өдөр тул нутгийн айлууд наадамд сойх морьдоо барьж байгаа нь энэ. Уяан дээр айраг цагаа сөгнөж хөгшин, залуу уяачид, хүүхэд багачууд цугларч, өвгөн хуурч хуур татна. Арц, хүж уугиулан уяа шузгаа ариулан тойруулна.

Ийнхүү уяа морьдоо барьж байтал нэг шарга адуу ижил сүрэгтээ ирж байгаа мэт янцгаасаар айсуй. Хэний адуунаас тасраа юм бол ороо адуу болтой гэж улс ярилцана. Харин шарга даага адууны захад ирснээ хэдэнтээ хөрвөөгөөд, нэгэнтээ янцгаалаа. Сартай хүрэн азарга хамар амаа тачигнуулан очиж шарга даагыг үнэрлэсэнээ дэл сүүлээ үнгэлцэн ижилсэв. Уяан дээр байсан хүмүүс гүйж ирсэн шарга дааганы бараг дэргэд шахам ирлээ. Үргэж бусгаад дэргэж хатираад явчих юм болов уу гэтэл тэгсэнгүй. Өвс ганц нэг хазлан тургилна. Хуурч өвгөн толгой сэгсэрч:

-Бадам аа, Мөн ч бэлгэ дэмбэрэлтэй сайхан юм болж байна даа. Хурдан морь барьж байгаа өдөр шарга адуу гүйж ирлээ. Шарга адууг эр хүний хийморь унаа гэдэг. Танай азарга хажиглахгүй байхыг бодоход энэ цаанаа нэг учиртай. Үр төл нь ч юм билүү гэхэд уяач залуу:

-Бадам гуай барьж аваад уячихвал яасан бэ? Хурдлах адуу ч юм билүү? Танайх энэ жил дандаа охин даагатай байгаа гэсэн байхаа гэж үг ивлээ.

Бадам шарга адуунд дөхөж очсоноо хүржигнэтэл инээж:

-Үнэхээр бэлгэ дэмбэрэлтэй юм. Гэхдээ ч бэлгэшээлээ, бэлгэшээлээ гэхэд хүний адууг барьж аваад уяж яаж болох вэ? Лавтай манай адуу биш. Гүйж яваа адуу ч юм билүү гэхээс өөр үг хэлсэнгүй.

Энэ үед Бадам гуайн бага хүү Галт, ахынхаа чихэнд:

“Ямар хөөрхөн даага вэ? Өөр айлын адуу руу битгий явчихаасай” гэж шивнэж байлаа. Төмөр дүүгээ нэг том харснаа:

–Эр даага байна гээд л бод доо. Яг чиний унаа гэж хариу инээвхийллээ.

Бадам гуай уяа руугаа алхах зуураа,

-Энэ шарга даага буйлан тамгатай юм. Тэгэхээр энэ хавийн адуу биш. Холоос гүйсэн болтой. Лав эмээл тохоогүй эмнэг адуу. Ямар учиртай юм, манай хэдэн адуу ер хайрч, хажигласангүй. Тэгж байгаад эзэн нь өөрөө ирж авах байлгүй гэж бодно.

Үдэш болж айлууд уяа морьдоо тавьж адуугаа зална. Бадам гуай оройн хоолоо идэх зуураа хоёр хүүдээ хандаж:

-За хүүхдүүд минь хүний өөрийн хэдэн унага чинь нялх байна. Өнөөдрөөс айлуудтай ээлжлээд адуугаа манаж хоносон нь дээр. Энэ шөнө манай ээлж. Галт ахдаа нэмэр бол. Цув авч мордоорой бороо орж мэднэ гэлээ.

Ээж нь хоол аягалах зуураа:

-Энэ хоёр маань балчирдах байлгүй дээ гэхэд Төмөр:

-Найзууд маань адуу манана гэж байна лээ. Арван тав хүрчхээд ааваараа адуу манууллаа гэж шоолно шүү дээ. Галт харин яадаг бол гэлээ.

-Таныг байхад би айхгүй ээ. Тэгээд ч би тэр хөөрхөн дэлтэй шарга даагыг манаж хономоор байна гэж Галт цовоо дуугарлаа.

-Ха ха Манай энэ Галт шарга даагыг их шохоорхоод байгаа юм. Гүйж яваа адуунд хориг саад битгий хийгээрэй. Өнөө шөнө цаашаагаа гүйж ч мэднэ гэж аав нь хэллээ.

Төмөрөө, Галт хоёр морьдоо юүлээд адуугаа усаллаа. Шарга даага тэдний адуунаас явах байтугай хэдэн морьдтой нь ижил дасал болоод хошуу холбон ус залгилж байв.

-Ахаа энэ шарга даага манай адууг зорьж ирсэн байхаа. Тэр одоо хаашаа ч явахгүй тиймээ.

-Мэдэхгүй ээ. Аав буйлан тамгатай адуу говь нутгийнх байж магадгүй гэж байна лээ. Говь руугаа гүйх ч юм бил үү.

Тэд ийнхүү ярилцан адуугаа аядуухан гилж явахад зүүн уулын сугаар тэргэл саран дээшлэн мандаж байлаа. Унаган дэлтэй зэгцгэр шарга даага сарны гэрэлд үлгэрийн сайхан хүлэг мэт харагдана.

-Ахаа та шарга даагыг надад сургаж өгөх үү? Би наадамд унаж уралдмаар байна.

-Би ч гэсэн шарга даагыг сургаж уямаар байна. Аав зөвшөөрөхгүй байх л даа. Энэ шөнө л шарга даага манай адуунаас явахгүй бол хэзээ ч явахгүй гэсэн үг. Хуурч өвөө “Гүйж яваа адуу айлын адуутай ижилсдэггүй юм. Энэ шарга танайхыг зорьж ирсэн буян байх шүү” гэж аавд хэлэхийг нь би сонссон.

-Би шарга даагыг л унаж уралдмаар байна.

-Галтаа чи өмнө нь яг ингэж хэлсэн шүү дээ. Адуу сайхан тогтож байна. Хоёулаа тэр хадны нөмөрт бууж жаахан сууя.

-Та одоор хойд зүгийг олж чадах уу?

-Чадна. Тээр дээр харагдаж шанага долоон одны хамгийн дээд талын тод од бол Алтан гадас. Алтан гадас ямагт хойд зүгийг заадаг юм.

-Ахаа ерөөсөө шарга даагаа Алтан гадас гэж нэрлэе.

-Чи бүр шарга дааганаас өөр юм бодохгүй болжээ.

-Би ийм хөөрхөн шарга даагатай болохсон гэж мөрөөддөг байсан. Та надад номхруулаад өгөөч.

-Харин ээ. Хулжаад явчих юм болов уу? За ер нь мордьё. Чи адуугаа хурааж бай. Би уургалаад орхиё. Хэр догшин байх бол үзье.

Тэднийг мордоход сар дээр хөөрч эргэн тойрныг гийгүүлж байлаа. Адуугаа хумьж байснаа Төмөр гэнэт морио гуядан ухасхийж шарга даагыг уургаллаа. Адуу нэг дэр хийснээ тэгс гээд тогтож идээшиллээ. Шарга даага хамар тачигнуулан зүтгэснээ намайг яах нь энэ вэ гэсэн шиг эргэж харан

захадлаа. Сарны саруулд хол ойрын бараа өдөр мэт тодорхой. Ах дүү хоёр шарга даагыг элбэж хамжин байж эмээллээд Төмөр мордлоо. Шарга даага адуун дундуур зүсэн орж хэдэнтээ булгиснаа бөг бөг шогшив. Дараа нь Төмөр шарга дааганд Галтыг мордуулаад, өөрөө хөтөлж адуугаа хэдэнтээ тойров.

-Ахаа шарга даага ингээд номхорчихлоо шүү дээ.

-Хөтөлж яваа морь догширдоггүй юмаа.

-Ахаа тавьчих. Би тантай зэрэгцээд явъя.

Галт ингэж хэлээд шарга даагаа гуядаад автал булгиад ухасхийлээ. Галт хэд бухахад нь овоо тогтсоноо цулбуурдаад авахтай зэрэгцэн урд бүүргээ даван ойчлоо.

-Дахиад мордох уу гэж Төмөрийг асуухад Галт “Тэгье харин та намайг хөтлөөрэй” гэж сулхан дуугарлаа. Төмөр дүүгээ өргөж мордуулаад цулбуурдан хөтөлж адуугаа тойрлоо.

-Төмөрөө ахаа би өөрөөсөө л болж ойчлоо. Гэнэт гуядахаар цочоод булгисан байх тиймээ.

-Тэгсээн. Биеэр том гэлээ ч биднийг бодвол хоёрхон настай нялх адуу шүү дээ. Одоо шарга даагаа адуунд нь тавъя. Гүйж яваа адуунд саад битгий болоорой гэж аав хэлсэн.

-Тэгье. Би ойчсон ч гэлээ шарга даагыг унасан даа баяртай байна.

Дорно зүгээс үүр хаяарч, шувууд шулганалдаж эхэллээ. Ахынхаа нөмөрт суугаад зүүрмэглэж байсан Галт цочиж сэрээд,

-Ахаа шарга даага байна уу? гэлээ.

-Чи яав аа. Үүр дөнгөж хаяарч байна. Шарга даага хулгар хээр морины нөмөрт хэвтээд унтаж байна.

-Би Шарга даага чанга гуядлаа гэж надад гомдоод яваад өглөө гэж зүүдэллээ.

-Чи одоо унтмаар байна уу?

-Үгүй би шарга даагаа унтаж байхыг хармаар байна.

-Шарга даагаа гэнэ шүү. Ямар биднийх болчихсон биш.

-Гүйгүүл морь айлын адуунд хонодоггүй гэсэн. Одоо ч манайх болсон байхаа.

*** **

Хүүхдүүд ургах нарнаар адуугаа хурааж гэрийн зүг гиллээ.

Уяан дээр хөвгүүдээ тоссон аав нь “Адуу сайхан тогтож хонов уу” гэснээ “Галт наад духаа яагаав” гэлээ.

Галт “Мориноосоо ойчоод” гээд инээвхийллээ.

-Юу инээх гэж дамшиг чинь. Үүргэлж яваад мориноосоо унаж дээ. Тэгсэн биз Төмөрөө. Дүүгээ хараад явж чадахгүй гэснээ шарга даагыг анзаарч харлаа. Төмөрөө ч нүүр нь уласхийснээ:

-Ааваа уяа морьдоо барих уу гээд уургаа сунгалаа.

Морьдоо барьж, унагаа зэллэчхээд Галт, Төмөр хоёр сая гэртээ орж айраг залгиллаа.

Ээж нь Галтыг хараад тэвэрч авснаа:

-Нялх амьтнаар адуу мануулаад. Хар даа энэ духыг нь цөмлөх шахаж гэж аавыг нь үглэхэд Бадам гуай:

-За гайгүй дээ жаахан шалбархай. Харин эд миний үгэнд орсонгүй. Амьтны нялх үр төл ижлээ олохгүй будилж явахад адуундаа ганц хонуулахгүй барьж унасан байна. Шарга даага булгиулж байж унасан биз. Төмөрөө би чамд хэлсэн дээ. Гүйж яваа амьтныг саатуулдаггүй юм гэж. Гэтэл чи.

Ингэж хэлээд аав нь жирэм бариад ухасхийтэл Галт аавыгаа тэврэн:

-Би ахыг гуйгаад байсан юм. Шарга даагыг сургаж өгөөч гээд гуйсан гэж хэлээд мэлмэртэл уйллаа.

Гэрт нэг хэсэг нам гүм болов.

Бадам гуай жаал дуугүй сууснаа:

-За хүүхдүүд минь Энэ даага их холоос зүдэрч ирсэн адуу. Ямартай ч манай адуунаас нэг хэсэгтээ явахгүй нь болтой. Одоо тэгэхээр өдөр бүхэн саам өгч тэнхрүүлэх хэрэгтэй. Нэгэнт эмээл тохсон хойно номхруулах нь зөв. Төмөрөө чи дааганд хүндэднэ. Дүүдээ унуулаад хөл хөнгөнтэй номхон мориор хөтөлж сурга гэлээ.

Хөвгүүдийн царайд баярын мишээл тодорч шарга даагаа тэнхрүүлэх, номхруулах ажилдаа шаламгайлан орлоо. Шарга даага сааманд дуртай гэж жигтэйхэн. Харин Галт шарга даагаа унаад ахынхаа хулгар хээр морьтой уралдах бүр ч дуртай. Өглөө бүхэн адуу хураахад Галт шарга даагаа тосож гүйнэ. Шарга даага нь ч Галтыг танин хүзүү сунган эрхэлнэ. Гүйгүүл шарга даага одоо Галтын шарга болжээ.

Наадмаар уралдуулна гэж Галт хошуу цорвойн ээжээрээ дэмжүүлсэн боловч аав нь алдуул морь уялаа гэж амьтан хүн муу хэлнэ гээд зөвшөөрсөнгүй ээ. Шарга даагаа өдөр бүхэн барьж саам уулгадаг боллоо. Уяа морьдын хөл чангарч наадам ойртож байлаа.

Тэр өглөө Төмөрөө:

-Галтаа өнөөдөр хоёулаа Данигай өвөөгийн очноо. Шарга даагаа эмээллэчих гэж хэллээ.

-Яах гэж?

-Чи очоод л мэднэ.

-За одоохон.

Төмөрөө эмээлээ тэврэн гүйж яваа дүүгээ хараад:

Дүү маань шарга даагаа унаж уралдъя гэж дандаа гуйгаад байх юм. Гүйгүүл морь уяхгүй гэдэг аавын зөв. Гэхдээ л дүүгийнхээ хүслийг биелүүлмээр бодогдоод байна. Хуурч өвөөгийн үгэнд л аав орно доо гэж бодож зогслоо.

Тэд хуурч өвөөгийн очлоо.

Өвөө шарга даагыг шинжиж үзээд та хоёр ойрхон газар тарлаадах гэв. Шарга даага Төмөрөөгийн хулгар хээрийг гүйцэж алдан, гүйцэж алдан хурдалсаар зуузай холбож ирлээ. Өвөө бор морио гуядан хэсэг дуугүй шогшуулснаа:

-Хөлийн гишгэдэл нь их чанга бяртай адуу байна энэ шарга. Барагтай адуу танай хулгар хээртэй зэрэг гарахгүй. Аав нь зөвшөөрвөл уралдахад буруугүй.

-Аав зөвшөөрөхгүй байна л даа.

-Зөвшөөрүүлж болох ганцхан арга байна.

-Яаж ?

-Бага сунгаанд давхиулаад үз. Би аавыг чинь гуйя.
Тэдний ийн ярилцахад Галт эмээл дээрээ өндөлзөн “Еэ гялай, еэ гялай” хэмээн алга ташиж байлаа.

Хуурч өвгөн Галтыг харан инээмсэглээд:

-Баярлах яах вэ. Төмөрөө чи адууны манаан дээрээ уяж хоноод үүрээр битүү нэмнээд нэг сайн хөлс авчих. Хөлсийг нь салхи сэвэлгүй нөмөр газар хусаарай гэлээ.

-За. Би чаднаа. Та харин сунгаанд давхиулахыг л.

-Би ааваас чинь гуйна даа.

*** **

Хөвгүүдийн хувьд тэсэж ядан хүлээсэн бага сунгааны өнөөдөр болно. Бадам гуай том хүүгээ дуудаад:

-Хуурч гуай шарга даагаа сунгаанд давхиулаадах хурдан эсэхийг шинжмээр байна гэх юм. Ганц давхил хийж, хөлс аваагүй байж уралдуулавал хэмхлээд хаячихна шүү дээ гэлээ.

Төмөрөө гэмшингүйгээр толгойгоо илснээ:

-Ааваа би нэг хоёр хөлс авсан л даа гэж түгдчив.

-Юу? Та нар чинь шарга даагаа бүр уяж сойгоод эхэлчхэж.

-Дүү маань л уях гээд байх юм.

-Чи ч бас дуртай байгаа л даа. За тэгэхээр чи дүүгээ эргүүлж өгсөн нь дээр байх. Хамаагүй битгий ороолго. Өөрийнх нь тааваар давхиул гэж захиарай.

*** **

Бага сунгаанд сойсон гуч гаран даага уул жийсэн тэнүүн хөндийн сэжүүрээс тоос татуулан эргэлээ. Удалгүй даага ирлээ гэгцгээж хөл хөдөлгөөн болон уяачид барианы газраас өндөлзөн дурандана. Тоосны үзүүрт бүгээн зүсмийн даага тодрон тодорсоор ойртлоо. Шарга даага тасархай хол түрүүлж явна. Хүмүүс босон суун саравчилж

-Энэ чинь юун шарга даага байдаг билээ гэлцэнэ.

Хуурч өвгөн дурандаж сууснаа:

-Гүйгүүл шарга мөн дөө. Гүйцэгдэхгүй хурдан адуу байх нь. Энэ Бадамыг гуйж байж уралдуулж байгаа юм шүү гэснээ “Миний зөв байж” гэх шиг бардам дээгүүр харж монхолзоно. Уяачид:

-Аан нөгөө морь барьдаг өдөр гүйж ирдэг шарга даага байна шүү дээ гэлцэхэд Торгон Дэмбээ:

-Хэ цсс. Аль нутгийнх гэдгийг нь мэдэхгүй алдуул адууны тоосоор энэ Бадам биднийг булах нь ээ гэснээ нударгаа сэгсрээд мордлоо.

Торгон Дэмбээ гуайг тосоод ирж явсан хоёр морьтны нэг ширвээ хар сахалт залуу:

-За ах хүү морь хурдан уу. Бид хурд цуглуулж яваа улс. Танай сумын энэ шарга даага тасархай хурдан адуу юм даа. Бадам гэдэг хүний адуу гэлүү гэхэд Дэмбээ гуай моринхоо амыг эргүүлэн тэр залууг сүрхий ажсанаа:

-Хурд цуглуулж яваа улс юм биз дээ. Ха ха. Тэр шарга даагыг үнэ цохиж аваад шалдан хоцрох санаатай.

-Яагаад шалдан хоцрох гэж.

-Бадамын адуу бишээ. Гүйж яваа адуу. Алдуул үрээ. Удахгүй эзэн нь ирж авах байлгүй. Хүний юмаар хүүдэгнэх гэдэг л болж байгаа юм.

-Ха ха алдуул гэдэг чинь ч аятайхан сонсогдож байна шүү.

-Та хоёрыг чинь богцондоо багтахгүй мөнгөтэй улс гэж бодсон чинь.

-За ах минь олон үгээр яахав. Хоёулаа явж хурдан шаргыг нэг сайн хараад авъя

-Тэгсэн чинь дээр байлгүй.

Ширвээ сахалт мориндоо ташуур өгч тэд түрүү дааганы уян дээр ирлээ.

Ширвээ сахалт “Бараг шүдлэн шиг товир даага юм” гэхэд хамт яваа залуу “Эзэнтэй нь уулзаж үнэ хаялцах уу” гэлээ. Ширвээ сахалт аман дотроо “Буйлан тамгатай юм гээч” гэснээ

-Үгүй ээ тэр түрүүчийн нөхрийн хэлдгээр алдуул адуу наймаалцаж шалдан үлдээд яахав. Хоёулаа ер нь ажиг сэжиг аваагүй дээр нь явъя. Авах нь гэж бодоод үнээ нэмчхэж магадгүй. Ингээд нутаг буцнаа гэж эрсхэн хэллээ.

Хуурч өвгөн Бадам уяач дээр ирээд:

-За хө Гүйгүүл шарга ч Галт хүүгийн шарга боллоо доо. Наадмаар тоосоо өргөхгүй бол морь, эзэн хоёрын аз харина. Тийм биз. Бадамаа гэлээ.

Бадам:

-Гүйж яваа адуу гэж бодсон юм. Тэгсэн чинь уралдах гэж ирсэн болтой. Таны заавраар хүүхдүүд маань уяад эхэлчихсэн байна шүү дээ. Наадмаар уралдана даа гээд ханцуйгаараа духны хөлсөө шударлаа.

*** **

Үүрээр адуундаа мордсон Төмөрөө мориныхоо хурдаар адуугаа пижигнэтэл хөөсөөр ирж гаднаа буулаа. Аав нь дүүг нь дагуулан сандуу мэндүү гарч ирээд:

-Хүү минь адуугаа элдээд юу болов гэвэл.

Төмөрөө:

-Аваа шарга даага алга байна гэлээ.

Адуу бүрэн мэнд боловч ганцхан шарга даага алга байлаа. Өвсний чийг хатахаас өмнө гэж яаран морьдоо барьж эмээллээд гурвуул адуу хоносон газар давхиж очлоо.

Аав нь мөр шинжин баахан явснаа:

-Өвсний налархай оллоо. Ганц морьтой хүн ирж уургалж бариад, хөтлөөд явжээ. Уургаа чирсэн мөр нь энэ байна. Баруун хойд уул өөд чиглэж дээ. Өвсний тачирт мөр нь балархай болчихлоо. Одоо мөр хөөгөөд олохгүй гэв.

Ингээд Төмөр, Галт хоёр аавынхаа захиснаар унаган морьдоосоо аль хөнгөрүүн сайныг нь шилэн унаж ойрын хэдэн сумын нутгаар эрэлд мордсон боловч шарга даагаа олсонгүй.

Бадам гуайхан байтугай сум даяараа шарга дааганыхаа араас харуусаж морьтой унаатай нь хол ойр эрэл сурал болж, үлдсэн нь чих тавин суух болов.

*** **

Гэтэл хэд хоногийн хойно шарга даага анх ирсэн шигээ л гүүн зэлэн дээр янцгаасаар давхиж ирлээ. Ялгаатай нь гэвэл хөлдөө чөдрийн тасархай, хүзүүндээ бугуйлтай хүрээд иржээ.

Галт даагаа хүзүүдэн уйлахад шарга даага нь түүнийг өрөвдөх мэт мэлтийгэл харна.

Аргагүй л миний хүүгийн унаа юм гэж ээж аав хоёр нь нулимс унагаад авлаа. Шарга даага эргэж ирсний сургаар нутгийн олон бараг тэр чигээрээ Бадам гуайнд цуглаж найр болох шахаж байв.

Гэтэл уяан дээр хөтөлгөө морьтой хүн бууж харагдлаа. Ирсэн хүн бага сунгаан дээр үзэгдээд өнгөрсөн нөгөө ширвээ сахалт мөн болтой. Тэр хүн Бадам уяачийн баруун хоймор тухалж хултай айраг хүд хүд залгилснаа:

-Шарга дааганыхаа араас мөшгисөөр яваад танайд буучихлаа гэж тамшааллаа. Гэрт нам гүм болов.

Галт тэсэлгүй “Худлаа энэ чинь миний даага” гэхэд

Бадам:

-За тийм байдаг байж. Та энэ дааганы эзэн нь гэдгээ юугаар батлах гэж байна гэж асуулаа.

Ширвээ сахалт барьж орж ирсэн хадганд боолттой зүйлээ задаллаа. Буйлан тамга байлаа. Ширвээ сахалт:

-Тамга нь нотлоод өгнөө. Энэ миний унаган адуу байгаа юм гэлээ.

Торгон Дэмбээ Ширвээ сахалтын үгийг өлгөж аваад:

-Эзэн нь ирнэ гэж хэлээгүй юу. Чи наад алдуул адуугаа аваад бушуухан явж үз. Чамаас болж мань мэт нь хүний хурдан адуу нутгийн дээс алхуулсан хэрэгт сэжиглэгдэх шахаж байна гэж хэнхэлзлээ.

Бадам:

-Тамга яахав тамга. Энэ даага манай адуунд хоёр дахиа гүйж ирлээ. Таны унаган адуу яахаараа миний адуунд гүйж ирээд байгаагийн учрыг нэг л олохгүй байна. Та тамгаа нааш нь өгөөч бид шарга дааганы тамгатай ацаг шүдний зөрөөгүй таарах эсэхийг үзье.

Ингэж хэлэхэд хүүхэд хөгшидгүй зөв зөв гэгцгээлээ.

Бадам гуай тамгыг барьсаар очиход шарга даага үргэх янзтай байснаа толгой хаялан ялаархлаа. Бадам:

-За та нар харж байгаа биз. Энэ тамга шарга дааганы тамганаас ялимгүй том байна. Тэгээд ч хийцийг нь харахад хэд хоногийн өмнө хийсэн байна. Таны тамгаар мөшгөвөл шарга даага хулгайлсан хүн олдох юм байна даа гэвэл:

Ширвээ сахалт:

-Тамгаа шинэчлэх эсэх нь миний хэрэг. Сүүлд хийхдээ өмнөхөөсөө жаахан хэмжээ алдаж л дээ. Энэ даага хэний адуу болохыг шалгадаг тогтоодог газар нь шийдээд өгөх байлгүй гэж хэлээд тамгаа булаах шахам шүүрч аваад мордлоо.

*** **

Торгон Дэмбээ уяан дээрээ залуу уяач Очиртой их л чухал зүйл ярьж байгаа болтой хүзүү толгой холбон шивнэлдэх шахуу сууна.

-За Очир минь сумын наадмаас аймаг, улсад уралдах хурдан хүлэг үнэ цохиж авахаар бэлтэй улс ирсэн байна. Манай уяан дээрээс чиний саарал даага л юм дуулгах байсан юм. Одоо тэр Бадамын шарга даага гэж нэг гайхал гараад ирлээ. Хулгай аваад жилийлээ гэж бодсон чинь өөрөө гүйгээд ирэх юм.

-Шарга даага аргагүй хурдан юм билээ.

-Түрүүлсэн даагыг 30 саяар авна гээд цаана чинь ярьж явна. Тэгэхэд чи хүний морины хурдныг гайхаад сууж байдаг.

-Одоо тэгээд яахав Дэмбээ ахаа. Ямар арга байна?

-Арга байнаа. Шарга даагыг дутуу эргүүлчхэд чиний дааганы өмнө гишгэх адуу байхгүй болно. Аргыг нь заагаад өгөх юм бол 30 саяаа хуваах юм байгаа биз. Ха ха.

-30 сая. Багагүй мөнгө сонсогдож байна шүү. Тэгэлгүй яахав хуваана.

-Чи одоо мордож давхиад хүний үгнээс гардаггүй нэг чих зөөлөнтэй хүүхэд олоод ир.

-Хуурч өвгөний ачийг л дуудчихъя. Бие жижиг болохоос энэ жил арван дөрөв, тав хүрч байгаа хүүхэд. Миний үгнээс гардаггүй юм.

-Дараа нь л хэл ам гаргахааргүй, тэгээд бас сэргэлэн хүүхэд байх хэрэгтэй шүү.

-Өө. Сайн хүн санаагаар гэгчээр тэр давхиж явна.

-Тэгээд даллаач ээ, даллаач.

-За Хүрлээ хүү хаа хүрэх нь вэ?

-Бадам гуайнд очиж унага татаж өгье.

-Ах нь чамтай нэг чухал зүйл ярилцахаар дуудсан юм. Эр хүн хэлсэндээ, эмээлт морь харайсандаа гэгчээр чамайг би хэлсэндээ хүрдэг том эр болсон гэж боддог шүү.

-Тэгэлгүй яахав Очир ахаа. Би.

-За тэгвэл чи Дэмбээ ахынхаа юу хэлэхийг сайн сонс.

-За Хүрлээ хүү. Дэмбээ ах нь энэ нутагтаан хэчнээн их хайртай хүн билээ. Даяараа мэднэ. Харин чи ер нь төрж өссөн нутагтаа хэр хайртай хүн бэ?

-Хайртай байлгүй яахав.

-За зөв дөө. Тэгвэл нутаг усныхаа төлөө нэг сайн үйлс бүтээхэд оролцох уу?

-Оролцъё.

-Манай сумын наадамд аль нутгийнх нь мэдэгдэхгүй алдуул морь түрүүлэх гээд байна.

-Ямар?

-Нөгөө сунгаанд түрүүлдэг шарга даага.

-Өвөө тэр даагыг гүйгүүл адуу гэж байсан.

-Алдуул, гүйгүүл ялгаа байхгүй. Аль нь ч байсан нутгийн нэрэнд муухай.

-Хүрлээ чи тэгэхээр олон жил морь унасан туршлагатай унаач хүүхэд. Даага хаанаас эргэдэгийг мэдэх үү?

-Мэднэ.

-За тэгвэл манай халтар даагыг унаж яваад шарга даагыг дагуулж дутуу эргүүлнэ. Энэ чинь л чиний нутгийнхаа төлөө хийж байгаа гавьяа шүү дээ.

-Өвөө?

-Өвөөдөө огт хэлж болохгүй. Тэгвэл эр улсын нууц задарна. Бас дээр нь чамайг шагнаана аа. Ах нар нь.

-За тохиров уу?

-Тохирлоо. Эр хүн хэлсэндээ, эмээлт морь харайсандаа.

-Зөв хө. За чи явж гүүгээ тат. Дуудахаар хүрээд ирээрэй.

*** **

Хүрлээ хүү давхисаар Бадам гуайн уяан дээр буулаа.

Галт тосож ирээд:

-Хүрлээ ахаа та хурдны моринд томдсон гэж үнэн үү? Төмөрөө ах бас томдсон. Тэгээд би 5 нас унаж уралдах гэж байгаа. Та миний шарга даагыг сунгаанд түрүүлэхийг харсан уу? Миний шарга даагыг очиж хараач. гэлээ.

Энэ үед Хүрлээ “Ангийн найз Төмөрөөгийнхөө дүүг хурдан шарга даагатай нь хууран мэхлэх гэж байгаа шүү дээ” гэж бодохоос мордоод зугтмаар санагдаж байлаа.

Гэвч тэр нэг л мэдэхэд уяан дээр ирсэн байлаа. Ахмад, залуу уяачид морьдынхоо уяа сойлго хэрхэн таарсан тухай хүүрнэн сууцгаана. Хүрлээ тэднээс дөлсхийн зогсоно. Бадам гуай:

-Хүрлээ хүү наашаа суу. Хурдны моринд томдоно гэдэг эр хүн болж байгаагийн шинж. Наадам гэдэг эр хүний мөс чанар шалгасан шударга сайхан цэнгэл дээ. Одоо та нар уралдах биш уях нас чинь болсон гэлээ.

Бадам гуайн хэлсэн үг, хүндэтгэл, итгэл түүний сэтгэлийг өөрийн эрхгүй дэнслүүлж, тэсэлгүй мордож давхихад нутгийнх нь салхи чихэнд нь “Наадам гэдэг эр хүний мөс чанар шалгасан шударга сайхан цэнгэл дээ” шивнэн хэлсээр байлаа.

Хүрлээ гэртээ ирээд унтахаар хэвтсэн боловч нойр нь хүрсэнгүй.

Өвөө нь тамхиа шившингээ “Миний бор хүү нэг л унтах, зүүдлэхийн хооронд хөрвөөгөөд байх шив” гэлээ.

Хүрлээ “Өвөө, өвөө” гэсээр өндийж ирлээ. Өвөө нь духыг нь барьж үзвэл халуунтай байлаа.

-Яав ? Юу болов?

-Өвөө та Дэмбээ гуайд “Манай хүү таны даагыг унаж чадахгүй нь” гээд хэлээд өгөөч.

-Юун даага унах. Миний хүү чинь даага байтугай их нас унахгүй. Энэ Дэмбээ хүүхэд уруу татаад.

-Үгүй өвөө би өөрөө уная гээд хэлчихсэн юм.

-За яах вэ одоо орой болчхож. Маргааш наадмын өглөө. Цаадах чинь нэг арга олно биз. Өвөө нь өглөө хэлье.

-За ер нь хэлээд хэрэггүй юм байнаа. Би даагыг нь унаад л өгчихье өвөө.

-Очиж, очиж даага унахдаа яахав. Өөрөө л мэд дээ. Эзнээ даадаггүй хүлэг гэж байдаггүй хойно. Өвөө, ач хүү хоёр ийн ярилцсаар унтахаар хэвтлээ.

Сумын наадам баяр хөөрөөр цалгиж наадамчин олон уламжлалт сайхан соёл, заншлаараа гоёж хүндэтгэл ёслол төгөлдөр үргэлжилнэ.

Их морь ирсний дараа даага уралдахаар гарлаа. Хүрлээ хүүгийн чихэнд “Эр хүн хэлсэндээ эмээлт морь харайсандаа”, “Наадам гэдэг эр хүний мөс чанар шалгасан шударга сайхан цэнгэл дээ” гэсэн үгс ээлжлэн сонсогдсоор нэг мэдэхэд гарааны зурхай ойртсон байлаа. Даага эргэлээ.

Тэртээ уулын өврөөр цагаан тоос татаж наадамчин олон “Даага ирлээ” гээд шуугилдаад явчихлаа. Улс амьтан дурандан өндөлзөнө. Ганц бүгээн зүсмийн адуу барааны холоос тасархай ирж явна. Бадам гуай дурандаж дурандаж:

-Мөн ч сайхан ирж явна. Шарга даага маань мөн байна гэлээ. Тэгтэл хажууд нь шахуу сууж байсан Дэмбээ:

-Араас нь адууны бараа алга. Танай шарга дутуу эргээд зугтчихаж дээ гэснээ бах нь ханасан байртай залуу уяач Очир луу нүд ирмэж байгаа харагдлаа.

Бадам “Нээрээ энэ чинь араас юм үзэгдэхгүй байх чинь” гэж эргэлзлээ.

Гэтэл даага эргүүлсэн тугтай машин гараад ирлээ. Шарга даага машинд гүйцэгдэхгүй хурдалсаар барианы газарт орж ирэв. Наадамчин олон уухайлан тосож авлаа. Ахиад л хүмүүс өндөлзөж даага одоо л хошуу тойроод гараад ирлээ гэгцгээнэ. Шарга дааганыхаа хөлсийг хусаж байтал тугтай машин дэргэд нь ирж зогслоо. Бадам гуай бусад даагатай зэрэг эргэсэн гэх хүүгийнхээ үгэнд итгэж ядан байсан тул морины комисс юу гэдэг бол гэж тосож очлоо.

Морь эргүүлсэн хүн:

-Бадам гуай таны даага гэснээ гарыг нь чанга атгаж онцгой хурдан адуу юм. Гараад л гүйцэгдэхгүй хурдалсан. Тэр чигээрээ орж ирлээ шүү. Таны хулгар хээр нэг ингэж гардаг сан, яг л ижилхэн гараатай юм. Сайхан наадлаа даа гэлээ.

Сая л Бадам гуайн магнай тэнийж,

-Тийм байлгүй зарим улс шарга даага наанаас эргэсэн гэхээр нь хүүгийнхээ ч үгэнд итгэхгүй эргэлзэж суулаа гэв.

Очирын саарал даага аман хүзүүдэж, харин Дэмбээ гуайн даага сураг ч үгүй байлаа. Сүүлдэж ирсэн дааганууд ганц нэгээрээ цувран шогшино.

Даагаа амдан тосож ирсэн Дэмбээ гуай ташуур далайн:

-Чиний нөгөө хэлсэндээ хүрнэ гэсэн чинь хаа байна гэхэд Хүрлээ:

-Бадам гуай надад “Наадам гэдэг эр хүний мөс чанар шалгасан шударга сайхан цэнгэл” гэж хэлсэн юм. Харин би Очироо ах та хоёрын нууцыг хадгалнаа гэлээ.

Түрүү морины уяан дээр гадна дотны олон хүн шавж шарга дааганы гайхалтай хурдныг шагшин, бахдан ярилцана.

Хүрлээ хүү шарга дааганы хондлойг илбээд:

-“Шарга даага минь чи түрүүлж сайхан наадлаа. Би чиний өмнө буруугүй болохоор бүр сайхан наадлаа” гэж хэлчхээд яваад өглөө. Хажууд нь байсан Галт:

-Хүрлээ ахаа та сая юу гэж хэлсэн бэ гэхэд Хүрлээ:

-Энэ миний нууц байгаа юмаа гэж олонд дуулдахаар хэллээ.

Дэмбээ Очирыг дуудаж:

-Чиний нөгөө дуулгавартай гээд байсан хүүхэд чинь хамаг төлөвлөгөө нураалаа. Би энийг нь мэдсэн бол өөр хүүхэд олох байсан юм. Чамаас болж байгаа юм гэж зандрахад Очир:

-Энгүй их хурдан хүлэг юм байна. Харин ч будлиулахгүй давхиулсан Хүрлээ дүүдээ очиж баяр хүргэе дээ гэж хэлчхээд цааш алхлаа.

Бадам гуайн хурдан шаргыг нь харан нүд хужирлаж зогсох олныг зүсэн орж ирсэн бүдүүн бор эр:

-Ах хүү сайхан наадлаа. Аргагүй хурдан хүлэг юм. Мөн ч хол тасарч түрүүлээ. Би хурд цуглуулж яваа хүн. Таны даагыг олны нүдэн дээр 30 сая төгрөг тоолж өгөөд авна даа. Болно биз дээ гэж түхэлзлээ. Бадам гуай:

-Хэ хэ авна гэнэ шүү бэлтэй хүн байх нь. Монгол хүн мориныхоо хөлсийг хатаагүй байхад наймаа ярьдаггүй юм. Ах нь даагаа зарахгүй ээ. Тэгээд ч манай адуунд гүйж ирсэн хүлэг. Энүүхэндээ гэхэд миний ч юм биш. Хүү маань уяж уралдана гэж шалаад байхаар тоосыг нь үзэж сууна гэлээ. Бүдүүн бор эр:

-За ах хүү үнэрхээд яахав. 45 сая болгоё. Сумын наадамд түрүүлсэн дааганд үүнээс илүү үнэ өгч чадахгүй шүү. Үгүй гэвэл аман хүзүүнд ирсэн даагыг аваад буцлаа гэж үнэ хаялаа.

Бадам тэр залууг нэг л дурамжхан харснаа:

-Тэг дээ дүү минь. Хүлэг хүүхэд хоёрын нас нь бага байна. Энэ нутгийн нэрийг их хол дуурсгах хурдан хүлэг ч юм билүү. Тийм биз дээ та минь гээд инээж зогслоо. Уяачид:

-Тэгэлгүй яахав. Галтын шарга гэж гайхалтай хурдан морьтой боллоо шүү дээ гэцгээнэ.

Дэмбээ эмээл дээрээ хэнхэлзэж:

-Бадам чи дэмий онгирч хурдан морины ханш унагаж байна. Тултал үнэ хэлээд өгч л байхгүй. Чиний адуу биш алдуул үрээ. Маргааш ирээд эзэн нь авахад чамд хөөрүү сэтгэлээс өөр юу үлдэх юм гэж цэцэрхлээ. Бадам:

-Дэмбээ чи дандаа юм болгоноос хонжоо харж явах юм. Уяач бидний сайн муу хойч үедээ сургамж болно шүү. Сумын наадам хурдтай байж болдоггүй юм уу гэж хатуухан хэлээд авлаа.

Дэмбээ “За яахав шарга дааганы эзэн нь тодрох өдөр ирэх байлгүй”гэснээ чүү гэж морио гуядаад хатируулж одлоо.

Залуу бөх түрүүлж, битүү морь айрагдахад баярлаж байдаг Монгол хүний сэтгэлд сумын наадмын сонин сайхан нь ирэх жилийн наадам болтол яригдана. Хүн бүхэн хурдан шаргыг магтан шагшин ярьсаар байлаа.

*** **

Дэмбээ гэртээ айраг шимэн суунгаа радио чагнана. Тэгтэл нэгэн зар ёстой л загатнасан газрыг нь маажаад авлаа.

-Алив “Шарга даага алдсан тул” гэж байна шүү. Буйлан тамгатай мөн дөө. Утсыг нь тэмдэглээд авах юм шүү. Тэгнээ тэр. Би мэдээд байсан юм. Шагналтай гэж байна. Ингэж хэлүүт хултай айргаа цалгилж орхиод гэрээсээ гүйхээрээ гарав.

Дэмбээ гуай хул морио давчин өвхөгнөсөөр урд уулан дээр гарлаа.

Тэгээд өврөө тэмтчин утас, дугаар бичсэн цаас хоёроо гаргаж ирэв.

-За би зарын дагуу залгаж байна. Чи тэгээд шарга даагаа алдсан юм биз дээ.

-Алдаад гурван сар болж байна.

-За чиний шарга их ойрхон байна даа. Тамга тэмдэг нь ч таарч байна. Олоод өгвөл тэгээд ямар шагналтай юм бэ дээ.

-Бүдүүн морь өгье

-Хэ цэсс. Даага чинь манай суманд түрүүлээд гуч, дөчин сая хүрч байдаг. Тэгэхэд чи ганц морины шагналтай гэж байдаг.

-Шарга даага маань уралдаад түрүүлсэн нь үнэн юм биздээ.
-Үнэнээр барах уу. Гайхагдаж байгаа адуу даа. Түрүүлж ирээд хөлс нь хатаж байхад дараагийн даага ирж байдаг юм.
-Та аль нутаг усны хэн гэдэг хүн бэ. Тэрийг хэлтлээ уднаа. Наймаа тохирч байж хэлнэ шүү.
-Та ямар үнэ хөлс авмаар байна.
-Тав зургаан адуунаас наашгүй байх шүү.
-За тохирлоо.
Торгон Дэмбээ ингэж шарга дааганы эзнийг олсондоо хагартлаа баярлаж, олсон олз нь нүдэнд нь харагдаж байлаа.

*** **

Бадам гуайнх гүүгээ сааж байтал уяан дээр нь нэгэн хөтөлгөө морьтон бууж харагдана. Хөтөлж ирсэн шарга зүсмийн адуу нь хангинатал янцгаахад гүүн эзлэн дээр байсан шарга даага цангитал үүрсэн уяаны зүг шогшлоо.

Бадам гуай хоёр хүүгээ дуудаж,
-Хараач тэр шарга даага чинь эх рүүгээ очлоо. Одоо л юмны учир олдох нь. Ээ хөөрхий гэснээ аньсга нь чийгтээ ирлээ. Төмөрөө аав руугаа харснаа:
-Нээрээ ноднин арилжсан шарга гүү маань байна шүү дээ гээд дүүгээ дагуулан уяа руу гүйлээ. Шарга даага эхтэйгээ дэл сүүлээ үнгэлцэн эрхэлнэ.
Эрлийн хүн, Бадам нар харилцан мэнд мэдэж гэрт орцгоолоо.

Эрлийн хүн тамхилангаа:
-Чамаас авсан энэ шарга гүү маань хээлтэй байсан юм билээ. Хурдны удамтай хүлэг төрлөө. Уяж сойно доо гэж бодож байтал зуны эхэн сард шарга даагаа алдчихсан. Радиоогоор зар өгч байж сая сураг авлаа гэв. Бадам толгой дохиж,

-Би ч чамайг уяан дээр буухад учрыг гадарласаан. Надад ч нэг тийм зөн төрөөд байсан юмаа. Эхийнхээ хээлэнд очсон унага нутгаа гүйдэг гэж сонссон болохоос надад тохионо гэж бодож явсангүй гэлээ. Эрлийн хүн:

-Гарсан нь тэнд болохоос ураг бүрэлдэх нь аргагүй л энд л дээ. Нялх амьтан ч нутгаа санаад гүйдэг юм байна. Хөөрхий, гэхэд Дэмбээ гуай:

-За би ч мордьё доо гээд өндөлзлөө. Бадам:
-За Дэмбээ. Учиргүй өндөлзөж хавчигнаад юу болов. Сууж хуучлаач. Энэ бид хоёр цэргийн найзууд. Ноднин хангай нутгийн адуугаар угсаа сайжруулна гэж байж шарга гүүг минь авсан юм гэлээ. Эрлийн хүн:

-Аан нөгөө над руу утасдаж хэл өгдөг хүн та юу. Нээрээ Дэмбээ гэсэн шүү дээ гэхэд Дэмбээ гуай үг дуугүй гарч одов. Тэдний ярианд чих тавьж суусан Хуурч өвгөн:

-Ээдээ өвгөн би их юм үзсэн. Хол ойр зарагдсан адуу нутаг гүйдгийг ч мэднэ. Гэхдээ ингэж нялхаараа гүйж ирэхийг сонсоо ч үгүй юм байна. Энэ шарга мөн ч ухаантай, мөн ч хурдан адуу даа. Чи гүйж ирэхийг нь нүдээр үзсэн бол. Эх нутаг гэдэг ийм л үнэтэй байдаг байна хөөрхий. Даанч салахгүй эргэж буцаад байсан юм гээд гүнзгий санаа алдав.

Бадам “Эх үрс биесээ таньж байхад эргэлзэх зүйл юу байхав. Шарга даага одоо чинийх. Харин хоноод явна биздээ” гэвэл эрлийн хүн “Эрлээ олсон хойно эртхэн газар дөхье дөө” гэлээ. Аав нь хуурч өвгөн, эрлийн хүний хамт уяан дээр ирэхэд

Галт “Ахаа би шарга даагаа өгмөөргүй байна” гээд тэсэлгүй уйллаа. Бадам хүүгийнхээ толгойг илээд:

-Өгөлгүй яах вэ, миний хүү. Шарга даага нь эх нутагтаа ирлээ. Нутгийнхаа тоосонд уралдаж түрүүлээ. Эр улсын наймаа, наймаа л байдаг хойно гэлээ.

Эрлийн хүн шарга даагаа эхийнх хүзүүнээс холбож аваад мордлоо. Бадам гуай гүйж ирсэн хурдан буян шарга дааганыхаа сүүлнээс хишиг авч хүүдээ өгөхөд Галт даагаа хүзүүдэн уйлав.

Эрэлчин эх, хүү хоёр шаргыг хөтлөн шогшуулж явснаа зам шулуудав бололтой. Мориндоо ташуур өгөн чүү гээд ухасхийлээ. Гэтэл Шарга даага зог тусан эргэцэж төрсөн нутгийн зүг хангинатал янцгаалаа. Эрэлчин золтой л эмээлээсээ ховх татуулчихсангүй.

Эрлийн хүн шарга даагыг ташуурдаж нутгийнхаа зүг давхихыг оролдсон ч даага үе үе эргэцэн захидаж зог тусаад гэлдрэхээс хэтэрсэнгүй.

Эрэлчин мориноосоо бууж:

Энэ адуу нутагтаа үнэн хайртай юм байна. Аваад буцсан ч эргээд гүйх нь дамжиггүй. Хүйн холбоотой нутагтаа үлдэг дээ. Эд эс бүхэнд оршиж байдаг эх нутаг юутай их үнэтэй зүйл вэ? гэж хэлээд шарга даагыг сул тавилаа.

Шарга даага эх нутгийхаа зүг тоос татуулан давхив.

Даага нь хангинатал янцгаан, хатируулсаар ирэх бараанаар Галт урдаас нь тосон гүйлээ.

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар уран, бүтээлийг хураангуйлж бичнэ үү?
2. Зохиолын дүрүүдийн зан чанарын онцлогийг тодорхойлон бичнэ үү?
3. Зохиолд дэвшүүлсэн үзэл санааг тодорхойлон бичнэ үү?
4. “Эх нутаг”сэдвээр эсээ зохион бичнэ үү? / үгийн тоо 250 хүртэл/

Хүн чанарын инээд

Н. Мандал

Манай ангийн Болд хөлөө гэмтээснээс болоод олон хоног хэвтэж эмчлүүлэхээр болов. Уг нь муухай ч, эл мэдээг сонсоод би баярлалаа. Үймээний эзэн, “Дээрэлхүү Дэндгэр” мөд ирэхгүй нь хэмээн баярласан юм.

Тэр том биетэйгээрээ далимдуулан намайг ангийн дарга гэж огт тоодоггүй ганц хүүхэд. Саяхан миний мөрнөөс базаж танихгүй охидын өмнө дүүгүүрдэн зөндөө ичээж билээ. “Уртын харайлтын дүүргийн аваргыг хардаа” гээд л эргүүлээд тохуурхаад байсан. Түүнд гомдох ч багадана!

Гэтэл түүний найз “Ганган Шар” мөнгө цуглуулан эргэх тухай санал гаргав. Ангийн даргын хувьд хүүхдүүдийг зохион байгуулах ёстой ч би шууд эсэргүүцэж, “Тэгснээс кино үзсэн нь дээр” хэмээн хашхирахад бүгд дэмжихгүй хаачих вэ.

Тэгж байтал чөлөө аваад явсан маань ирэв. Жигтэйхэн баргар царайлсан орж ирээд бидэнтэй мэндэлсэн ч үгүй, “Манай Болд хөлөө тайруулахаар болжээ” гэж гунигтайгаар мэдэгдлээ.

Эл гэнэтийн аймшигтай мэдээг сонсоод бүгд надтай ижил дуугарч чадахгүй почирдон ангид нам гүм болоход багш:

- Та нар Болдыг эргэсэн үү? гэж асуун улам цочоов.

Тэгтэл ч “Ганган Шар” энэ л асуултыг хүлээж байсан аятай сандлаа шажигнуулан босоод, “Би эдэнд эргэе гэсэн. Тэгтэл ангийн дарга эргүүлээгүй” гээд суулаа.

Багш дуугаа өндөрсгөн:

- Үнэн үү, Тэргэл ээ? гэж надаас асуулаа.

- Үнэн.

- Яагаад? Яагаад тэгсэн юм бэ? Дуугараач! Чамд хүн чанар байна уу? Эсвэл чи түүнийгээ гээчихээ юу?

Багшийг ийн асуухад эртээдийн дүүгүүрдүүлсэн ичгэвэртэй явдал бодогдсон тул өөрийн мэдэлгүй “... тэр... тэр... хонгилд... “ хэмээн амандаа бувтнаж эхэлтэл:

- Хонгилд оо? Чи хүн чанараа хонгилд гээчихсэн хэрэг үү? гэж гайхаад, “-Гар! Хүн чанараа олоод ир!” гэж тушаалаа.

Өөр хүүхэд багшийн энэ тушаалыг ойлгохгүй. Үнэндээ, би ч ойлгоогүй. Гэсэн ч хонгилд гарлаа.

Ангиудад хичээл орж байгаа тул хэн ч алга. Би зүүнээс баруун тийш тонгойн алхав. Дараа нь урт хонгилыг алхмаар хэмжиж байгаа аятай баруунаас зүүн тийш зугуухан яваад байлаа. Яалаа гэж сургуулийн модон шалан дээр миний хүн чанар хэвтэж байх билээ дээ? Тэр хүзүүнд зүүсэн гинж, халаасанд хийсэн харандаа шиг сугараад уначихдаг зүйл үү? Үгүй шүү дээ!

Тэгээд цонх руу хартал миний гунигтай царай шилэнд тусаж үзэгдэв. Би өөрийнхөө дүрс рүү очоод, “-Чи миний хүн чанар мөн үү? гэж асуулаа. (Зүгээр л тэгсэн хэрэг) Тэгтэл яасан гэж санана? Шилэнд туссан дүрс өөдөөс хачин гомдолтой харснаа:

- Мөөн гээд амаа өмөлзүүллээ.

- Аан? Чи яагаад энд...

- Тэр тухай дараа ярья.

Дүрс ингэж хэлмэгцээ уйллаа. “-Би... би... Болдыг өрөвдөж байна. Тэр их зовж байгаа байх. Эргэж очсон бол баярласандаа эдгэчих хүүхэд шүү дээ...”

Хүн чанарыг ийн ээрэн мэгшихэд би:

- Тиймээ, эргэх ёстой байсан. Миний буруу гэж арай ядан дуугарав.

Хонгил руу ирж яваа хэний ч юм хөлийн чимээ сонсдоход Хүн чанарын уйлах дуу улам чангарлаа. Би зовсондоо шилэнд туссан уйланхай дүрсээ халхлахаар нүүрээ наав. Чингэтэл ч магнай хавьцаа зүггүй эрвэгэнэн нүд бүрэлзэж, хамар шархирлаа. Ам жигтэй өмөлзөн хоолой зангирахад нулимсаа бушуухан шудраад анги руугаа гүйн оров.

Багш хичээлээ ярьж байсан ч надаас:

- За яав? Хүн чанараа хонгилоос олов уу?” гэж аяархан асуув.

- Тийм ээ, багшаа, хичээлээ тараад цөмөөрөө эмнэлэг рүү явцгаая?

Ингээд бид Болдын хэвтэж байгаа эмнэлэг рүү гүйцгээсэн юм. Болдтой уулзаж чадаагүй ч эмч нь, “Түүнд хагалгаа хийнэ, гэхдээ хөлийг нь тайрахгүй” гэж хэллээ.

Үүнийг сонсоод зүрх учиргүй булиглахад ам айхавтар том ангайн би өөрийн эрхгүй чангаар инээж хацрыг минь даган нулимс урсав. Тэгэхэд би

ХҮН ЧАНАР инээж байна даа гэж таасан. Хүүхдүүд ч яг над шиг амаа ангайгаад нулимстай инээж байсан. Багш өөрөө нулимсаа арчих хэрнээ, “Битгий уйлцгаа... баяртай явдал... битгий уйл” хэмээн бидэнд сануулж байлаа.

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураингуйлан бичнэ үү?
2. Зохиолд зохиомжийн задлал хийнэ үү?
3. “Чиний бодлоор хүн чанар вэ?” сэдэвт эсээ бичнэ үү? /үгийн тоо 250 хүртэл/

IV бүлэг. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол - уран сайхны болон баримтат тууж

Хорвоотой танилцсан түүх

Л. Түдэв

Оршил

Хорвоод бид хоёр мэндлэлцсэн тэр цагаас эхлээд нэг тал би, нөгөө талд хорвоо эсрэгцэн орших болов оо. Намайг өмссөн цамц ч үгүй гар хоосон төрөхөд хорвоо яндашгүй баян байлаа. Би энгийн хялбар амьтан төрж байхад хорвоо ээдрээтэй нарийн ертөнц байлаа.

Хорвоо нууц. Хорвоо сүртэй. Би нялх. Би гэнэн. Гэвч би хорвоог таних ёстой. Хорвоо бол намайг таних хэрэгцээгүй байж. Хорвоог таних гэмээж нь миний төрсний хэрэг бүтэх учиртай юм санж. Тэгээд би ээж, аавын заяасан бие сэтгэлийн эрдмийг нээгдүүлэхээр хорвоогийн учрыг танин мэдэх аянд гарч дээ. Тэр аян төгсгөлгүй урт, нэг нас богинодож, нэг бие хэврэгдэх байж. Тэгэвч аянаас зүрхшиж, алжаалаас айлгүй одсон эцэг өвгөдийн зам намайг хөтөлжээ.

Над таван сайн зэвсэг байлаа. Ихийг үзэж ихийг сонс гэж нүд чихийг хосоор, бага чалч гэж амыг нэгийг заяажээ. Зэвсгээ тийн агсаад би танин мэдэхийн аянд гарсаар гучин гурав дахь жилдээ явж байнам.

Анх намайг харахад хорвоо үлгэрийн орон шиг байжээ. Хүүхдийн нүдээр би түүнийг харж дээ. Одоо над хорвоо гэгч гэр шиг минь үзэгднэм. Хожмын нэг өдөр хорвоо над таван хуруу шиг минь бодогдох болуужин.

Танин мэдэхийн их аян өлзийтэй болтугай.

Эхлэл

Энэ түүх арван зургаадугаар жарны цагаагчин гахай жилийн шиний наймны үдэш эхэлжээ. Тэр үдэш тэр эгшинд хорвоогийн ам бүл нэгээр нэмэгдэж хоёр миллиард таван зуун гучин гурван сая дөрвөн зуун наян ес болжээ. Хорвоогийн эр хүний тоо мөн нэгээр өсөж дахин нэг хүлэг морин эмээл хазаартайгаа хэрэгтэй болжээ.

Энэхүү өгүүлэгдэн буй намтар түүхийг бүтээгч тэр эр хорвоог танилцсан эхний зургаан жилийнхээ явдлыг өөрөө эргэн санахгүй юм билээ. Эхлээд уйлж сурсан юмсанж. Уйлахаараа айлгаж хоол олж иддэг юм байждээ. Удахгүй инээмсэглэж, тэгээд уурлаж, тэгснээ мөлхөж төдөлгүй явж улмаар ярьж сурсан бололтой. Тэгээд л зураг зурж сурсан юм байх. Анхны бүтээлүүдээ шороонд хоцроосон тул архивт үлдээгүй юм гэдэг.

Нялх оюунд тогтож үлдээгүй тэрхүү зургаан жилийн явдлыг ээж нь хожим цухас цухас дурссан билээ.

Нэг өдөр нарны талыг үүл халхалчихсан байхыг чи үзээд :

-Ээжээ нар хэмхэрчихсэн байна гэж их л санаа зовон хэлж билээ. Бас нэг өдөр эмгэн ээжийгээ уул даваад явахыг үзмэгц уйлганаж,

-Ээжээ, буурал ээж тэр уулын цаад руу өнхрөөд орхичихлоо гэж билээ. Чи бяцхан цагаан явуугаар тоглодог байлаа түүнийгээ амандаа үмхэж яваад залгичихжээ. Шөнө дунд түүнээ санаж уйлсан юу болов гэхэд гэдэс рүүгээ зааж,

-Явуу минь энэ рүү орчихсон гэж гаслан уйлж билээ. Хуурсан тариа тээрэмдэж байтал өг гэж ууртай нэхэв. Зодчихоод ав гэж тоглоход үнэмшиж, залтасны хэлтэрхий авч ирээд намайг нэг цохиж аваад дараа нь тариа авахаар хоёр гараа сарвайв. Тэгэхдээ баганын хоёр талаар тэвэрч тоссон юмсан. Нэг атга тариа аваад буцах гэтэл багана тээглэж хоёр гараа салгая гэтэл тариагаа асгачих болж их сандарсан билээ.

Энэ мэт олон учрал хэрэг төвөг тарьж явсан тэрхүү зургаан жил өнгөрөхөд мань эр юу хийж, хэлж явснаа өөрөө мартахгүй болсон юм санжээ.

Чулуутай танилцсан түүх

-Ээжээ, над тоглоом өгөөч ! гэж би нэг өдөр гуйлаа. Ээж :-Гол дээр оч тэнд чиний тоглоом бэлэн бий гэв. Би гол руу явлаа зуны дунд үед бараг усгүй болон хатдаг мөртлөө хаврын дунд сард хавь ойрыг усаар ундалж, эргээ халин шуугин шаагьдаг уулын догшин зантай голын хөвөөнд манайх өөдөө уруугаа нүүдэллэн нутагладаг байлаа. Намайг гол дээр очиход айлын хүүхдүүд ямар нэгэн юм ирэх мэт чулуун дунд доош бөхийн явцгааж байлаа.

-Та нар юу хайж байгаа юм бэ? гэж сониучлан асуув.

-Тоглоом гэж тэд нар ам амандаа товчхон хариуллаа

-Ямар тоглоом гэж асуувал

-Ийм тоглоом гэж нэг жаал жижигхэн дөрвөлжин чулуу үзүүлэв. Тэр чулуу ногоон алаг атлаа наранд гялтагнан гялалзсан дөрвөлжин толботой байв. Тэр мэт сонин хачин чулуу байдаг гэдэгт би үнэмшиж ядан барьж үзлээ.

-Энэ бол авдар шүү. одоо манайх хамгийн гоё авдартай айл болно гэж тэр чулууг олсон хүү гайхуулав.

-Голын чулуун дотор байхгүй юм үгүй. Авдар сав, аяга, дээл, боов, чихэр, морь, тэмээ, цөм бий гэж нэг охин гэж ярилаа

-Би хүүхдүүдийг дуурайж чулуун дотор хайгуул хийж эхэллээ. Анхандаа над юу ч олдсонгүй үүнээс гадна чулуун дотор бүдчин яваад хөлөө шалбалж уйлав. Хүүхдүүд намайг тойрон ирж

- Битгий уйл, чулуун дотор эвтэйхэн гишгэж сур. Чулуу их ууртай шүү гэж нэг охин сануулав.

-Би өвдсөндөө уйлаагүй. Надад тоглоом олдохгүй байна гэж өчлөө. Тэгтэл миний танил цоохор хамартай жаал

-Наад хөлийн чинь хажууд нэг морь байж байна. Сайхан цагаан морь гэв. Авч үзвэл морьтой яг адилхан хэлбэртэй цагаан чулуу байв.

-Нээрээ яасан хөөрхөн морь вэ гэж хүүхдүүд шохоорхлоо.

-Чи энэ морио миний тэмээгээр сольчих гэж нэг өөр хүүхэд хоёр бөх шиг сэрэвгэр юмтай хөх чулуу үзүүлэв.

-Чиний тэмээ ноос нь зулмарчихсан юм байна гэж өөр нэг жаал хэлэв.

-Яагаад гэж нөгөө нь гайхав.

-Яах вэ дээ Хөх өнгөтэй байна. Тэмээний ноос зулмарчхаараа ийм цэлдэн хөх арьс гардаг шүү дээ гэж тэд маргав. Энэ бүхэн надад үнэмшигдлээ. Голын чулуун дотроос анх удаа бяцхан хар толботой цагаан морь олдов. Үүндээ урамшин үдийн хонь хотолтол гол дотор тэнэв. Хормой дүүрэн чулуун эдлэлтэй буцаад ирж явахад хүмүүс дайралдан толгой сэгсэрч

-Дээлийн хормой яаж тэснэ

-Мөн олзтой эр ээ гэх мэт ярьцгаав. Ээж намайг хараад инээмсэглэж

-За тэр шүү, Гол дээр тоглоом их байгаа биз гэв. Би

-Зөндөө байна. Ээж ээ би хонь саасны дараа гол руу явъя гэж гуйлаа.

-Яв яв.

Миний хормойлж ирсэн чулуун дотор юм бүхэн байлаа. Хоёр дөрвөлжин чулууг авдар гэв. Хэдэн дугариг чулууг таваг, тогоо, аяга, шанага болгов. Өнгө өнцгийн гулуузан чулуунууд дээл боллоо. Үдээш хойш нөгөө цоохор хамарт найз маань ирж,

-Хоёулаа манайд очъё гэв

-Танай ааваас айж байна гэв. Учир нь цоохор хамартын аав нь бавайсан сахалтай аймаар хүн байдаг юм.

-Би өөрөө аав байхгүй юу гэж тэр хүү хэлээд

-Надаас чи айж байна уу хэмээн гараас минь хөтлөн явлаа. Гэр лүүгээ биш өөр зүг рүү явсан би гайхав. Голын хөвөөний сайхан ногоон зүлгэн дээр ирлээ. Ногоон зүлгэн дээр торгны хээ шиг дугуй алаг юмс үзэгдлээ. Тэдгээрийн хамгийн захынх дээр ирвэл өнгө өнгийн чулуу дугуйруулан өржээ.

-За энэ манайх гэж найз минь хуруугаар зангаснаа,

-Харахгүй юу. Тэр манай хар халтар нохой хэвтэж байна. Манай нохой их ууртай шүү. Зууж мэднэ гэснээ гарныхаа салаанд буй морь шиг чулууг газарт шигтгэж,

-Нохой хорь гэв. Тэгээд өөрөө

-Нохой зуухгүй ээ. Уяатай гэж хариулав. Над руу хандаж,

-За хоёул мориноосоо бууж манайд оръё гэв.

Чулуугаар ингэж гэр барьж тоглодог ажээ.

-Манай хүүхдүүд тэр тоглож байна гэж гадаа хажууд байгаа арван хэдэн жижигхэн бөөрөнхий чулууг заав. Тэгснээ хөмсгөө зангидаж, хэдэн жижигхэн бөөрөнхий чулуу заав. Таван салаа боов идэх үү? гэж сүртэй дуугарснаа олон бөөрөнхий чулууны хамгийн багыг зааж,

-Хараач, тэр муу Болд айж байна гэв,

Болд гэж нэрлэсэн чулуу нь огт хөдлөхгүй байлаа. Тэгтэл хөрш айлын охин гүйн ирж,

-Батаа чи яагаад хүүхэд загнаад байгаа юм бэ? Эвий муу Болд чи битгий уйл за юу? гэж нөгөөх Болд гэж нэрлэсэн чулууг аргадав.

Болд чулуу хөдөлгөөнгүй хэвээр.

-Энэ манай авгай Дэжид гэж Батаа нөгөө охиныг зааснаа,

-Дэжээ чи цайгаа хийгээч, зочин ирчхээд байхад яасан шившигтэй юм бэ? гэв. Дэжид шалавхан хөдөлж гэрийн төв дунд газар хатгасан шовшор чулуунууд дээр тогоо мэт дүгрэг чулуу тавив. Дараа нь нунтаг цагаан чулуу авч уур шиг юманд хийгээд нүдэж эхлэв. Бат болохоор авдар гэгдсэн дөрвөлжин чулуун дээрээс нарийхан цагаан чулуу авч амандаа зуугаад сорьж, тамхи дуусчихаад туулайн баас татаж байна хө гэж ярив. Энэ бүхэн над үлгэр мэт бас тэгээд бас яг л үнэн юм шиг санагдлаа. Даруйхан өөрийн гэртэй болж, эхнэр аван хүүхдүүдээ хотоос боов авчирч өгөхийг хүсэв. Тэр зуур айлын хүүхдүүд цугларан ирж тус тусын чулуун гэрийг эзгэнэн сууж хөл хөгжилтэй тоглоом эхэллээ.

Хүүхдүүд бие биендээ айлчилж бэлэг авч, наймаа хийж тоглоно. Энэ өдрөөс эхлээд би голын чулуун дунд өдрийг өнгөрөөх болов. Гэртээ үзсэн болгоныг чулуун дотор хайв. Тэг тэгсээр юм бүгдийг олж чулуун гэртэй болов. Гэтэл авгай олдсонгүй. Хүүхдүүд гэвэл бараг хориодыг оллоо. Голын усан дотор хүүхдүүд их байдаг ажээ. Элэгдэж мөлчийсөн бөөрөнхий чулуу бол хүүхэд ажээ. Манай гэрийг Бат барилцаж өгөөд. За яах вэ?, чи манай эхнэрийг ав би өөр авгай олно. Дэжид чи үүний авгай бол, за юу? гэв.

Дэжид: - Чамд торгон дээл бий юу? гэж асуув, Би дөрвөн гонзгой чулуу олсон байх тул түүнийгээ үзүүлж: Энэ байна гэв.

Дэжид:

- Тэгвэл чи намайг аймагруу дагуулж явж байх юм уу? гэв.

- Байна байна.

Энэ болзлыг зөвшөөрсөнд Дэжид манайд шилжин ирлээ. Батаа болохоор дүү Лхагвагийг гэртээ аваачив. Ингэж би олон хүүхдүүдтэй том цагаан гэртэй болж, толгой дээрээ хоёр сөрвөгөр сонжуутай авгай авлаа.

Аяа, би хорвоо чамтай чулуугаар анх танилцаж дээ. Чулууны өнгө нь тоолж баршгүй олон. Улаан, ногоон, шар, бор, хөх, хүрэн, цагаан чулуунууд дангаар болон холилдон оршино. Чулуу бас зөөлөн хатуу, халуун хүйтэн, иртэй иргүй байдаг юм билээ. Голын усанд элэгдсэн бөөрөнхий чулуу бол мөлчгөр зөөлхөн бас бүлээхэн эелдэг байна. Өндөр уулын орой дахь чулуу мөн салхинд элэгдэн зөөлөрсөн боловч хүйтэн байна. Харин асганы чулуу юунд ч элэгдээгүй учир хатуу, хурц бас хүйтэн байдаг. Батаа бид хоёр өдөр ирэх тусам шинэ шинэ олзтой байдаг боллоо. Нэг өдөр дотроос нь хөвөн шиг юм цувдаг тийм сонин чулуу олов. Гэтэл манайд хот газраас нэг зочин ирлээ. Тэр зочин том хүн мөртлөө бас л чулуунд дуртай хэвээрээ байжээ. За миний дүү нар та нарын тоглоомыг үзье? гэж тэр гуйлаа. Бид түүнийг дагуулан чулуун гэр дээрээ авчрав.

-Пээш яасан баян хүүхдүүд вэ? гэж тэр хүн уулга алдан баярлав. Батаагийн тоглоомон дотроос нэгэн чулууг тэр хүн авч сониучирхан үзэхэд.

- Ах аа та манай авдараар яахан вэ? гэж Батаа дургүйцлээ. Өө энэ манай авдар юм уу? Чи зөв нэрлэж дээ. Энэ чинь эрдэний авдар байна гэж тэр хүн амандаа ярих зуур өврөөсөө жижиг алах гарган гялс хийлгэн тогштол. Батаагийн авдар тал дундуураа хагарлаа. Батаа:

-Ахаа , авдрын минь яагаад хагалчхав гэж гэнгэнэн уйлав. Өнөө хүн Батаагийн толгойг илж, “битгий уйл би чамд өөр авдар өгнө” гэж өврөөсөө жижигхэн модон шоо гаргаж өгөв.

Үүнд: Батаа тайвширлаа. Тэгтэл тэр хачин хүн манай гэрт ирж нүдээ бүлтийлгэн харснаа гадаа хураалгаатай байсан чулуунаас хэдийг авлаа. Ахаа та шуудайтай ноосоор яах нь вэ гэж би гайхлаа, Өнөө хүн,

-Өө хө, энэ танай шуудайтай ноос юм уу? бас л зөв нэрлэж дээ. Тэгээд энэ ноосоо хоршоонд өгөхгүй яасан юм бэ? гэж асуув. Аагинт ирээгүй байна. Тэгвэл би аагинт болъё үүнийг чинь хоршоонд авъя оронд нь ёотон өгье. Ээ харлаа ахад нь ёотон байхгүй гэснээ тэр хүн өвөрөө ухан хачин дугуй шилтэй юм гаргаж ирээд шуудайтай ноос руу минь удтал гөлрөн ширтээд дотроос нь гарч буй ноолорсон юмыг имэрч үзэв. Сайн ноос байна даа гэж амандаа ярив. Тэгээд над руу хандаж за чи ноосоо над тушаа, оронд нь энийг ав. Энэ бол

шидэт дуран юм. Үүгээр чулуу шинчилдэг билээ. Чи сайн шинжээч болоорой чулуунаас алт, эрдэнэ, мөнгө гаргаж авдаг юм. За, чи үүгээр хар гээд дуран шиг юм аа надад өгөв. Үүгээр нь чулууг ажиглан үзвэл маш тодорч харагдах ажээ. Нээрээ шидэт дуран бололтой. Чи энэ хар хорхойг наадхаараа хар гэж өнөөх хүн хэлэв. Хорхой бараг л эрхий хуруу шиг болж үзэгдэнэ. Би баярлаж шуудайтай ноосоо тэр ахад цөмийг тушаав. Тэгтэл: - Та нар үүнийг хаанаас олсон бэ? зааж өгөөч гэж өнөө хүн гуйв. Бид зааж өгсөн. Тэр том хүн мөртлөө чулуугаар тоглох дуртай хачин ах байж билээ. Бидний тоглоомон дотроос нэг сайн дайлан чулуутай болоод тэр ах буцсан. Буцахдаа за миний дүү нар, чулууг харж байгаарай. Чулуу бол эх орны чинь элэг зүрх юм гэж тэр захив. Тэр хүний тухай ээжээс асуухад тэр хариулсан нь:

-Аа тэр чинь гийлогч хүн гэнэ. Чулуунаас эрдэнэ олдог хүн гэнэ. Бид түүнээс хойш гийлоогч болж тоглодог сон. Хожим дуулбал тэр хүн бидний тоглоомон дотроос зэс, төмөр, хар алтны хүдэр олсон гэгцгээж байв. Аяа би хорвоотой чулуугаар анх танилцаж дээ. Чулууг би гартаа атгамагц танидаг. Зун намрын зургаан сард хөл нүцгэн явдгаас чулууны авирыг хөлийн тавхай минь гараас илүү мэддэг байж дээ. Чулуу бид хоёрын нөхөрлөл улам гүнзгийрлээ. Нэгэн өдөр доод саахалтын дэггүй шар гэдэг том хүүхэд бидэн дээр ирж дундаа бариул мэт илэг оёсон урт сур үзүүлж

-Үүнийг та нар мэдэх үү? дүүгүүр гэдэг юм. Харж бай гээд манай гэр дотроос Дэжидийн дээл болох гонзгой хүрэн чулуу авч, нөгөө дүүгүүрийнхээ элгэн хавчаарыг толгой дээгүүрээ хэд эргүүлмэгц сурны нэг үзүүрийг тавьсанд жингэнэсэн сонин дуу гарч, Дэжидийн дээл сэнс мэт эргэлдэн нисэж одов. Тэртээ урд энгэрт яс хэмлээд хэвтэж байсан нохой зүг тэр сум нисэн одов. Төдхөн нөгөө нохойны хэмлэж буй ясан дээр тас хийн суулаа. Нохой ган хийн гасалж сүүлээ хавчин ухаан зүггүй зугтааж одов. Дэггүй шар инээж. Хохо шар ах нь шарсан мах андахгүй гэж гайхуулснаа Та нар балчир байна. Чулуугаар чинь ингэж тоглодоггүй юм. Чулуу чинь тоглоом биш зэвсэг чулуугаар дүүгүүрдэж туулай харайлгаж тоглодог юм. Бид нар тэгээд чулуугаар зэвсэг хийх болов. Бид чулуугаар хонь, үхэр шидэх болов. Зурам, хулгана руу ч бэлэн чулуу ч илгээх болов. Өндөр уулын оргилоос чулууг доош өнхрүүдэг болов. Чулуугаар малын хашаа хороо барьдагийг мэдэв. Хожим сургуульд ороод Чулуун зэвсгийн үе гэж багшаас сонсов. Тэгээд чулуугаар зөвхөн би ч биш хүн төрөлхтөн өөрөө хорвоотой танилцсаныг ухааран мэдэрч билээ. Бүр хожим нь чулуугаар хөшөө дурсгал босгодгийг мэдлээ. Нутгийн маань өндөр давааны майныг эцэг дээдсийн өв дурсгал хүн чулуун хөшөөнөөс эхлээд аугаа Пушкины хөшөө хүртэл чулуугаар бүтсэнийг хүртэл мэдэж чулуунд бүр ч бишрэн дурлаж билээ. Аяа чулуу чи ертөнцийн хөрсөнд ургасан хатуу цэцэг юм билээ.

Дуутай танилцсан минь

Аав нэгэн өдөр авдрынхаа арын хонгилоос нарийхан шар алаг хөндий мод гаргаж ирлээ. Хөндий хулсан савааны бөөрөн дээр нь хэдэн нүх гаргасан байлаа. Аав түүнийгээ хөндлөн барьж, бөөр лүү нь нэг үлээж үзсэнээ, хурууныхаа өндөгнүүдийг шилэмдэж чийгэллээ. Дараа нь хулсан савааг хөндлөн барьж, нүх бүр дээр хуруу бүрийн өндгөөр дарж, уруулаа урагш үлээж эхэллээ.

Эхлээд салхин уяхнаа исгэрэх мэт дуу гарч, төдөлгүй огцом өөрчлөгдөн усны урсгал адил болж, миний урьд өмнө хэзээ ч сонсож байгаагүй тийм сайхан дуу гарлаа. Аавын гарын хуруунууд хулсан савааны бөөрөн дээр ээлж дараалан цовхин бүжих мэт дэгдэн товшиж, дууны аялгуу нь тэрийг дагалдан хувирч байлаа.

Хөндий тэр хулс, аав хоёр тоглон наадаж, бие биеийг хөөцөлдөн, барин тавин байх мэт санагдана. Аавын хуруу хулсан саваанаа буухад тэр нь баригдсандаа баясан инээх ба эсвэл гомдон гаслах, улмаар чарлан зүггүйтэх мэт ажээ. Тэрхүү хулсан савааны гаргаж байгаа дуу нь зуны сарын ногоон ой хөвч шуугин исгэрэх шиг, цавчим элгэн хаднаас булгийн тунгалаг ус хоржгонон буух шиг тэгснээ хөвчийн өндөр модонд хөхөө шувуу хавшин донгодох мэт, хан уулсын цэнхэр оргил дээгүүр усны шувуу гангар гунгар нисэн ирэх мэт санагдана. Өвөөлж бөвтнөж, хойлог ёолж, шар шувуу уухилж, шаазгай шагширч, хэрээ гуагалан, элээ унгалдахыг ч би тэрхүү хөндлөн модноос сонслоо.

Намрын хонгор салхинд өвсөн толгой шуугин давалгаалах, хонь мал төллөн хурга ишиг эхтэйгээ нийлэхэд, хадны цуурай тэднийг дуурайн майлах мэт дуу авиа ч бас л тэрхүү хөндлөн модноос сонслоо.

Миний өчүүхэн бор зүрх уяран хайлж, бадран догдолж, баясан цовхчиж, туранхай цээжний минь чанад багтаж ядан, донсолж байлаа. Тэрхэн мөчид би хамаг бүхнийг мартаж, гагцхүү эцгийн эвэрлэг арван хуруу хулсан саваанаа дэгдэн наадахыг л ажиглан суулаа. Аавын духнаа гарсан гүнзгий атирааг дагаад хөлс дааварлан гялтганаж, уруул нь үл мэдэн чичиргэнэн, нүдний нь харц алсын алсыг ширтсэн мэт намуухан болжээ.

Нэг мэдсэн харанхуй нөмрөөд орхих мэт хачин жигтэй, бас ч зэврүүхэн болжээ. Аав тоглохоо зогсоосноос, тэр мэт хачин сэтгэгдэл төрлөө.

- Аав аа, энэ чинь юу юм бэ? гэж би сая ухаан орсон адил гайхан асуулаа.

- Лимбэ гэдэг хөгжим. Үүгээр орчлон хорвоогийн дуу чимээг үйлдвэрлэдэг юм гэж аав шоглох мэт хэллээ. Аав үйлдвэрийн ажилчин болсноос хойш тэгж үйлдвэр гэхчилэн ярьдаг болчихсон юм.

- Аав аа юутай сайхан юм бэ? Над зааж өгөөч гэж би гуйлаа.

- Өөрөө оролдож сур. Тэгвэл сурах эсэх нь мэдэгдэнэ. Өөрөө оролдоод чадахгүй бол, түүнд авьяасгүй гэж мэдээрэй. Энэ ярианаас хойш би лимбэ гэдэг хөндий савааг толгойгоо дүйртэл үлээж, сар шахам боллоо. Тэр лимбэнээс ямар нэгэн дуу гарахгүй биш, гарч байна аа. Гэхдээ өвлийн шөнө хотны захад чоно улих юм уу, эсвэл гадаа тавьсан данхны цоргоор салхи орох үед юу дуулддаг билээ? Тэр мэт дуу авиа гарч байлаа.

- Яршиг, дамшгаа минь толгой эргэж гүйцлээ.

- Чихний улиг барлаа гэж, эмэг ээж, залуу ээж цөмөөрөө уцаарлаж байлаа. Тэр бүхэнд би шантарсангүй. Лимбэ үлээн ёнгинуулсаар байтал, ээж нэгэн өдөр намайг дуудаж:

- Миний хүү, би чамд өөр сайхан хөгжим зааж өгье. Энэ лимбэ чинь чих дөжрөөчих золиг байна, орхи! гэвээ. Ээж маань чүдэнзний хайрцагнаас арай жижигхэн дөрвөлжин хулсыг буйлан дотроосоо гаргаж ирэв. Тэр дөрвөлжин

хулсны голд нүхэлж хоёр нимгэхэн хэл шиг юм зоогоод нэг үзүүрт нь урт шар утас бэхэлжээ. Ээж:

- Аман хуур нэртэй юм гээд, нөгөөх дөрвөлжин хулсаа амны хөндийд байрлуулж, тагнай хэл хёрын хооронд тогтоогоод, утасны үзүүрээс чичрэгнүүлэн татаж нэг чангалан, нэг султгаж уруулаа хөдөлгөн наадахад, аавын лимбэнээс дутахгүй мөртлөө намуухан дуу гарч эхлэв. Тэр дууны сайхан нь миний сэтгэлд таатай чихэнд чимэгтэй байлаа. Ээжээс бяцхан холдъё гэвэл, тэр аман хуурын дуу сонсогдохоо болино.

- Миний хүү чамд энэ ямар санагдаж байна? гэж ээж надаас асуув.

- Сайхан байна. дуу нь жаахан бүдэг юм.

- Аав чинь бас л сайхан дуутай юм байна гэж аман хуурт дурласан. Хуураа татаач гэж үргэлж гуйдаг сан. Тэгээд аман хуурын дууг бүдэгхэн байна гэж, хацарт минь хацраа наан чагнадаг сан, гэж ээж яриад, санаа алдаж, миний толгойг иллээ. Тэр цагаас хойш би дуунд дуртай боллоо. Аавын лимбэдэхийг, ээжийн хуурдахыг сонсох бүрий сэтгэл уярч, хоолой дээр минь бөөн юм зангиран ирдэг сэн. Тэгээд би хөгжимчин болохыг хүсэв. Нагац ахынд айлчлан очихдоо, өөр нэгэн хөгжимтэй танилцлаа. Нэгэн үзүүрт нь илгэн бүрээстэй лааз бэхэлж, нөгөөд нь хөндлөн бариул зоож, хооронд нь адууны хялгас татсан тийм хачин юм нагац ахын авдар дээр байхыг, би олж үзээд, юу гээч эд болохыг мэдэх хүсэл хязгааргүй буцлаад, аргагүй суулаа.

- Бисаанз гэдэг юм. Дуу гарна гээд, нагац ах тэр хачин багажаа авч, лаазтай талаар нь өвдөг дээр тавьж, нум шиг юмаа хөрөөдөж зүүн гарын хурууг дээш доош гүйлгэж эхлэхэд, мөн л урьд сонсогдоогүй уяхан дуу гарлаа. Бисаанзны дуу нь лимбэнийхийг бодвол нарийн бүдүүн янз бүр болохдоо чадварлаг ажээ. Миний сэтгэл бисаанзанд татагдан автагдлаа. Аав түүнийг мэдээд, надад бисаанз хийж өгөхөөр амлав. Хэд хоногийн дараа бисаанзнаас салахаа байлаа. Тэгтэл буурал аав манайд айлчилж ирэв. Би түүнд бисаанзаа гайхуулан үзүүлэхэд,

- Пийш, яасан сайхан бисаанзтай юм бэ? аль вэ аав нь даръя гэж ухасхийн бисаанзыг авч хяхтнуулан хөрөөдлөө.

- Өвгөн та хөгий нь тааруулаач! гэж манайд ирсэн өөр нэг өвгөн хэлсэнд:

- Харин тааруулахаар л ядаж байна даа! гээд буурал аав бисаанзны чихийг дураараа мугшиж гарав. Маргааш өглөө босож үзвээс бисаанзны иш углуургаараа хугараад, амьгүй могой шиг гульжийж хэвтлээ.

- Чихийг нь хэтэрхий мушгиснаас, их биеэ хуга даржээ! гэж нагац ах өгүүллээ. Бисаанзаа засуулж авах гэж аймгийн төв орлоо. Аав аймгийн төв дээр мужаан хийж байсан юм л даа. Бааст гэдэг ногоовтор нүдтэй зузаан уруултай жаал шанага цохиж, пиржигнүүлэн дуугаргаж, нөгөө гараар ишин дээрээс нь атган, хуруугаар дарж байлаа.

- Юу вэ, жаал аа? гэв.

- Мандолин хөгжим гэж мэдэх үү? Чам шиг нусгай үүнийг шанага гэж андуурна л даа хэмээн тэр хүү ёжлов. Тэр даруй би түүний шавь боллоо. Түүнд би нэг сайн чавх өгч, дээр нь хөөрхөн шар шил нэмэр болгов. Бааст түүнийг дуртайяа авч, надад багшлах болов. Миний зүүн гарын дөрвөн хурууны өндөг төдөлгүй цэврүүтлээ. Хөгжмийн утсанд хүрэхэд, халуу шатан

өвдөнө. Гэвч хөгжимд дурлах сэтгэлийг минь зуурдын өвчин дийлсэнгүй. Цэврүү нь эвэр болон хувирлаа. Эвэр өндөгтэй болсноос хойш мандолин дарах хорхой минь улам нэмэгдэж, байж сууж ядах болов. Хоёр дууг сайн мандолиндаж сураад байтал, гай тохиолдлоо. Гарын хурууны чилэхийг мэдэхгүй тоглож байтал, жингэнэх дуун сонсогдож мандолины нэгэн утас нь тасран нисэж одлоо. Бааст бид хоёр гаслан уйлав. Тийнхүү над хөгжимчин болох аз дутжээ. Хөгжимнөөс сонирхолтой нэгэн юмтай, яг тэрхүү мандолины утас тасарсан чөлөөнд, учран тохиов. Тэр бол зураг байлаа. Зураг хөгжмийг ялж биш, хөгжмөөс зурагт урваад дахин түүнтэй учирсангүй. Тэгээд би эцгийн адил лимбэ хагас дуугаргадаг төдийгөөр хөгжмийн боловсролоо дуусгажээ. Гэвч би хорвоогийн уяхан дууг хөгжмөөр дамжуулан мэдэрснээ үл мартав.

Зурагтай танилцсан минь

Жаалхүү гэдэг өвгөнийх олон хүүхэдтэй айл байв. Нэгэн өдөр тэдний хамгийн том хүүхэд гэрийнхээ гадаа завилж суугаад, өвөр дээрээ дөрвөлжин мод тавьж ямар нэгэн юм хийж байхыг харлаа. Юу хийж байгаагий нь үзэх сэн гэхээс тэсэж суух аргагүй болов. Ороо хонь барих гэж байгаа юм шиг сэм сэмхэн гэтсээр, тэр хүүхдийн ар талд очоод өнгийн харвал онц сонин юм үзэв. Модон самбар дээр үнс түрхжээ. Нарийхан үзүүртэй савх модоор үнсэн дээрээ нааш цааш зурж байгаагий нь харахад гайхмаар ажээ. Даваасамбуу гэж тэр хүүг нэрлэдэг юм. Даваасамбуугийн гар нь нааш цааш уяхнаар хөдлөх бүрийд үнс түрхсэн самбар дээр дүрс гараад ирлээ. Бух урд хөлөөрөө газар цавчлан хэлээ унжуулан туужуу мэт сүүлээ хондлой дээрээ агсжээ. Даваасамбуу намайг ар талдаа ирээд ажиглаж байхыг мэдсэнгүй. Цааш тавтайяа үргэлжлүүлэн зурсаар байв. Удаж төдөлгүй дахиад нэг сарлагийн бух зурчихлаа. Хоёр сарлагийн бух өөд өөдөөсөө харж сааглан мөргөлдөхийг завдаж буй ажээ. Би тэр сонин зургийг нүдээ бүлтэртэл гөлрөн зогсож хамаг юмыг нэгэн агшнаа мартжээ. Модон дээр модоор тэгж сайхан зурж болдгийг анх удаа тийнхүү мэдэж авлаа. Гол нууц нь модон самбар дээр түрхсэн аргалын үнс гэдгийг нь би мэдлээ. Даваасамбуу гэв гэнэт нөгөөх зургаа үнс асган балласанд би харамсаж “хүүе битгий” гэж алдав. Даваасамбуу над руу эргэж харснаа ухасхийн боёож гэрийн зүг одлоо.

Санамсаргүй нээж олсон нууцаа туршиж үзэхээр би гэрийн зүг салхи мэт дэгдэн одлоо. Гэрт орж ямар нэгэн дөрвөлжин мод хайж гарлаа. Гэрт хэн ч үгүй тул дураараа загнах эрхтэй байлаа. Гай болоход гэрт нэг ч хавтгай мод байсангүй. Цорын ганц боломжийн мод гэвэл өрөм хатаадаг тос нэвчсэн бор мод эргүүл дээр байв. Хэсэг эргэлдсэний эцэст би тэр модыг олзлон авч тулганы захаас аргалын цагаан үнс хайж олоод дээр нь нунтаглан түрхэв. Дөрвөлжтэй түлээ дотроос бяцхан мод олж хутгаар үзүүрлэв. Зурах ажилдаа оров. Сарлагийн бух зурж эхлэв. Даваасамбуу шиг уран зурах гэгч огт хялбар биш ажил байжээ. Хөлсөө урстал ноцолдоод хөрш айлын нэг бух зурах гэж улайран сууж байтал, гэв гэнэт хацар дээр халуун оргив.

- Чи яагаад өрөм хатаадаг мод бузарлав. Ээжид чинь хэлж турсагы чинь хуулуулна даа! гэж загнах дуунаар өндийн үзвээс авга эгч зогсож байлаа. Бид нар авга эгчийг “Айдаа” гэж авгайлна. Харин хүмүүс “тарган” гэж дуудна. Нэр хоч хоёр нь яг адилхан тийм хүн манай тэр голд ганцхан Айдаа байж дээ.

- Айдаа, энийг хараа, юу вэ? гэж зурсан зургаа заалаа.
- Аль вэ, яагаав Донтор л байна гэж Айдаа хөхөрч гарав. Донтор гэж хөрш айлын доголлон халтар нохойны нэр л дээ.

-Донтор биш ээ. Ааяа Балдангийн халзан бухыг зурсан юм гэж би ярьсанд Айдаагийн инээд улам хүрч бүр сүүлдээ эвхрэн ойчоод нүдний нь нулимс цувж, цээж нь хэрчгэнэн хөхөрсөөр байлаа. Айдаа инээдээ барьж чаддаггүй. Тийм хачин хүн л дээ. Түүнийг хөхөрч хэвтэх хоорондуур би гарч зугтаалаа.

-Үнс түрхсэн самбараа аргал доор нуув. Түүнээс хойш миний хийдэг юм зураг боллоо. Зун бол голын хөвөөнөө нойтон шавар, торгон элс, өвөл бол цасан дээр элдэв амьтны дүрс зурна. Нэг удаа манайд айлчлан ирсэн Ехөөмянган өвгөний арьсан дээлийн ар дээр могой зурж орхив. Өвгөн түүнийг мэдсэнгүй. Өглөө тэр босоод дээлээ өмсөх гэснээ могойг үзэж нүд нь бүлтрэх шахан айж:

- Ай хан хурмаст минь! гэж хашхираад дээлээ чулуудчихав. Тэр могойгоос айдаг юм байжээ. Би тэр могойноос болж хоёр хацраа хорстол “илүүлэв”.

Салхитай танилцсан түүх

Эмээ, ээж, бид гурав гадаа сууж байлаа. Гэв гэнэт нэгэн муухай дуун гарав. Эхлээд ууг ууг гэж сонсогдсоноо, тэр даруй өөрчлөгдөж сийг сийг сийг гэх болов. Тэгснээ өөрчлөгдөж эсий эсий гэж хяхаргалан дуугарлаа. Үүн шиг дуутай амьтныг би хэзээ ч үзээгүй байлаа. Хонь бол май май гэж ямар нэгэн юм өгч байгаа мэт ямагт горьдооно. Ямаа бол бэ бэ бэ гэж асууна. Үхэр болохоор муу муу гэж үргэлж уурлан загнах мэт дуугарна. Нохой болохоор хав хав хав гэнэ. Чухам юу хавуулах гэдгийг би мэддэггүй байлаа. Дээл хавна гэж ээж тушаал өгдгийг гайхдаг байлаа. Зурам бол час час гэнэ. Тарвага бол хого хого гэнэ. Хөхөө бол гүүг гүүг гүү гэнэ. Хар хэрээ гуаг гуаг гэнэ. Амьтан бүгд өөр дуутай байх боловч тэдний дуунд хүнд ойлгогдох юмгүй санагдсан. Заримдаа би амьтдын дуугаар нь нэрлэхгүй яасан юм бол гэж гайхна. Жишээ нь: Илжгийг ийгоо гоо, хэрээг гуаг гуаг гэж нэрлэдэг бол яг л таарах байсан мэт санагддаг сан. Нэгэн өдөр том хүрэн шувуу шонгийн орой дээр суугаад эсий хөөрөг эсий хөөрөг гэж хашхирч байхыг үзэв. Тэр шувууны нэрийг би мэдэхгүй байлаа. Иймд түүнд эсий хөөрөг гэж нэр өгөв. Миний хамгийн сайн хүн ээж тул түүнд очиж асуусан нь:

- Ээж ээ, эсий хөөрөг гэж дуугардаг шувууг хэн гэдэг юм бэ?

- Юуны чинь эсий хөөрөг

-Тэр шонгийн орой дээрхийг?

- Аа тархи! Тэр чинь элээ байхгүй юу? Хэн чамд эсий хөөрөг гэж зааж өгөөв?

- Тэр шувуу өөрөө тэгж дуугарах юм байх чинь?

- Аа тархи! Элээ унагалдан янцгаахаараа тиймэрхүү дуугардаг юм шүү. Энэ ярианаас хойш би элээ л үзвэд эсий хөөргө гэж хашхирдаг сан. Намайг тэгж хашхирахад элээ огт үл тооно. Тэгэхэд би хэлээ мэдэхгүй зөнөг гэж их л бачимддаг сан.

- Эмээ элээ яагаад хэлээ мэдэхгүй юм бэ? гэж би арга барахдаа асуусанд буурал ээж:

- Яаж байна гэв?

- Эсий хөөрөг гэж өөрөө дуугардаг мөхтлөө намайг хэлэхээр хариу өгөхгүй юм.

- Аэ цэс, улай үзэхээрээ л элээ унагалддаг болохоор хүнтэй юу гэж үг солих вэ дээ. Үүнээс хойш, би амьтан болгон хоол үзэхээрээ л дуугардаг юм байх гэж таамаглах болов. Гэтэл тэр бодлыг буруу, яагаад гэвэл амьтан хоорондоо хэрэлддэг байх гэж миний нэг найз бас сонин юм ярив. Нохойнуудыг ажиглаж байгаад тэр тэгж боджээ. Би энэ бүгдийг эрэгцүүлэн бодож зогстол ахиад л өнөөх ууг ууг үүг гэсэн дуу гарав.

- Ээж ээ, энэ юуны дуу вэ? гэвэл

- Ямар дуу?

-Ууг ууг ууг гэх дуу

- Өө энэ үү? Салхины л дуу. Үүнээс хойш би салхийг ууг ууг ууг гэх мэт хачин исгэрдэг амьтан гэж бодох болов. Салхийг би дуугий нь сонсохоосоо олж үздэггүй байлаа.

- Эмээ ээж ээ! Салхи яагаад үзэгддэггүй юм бэ? гэж би асуувал

- Тэр чинь биегүй хоосон хий байхгүй юу гэв.

Үүнээс эхлээд биегүй хоосон мөртлөө дуутай юм байдаг гэж итгэв. Гэнэт нэгэн өдөр их тоос бужганаж, малын адсага, цаас, төмөр хувин цөм агаарт хөөрөн гарав. Манай гэрийн өрх хөвөлзөж, тэнгэр өөд авч явахыг завдав. Хүмүүс тэвдэн сандарч, гэрээ олс дээсээр дарууллаа. Гэрийн гадуур байсан арьс, даавуу, цаас, модны хог цөмийг салхи авч одов.

- Ээж ээ салхи тэнгэрт байдаг юм уу гэж би асуулаа.

- Яаж байна?

- Хамаг юмсыг дээш нь аваад явчихлаа.

-Тэгвэл тэнгэрт л байдаг биз дээ.

- Яаж тэнгэрт гарах вэ?

- Тэнд гарч юу хийх нь вэ?

- Малгайгаа олж ирье

- Өө, чи малгайгаа салхинд тавиад туучихаа юу?- Би өгөөгүй. Өөрөө л аваад явчихсан. Салхи гэдэг чинь дүрсгүй муухай амьтан байх чинь вэ.

- Нээрээ ч дээ. Салхийг би үзэн ядах болов. Хамгийн муухай юмны тоонд салхийг оруулав. Яагаад гэвэл байн байн салхи манай гэрийг авч явах гэж айлгадаг байлаа. Тэгж байтал их хэрэг гарав. Аав ээжийн түүж өвөлд бэтгэсэн зургаан шуудай өвс байв. Түүнийг харж бай гэж аав надад захисан юм. Нэгэн өдөр гайхал салхи ирж зургаан шуудай өвсийг нэг нэгээр өнхрүүлэн тэртээ гүвээгээр давж одлоо. Салхи бид хоёр юутай их муудалцсан гэж санана. Салхийг биеэр нь олж хардаггүй дээ би ихээхэн хорсдог байв. Салхи их хүчтэй шүү. Түүнийг зогсоох юм байхгүй гэж аав ярьдаг байлаа. Тэгж салхи бид хоёр дайсан болоод хэдэн жил өнгөрөв. Би сургуульд орлоо. Аймгийн төв дээр ирж сурлаа.

- Ай мөн их салхитай газар шүү! гэж аймгийн төвийн тухай би сонслоо. Сургууль орсны маргааш өглөө салхи ирлээ. Аймгийн төвийн хамаг элс эрчлэн хуйлран хөх тэнгэрт гарч эргэн тойрон юу ч үзэгдэхгүй боллоо. Манай анги дөрвөн баганатай том бор гэрт байдаг байлаа. Хичээл дээр сууж байтал

салхи эхэлсэн юм. Анхандаа өрх бүтээгдлээ. Дараа нь хэд хэдэн унь ойчив. Чойжилын толгой дээр цохижээ. Тэр уйлав. Хүүхдүүд айж тооно өөд ширтэнэ.

- Хүүхдүүд ээ та нар чимээгүй сууцгааж бай. Би гараад гэрээ даруулаад ирье гэж багш хэлээд бостол хана, унь хажигнан шуугьж, анги маань нэг жайвийж, нэг шовойсноо нэвсгэнэхийх шиг болов. Бид бараг ухаан алджээ. Гэр ойчсон юмсанж. Дээрээс унь, эсгий дарж аваад хөдлөх аргагүй болгож хүүхдүүд шуугилдав. Салхи улам догширч байлаа. Олон багш нар хамсарч биднийг арай хийн салхины заналаас аварчээ. Түүнээс хойш бүтэн долоон жилийн турш манай анги салхинд байн байн ойчсоор байв. Ингэж би салхитай танилцав. Салхийг занатай байлаа. Гэтэл салхины тухай багш маань олон сонин юм ярив. Салхины хүчээр том тээрэм эргүүлдгийг мэдэв. Салхи, салхи чи хүчтэй. Сүрэг үүлсийг туунам гэсэн шүлэг хожим нь цээжилж билээ.

Цүнхтэй танилцсан минь

-Үүнийг харав уу? Хүүхдүүд ээ? Юу вэ та нар хэл дээ! гэж ангийн багш асуулаа.

Ангид анхандаа чив чимээгүй байлаа. Багш миний хэдэн дэвтрийг толгой дээр хоёр гардан өндөрт өргөж, нийгэд үзүүлж байлаа. Миний дэвтэр тэгж олны сонирхол татах болсны учрыг та нар мэдэж байгаа биз. Сургуулиас гэр, гэрээс сургууль хүрэх хоорондын хүнд хэцүү аяны замд элээгдэж үнгэгдээд, хиртэж урагдаад яг л хатсан аргал шиг болчихсоноос дэвтэр маань олны анхаарал татжээ. Хэрвээ цэвэрхэн байсан бол хэн түүнийг ингэж их үзмэр болгох билээ.

-Тогооны бариул байна! гэж хэн нэг нь хулгана шиг чисхийн дуугартал манай ангийнхан инээлдэв.

-Дэвтэр биш байгаа биз! гэж багш инээмсэглэн асуулаа. Хүүхдүүд бас л инээлдэж,

-Дэвтэр байсан юм л даа гэж нэг нь хэлэв.

-Өөр ийм дэвтэртэй хүүхдүүд байна уу гэж багш асуув. Үгүй ээ гэж тэд ичих ч үгүй худал хэлэхэд нь би бас тэсэж чадсангүй.

-Багш аа, Пунцаг бас ийм дэвтэртэй шүү гэхчлээ. “Дэрэн цагааны” чих нь час улайхыг би харлаа. Пунцаг бол сармигар дэлдэн чихтэй, цагаан хүүхэд учир бид түүнд “дэрэн цагаан” гэж цол олгосон юм.

-Тийм үү Пунцаг? гэж багш асуув.

Пунцаг дуугарсангүй. Чавган улаан царайтай болов. Багш миний үгэнд үнэмшсэн бололтой,

-Пунцаг чи дэвтрээ аваад ир! гэв. Би ижил ханьтай болсондоо сэтгэл тайвширч баяр хөөртэй болоод самбарын дэргэд номхон зогсож байлаа.

-Харав уу? Хүүхдүүд ээ! Энэ хоёрынх шиг дэвтэртэй байж болох уу гэж багш асуулаа.

-Болохгүй гэгцээв.

-За та хоёр мэдэв үү! Дэвтрээ ийм муухай болгож болохгүй шүү. Цэвэрхэн байх хэрэгтэй. Ийм муухай дэвтрийг харахаас дургүй хүрнэ. Та хоёр яаж байгаад дэвтрээ ингэчихдэг улс вэ? гэж багш байцааж эхлэв.

-Энэ дэвтрийг би муухай болгоогүй гэж гэнэт би ам ангайчихсан чинь багшийн нүд их болж,

-Хэн муухай болгосон юм бэ? Салхилгагүй жаалууд тэгсэн үү? гэв.

-Үгүй. Цүнх маань л тийм болгочихсон юм.

-Юу гэнээ. Чиний цүнх тийм муухай юм уу? гэж багш гайхан асуулаа.

-Цүнх маань өөрөө нугалчихдаг юм. Тэгэхээр доторх дэвтэр нь бас нугарчихдаг юм гэж би хэлээд ногоон даавуугаар оёж, элгэн дээр нь улаан таван хошуу хадсан цүнхээ багшид үзүүлэв. Багш бас л гайхаж,

-Энэ цүнх тэгээд чиний дэвтрийг өөрөө нугалчихдаг юм уу? гэв.

-Үгүй ээ. Дээрээс нь дараад ойчихлоор даавуун юм болохоор нугалчихдаг.

-Чи бүдэрч ойчоод байдаг хөл муутай хүүхэд үү?

-Үгүй ээ гэж би хэлтэл арын ширээнээс Лхаасүрэн:

-Багшаа наадах чинь гэртээ харих замдаа Дэрэн цагаа... гэснээ амаа барьж, наад Пунцагтай чинь дандаа барилддаг юм. Тэгээд ойчих болгондоо цүнхтэй дэвтрээ нуга дарчихдаг юм гэж ховлов.

Пунцаг бид хоёр дайсан этгээд рүүгээ заналтайяа харж зогслоо. Тэгтэл багш:

-Өө тийм үү, тэгвэл цүнх буруутай биш та хоёр өөрснөө ноцолдож байж дэвтрээ үнгэдэг улс байна. Үүнээс хойш бүү тэг. Энэ муухай дэвтрээ сольж, шинэ дэвтэр дээр хуулаад ир! гэв.

-Хайран юм гэж би санаа алдав. Хүүхдүүд нирхийн инээлдлээ. Багшийн уур сая л хүрсэн бололтой нүд нь аймаар болж,

-Юу гэнээ чи! Энэ муу тогооны бариулыг хайран гэв үү, чи? гэж хашхиран асуув.

-Үгүй ээ. Багш аа энэ дэвтэр дотор таны тавьсан гурван сайхан тавын тоо байгаа юм. Тэр маань хайран байна.

Энэ үгийг сонсоод багшийн царай сайжирч бүр инээвхийлэх байдал ороод,

-Аа дүн үү? Тэрнийг би чамд бас хуулж өгнө гэв. Хичээл тараад гэртээ ирэх замдаа Пунцаг бид хоёр ханатлаа барилдаж авав. Нэгэнт үнгэлдээд хуулах болсон дэвтрийг хайрлах юм алга байв.

Гэртээ орвол аав ажлаасаа ирчихсэн сууж байлаа.

-За ямар дүнтэй вэ? гэж надаас асуулаа. Аавд нуух юмгүй тул би түүнд эрхэлж,

-Муу. Өнөөдөр багшдаа загнуулаад... гэв. Аавын сэтгэл зовж,

-Яагаад багшдаа загнуулав. Буруу юм хийв үү гэв.

-Буруу юм хийгээгүй. Гэтэл дэвтрээ муухай болгосон гэж багш загнасан гэхэд аав:

-Аль вэ тэр, дэвтрийг чинь үзье хэмээв.

Би нөгөөх гайтай дэвтрийг чинь дуртай дургүй авч өгөв. Аав харангуут,

-Дэвтрээ ийм болгочихсоноос цааш загнахгүй яах вэ. Загнахаар барахгүй зодох хэрэгтэй байж гэв. Үүнд би гомдож:

-Би өөрөө буруугүй юм чинь гэв.

-Хэн буруутай вэ?

-Цүнх?

Энэ үгэнд аав бас гайхав бололтой.

-Цүнх юуны буруутай вэ?

-Энэ муу даавуун цүнх чинь дотроо байгаа дэвтрийг хамгаалж чадахгүй юм.

-Яагаад?

-Барилдах дээр нугарчхаад байх юм.

-Барилдахдаа газар аваад тавьчихгүй юу.

-Тэгэхээр... хүүхэд аваад зугатчихдаг.

-Багшдаа үүнээ хэлсэн үү?

-Хэлээгүй

-Барилдахгүй байж болохгүй юу?

-Болохгүй. Дэрэн цагаан бид хоёр заавал үзэлцэж байх ёстой. Аав инээмсэглэн бодол болж, миний элс шороотой толгойг илэн хэсэг суув.

-Чи дандаа ойччихдог юм шив дээ? гэж асуулаа.

-Үгүй ээ. Дэрэн цагаан бас ойчдог. Түүний дэвтэр бас л ийм болчихсон. Бид хоёулаа загнуулсан.

Аав дахиад л бодлогоширсноо:

-За яах вэ, аав нь чамд цүнх хийж өгье. Маргааш өглөөнөөс эхлээд чиний цүнх дэвтэр нугалахгүй болно гэв. Аав мужаан хүн болохоор тэр дороо мод харуулдаж, жижигхэн модон цүнх хийв. Дээшээ онгойдог бяцхан тагтай, хоёр хажуудаа зүүдэг сэнжтэй, бас жижигхэн цүү цуургатай хийжээ. Шаравтар будгаар будаж бөөрөн дээр нь улаан таван хошуу зурав. Энэ бүхэн миний санаанд багтамгүй тийм нарийн зүйл шиг бодогдов. Одоо би мангуурч ойчтолоо барилдаж болно. Дэвтэр маань модон цайзан дотроо эрүүл чийрэг, ариун цэвэр орших болно гэж бодохоос баярлан дэвхэцмээр санагдав.

-Чийтэй будгаар будчихлаа. Өглөө болоход хатчихна гэж аав амандаа ярьж миний хамгийн том номын хэмжээг авч үзээд инээмсэглэв. Хэмжээ таарсан бололтой.

Маргааш өглөө нь аав:

-За одоо цүнхэнд буруу өгөх аргагүй шүү. Өөр л юм бодож олоорой гэв. Тэр өдөр би үзэсгэлэнгийн амьтан болж хувирав. Сургуулийн хаалгаар орж ирмэгц манаач өвгөн нүдээ том болгож,

-Чи чинь юун хайрцаг үүрээд ирэв? гэж асуухад уур хүрч,

-Хайрцаг биш цүнх байхгүй юу? гэххээд цааш одов. Манаач:

-Хай гайхалдаа гэсээр хоцров.

-Хүүе, хүүхдүүдээ, хараач. Энэ юу гээч вэ гэж ангийнхан шуугилдлаа. Хүүхэд бүр цүнхийг минь үзэх гэж сарвалзлаа. Би их үнэрхэж гайхуулав. Хүүхдүүд их сониуч ажээ. Гэтэл бас багш нар миний цүнхийг үзэх гэж тойрон шавж бас контортоо дуудаж үзэх гэж оролдов.

-Тэр өдөр шиг олны анхааралд орж ярианы эзэн болсноо хожмын олон жилүүдэд би үзээгүй билээ.

Хүүхдүүд надад “модон цүнхэт” гэж шинэ цол өргөмжлөв.

-Модон цүнхэт гуай барилдах уу гэж нэг нь анх хэлээд энэ цолыг бий болгов. Урьд нь намайг “сарлагийн тугал” гэдэг байснаас энэ нь арай үнэн нэр тул би тэрэнтэй дороо эвлэрлээ. Модон цүнхтэй болсноос хойш миний дэвтэр шинээрээ байдаг болов. Харин над шиг модон цүнхтэй хүүхэд дахиж хэзээ ч гарсангүй. Гагцхүү Дэрэн цагаан намайг дуурайн ижилсээд бас модон цүнх зүүсэн. Гэвч түүнд шинэ цол олдсонгүй. Дэрэн цагаан хэвээрээ үлдэж билээ.

Удалгүй модон цүнхнийхээ өөр нэгэн ид шидийг би санамсаргүй нээж олов. Ахлах ангид сурдаг том хүүхэд Дэрэн цагаан бид хоёрыг гэнэт зодохоор нударгаа зангидан давхиж ирэв. Хичээл тараад явж байсан юм. Айхдаа өмнөөс нь цүнхээ өргөн халхалж орхисон чинь нөгөө хүүхэд модон цүнхний бөөрөн дээр нүцгэн нударгаараа түсхийтэл буулгаж аваад өвдсөндөө болж ярвайн ухрав.

Үүнээс хойш модон цүнхээ бамбай болгон ашигладаг болов. Ингэж би модон цүнхтэйгээ долоон жил нөхөрлөсөн юм. Найм дахь жилээсээ би түүнээс ичих болж билээ.

Хадны мангаатай танилцсан нь

-Хадны мангаа ирнэ, ий яадаг билээ? гэж намайг анх удаа Айдаа эгч айлгав. Түүнээс хойш би энэ үгийг олон хүнээс сонсож билээ. Том хүмүүс “Хадны мангаа ирнэ” гэж хоосон айлгахаас биш тэр мангаа нь чухам юу болохыг надад тайлбарлаж хэзээ ч хэлдэггүй байлаа. Би том хүний ярианаас эргэцүүлэн бодож хадны мангаагийн төсөөлсөн дүр бий болгож авлаа. Миний бодлоор бол тэр хадны мангаа хахирган муухай дуутай бүдүүн хөлтэй хар гартай улаан нүдтэй байх ёстой. Манайх хад уул ихтэй газар нутагладаг тул хадны мангаа элбэг тохиолдох бололцоотой газар байлаа. Гэвч би долоо, найман нас хүртлээ хадны мангаатай ер дайралдсангүй. Ээж аав томчуулын хэлдгээр бол миний аливаа муу юм хийх болгонд л хадны мангаа ирэх ёстой байлаа. Эхлээд би мангаанаас айдаг байв. Дараа нь хадны мангаа гэж юу байдгийг нүдээр үзэх сэн хэмээн хүсэмжлэх боллоо. Хүслээр болсонгүй, тэгэхээр нь хадны мангааг урин дуудахаар шийдэв. Дүрсгүйтэхээр хадны мангаа ирдэг юм бол хэд хэдэн том хэрэг гаргаж байгаад ирэхий нь үзье гэж шийдэв. Хэрвээ хадны мангаа ирвэл тулалдах бэлтгэлтэй байхын тулд аавын тонгоргыг авч өвөртлөв. Бас нуугдах газар хайж оллоо. Тэр өдөр манайд нэг зочин ирээд хоймор завилан сууж байлаа. Ээжийн буйлан дотроос хэдэн битүү зүү авч түүний хормойг ширдэгтэй барьж хадав. Миний хийж байгаа ажлыг хэн ч мэдсэнгүй. Зочноор ирсэн өвөө цай ууж гүйцээд, явахаар болж малгайгаа өмсөөд ухасхийн босох гэтэл хормойдоо татагдан ар тийшээ ойчихлоо.

- Бурхан минь, та яаж байна аа? гэж ээж айн сандарлаа. Өвгөн ар тийшээ ойчихдоо хоймор байсан торхтой тарга рүү нэг гарын сугандаа хүртэл дүрчихжээ. Би тэсэж ядсангүй инээд алдан гүйж гаргамагц буурал ээжийнх рүү очлоо. Буурал ээжийн ард нуугдан суугаад хадны мангаа орж ирэхийг хүлээж байв.

- Чи юунаас нуугдаа вэ? Хүү минь гэж буурал ээж асуусанд хадны мангаанаас нуугдаж байна. Тэр одоохон үүд сөхөөд ирнэ гэж би сүртэйеэ хариулав. Эцэг чинь хадны мангаа бол доо гэж эмээ ээж уулга алдлаа. Би хүлээгээд л байлаа. Хүлээгээд л байлаа. Мангаа ирдэггүй. Тэгэхээр нь шагайж харвал бас л юу ч алга. Арга барагдаад гадаа гарлаа. Хадны мангаа андуураад манайд ирчихсэн байх гэж сэжиглэв. Гэрийнхээ үүдээр сэм шагайвал юу ч алга. Ээж ганцаараа л байна. “Саяын хийсэн хэрэг ялихгүй юм байж гэж хэсэг явлаа. Тэр их бодлын ачаар нэгэн хэрэг бодож оллоо. Шөвөг хайж олоод, лам ахынд очиж хөхүүртэй айргий нь цоо хатгавал мангаа лавтай ирнэ гэж бодоод уул хэргийг ёсоор гүйцэтгэв.

- Ээ дацан хөхүүртэйгээ ноцолдож, айраг нь тулгын зах хүртэл цагаан зураас татуулан гоожиж байлаа. Хадны мангаа бас л ирдэггүй. Арга ядаад айргийн том хулаар дүүрэн цог хорхой түүв. Аягыг эвтэйхэн таглаад Доной өвгөнд аваачиж өгсөн чинь тэр их баярлан аваад:

- Гялайлаа хүү минь. Аав чинь хотоос ирээ юү? гэв.

- Тэгсээн гэтэл өвгөн аяганы тагийг авлаа. Дүүрэн цог хорхой байхыг үзээд:

- Золиг дамшгаа гэж хашхиран аягаа чулуудаж орхив. Би ухасхийн зугатаж мухар эргэнд орж нуугдаад өврөөсөө аавын тонгоргийг гарган зэхэв. Одоо ч хадны мангаа лав ирнэ гэж бодсон юмсан. Мангаа бас ирсэнгүй. Иймд би урам хугараад зурамны хавхаа авч гэрээс холдон явлаа. Манайд бас ирсэнгүй. Иймд би урам хугараад зурамны хавхаа авч гэрээс холдон явлаа. Манайх шинэ нутагт дөнгөж буугаад байсан юм. Голын урд талд өндөр ханан хад байхыг би их сонирхсон тул тийш явлаа. Магадгүй хадны мангаа ч дайралдаж болно.

Асууулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Зохиолын туурвил зүйн онцлогийг тайлбарлана уу?
3. Баримтат зохиол, түүний ач холбогдлыг тайлбарлана уу?

Зудын жил

Д. Гармаа

Нэгдүгээр бүлэг

-Бос хөөе, бос гэм золиг оо!... гэж намайг хүн дуудах шиг болов. Би толгой дээгүүрээ дээлээ нөмрөөд шурган унтсаар л байв.

-Босно уу, үгүй юу чи! гэж өнөөх дуу ахиад гарснаа, гэнэт хучлагыг минь хуу татаад явчхав. Би өөрийн эрхгүй өндийж, нүдээ нухан байтал,

-Бушуул! Яагаад суугаад байна! Чамд хүн үг хэлж байна уу, үгүй юу? гэснээ Догоо эмээ, өрөөсөн гутлаараа намайг шидэв. Хэрэв би амжиж бөхийгөөгүйсэн бол юу болох байсныг бүү мэд. Би ч бушуухан босов.

-Ай муу гөлөг чамайг! Голоос ус авчир, галаа түлээд яв! гэж зүүн орноос Догоо гуай уухилав. Би Догоо гуайг дахин гутлаараа шидэх вий гэсэн мэт түүн рүү айн хялалзсаар зууханд аргал зэрэглэж, цаасны өөдөс цуглуулан банзан шүдэнз хавирч гал ноцоох гэж оролдном. Аргал мөд асахгүй. Адууны хомоол үйрүүлэн байж арай гэж асаахад хүхээг нь эвдэрхий муу зуухнаас утаа савсаж гэрээр дүүрэн утаа болно.

-Аа заяа нь харламар... хормойгоо чирсэн новш... Тэр гал түлчхэж байгааг нь хараарай! Чонын бэлтрэгийг... зориуд тэгж нүдийг минь хорсгох гэж утаа тавьж байгаа юм! гэж Догоо гуай уурсан, уухилан өндийхөд би түүнийг гуталдаа хүрдгийн даваан дээр дээлээ шүүрэн авч зугтааж гарав. Авгайн дуу хангинасаар. Энэ авгай хэцүүхэн хүн байв. Намайг өглөө болгон ингэж босгоно. Хичээлээс ирмэгц би аргал түүж, их ядрах тул шөнө ухаангүй унтах бөгөөд анхандаа өглөө дуудахад нь сэрдэггүй байв. Тэгэхийн хамт Догоо гуай нэгэн мэргэн арга олжээ. Намайг дээлээр

минь хучин унтуулж, ханцуйнаас урт оосроор оосорлон түүнийгээ орноос уяж хононо. Өглөө өнөөх оосроосоо ганцхан угзрахад би нүцгэрч дээл минь Догоо гуайн орны өмнө оччихсон байна. Догоо гуай их зальтай. Ер нь харваас тийм гээч. Нүд нь онигор, эгээ л нэг гахайных шиг. Аманд нь цорын ганц шүд буй. Тэр нь үүдэн шүдний нь үлдэгдэл бөгөөд араанууд нь цөм уначихсан атал яагаад тэгж зөвхөн үүдэн ганц шүд үлдсэнийг бүү мэд. Нүүр нь олон үрчлээтэй. Юм идэхэд зөвхөн эрүү ам хоёр нь нийлж байгаа шиг санагдах бөгөөд инээхэд нь өмнөх ганц шүд нь ёрдойн харагдана.

Гадаа хяруу унаж, гол руу хөл нүцгэн гүйхэд хайрна. Миний мөр цэвцийсэн цагаан хяруун дээр харлан үлдэхэд би жигтэйхэн даарсан хөлөө дулаацуулахын тулд үхрийн баасанд дүрнэ. Намар орой болж байв. Өглөөний наранд хяруу буусан тал мөнгө шиг гялалзана. Хэрлэнгээс өглөө эрт уур манан савсаж, тунгалаг цэнхэр гол дөлгөөн эгшиг гаргаж урсана. Би хувингаараа ус хутгаж, эргэж гүйнэ. Миний хувинтай усаар наран наадаж ийшээ найгахад хувингийн энтээ тал руу цалгиж, тийшээ найгахад тэртээ тал руу цалгина. Хувинтай ус маань нарны гэрлээр сүлэгдсэн шиг санагдахад би нарыг л тийнхүү хувиндаа хийгээд барьж яваа шиг санагдана.

Гэртээ ирэхэд гал хэдийн асаж гэрт дулаан болжээ. Би тогоо тавьж, ус хийв. Догоо авгай галд дулаацаад ухаангүй хурхирч байв. Амьсгаа нь гарахгүй бүтчих гэж байгаа юм шиг ффүү... фф... фф... гэнэ.

Цай болтол би хичээлээ үзэв. Гэрийнхээ даалгаврыг арай гэж амжиж хэл бичгийнхээ дасгалыг дуусгатал, цай ч буцлав. Би зэс шанагаар сүү авчирч сүлээд босоо том домбонд уудлав. Тэгээд өчигдөр орой Догоо гуайн аяганд хийж өгсөн дөрвөн ширхэг боорцгийг идэж, цай уугаад, номоо даавуун цүнхэндээ хийгээд гэрээс гарлаа. Гадаа салхи тогтуухан, наран таалж, хүүхдүүд шуугилдаж байв.

Манайх дөрөвдүгээр анги. Бид арван долуулаа. Зарим нь хоёроор зарим нь ганцаар ангийн шар партнуудад сууцгаана. Энхээ бид хоёр нэг ширээнд. Тэр бол манай зэргэлдээ айлын охин шүү дээ. Энхээ их хөөрхөн ааштай. Тормолзсон тас хар нүдтэй. Нарийхан туранхай охин байв. Хичээлдээ бол их сайн.

Намайг ангидаа очиход хүүхдүүд цуглаад ид шуугилдаж байна. Даваа, нэгэн ногоон шугамтай дэвтэр таван хошуутай даавуун цүнхнээсээ гаргаж,

-Хар л даа та нар! Ах авчирч өгсөн юм л даа гэж гайхуулав. Энэ бол ёстой дэвтэр байв. Талбай гаргаж шугамдсан хатуувтар ногоон хавтастай, гялгар цаастай, арван хуудастай дэвтэр юм. Энхээ тийм дэвтэр байхгүйдээ харамссан юм шиг түүний гар луу шүүрс алдан харав.

-Зарна шүү авах уу? гэж Даваа эгээ л нэг морины наймаачин шиг хэлэв.

-Чи юугаар өгөх юм бэ?

-Домбон саахраар өгнө.

Энхээ бодол болно. Чихэр ховордож домбон саахар ч олдохоо байжээ. Бас дэвтэр нүдний гэм байв. Багш бидэнд нэгэн зузаан бор цаас тарааж өгнө. Энэ бол модны хээ нь хүртэл харагдах черниль уудаг муу цаас байв. Аль аль нь ховор тул тэр хоёр наймаа тохирч чадсангүй. Тэгтэл ч нарийхан бэлхүүстэй, хөмсөг нарийнтай Цэрэндолгор багш маань ороод ирэв. Бид гар гараа урдаа тавьж суув.

-За хүүхдүүд ээ, хичээлээ эхэлье. Өнөөдөр 1944 оны 10 дугаар сарын 3 гэж багш эхэлнэ. Бид цөм будаа түүх гэж байгаа шувуу шиг нэг зэрэг тонголзон, самбар луу нэг харж, дэвтэр рүүгээ нэг бөхийнө.

Хичээл тармагц бид тал тал тийшээ номоо үүрэн гүйж одов. Өнөөдөр бямба гараг. Хичээл эрт тарсан. Манайд зочин ирсэн байв. Үл таних хар сахалтай хүн хоймор сууж, өмнө нь Догоо эмээ халаасан гүцтэй архи аяганд хийж байв. Би цүнхээ орон дээр тавив.

-Аяга аваад цайгаа уу! гэж Догоо эмээ хичээлээс эрт тарсан нь миний буруу юм шиг хялалзан хэлэв.

-Энэ чинь юун хүүхэд билээ? гэж хар сахалт асуув.

-Энэ өнөөх Дамчаагийн том банди. Эцэг нь түр цэрэгт татагдаад гэр нь Улаанхайрхан руу оторт гараад, үүнийг манайд орхисон юм...

-Аа.

Би аяга авч цай хийж суув. Догоо гуай хуруугаа хүүдийний ам руу хийж дөрвөн ширхэг боорцог сурмагаар хавчин гаргаж ирээд алган дээр минь тавив.

-Бушуу идэж уу! Тэгээд аргалд явна шүү. Цас хэзээ язаагүй дарах нь... Түлш алга гэнэ. Би Догоо гуай руу хялалзан байж цайгаа уугаад, боорцгийг өвөртлөн босов.

-Морь минь усгүй хэцүүдэж байгаа юмсан. Чи хө, морь унаж чаддаг уу?

-Чадалгүй яах вэ. Хурдны морь унадаг хүүхэд... Чи энэ ахынхаа морийг услаад ир! Холхон явж, бүрднээс усална шүү!

-За... гээд би гарав.

Хээр үрээ манай гадаа хантайраастай байв. Би моринд мордож бүрдний зүг давхин одов.

Ингэж давхих нь сайхан байлаа. Амьтны элдэв шуугианаас холдсондоо баярласан зүрх минь түг түг цохилно. Гандаж шарлангуй өнгөтэй болсон уудам талын дээгүүр тогоруун цуваа гангар гунгар дуугаран ниснэ. Зэллэн одох тогоруунуудыг өмнө зүгийн тэнгэрт бараа тасартал би хараад “Аав минь тэнд бий” гэж алс өмнө зүг рүү ширтэн бодол болов.

Аавыгаа бодохлоор сэтгэл хачин болно. Гэр минь санагдаж ээжийгээ үгүйлнэ. Гэвч би чинь эр хүн шүү дээ гэж бодлоо.

“Ахайм” гэж би томоор ханиаж, бүрдийн шар зүлгэн дээр бууж, морио булгаас услав. Наран шингэх дөхөж, бадман улаан туяа нь бутны сүүдрийг уртасгасан байв.

Гэдэс минь хоржигнон, уусан цай тулманд хийсэн ус шиг чимээ гаргана. Анх энд ирсэн өдрөөс хойш би Догоо авгайнд ганц ч удаа

цадсангүй. Догоо авгай зун манайд очиж, хоёр хоносон. Тэгэхдээ энэ тэрээ болж, намайг энхрийлэн таалж,

-Ээ гэгээн минь, хүүгий чинь би л энэ жил гэртээ байлгаж үзье. Тэр дотуур байр гэдэг чинь горьгүй газар шүү. Ядаж хоол унд муутай. Ер нь олон амьтанд хийсэн хоол яаж ч олигтой амттай байх вэ? гэж улигласаар ээж аав хоёрыг зөвшөөрүүлж, тэгээд өвлийн эхэн сард хоолонд минь тал үхрийн мах, хэдэн хонины махтай авахаар тохирчээ. Намар ээж бид хоёрыг ирэхэд ч Догоо гуай мөн л тийм байдалтай угтав.

Гэвч ээжийг минь явсны маргаашнаас өнөөх сайхан ааш нь ор мөргүй болоод, одоогийнх шигээ өглөө болгон босгож, цай уухад дөрвөн л боорцог өгдөг болов. Тэр битгий хэл, авчирсан цагаан даавуун хөнжлийг минь ч нөмрүүлсэнгүй. Нэгэн гудас орон дээр хаяад, дээлээр минь хучуулдаг болов. Ингээд бодохлоор уйлмаар байв.

Хээр үрээ ус залгилна. Тэр амьтан их цангажээ. Хамраар нь ус годхийн гарахыг ч тэр эс тооно. Би хээр үрээг усанд ханахаар хөтөлж явав. Тэгж явахдаа ихэд сонин нэгэн зүйлийг харлаа. Юу гэвэл, өрөөсөн хөл нь хугархай нэгэн тогоруу миний хөлөөс зайлах гэж далавч юугаа дэвэн дэвэн байв. Миний зүггүй хөдөлж хөлгүй тогоруу бид хоёрын хэн нь хурдан болохыг үзэхээр шийдэв.

Би түүний хойноос элдэв. Хээр үрээ үргэж байвч цулбуураас нь татахаар арга буюу явна.

Би тогорууны хойноос хашхиран элдэвлэв. Тогоруу дэвэн дэвэн явгалж зугтсаар байв. Гэвч хөлгүй тэр амьтан хаа холдох билээ. Хөлөө дороо хийн навсайн унав. Би чулуу эрж нэгэн бутны дундаас нударган хэртэй чулуу олоод шувууны дэргэд очиж, яг толгой руу нь буулгахаар гараа өргөтөл, наран сөрөг нэгэн юм гялсхийв. Би чулуугаа хаячхаад гүйж хүрвэл, том сувдан даруулга байлаа. Гараа өргөн харахад нарны гэрэл тусаж, тэрхүү сувднаас нь өнгө өнгийн гэрэл гарна. Утсан оосор нь хуучирч өгөршжээ. Би бодол болов.

Энэ тогоруу надад үүнийг өглөө гэж би бодов.

Амиа гуйсан ч байж магадгүй гэж би гэнэт бодов. Тогоруун дээр ирвэл, тэр айж бүлтийсэн улаан нүдээр намайг заналтай ширтэнэ.

-Уучил намайг... гэж би тогоруунд хэлэв. Тогоруу юу ч эс дуугарав. Улаан нүд нь хорсолтой гялалзаж,

-Чи муу тэнэг жаал. Намайг алах гэж явахаар, наадахаа аваад зайл гэх шиг болов. Би сувдан даруулгыг өвөртөө хийж, мориндоо мордов.

Хоёрдугаар бүлэг

Нэгэн удаа би дотуур байрны тэрүүгээр явж байв. Хүүхдүүд хоолондоо орж, гал тогооны өрөөнөөс аяга таваг хангинах сонсдоно. Би цонхонд хамраа налчийтал шахан байж харав. Хүүхдүүд урт сандлууд дээр сууцгаана. Өмнө нь таваг шөл, бин харагдана. Хэдийгээр бин нь хар гурилынх байсан боловч түүн шиг сайхан зүйлийг би ер нь энэ насандаа үзсэн болов уу даа! Бас тавагтай шөлнөөс нь уур савсаж таанын үнэр ханхалж байв. Би тэсэж чадсангүй шүлсээ залгив. Ай, энэ дотуур байрныхан ямар гоё юм бэ? Нэг харвал манай ангийн Даваа

бингээ идэлгүй өвөртөлж байна. Гал зуухны үүдэн дээр очиж түүнийг хүлээхэд Даваа ч хөлс нь бурзайчихсан гарч ирснээ намайг хараад гайхсан юм шиг,

-Чи юу хийж байгаа юм бэ? гэж асуув.

-Надад бингээ өг л дөө гэж би гуйв.

-Яах юм... гэснээ Даваа гэнэт нэг юм санах мэт болж,

-Тэгвэл чи юу өгөх вэ?

-Би юу би... гэж бодол болов. Надад даавуун цүнхнээс өөр юм олдсонгүй тул,

-Даавуун цүнхээ өгнө гэвэл,

-Яасан сайн юм. Тэгвэл май! гээд Даваа алгыг минь дулаацуулсан бүлээн бин гар дээр минь тавив.

Миний баярласан гэж тоймгүй. Би бинг бушуухан хазаж амтлан залгив. Ийм сайхан амттай бинг би ер нь хэзээ ч үзээгүй билээ. Идэж дуусдгийн даваан дээр гэнэт “Хожим ахиад өлсөнө шүү дээ. Догоо авгай юу ч өгөхгүй дээ” гэж саналаа. Гэвч би тэвчиж чадалгүй бинг тойруулан хазсаар байгаад, тавтын зэс мөнгө шиг жаахан дугаргийг үлдээжээ.

Бид ангидаа цуглацгаав. Тэр өдөр сургуулийн захирал багш ариун цэвэр шалгахаар гэнэт орж ирэв. Би захныхаа даавууг угаасан учир хээв нэг л зогслоо. (Догоо гуай ус алга гээд, зөвхөн дээлний захны дотуур нэгэн цагаан даавуу хадаж өгдөг байв) Хүүхдүүдийг үзсээр миний өмнө ирээд захирал багш,

-Цэдэв дээлээ тайл! гэлээ.

Энэ бол ширвээ хар сахалтай, өндөр хүн байв. Харц нь их ширүүн хүн юм. Би дальдчин байж бүсээ тайлтал өнөөх нэгэн гайт бин өврөөс өнхрөн ойчив.

-Энэ юу вэ? гэж захирал багш бинг дээш өргөхөд, манай ангийнхан нирхийтэл инээлдэн, би ичсэндээ улайлаа.

Захирал багш миний ойрдоо ус хүргээгүй цамцыг харж, дур нь гутсан бололтой хөмсөг зангидав. Тэгээд өнөөх гайтай бинг толгой дээр тавьж, самбарын өмнө эгээ л үзмэр шиг зогсоов.

-За хүүхдүүд ээ харцгаа! Энэ Цэдэвийн ариун цэвэр ямар байна! Бас тэгээд хувцсаа ийм муухай байлгаад зогсохгүй, бин өвөртөлж ангидаа ирсэн байна. Түүний толгой дээр байгаа бинг харж байна уу? гэв.

Миний нүүр лүү халуун нурам цацах шиг, хүүхдүүдийн шоолон инээлдэх нь хацрыг хорсгон байв. Ингээд зогссон бол бас яамай. Хэсэг зогссоноо захирал багш,

-За хүүхээ намайг дагаад гар! гэж тушаав.

Би хойноос нь гарав. Тэр өдөржингөө шахуу анги хэсэж, доод ангийн жаалуудын өмнө нүүрээ улайлгав. Би нулимсаа барьж чадалгүй уйлж байв. Бодоод үз л дээ, ямар гутамшигтай юм болсон гэж санана!

Хэзээ хэзээгүй тэсрэхэд бэлэн бөмбөг шиг ичиж улаан болсон би жижиг жаалуудын өмнө толгой дээрээ бин тавиад зогсоход өнөө жаалууд хи хи хи гэж инээлдэнэ.

Ингэсээр арай гэж нэг захирал багш намайг явуулахдаа Догоо эмээг заавал авчир гэв. Би айж хулгасаар Догоо эмээд очоод,

-Таныг захирал багш дуудаж байна гэвэл эмээ амандаа юм зажлах мэт эрүү, хамар хоёроо хөдөлгөснөө,

-Яах гэж дуудаав? гэлээ.

-Мэ... мэ... мэдэхгүй гэж би арайхийж хэлэв.

-Тийм гээ! Чи л болоод мэдэхгүй байгаа вий, хэл! гэж Догоо гуай над руу аймшигтай харж ойртов.

-Би яагаа ч үгүй... би... би гэж намайг ээрэхэд Догоо гуай хананаас гөрмөл суран ташуур авч,

-Чи үнэнээ хэлнэ үү, үгүй юу? Хормойгоо чирсэн турсага муу хуухай!

Би ээрэн нус нулимсандаа хахаж цацан байж үнэнээ хэлэв. Догоо гуайн царай тэгэхэд ямар болсон гэж санана. Эгээ л нэг дүнсийтэл бүрхсэн тэнгэр шиг бараалав. Гэвч ташуураа хананаас өлгөөд, уухилсаар галынхаа өмнө суув. Тэгснээ гэнэт сайхан зантай болж инээд алдав.

-Үгүй ер яалаа гэнэ ээ? Бин толгой дээрээ тавьсан гэнээ. Ха ха ха гэж ташуур далайж байгаагүй юм шиг Догоо гуай тэгж удтал хөхрөхөд унжсан том зовхи нь чичирч байв. Дараа нь нулимсаа арчаад газар тулан босож, үхэг рүүгээ явав. Өлссөн ямааны нүд шиг миний нүд горьдон гарыг нь харсаар байлаа. Энэ удаа Догоо гуай дөрөв биш долоон боорцог гаргаж дээр нь бас жаахан өрмийн хэлтэрхий тавиад,

-Май ид дүү минь... Юу гэсэн үг вэ. Насаа нэм! Ингэж өлсөж байна гэдэг чинь... Аав ээж чинь дуулбал юу гэхэв гэлээ.

Тэгээд харц нь ихэд уярангуй зөөлөн болж ирснээ, бараг шивнэх шахам дуугаар,

-Хүү минь одоохон хувцсаа сольчих! Бас хөнжлөө гаргаад орон дээрээ тавь! Тэр захирал багш манайд ирж ч үзэж магадгүй хүн шүү. За юу?

-За.

Эмээ хоймроо байх хээ нь хөө тортогт дарагдаад мэдэгдэхээ байсан авдраас баадантай юм гарган задалж, шинэхэн шувуу даавуугаар хийсэн миний хөнжлийг, бас ээжийн минь намар авчирсан цамцыг гаргаж ирэв. Би бүсээ тайлж эхлэв.

Гэвч захирал багш ирсэнгүй. Эмээ ганцаар их ууртай ирэв.

-Тэр цамц тайл! гэж тушаав.

Би гайхан харвал эмээ гөрмөл суран ташуураа хананаас авч,

-Тайл наадах цамцаа! Хормойгоо чирсэн муу новш! Тэр хиртэй цамц, захны даавуу угаа! гээд заавал шийтгэхийн тулд нуруу руу нэгэн удаа гуядаж,

-Ахиад намайг ингэж захирал дуудвал уу? Сайхан мэдээрэй гэв.

Би ус халаан Догоо гуайгаас айж дальдчин байж цамцаа угааж гарав.

Хоолны дараа намайг тосон дэнгийн бүдэг гэрэлд хичээлээ давтахаар суухад Догоо гуай хажууд минь ирж бөгтийн зогсоод миний бичиж байгаа руу удтал харав.

-Алив чи юу хийж байна? Хичээл чинь мөн үү?

-Мөн.

-Тэгвэл унш!

-Үгүй тоогоо бодсон юм.

-Тэгвэл бод!

-Дөрвөн дөрвийн арван зургаа, зургааг тавь, нэгийг санаад гэж би амандаа үглэв.

-Битгий дэмийр! Нэгийг чи санаж яах нь вэ? Шууд арван зургаа гээд л тавибал болоо биз

-Үгүй, эмээ тэгж боддоггүй юм.

-Би мэдэж байна хэмээн эмээ зандраад,

-Тоогоо бичив үү? За сайн, тэгвэл тэр бичгээ унш!

-Ямар бичиг...

-Яагаав бичдэг бичиг... унш бушуу!

Би эмээгийн өмнөөс харснаа айж, хэл бичгээ гаргаж уншив. Эмээ ихэд сонирхож байх бололтой.

-Чи нээрээ ингэж уншиж байна уу?

-Уншсан л юм даг...

-Хаана байна, тэр бичиг чинь?

-Энэ байна гээд би хуруугаараа уншсан мөрүүдээ заав.

Эмээ түүн рүү бөхийн байж харав. Гэвч нүд нь гөлийж эгээ л нэг сохор хүн шиг байв.

-За сайн байна. Одоо унт! Дэн дуусах нь... гээд эмээ ор луугаа явав.

Гуравдугаар бүлэг

Цэрэндолгор багш нэг удаа манайд ирэв. Багшийг үзээд эмээ дуу алдан, урьд хэзээ ч байгаагүй сайхан зантай болоод,

-Алив хүү минь, багшдаа гудас дэвсэж өг! Эмээ нь одоохон аяга цай пурхийлгээд орхиё гэлээ.

Тэгээд авдарнаасаа миний ер үзээгүй мөсөн чихэр, улаан чангааз гарган том тавганд хийгээд, бас цагаан тос аяганд хийн, эх нь охиноо ингэж хайрлах болов уу гэлтэй эелдэг сайхнаар харан багшид өгөөд,

-Цэдэв бид хоёр ч гэсэн цайгаа ууя гэнгүүтээ өнөөх цагаан тосноос хэлтэлж надад өглөө.

-Манай Цэдэв их сайн. Томоотой ч гэж ярихгүй, гагцхүү би гэдэг хүн нас өдий болж энэ маань балчирдаж, хувцас хунараа сайн цэвэрлэж чаддаггүй хүүхэд юмаа гээд эмээ,

-Цэдэв чи голоос жаахан мөс дөхүүлж ирэхгүй юу? Эмээгийнх нь өвдгөөр хатгаад горьгүй нь... гэв.

Би ч шуудай авч гарав. Эмээ багшид юу ярьсныг би мэдсэнгүй. Би гэрээ их санаж байв. Манайхаас хүн ирэхгүй л байлаа. Дам сураг дуулвал манайхны хот тэр чигээрээ оторт явцгаажээ. Цас их унав. Өвөл

эхлэхэд жавар тачигнаж, хичээлд хөвөнтэй дээлтэй явж болохгүй боллоо. Догоо эмээ үстэй дээлийг минь гаргаж өгсөнгүй.

Би хөвөнтэй дээлийнхээ дотуур юм давхарлаж өмсөөд хичээлдээ явдаг байв.

Багшийг ирсний маргааш эмээ сайхан зан гаргаж сумын урд байх довцог дээрээс чаргаар гулгаж тоглож байгаа хүүхдүүд дээр очиж тогловол тогло гэв. Би ч хар хурдаараа гүйлээ.

-Өө, Цэдэв!

- Нааш ир! .

- Миний чарганд суу гэж хүүхдүүд дуудав. Энхээ шууд босож ирээд миний гараас хөтлөн чарган дээрээ суулгаад:

-За хөдөллөө шүү. Би чиний хойно сундална гэв.

Нээрээ өөрөө сундалдан модон чарга хөдлөхөд довцгийн уруу чарга маань салхи шиг хурдлан одов. Нүүр лүү цас пургиж, салхи сэнгэнэх шиг болов. Гэнэт гайтай юм боллоо. Чих гэнэт часхийгээд явчлав. Би дуу алдан чихээ барилаа. Гэвч чих минь мэдээ алджээ. Надад үстэй малгай байсан боловч шинээр нь өмсөөд урчихна гээд эмээ өгөөгүй. Би зуны малгайтай явсан юм байхгүй юу. За ингээд чаргаа зогсооход Энхээ босож ирээд миний нүүр лүү харж,

-Чи яав, яагаад ёолов? гэж асуулаа.

-Яагаа ч үгүй гэж би нэрэлхэв.

-Нээрээ юу?

-Нээрээ!

-За тэгвэл хоёулаа одоо өндөр газраас гулгана. Ёстой сайхан болно гээд Энхээ чарганыхаа оосроос татав.

Би чаргыг чирж бид хоёр хөтлөлцөөд довцог өөд авирав. Энхээ өөрт нь яг таарсан үстэй дээл, бор эсгий гутал, цагаан хурган малгайтай даарах учир байхгүй тул хамрын нь хөлс бурзайсан байв.

Бид хоёр ахиж довцгоос бууснаас хойш миний чих бүр мэдээ алджээ. Би бодохдоо дулаацаад даарахаа байж дээ гэж бодож байв.

Тэр өдөр ямар хөгжилтэй байсан гэж санана! Би баярлаагүйгээ баярлаж байв. Би инээд алдаж, хүүхдүүдтэй шуугилдан гүйлдэнэ. Заримдаа газрын уруу хурдалсан чаргатайгаа онхолдоод Энхээ бид хоёр элгээ хөштөл инээлдэж байв.

Нэгэн удаа Энхээ бид хоёр ингэж унаад цасан дээр хөрвөн бостол гэнэт Энхээ,

-Хүүе Цэдэв! Чиний наад чих чинь яачих аа вэ? гэлээ.

-Яаж байна? Зүгээр л байна даг гээд би чихээ барин үзвэл цас мөс шавчихсан, бас ихэд хүнд болчихсон байв.

- Чи чихээ хөлдөөжээ. Ээ бас тоогүй! гэнгүүтээ Энхээ цагаан хурган малгайгаа авч надад өмсгөөд,

-Одоо харьцгаая, хүүхдүүд рүү очоод яах вэ гэв.

Бид хоёр чаргаа чирэн одов.

-Хүүш та хоёр хаачих нь вэ?

-Жаахан тогло л доо! гэж хүүхдүүд хойноос хашхиралдана. Би одоо яана! Хүүхдүүдийн царайг, багш нарынхаа царайг яаж харна! Бас энэ чих

гэсэж зүгээр болохгүй, хөлдүү чигээрээ хугараад унавал яана? гэж бодоод гашуунаар уйлав.

-Битгий уйл, би эгчид хэлнэ. Эгч эмнэлгийн сувилагч болохоор лав эмнэж чадна гэж Энхээ намайг тайтгаруулна.

Гэр лүүгээ дөхөж яваад манай гадаа нэгэн майхан боссон байхыг би харж ухаангүй баярлав.

-Энхээ хараач! Манайхаас хүн ирсэн байна. Аав, ээж ирсэн дээ! Хоёулаа очёё. Ээж ирсэн бол ааруул лав авчирсан... гэж Энхээгийн гараас хөтлөн гүйв.

Манай гэрийн баруун талд майхан барьжээ. Хоёр хүн, сөглөж хэвтүүлсэн тэмээнүүдээс шуудайтай ачааг нь буулгаж байв.

Тэд танихгүй улсууд байв. Энхээ бид хоёр гайхсаар явж гэрт оров.

-Хаашаа алга болчхов? Бүтэн өдөржин дэмий тэнээд... Бушуу наад нүүр гараа угаа, гурил зуур! гэж эмээ бид хоёрыг үүдээр толгойгоо цухуйлгамагц зандрав. “Яасан ууртай эмээ вэ?” гэж шивнээд ормогц,

-Эмээ! Цэдэв маань чихээ хөлдөөчихсөн одоо яана? гэвэл,

-Хохь нь! Хэн түүнийг хээр явж пасанд умба гэсэн юм бэ? Бушуу наад нүүр, гараа угаа, чи яв! гэж Энхээг хөөв. Энхээ надаас малгайгаа аваад гүйн одов.

Би ч урам муутайхан шиг гараа угаан гурил зуурахаар түмпэн авав. Чих минь хорсож эхлэв.

Дөрөвдүгээр бүлэг

Жингийн хүмүүс холоос давс ачиж ирсэн улс байв. Хоол хиймэгц Догоо гуай тэднийг дуудаж,

-Хоол ид хүүхээд, халуун дээр нь ид гэлээ.

Намайг бол хоолоо халуунд нь ид гэж ер хэлдэггүй. Тийм учраас маш чухал улс ирснийг би тэгэхэд л ойлгожээ. Хүмүүс ч орж ирэв. Хууз сахалтай, нэхий дээлтэй өндөр хүн, хорчгор туранхай бор өвгөн хоёр байлаа.

Догоо гуай тэдэнд их сайн байх бололтой. Хоол хийж өмнө нь тавиад, орныхоо хөндийд ямагт хадгалдаг цагаан савтай архинаасаа таслан халаав. Тэгээд над руу эргэж,

-Чи юугаа хараад байна? Унт! гэв.

Миний чих ихэд өвдөж байв. Би Догоо гуайн өгсөн аяга хоолыг идээд, унтахаар орондоо оров. Тооноор нь оддын гэгээ сүүмэлзэж байв. Миний нойр хүрсэнгүй. Дээлээ толгой дээгүүрээ нөмрөн хэвтэв. Ингэхгүй бол болохгүй, би хөлдсөн чихээ хүйтэн гараараа илэн байж, унтсан юм шиг хэвтэж байв. Энэ завсар өнөөх аяны улсууд ч ярьж эхлэв.

-За тэгэхээр Догоо гуай минь бид танд арван шуудай давс орхилоо шүү. Одоо чинь дайн тулааны цаг болж, юм ховордсон үе. Хэрэв аятайхан борлуулаад юм болгоод өгвөл танд бид харамж шангийг нь гомдоохгүй өгнө гэж мэдээрэй гэж ширвээ хар сахалт хэлэв.

-Ээ хүүхэд минь бололгүй яах вэ. Эмээ нь яаж иигээд цааш нь харуулж л орхино гэж эмээг хариулахад,

-Амьтан хүнд мэдэгдэж эвгүй юм болох вий дээ. Одоо цаг гэдэг тун зовлонтой, ялих ялихгүй юмнаас хэрэгт ороход амархан. Танай энэ хүүхэд зүгээр л байгаа даа. Сургуулийн хүүхдүүд ч хэцүү шүү. Толгой дээр цахиур хагалж мэднэ гэж тожгор өвгөн хэлэв.

-Энэ уг нь айлын хүүхэд. Эцэг нь түр цэрэгт татагдаад зүүн хязгаарт байгаа. Гайгүй томоотой, томоогүй байлаа ч гэсэн яах вэ, гарын дор юм. Үнэнийг хэлэхэд өвлийн идшинд нь болоод л суулгачихсан юм л даа...

-За хөөрхий тийм байж...

-Унтаж амар хүүхэд минь!

Догоо гуай хойроор гудас дэвсэж ор засав. Би дотроо нэгийг бодсоор байлаа.

Өглөө босоод би анчны майханд оров. Тэнд шуудайтай давснуудыг давхарлан тавьжээ. Пүүгээ дэвсгэрээ нэг талд нь хураасан байв. Яах гэж орсноо ч мэддэггүй юм. Нэгэн уутан дотор цайны нь хийц байв. Дээрээ зураасан хээтэй том том боорцогнууд, кило хүрэх үгүйтэй хатаасан гогцоо боов байв. Би юу ч авсангүй. Энэ өдөр би туйлаас их өлсчээ. Эмээ надад цайны хийц дууссан гээд боорцог ч өгсөнгүй. Хичээлдээ очсон боловч би хоолны тухай л бодсоор байв.

Хичээлийн дараа би өлссөндөө өөрийн эрхгүй аянчны майхан руу оров.

Би хатаасан гогцоо боов дөрвийг авч усанд явахдаа идэхийн тулд хоёрыг өвөртлөөд, үлдсэнийг нь гэрийн ар дээр тавьж хадгалав. Би усанд явлаа. Өнөөх боовноос зажилсаар явав. Түүн шиг сайхан боов насаараа идэж үзээгүй санагдана. Ааруул шиг хатсан боов аман дотор минь тачигнаж, арай гэж дийлэн хазахад минь арааны шүлс асгаруулам амттай байв. Би өлссөн нохой үхрийн том булуу мэрэхийн адил, гогцоо боовыг шүлсээ гоожуулан байж идэв.

Анхны цас ороод удаагүй байлаа. Хоёр эргээр нь цас хөвсийсөн их гол уур манан татуулж урсаж байв. Би гогцоо боовоо идэж дуустал будант алсын хязгаар луу харж зогсов. Тэгээд усаа татаад явлаа.

Намайг ирэхэд Догоо гуай үүдэн дээрээ ташаагаа тулан зогсоод хилэн бадарсан нүдээр намайг харж байв.

-Аа муу турсага, боовны хулгайч! гэж тэрээр саахалтын хэрийн газраас хашхирав.

Би өчүүхэн хулгана адил бүлтгэнэсээр очлоо.

-Аа муу заяа нь орхимор! Хормойгоо чирсэн шидэл! Хүний хоол мөрөөрөө цуслахгүй, бас ирсэн хүнийг зүгээр байлгахгүй, хуруу хумсаа шургуулна гэнээ! гэж тэрээр бүр чанга хашхирч намайг дэргэдээ очмогц барин авч дээлний захан дээрээс шүүрэхэд би эгээ л нэг шилэн хүзүүн дээрээсээ базуулсан нохойн гөлөг шиг хий өргөгдөв. Энэ сацуу хэрэв жинчид ирээгүй бол юу болох байсныг бүү мэд. Жинчид эмээг тайтгаруулан аргадаж байж намайг тавиулав.

-За гайгүй муу турсага чамайг... Хашраах цаг ирнэ! гэж Догоо авгай уухилсаар суув.

Маргааш орой нь намайг хичээлээс ирэхэд Догоо гуай ихэд хөгжилтэй болсон байв. Надад хоёр ширхэг боорцог аяганд хийж өгөөд,

-Цайгаа бушуу уу! Одоо чиний бичгийг хамт үзэцгээнэ! Би гайхан байж цайгаа ууж дуусав.

-Номоо авчир, бушуул! гэж Догоо авгай тушаахад би хэдэн дэвтрээ гаргаж ирэв.

-Үзгээ гарга, бич! гэж Догоо гуай тушаагаад намайг дэвтрээ гаргахлаар,

-Бич... ингэж бич!. гэж хэллээ: Би салганан чичирсээр бичиж эхлэв.

-Цэдэв би аянчны майханд ороод... гэж . Догоо гуай дуудаж гарлаа. Надад энэ үг хэдийгээр аймшигтай байсанч боловч би бичихээс өөр яах билээ.

-Бичив үү? Юугаа муухай харсан юм. Цааш нь бич... боов хулгайлсан нь үнэн “Идэж байхад сайхан байлаа... “ Бич, бич! бичээ моншоо! “Идэж байхад сайхан байлаа. Баригдаж байхад муухай байлаа” Бичив үү? Алив харъя гээд Догоо гуай миний бичиг рүү бөхийн харснаа,

-За унш! гэж тушаав. Миний нүүр улайж, тийм гэхийн аргагүй улаан юм болжээ. Гэвч би уншихаас өөр аргагүй болов.

-Цэдэв би... аянчны майханд ороод боов хулгайлсан нь үнэн...

-Унш, унш!

-Идэж байхад сайхан байлаа гэнгүүт би эхэр татан уйлж гарав.

-Унш гэм! Үхсэндээ уйлсан турсага вэ?

-Баригдаж байхад муухай байлаа.

Миний нүүр царай, дуугарч байгаа дууг сонсоод Догоо авгай ихэд сэтгэл ханасан бололтой хөхөрч гарлаа.

Үүнээс хойш би Догоо авгайн зугаа гаргах амьтан болов. Догоо гуай уйтгарласан үедээ өнөөхийг чанга дуугаар уншихыг надад тушаана. Би ч уншиж эхэлнэ. Тэр битгий хэл нэгэн удаа, гаднаас хэдэн авгай дагуулж ирээд,

-За та минь, манайх гэдэг айл нэг айхавтар хулгайчтай болоод байна. Аянчны майхан ухаж боов хулгайлдаг хүн чинь энэ шүү дээ гэж намайг заав. Би ичиж улайн доош ширтэхэд авгайчууд над руу гайхсан мэт харцгаав.

-Хулгайлсан юм нь энэ байна. Шинэхэн хулгайч болоод гэрийн ар дээр тавьчихсан байхаар нь олсон юм гэж өнөөх гайт хоёр боовыг дээр өргөн харуулснаа Догоо гуай,

-Алив тэр ном унш! Миний бичүүлснийг унш, бушуу! гэж тушаав.

Би дэвтрээ гаргаж өнөөх гайт үгнээс ичин, хоолойгоо зангируулан байж уншихад авгайчуул бахаа ханатал инээлдэцгээв. Ялангуяа тэдний янцгаах мэт инээдэм дундаас Догоо гуайн инээд бүр ч онцгойрч байв.

-Байг даа, нялх амьтныг!

-Инээдтэй хүүхэд юм.

-Догоо чи арай ширүүдэж байна гэлцэнэ.

Ингэж би Догоо гуайн таних танихгүй хүн болгоны өмнө ичиж зовон өнөө зүйлийг уншдаг албатай болов. Би өшин уурлаж эхлэв. Хэдийгээр нас минь бага, цус минь шингэн ч гэсэн ингэж амьтан хүний доог болох юу билээ? гэж бяцхан гарын хумсаа шигдтэл зангидаж хөмхийгөө зуув.

Тавдугаар бүлэг

Догоо гуай аянчны авчирсан давсыг зарж эхлэв. Үдэш орой манайхаар хүмүүс орж, Догоо гуайтай уулзахад тэд шивнэсэн дуугаар ярилцан, мөнгө төгрөгөө өгөлцөж авалцах боловч олонх хүн,

-Дэндүү үнэтэй байна. Дайн тулааны цаг болчихоод хоршоо худалдаанд давс ирэхгүй болохоор л авахаас биш... өөр цагт сан бол... гэлцэнэ.

-Энэ чинь миний юм биш. Хэрэв минийх байсан бол би хамаагүй хямд өгч байхгүй яах вэ... гэж Догоо гуай аргалаад мөнгийг дээлийнхээ халаас руу шургуулж, давсыг хүүдийлж өгнө.

Үдэш тосон дэнгийн гэрэлд мөнгөө тоолон амандаа юм шивнэнэ. Нэгэн удаа би хөнжлийн завсраар эмээгийн тоолохыг харав.

-Үүнийг тэдэнд, үүнийг өөртөө... гэж Догоо эмээ мөнгийг хоёр тусад нь ялгаж байв. Би сая л ойлгов. Жинчид давсаа дөрвөөр өгөөрэй гэснийг Догоо гуай зургаа хүргэн зарж байв. Дундаас нь шанага давс бүрт хоёр цаас хожиж байв.

Би өнөөх сувдан даруулгыг номынхоо цаасанд ороон хийсэн байв. Ээж минь ийм даруулгатай болохсон гэж хэзээнээс хүсэж байсан юм. Би өвлийн амралтаар харихдаа үүнийг аваачиж өгнө гэж амь шигээ хадгалж байлаа. “Ээж минь юутай их баярлах бол! Баярлаад зогсохгүй намайгаа үнсэж, миний хүү ухаантай хүү шүү” гэж айлын ээж нарт ярина вий гэж бодож байв.

Шинэ жил дөхөж байлаа. Манай сургуулийнхан шинэ жилээр сүлд мод чимнэ гэж хөл хөөрцөг болж байв. Би хүүхдийн концертод орох болов. Энхээ бид хоёр хамтран дуулах болжээ.

Ногоон зүлэг байна аа гээд

Наадмын ёстой бөх шиг

Хамаагүй чангаар унагаавал

Харин би чинь уурлана шүү гэж Энхээг эхлэхэд,

Чи өөрөө барилдана гэххээд

Чангаар унагаавал уурлана гээд

Яагаа ч үгүй байхад хулчийдаг

Янзын жаал чи шүү дээ гэж би дуулна.

Бид сургуулийн улаан буланд концертод бэлдэж байв. Цэрэндолгор багш маань бидэнд дуу зааж, концертыг найруулж байлаа. Ийнхүү нэгэн удаа концерт давтаад харьтал, эмээ их л ууртай суух бөгөөд намайг ормогц авдраас цаасанд боодолтой нэгэн зүйл гаргаж,

-Чи үүнийг хаанаас хулгайлсан бэ? Аа гэж зандрав. Харвал миний өнөөх хээрээс олсон сувдан даруулга мөн. Би үнэнээ хэлэв.

-Аа тийм үү? Тийм юм бол чи эрт надад өгөхгүй яасан юм бэ?

-Би ээждээ хадгалсан юм л даа.

-Чи яагаад эзнийг нь олж өгөхгүй заавал ээждээ гэж хадгалдаг билээ? Сургуулийн хүүхэд чинь юм олбол эзнийг нь заавал олж өгдөг биш билүү? гэж Догоо гуай ширүүн гэгч асууснаа,

-Би үүний эзнийг нь олж өгнө гээд далд хийв. Үнэндээ бол Догоо гуай эзнийг нь олж өгөхгүй гэдгийг би мэдэж байсан л даа.

Нэгэн удаа Баян-Улаанаас жин ирэв. Тэр жингээр ээж миний хоолыг явуулжээ. Надад гэж цаасанд боодолтой боов, цагаан тос, чихэртэй ааруул явуулсан байв. Догоо гуай цагаан тосноос хэлтэрхийг миний аяганд хийгээд,

-За ховрын юмыг үзмэгц битгий идчих гээд бай! Хааяа амталж байхад сайхан байхгүй юу гээд авдрандаа хийв. Бас хэдэн кило ноос явуулж, хоршоонд тушаагаад дугуй булантай цай, тамхи авч явуулаач гэсэн байв.

-Чи энэ ноосыг хоршоонд аваачиж тушаа! Тэгээд дугуй булантай цай, тамхи хоёр үнэнд нь аваад ир гээд намайг явуулав.

Би ч хоршоо руу ноосыг үүрсээр очлоо. Тэнд хүн амьтан байсангүй. Түүхий эдийн эрхлэгч Данзан гуай намайг таньж, миний үгийг сонсоод ноосыг авч, нэг дугуй булантай цай, улаан дүнсний хамт өгөөд дэвтэр дээр хорын харандаагаар юм тэмдэглэв. Гэвч энэ тамхи, цайг эмээ манайх руу явуулаагүй болохыг би бүр сүүлд мэдсэн билээ. Учир нь тэр үед цай, тамхи их үнэ хүрдэг байв.

Зургаадугаар бүлэг

Мичин жилийн цагаан сар болов. Шинийн нэгний өдөр би сумын төвийн хэдэн айлаар хэсэж, хар гурилын боов хэдэн ширхэгийг оллоо. Энэ боовнуудыг эмээ инээд алдан хүлээн авсныхаа дараа,

-Хүү минь, чамд шигшсэн гурилын ганц цагаан боов олдсонгүй юу? гэлээ.

-Үгүй... гэхэд минь,

-Чамд энүүхэн хөдөөгүүр таньдаг айл бий билүү?

-Бий... Жавзан эгчийнх. Ухаагийн өвөр лүү бий. Бас Самдан гуайнх...

-Иш хүү минь, тэгвэл мордож үз. Эмээ нь морь олоод өгье гээд Догоо гуай гарч одсоноо удсан ч үгүй нэгэн морь хөтлөн ирэх нь сонсогдлоо.

Намайг байдгаар хувцаслав. Би ойрдоо өмсөөгүй шинэ даалимбан гадартай үстэй дээл, цагаан хурган малгайгаа өмсөж ёстой нэг цагаан сараар л хүн ингэж явдаг болов уу гэмээр ихэмсгээр ханиасаар морь унан сумын төвөөс шогшуулан гарав. Энэ өдөр хөдөө нутагт хэдий зудтай боловч нартай байв. Цасны ширхэгүүд нарны гэрэлд солонгорон харагдана. Уул хөндийн алсад адуу бэлчин бараан дүрс нь тэнгэрийн цэнхэр хязгаартай нийлэх мэт үзэгдэнэ. Тал нутгаар морьтой золгоочид, хэсүүлчид нааш цааш давхилдах бөгөөд хурц тод өнгийн хувцас нь ялгаран харагдана.

Яах гэж ийнхүү намайг хөдөө айлууд руу явуулсныг би сайн ойлгохгүй л байв. Юу ч гэсэн Догоо эмээд цагаан гурилын боов л хэрэгтэй юм байж...

Би тэр өдөр нээрээ ч ганц цагаан боовтой болов. Түүнийг Жавзан эгч нэгэн дугуй цагааны хамт өгөв. Бас хар гурилын дөрвөн боовтой болж, ганц төгрөг хүртэл олов. Орой намайг ирэхэд Догоо гуай сайхан зантай угтав.

-Ээ хүү минь даарсан байлгүй яах вэ. Суу, суу, цай уу! Хоол ид, дулаац хэмээн эгээ л нэг том хүн угтах мэт хэлээд,

-За эмээдээ бэлгээ өгчих гэв. Би өврөө ухаж, айлаас олсон хар, цагаан гурилын боовоо цөмийг нь өгөв. Тэгэхдээ нэг цаасаа л өгсөнгүй.

-Аа бас сайн хүү шүү гээд эмээ боовнуудыг далд хийж, дугуй цагаанаасаа эмтлэн амсаж үзсэнээ,

-Май, үүнийгээ чи ид! Юм олсон хүн идэлгүй яах вэ гэж тун чухал зүйл буцаан өгөх мэт хоёр гараа сарвайв.

Энэ өдрөөс хойш би боовнуудыг дахин үзсэнгүй. Эмээ надад боовнуудаас зөвхөн өгөөгүйгээр ч барахгүй улам ч харгис догшин болж, зарахгүй ажилгүй боллоо.

Үүр цаймагц намайг хэдэнтээ дуудсанаа сэрэхгүй болохоор өнөөх оосроосоо угз татан дээлийг минь хамж авна. Намайг өөрийн эрхгүй өндийхөд,

-Хормойгоо чирсэн новш! Настай хүнийг өрөвдөх хайрлахаа мэдэхгүй. Одоо бушуу гал түлээд, мөсөнд яв! гэж тушаана.

Би гал түлж, шуудай авч гол руу явах бөгөөд хүйтэн хайруу өглөө мөс хагалах шиг хэцүү юмыг би үзсэнгүй. Жижиг сүхээр мөсийг цохино. Зузаан шил шиг тунгалаг мөс дороо хөндийгүйгээр чулуутайгаа барьцалдан хөлдсөн учир, надад юун амар дийлдэх билээ.

Арай гэж эмтлэн, шуудайны дундуур мөс үүрэхэд жавар хацар гарыг хайрч, гар минь улайн, даарснаас мэдээ алдана. Бээлий надад байсангүй...

Хичээлдээ би ямагт хожигдох бөгөөд үргэлж өлсгөлөн явна. Байрны хүүхдүүд хоолноосоо хааяа илүүчилж, хар гурилын тал мантуу ч юмуу, нэг үмх мах цаасанд боон авчирч өгнө. Энхтуяа их сайн жаал. Тэр надад гэрээсээ идэх юм авчирч өгөх бөгөөд тэр нь хэдийгээр адууны мах боловч түүн шиг амттай зүйлийг би ер идэж үзсэн болов уу даа. Хичээл тармагц би гэртээ ирнэ. Догоо авгай дөрвөн ширхэг боорцог өгөөд хар цай аяганд хийж,

-Бушуу идэж уу, барилгын түүгээр явж зомгол түүж ир! гэж тушаав. Би барилгын түүгээр очиход тэндхийн ах нар цөм манай аавын танилууд байв.

-Аа Цэдэв хүү ирэв үү?

-Ааваас нь сураг байна уу?

-Алга ий. Зовох юмгүй хүү минь, цэрэгт сайн яваа гэнэ билээ. Тамсагбулагт байгаа гэсэн. Нутгийн улсууд сая очоод ирсэн дээ.

-Энэ хүү Догоогийнд гэл үү? Айхавтар чавганц даа. За хүү минь май, наад жаахан зомголоо шуудайлж ав! ...

Би зомголыг яаран шуудайлна. Энэ завсар өнөөх ах нар ярьсаар л байна.
-Ай хөөрхий дайн ч болох юм бил үү? Цаг хэцүү байна...
-Ах нар муусайн Германуудыг баруун тийш нь хөөсөөр гэдэг шүү.
-Тэд дийлнэ. Сайн санаатай хүмүүс юунд ч дийлддэггүй юм.
-Дайн болбол хэцүүдлээ. 39 он шиг юм болох вий гэж зовох юм.
-Дайн хаана ч дайн л юм. Идэх уух, өмсөх зүүх хүртэл ховордоод энэ
зуд хүртэл хажуунаас...

Би зомголоо үүрэн буцаж алхана. Тэр дайн гэгч юу вэ гэж бодном. Бодон бодсоор эцэст нь дайн гэгч манай Догоо эмээ шиг ийм л нэг ууртай чавганц байдаг болов уу гэж сананам. Ийм чавганц айл бүрээр ороод, идэх уухыг нь хамж, байдгийг нь цөлмөөд, хүмүүс эгээ л над шиг хоосон нойтон явахыг дайн гэдэг болов уу гэж бодном. Тийм ч байж магадгүй.

Би алхсаар л байв. Бяцхан зүрх минь баясалтай цохилно. Аав минь сайн яваа. Тамсагбулагт байгаа. Аавынхаа тухай дуулсан болохоор сэтгэлд таатай. “Аав минь мөд ирнэ. Манайх ойртон нүүж ирэхэд би гэртээ харина. Энхтуяа бид хоёр хурганд явж, Хэрлэнгийн эрэг дээгүүр ус харан хөл нүцгэн гүйлдэнэ. Тэгэхэд ийм их цас байхгүй. Уул хөндий нов ногоон байх биз. Ай яасан гоё вэ?” гэж би хөөрөн бодлоо.

Намайг зомгол үүрээд ирэхэд Догоо гуай ер баярласан шинжийг үл үзүүлэх бөгөөд,

-Тэр хатавчинд тавь! Тэгээд цай уувал уугаад, мөсөнд яв! гэж тушаана. Мөсийг би өдөрт хэдэн үүрэх боловч Догоо гуай цай их уух учир дорхноо дуусдаг байлаа.

Нэгэн удаа намайг мөснөөс ирэхэд Догоо гуай сайхан зантай угтав. Тэрээр тоотой хэдэн боорцгон дээр минь домбон саахрын хэлтэрхий тавиад,

-Цай уу, дараа нь хоёулаа гэртээ захиа бичнэ гэв.

Намайг цайгаа ууж дуусмагц эмээ миний толгойг ихэд энхрийлэн нэгэн удаа илээд,

-За цаас ав, бич! гэж тушаав. Би ч харандаа, цаас бэлдлээ.

Сайн уу, ээж ээ!” гэж Догоо гуай зүгээр л нэг хүнтэй мэндэлж байгаа юм шиг эхлэв.

“Би их сайн байна. Эмээ надад их сайн байдаг. Би өлсөөгүй, дандаа цатгалан байна. Та нарыг санаагүй. Наашаа ирээд хэрэггүй. Сургуулиа тарахаар нэгмөсөн очно”... ингэж бичүүлээд захиаг авч,

-За одоо зомголд яв, би энэ захиаг явуулна гэв.

Надад хичээлээ унших зав олддоггүй байлаа. Нэгэн өглөө ийм явдал боллоо. Тэр өдөр маш сайхан тунгалаг нар мэлтийтэл тусна. Тооны хичээл орж байв. Цэрэндолгор багш хүүхдүүдийн даалгаврыг шалгав. Би муу дүн авлаа.

-Яаж байна аа, Цэдэв ээ! Яагаад муу авч орхив? Чи чинь гурван жил дараалан сайн сурсан шүү дээ? гэж багш зэмлэнгүй байдлаар надад хэлэв. Би толгойгоо маажин зогсов.

-Дүү минь, багшдаа үнэнээ хэлчих. Чи ер нь энэ жил сурлагаар их муу болжээ. Яагаад байна?

Миний нүүр улайн, чих хүртэл халуу оргиод явчихлаа.

-Багшаа надад болох уу? гэж Энхээ тэндээс гараа өргөв.

-За!

-Багшаа, энэ Цэдэвийн байгаа айл байна шүү дээ. Догоо эмээ чинь их ууртай юм билээ. Цэдэвт идэх юм өгдөггүй. Бас дандаа хялалзаж, цэхэлзэж үргэлж л түлээ түү, мөс авчир гэдэг юм билээ. Тэгээд хөөрхий амьтан Цэдэвт хичээл давтах зав олддоггүй байгаа байхаа...

-Тийм үү? гэж Цэрэндолгор багш дуу алдаад нээрээ юу хэмээн надаас асуув.

Би юу ч хэлж чадахгүй зогссоор л байв.

“Одоо яана? Багш эмээ дээр очно. Эмээ надад муухай зан гаргаж зодно” гэж би айн бодно.

“Үгүй тэгснээс явсан нь дээр... Ээж дээрээ очсон нь дээр... оргоё” гэж би гэнэт шийдэв. Ийнхүү би хичээл тартал тэсэж ядан хүлээв. Хичээлийн дараа намайг гуанз руу явахад Энхээ,

-Чи хаачих нь вэ? Харихгүй юм уу? гэлээ.

-Үгүй, чи явж бай!

Чи надад гомдсон юм биш биз?

-Үгүй, үгүй...

-За тэгвэл баяртай!

Энхээг гүйн ормогц би шууд гуанз руу очив. Манай сум дорно зүг явсан машины зам дээр байдаг тул өдөр бүр машин ирнэ. Тэр машинууд гуанзны хажууд зогсож, даарч бээрсэн аяны хүмүүс гуанзанд хооллон дулаацаад явдаг байв.

Би гуанзанд бушуухан орж, нэг төгрөгөөрөө мантуу авав. Хар гурилын мантуу хоёр ширхэг өгдөг байлаа. Би халуу оргисон тэр мантууны нэгийг идэж, нөгөөг нь сүүлд идэхийн тулд өвөртөө хийв. Гадаа гарвал гурван машин зогсож байх бөгөөд хүмүүс нь гуанзанд бужигналдана. Би машин дээр сэмээрхэн гарч, тэвшний өмнө талд байх босгож тавьсан хэдэн шуудайтай ачааны дэргэд бөхийн суугаад дээрээсээ эсгийгээр даруулав.

Долоодугаар бүлэг

Удаж, удаж хүмүүс машин дээр сууцгаалаа. Азаар над дээр хүмүүс суусангүй байтал машин хөдөлсөн боловч нэгэн настай авгайн дуу гарч,

-Даржаа чи шуудайтай юмаа, гурил түшүүлээд тавьчихсан юм уу? Урд тал руу зай гарчихсан байх чинь... гэлээ.

-Үгүй шүү. Миний шуудайтай юм энд байгаа...

-Тэгээд наадах чинь хэний юм тэнд оччихов... Та нар намайг шахаад болохоо байлаа...

Миний ухаан гарах шахав. Би дүүрлээ гэж бодоод бөхийн суусаар л байв. Гэвч өнөөх шуудайны эзэн залхуу хүн бололтой.

-За яршиг, машин нэгэнт хөдөлсөн. Донсолгоонд зай гарах биз! гээд хажуу тийш налж суухдаа яг миний толгой дээр тохойлдов. Надад хэцүү байлаа. Тэр их хүнд хүн бололтой. Хэсэгхэн зуур яваад миний толгой өвдөж эхлэв. Хүзүү минь хөшиж, нүд эрээлжлэв. Би арай л ёо ёо гэж орилсонгүй. Гэтэл ашгүй машин донсолж өнөөх хүн нөгөө тийшээ налав. Гэвч өндийхөөс өөр аргагүй боллоо. Хүзүү хөшөөд сүйд болж байв. Машин нэлээд явснаа зогсов. Жолооч нь машиндаа бензин хийх бололтой.

-Хүүе Даржаа, наад торхныхоо бөглөөг аваад энэ шалаанкийг шургуулаад орхи! гэж жолооч хашхирав.

-За за гээд Даржаа нь миний хажуу талын торх руу өвдгөөрөө мөлхөхдөө хүзүүн дээр минь дөрөөлөв.

-Ёо , ёо , ёо гэж би хашхирлаа.

-Хүүе та минь, юу болох нь энэ вэ?

-Хүн орилоод байна!

Би тэсэж, нулимсаа хүчээр бариад шүдээ зуув.

-Яалаа гэнээ?

-Хүн “Ёо, ёо” гэж орилсон... Хаанаасыг хэн мэдэх вэ? Их л холоос орилох шиг болсон дог.

-Дулмаа чиний чих буруу дуулсан байлгүй яахав гээд Даржаа,

-За соров уу, болсон уу? гээд хойшоо болов.

Хэдийгээр мөрөн дээрээс Даржаа гуай холдсон боловч дараагийн аюул намайг зовоож эхлэв. Энэ бол бүтэж үхэх аюул байв. Машин зогсож байхад үүгээр түүгээр сийгэх салхи алга тул бор эсгийн дор бүгчимдэж эхэллээ.

Би бүтэж үхэхгүйн тулд эсгийнд нүх гаргах гэж хумсаараа эсгийг сэмлэн урав. Яг машин хөдлөхөд эсгий цооров. Эсгийг хуруу хэртэй цоолж, түүгээр хүмүүсийг ажиглан, өөрөө ч чөлөөтэй амьсгалж явав.

Миний хажууд дах нөмөрсөн бүдүүн хүн байна. Өнөөх Даржаа гэгч тэр бололтой. Нөгөө талд настай авгай хөвөнтэй дээл толгой дээгүүрээ нөмрөөд суужээ. Цаашаа харахад бас нэг хэдэн хүн сууж байв.

Гэнэт үүргэлж байснаа сэрсэн юм шиг өнөөх авгай над руу харж аймшигтай чангаар,

-Ай гэж хашхирлаа.

-Юу болов оо? Дулмаа гэж Даржаа толгойгоо өндийлгөн асуув.

-Чи түүнийг хар! Эсгийний цоорхойгоор хүний амьсгаа харагдаж байна гэж Дулмаа шивнэн хэлэв. Би амьсгаагаа дотогш нь татав. Даржаа нааш харснаа инээд алдав.

-Чи мөн хөгийн хүн ээ дээ Дулмаа! Зүгээр нэг цоорхой л байх шив гээд Даржаа доош бөхийн тамхи татав.

Би амьсгаагаа гаргаж уртаар амьсгаа авав. Дулмаа гуай над руу нүд салгалгүй ширтэнэ.

-Ай гэж тэр ахиад дуу алдав.

-Та нар чинь юу болоод байна? гэж хойноос нэг хүн асуув. Дулмаа гуай энэ удаа юм хэлсэнгүй. Нүдээ анив. Тэгээд харахад нь би өнөөх нүхээр хэлээ булталзуулж байв.

-Ээ бурхан тэнгэр минь, гээд Дулмаа гуай ахиад дуу алдав. Тэгэхэд машины хүмүүс инээлдэв. Цаашаа харж суусан хүүхэн над руу эргэж,

-Та чинь юу болоод байна даа? гэхэд Дулмаа гуай над руу дохив.

Энэ үед миний амьсгаа харагдсан байлгүй яах вэ. Өнөөх хүүхэн айж царай нь жигтэйхэн болоод явчихлаа. Тэгээд цааш эргэж бусад улсдаа шивнэв.

-Нээрээ тийм байна...

-Цантчихаж...

-Амьд амьтан л байгаа хэрэг.

-Оргодол хулгайч ороод суучихав уу? гэж жиг жуг гэлцэв.

Гэнэт Даржаа гуай миний дээгүүрх эсгийг хүчит гараар угз татан авав.
Би айж хулгасан амьтан хүзүүнийхээ чилээг гаргах гэж өндийлөө.

-Ээ базарваань, хэлээгүй юу гэж Дулмаа дуу алдав.

Аяны хүмүүсийн ширүүн нүд над руу ширтэнэ. Энэ сацуу ч нэг нь
машины бүхээг цохиж, машин ч зогслоо.

-Юу болов? гэсээр жолооч буув.

-Наашаа өнгий, үүнийг хар! гэж Дулмаа гуай бүхнээс түрүүн хашхирлаа.

Жолооч тэвш рүү авиран харснаа намайг сая л үзэж,

-Хүүе энэ чинь юу вэ? гэхэд,

-Сайн эр!

-Оргодол!

-Намайг хэчнээн айлгав аа гэлцэнэ.

Би доош бөхийн хэсэг зогссоноо үг дуугүй машинаас буув.

-Хүүе чи хаачих нь вэ? гэж жолооч миний мөрнөөс татав.

-Гэртээ харина...

-Гэр чинь хаана вэ?

-Баян-Улаанд...

-Ээ дүү минь чи буруу машинд суусан байна. Баян-Улаан чинь бүр
сумнаас нөгөө тийш явдаг замтай байхгүй юу? гэж жолооч бодол болон
хэлээд, гэртээ харих гээд сургуулиасаа оргочихсон эр байж, үгүй ээ мөн сайн
эр ээ!

-За байз, үүнийг чинь яадаг хэрэг вэ?

-Буцах машинаар явуулж орхиё. Жаахан хүлээвэл машин ирэх байлгүй.

-Хээр зогсоод осгох нь, дараагийн сум хүрээд хүнд захъя.

-Нээрээ тэгье гээд жолооч намайг машиндаа суулган цааш хөдлөв.

Хүмүүс надаар тоглоом хийн шуугилдаж байв.

-Энэ солиг нэг л учиртай оргосон доо гэж Дулмаа гуай хэлээд,

-Хүү чи яагаад гэртээ харих болов? гэрээ санаа юу? Эсвэл өөр
шалтгаан...

-Гэрээ санаад... гэхэд минь,

-Үгүй чи үнэнээ хэл. Май энэ чихэр ид! Тэгээд үнэнээ хэл. Энэ их
хүйтэнд ер хэдий гэрээ саналаа ч гэсэн аль нэг машинд хамаагүй суух ёсгүй
дээ, нэг учир байна гэв.

Би Догоо эмээгийн тухай ярьж гарлаа. Хүмүүс энэ түүхийг нулимсаа
урстал уйлж байж, бас нулимсаа урстал инээж байж сонсов.

-Тэгнээ тэр. Үүний нүд тэгж хэлээд байсан юм гэж Дулмаа гуай хэлээд,

-Дүү минь одоо буцаж очоод тэр Догоогийнд битгий оч! Цэрэндолгор
багш дээрээ л оч! Тэгээд байранд суусан нь дээр. Юу гэсэн үг вэ. Тэр чинь их
муу хүн байна.

-Нээрээ тэг дүү минь. Бас нутгийн амьтныг дамаар шулж байдгийг нь
дуугүй өнгөрч болохгүй гэж Даржаа гуай хэлэв.

Дараагийн суман дээр тэд намайг орхиж явахдаа, нэг нэг төгрөг өгөөд,
захисныг заавал биелүүлээрэй, зоригтой байгаарай гэж захицгаав. Дулмаа
гуай бүр намайг өрөвдсөндөө уйлж явав.

Өртөөний гэрт би хоёр хонов. Машиныуд дандаа л баруун талаас ирээд
дорно зүг явна. Энэ машиныуд берзонтээр бүтээсэн сум ачиж, заримынх нь

хойноос их буу зүүсэн байв. Хоёр хоносны дараа өртөөний сайхан зантай өвгөн нэгэн цэргийн машинд намайг гуйж суулгаж өгөв.

Наймдугаар бүлэг

Намайг суулгасан машин сургуулийн өмнө зогсоход, мэдсэн юм шиг Цэрэндолгор багш маань гараад ирэв.

Жолооч өртөөний өвгөний захиснаар миний тухай ярьж, намайг хүлээлгэн өглөө. Цэрэндолгор багш ч намайг дуу алдан тэвэрч авав. Тэгээд,

-За дүү минь, ангидаа очъё доо гээд гараас хөтөлсөөр ангидаа оров. Манай ангийнхны баярласан гэдэг жигтэйхэн. Намайг эрж тэд энд тэндгүй явжээ. Тэгээд муу юм бодож ихэд гунигтай болсон байв. Гэтэл би зүв зүгээр хүрээд очдог. Тэгэхлээр баярлалгүй яах вэ! Ялангуяа Энхээ бүр ч их баярлаж байв.

-За хүүхдүүд минь сууцгаа! гээд багш намайг ширээнд минь суулгаж,

-Цэдэв маань эргээд ирсэн нь юутай их баяр вэ? Тиймээ, хүүхдүүд ээ! Харин харамсалтай нь оргож зугтсаны оронд багшдаа, нөхдөдөө үнэнээ хэлэх ёстой байв. Энэ бол Цэдэвийн буруу. Бид нар бас Цэдэвийнхээ гэр орны амьдралтай ойртоогүй нь бас буруу. За ингээд одоо Цэдэвийг байранд суулгана. Аль нэг муухай санаатай хүнд Цэдэвийгээ загнуулах ч үгүй, заруулах ч үгүй. Тийм биз хүүхдүүд ээ?

-Тийм ээ гэж бүгдээр нирхийлгэв. Яг энэ үед хаалга сэвхийн нээгдэж Догоо гуай уйлсаар орж ирэв. Тэрээр намайг тэврэн авч нүүр нүдгүй үнсээд, үглэн дуулж гарав.

-Ээ бурхан минь, миний энэ хэдэр зан хүүхдийг алах шахав шүү дээ. Ингэж яваад чоно, нохойд идүүлсэн бол яана! Осгосон бол яана, ээ бурхан минь.

-Догоо гуай та гарзнаж байна уу? Бид ангийн хурал хийж байна гэж Цэрэндолгор багш зөөлхөн хэллээ.

-Ангийн хурал аа? За за... би одоохон... гээд над руу эргэж,

-Тармагц хүү минь харьж үз. Эмээ нь сайхан хоол унд хийгээд хүлээж байя гээд гарлаа.

-За тэгээд Цэдэв хүү өөрөө юу гэж бодож байна даа? гэж надаас багш тайван асуув.

-Би сургуульдаа хайртай.

Би байранд сууна. Би ... Догоо гуайнд очихгүй. Догоо гуай намайг зоддог... гээд л би уйлж орхилоо.

-Зүйтэй. За тэгвэл хүүхдүүд ээ одоо Цэдэвийгээ байранд нь оруулж өгье.

Хүүхдүүд шуугилдан гарахад би тэдэнтэй хөтлөлцөн гүйж байв. Намайг тэд саруулхан том дотуур байрны тасагт оруулаад нэгэн модон орыг:

-Энэ чиний ор гэж заав. Бас Энхээ энэ тэр нярваас ор дэр авчирч орыг минь засаж өглөө. Хоёр хүүхэд Догоо гуайнхаас миний хувцас хунарыг авчрахаар гүйн одлоо.

Багш намайг халуун усны байшинд авчирч тэнд байсан нэг эгчийг дуудан,

-Манай Цэдэвийг нэг сайхан угаагаад орхиорой! Шинэ цуу ямбуу цамц, өмд өмсгөөрэй. Өнөөдрөөс эхлээд манай сургуулийн дотуур байрны хүүхэд болж байгаа юм шүү гэж захилаа.

Би усанд оров. Ай ямар сайхан гэж санана. Энэ бол миний анх удаа орж үзсэн халуун ус байв. Би хирээ сайтар угаав. Ингэж би анх удаа 1944 оны мичин жилийн зудны өвөл дайны амьсгаагаар зан нь эвдэрсэн Догоо гуайн хар хараал, хатуу гараас ангижирч, сургуульдаа бүр мөсөн очсон юм даа.

Асууулт даалгавар:

1. Зохиолчийн намтар, бүтээлийг хураангуйлан бичнэ үү?
2. Жаалхүү, Догоо эмгэн, багш нарын дүрийг харьцуулан тайлбарлана уу?
3. Зохиолд зохиомжийн задлал хийнэ үү?
4. Зохиолд тухайн нийгэм цаг үеийг хэрхэн тусгасныг тайлбарлаарай.

Энх тайвны манаа

Ц. Уламбаяр

Машин, машин ирлээ! гэж бөмбөг тоглож байсан хилчдээс хэн нэг нь хаширав: Тэд тоглоомоо дуусгалгүй дутуу орхиж, цөм зүүн хойш харцгаав.

Буданчийн голын хойт хөндий, цэнхэр униар татан цэлийсний дунд гозгор цагаан тоос босож, халсан моторын дуу тачигнан сонсогдож байлаа. Отрядын төв байгаа жижиг хөх толгойг чиглээд хурдлан яваа тэр машин бол шуудангийн машин байжээ. Амралтын энэ өдөр хүмүүс өөр өөрийнхөө юу дуртайг хийцгээж байжээ. Буданчийн голыг өгсөж уруудаад бужигнаж байсан хүмүүс машины бараагаар цугларан ирцгээв.

Хойт хөндийд тэмцээний буудлага хийж байсан хүмүүс ч бууж ирэв. Клубийн үүдэнд тусгайлан зассан газар шатар наадаж байсан дэд хурандаа Зонров хүртэл хожих хожигдохоо үзэлгүй штабын үүдэнд бөөгнөрөн байгаа хүмүүсийн дэргэд хүрч иржээ.

Өглөөнөөс аваад үд өнгөртөл биеийн тамир, бүжиг, шатар зэрэг олон төрлийн тоглоомоор тоглохдоо халуун байна гэж ганц ч үг дуугараагүй байсан хүмүүс одоо машин хүлээх энүүхэн хооронд хүн болгон л яасан халуун өдөр вэ? гэж шагшин ярьцгаана. Үнэндээ ч халуун өдөр байлаа. Шууданг удаж ирдэг юм болов уу гэж бодвол тийм биш юм. Долоо хоног бүр ирдэг шууданг хаанаас тэгж бодож болох вэ? Харин шуудангаар ирэх ном, хэвлэлийг үзэж өдөр ирэх тутам өрнөн цэцэглэж байгаа сайхан эх орныхоо бадрангуй хөгжилтэй цаг тухай бүр хожимдохгүй танилцаж байхыг хүсэн эрмэлзэхдээ тэд ингэж хүсэл мөрөөдөл болж байгаа юм. Дэд хурандаагийн гол шаардлага ч тийм юм. Мэндэлснийхээ дараа за ямар сонин ном уншиж байна? гэж асуух нь дэд хурандаагийн ерийн заншил нь болсон хэрэг юм! Машин явсаар хүрч ирэв. Алс хол Улаанбаатараас гараад энэ жолооч намайг амруулахгүй хийсгэн давхиулсаар баахан ядруулав гээд амьсгаадан зогсож байгаа юм шиг шуудан ачиж ирсэн машины радиаторын ус буцлан шуугьж байв. Энэ жолоочийн довтолгон давхисныг буруутган үзэж болохгүй. Хилчид гадаа дэвсгэр дэвсээд том том булигааран богцтой юм буулгаж яаран задлав. Ангийн дарга нар сонин захиалагчдынхаа нэрсийг бариад манайд өдий, танайд төдий гээд бужигнаж байна. Намын товчооны дарга сонины боолт олсыг тайлах гээд оролдон ядаж байв.

Харсан хүмүүс нөхөр дарга аа! Та үүнийгээ огтолчих л доо гэж шаардаж байна. Олон өнгийн марк наасан том жижиг олон хэвийн үсгээр бичсэн хэдэн зуун захидлыг тал бүрээс нь шүүрч надад юу байна? Май! Энэ чиний захидал байна гэх зэргээр шуугилдаж байлаа. Тэр үед хөөрхөн хөх толгой дээр алсын бараа хараад зогсож байсан байрын манаа, холбооны байранд заставуудтай холбоо барьж байсан холбоочин хоёроос бусад нь цөм энд бужигнаж байх шиг байв.

Шуудан ирснээс хойш даруй хоёр цаг өнгөрлөө. Хилчид их төлөв байрандаа орж гэр орон, ах дүү, амраг садангаасаа ирсэн захидлыг уншицгааж, нутаг нутгийнхаа сонинг харилцан ярилцаж бас хариу бичих нь бичиж, ертөнц дахиныг гэрэлтүүлэн харагдуулагч гайхамшигт толь болсон сонин хэвлэлээ уншицгааж байлаа.

Дэд хурандаа Зонров төвөөс ирсэн бичиг тушаалуудтай танилцаж хариу бичих хүмүүст зааварлаад, штабаас гарч хэсэг сонин барьсаар гэр тийш явав. Цамцныхаа захны товчийг тайлж ширээнийхээ дэргэд суугаад аягатай хүйтэн сүүг авч уух зуураа шинэ сонин уншиж эхлэв. Хувьсгалын 27 жилийн ойг угтаж манай эх орны үйлдвэрүүд төлөвлөгөөгөө төдий өдий зуун хувиар давуулан биелүүлж байна. Манай өргөн уудам орны малчид анхдугаар таван жилийн төлөвлөгөөний эхний жилийнхээ тэргүүн хагаст тийм тийм амжилт гаргаж байна гэх зэрэг манай улсын энх тайван цагийн бүтээн босгох баясгалант их хөдөлмөрийн өрнүүн дүнгүүд сонинд дүүрэн бичигдсэнийг сэтгэл хангамжтай уншиж байлаа. Гэтэл хаалга тогшиж холбооны жижүүр орж ирээд нэгэн мэдээ өглөө.

Тэр мэдээнд “арван зургаа, хорин нэгдүгээр тэмдэгт тазруудаар таваас долоон морьтой дайсан этгээд өглөөний арван нэгэн цаг хагаст манай улсын хилийг зөрчиж тагнуул хийж байгаад буцлаа... “ гэснийг уншихдаа Зонров хөмсгөө зангидаж байлаа. Тэгээд сонингоо ч уншиж дууссангүй, аягатай сүүгээ ч ууж барсангүй, цамцныхаа захны товчийг дахин товчлоод яаран гарч штаб руу явжээ.

Би энэ зүйлийг, таны хэлж байгаагаас огт өөрөөр бодож байна. Бид гадаад Монголын хязгаарын цэргээс амьд хүмүүсийг барихдаа, тэдний хилийн гүн дотор орохгүйгээр яасан ч гэсэн барьж чадахгүй гэж хэлээд ноён Зо Пу Сан, арван тав дахь янжуураа асааж, энэ хүн юү гэж хэлэх бол гэсэн байртай хажуудаа сууж байгаа дөрвөлжин хар шил зүүсэн, энгийн хувцастай шинэ ирсэн хүн тийш харлаа. Тэр ноён бол гоминданы Ч... хотоос брезент бүтээлгэтэй ачааны арван машины хамт, дөнгөж сая цагийн өмнө баруун хойт хязгаар Син- цзян мужийн Ү... хотод хүрэлцэн ирээд байгаа хүн юм байжээ. Нэр нь Жон. Энэ ноёныг хэн ч харсан жирийн нэг хүн гэж хэлмээр байв.

Би гучин хэдэн жил тагнуулын газар ажиллахдаа нэг ч удаа алдаа гарган осолдож байгаагүй юм. Ямар хашир догь тагнуулчин ч гэсэн хэний төлөө ажиллаж байгаагаа надаас нууж ер чаддаггүй юм гэж үргэлж гайхуулах дуртай ноён Зо Пу -Сан хүртэл энэ хүнийг чухам хэний төлөө ажиллаж байгаагийг нь мэдэх нь байтугай одоо хүртэл түүний нэрийг нь олж сонсоогүй байгаа нь хачин гайхалтай хэрэг. Тэр ноёны үнэмлэхүүд гэдэг нь тун айхавтар сүрхий сүр бадруулсан зүйлүүд байна. Зарим үнэмлэх нь их ноён Чан Кай

Шигийн гарын үсэгтэй хүртэл байсан дээрээс Зо Пу -Сан тэгж үхтэлээ хулчийсан юм байжээ. Зо Пу Саныг айлган сүрдүүлсэн залуу ноён маань, ямар нэгэн хүнд ноцтой бодолд дарагдаж амар хялбар тайлагдахгүй оньсогын өмнө тулгарсан мэт бодол болж бичиг гэтэл бичиг ч биш, зураг юм уу даа гэтэл энэ дэлхийд урьд хожид байгаагүй ямар нэгэн амьтны дүрсэрхүү дэмий балай юм эрээчиж байсан цаасаа хумхин үнгэлдүүлж хогийн сав руу хаяад

Та ямар учраас тэгж бодож байна! гэж асуусанд ноён Зо Пу -Сан янжуурынхаа сорсон утааг залгилгүй дээш нь үлээгээд,

Тэр Монголчууд гэдэг чинь чонын санаатай улс байгаа юм. Манай гоминданыхныг эв найрамдал, энх тайван байдлыг эвдэж байна энэ тэр гээд л дэлхий дахинд зарлах болно. За тэр ч бас гайгүй хэрэг гэж бодъё. Монгол улсын хилийн дотор гоминданы цэргүүд төдий километрийн газар байгаа тийм нэртэй нутагт тэгж ингэж будлиан самуун гаргасан гэх зэргээр биднийг хаашаа ч гарах газаргүй болтол нот, эсэргүүцэл гаргаж манай Чан Кай-Шигийн засгийн газрыг, баахан зовоох болно байх гэж би тун их зовж байна гэж хэлээд өмнөө дэлгээтэй байгаа нарийн тодорхой зурагдсан Монголын баруун хязгаарын газрын зураг дээр ямар нэгэн үл олдох чухал нарийн зүйлийг эрж байгаа юм шиг гөлрөн харж байлаа. Ноён Жон суудлаасаа босож тасалгаан дотор ийш тийш хэд алхаад, цонхны дэргэд очжээ. Тэгээд энэ цонхны хөшгийг юунд ингэж гашуудлын юм шиг заавал хар бараан юмаар хийсэн юм бол гэж бодов. Гэвч би одоо ямар баруун зүгийн орнуудад хурим найрын газар сууж байгаа биш дээ. Тэр бол тэндхийн л хэв заншил юм биз. Үнэндээ Хятадын гашуудлын ёс бол цагаан өнгийг эрхэмлэдэг шүү дээ. За тэр ёс дэглэм ч ямар хамаа байх билээ. Энэ бол нэгэнт тагнуулын газар болсон хойно хар хөшигтэй байх нь долоон зөв юм гэж бодоод цонхны хөшгийг ярж гадагш харжээ. Ноён Зо Пу Саны яамлан байгаа ганц дан хөх туйпуун байшин нь ноён Жоны сэтгэлд тун тохиромжтой санагджээ. Тэгэхдээ сайхан барилгын хувьд биш, ажил хэргийнх нь хувьд тохирсон бололтой. Тэр байшин гадна талаараа байшингаасаа өндөр хэрэмтэй, тэр хэрмийн хаалгаар ортол энгийн хэдэн байшин байна. Тэр байшингийн нэгд ороод хөшигний араар оруулан хийсэн оньсыг дарахад туурга нь хаалга болон онгойдог юм. Тэр хаалгаар дамжиж дотогшоо ортол бас нэгэн давхар хэрэм байна. Тэр хэрмийн дотор энэ байшин байгаа юм байжээ. Ноён Зо Пу Саны энэ хөх байшинг Ү... хотын тоотойхон хүн мэддэг юм гэнэ. Хөх байшин ч нууц, хөгшин Зо Пу-Сан ч нууц, ер нь тэнд, нууцгүй юм алга шиг байжээ. Цонхны цаана шөнийн гүн харанхуй Ү... хотыг нөмрөн бүрхсэн байх нь шинэ ирсэн ноёны сэтгэлийг уймруулж, учир нь олдохгүй байгаа тэр ажил хэрэгтэй нь адил юм шиг санагдуулжээ.

Ноён Жон уртаар санаа алдаад хөшгийг дахин хааж цонхны тэндээс эргэж Зо Пу-Саны дэргэд хүрч ирээд,

Монголчууд юу ч гэж галзуурч байсан хамаагүй хэрэг. Хэрэв гадаад Монгол урьд адил тийм эсэргүүцлийн нот ирүүлэх юм бол манай гоминданы засгийн газраас ийм хариунуудыг өгч болох мэт санагдаж байна. Манайх руу Монголын хязгаарын цэрэг довтолсон болохоос биш, манай цэрэг довтолсон удаа нэг ч байхгүй гэж хариу өгч болох байна. Тэр хариуг бүтэхгүй гэж үзвэл бас нэг сайн арга байна. Хэний ч харьяат биш хилийн дээрэмчин довтолсон

юм гэж хэлж болох байна. Үүнд, манай гар хөл бологч нар гомдож байж магадгүй юм. Гэвч хэрэг нэгэнт бүтэж байвал тэднийг тайтгаруулж болно.

За ер нь хариу өгөхгүй байсан ч яадаг юм. Энэ явдал бид мэтийн дотоодын нарийн нууц ажилтан хүмүүсийн ажил хэрэгт ер хамаагүй хэрэг. Тэр нялуун зантай дипломат нартаа л хэрэгтэй юм биз. Одоо үед манай гоминданы дипломат нар ч гэсэн тэр мэтийн дэмий балай хэргийн хойноос хөөцөлдөхөө болиод байгаа юм.

Иймд ер нь олон таван санаа огт хэрэг алга. Харин энэ шөнө хүмүүсээ явуулах хэрэгтэй болоод байна. Зо Пу -Сан та чухам аль чигээр явуулах төлөвлөгөөтэй байна вэ? гэж хэлээд түүний үзэж байгаа газрын зураг руу тонгойжээ.

Ноён Зо Пу-Сан гуулин тоногтой хуучин цагийн хийцтэй, нүдний том цагаан шилээ засаж зүүгээд зураг дээр том хүрэн толбоор тэмдэглэсэн газар муурны хумс шиг урт хурц хумстай судас нь гүрийсэн хатангир гарын нарийхан хуруугаар чичлэн зааж,

Энэ чигээр довтолбол зүгээр гэж санаж байна гэжээ. Ноён Жон яг тэр том хүрэн толбо дээгүүр зурагдсан бүдүүн улаан зураасыг хараад улайсгасан халуун төмөрт хайрагдсан юм уу, эсхүл цахилгаан тогонд цохиулсан юм шиг татганан дал мөрөө хавчисхийлгэж ширээн дээр байгаа өтгөн хүрэн архинаас нэг хундага залгилав. Тэгээд:

Энэ чинь ямар нэртэй газар гэгчив? гэж огт мэдэхгүй хүний царай гарган асуусанд Зо Пу-Сан гал нь буурсан жартгай бор нүдээр хамрынхаа хоёр талаар унжсан саравчныхаа дээгүүр ноён Жон тийш гайхсан янзтай хараад,

Энэ бол Байтаг богд гэдэг уул байгаа юм гэлээ. Ноён Жон нүүрнийхээ хамаг арьсыг үрчийлгэн ярвайгаад,

Монгол улсын хил, яг энэ Байтаг уулын орой дээгүүр гарч байгаа хэрэг юм уу гэж асуусанд Зо Пу –Сан, шилэн хүзүүгээ маажгаад,

Түүхийн ёсоор авч үзэх юм бол үнэн хэрэг дээрээ тийм биш юм. Энэ Байтаг богд уул бол гадаад Монголын хилийн гүн дотор байгаа тэдний уул юм гэж хэлээд, тэр хүрэн толбын зүүн хойт хажуугаас дотогш гарсан нарийхан хөх зураасыг зааж,

Энэ бол Бүдүүн Халгайтын гол гэж нэмж хэлжээ. Ноён Жон ганц хундага дарсандаа халамцаагүй боловч тун сүрхий зүрх орчихсон царай гарган гараа ардаа үүрч цээжээ гэдийлгээд,

Халгай гэдэг чинь, Монголоор гар хүргэж болдоггүй өргөст халуун өвсийг нэрлэдэг юм. Тэгэхээр тэр газар тийм өвс их ургадаг юм байхдаа гэж хэлсэнд Зо Пу-Сан, бүр их гайхсан янзтай далаа хавчиж хоёр гараа сарвайлгаад бид “Р” гэдэг үсэг хэлэхдээ муу Байтаг гэдгийг та яахин ойлгохгүй байх билээ. Тэр газар бол Бүдүүн Халгайт биш Бүдүүн Харгайт гэдэг юм. Харгай гэдэг үг бол Монголоор модтой газрыг нэрлэсэн бололтой юм шиг байна. За ингэж нэр томьёоны хойноос хөөцөлдөх маань одоохондоо онц биш шиг байна. Харин жинхэнэ ажил хэрэгтээ түргэн орвол яана гэж хэлээд, санамсаргүй сүрхий үг, зүрх гарган хэлснээсээ зовсон бололтой ноён Жонг царайчлан хэлэх үгий нь хүлээж байжээ.

Ноён Жон, Зо Пу Саны дээд уруулынхаа хонхорт тавьсан жижиг дөрвөлжин сахлыг хараад мянга есөн зуун дөчин таван оны намар цаг, Японыг дарагдсаны дараа Нанжин хотод оршиж байсан Японы тагнуулын газрын албан хэрэгтэй танилцаж байгаад, ноён Зо Пу Саны яг мөн энэ янзаараа авахуулсан зургийг үзэж байснаа санаж, энэ хүн тэр цагтаа Японы төлөө ямар их үнэнч шударгаар ажиллаж байсан бол гэж бодоод өмднийхөө карманд үргэлж авч явдаг жижиг буундаа өөрийн эрхгүй гараа хүргэсэн байлаа. Гэвч эгшин зуур биеэ эзэмдэж гараа буунаас салгаж төв төвшин байдалтай болж,

Эрхэм ноён Зо Пу-Сан та яагаад заавал тэр Бүдүүн Харгайтын чигийг сонгож авсан хэрэг вэ? гэж асуусанд Зо Пу-Сан өөрийгөө ноён гэж хэлүүлэх туйлын их дуртай хүн юм. Гэтэл энэ хүн зөвхөн ноён гэж хэлээд зогссонгүй, харин эрхэм ноён гэж хэлсэнд бүр ч их тааламжтай сайхан санагдаж, зулайгаар халзайгаад хоёр шанаандаа санчиг болон үлдсэн үсээ төрөлхийн сурсан зангаараа илэн засаад, ярвайн инээмсэглэж

Бүдүүн Харгайтын гол бол их шугуйтай газар юм. Тэр голын адагт Монголын хилийн манаанууд байрлан суудаг. Тэгэхлээр манай цэргүүд уг голыг уруудаж нуугдан очоод тэдний манаануудыг ганц ч үг дуугаргалгүй барин авч тэндээ хориглон байж, ирсэн хүн болгоны нь урхиндаа оруулан аваад ан гөрөө ихтэй буцаж ирэхэд дөхөмтэй юм гэж санаж байна гэж хэлсэнд, ноён Жон үл мэдэг инээмсэглэж

Таны энэ төлөвлөгөөг би тун их догь болсон юм байна гэж бодож байна. Иймд ноён таны тааллаар больё. Та одоо нарийн бичгийн даргаа дууд гэж хэлээд цагаан бүрхүүлтэй хонхор зөөлөн сандалд шигдэн суужээ.

Ноён Зо Пу-Сан, өндөр шагнал горьдсоноо мэдэгдэхгүйг хичээсэн царай гарган, цахилгаан хонхоо дарав.

Хажуугийн тасалгаанаас энгийн хувцастай, туранхай цагаан царайтай, олон хоног нойр алдсанаас нүд нь улайсан, хорин хэдэн насны залуу орж ирээд, ердийн заншлаараа номхон зогсож тушаалыг хүлээжээ.

Заавал тийм байх ёстой юм шиг ноён Жон инээсэн, ярвайсан хоёрын хооронд байдал үзүүлэн нүүрнийхээ хамаг арьсыг хамар дээрээ бөөгнөрүүлэх мэт болж занан зүхэж байгаа янзтай долоовор хуруугаараа түүн тийш чичлэн зааж

Чи одоо яваад Ч... хотоос сая ирж энэ баруун хашаанд буусан цэргүүдийн командлагч дэд хурандаа Хау Ен гэдэг хүнийг дагуулаад ир!

Бусад цэрэг офицеруудтай уулзаж болохгүй! Тэд чамаас бидний ирсэн энэ хот, ямар нэртэй хот вэ гэх зэрэг олон таван юм асууж магадгүй. Тэгвэл чи, би хятад хэл мэдэхгүй гэж англиар хэлээд толгойгоо сэгсрээд бушуухан гарч ирээрэй. Хэрэв чамайг тэдэнтэй ганц ч гэсэн үг сольсон байх юм бол маргааш чиний наадах бөндгөртэй чинь ярилцах болно гэдгийг чи хатуу мэдэх хэрэгтэй. Тэр дэд хурандааг дагуулж ирэхдээ хаана ирж, хэнтэй ямар хэргээр уулзах гэж байгааг хүртэл хэлж огт болохгүй. Харин түүнийг энэ хойт талын долоодугаар хаалгаар оруулж ирээрэй! гэж тушаажээ.

Нарийн бичгийн дарга мэдлээ гэж ёслоод тонголзон гарч явжээ. Тэгээд удаж төдсөнгүй махлаг тарган, нэлээд өндөр, цоохор нүүртэй, дээд шүд нь эрүүнийхээ шүдний дотор талаар орсон яйвгар урт эрүүтэй, дөчин хэд хүрсэн бололтой шанааны нь үс буурал болсон дэд хурандааг дагуулан орж иржээ.

Хуурай газар эцтэлээ дэвхэрч яваад сая нэг намгийнхаа усанд орж аваад сэтгэл нь амарсан мэлхий шиг хонхор сандалдаа шигдэн сууж шил зүүсэн тэр хоёр ноёны чухам алинд нь ёслохоо сайн мэдэхгүй,

Дэд хурандаа би эрхэм ноёдын тушаал ёсоор хүрэлцэн ирлээ гэж хэлээд дунд нь ёсолжээ. Нөгөөдөх Ч... хотоос хамт ирсэн Жон биеэ бага зэрэг хөдөлгөөд сурсан зангаараа нялганаад сул сандал тийш зааж

Ноён дэд хурандаа та, морилон суу гэжээ. Дэд хурандаа Хау Ен, Ч... хотод байдаг арван найман настай дайвар эхнэр Жин Хау гэдэг хүүхнээсээ илүү хайртай нарийнхан тахир цагаан сэлмээ хоёр өвдөгнийхөө хооронд тулж суугаад, цээж гэдгэр, толгой дээгүүр, гал нь унтарсан цэхэр нүдээр ноён Жон тийш харжээ.

Дэд хурандаагийн сэлмэндээ тийм их хайртай болсон учрыг олон хүн мэдэхгүй байж ч болох юм. Тэр тахир цагаан сэлмээр эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө босож тэмцсэн Хятадын ажилчдын жагсаалыг дарах гэж ир, мөр аль дайралдсан талаар нь нүүр нүдгүй цохилж байсан удаа олон бий. Тэр сэлэм бол Хятадын үнэнч шударга үй олны цусаар будагдаад, үнэний хувь байхгүй харгис хар хэргийн билүүгээр ирлэгдэн хурцлагдсан цуст мэс юм.

Хамгийн тэмдэглэлтэй ойрын нэг зүйлийг дурдахад, энэ өнгөрсөн 19... оны намар цаг Ш... хотод болсон шинэ дайн өдөөгчдийг эсэргүүцэн, эв найрамдал, энх тайвныг хамгаалан тэмцсэн ард түмний өргөн их жагсаалыг цус урсган тараах хэрэгт энэ сэлэм мөн л гозолзож байсан юм байжээ.

“Шинэ дайн шатаагчид сөнөтүгэй”, “Улс түмний энх тайвны ариун үнэн хэргийн төлөө хүчээ нягтруулъя”, “Хятад улсын дотоод хэргээс Англи, Америкийн харгисуудыг хөөн зайлууъя” гэх зэрэг үг үсэг бүхий яриа лоозон, туг далбаа барьсан олон түмэн хүн гудамжинд жагсан гарчээ. Тэр жагсаалд таяг тулсан өвгөд, сургуулийн сурагч, оюутан залуу, хүүхдээ тэвэрсэн эмэгтэйчүүд, гоминданы погоон тэмдгээ авч хогийн сав руу хаясан, цэргийн хүмүүс хүртэл оролцсон тийм өргөн сүрт жагсаал болжээ.

Дэд хурандаа Хау Ен, тарган цагаан морь унаж, энэ сүрхий сэлмээ бариад, тэр жагсаалыг тараах цэргийн хамт дайран орж, байлдан тулалджээ.

Тэгэхдээ нялх хүүхдийг эхийнх нь гар дээрээс энэ сэлмээрээ өлгөж аваад сарвалжуулан чарлуулж, тав бахаа хангасан төдийгүй махчин харцагад зулзагаа шүүрүүлсэн ангир шувуу ганганан гасалж, түүний хойноос гашуудан бахираад гүйж байгаа эхэд нь гүйцэгдэхгүйг хичээж мориндоо ташуур өгөөд хар хурдаар нь харайлгаж байхдаа сая нэг хүсэл нь ханаж байжээ.

Хүүхдийг тэгж алаад, засмал гудамжны шулуун шалан дээр сарвайтал нь шидэж, улам улайран дайрсаар ёстой нэг галзуурсан чоно шиг загнаж, гарынхаа аль ойр дайралдсан болгоныг хярган хядаж байсан хайрт сэлэм нь эн юм байжээ.

Одоо энэ сэлэмнээс гэмгүй олон номхон хүний ариун цус арилаагүй ч байж мэдэх юм.

Гэвч дэд хурандаа Хау Ен –г дандаа тэгж гудамжны зэвсэггүй жагсаалтай байлдаж явсан хүн гэж хэлбэл огт буруу болно.

Түүний зүүн хацар дээрх сэлмээр цавчигдсан сорив бол бүр ч юу юунаас илүү баларшгүй тамга болон тогтжээ.

Би хорь гаруй удаа дайн тулаанд явж, долоо дахин шархадсан гэж яриа болгоныхоо өмнө оршил болгон ярьдаг заншилтай хүн юм аа. Ялангуяа жаахан юм балгасан цагтаа бол бүр ч сүрхий. Хүн амьтан аймаар зүйлийг ярьдаг байжээ.

Харин энэ удаа ярих зав одоогүй байгаа бололтой дув дуугүй сууж байна. Ноён Жон, Хау Ен –г цэрэг улс төрийн боловсролоос хоцорсон ёстой нэг гахай шиг тэнэг амьтан гэж дотроо тоохгүй үргэлж голдог боловч, хэргэм зэргийн хойноос ухаан жолоогүй хөөцөлддөг мөнгө зоос олохын тулд ямар ч хэрэг гаргахаас буцдаггүй яргачин зангий нь сайн мэдэх тул хуурамч зан гарган тонголзоод, Хүндэт ноён дэд хурандаа таныг бид хамгийн хүнд бөгөөд чухал хариуцлагатай нэгэн албанд томилон явуулах гэж байна. Тэр албанд таныг маш дуртай морилон явж их гавьяа байгуулаад ирнэ байх гэж би гүн итгэж байна. Танд ганц би ч итгэж байгаа хэрэг биш, гоминданы засгийн газар нэгэн адил итгэж байгааг уламжлах эрхийг надад олгосон юм гэж хэлсэнд дэд хурандаа Хау Ен ухасхийн босож номхон зогсоод.

Дэд хурандаа би, чадахын хэрээр зүтгэхийг баталж, таны ариун өлмийн өмнө мөргөн сөгдье гээд ёслон тонголзсонд ноён Жон толгой дохиод;

Зүгээр, зүгээр. Та морилж суу гэжээ. Хау Ен дахин сандалдаа суугаад,

Ноён та намайг ямар албанд томилон зарах гэж байгаагаа айлдан хайрлаж болох болов уу гэж хэлсэнд ноён Жон;

Үүнийг танд дээр хэлээгүй миний буруу. Гэвч одоо хэлэхэд хожимдох юу байх билээ. Та явж Гадаад Монголын нутаг руу ороод, тэдний хилийн цэргээс амьд хүн олныг барьж ирэх хэрэгтэй байна гэж хэлсэнд, Хау Ен-гийн царай нь хувхай цагаан болсныг ноён Жон ажиг авсан бололтой.

Та гүйцэтгэж лав чадна. Тийм найдвар юунд байна вэ? гэвэл таны удаа дараа байгуулсан гавьяат олон явдал чинь баталж байна. Хоёрдугаарт таны одоогийн командлан явах энэ цэргүүд бол зүүн хойт фронт дээр улаантантай байлдаж байсан ангиас тэдний хамгийн түрүүнд явсан дайрагч отрядын шигшмэл хүмүүсийг зориуд энэ хэрэгт татан авчирсан юм. Тэд бол дайрахаас ондооноор байлдаж сураагүй хүмүүс юм.

Та мэднэ, манай гоминданы цэрэг дандаа албан хүчээр баригдан дайчлагдсан хүмүүсээр бүрдсэн байхад тэд бол цөм өөрийн сайн дураар мордсон хүмүүс юм. Тэдний уг үндэс нь дээрэмчин гаралтай боловч цөм манай хэргийн төлөө амь насаа зориулсан улс байгаа юм. Тийм болох нь удаа дараагийн шалгалтаар батлагдсан хэрэг. Хүндэт ноён та сэтгэл бүү зов! гэж хэлээд ягаан хайрцагтай янжуур гаргаж өөрөө нэгийг асаагаад дэд хурандаа Хау Ен-д бас тамхилав. Хау Ен, салгалсан гараар тамхинаас авч асаагаад олон зүйлийн хүнд бодолд дарагдаж эхэллээ.

Анх Ч... хотоос нааш гарахдаа чухам хаачхаа сайн мэдэхгүй боловч ойр зуур явж, улаантныг талархан үздэг, сэжиг бүхий нутгийн хүмүүсийг барих юмуу, их сайндаа тариачны бослогыг даруулахаар явуулж байгаа юм байх гэж бодож явлаа. Гэтэл энэ хэрэг нэгэнт тийм биш болоод ангийн буугаар зэвсэглэсэн тариачинтай ч буудалцахгүй, тосгоны нохойг шуугиулан очоод нам гүм унтаж байгаа айлын хаалгыг сүр бадруулан учир дүрсгүй балбан дэлсэж тайлахаас нь өмнө эвдэж ороод, Танайд цаазтай номнууд буюу хориотой ухуулах хуудас байгаа юм биш биз. Ямар боловч бид танайхыг

нэгжиж үзнэ гэж хэлээд хамаг юмы нь онгичиж, уг эрсэн зүйлээ гарсан гараагүй хамаагүй, аль өнгөтэй өөдтэй хамаг хогшлы нь хамж аваад гэрийн эзэн гэмтэй гэмгүй хамаагүй нүдэндээ эвгүй харагдсан юм уу, ноён Хау Ен -гийн ханцуй руу хэдэн янчаан сэмхэн шургуулж чадахгүй бол чи коммунист гэж хэлээд гары нь ард нь янгинатал хүлээд тууж явдаг тэр ажилтай нь огт зүйрлэшгүй, хатуу ширүүн бөгөөд хүнд ноцтой зүйл өмнө нь хүлээж байх шиг, давж болшгүй хана хэрэм урд нь босох шиг санагдаж байжээ. Ядахдаа сүүлийн үед Хятадын баатарлаг арми, амжилттай давшин гоминданыхан балран нурсаар байна гэдэг түгшүүрт мэдээ олонтоо ирдэг болжээ. Энэ сагсуу ноён гаднах байдлаараа түүнийг шал тоохгүй царай гарган байхыг хичээдэг боловч, үнэн хэрэг дээрээ зүрхэнд нь хилэнт ардын хурц жад тулж, шударга түмний таслан шийдэх, шүүхийн хэрэгтний ширээ харагдах шиг болдог болсон үед нь ийм сүрхий хүнд явдал өмнө нь тулгарчээ. Ноён Жон суудлаасаа босож Хау Ен-гийн мөрөн дээр гараараа аяархан дарж,

Та Монголын хилийг хаагуур яаж давах, нэвтэрч орсон хойноо хүмүүсийг яаж барих зэрэг хамаг явдлаа одоо энэ хүнтэй зөвлөх хэрэгтэй байна. Би танд нууцын нууц нэгэн зүйлийг хэлье. Энэ хүн бол манай баруун хойд хязгаарын тагнуулын газрын дарга ноён Зо Пу-Сан гэгч хүн юм. Харин та энэ чухал хүнтэй танилцах их завшаан олдсондоо баярлах хэрэгтэй.

Энэ ноён бол Гадаад Монголын баруун хязгаарыг өөрийнхөө баруун гарын таван хуруунаас илүү сайн мэдэж байгаа хүн гэж итгэхэд болно гэж хэлээд, цонхны дэргэд очиж, гараа ардаа үүрч, хана налан зогсжээ. Хау Ен-гийн өвдөг дагжин чичирч байв. Тэр нь айсандаа болсон хэрэг биш байхаа. Харин хашир догь чоно, ангийн сүрэг харахаараа хөлөө долоодог шиг ноён Хау Ен дайн тулааны тухай сонсохоороо ингэж өвдөг нь чичирдэг заншилтай болсон хүн юм. Энэ удаа бүр санаа зовмоор чичирч байв. Үүнийгээ мэдэгдэхгүйг хичээж ноён Зо Пу-Сантай ойртож суугаад түүний өмнөх газрын зургийг харна.

Зураг дээр ч яахав, Монгол улсын хил хязгаар бүдүүн улаан зураасаар зурагдсан байна. Харин чухал тэр газар дээрээ ямар шуухан чөтгөр оршиж байгааг тэр хоёр ноён байтугай тэнгэр бурхан ч олж болгоон таалаагүй байгаа хэрэг байж мэднэ гэж боджээ.

Монголчууд гэдэг чинь бас ч тийм амархан улс биш байх аа. Энэ хоёр ноён ширээний ард суугаад гайхуулж л байна. Тэд биднийг байтугай Их Наран улсын хүчирхэг цэргийг хүртэл зад цохисон алдар цуутай улс юм гэнэ лээ гэж бодохоос нэг л хачин санагдаж, айсан гэтэл айгаагүй юм шиг, айгаагүй гэтэл айгаад ч байх шиг сэтгэл нь үймрээд хачин болж байжээ.

Ноён Зо Пу-Саны хатангир гарын нарийхан хуруу газрын зураг дээгүүр түргэн түргэн гүйж, түүний хэлж байгаа үг нь шүдгүй амаар үлээгдэн исгэрч, Хау Ен-гийн чихэнд сайн тогтохгүй, дахин дахин лавлан асуусаар дөчин минутын дараа арай гэж уг зорилгоо сая нэг мэдэж авчээ. Тэгээд устгах, барьж ирэх гэдэг хоёрхон үгийг сонсохтойгоо зэрэг хийморь цог нь сэргэдэг тэр хүний дотор бүүдгэр, сэтгэл нь эвгүй байсан боловч байн байсаар овоо онгойжээ. Ноён Жон тэр хоёрыг ярьж дууссаны дараа ойртон ирээд:

За та хийх ажлаа мэдэв үү? гэж асуусанд Хау Ен хоолой засан,

Мэдлээ, тэгээд бид хэзээ хөдлөх вэ гэж асуусанд ноён Жон хөмсгөө зангидаад

Хэзээ юу байхав. Одоо ингээд гучин минутын дараа яг шөнийн хоёр цагт хөдлөх хэрэгтэй Аль зүг ямар зорилготой явж байгаагаа цэргүүдэд байтугай, офицеруудад ч хэлж болохгүй. Хотоос гарахдаа машины бүтээлгийг цөмийг битүүлэн хаасан байх хэрэгтэй. Зам заах хүнийг ноён Зо Пу-Сан гаргаж өгөх болно. Та нарт Т... гэдэг ангийн харьяа Г... гэдэг харуулаас холхон зайтай газар очиж буугаад, тэнд машинаа орхиж манаа үлдээгээд тэр харуулаас морь, тэмээг хэрэглэж цааш явах болно. Монголын хилийг давахаас нааш цэргүүдийг хэнтэй ч уулзуулж болохгүй.

Та нар өнөө шөнө яваад нар гарах үеэр хүн амьтангүй газрыг сонгон бууж амраад мөн үдэш болохоор дахин хөдөлж, шөнө дөлөөр яваад Г... гэдэг харуулын хавьд очиж буугаад тэндээ явах ажлаа сайн бэлтгэж байгаад цааш явах хэрэгтэй гэж хэлээд Зо Пу-Саны ширээн дээр байгаа календариас хоёр хуудас эргүүлж үзэв.

Монголын хилийг долоодугаар сарын наймны өглөө давсан байх хэрэгтэй. Миний дэргэд нэг холбоочныг аппарат хэрэгслий нь хамт үлдээж та ажил хэргээ яг эхлэхийн хамт надтай холбоо барьж эхлэх ёстой. Төмөр мухлагтай ачааны гурван машиныг Монголоос олзлох цэргээр дүүргээгүй байсан цагт эргэж ирсний хэрэггүй. Нэн ялангуяа ийм хувцастай хүмүүсийг заавал барьж ирэх хэрэгтэй гээд нэг гар зургийг гарган үзүүлэв. Тэр зураг дээр саравчтай ногоон малгай, бор цамц, хөх өмдтэй офицер хүний зураг байлаа.

Баригдсан хүмүүсийг гэмтээж огт болохгүй. Хэрэв тэд хэрцгий зан гаргаад байвал бас дэндүү аргадах хэрэггүй. Би чухал нэг зүйлийг бас нэмж захъя. Нам, эвлэлийн гишүүний батлах бичиг заавал олж ирэх хэрэгтэй. Бусад бичиг баримтыг хэлэх хэрэг юү байх билээ. Та өөрөө сайн мэдмэ. За сайн яваад олзтой омогтой ирээрэй! Танд ажлын их амжилтыг хүсэж, дахин энэ ширээг тойрч инээн уулзаад баярын хундага өргөн уухын сайн билиг оршиг! гэж ерөөе гэж хэлээд ширээн дээр байгаа хүрэн архианаас гурван хундага тулган уужээ. Таны зарлигийг ёсчлон гүйцэтгэж Монголын муусайн цэргүүдийг хулгана шүүрдэг муур шиг дайран ороод, базан барьж ирье гэж ёслоод гарч явжээ.

Дэд хурандаа Хау Енг гарснаас хойш яг нэг цаг болоод Зо Пу-Сан, ноён Жон хоёр нойрсох ордондоо морилон очихоор гадаа гарах үед Хау-Енгийн хамгийн сүүлийн машин Ү... хотыг ардаа орхин хөдлөн гарч байжээ.

Хөх байшингийн довжоон дээр зэрэгцэн зогсоод, зүүн зүг, бүрхэг тэнгэрийн хаяа руу ширтэн харж байгаа тэр хоёр ноён, хэдийгээр нэг зүгт хараад мөн нэг газар зогсож байгаа боловч дотроо хоёр шал өөр зүйлийг бодож байсныг хэн санах билээ. Ноён Жон дув дуугүй хэсэг зогсож байснаа санаа алдаад:

За маргааш өглөө болтол баяртай. Ноён танд амгалан нойрсохыг хүсье гэж хэлээд хэрмийн хаалгаар гартал гоминданы цэргийн олонх ноёдын хэрэглэдэг, энгийн нэг машин хүлээж байсанд сууж явсаар тагнуулын газрын зочид буудлын хоёр давхар ягаан байшингийн үүдэнд очиж зогсоод машинаас бууж байшинд оржээ.

Тэр ноёны өмнө тун нарийн сайнаар найруулсан Хятадын олон төрлийн амтлаг зуушаар дүүргэсэн ширээ хүлээж байснаар барахгүй тэр ширээн дээр байгаа янжуур ч хятад, архи ч мөн хятадын архи байв. Ноён Жон түүнийг үзээд бодсон нь; Үгүй ер энэ гоминданыхан гэгч ер нь ёстой нэг усан тэнэг амьтад байх юм даа. Би болоод ер нь Хятадад ажиллаж байгаа манай Америк ноёд бол цөм Америкийнхаа төлөө, тухайлбал Вашингтоны цагаан ордонд морилон байдаг тэр нэгэн хүний төлөө үнэн голоосоо чармайн зүтгэж байхад эд манайхныг хүзүүн дээрээ мордуулаад, бидний хаашаа яв! гэсэн тэр зүг явж, мөн юу хий гэсэн болгоныг хийж, кармандаа байгаа алтаа суйлуулж байгаагаа мэдсэн ч мэдээгүй юм шиг сууж байдаг тийм тэнэг мангуунууд юм. Гоминданы хэдэн муусайн тэнэг ноёд намайг хүртэл хятад хүн гэж итгэж байдаг юм. Миний эх хятад хүн байсан юм гэнэ билээ. Эцэг минь Америкаас хойш эх ямар ч байсан яахав. Ер нь Америк язгуурын ноён хүнд эцэг эх ямар хэрэгтэй юм бэ? Эх орон гэдэг бол бүр ч шал дэмий юм. Яагаад тэр вэ гэвэл дэлхийн бөмбөрцөг бүхэл бүтнээрээ манай Америкийн долларын эздийн юм байх хэрэгтэй. Саяын явуулсан тэр долоон машин ч гэсэн манай Америк заводад үйлдвэрлэсэн цэргүүд нь ч гэсэн герман марктай Америк буу зэвсгээр зэвсэглээд мөн Вашингтоны цагаан ордонд морилон суугаа тэр эрхэм хүний төлөө их үйл хэрэг бүтээхээр явж байгаа юм. Түүнийгээ тэр хар малууд огт зүүдлээ ч үгүй явж байгаа байх даа, хөөрхий зайлуул. Энэ хэрэг бол ёстой нөгөөх хүний гараар могой бариулна гэдэг болж байна. Ер нь энэ хэргийг Америкууд хийж байна гэж хэн ч маргаж чадахгүй байх аа. Яагаад тэр вэ гэвэл Монгол, Америк хоёр өөр өөр тивд, Улаанбаатар, Вашингтон хоёр алс хол байна. Муугаар боддог юм гэхэд Монголын хилийн дотор хүүрээ үлдээдэг юм гэлээ ч хятад хүний хүүр, буу зэвсгээ орхидог юм гэлээ ч герман марктай буу зэвсэг хаягдахаас биш манай Америк гүрэнд ямар ч холбогдолгүй байх ёстой. Би энэ хэргийг мөн чөтгөр шиг нарийн зохиолоо доо гэж бодоод, мөн Зо Пу-Саны олон олон зүйл дээр давагдаж байсныг бодож, тэр хөгшин чөтгөр бас ч тийм амархан эд биш байна шүү. Гэвч би толгойгий нь эргүүлэхээ л эргүүлсэн гэж ёстой нэг хөх инээд нь хүрч олон төрлийн хоолноос амтархан идэж, элдэв янзын лонхтой улаан цагаан дарснаас шимэн шимсээр согтоогүй боловч нэлээд халамцжээ.

Ноён Зо Пу-Сан, ноён Жон хоёрын хөх байшингийн довжоон дээр зэрэгцэн зогсож байсан шөнийн хоёр цаг хагаст, ахмад Майдрагийн ангийн байрны манаанаас “машины гэрэл” гэдэг хоёрхон үгтэй мэдээ жижүүрийн байранд хүрэлцэн иржээ.

Байлдагч нартаа маргааш заах хичээлийн материал боловсруулж дуусаад, хилийн манаануудаас ирсэн мэдээтэй танилцаж байсан ахмад Майдраг бичгийн ширээний араас түргэн босож, өврөөсөө шүглээ гаргаж аваад гадаа гарчээ.

Тэр шөнө тэнгэр бүрхэг, туйлын харанхуй байв. Тал нутгийн хуурай бүлээн салхи, ахмад Майдрагийн хөрсжисөн бор нүүрийг илэн таалж хөдөө хээрийн хөгжилтэй дуучин бор шувууд исгэрэн дуугарахаас өөр чимээ аниргүй нам гүм байлаа .

Майдраг, Дундговь аймгийн нутаг Дэлгэрхангай уулын ар, Төхөмийн хөндийд ийм сайхан шөнө адуу манаад явж байсан бага насныхаа явдлыг ч бодсонгүй. 1931 онд Дотоодыг хамгаалахын харьяа хил хамгаалах ангид, би танайд орж заавал хилчин болох хүсэлтэй гэж өөрийн сайн дурыг илэрхийлэн гаргаж, цагдаагаар эхлэн орж алдар цуут цаст Алтайн нурууны шувтрах үзүүр, Ноён Богд гэдэг газар очоод “Явган цэргийн хүрэн” гэдэг винтовоор зэвсэглэн, хилийн харуулд ийм харанхуй шөнө бишгүй олон удаа явж байсан залуу насныхаа явдлыг ч санасангүй, ганцхан тэр машин юун машин юм бол байлдагчид минь сайхан амарч байгаа юмсан гэхээс өөр зүйлийг бодсонгүй. Бор шувууны исгэрэх чимээ олшрон байгааг бодоход үүр цайх дөхсөн бололтой. Хот газар бол жолооч нарыг цочоодог, хязгаарт бол түгшүүрийг зарладаг хуруухан чинээ боловч сүрхий чанга дуутай шүглийн дуу, исгэчин хашхирч, тухтай сайхан амарч байсан байлдагчдыг амтат нойрноос нь хайрлах сэтгэлгүй сэрээн босголоо.

Майдрагийн шүглийн дууг зогсож амжаагүй байхад нэг байлдагч гарч ирээд эзлэх байр тийш гүйж байгаа харагдав. Даваадорж юм уу даа гэтэл арай намхан нуруутай юм. Тэр хүн бол хөнгөн пулемётын наводчик, байлдагч Тэгшээ мөн гэдгийг ахмад Майдраг танив. Тэгшээг бүхлээрээ унтдаг байж магадгүй гэж зарим нөхөд нь таамаглан хэлэлцдэг боловч үнэн хэрэг дээрээ тийм биш юм. Тэгшээ бол бусад нөхөдтэйгөө адилхан хувцсаа бүрэн тайлаад унтаж амардаг хүн юм. Түүний ялгавартай нь бусдаасаа түргэн амжиж хувцасладгаараа ялгавартай байжээ. Тэгшээ туслах наводчикаа мөд амжихгүй байх гэж бодсон бололтой пулемётныхоо сум хэрэглэлийг өөрөө аваад гарсан байлаа. Тэгшээ байраа эзлээд нөхдийгөө хүлээж ядаж байжээ. Үнэндээ тийм цагт хилчин хүний хүлээсэн ганц минут гэдэг жирийн цагт хүлээсэн бүхэл бүтэн цаг шиг удаан байдаг юм. Байлдагчид тус тусынхаа байрыг эзэлж бэлхэн болжээ. Ахмад Майдраг Кировын заводод үйлдсэн шөнийн гэрэлтэй бугуйн цагаа харсанд хоёр цаг хагасаас гурван минут өнгөрч байв. Майдрагийн бугуйд байгаа тэр цаг, хязгаарын цэргийн дээд командлалын штабын байранд байдаг урт унжуургатай том шар цагаас ганц минут ч зөрдөггүй нь тэнд ажиллаж байдаг генерал, хурандаануудын бодлого төлөвлөгөөтэй ахмад Майдрагийн ажил хэрэг салахгүй нэг байдаг юм гэгчийг үзүүлэх гэсэн мэт байв. Бүхэл бүтэн анги гуравхан минутад тэгж байраа эзэлж бэлхэн болно гэдэг бас ч тийм амархан хэрэг биш. Гэвч Майдрагийн сэтгэлд бас л удаан юм шиг. Үүнээс түргэн амжиж болох тухай шаардлага тавина гэж санагдаж байжээ.

Байлдагчдыг байраа эзэлж бэлхэн болсноос хойш арав хэртэй минут болоход гэрлээ бага болгон хассан суудлын машин хилийн дотоод талаас Майдрагийн сумангийн байрыг чиглэн ирж яваа харагджээ.

Манаанууд түүнийг зогсоон шалгаад дотогш өнгөрүүлж байв. Тэр машин явсаар сумангийн байранд хүрч иржээ. Ахмад Майдраг тосож очив. Машинаас отрядын дарга дэд хурандаа Зонров бууж иржээ. Сумангийн дарга рапорт өгөөд дэд хурандааг дагуулж байран тийшээ явах гэтэл Зонров тэр ангийн хориглон хамгаалах бэлтгэл ажил нь ямаршуу байгаатай танилцахаар окоптоо бэлхэн хэвтэж байгаа байлдагч нар тийш явж очжээ. Дэд хурандаа Зонров зарим нэгэн хүний биеэ бэлдсэн байдлыг шалгаж үзэв. Энэ удаа онцын

дутагдал олсонгүй, харин үүний өмнө нэг ирэхэд нь нэг хүн хөлөө муу ороосон, бас нэг хүн цамцныхаа товчийг бүрэн товчлоогүй байсныг үзээд тун их юм болж билээ. Гэвч тэгэхэд уурлаагүй юм. Ер нь дэд хурандааг уурлаж байхыг бараг үзээгүй гэж хэлэхэд болно. 1947 оны долоодугаар сарын тавны өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн дотор байгаа Хужиртын ам гэдэг газар гоминданы таван зуу илүү дээрэмчин цэрэгт гучин хэдүүлхнээ бүслэгдэн хорин дөрвөн цагийн турш тулалдаж байхдаа ч гэсэн төдий л уурлаагүй юмсанжээ. Харин тэр тулалдаанд нэг цэргээ дайсанд алагдахад аргагүй нэг уурлаж билээ

Манай дэд хурандаа хязгаарын цэрэгт олон жил ажиллаж байгаа хүн. Зөвхөн отрядын даргаар арав гаруй жил болж байгаа хүн. Энэ завсар уурлаж харааж байхыг нь би ер үзээгүй юм гэж хамт олон жил ажилласан нөхөд нь хэлдэг байжээ. Гэвч эд Зонровын зөвхөн хязгаарын цэрэгт ажилласан энүүхэн хэдэн жилийг дурсахаас биш, хаанаас түүний бүхэл бүтэн амьдралыг нэгд нэггүй тоочин чадах вэ.

Ардын Хувьсгалын өмнөх бэрх хатуу тэр цагт эцэг Шаравыгаа дагаад, хуучин Засагт хааны аймаг, Сартуул гүний хошуу нутгаас гарч, Дөрвөд далай хааны аймаг, Улаангомьн нутаг хүртэл нүүдэл дагаад явж байсан тэр нэгэн жаал хүүгээс эхлэн эрх чөлөө, баяр баясгалантай манай гэрэлт энэ сайхан үеийн бат хамгаалагч ардын эрэлхэг армийн дэд хурандаа хүртэлх хөгжин дэвшиж ирсэн тэр замыг хэн хамаагүй бүрэн тоочин яахин чадах аж даа. Төрөлхийн эцэнхийвтэр нүүрэнд нь өвгөн настай болсон хүнийх шиг хэд хэдэн атриа суужээ. Тэр гүнзгий атриануудыг хэрэв ном бичиг адил уншиж болдог сон бол хурандаагийн амьдралыг нарийн тодорхой мэдэж болох сон байхаа.

Одоо амарцгаа! Тэгээд цагийн хуваарийн ёсоор ажилдаа орцгоо! гэж хэлэхдээ урьд адил сайхан зантай байжээ.

Нарийн сайн ажигласан хүнд түүний зөөлөн намуун номхон бор нүднийх нь хөдөлгөөн бүр ч удаан болсон шиг, түүний сэтгэлийг ямар нэгэн хүнд зүйл зовоож байгаа нь илэрхий байжээ. Улсын хилийн чухал нэгэн томхон хэсгийг хариуцаж суугаа хүний сэтгэл зовохгүй байж яахин болох билээ.

Гэвч энэ удаа ерийн байдгаасаа их л өөр байдалтай байна. Зонров Майдрагийг дагуулан явж байранд оржээ. Тэр байр нь өрөө тасалгаа байхгүй жирийн нэг шороогоор далдлагдсан газар байшин юм. Гэвч ямар нэг гоё байшингаас дутахгүй тохилог цэвэрхэн, гэрэл тусах жижиг гурван цонхтой, тэр цонх нь өөртөө таарсан хөшигтэй, байшин дотроо тавилга төхөөрөг ихтэй юм. Сүхээр нүдсэн ч хэмхрэхгүй бүдүүн цоожтой том төмөр авдар хоёрыг баруун талын туурганыхаа наагуур зэрэгцүүлэн тавьсан байв. Бас хойт талдаа хүрэн цэмбэн бүтээлэгтэй бичгийн ширээ, тэр ширээн дээр байгаа хэрэгсэл нь цөм хир тоосгүй гялалзаж байна. Наагуураа хөшигтэй газрын зураг хананд өлгөөтэй байна. Ер нь юм болгон нь эмх цэгцтэй тун их нямбай айл юм. Тийм байхгүй бол дэд хурандаагийн сэтгэл нь нэг л ханадаггүй юм байжээ. Зонров ширээний ард суугаад юуны өмнө энэ шөнийн манаа хаана хаана тавигдсан, тэр манаанд хэн хэн гарсан, тэднээс ямар мэдээтэй байгаа зэргийг танилцав.

Одоогийн чухам энэ минутад түүний сэтгэлийг зовоож байгаа ганц зүйл бол Ч... хотоос Ү... хот тийш явуулсан арван машин цэргийн тухай зүйл байжээ.

Тэр арван машин цэрэг бүгд зуун далан таван хүн. Командлагч нь дэд хурандаа Хау Ен гэгч гэдгийг хүртэл тодорхой мэдсэнээр барахгүй, тэдний зэвсэг бол 50-75 -ын миномёт дөрөв, хүнд пулемёт хоёр, хөнгөн пулемёт зургаа, винтовын бөмбөг буудагч хоёр, цэрэг болгон Америк винтовоор зэвсэглэсэн юм гэдгийг хүртэл тодорхой мэдсэн хэрэг байжээ. Тийм юм бол юунд тэр хэргийн тухай тэгж их зовж байгаа юм бэ? гэвэл төмөр мухлагтай гурван машинд чухам юу ачиж явааг мэдэж чадаагүй хэрэг байжээ. Тэр цоожтой мухлагийн түлхүүрийг Хау Ен өмднийхөө баруун талын карманаас салгахгүй авч явдгийг бодоход тун нарийн чухал зүйл байх ёстой. Түүнийг мэдэх юмсан, мөн тэд манай отрядын чигээр ирэх нь магадгүй боловч чухам хэдийд хаагуур довтлон ирэх нь одоо хэрдээ тодорхой мэдэгдээгүй байгаа нь юу юунаас илүү шаналган зовоож байжээ. Фашистын Герман, милитарист Япон хоёрын үүсгэн дэгдээсэн эзэрхэг түрэмгий аюулт хоёрдугаар дайны гал намдаж, пижигнэж байсан буугийн дуу зогсоод хоёр гурван жил болж байна. Нарт дэлхийн олон сая жирийн хүний хүсдэг өнө удаан энх тайвныг үнэн голоосоо хүсэн эрмэлздэг Монгол Ард Улсын хязгаарын цэргийн дэд хурандаа Зонровын оролцоот тэр хил хязгаараар сүүлийн үед тагнуул, хорлон сүйтгэгчид ирэх нь олширч байгаагийн дээр гоминданы харгис ноёдын хөшигний араар суугаа Америкийн зандалчид тэгж зэвсэгт ангиар довтлон дайрах гэж байгааг мэдсэн дэд хурандаагийн сэтгэл зовохгүй байж яахин болох билээ. Зонров, Майдрагийн сумангийн байранд хоёрхон цаг болохдоо хил хамгаалалтын зохион байгуулалт ямар болсон, мөн хилийн манаанууд ямар шүү ажиллаж байгаагаас эхлэн ангийн аж ахуйн бүх бэлтгэлтэй, түүний хамгийн жижиг зүйлтэй хүртэл тун нарийн тодорхой танилцаж амжаад зэргэлдээ застав тийш явахдаа:

Ямар боловч ирэх шөнөөс эхлэн “Бүдүүн Харгайт”-ын голын адагт байрлуулдаг... төдий хүнтэй манааг өөрчилж дунд даргаар удирдуулсан арван хүнийг томилж уг голыг өгсүүлэн аваачиж гурван замын бэлчир нэргүй өндөрт байрлуул! Тэгээд отрядын штабаас тушаал ирэх хүртэл түүнийг битгий буулга! Бусад манаануудад төдий хүнээр хүч нэмэгдүүлж тийм тийм газруудад байрлуул! гэж тушаагаад явжээ.

Зонровын явснаас хойш ахмад Майдраг дэд хурандаагийн ярьсан тэр төмөр мухлагтай гурван машинд чухам юу байгаа хэрэг бол, тэд манай сумангийн зурваст газраар ирдэг болов уу гэж бодсоор үүр цайж гүйцээд цонхоор туссан өглөөний гэгээнд гэрэл туяагаа аль эрт булаагдаад дэмий сүүмэлзэн байгаа лааг хүртэл унтраахаа мартаж орхиод сууж байжээ. Тэгээд ширээний араас босож гадаа гарах гэснээ асаагаастай байгаа лааг хараад түүнийг үлээж унтраавал хэншүү болно гэж бодсон бололтой хар бор ажилтай хатуу ширүүн тулалдаан хийж бөхөжсөн том гарын бүдүүн хуруугаар чимхэж унтраагаад, гадаа гарч говийн хүний заншлаар тэнгэрийн хаяа руу харсанд уудам цэнхэр тэнгэрт чөлөөтэйгөөр аялан байдаг задгай цагаан үүл хөөцөлдөн нүүж, тэнгэр цэлмэх төлөвтэй зөөлөн салхи сэвэлзэн, үлээж, зун цагийн залуу ногооны анхилам сайхан үнэр ханхалж байх нь Майдраг минь чөлөөтэйгөөр

амьсгал, чи олон олон хүнд зүйлийг туулан давахдаа нэг ч удаа сандран тэвдэж байгаагүй шүү, чи түүнийхээ үрээр ч давж дийлсээр ирсэн юм гэсэн шиг тааламжтай сайхан өглөө угтан авчээ. Хилчид биеийн тамирын дасгалаа хийгээд нүүр гараа угааж, цайгаа уугаад өглөөний сонин уншлагандаа орсон байлаа. Тэд ердийн заншлаараа дугариглан суусан байв. Тэдний дунд заставын орлогч Хаянхярваа зогсоод ярьж байгаа харагдана. Майдраг өөрийнхөө хамгаалбал зохих хэмжээт хил хязгаараа энэ шөнө бүрэн бүтэн манаж хоносондоо баярлаж гэрийн зүг урамтай алхаж явах боловч түүний сэтгэлийг нөгөө зүйл мөн л зовоосон хэвээр байна.

Майдраг явсаар гэрийнхээ гадаа хүрч очиход нь малчин Монгол хүний ердийн амьдрал угтан авчээ. Тугалын зэл дээр гэрийнх нь эзэгтэй үнээгээ саагаад ажиггүй сууж байна. Гэртээ ороход нь тавагтай өрөм бэлэн харагдаж, бас зуухан дээр халуун цай байгаа нь таатай. Өчигдөр орой хоолоо идэхийг мартсан болохоо сая санажээ. Манай хил хамгаалах ангиудыг нүдээр үзээгүй зарим нэг хүмүүс энд дурдаж байгаа зүйлийг гайхаж магадгүй юм. Тэд малаа малласаар саалиа сааж, идээ цагаагаа авсаар аж төрөн амьдарч суудаг хүмүүс юм. Түүн тухай гайхах хэрэг алга. Хаянхярваа өврийн жижиг дэвтрээ дэлгээд сүүлийн үеийн сонин сэтгүүлээс товчлон авсан зүйлээсээ ярьж байна. Тэр тун аяархан дуутай хүн юм. Хилчид суугаагаараа гулгаж улам улам ойртсоор байна.

Манай энэ их үе бол дэлхий дахинд бүр ч тодорхой суурийг эзэлж байгаа юм. Бидний санадаг сарвайдаг ганцхан зүйл бол манай хайрт эх орон, бидний өшин зандаг зүйл бол энэ сайхан эх оронд минь халдагчид юм. Удаа дараа манай эх оронд халдаж ирсэн дайсан болгоныг бид хиар цохиж байсан түүхтэй билээ.

Хиагт, Хүрээ хоёрт бүгшиж байсан гамин, бароныг их жанжин Сүхбаатар бут цохисон, баруун хязгаарт үүрлэн байсан цагаантныг манай цэрэг ардын Хатанбаатар Магсаржавын удирдлагаар хөөн цэвэрлэсэн. Халхын голоор халдаж ирсэн Японы Самурай нарыг манай армийнхан, Зөвлөлтийн баатарлаг цэрэгтэй мөр зэрэгцэн явж бут цохисон түүхтэй.

Баруун зүгт Германы фашист, алс дорнодод харгис Япон устаж, одоо бид энх тайван сайн сайхан амьдрах замдаа ороод байна. Бид бол Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эв найрамдал, энх тайван байдлыг нүдний цэцгий мэт сахин хамгаалагчид мөн. Манай нам засгийн тууштай бодлого бол ганцхан эв найрамдлыг эрмэлздэг юм. Бид айл хөрш улстайгаа найртай байхыг чин сэтгэл, үнэн голоосоо хүсэн эрмэлздэг улс. Түүний тодорхой нэгэн баталгаа бол Зөвлөлт Монгол хоёр улсын хорин долоон жилийн туршид нөхөрлөсөөр ирсэн чин бат мөнхийн нөхөрлөл гэрчилж байна гэж Хаянхярваа яриагаа цааш нь үргэлжлүүлж байна.

Нарны гэрэлд өнгө нь өөрчлөгдсөн үүлний улаан ягаан туяа тойрон суусан хилчдийн хүрэн бор царайнд туссан байх нь хүрэл хүмүүс болсон шиг харагдаж байна. Зөвлөлтийн зохиолч К. Симоновын бичсэн “Орос хүмүүс” гэдэг зохиолын дотор гардаг ёсоор тэр хүмүүсийн сэтгэлийн дотор янз янзын зүйл бодогдож байна. Тунаран цэнхэртэж байдаг Хөвсгөл нуур, тэр нуурын хөвөөгөөр зусландаа буусан хот айл, тэр хот айлын аль нэг талд нь байгаа элбэг баян идээ цагаагаа дэлгэсэн эсгий гэр, тэр гэрт суудаг баяр баясгалант ах

дүү, эцэг эхээ нэг хүн бодож байхад нөгөө нэг нь хоногийн газраас хурдлан давхиад туулан бардаггүй хонгор шаргал говь талаа санаж байна.

Өдөрчийн газраас бараагий нь харахад мөнгөн цагаан оройгоороо мөнх хөх тэнгэрийг баганадан байдаг цаст Алтайгаа бодож байхад зарим нэг хүн өдөр шөнөгүй сахин манаж байдаг ижил дасал болсон хил хязгаараа санаж байна.

Өргөн уудам Монгол нутгаа, эрх чөлөөт сайхан амьдралаа бүхэл бүтнээр нь бодож байгаа хүн ч байх жишээтэй байжээ.

Тэр бол манай амьдралын доторх үнэн бодит зүйл юм. Манай хилчдийн бодож байгаа тэр бодол нь ямар ч байлаа гэсэн нэгэн холбоосонд бат зангилагдсан юм. Тэр нь хайрт эх орон нь билээ. Түүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Тэр нь ажил хэрэг дээрээ батлагдсан хэрэг. Энэ өглөөний улс төрийн ярианы дараа цагийн хуваарийн ёсоор ерөнхий эрдэм, биеийн тамир, улс төр зэрэг олон төрлийн хичээл заагдаад, манаануудаас онцын юмгүй тайван байна гэсэн мэдээтэй жирийн нэг өдөр өнгөрчээ. Оройн хоолны дараа суман даргын хуваарилсан нэрсийн ёсоор ахмад Майдрагийн байранд бүрэн зэвсэг зүүсэн есөн байлдагч ороод номхон зогсож тушаалыг хүлээв. Хилчдийг орох үед Майдраг, Хаянхярваа хоёр хананд байгаа газрын жижиг зургийн дэргэд зэрэгцэн зогсож удтал ярилцаад дуусаж байжээ. Ахлах дэслэгч Хаянхярваа бүрэн зэвсэгтэй байх нь тэдний ахлагчаар явах нь тодорхой байжээ. Тэр хүн зүүн хязгаараас дөнгөж сая долоо наймхан хоногийн өмнө энэ ангид шилжин ирсэн хүн билээ. Хаянхярваа Булган аймаг, Хутаг-Өндөр сумын тавдугаар багийн нутаг дөлгөөн урсгалт Сэлэнгэ мөрний хөвөө, Цагаан голын цэцэг навчтай гоёмсог сайхан эрэг, өлбөнхөн хүрмээ нөмрөнхөн сууж байгаа өвгөн хүн шиг харагдан байдаг өндөр сайхан Намнан уул, түүний ар өврийн хөндийг бол хаанаас тэгж зураг дээр заалгаж байх билээ.

Нүдээ аниад явсан ч тэнд нь тийм дов сондуул бий, энд нь ч ийм тарвага зурамны нүх байдаг гэгчийг хүртэл олохсондоо. Мянга есөн зуун дөчин гурван оноос эхлэн дөнгөж энд шилжин ирэхээ хүртэл ажиллаж байсан Эрдэнэ Цагааны дов толгод, Халхын голын бургаст тохой, элст манхны уудам хөндий бол мөн л зураг хэрэглэхээргүй мэддэг нутагшсан газар орон нь юм байжээ.

Түүнийг мөдхөн л энэ газартаа дасаж орхиод дараагийн ирэх нөхөртөө бас л зааж өгөөд сууж байх болно доо, энэ бол манай хилчдийн ерийн нэг заншил болсон хэрэг, халагдах хугацаа нь болсон догь цэрэг шинэ ирсэн дүү нараа дагуулан явж газар орныхоо байдалтай танилцуулж өгөөд чухам халагдаж явахынхаа даваан дээр хоргодоод байдаг нь учиртай юм. Халаагаа өгч байгаа нөхөртөө хэдэн жилийн турш гараасаа салгалгүй барьж явсан буугаа шилжүүлэн өгөх, чухам тэр минутад түүнээс салж ядан сэтгэл нь хөдлөөд тун хачин болж байдгийг хил дээрээс халагдаж үзсэн манай хуучин хилчид л сайн мэдэх байх аа. Намайг санахад түүний учир нь өдөр шөнөгүй сэргийлэн манаж байсан тэр нутагтаа, хамт байсан олон нөхдөдөө ижилсэн дассаны гэрч тэмдэг юм. Манай залуучууд эх орныхоо энхрий дархан хил хязгаарыг сахин хамгаалж байхдаа хэчнээн их дуртайн илрэл нь болсон хэрэг юм гэж бодож байсан ахмад Майдраг тэр арван хүнийг сайн таньдаг боловч цэргийн дүрмийн шаардлага ёсоор нэр нэрээр нь дуудах хэрэгтэй боллоо.

Зургийнхаа хөшгийг хаагаад бичгийнхээ ширээний нүднээс харуул манааны тэмдэглэлийн дэвтрийг гаргаж дэлгээд, Ахлах дэслэгч Хаянхярваа, тасгийн дарга Гиваан, хилчин Даваадорж, Гончигзэвгээ, Архад, Пэлжээ, Тэгшээ, Баян, Дандархайдав, Чойжин гэж дуудахад цөм “би” гэж хариулжээ. Майдраг суудлаасаа босож хүн бүрийн биеийн бэлтгэлийг шалгаж үзээд,

Нөхөд та нар одоо ингээд улсын хилийг сэргийлэн манахад бэлхэн үү? гэж асуусанд цөм,

Бэлхэн! Нөхөр ахмад аа! гэж нэгэн дуугаар хариулсанд, Майдраг гүйцэтгэх үүргий нь тодорхой хэлж өгсний дараа уг нь шар өнгөтэй байгаад одоо элэгдэж гялгар хар болсон суран бүсэндээ хоёр гараа хавчуулж цамцныхаа өврийн хунирсан үрчлээг хойш нь болгон засаад номхон зогсож: Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дархан хилийг сахин хамгаалахаар алхаад! гэж командалсанд хилчид

Тушаал ёсоор! гэж ёслоод гарч явжээ. Тэр үед зуны сарын урт шар нар өдрийнхөө албыг хаан өнгөрүүлээд, баруун уулын цаагуур орж хилчдийн хамаг анхаарал сэрэмжийг улам дайчлан татдаг шөнийн хар сүүдэр үүл талыг нөмрөн бүрхсээр айсуу яваа үдшийн цаг болжээ. Алсын бараа бүрэн тасарч байсан үдшийн цагаар арван нөхөд мордон явжээ.

Хоёр хоёроороо зэрэгцэн жагссан цувааны түрүүнд явж байгаа манааны ахлагч Хаянхярваа мориныхоо амыг татасхийгээд зогсжээ. Ямар хэрэг гарав, юу хэлэх нь вэ гэсэн байдалтай есөн нөхөд нь тойрон иржээ.

“Нөхөр Тэгшээ, Чойжин та хоёр толгойн сэргийлэхэд гар”. Дайсантай тулгарвал дохио өг! Хэрэв юутай ч дайралдахгүй бол километр тутамд тайвнаа мэдэгдэж бай! Та хоёрын ахлагч нь нөхөр Тэгшээ гэх зэрэг сэргийлэхийн албан үүргийн тухай тодорхой хэлж өгөөд цааш хөдлөн явцгаажээ. Хаянхярваа ор зангий нь мэдэхгүй морь унасандаа, анх мордох үед баахан зовж байсан боловч морь нь агтны байлдагчийн магтан хэлсэн ёсоор, нээрэн ч гоц сайн морь дайралджээ.

Морь нь тургих, янцгаах нь байтугай амгайгаа ч дуугаргахгүй яг зуугаад, дөрөөгөө хавирчих вий гэсэн шиг хажуугийнхаа мориноос зайтай явахыг хичээгээд, хөлөө хүртэл аяархан аяархан өргөж тавиад ямар нэгэн юманд гэтэн мярааж байгаа юм шиг явж байжээ.

Энэ морьдыг манай хилчид л ийм сургуультай болгожээ. Адгуус мал хүртэл бас хачин байх юм даа, ямар байдлын дотор л байна, тэр байдалдаа сурч дасдаг юм байна шүү дээ гэж боджээ. Түүний улмаас аванхайлж сая зүүн хязгаараас нааш ирэхдээ Улаанбаатар хотоор дайрч тэнд цирк үзэж байснаа санажээ. Нүд гялбам цахилгаан гэрэл болсон байшин дотор хөгжмийн яруу сайхан аялгуугаар хүний хийдэг бүжиг хүртэл хийж байсан тэр жирийн нэг Монгол морьд үзэгчдийн нижигнэсэн алга ташилтын дотор бүр хүний санаанд багташгүй олон төрлийн сургууль хийж байхыг бахдан харж байснаа боджээ. Болдог сон бол манай энэ морьдыг ийм шүүхэн үнэнч зүтгэлтэй амьтад юм байна гэгчийг тэр олон үзэгчдэд үзүүлэх юмсан. Хэрэв тэгвэл яасан их сонирхох байсан бол, за тэгж гайхуулах маань ч яамай, харин тэр сайхан циркээ, хайрт Улаанбаатар хотоо, жаргалтай амьдран сууж байгаа ард түмнийхээ зол заяа, энх тайван байдлыг хамгаалан чадвал энэ морь бид хоёр ариун үүргээ нэр төртэй гүйцэтгэж олон түмнээ баясуулах нь чухам тэр болно

гэж бодож явжээ. Толгойн сэргийлэхэд гарсан Тэгшээ битүү хар хилэн нөмөрсөн юм шиг шөнийн гүн харанхуйн дундуур урагш зүсэн явж байхдаа хаанаас чухам юу гараад ирэх бол гэхээс өөр зүйлийг бодохгүй, ганцхан тэр зүйлдээ анхаарал тавьж чимээ чагнан сэрэмжилж явна.

Тэгшээ морио эмээллэж унаад гарахын цагтаа ялангуяа хил дээр явж байхдаа ёстой нэг агаар тэнгэртээ халин нисэж яваа уулын бүргэд шиг хийморь нь сэргээд явчихдаг байжээ. Энэ удаа бүр ч урьд урьдахаасаа улам илүү цог жавхлантай гялалзан явж байна. Цэцэг ногоо дэлгэрч хөх униар татсан зуны сарын хүслэнт сайхан тэр нэгэн өглөө Ховд аймаг, Чандмань сум, Хустын голоор нутаглан байгаа өсөж төрсөн гэрээсээ мордохыг бэлтгэж, тарган халтар мориндоо мөнгөн тоногтой эмээл тохоод хүүхэд байхдаа хэрэглэж байсан цоохор хумбан аягандаа дүүрэн сүү хийлгэж уугаад хайрт эхдээ үнсүүлээд мордохдоо эхийнхээ үрчгэр хацрыг дагаад урсаж байсан нулимсын учрыг ч сайн анзаарахгүй уг явах аян чамдаа яарч байжээ. “Миний хүү хүний хойно оролгүй явж олон аавын хүүхэдтэй эв найртай байж дарга, багш нарынхаа үг сургамжийг гажихгүй дагаж их эрдэм ном сураад ирээрэй!” гэсэн үгийнх нь хариуд нь зөвхөн,

Тэгье, ээж минь за сайн сууж байгаарай! гэдэг хоёрхон үг хэлээд өөр юу ч хэлэлгүй тэр чигээрээ мордож хойноосоо сүү өргөөд хоцорч байсан эхийгээ ч эргэж харалгүй, мөнгөн дуулгатай баатар эр шиг гялалзанхан байдаг цаст өндөр Жаргалант Алтай уул, номин хөх тэнгэрийн хаяатай нийлсэн юм шиг цэлэлзэн цэнхэртэж байдаг усны шувууны хуран цугларах орон болсон Дөргөн, Хар ус нууруудаа ч ажиглан үзэлгүй давхин давхисаар далд орж байсан яг тэр өдрийнх шигээ л чигээрээ явж байна.

Тэгэхэд хязгаарын цэрэгт шалавхан орж ногоон алаг погоон тэмдэгтэй шинель өмсөж, хилчин болох юмсан гэдэг ганцхан зүйл түүний сэтгэлийг бүрэн эзэлж яаруулан байсан бол энэ завсар тэр хүсэл нь бүрэн биелжээ. Одоо ямар хүсэл нь дутуу байгаагий нь бодож олох хэрэгтэй болжээ. Тэгшээг бага байхад эцэг Баянбал нь өвлийн шөнийн уртад ямар нэгэн баатар эрийн тухай тууж намтрыг гэр бүлийнхэндээ уншиж өгдөг байжээ. Тэр цагт Тэгшээ хөдсөн дээлээ нөмрөөд заг модны сүрхий илчлэг улаан цогонд бор гэдсээ хүрэн болтол нь ээгээд тэр тууж намтруудыг амтархан сонсож байхдаа “Би хэзээ нэг номыг аав шиг уншиж чаддаг болно доо” гэж уг номуудын хуучран шарласан хуудсуудыг саарьтай жижиг бор гараараа дэмий л барилан үздэг байсан тэр үеийн хүсэл нь аль эрт биелэгджээ. Тэгшээ арван гурван настайдаа сумын төвд очиж бичиг үсгийн түр сургуульд онц сайн суралцаж үнэмлэх, үнэ бүхий зүйлээр шагнагдаад тун их баярлаж ном сурсныхаа дурсгал гэж нэг хөөрхөн эрээн шилэн савыг гурван төгрөгөөр худалдан аваад ээждээ бэлэг болгон авчирч өгчээ. Тэр шилэн савыг ах Цоохүү нь одоо хүртэл хадгалж сайн малчдын баярын өдөр авдраасаа гаргаж идээнийхээ дээжийг хийж их Ленин, Сүхбаатар хоёрын зургийн өмнө тавиад, “Миний үр хүүхдийг эрх чөлөө, сайхан амьдрал, эрдэм номтой болгож өгсөн та хоёр минь түм насалсан ч болоосой гэж хэлдэг байжээ. Тэгшээ одоо тийнхүү багадаа хүсэж байсан бичиг үсгийг сурснаар барахгүй нөгөөх хуучны тууж намтруудыг аль эрт уншаад шударга хүн төрөлхтний их багш Лениний гайхамшигт зохиолууд, бүх Монголын ард түмний мэргэн жолоодогч Сүхбаатарын намтар, мөн

тэдний үйл ажиллагааг бахархан судалдаг болжээ. Тэгшээ утга зохиолын номуудыг тун их уншдаг хүн юм. “Болд хэрхэн хатаагдсан нь” гэдэг номыг энэ завсар олон дахин уншсаар байгаад одоо бараг цээжээр мэддэг болжээ.

Тэгшээ үүний урьд харуул манаанд бишгүй олон удаа явахдаа нэг л их юм болдог байсан атлаа энэ орой үлдэх нөхөдтэйгөө нэгэнтэй нь ч гар барьсангүй.

Би, их амжилттай яваад ирнэ. Харин та нар надад сайхан сонин ном олоод тавьж байгаарай гэж захидгаа хүртэл давтан хэлсэнгүй байжээ. Сумангийн даргатай хүртэл гар барьсангүй, хоёр гуравхан хоноод ирэхийн хооронд тэгж нэг их маяглаад юу хийхэв гэж өөрөө өөрийгөө зэмлэсэн янзтай, олон таван үггүй шууд мордоод явжээ. Харин энэ явахынхаа урьд өдөр, амралтынхаа цагт, дарга нарынхаа байраар очиж өөрөө хадаж чаддаг байсан мөртөө, заставын даргынхаа хүүхнээр солих болоогүй байсан ч хамаагүй цамцныхаа заханд цагаан даавуу хадуулж, ханзраагүй байгаа боловч товчоо бэхлүүлэн оёулахдаа,

Би өөрөө үйлэнд тийм муугүй боловч, бүсгүй хүнээр оёулах нь нэг л аятайхан юм шиг санагдаад байна. Та намайг битгий буруушаагаарай! гэж хэлээд инээмсэглэж байжээ. Нөхрийгөө дагаж баруун, зүүн хязгааргүй явж хилийн цэрэгтэй нэгэн эцэг эхийн үр хүүхэд шиг ижил дасал болж сурсан тэр ариун цагаан сэтгэлтэй бүсгүй, Тэгшээд хүн хүнээс илүү хайртай болсныг учир мэдэхгүй хөндлөнгийн хүн хажуугаас нь харвал муу юм бодож болохоор байдаг байжээ.

- За чи чинь юу болоод ингэж маяглаж байгаа билээ гэж хүүхнийг асуухад

- Юу болох юу байхав. Тэгшээ хэвээр л байна шүү дээ гэв.
- Намайг санахад тийм биш шиг
- Таныг санахад тэгээд би, ямар болсон шиг байна?
- Эрт урьдын ямар нэгэн инээдмийн жүжигт тоглож байгаа жүжигчин шиг нэг их маяглаад байна шүү дээ гэж хүүхэн хэлээд инээмсэглэж байжээ.

- За чи тэгж намайг шүүмжлэх ч юу байхав, би яарч байна. Зүгээр үүнийг хадаад аль гэж хэлээд цамцаа тайлж өгчээ.

- Ийм л шулуун шударга байвал зүгээр юм даа гэж хэлээд цамцы нь авч түүн тийш харалгүй:

- Би чиний хайртай хүүхэн Нацагмаа шиг чинь хадаж чадахгүй байх аа даа. Гэвч хар хүний чинь ханзарсан товчий нь хадаж, хар болсон даавуугий нь сольж өгдөг байсан шүү гэж түүнд чинь хэлэх юмсан, хэрэв тэгвэл тэр надад чи яасан сайн хүн бэ, би чамд тун их баярлав гэж хэлэх байсан байхдаа гэж хэлээд цамцны нь заханд нямбай нугалсан цагаан даавууг хадаж байжээ.

Тэр үгийг сонсоод хайрт хүүхэн Нацагмаа нь санагджээ. Хаа байгаа алс хол, зүүн аймаг Хэрлэн голоор нутагтай энэ хүүхэн, баруун хязгаар Ховд аймаг, Чандмань сум, Хустын голоор нутагтай тэр Нацагмаа хүүхэнтэй яагаад тэгж их сүрхий танил болсон хэрэг вэ? гэвэл энэ хоёр хүүхэн нүүр тулж танилцаагүй боловч сэтгэл зүрхээрээ танил болсон хэрэг юм байжээ.

Шугамтай шугамгүй элдэв янзын цаасан дээр хүрэн, хөх зэрэг олон өнгийн бэхээр нэгэн хэвийн мах муутайхан жургар туранхай үсгээр бичигдсэн хатуу зөөлний тэмдгийг огт алдахгүй хичээж Д, Т хоёрыг нэг ч солилгүй

чармайн бичсэн янаг амрагийн үгээр элбэг баян олон арван захидлыг Нацагмаагаасаа хүлээн авчээ.

Би чамд хязгааргүй хайртай, манай аав чамайг их ажилсаг, томоотой, тун сайн хүү байгаа юм гэж үргэлж магтаж байх юм. Бас танай ээж надтай уулзах болгондоо нэг л их баярласан янзтай байх юм. Манай багийнхан чамайг сайн ухуулагч байсан юм гэж магтаж байх юм. Үүнийг бодоход чи бид хоёрын нийлэн суух явдалд дургүй хүн нэг ч байхгүй байх аа! гэж би боддог. Цэрэгт явахынхаа урьд өдөр өнөөдөр заавал дуусгана гэж чиний удирдсан залуучуудын бригадын малтаж гаргасан тэр худгийг одоо манай нутгийнхан чиний нэрээр нэрлэн ярилцаж байх нь миний чихэнд тун аятайхан сонсогдох юм. Би хайрт чамайгаа цэргээс ирэхийг чинь хүлээж байна. Хоёулаа шинэ сайхан гэр бүл больё гэж цэрэгт явахаасаа өмнө чиний гуйж байсан зүйлд би тэр цагт хариу өгөхгүй байсан нь чамд дургүй болоод тэгсэн хэрэг биш шүү. Тэр бол бүсгүй хүний ичимхий байдлаас болсон хэрэг гэгчийг чи юунаа андах аж. Би чамдаа туйлгүй үнэнч, хязгааргүй хайртай, Ганцхан чамайгаа хүлээж байна. Чи их эрдэм ном сураад ирээрэй! гэх зэрэг аль нарийн нандин зүйлээ сэтгэл харамгүй бичсэн захидлууд нь энэ заставын даргын хүүхэнд хадгалагдан байдаг байжээ. Түүгээр ч барахгүй нэгэн том ягаан цэцгийг хоёр талаас нь үнэрлэн байгаа буга согоо хоёрыг шаалан оёсон цэнхэр пансан алчуур нь хүртэл мөн энэ хүүхний гарт хадгалагдсан байдаг юм байжээ. Тэгшээ гуйж байгаад Нацагмаагийн захидлуудыг гаргуулан авч дахин уншиж үзжээ. Түүний нүдэнд осолдохгүй л цагаан цаасан дээр хар бэхээр бичигдсэн захидлын үсгүүд харагдаж байвч сэтгэлд нь хорин хоёрхон настай, тэвхэлзсэн эршүүд биетэй Нацагмаа, түүний өргөн хүрэн царай, бараг нүүрэндээ томдохоо шахсан урт сормостой давхраат алаг нүд нь Тэгшээг хараад үргэлж инээмсэглэж байдаг байдал нь уурлах хараахыг ер мэдэхгүй ялдам сайхан зан нь хүртэл тодхон бодогдож байжээ. Тэгшээ алчуурыг авч үзэв. Нацагмаа минь үүнийг хонь хариулж явахдаа л оёсон байхдаа гэж боджээ.

Тэр алчуур цоо шинээрээ хадгалагдаж байжээ. Нацагмаа минь үүнийг оёж гүйцээгээд надад явуулахдаа чухам юу гэж бодож байсан бол, үүнийг үзэх бүрдээ намайгаа дурсаж байг гэж бодоод явуулсан байхдаа гэж санав.

Тэгшээ, уншиж гүйцсэн захидлуудаа атгаад, дун цагаан эсгий дээр олон өнгийн даавуугаар гоёмсоглон оёсон ширдэгний угалзыг гөлрөн харж байв. Гэвч тэр угалзыг сонирхсонгүй, харин Хустын голыг өгсөж уруудаад давхиж явснаа, Батчулуун гуайнд очиход Нацагмаа нь тосож гараад, паанай гэдэг нэртэй сүрхий зуудаг, зүрх цагаан том хар нохойгоо хорьж өгдөг байсны нь тэр нохой сүүл сүүлдээ дасаж орхиод Тэгшээг ирж явахыг хараад барааны газраас угтан ирж, эрхлэн байдаг нь хүртэл санагджээ.

Цэргээс халагдаад харихад намайг хамгийн түрүүнд тэр паанай үзнэ. Тэгээд тэр угтан ирээд эрхэлж, морь өөд цоройгоод явуулахгүй баярлан гийнаад яасан их юм болж байх бол, Нацагмаа түүнийг хараад чухам яах бол. Аав аа! Тэгшээ ирлээ! гээд гэртээ гүйж орох болов уу? Үгүй бол шууд миний урдаас тосон гүйх болов уу? гэж бодов.

Цамцны заханд даавуу хадаад, мөн товчий нь бөхлөн оёж гүйцсэн хүүхэн, нүднийхээ булангаар Тэгшээ тийш хоёр дахин харснаа босож ирээд дэргэд нь зэрэгцэн сууж: Би хэрэггүй юм хэлээд чинийхээ сэтгэлийг дэмий

зовоочхов уу даа гэсэнд Тэгшээ баясгалантайгаар нүдээ гялалзуулан түүн тийш зөөлнөөр харж, Тийм биш өвгөн минь, миний сэтгэл огт зовоогүй, би харин их сайхан зүйлийг бодож байна... гээд цааш нь ярих гэтэл гаднаас заставын дарга ороод иржээ. Заставын дарга хооронд нь орж суугаад, тэр хоёрын хүзүүн дээр хоёр гараа тавиад, За та хоёр маань бас л Нацагмаагийн тухай ярилцаад сууж байна уу? Би энэ ярианд чинь оролцвол яана. Ойрдоо захидал ирсэн үү? Түрүүчийн долоо хоногт миний үзсэн захидлаас хойш юу байна? гэсэнд хүүхэн: За шувуу биш тэр чинь хаанаас дандаа тийм амархан ирж байдаг юм бэ. Ядахдаа хоёр гурван шуудан алгасаж байгаад нэг ирэлгүй яадаг юм бэ гэж хэлсэнд заставын дарга:

Тэгшээ минь захидал гэснээс би чамд нэг зүйлийг хэлье! Манай зарим нөхөд, цэрэгт байхдаа одоо мөн яг л чи бид нар шиг ийм сайхан ижил дасал болсон мөртөө, цэргээс халагдаад гэртээ харих дээрээ мартаж орхидог муу зан байдаг юм. Чи битгий тэгээрэй дээ. Ялангуяа чи Нацагмаатайгаа хуримаа хийх сар өдрийг тодорхой бичнэ шүү. Тэр өдөр чинь бид хоёр чиний ирүүлсэн захидлыг уншиж та хоёрыгоо дурсан ярилцаж, хоол идэх болно. Тэгэхдээ бид хоёр зуун грамм ууна. Зөвхөн зуун грамм шүү, түүнээс илүү ууж болохгүй нь мэдээжийн хэрэг. Тэгэхэд би чинийхээ хамгийн дуртай “Хоёр Алтай” гэдэг дууг дуулна. Би чам шиг тийм сайхан дуулж чадахгүй ч гэсэн чамайгаа дурсаж тэр дууг дуулна. Тэр өдөр Нацагмаа та хоёр мөн л бид хоёрыгоо дурсан санаж, тэр найран дээр хамт байгаа юм шиг бодож байгаарай! гэж хэлжээ.

Тэр үгийг сонсоод Тэгшээгийн сэтгэл цэцэг навчаа дэлгэсэн зуны сайхан цагт, айраг, архи, идээ цагаа ханхалсан эсгий гэрийн дотор аавынхаа морин хуурны хүн тэнэсэн сайхан эгшигт “Хоёр Алтай” -гаа хангинатал дуулж, айл саахалтынхаа хүмүүсийг баясгаж байсан явдал нь санагдаж байжээ.

Тэгшээ одоо урьд өдрийн болж өнгөрсөн амин хувийн энэ явдлаа ор мартаж орхиод ганцхан улсын халдашгүй дархан хил хязгаарыг сахин хамгаалах хариуцлагатай үүргээ бодсоор тэр зүйлдээ их сэрэмж анхаарлаа тавиад явж байна.

Тэгшээ ямар ч морь хамаагүй унадаг мөртөө энэ өдөр хамгийн хайртай халзан морио барьж унасан байжээ. Энэ морь бол сумангийн хуучин дарга Нэхийтийн морь юм.

Тэгшээ хувьдаа хэд хэдэн сайн морьтой боловч энэ мориндоо их хайртай юм. Нэхийт өөр ангид шилжихдээ энэ морио Тэгшээд өгсөн байжээ. Тэгшээ гурван настайгаасаа хойш нэг ч удаа уйлаагүйгээ хорин гурван насан дээрээ, сумангийн дарга Нэхийтийг өөр ангид шилжиж суух болсон тэр өдөр түүнээс салахдаа өөрийн эрхгүй нүднийхээ нулимсыг нуугаад арчин хоцорч байжээ.

Манай өргөн уудам орны өнцөг булан бүрээс цуглаж улсынхаа хил дээр хэдэн жил хамт сууж ижил дасал болсон хүмүүс, цөм тийм байдаг юм гэгчийг учир мэдэх хүн болгон тодорхой мэднэ. Ялангуяа хил дээр байж үзсэн хүмүүс бүр ч сайн мэднэ. Амьдралыг ёстойгоор нь мэдэх хүн болгон түүнийг шоолохгүй байх аа. Пагдгар намхан нуруутай, битүү хууз сахалтай, царгиа бүдүүн дуутай тэр хар хүн Тэгшээтэй эрт урьдын танил нь биш юм. Ядахдаа нэг аймаг ч биш, Тэгшээ бол Ховд, Нэхийт бол Булган аймгийн хүн байжээ.

Ахмад Нэхийт Тэгшээг анх цэрэгт ирэхээс нь эхлээд бусад нөхдийн адил чухал юм болгонд дагуулан явсаар хил хамгаалах ажилд нэлээд дадлагажуулжээ. Нэхийтийг нутгийн хүмүүс “Нэхийт баатар” гэж нэрлэдэг болсон юм. Хүмүүс түүнийг зоригтой эр “Манай Нэхийт баатар” гуай гэхэд тэр туйлын их дургүйцэж:

Та нар огт шал дэмий юм хэлж байх юм. Харин манай Тэгшээг үзвэл яана гэж хэлдэг байжээ. Тэр хоёр хамт явахдаа тун их дуртай байдаг байжээ. Нэхийт Тэгшээ хоёр хорь шахам удаа цуг явахдаа манай улсын энхрий дархан хил хязгаарыг зөрчихөөр оролдсон олон тооны тагнуул, хорлон сүйтгэгчдийг барьжээ. Тэгшээ харуул манаанд явах болгондоо ахмад Нэхийттэй хамт явдаг байсан олон удаагийн дурсгалт явдлуудаа дурсан бодож явдаг хүн юм. Гэвч бас Майдрагаас салах юм бол мөн л ийм болно доо. Энэ шөнө бас л Нэхийтийгээ бодсоор явж байна.

Манай арван нөхөд явсаар Бүдүүн Харгайтын голын адагт байгаа манааны байранд хүрэлцэн очоод тэнд байсан манаанаас албан үүргээ хүлээн авч цааш явсаар уг эзлэх тушаалтай Нэргүй өндөрт очиж байрлаад хянах сэргийлэх ажлаа үргэлжлүүлэв.

Харуулын ахлагч Хаянхярваа, од түгж гүйцээд цайвартан байгаа шөнийн тэнгэрийн доогуур алсыг хараад, ажиггүй хэвтэж байгаа цаст уулын хүчит цагаан арслан шиг харагдан байгаа Байдаг уулыг сонирхон харж энэ уул яагаад ийм нэртэй болсон хэрэг юм бол гэж бодов. Нутгийн хүмүүсийн ярьдгаар бол олон янзын домог байдаг байв. Нэг торгууд өвгөний хэлж байснаар бол энэ ууланд байхгүй ан гэж байдаггүй юм гэнэ. Энд ховор ан болгон байдаг, тэгээд Байдаг гэж нэрлэсэн юм гэнэлээ гэж ярьж байсан нь ортой ч байж мэдэх юм даа гэж санагдаж байжээ.

Хаянхярваагийн хажууд байгаа нөхөд нь цөм тус тусынхаа харвал зохих чиг чигээ ажиглаад, чимээ аниргүй хэвтэцгээж байв.

Алсад бүдүүн Харгайтын голын урсгал нэгэн ая хөгжимдөн шаагьж, ялааны жингэнэж дуугарахаас өөр чимээгүй, тун хачин нам гүм байжээ.

Манай арван нөхдийг манааны байранд очиж суусны маргааш буюу 1948 оны долоодугаар сарын долооны өдрийн орой яг харуй бүрий болж байх үед дэд хурандаа Хау Ен-гийн анги, машинаа орхиод морь, тэмээ хэрэглэж Монгол улсын хил тийш хөдлөн гарчээ.

Хоорондоо хоёр, хоёр километрийн зайтай гурван хэсэг морин цуваа болжээ. Цуваа болгон тавин хүнтэй юм. Түүний араас тэмээн ачаа, тэр ачааг хорин таван хүн дагаж явна.

Хөдлөхийн өмнө хүн болгонд нарийхан шанз олс хоёр, хоёрыг өгснийг бодсон ч тэр, хоосон тэмээ хориодыг хөтөлж явааг бодсон ч тэр, ямар боловч хүн барихаар явж байгаа юм байна гэдгийг цэрэг болгон таамаглан мэдэж байв. Төмөр мухлагтай гурван машиныг маргааш өглөө бидний хойноос явуулаарай! гэж тушааж байсныг бодоход бүр ч хэрэг тодорхой болж байжээ.

Гэвч чухам хаа очиж, ямар хүмүүсийг барих гэж яваагаа одоо хүртэл мэдээгүй байгаа нь тун хачин гайхалтай юм. Тэр тухай асуух ч хэрэг алга. Хэрэв асуувал улаантныг барих гэж яваа юм гэж хэлнэ биз. Яасан ч олон улаантан гэгчив. Улаантнууд олширч өргөн хүрээтэй болж байна. Үүнээс

өмнө зөвхөн Орос, Монгол хоёрыг улаантан гэж тоолдог байсан бол одоо хойд Солонгос, Хятадын зүүн хойд мужууд, бас Европт арав шахам улс улаантан болоод байна. Бид одоо тэр олон улаантны чухам алинд нь очих гэж яваа хэрэг юм бол алин ч байлаа гэсэн улаантан л болсон хойно амаргүй шүү дээ гэж хүн болгон бодож явжээ. Хау Ен цувааны түрүүнд зам заагчидтай зэрэгцэн таг дуугүй явж байна.

Тэд урагш онцын саадгүй явсаар байв. Зуны сарын богино шөнө өнгөрөх тийшээ хандаж, үүр цайх дөхөж байгаа бололтой тэнгэрийн хаяа зүүнтээнээсээ судал татан цайрч байв. Цувааны түрүүч нэгэн даваа өөд өгсөж явсаар орой дээр нь гарч очив. Зам заагч мориныхоо амыг татаж зогсоод Хау Ен тийш хазайж:

Ноён гуай! Одоо Монгол улсын хил дээр хүрч ирлээ шүү гэж шивэгнэв. Хау Ен, бууны дуу сонссон юм шиг сандарч мориноосоо буун харайж, газар тэврээд чимээ чагнав. Холхон зайтай газар голын ус шуугин урсахаас өөр чимээ аниргүй нам гүм байв. Тэгээд өмнөх газраа харахад нь тэр өндөр уулын ёроол бэл гэх юм үзэгдэхгүй, шөнийн өтгөн харанхуй нүүгэлтэн тунаад нисэж үхмээр гүнзгий хар нүх шиг харагдаж байх нь та нарыг талийгаач болгох газар энд байна. Дайн өдөөгчдийн гар хөл болсон та нарыг энэ нүхэнд авслан булах гэж байсан юм гэсэн шиг нэг л хачин эвгүй зэвүүцмээр харагдаж байжээ.

Хау Ен, аман дотроо “Улсын хил” гэж шивнээд ямар байдаг бол гэсэн шиг санамсаргүй газар самардаж үзэв. Ийм л хатуухан байдаг юм даа гэсэн шиг чулуун хайрга дайралдаж байв. Хау Ен-г сая наашаа гарахаас өмнөхөн Вашингтоноос ирсэн нэгэн Америк ноён Ч... хотын цэргийн ноёдод лекц уншиж байсан нь санагдав.

Тэр ноён Америк төрийн бодлого гэгчийг хоолойгоо сөөтөл магтан хашхичаад ярианыхаа төгсгөлд: Манай Америкийн ойрын ирээдүйн зорилго бол энэ дэлхийн бөмбөрцөг дээр байгаа олон улсын хил хязгаар гэгчийг газрын зураг дээрээс арчин баллаж зөвхөн Америк гэсэн үг үсгийг үлдээхийг хүсэн эрмэлзэж байдаг юм гэж хэлэх шахсанаа Америк, Гоминданыхан гэдэг хоёр нэр томъёог үлдээх болно гэж байсан нь бодогдоод, нээрээ ч энэ хил хязгаар гэдэг зүйл хэнд хэрэгтэй юм бэ? баллан арилгаж байвал таарах юм гэж бодож байжээ. Тэр Америк ноён гадаад Монголын тухай онцлон тэмдэглээд:

Дорно зүгт эв найрамдал, эрх чөлөө гэдэг хортой бодлогын талаар үлгэр жишээ болж хамгийн аюултай муу нөлөөг бие махбодтойгоор үзүүлж нөлөөлөн байгаа ганц улс бол Монгол улс юм, энэ Монгол Улс гэдгийг нэг үгээр хэлэхэд шинэ дайныг явуулах гэсэн манай Америк ноёдын эрхэм зорилтын эсрэг зогсож байгаа энх тайвныг эрхэмлэдэг хортой муу ухуулах хуудас шиг юм гэж нэрлэвэл таарна. Тэгвэл бид тэр ухуулах хуудсыг дэлхийн бөмбөрцөгөөс хуулан хаявал зохино. Түүнийг ганцхан танай Гоминданыхан л авч хаях ёстой, одоо тэр цаг нь болоод байна. Тийм ч учраас бид Монгол Улс гэгчийг Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүнд элсүүлэн авахаасаа татгалзсан юм гэж царайгаа улайтал хашхирч байсан нь хүртэл санагдаж байжээ. Цэргүүд хойно хойноосоо ирж Хау Ен-гийн дэргэд бөөгнөрөн зогсов. Хау Ен толгойн сэргийлэхэд хоёр хүнийг нэмж бүгд таван хүн болгон томилж газарчийн хамт явуулаад цэргүүдээ хойноос нь явуулах тушаалыг өгөөд урагш хөдлөн явцгаажээ. Цөм бүсэндээ хүлгийн нарийхан олс хавчуулсан тэр цэрэг

хувцастай араатнуудын хутган жад нь үүрийн үнэгэн харанхуйн дундуур сэрэлзэн гозолзож байх нь ямар нэгэн үхсэн амьтны сэгийн хэрзийсэн яс шиг харагдаж байна. Та нар яаж байгаа чинь энэ гэгчив? гэж дэлхийн бөмбөрцгийн тив бүхнээс хилэгнэн уурласан хэдэн олон сая шударга хүний хурц нүд ширтэн харж байх шиг тэнгэрийн гүнээс олон түмэн одон мичид жирэлзэн гялалзаж байжээ.

Хау Ен -гийн анги цуван явсаар нөгөөх өндөр уулын бэлд бууж голын модонд орох үед үүр цайж гүйцжээ. Тэд шигүү ургасан модон дотор хориглон нуугдаад ойр хавийг хянаж эхлэв. Хау Ен Америкийн цэргийн согтуу ноёноос хоёр лонх архи өгч худалдан авсан Америк дурангаараа дурандав. Тэр ноён энэ дуранг өгөхдөө:

Та нар бол сохор хар нохойнууд гэж Америк ноён болгоны амны уншлага болсон үгээр доромжлоод цааш нь дурангаа магтаж хэлсэн нь: Миний энэ дурангаар хүний юу хүссэн болгоныг харж болно. Хэрэгтэй бол бүх дэлхийг ч үзэж чадна. Яагаад тэр вэ гэвэл энэ дуран Америк юм болох учраас тийм эрдэм чадалтай байгаа юм гэж чалчиж байжээ. Тэр согтуу ноёны галзууран гайхуулж байсан энэ Америк дурангийн шилэнд одоо чухам юу харагдаж байна вэ? гэвэл, ноён Хау Ен -тэй нэгийгээ үзэх гэж занан зүхэж байгаа нөгөө Монгол цэргийн бараа ер харагдсангүй, харин мөсөн уул бүхий гадаад их далай долгилон байгаа юм шиг Монгол улсын зурагт нутгийн нэгэн хэсэг Бор цонжийн өргөн уудам говь цэнхэртэн цэлийгээд сүрлэг өндөр цаст Алтайн нурууны үүлэн цагаан уулс гялалзан харагдаж байжээ. Одоо бодоход тэр мөсөн уулыг Хау Ен-гийн сууж явсан далайн онгоц хэмээх мөргөж бут үсэрсний дараа нь аврахын горьдлого тасраад далайн сүрт давалгаан дээгүүр ганц сул банз унаад хөвж яваа юм шиг сэтгэлд тавгүй нэг л хачин болж байна. Хау Ен цэргүүдээ энэ модонд түр амруулахаар шийдэж бага амралт хийцгээ гэж тушаав. Амь тэмцэн тулалдахын өмнө ухаан санаагаа балайртал архи уухыг эрхэм болгодог нь харгис гоминданы хөлсний дээрэмчин цэргийн ердийн заншил нь болсон хэрэг юм. Хау Ен лонхтой архи гаргаад саваар нь залгилж байв. Цэргүүд мөн л уулгамч юм шиг хүн болгон ташмагтай архиа хөхөж, шар будааны гурилаар жигнэсэн мантуугаа идэцгээж байна. Тэгээд ямар нэгэн баяр ёслолд жагсах гэж байгаа юм шиг голын усанд цонхир цагаан нүүр гараа угаацгаажээ. Та нар ариун сайхан усы минь битгий бузарла! гэсэн юм шиг Бүдүүн Харгайтын голын тунгалаг ус яаран урсаж байна. Удсангүй баруун уулын оройд өглөөний алтан шар нар тусаж элдэв олон зовлонг үзэж өнгөрүүлсэн өвгөн хүний атираат үрчгэр нүүр шиг “Байдаг Богд” уулын олон сархиаг сүүдэр татан зурайгаад ямар нэгэн уран зураачийн гараа гарган зурсан зураг шиг харагдаж байна. Зүүж явсан савтай архинуудаа хуу шавхан ууж гүйцээд одоо чухам яахаасаа ч буцахгүй болсон тэр зэрлэг харгис дээрэмчид морьдоо хөтөлж голыг уруудан явцгаажээ.

Долоон нөхөд нь дөнгөж сая гол дээр очиж амрахаар яваад манааны байранд зөвхөн Тэгшээ хоёр нөхрийн хамт үлдсэн цаг байлаа. Шөнө нойргүй хоносон Тэгшээгийн нүд анилдаж, бие нозоорч байжээ. Гэвч Тэгшээ цэрэгт ирснээсээ хойш, манаанд байхдаа ганц ч удаа үүргэлж үзээгүй хүн юм.

Тэгшээгийн нүдний буланд голын модон дотроос үргэж цочсон бололтой шувуунууд түргэн түргэн нисэж байх нь харагдав. Үүнийг харснаас хойш Тэгшээгийн нозоорч байсан байдал хулжин алга болжээ.

Тэгшээ хоёр нөхөртөө нүдээрээ дохио өгчээ. Манай гурав яг тэр шувуу үргэж ниссэн зүг анхааран ширтэж байв. Удсангүй модон дундуур морьтой дөрөв таван хүн явж байгаа харагдав. Бид дайсан мөн шүү гэсэн шиг тэдний бууны хутган жад наранд гялалзаж байна. Тэр тав, голыг уруудан ажиггүй явцгааж, бас араас нь морьдоо хөтөлсөн олон хүн цувран явж байгаа харагдана.

Тэгшээ үүнийг хараад шүдээ зууж царай нь тас хар болон барайж ганц ч үг дуугарсангүй хэвтээгээрээ сэмхэн гулгаж уулынхаа ар луу буугаад гол дээр байгаа нөхдөдөө, дайсан! гэдэг дохио өгөв. Тэгээд буцаж байрандаа ирж хэвтээд дайсныг аман дотроо тоолж байв. Манай долоо яах яахын завгүй манааныхаа байранд хүрэлцэн ирээд тэднийг дурандав. Цөмөөрөө бор саарал өмд цамцтай, саравчтай овгор малгай өмссөн нэгэн жигд намхан нуруутай цэргүүд буугаа өмнөө бэлхэн бариад гэтэн мярайж яваа харагдав. Хаянхярваа хэдэн үг яаран бичиж дугтуйлаад сумангийн дарга ахмад Майдрагт гэж нүүрлэв. Тэгээд хилчин Пэлжээд холбоо барих тушаал өгчээ.

Болгоомжтой явж, түргэн гүйцэтгэ! Хэрэг тохиолдвол мэдээгээ устга! Одоохондоо тавь гаруй хүн байна. Цаана нь бас байж мэднэ. Гэвч битгий сүр бадруулаарай чи мориныхоо хамгийн сайныг сонгож унаад яв! гэж тушаасанд Пэлжээ тушаалыг давтаад явах болов.

Чи миний халзан морийг унаад яв! гэж хэлээд Тэгшээ морин тийш очоод олмыг чангалж байлаа. Олом чангалах тэрүүхэн хооронд энэ халзан морины эзэн сумангийн дарга хайрт нөхөр Нэхийт нь санагдаж байв. Мянга есөн зуун дөчин долоон оны тавдугаар сарын сүүлчээр манай улсын хилийн дотор дур мэдэн орж ирээд хориглон байсан дайсныг хил хязгаараасаа хөөн гаргаж байхдаа энэ халзан морийг Нэхийт унаад гялалзан явж байсан нь санагдав. Тэгэхэд Нэхийт Тэгшээ хоёрыг дайсны хорь гаруй морьтой хүн бүслэн авахад тэднийг шууд дайран ороод хага зүсэн гарч байж билээ. Мөн оны зургаадугаар сарын тавны өдөр манай улсын хил хязгаар луу дахин хулгайн аргаар довтлон ирсэн таван зуу илүү дайсныг бут цохин няцаагаад тэдний үлдэгдлийг хөөн гаргахад мөн энэ халзан морио унаж явжээ. Тэгэхэд Тэгшээгийн унасан хүрэн морь энэ халзан морьтой зуузай холбож ангиасаа хол тасран түрүүлээд харайлгаж явсан юм байжээ. Нэхийт Тэгшээг үзээд чи үүнээс хойш ингэж ангиасаа тасран салж болохгүй шүү нөхөр минь! гэж хатуу сануулга өгч байжээ. Түүнээс хойш бас нэг сүрхий ширүүн тулалдаанд Тэгшээ морио алуулаад дайсанд яасан ч гэсэн өгөхгүй гээд эмээл хазаараа үүрээд бүслэлтээс гарч явахад Нэхийт, Тэгшээ дээр мөн энэ халзан мориороо давхиж ирээд: Чи яасан чулуун зүрхтэй хүн гэгчив. Наад эмээл хазаараа хаяад бүслэлтээс түргэн гарахыг бод! Би чамд байлдааны үеийн офицер хүний үгийг хэлж байна гэж хэлж байсан нь хүртэл бодогдож амжив. Тэгшээ, Пэлжээ хоёр гар барилцан салж ядан байгаад аргагүй хоёр тийш явжээ.

Пэлжээ мориндоо мордоод хадан дундуур харайлган давхив. Халзан морь эзнээсээ салсандаа тэгсэн юм болов уу, ижлээсээ холдсондоо тэгсэн юм болов уу, амы нь татахаар үүрсээд хоёр чихээ хулмайлан хурдлан явж

байжээ. Пэлжээгийн ар талд түүний хайрт есөн нөхдийн хориглон хоцорсон нөгөөх Нэргүй өндөр хар уул улам улам холдсоор алсад цэнхэртэн хоцорчээ. Халзан морь барагцаалбал минут тутамд километр илүү газар хурдалж явлаа.

Дайсан хойно хойноосоо гарч ирсээр улам олон болж барагцаалбал зуун тавь гаруй хүн болжээ. Тэднийг яг харалдаагаа ирүүлээд Хаянхярваа амныхаа хоёр талыг алгаараа халхлаад,

Зогс Зэвсгээ хая! гэж хашхирав. Тэд анчны үргээлт сонссон чонын сүрэг шиг бөөгнөрөн зогсжээ. Хаянхярваа дахин хашхирав.

Ахлах дэслэгч ээ! Яаж байгаа юм бэ? Эднийг олон таван үггүй шууд буудъя гэж хамгийн дуу цөөнтэй Даваадорж шаардангуй хэлсэнд, Тийм биш, буудахад хожимдохгүй, Бид бол дайныг хүсдэггүй, эв найрамдлыг хамгаалж энх тайвныг эрхэм болгон сахидаг улс. Тийм учраас бид эднээс урьтаж яасан ч гэсэн буудахгүй гэдгээ сануулж байгаа юм, эд ямар ч хүмүүс байж болох юм гэжээ. Дайсан морь тэмээгээ модон дотор орхиод цөм явгалан давшиж эхлэв. Тэгээд ясанд хадсан хяхарган муухай дуутай ямаан бүрээ татав. Тэр бүрээний дууг сонсоод манай есөн нөхдийн бие арзасхийх шиг хачин муухай болж байжээ. Нэгдсэн Үндэстний байгууллагын хурлын индрийг ашиглан Англи, Америкийн харгис ноёд, Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүнд авахгүй гээд хашхичиж байсан нь дэлхий дахины шударга хүн төрөлхтний чихэнд ямар шуухан муухай сонсогдож байлаа, бүрээний дуу яг түүн шиг муухан сонсдож байна. Дайсан бүрээ татсаныхаа дараа, давшилтаа түргэтгэн гүйцгээж байв.

Хаянхярваа дахин хашхирав. Тэд манай есөн хилчний зүг гал нээж тун саяхан хэдэн минутын өмнө ус шуугих, ялааны жингэнэхээс өөр чимээ аниргүй нам гүм байсан манай дархан хилийн тайван байдлыг шууд эвдэн цочоожээ. Манай хүмүүсийн нүүр царайг хэн ч харсан цөм эцсээ хүртэл тулалдана гэсний шинж илэрхий байлаа. Хаянхярваа цагаа харав. Яг ес болж байна.

Чойжин, Баян, Гончигзэвгээ гурав тэр урдах өндөрт Дандархайдав бид хоёр энэ дундах онь дээр, Гиваан Даваадорж, Тэгшээ гурав тэр хойтох нахиу дээр байрла! Нөхөр Архад морио барь! Улаан пуужингаар гал нээх дохио өгнө гэж тушаав. Манай ес түргэн явж тус тусынхаа байрыг эзлэв. Манай есөн нөхдийн байгаа өндөрлөгт винтовын бөмбөг, миномётын сум хойно хойноосоо исгэрэн ирж, хүнд пулементын сум шуугин асарч газар донсолгон хад чулууг онгичин бужигнуулж, утаа шороо дээш манарах нь цэлмэг хөх тэнгэр өөд багана мэт суунаглаад хавь ойрыг юу ч харагдахгүй харанхуй манан болгов. Дайсны давшилт улам ойртож офицеруудын хараах, загнах, командлах тушаах нь хүртэл тодхон сонсдож, барагцаалбал найман зуугаад метрт түрүүч нь хүрч иржээ. Гурван хэсэг тасарсан манай хилчид галлахыг яарч тэсэж ядан хүлээж байжээ. Дайсан одоо зөвхөн винтовын бөмбөг, миномёт, хүнд пулемётоор буудах төдий биш, хөнгөн пулемёт винтовоор галлаж байх нь хад уул нурж байгаа юм шиг нүргэлэн шуугиад манай есийн эзлэн байгаа өндөр хар уул ширүүн гал дээр буцалж байгаа ус шиг оволзон бужигнаж байна.

Хаянхярваа цагаа харав. Есөөс арван минут өнгөрч нарийхан улаан зурвас тэнгэр өөд зурайн татав. Түүнийг замхарч амжаагүй байхад хойт талын нахиу дээрээс Тэгшээгийн хөнгөн пулемётын танил дуу тачигнаж эхлэв. Бусад хоёр хэсэг нь мөн түүнийг залган галлав. Тэгээд пуужин буудав.

Манайхан буудахдаа хамаа намаагүй хандсан зүг тийшээ буудсангүй, цөм хичээнгүйлэн шагайж сум болгоныг зохих эзэн олгож байжээ. Тэгшээ хүртэл пулемётоо үргэлжлүүлэн пижигнүүлэхгүй богино ээлжээр галлаж байв. Дайсан алагдсан, шархадсан хүмүүсээ яаран сандран ар тийш нь зөөж эхлэв. Гэвч давшилтаа зогссонгүй, харин улам урагш зүтгэлэн тэмүүлж галлах нь ширүүсэн нэмэгдсээр байна. Тэд хүний олноор ааглах санаатай байгаа бололтой уулын ёроолд тулж ирээд тойрон ороож бүслэн эхлэв. Одоо манай ес ганц зүгээсээ биш, харин тал бүрээсээ буудуулах болжээ. Ар талын гүнзгий жалгад морьдоо барьж байсан Архад алагдаад, суларсан морьд нь ийш тийшээ бужигналдан давхилдаж алсад гараад юу болж байна даа, бид одоо яавал зохих вэ? гэсэн янзтай харж хэсэг зогссоноо сумангийн байр тийш бараг бөөнөөрөө тоос татуулан алга болж өгчээ. Хаянхярваа, Дандархайдавыг явуулж Архадын буу зэвсгийг авхуулав. Тэгээд тэр чигүүдэд бууд! Тэнд байраа соль гэж үргэлж зааж удирдан байв. Тэр үед Дандархайдав: Ахлах дэслэгч ээ! Би ч гайгүй харин та өөрөө биеэ далдлахгүй байгаад дайсны суманд дайралдаж магадгүй байна шүү гэж хэлээд ер сандарч тэвдсэн царайгүй буудаж байлаа. Тэр үед Тэгшээ, Даваадоржийнхоо бэлдэж өгсөн магазинтай сумаар пулемётоо цэнэглээд бууныхаа хөлийг дахин суурилуулан засаад арын гүдгэр өөд авиран бужигнаж байгаа дайсан руу галлаж байв. Пулемёт ч хачин мэргэн тусаж байв. Хаянхярвааг нэг харахад нь Дандархайдав шархадсан байна. Цээжээрээ хүнд шархадсан тэр байлдагч цусаа их асгаруулаад царай нь хувхай цагаан болж тамирдан ядраад бууныхаа замгийг татаж хүч хүрэхгүй шахам байгаа боловч шүдээ зууж буугаа сумлаад нүд нь бүрэлзэж юм харж чадахгүй байгаа боловч буудах гэж оролдон ядаж байв. Хаянхярваа түүний шархыг боож эхлэв. Зүүн талынхаа хөх махны дээд талаар шархадсан байлаа.

Ахлах дэслэгч ээ! Би гайгүй зүгээр шахам байна. Энэ хар хогуудтай нэгийгээ үзэлцье гэж хэлэхдээ, үг нь тасалдаж дорой сулхнаар дуугарч байна. Олон давхар боосон самбай даавуу нь удаж төдсөнгүй цус нэвтрээд ирлээ. Хаянхярваа, Дандархайдавын цэл хүйтэн болсон магнайгий нь илж ташмагтай уснаасаа залгилуулаад ар тийш нь явуулах гэсэнд: Дарга минь намайг битгий явуул! Би тэднээс ганцыг боловч хороохыг бодож байна гэж дахин давтан гуйсанд Хаянхярваа түүнтэй маргаад тусгүй гэж бодсон бололтой түшин явсаар нэг хонхордуу газар аваачиж хэвтүүлээд: За чи эндээсээ битгий хөдөл! гэж хэлээд дэргэд нь сум овоолж өгөөд явж дахин шинэ байр эзэлж буудаж эхлэв. Урд гозгор дээр гурван буу дуугарч байснаа одоо хоёр болж сонсогдох нь Хаянхярваагийн сэтгэлийг зовоож эхлэв. Тэнд байлдагч Баян алагдаад Чойжин, Гончигзэвгээ хоёр үлдэж ид тулалдан байлдаж байгаа үе байна. Хаянхярваа хоёр хэсгийнхээ зөвхөн бууны дууг ажиглан чагнаад, мөн өөрийнхөө чигээр цухуйж ирсэн болгоныг буудаж далд оруулсаар байна.

Тэгээд Дандархайдавыгаа эргэж үзтэл тэр нь нөгөө хонхроосоо мөлхөн явсаар бараг ил шахам гараад хорь гаран сум буудаад дахин хүнд шархадсан байв.

Түүнийг өндийлгөсөнд дөнгөж амьсгаатай төдий байна. Цамцныхаа өврийг маажлан байж өврөөсөө уул нь хүрэн байгаад одоо үнгэлдэж бор болсон нэгэн жижиг дэвтэр гаргаж өгчээ. Тэр нь намын дүрэм байв. Дандархайдав нүдээ харах гэж оролдоод чадсангүй Тэгээд омголтсон уруулаа эвлүүлэн ядан байж: Дарга минь би... намайг Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүнд тооцохыг гуйя, хөгшин эхэд минь... гэж хэлээд цааш нь юу ч хэлж амжсангүй нас баржээ. Байлдагчаа Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүнд элсэхээр биеэ бэлдэж даах хүмүүсээ хүртэл олоод намын үүрт өргөдлөө гаргаж зөвхөн хурал хүлээж байсны нь Хаянхярваа санав. Хаянхярваа нас барсан байлдагчаа дайсны суманд дахин дайралдах вий гэж хайрлан аяархан өргөж явсаар нэг хонхорт хэвтүүлээд түүнийхээ өшөөг авна гэж тангарагласан юм шиг, буудаж байгаад дутуу сумлан орхисон буугий нь аваад мөн түүнийхээ хэвтэж байсан яг тэр газар нь хэвтээд та нар бас намайг ал! гэж аман дотроо шивнээд шүдээ зууж галлав. Тэр буу ч гэсэн эзнийхээ өшөөг авъя гэсэн шиг хачин мэргэн тусаж байна. Хаянхярваа байраа олон дахин сольж, бууныхаа төмрийг улайстал буудалцлаа. Дайсны бүслэлтийн цагариг дотогш улам агшиж сумын ирэлт ёстой нэг аадрын ширүүн бороо шаагин орж байгаа юм шиг асган цутгаж байна.

Гиваан, Тэгшээ, Даваадорж гурвын байгаа тэр газар дээр бүр ч юу юунаас илүү олон сум нисэн бууж байна.

Миномётын нэг сум исгэрэн ирээд, манай гурвын яг дунд нь буув. Яах ийхийн завгүй пижигнэн тэсэрч, хад чулууг бутраан бужигнуулж харанхуй утаа манарав. Зүүн талын хотгорыг дагаад мөлхөж явсан дайсан руу галлаж байсан Тэгшээ, толгой нь газрын уруу хандаж, тас гэдрэгээ хараад савж унасан байна.

Пулемёт нь онхолдон унажээ. Хоёр нөхөр нь босож дэргэд нь очтол түүний баруун талын хөл тас үсрээд, дөнгөж шөрмөсөндөө торж байв. Шархы нь боох гэж оролдов. Гэвч боохын арга алга. Тэр хооронд Даваадорж, пулемётоо босгож аваад галлажээ. Гиваан оролдон байж, Тэгшээгийнхээ шархыг боосон болжээ.

Тэгшээ нэг минут хэртэй ухаангүй байснаа сэргээд арын байранд оч! гэж нөхдийгөө гуйхад нь үгүй гэж тас зөрөөд: Би зүгээр байна нөхөд минь, та нар битгий зов! гэж хэлээд байраа солихоор чулуун дундуур хөлөө чирэн мөлхөж байгааг хоёр нөхөр нь зүрхлэн харж чадсангүй. Харин өөрсдийнх нь яс чөмөг тас үсрэх шиг санагдаж байжээ.

Тэгшээ ажиггүй мөлхөн явсаар шинэ байранд очиж Даваадоржийнхоо винтовоор буудаж байв. Тэр үед Даваадорж нь пулемётоор галлаж, тэр чигээр цухуйсан болгоны нь өвс хадах мэт хяргаж байв. Гиваан Даваадорж хоёр Тэгшээгийнхээ хойноос цувран мөлхсөөр дэргэд нь очиж нөхөртэйгөө зэрэгцэн хэвтээд дахин буудалцлаа. Тэгшээгийн нүүр нь цонхир цагаан болж, том хар нүднийх нь харц аймаар ширүүн болжээ.

Дайсан тэр завсар олон хүнээ гарзадсан боловч уг нь олуулаа тул тун сүрхий бардан зан гаргаж манай гурван хэсгийг тус тусад нь бүслэн аваад,

буудахаа больж цөм мөлхөцгөөж байгаа нь одоо та нар яасан ч гэсэн бидний гараас гарахгүй, цөмий чинь амьд барина гэсэн янзтай байлаа.

Тэнд тийм айхавтар аймшигтай явдал, ширүүн тулалдаан болж байхад тэр хэргийн жинхэнэ эзэн Вашингтоны дуулгавартай зарц нөгөө нялуун зантай ноён Жон ямар ч гэмгүй хүний царай гарган торгон хөнжлийн дотор амгалан дүрээр нойрсож байна. Тэр хүн урьд шөнийн турш шилтэй архитай хэтэрхий найзалсан дээрээс ийм орой болтол дээшлээгүй нойрсон байгаа хэрэг юм байжээ. Гэнэт нэг хүн хаалга цохиж ноёныг нойроос нь цочоон сэрээчхэв. Ид нойрон дундаа дугжран байсан тэр хүнд хаалга цохисон тэр чимээ бол Бүдүүн Харгайтын голд болж байгаа ширүүн тулалдааны газраас пулемётын сүрт чимээг тэр чигээр нь хуулан буулгаж авчран сонсгож байгаа юм шиг хачин эвгүй дуулджээ. Цочин сэрсэн ноёны зүрх пал пал хийн цохилж тэр орж ирсэн хүнийг хамаа намбаагүй хаалга чанга цохиж цочоолоо гээд алгадаад авмаар байсан боловч, түүний гарт бичиг байхыг хараад алим жимсний бараа харсан хүүхэд шиг нүдээ нухлан шууд өндийгөөд эвшээлгэн: Наадах чинь юу вэ? Хаанаас ирэв гэсэнд, холбооны хүн: Ноён Хау Ен -гээс ирсэн мэдээ байна гээд бичгийг өгчээ. Түүнийг авч үзвэл Хау Ен -гээс ирүүлсэн утас байна.

Бид гуч гаруй хүнээ алуулж, хорь гаруй хүнээ шархдуулан, нийт тавь гаруй хүнээ гарзадсан боловч, амжилттай давшиж, Монголын хилийн тэр хэсэг цэргийг бүслэн авлаа. Тэд гурван хэсэг, барагцаалбал, бүгд дал, наяд хүн байх шиг байна. Хау Ен гэжээ. Ноён Жон тэр мэдээг хөнжил дотроо шалдан сууж хоёр дахин уншаад, түргэн хувцаслаж нүүр гараа ч угаасангүй өглөөнийхөө цайг ч уусангүй, гадаа бэлэн хүлээж байсан машиндаа сууж явсаар ноён Зо Пу Саны хөх байшинд морион очжээ.

Тэгээд уул ирсэн мэдээг Зо Пу Санд товч танилцуулж Монголын хилээс баригдаж ирэх тэр цэргүүдийг төвд хүргүүлэхийн наана урьдчилсан байцаалтыг явуулах газар бэлдүүлэх, мөн хорих байрыг үзэхээр Зо Пу Саныг дагаж гадагш гарчээ. Зо Пу Сан, ноён Жоныг дагуулан явсаар шууд газар доогуур орж явчив.

Энд Зо Пу Саны байцаалтын газар, мөн хорих байр байдаг юм байжээ. Тэр байцаалтын тасалгаанд тос болсон резинэн муна, тахир болсон төмөр сүмбэ, суран ташуур, нүд ухдаг тахир хутга, түр хэдэн минут дүүжлэн авдаг олсон бугуйл зэрэг олон төрлийн багаж хэрэгсэл цөм бүрэн байна.

Хэрэв түүнийг соёлт хүн үзэх юм бол дундад эртний үеийн хамжлагын ёст байдлыг үзүүлсэн музей буюу үзэсгэлэнгийн газар юм байх гэж бодохоос биш хаанаас одоо цагийн хүн төрөлхтөн ийм аргыг хэрэглэх вэ гэж марган зүтгэх байсан байх аа. Гэтэл ноён Жон түүнийг үзээд сэтгэлд нь бас л дутуу юм олон байх шиг санагдаж байжээ.

Тэндээс цааш явж хорих газрыг үзлээ. Тэр нүхнүүд шал ба цонхгүй, бас хана нь шороо хэвээр, хаалга нь хүний бугуйнаас бүдүүн төмрөөр торлож хийгдсэн юм байна. Жон ноёны сэтгэлд тэр тасалгаанууд нь бас л дэндүү саруул цэвэрхэн юм шиг санагдаж, түүнээс илүү харанхуй бөгөөд бохир газар гэж байж болох мэтээр санагджээ.

Хэрэв газрын дор бас нэг газар гэж байдаг сан бол тэр байрыг өөрчлөн тэнд байгуулах юмсан гэж бодогдож байжээ. Хау Ен -гийн бүслэлтэд орсон

тэр дал наян Монгол цэргээс ядаж ихэнх нь баригдаж ирэх нь зайлшгүй гэж хэлэлцээд, долоо найман тасалгаа түр зайчлан суллах хэрэгтэй болжээ.

Тэр харанхуй нүхэнд хятадын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө баатарлагаар тэмцэж байгаад баригдан хоригдсон хүмүүс олон байна. Олон сар хоног нар салхи үзэлгүй хоригдоод мөн байцаалтын газар олон удаа очиж тамлуулсан боловч эрх чөлөө, энх тайвны ариун шударга үнэн бат хэргээс буцаж няцсан хүн нэг ч гарсангүй байжээ.

Гары нь ард нь янгинатал хүлсэн Монгол цэргийг тэр харанхуй нүхнээс чих, хамар аль дайралдсан газраас нь барьж, байцаалтын газар чирч оруулаад аль чадах арга болгоноороо тамлан зовоож хэрэгцээтэй асуулт болгондоо зохистой хариу гаргуулан авна гэж бодохоос Хаяу Ен -г ойр байгаа сан бол бушуулаарай гэж хашхирмаар санагдаж байжээ. Зо Пу Сан, гаднаас цагдаа нарыг дуудан авчирч хэдэн тасалгаа суллан цэвэрлэ! гэж тушаав.

Цагдаа нар хоригдлуудыг чирэн гулдарч, бусад тасалгаануудад чихэн оруулж байна. Тэр хүмүүсийн дотор эрүүл бүтэн хүн нэг ч алга байна.

Зарим нь өрөөсөн гаргүй, зарим нь доголон, бас зарим нь сохор болсон байна. Тэднийг хараад инээмсэглэн зогсож байгаа тэр хоёр ноёныг олон хүний аймаар ширүүн нүд ширтэн байлаа.

Англи, Америкийн харгис ноёдын гар хөл болсон гоминданы гинжтэй нохойнууд та нар, биднийг энэ шорондоо бүх насаар минь хорьж яасан ч чадахгүй. Хятадын таван зуугаад сая ард түмнийг цөмий нь хорих тийм том шорон эрхэм ноёдод олдохгүй, манай хэрэг ариун бөгөөд үнэн, бид ялах нь лавтай, бидний талд бүх дэлхийн шударга хүн төрөлхтөн зогсож байна” гэж тэр муу хоёр нохойн гөлөгт хэлэх юмсан. Гэвч тэр хоёрыг тоож хэлэхээ больё.

Тэртэй тэргүй хятадын ард түмэн, бүрэн чөлөөлөгдөөд байх цагт та нар ардын шүүхийн өмнө хэрэгтэн болоод байхыг чинь бид үзэх болно. Тэгэхэд бид хэрэг нэхэмжлэгчээр сууна. Үүнд бид коммунист ёсоор итгэж байна гэсэн шиг цөм ажиггүй явцгааж байна.

Хувьсгалын нууцыг задруулснаас шууд үхсэн нь дээр гэж эрс шийдсэн чулуун зүрхт тэр хүмүүсийн хэн нь ч гэсэн хоёр ноёноос өршөөл гуйсангүй. Удтал харсан тэдний ширүүн харцат нүднээс дальдарч, халуун байна, харанхуй байна гээд яаран гадаа гараад хөлсөө арчиж байжээ.

Тэр хоёр ноёныг шоронгийн хаалгаар сандран гараад хөлсөө арчиж байх үед Бүдүүн Харгайтын голын хойт өндөрлөгт тун айхавтар сүрхий аймшигтай юм болж байна. Хаянхярваа хэд дахин байраа сольсон боловч нөгөө хоёр хэсэг дээрээ очиж биеэр удирдах зав чөлөө ер олдсонгүй, тэр хоёр хэсгийг одоо зөвхөн бууны нь дуугаар хэрхэн байлдаж байгаагийг нь таамаглаж байжээ. Урд өндөрт байн байн дуугарч байгаа хоёр буугийн дууг сонсохдоо Хаянхярваагийн сэтгэлд нөгөөх царгиа бүдүүн дуутай том алаг нүдтэй Чойжин, онигор нүдтэй махлаг тарган Гончигзэвгээ хоёр нь харагдах шиг болж, тэр хоёр минь яасан их цангаж байгаа бол. Алив би буудаж байя! Май та хоёр энэ усыг уу! Наад хөлсөө арч! Байраа тэнд соль! Тэр тэр чигүүдэд тэгж, ингэж бууд! гэж зааж өгөх юмсан. Тэр хоёр минь шархадчих вий дээ гэж бодогдохоос биш, өөрийнхөө ам цангаж байгааг ч мэдэхгүй, савандаа ус байгаа байхгүйг ч санахгүй, хацраа дагаад урсаж байгаа хөлсөө гарсан

гараагүйгий нь ч мэдэхгүй байгаагаар үл барам, өөрийнхөө алагдах шархдахын тухай бол бүр ч мартаж орхисон байжээ.

Хойт онин дээр байгаа гурван нөхдийнх нь чимээ Хаянхярваагийн чихэнд бүр ч тодхон сонсогдож тэнд тун их юм болж байх шиг байна.

Тэгшээгийн пулемёт үе үе чимээгүй болж байв. Пулемётоо чимээгүй болохоор нь Хаянхярваа шууд өндийгөөд ирдэг байв. Дахин дуугарахаар нь дотор нь онгойх шиг болоод үргэлжлэн буудалцдаг байжээ.

Манай пулемётыг чимээгүй болохоор дайсан дайрч байгаа бололтой шуугилдаад, дахин тачигнахаар нь чимээгүй болдог байжээ. Дайсан манай гуравт тун ойрхон очсон бололтой, гранат пис, пис хийн дэлбэрэх чимээ сонсогдож байна. Тэгшээ, Даваадорж, Гиваан гурвын байгаа тэр хэсэг дээр дайсан нээрээ ч хүчээ хуралдуулж дахин дахин дайрч байв.

Цаашаагаа хараад буудаж байсан Тэгшээ нөгөө хоёр тийшээ эргэж харалгүй, Тасгийн дарга аа! Запас магазин байхгүй. Одоо яана гэжээ. Гиваан миномётын бөмбөгөнд хэмх цохигдон эвдэрсэн магазинуудаа гомдолтойгоор харж байна. Даваадорж ганц магазинтай сумаараа пулемётоо сумлаад арын гүнзгий жалга өөд өгсөн мөлхөж яваа хэсэг дайсан руу галлаад магазинаа яаран мулталж Тэгшээд өгчээ. Тэгшээ түүнийг сандран сумлаад дахин өгөв. Гиваан цагаа харав. Арван нэгэн цагаас арван таван минут өнгөрч байв. Тулалдаан есөн цагт эхэлсэн гэж бодоход хоёр цаг арван таван минут тулалдсан хэрэг болж байна.

Манай гурав Пэлжээгийнхээ явсан тэр зүг рүү харсангүй, харин бие биеэ харцгаав. Холбоочин Пэлжээгийн явсан тэр зүг одоо харах юм бол зөвхөн цэнхэр униар татаад нэгэн жигд олон ухаа толгод үелэн шаргалтаж харагдахаас өөр юу ч үзэгдэхгүй байна. Дайсан хэсэг зуур чимээгүй болов. Гэвч чимээ аниргүй тэр байдал нь манай хилчдийн сэтгэлийг улам түгшүүртэй болгов. Тэд шинэ дайралтанд бэлтгэж байгааг манайхан сайн мэдэж байжээ. Одоогийн ирэх гэж байгаа тэр дайралт бол арван ес дэх нь болох юм. Тэр арван найм дахин дайрахдаа манай гурвын ширүүн галд тухай бүр хяргагдан няцсан юм. Дайсан арван минут хэртэй чимээгүй байснаа дахин шулганалдан шуугьж эхлэв. Тэд урьд нь манай гурвыг ганц магазинтайг мэдсэн бололтой мөлхөж дөхдөг байсан бол одоо цөм босоогоороо буугаа өмнөө бэлхэн барьсан яваа харагджээ.

Одоо тэд ганц талаас биш, зүг бүхнээс гарч иржээ. Манайхныг буудахгүй байхаар нь бүр ч их сагсуурч байна. Тэгшээ Даваадоржоосоо пулемётоо аваад магазин сумыг дуустал бууджээ. Дайснууд өвс хадагдахын адил хяргагдан унасан боловч бусад талаас нь дайрагчид бүр ойрхон хүрээд иржээ.

Одоо магазин сумлах ч зав олодохгүй болжээ. Манай гурав одоо яахав гэсэн бололтой бие бие рүүгээ дахин харцгаав. Ийм үед олон таван санаа хэрэггүй гэсэн бололтой Тэгшээ, шидсээр байгаад үлдсэн ганц гранатаа барьж нэг үзсэнээ, өндийж суугаад амь шигээ хайрлан байдаг хөнгөн пулемётоо аман дээрээс нь шүүрч аваад хад ташин гуядав. Нэг цохиход сүүл мод нь бут үсрэв. Дахиад нэг гуядахад нь гол төмөр нь тахир юм болчхов. Тал талаас өдий төдий дайсан бужигнан иржээ. Манай гурав одоо чухам яахав гэсэн шиг бас бие бие тийшээ харцгаав. Мөн л Тэгшээ түрүүлэн хажуудаа байсан нэг том

чулууг тэврэн авчраад цээжин дороо хийж хэвтээд үлдсэн ганц гранатаа цэнэглэн бэлтгэж элгэн дороо хийв.

Даваадорж амь мэт нандигнан хадгалж явсан Монголын хувьсгалт залуучуудын эвлэлийн гишүүний улаан батлахаа өврөөсөө гаргаж шүдээрээ тас хазаж ураад, нэгэн бага шиг чулуун доогуур шургуудаад Тэгшээгийнхээс бүр ч том чулуу авчирч цээжин дороо хийж биеэ хөндий болгоод мөн гранатаа цэнэглэн бэлтгэж элгэн дороо хийгээд хэвтэв. Гиваан ч бас хоёр нөхөр шигээ бэлдэв. Тэр завсар Даваадорж, Гиваан хоёр өмнөөсөө ирж яваа дайсныг винтовоор буудсаар байжээ. Тасгийн дарга аа! Та нэг, хоёр гурав гэж тоолно шүү гэж хэлээд Тэгшээ амьдралынхаа хамгийн сүүлийн үлдсэн тэр ганц минутанд тэр аль хүсэлтэй сайхан зүйл болгоно оо бодож амжъя гэсэн шиг ямар нэгэн зүйлийг бодсон мэт дув дуугүй хэвтэж байв. Гөлрөн байгаа том алаг нүдэнд нь санаагий нь дагаж чухам ямар юм харагдаж байсныг одоо хэн ч мэдэхгүй.

“Болд хэрхэн хатаагдсан нь” гэдэг номыг бичсэн зохиолч Николай Островский бол, ялих ялихгүй гэр зуурын зовлон тоочиж бэрхшээлээс айн сүрддэг хар амиа бодсон хүмүүсийг үнэн голоосоо үзэн яддаг тийм хүн байсан юм. Нөхөд минь хүн гэдэг бол зөвхөн амьсгаа авч амьдрахын төдийхөн амьд явах ёстой биш, харин улс ард түмнийхээ төлөө бүх амь насаа зориулсан байх хэрэгтэй юм гэж Тэгшээ үргэлж нөхдөдөө ярьж хэлдэг байсан юм. Одоо тэр зүйлээ давтан бодсоор байгаа биз. Бид цөмөөр эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүллээ. Сайн биелүүлсэн, муу биелүүлсэн алин болохыг эх орон минь өөрөө дүгнэг! Бид бүх чадлаараа эцсийнхээ амьсгалыг дуустал түүндээ үнэнч байлаа. Одоо дайсанд амьд баригдахгүй юм шүү гэж дотроо бодож байжээ. Мөн Даваадорж нь Тэгшээтэйгээ нэгэн адил тэр үлдсэн ганц минут хүрэхгүй хугацаанд нэлээд их зүйлийг бодож амжжээ. Мянга есөн зуун дөчин таван оны зуны сарын тунгалаг сайхан тэр нэгэн өглөө цэрэгт мордох гээд эцгийнхээ хамт ой шугуй бүрхсэн өндөр уулын ёроолоор гараад сумын захиргаа тийш давхин явж байснаа санав. Тэгээд нас бие цэрэгт тэнцэж Хөвсгөл аймаг Бүрэн сумын захиргаан дээрээс мордоход нь эцэг Хиров нь хүүгээ үнсээд: За миний хүү ээлжит албандаа мэнд сайн яваад их эрдэм ном сурч ирээрэй! Улс түмнийхээ энх төвшин байдлыг чулуун багана мэт тулах хэрэгтэй. Хэрэв хэрэгтэй цаг тохиолдвол амиа бүү хайрла, Монгол ардын баатарлаг армийн ариун өндөр нэрийг бүү гутаа! гэж эцгийнх нь захиж байсан тэр үнэт үг сургаал санагдаж байжээ. Элгэн дороо цэнэглэсэн гранат хийгээд дайсныг хүлээн хэвтэж байгаа тэр гурван залуугийн хэн нь ч гэсэн үхэхийг ер хүсэхгүй нь мэдээжийн хэрэг. Тэр гурван залуугийн ард талд дуу хөгжмийн аль яруу сайхан болгон цуурайтсан инээдэм, баяр баясгалан, цэнгэл жаргалаар бялхан байдаг, хөгжин цэцэглэж байгаа хүслэнт сайхан эх орон нь бий. Шинэ эмээл хазаар төхөөрөөд цэргээс халагдаж ирэхий нь хүлээж байгаа эх эцэг, дүү амраг садан нь бий. Тэд бол амьдралынхаа аль сайн сайхны зах руу дөнгөж сая ороод явж байгаа хорин хоёр гуравхантай гал халуун залуучууд юм. Гэвч үхэх хэрэгтэй болоод байна. Тэгэхээс өөр зам алга. Ховд аймгийн Чандмань сумын ард эмгэн Цоохүүгээс эхлэн бүх эх Хөвсгөл аймгийн Бүрэн сумын ард өвгөн Хироваас эхлээд бүх эцэг тэднийхээ жаргалтай сайхан байдлыг хамгаалахын төлөө үхэх хэрэгтэй гэж өөрөө өөрийгөө шаардан тулгаж байгаа

хэрэг юм. Дайсны түрүүч нь бүр ойртож хорь гучаадхан метр хүрч иржээ. Тэдний цонхир цагаан царай, овгор малгайных нь паалантай дүгрэг тэмдгүүд бүр ч ялгаран танигдаж байв. Манай гурав дайсн руу анхааран харахаасаа илүү амьд баригдахгүй юм шүү гэдэг ганцхан зүйлийг бодоцгоож байжээ.

Ангидаа мэдээ хүргэж, туслах хүчин авчрахаар Пэлжээгийн явсан тэр зүгт хэн ч харсангүй. Одоо тэр зүгт харах юм бол бөөн тоос манаран байна. Тэр бол манай туслах хүчин ирж яваа хэрэг юм. Гэвч түүнийг хэн ч анхааран харсангүй. Харлаа ч гэсэн хүлээж болохгүй. Хэрэв тэгвэл хэрэг нэгэнт хожимдох болно гэгчийг манай гурав тодорхой мэдэж байжээ.

Дайсан бүр ойртоод түрүүч нь долоо наймхан метрт хүрээд иржээ. Тэд нөгөө Америк ноёныхоо бэлдэж өгсөн хүлгийн нарийхан олсыг бүснээсээ сугалан авцгааж байгаа харагдана. Тэгшээ, тасгийн дарга тийшээ харна. Тэгшээ уг нь их ширүүн харцтай хүн юм. Гэвч тэр удаа бүр ч аймаар ёстой нэг өд сөд нь гүйцээд жигүүр нь бөхөжсөн уулын хүрэн бүргэд өндгөө харамлан тулалдах гэж байгаа юм шиг харагдав. Гиваан, Тэгшээгийн тэр аймшигт харцнаас дальдарс хийгээд Нээг! гэж чанга тоолов. Дайсан бүр дэргэд нь тулаад иржээ. Гиваан хоёр! гэж тоолох гэснээ нөхдийгөө хайрлаад дөнгөж сонсогдох төдий, Хооёр! гэж тоолов. Тэгээд гурав гэдэг тоог хэлж чадсангүй, түүнийг хэлэх гэж хэчнээн их бодсон боловч хэл нь ер нугарч өгсөнгүй. Дайсан бүр тулаад түрүүч нь Даваадоржийн дэргэд ирж ямар нэгэн юм хэлээд хашхичиж байна. Хамгийн түрүүчийн хүн бөхийх шиг болов. Даваадорж тасгийн даргынхаа гурав гэж тоолохыг хүлээсэнгүй шууд винтовоо хошуун дээрээс нь шүүрч аваад гэв гэнэтхэн босон харайжээ. Тэгээд өөрийнхөө дэргэд хамгийн түрүүнд ирсэн дайсныг толгой дундуур нь цохиж унагав. Бас нэгийг цохив. Даваадоржид тархиа хага цохиулаад газар шурган унаж байгаа дайснууд үхлийн муухай дуугаар орлин бахирцгааж байна. Дахиад нэгийг цохих гэтэл араас нь гурван хүн нэгэн зэрэг ноцож хажуугаас нь хоёр хүн дайрч барилаа.

Даваадорж тэдэнтэй ноцолдож дээр дороо орон бужигнаж байв. Дайсан хойно хойноосоо нэмэгдэн ирж арав гаран хүн болов. Тэд Даваадоржийг дарж аваад хүлж эхлэв. Гэтэл Даваадоржийн өвөрт байсан гранат гэнэт писхийн дэлбэрч тэнд овоорон бөөгнөрч байсан арваад дайсн баргаараа устан сөнөжээ. Даваадоржийгоо дайсантай ноцолдож байхы нь харсан Тэгшээ босох гэж хэд дахин өндийгөөд босож чадсангүй шурган унав. Даваадоржийг гранатаа тэсэлж байгаа тэр үед гүнзгий жалгаас хориод хүн гарч Тэгшээ тийш дайрч түрүүчийн нь хүн дэргэд нь тулж ирэв. Тэгшээ, та яваа гэсэн бололтой тасгийн дарга тийшээ хараад мөн гранатаа тэслэв. Тэр үед газар тэнгэр хоёр дээр дороо орж эргэлдэх шиг болоод чих дүлийрэн шуугьж нүд эрээлжлэн харанхуйлав. Улайрсан дайсны үхээгүй үлдэгдлүүд Гивааны дэргэд хашхиралдан ирж бууны жадных нь сүүдэр Гивааны бие дээр тусаж: Үхэр Монгол чи битгий тэнэглээд бай, бос! гэжээ. Гиваан үүнийг энх тайвны талынхан сонсоцгоог гэсэн шиг гурваа! гэж аль байдаг чадлаараа хашхираад мөн элгэн дорх гранатаа тэслэв. Тэр дууг нээрээ ч тэдэнд хүргэе гэсэн шиг Байтагийн хавь ойрын уул хад нүргэлэн цуурайтаж байжээ.

Тэр үед Зо Пу Саны нөгөөх хөх байшинд ноён Жон, Зо Пу -Сан хоёр зэрэгдэн сууж хажуугийн тасалгаанд холбооны хүн Хау Ен -гийн ангитай

холбоо барьж зав чөлөөгүй ажиллаж байжээ. Баярласан хэрээ бархирна гэгчийн үлгэрээр Зо Пу -Сан хийх юмаа олж ядсан байдалтай байснаа босож очоод цоожий нь түлхэхэд хөгжим хангинадаг бичгийн гоёмсог төмөр шүүтээгээ онгойлгов. Түүн дотроос гоёмсог хатуу хавтастай зургийн альбом нэгийг гаргаж ирээд ноён Жонд өгчээ. Ноён Жон түүнийг авч хуудсууды нь эргүүлэн эхлэв. Цөм дээгүүр нь улаан харандаагаар чагтлан зурж хүчингүй болгосон хөгшин залуу олон хүний зураг байна. Тэр зургийн эзэд бол цөм үүний урьд Монгол улс руу явуулсан тагнуулчин, хорлон сүйтгэгч нар байжээ. Ноён Жон хуудсыг эргүүлэн үзэж байснаа гайхсан янзтай;

Тэгээд одоо энэ олон хүнээс чинь чухам хэн хэн нь Монголд ажиллаж байгаа юм бэ? гэсэнд Зо Пу -Сан нэг нь ч байхгүй гэжээ. Ноён Жон инээмсэглэлийн баг болсон нүүрнийхээ арьсыг үрчийлгэн ярвайлгаад: Яагаад тэр билээ, хайчсан юм бэ? гэж асуусанд Зо Пу Сан: Цөм баригдсан юм. Монголын хилийн цэрэг гэдэг чинь улаан хөлтэй юм урдуураа гаргадаггүй тийм айхавтар гайхалтай сүрхий чононууд байгаа юм гэсэнд, ноён Жон шүдээ зууж хэсэг дуугүй байснаа: Гайгүй тэд тэгж л байг! Бид тэр баларсан хуучин аргыг хэвээр нь үлдээхгүй. Тэр замхарсан арга бол өнгөрсөн Японы арга ажиллагаатай адил байсан дээрээс тэгж нурж унасан хэрэг байгаа юм. Бид одоо ёстой Америк аргаар ажиллана гэж хэлэх шахсанаа болиод цоо шинэ аргаар ажлаа өөрчлөн зохионо. Вашингтоны гар аль хэр урт болохыг манай нөгөө зарим аймтгай тэнэг ноёд үзэг гэж хэлчх шахсанаа, бидний гар ямар шүү хол хүрдгийг үзэг. Одоо бид Монголын хилийг зүүн талаас нь маажиж эхэлнэ. Монголчууд тэр талынхаа хамгаалалтыг сулаар анхаардаг болсон байх ёстой. Яагаад тэр вэ? гэвэл чөлөөлөгдсөн Хятадын талыг тэд итгээд хяналт нь суларсан байх ёстой гэсэнд Зо Пу -Сан халзан толгойгоо сэгсэрч: Ноён гуай! Намайг санахад харин улам хэцүү болсон шиг бодогдож байна гэсэнд ноён Жон: Яагаад тэр вэ? гэсэнд Зо Пу Сан: Бид урьд Монголын цэрэг гэдэг ганцхан давааг дайна гэж санадаг байсан бол одоо чөлөөлөгдсөн Хятадын улаантан гэдэг бас нэг яггүй даваа нэмэгдээд байна шүү дээ гэсэнд ноён Жон: Тэд одоохондоо гэнэдэж болохоор нялх балчир байх ёстой. Бид тэднийг гэнэдүүлэн мэхэлж чадна гэх зэргээр дур мэдэн донгосож байтал хаалга цохиж холбооны хүн орж иржээ. Дорд тушаалтнаа хараад бүх насандаа инээж ер үзээгүй тэр ноён юу болоо юм бол энэ удаа үл мэдэг инээмсэглэсэн байдлаар холбоочин тийш харж:

— За ямар мэдээ байна? гэсэнд холбоочин урагш хоёр алхаж дөхөөд гөлөлзөн: Манайхан ерэн зургаан хүнээ алуулах, шархдуулах зэргээр гарздаад одоо яаж ч чадахгүй болоод ухарч эхэлсэн гэнэ. Монгол цэргийн эсэргүүцэл тун сүрхий, буурахгүй байгаагаар үл барам харин ар талаас нь нэмэгдэл хүчин ирж яваа гэнэ гэсэнд ноён Жон: Тэд тэгээд Монгол цэргээс хэчнээн хүн барьсан гэнэ вэ гэсэнд, холбоочин: Нэг ч хүн барьж чадсангүй гэнэ. Хүн барих нь байтугай ноён Хау Ен гуай өөрөө хүртэл гэдсээрээ хүнд шархадсан гэж байна. Бас тэгээд Хау Ен гуай танд ингэж айлтгаарай! гэж байна. Юу гэж? Монголын хилийг дав! гэж явуулдаг чинь шууд авсандаа ор гэсэн үг байна. Түүнийг чинь би сайн мэдлээ. Энд чам шиг тэнэг амьтан нэг ч алга байна гэдгийг тэр цаад тэнэг мангуу ноён шиг юмандаа хэл! Би чамтай амьд уулзаж чадахгүй нь мэдээжийн хэрэг гэж айлтгаж байна гэсэнд ноён Жон нөгөө

хуурамч инээмсэглэлээ алга болгоод галзуурсан амьтан шиг босон харайж холбоочныг хамраас нь цус садартал алгадаад нөгөө хатуу хавтастай альбомоороо Зо Пу Саны халзан толгой дундуур хоёр дахин татаад:

Муусайн хар малууд, дээлийн гол, хоолны сав болсон хар нохойнууд гэж аль мэддэг чаддаг хараал болгоно оо хэлээд боож үхэж байгаа амьтан шиг хоолойгоо шахан хашхичин дэвхцэж байжээ. Тэр үед Хау Ен -гийн ангийн үлдэгдэл сандран ухарч байна. Ноён Хау Ен нөгөө хайртай тахир цагаан сэлмээ хаа хаясан юм бол оосор нь тас буудагдаад алга болсон байна.

Түүгээр барахгүй өөрөө хүнд шархдаж ухаантай ухаангүй нэг юм машины кабинд суусан хэвтсэн хоёрын хооронд явж байна. Монгол цэргээс офицер барьж ирвэл толгойных нь хэмжээгээр алт өгнө. Цэрэг барьж ирэх юм бол мөн толгойны нь хэмжээгээр мөнгө өгнө гэж амласан, нөгөө Америк түншийнхээ шагналыг авах нь байтугай, түүнтэй амьд уулзахын горьдлого тасарчээ. Гэдсээрээ шархадсан амьтан од түгж гүйцэх дээр үхдэг юм гэнэ билээ. Би чухам хэдийд үхэх юм бол гэж бодсоор явж байна.

Монголын хилчдээс баригдсан хүмүүсийг ачиж буцна гэсэн нөгөө айхавтар сүрхий бэлдэж ирсэн төмөр мухлагтай машинууд одоо харин өөрийнхөө алагдсан шархадсан хүүрнүүдээ пиг дүүрэн чихэж аваад яаран сандарч ухран зугтаж явах нь шившигтэй харагдана. Тэр цэргүүдийг эргэн харахад нь цаст өндөр Алтайн сүрлэг уулс үдийн наранд улам өнгө орон гялалзаж, их санаа санаж ирээд шившигтэй муухайгаар бут цохигдоод ухаан жолоогүй зугтан буцаж яваагийг нь элэглэн шоолж байгаа юм шиг харагдаж байжээ.

Мянга есөн зуун дөчин найман оны долоодугаар сарын наймны өдөр Бүдүүн Харгайтад болсон тэр явдлаас хойш нэлээд хэд хоног өнгөрчээ. Дарга нарын гэр бүлийнхнийг оролцуулан тоолохгүй юм бол дандаа нэгэн жигд ижилхэн хувцастай хилчдээс өөр хүн амьтан арвитай үзэгддэггүй, ер нь хөл үймээн багатай юм шиг байдаг ахмад Майдрагийн сумангийн төв энэ өдөр ямар нэгэн зочин ирсэн бололтой тун их хөл хөгжөөнтэй байна.

Тэнд нээрээ ч айлчин иржээ. Ирэх, ирэхдээ нийслэл Улаанбаатар хотоос Улсын төв театрын жүжигчид, зурагчин, кино авагчид, сонин сурвалжлагч зэрэг олон хүн ирсэн байна. Кино авагчид “Арван баатар” гэдэг зураг авна гээд том жижиг олон авдар хайрцагтай юмаа задалж их бага янз бүрийн элдэв олон аппарат хэрэгсэл гарган арчин цэвэрлэж угсран залгаж байжээ. Өргөн хүрээтэй бөмбөгөр зузаан шил нүдэндээ зүүсэн, ширвээ хар сахалтай найруулагч нь тэр киноны тийм ийм хэсгийн тэнд, энд тэгж ингэж авна гэх зэрэг их яриа хөөрөө болж байна.

Мөн зураач ч гэсэн тэднээсээ хожимдохгүй жаазтай цагаан даавуугаа дэлгээд будаг бийрээ бэлдэж хилчдийн амьдралыг ажиглан сонирхож байна. Сумангийн төвийн зай багатайхан клуб пиг дүүрэн хүнтэй байна. Киноны гол дүрд тоглох гэж байгаа жүжигчид хилчдээс зөвлөгөө авахаар дасгал хийж үзүүлэн байна.

Тэр жүжигчид хилчдийн амьдралыг гарамгай судалсан хүмүүс юм. Хилчид тэднийг бахдан сайшааж нижигнэтэл алга ташиж байна. Хилчдийг тэндээс тараад гадаа гарах үед яг нар жаргаж байна. Хүмүүсийг дөнгөж байрандаа ороод байтал ахмад Майдрагийн шүгэл дуугарчээ. Шүглийн тэр

дуу тэр нэгэн шөнө дэд хурандаа Зонровыг ирэхэд жагсаж байсан явдлыг санагдуулж байна.

Хилчид тэр шөнийх шиг байраа эзлээд хориглон хэвтсэнгүй, харин жагсах шугамандаа очиж зогсжээ. Ноомхон! гэж Майдраг командлав.

Тэгээд цэргийн дансанд үүрд явах ёстой, хүндэт хүмүүсийн нэрсийг дуудах ёстой болжээ. Майдраг чичирхийлсэн хоолойгоор: Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар хилчин Тэгшээ! гэж дуудав. Жагсаалын эхэнд туг барин зогсож байсан нэг залуу хилчин цовоо чанга дуугаар: Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар хилчин Тэгшээ улсынхаа энх тайван байдлыг сахин хамгаалах их хэргийн төлөө амь үрэгдсэн! гэж хариулав.

Майдрагийн хоолой улам чичирч: Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар хилчин Даваадорж гэж дуудав. Туг барьсан нөгөө залуу улам сүртэй чангаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар хилчин Даваадорж улсынхаа энх тайван байдлыг хамгаалах ариун их хэргийн төлөө амь үрэгдсэн гэж хариулав. Тэр үед Майдрагийн сэтгэлд өргөн зузаан цээжтэй, пагдгар намхан нуруутай Тэгшээ нь амьд байгаа юм шиг, харин байх байхдаа тэр жагсаалынхаа хамгийн эхэнд хөнгөн пулемётоо бариад зогсож байх шиг санагджээ. Түүний махлаг тарган нүүр, ширүүн хурц харцтай том алаг нүд нь дүрэлзэн харж байх шиг бодогдож байна. Тэгээд зогсож байгаа Тэгшээгийн зүүн гар талд нь нөгөөх зөөлөн намуухан дуутай, олон таван үггүй өндөр нуруутай Даваадорж, мөн л винтовоо бариад зогсож байх шиг санагдан жагсаалын эхэнд туг бариад зогсож байгаа тэр залуу яг л Тэгшээ шиг харагдаж дуу болоод бүх байдлаараа тун адилхан санагдав.

Тэр сэтгэл хөдлөм байдлыг хараад зогсож байсан төвийн сонин сурвалжлагч тэр оройн тооллогын ёслолтыг гүйцэд хүлээж чадсангүй, гүйн гүйсээр явж буусан байрандаа ороод тэмдэглэлийнхээ дэвтрийг дэлгэж “Баруун хязгаарт” гэж гарчиг тавиад сэтгэлд нь хойно хойноосоо овоорон бууж байгаа зүйлийг мартчихаасаа өмнө тэмдэглэн авч амжъя гэсэн шиг яаран яаран бичиж байжээ. Тэр үед Тэгшээ, Даваадорж, Гиваан гурвын баатарлагаар байлдаж байсан яг тэр тэмдэгт газар дээр одоо зөвхөн гурван манаа биш, харин бүхэл бүтэн анги байрлаад, тэр ангийн байрын манаанд таван хүн гарч улсынхаа дархан хилийн манаанд зогсож байна.

Нар баруун уулын цаагуур ороод, үдшийн тэнгэрт сувдан өнгөт од ганц нэг үзэгдэн хээр талын жавхлант дуучин болсон бор шувуунууд цэнгэлтэй зунаа магтан жиргэж, гоминданы ноён Зо Пу Сан, Америк ноён Жон хоёрын хэлж чадахгүй мунгинаад “Бүдүүн Халгайт” гэж хазгай дуудаж байсан, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зурагт нутаг “Бүдүүн Харгайтын” гол Тэгшээ, Даваадорж нарын байсан тэр үеийн хэвээр шаагин урсаж байгаагаас өөр чимээ аниргүй нам тайван байна. Манааны хүмүүс үүр цайхыг хүсэн хүлээж байна. Хүлээх хүлээхдээ бүх дэлхийн бөмбөрцгийн тив бүхэнд эв найрамдал, энх тайвны үүр цайж гүйцээд “коммунизмын” гэгээн наран төгс мандах цагийг хүртэл манааныхаа тэр байранд бэлхэн зогсох болно.

1949—1950

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураингуйлан бичнэ үү?

2. Зохиолын агуулга, үзэл санааны ач холбогдлын тодорхойлон бичнэ үү?
3. “тусгаар тогтнолын үнэ цэн” сэдвээр эсээ бичнэ үү? /үгийн тоо 250 хүртэл/

Багын явдал

III. Гаадамба

Би

-Энэ чинь хэн бэ? Янжингийн “Босоо ороолон” мөн шив дээ!

-Юун “Босоо ороолон” гэж!. . энэ чинь гавьяат жүжигчин Төмөрсүх шүү дээ.

-Тэгвэл энэ маань бүр хүн болчоо шив дээ!

-Хүн болохгүй юу болох ёстой байсан юм?

-Чи мэдэхгүй ээ! Хүн боломгүй хачин зүггүй гайхал байсан юм!

/Бүжгийн жүжиг үзэгчдийн ярианаас/

Нээрэн ч та нар миний багын явдлыг мэдэхгүй байх. Би ийм жаал байсан юм.

Намайг Төмөрсүх гэнэ. Янжингийн “Босоо ороолон” ч гэнэ. Бас “Ийрэл саарал” ч гэнэ.

Төмөрсүх гэдэг нь манай нагац өвөөгийн өгсөн нэр гэж ээж хэлдэг юм. Өндөр өвөө надад яагаад тийм нэр өгснийг мэдэхгүй. Манай том сүх огт иргүй мөлгөр мөртөө түлээ хагалахад их сайн даадаг зузаан төмөр сүх байсан юм. Бодвол намайг төрөөд өлгийтэй хэвтэж байхад өвөө надад нэр өгөх гээд ийш тийш хартал манай том сүх нүдэнд нь тусаад надад Төмөрсүх гэдэг нэр өгсөн болов уу.

Янжингийн “Босоо ороолон” гэдэг нэр хэн өгснийг бүү мэд! Хамар хашааны Дондог өвгөн л өгсөн байж магадгүй юм. Тэр өвгөн намайг дандаа л тэгж нэрлэдэг байсан сан. “Босоо ороолон” гэж чухам юу байдгийг би мэдэхгүй боловч энэ үг “тамтаггүй зүггүй жаал” гэсэн утгатай томчуулын этгээд хачин үгийн нэг байх.

“Ийрэл саарал” гэдэг нь Буянт гуайн ус зөөдөг илжгийг хэлж байгаа юм. Миний хувьд бол энэ үг “дэлдэн” гэсэн өөр утгатай. Чих минь тийм болсонд үнэндээ чихний булаг өвчин, ээжийн эмчилгээ хоёр буруутай. Тэр уршигтай өвчнийг хөдлөхөөр ээж “булгийг чинь цэвэрлэнэ, хулхий чинь авна” гэж чихнээс минь татсаар байгаад дэрчгэр болгосон юм. Гэтэл манай гудамжны сэмхэн Гонгор гэдэг жаал энэ нарийн учир зовлонгий минь мэдэлгүй намайг уулаасаа усчин Буянт гуайн саарал илжиг шиг дэлдэн чихтэй төрсөн гэж тэнэглээд тэгж хочилсон юм.

Товчилбол, би түлээний сүхний нэртэй, дэрчгэр хөх жаал байжээ. “Балчир хүүхэд өдөртөө жаран чавганцын ажил хийдэг” гэж манай өвөө хэлдэг байсан. Би лав зуун хорин чавганцын ажилтай жаал байсан юм байх. Юу гэвэл намайг “Тун ч зүгээр байж чаддаггүй зүггүй жаал” гэж тун олон хүн ад үздэг байсан юм. Ямар хүн наад зах нь урд, хойд, баруун, зүүн гэж дөрвөн зүг байхад тэр зүгнүүд надад яагаад байдаггүй юм бол гэж би гайхдаг сан. Нэг

үгээр хэлэхэд би тэсгэлгүй их хөдөлгөөнтэй хүүхэд байлаа. Тун нэг зүгээр байя гэж бодсон ч зарим нь өдөөд байхаар дороос хатгасан юм шиг, нэг мэдэхэд л дүрсгүйтчихсэн байдаг байж билээ.

Зуны цагт бол би богино шуудаг өмднөөс өөр юм өмсдөггүй байв. Өвөл бол энд тэндээ үс нь халцарсан хуучин хүрэн савхин цэгээх малгай, хөвөнтэй хүрэм, даалимбан шировар дор, үстэй өмд голцуу өмсөнө. Бухаар гутлын түрийд залгаж хийсэн буриад сөөхий гутал юм уу, эсвэл эсгий гуталд калоош углаж өмсдөг байсан юм. Ийм л жаал байж дээ.

Манайх

Хорин жилийн өмнө “Тавын халуун усны” урдах хэдэн гудамж, хэсэг хашаа хотын урд зах болж байлаа. Тэр хэсэг хашааны зүүн үзүүрт Сэлбэ голын зүг харсан мухар гудамж юм уу доголын зүүн үзүүрийн хойшоо харсан хаалгатай хашаанд манайх байлаа

Хаалганаас эхлээд хашааны зүүн талаар үнээний саравчтай. Тэр саравчны сарампай модон дээвэр дээр өвс хураана. Хаалганаас баруун тийш хоёр пүнз байсны нэгд нь үүц хоол хийж, нөгөөд нь зуны бүрээсээ хураадаг юм.

Хоёр пүнзний өмнө том таван ханат гэр бий. Гэр дотор орохоор зүүн баруун хоёр талд нь төмөр ор, хоймор эгчийн (хүүхдийн) ор, түүний толгой талд хоёр авдар, хөл талд нь налуу оройтой хувцасны бяцхан шүүгээ бий. Ээжийн орны хөлд аяга савны шүүгээ, өвөөгийн (баруун) орны хөлд угаагуур бий. Шалавчин дээр сайхан ширдэг, хоймор бяцхан хуучин хивс дэвсээтэй. Зуухны ард аяга халбага хийх шургуулгатай шалны өр (ширээ) бий. Энэ бол манай хоол идэх газар, бас эгч бид хоёрын хичээл давтах (үүнээс болж заримдаа хэрэлдэж зодолдох) ширээ билээ.

Өвөөг та нар ямар хүн гэж санана. Партизан хүн шүү. Шингэн живэр, урт ооч сахалтай өндөөр гэгчийн өвгөн байсан. Ээж минь босоо нүдтэй, уртавтар царайтай, туранхайвтар бор авгай юм. Дэлгүүрт худалдагч хийдэг.

Манайх хоёр үнээ, гурван бяруутай. Таван жилийн урьд сургуульд орохоосоо өмнө би үхрээ хариулдаг байсан. Тэгэхлээрээ би бас ч “ажилтай” малчин хүү байжээ.

Үхрээ яаж хариулдаг байсны минь та нар сонирхож байна уу? Би өглөө үхрээ тууж гараад Сэлбийг уруудуулан жаахан явж гэрлийн хорооны баруун зүлгэнд хүрнэ. Тэнд гурван бяруугаа урт олсоор утасны модноос аргамжиж орхино. Тэгээд хоёр үнээгээ “Битгий салаад явчаарай” гэж зандчаад сүүлний нь үзүүрийг зангидаж холбоод Дунд гол гаргаад туучдаг байсан юм. Өөрөө?

Өөрөө нэг бол задгай гэрээр буусан хэсэг Казак айлаар хэсэж адууны мах иднэ. Эсвэл хээр ажил хийж байгаа төмөр замын Оросууд дээр очиж талх хиам өгөхөөр нь авч гэдсээ базааж аваад хонхорт нуусан модон чаргаараа гулгаж өдөржин ганцаараа тоглоно.

Намайг та нар аавгүй хүүхэд гэж санаж байна уу? Тийм биш шүү. Миний аав, тэр битгий хэл, цэргийн дарга хүн байдаг юм. Харин аав манайд ирэхгүй болсоор удсан болохоор би түүнийг мартаад гэрийнхээ хүний тооноос хасаад ярьчих гээд байдаг юм.

Хамар хашааны хун

1951 оны намар юмсан. Нэг зэврүүн өдөр ээж өглөө эрт ажилдаа (Тэр үед ээж 18 дугаар дэлгүүрт худалдагч хийж байсан юм) явж ирээд:

-Төмөрсүх ээ, гар! Мод хагал! гэв.

Эгч пионерийн ажилтай гээд явчихсан. Өвөө гэртээ алга байлаа. Тийм болохоор би хатавчнаас том сүхээ аваад, аргагүй, түлээ хагалахаар гарлаа.

Пүнзний баруун буланд богинохон хөрөөдсөн том хэрчим босгож тавиад бяр нэмэх гэж хөвөнтэй бээлийтэй гарынхаа алганд нулимс хэд үрээд том сүхээ далайж:

-Төмөрсүх-ээ мод хагал! гэж ээжийг дуурайж хэлээд, мод хагалж эхлэв. Нэг хэрчим хагалаад, дахиад нэгийг босгож, том сүхээ далайх гэтэл “Би Төмөрсүх. Энэ том сүх бас л төмөр сүх юм. Тэгэхлээр энэ бид хоёрын хэн нь мод хагалж байгаа юм бол!” гэж гайхав. Тэгээд сүхээ хэрчим дээр ирээр нь тавьж:

-Том сүхээ мод хагал! гэж тушаал өглөө. Сүх яах ч үгүй хэвээрээ л байна. Хэрчим хагарахгүй юм. Тэгэхлээр нь би сүхээ авч пүнз түшүүлж тавиад:

-Төмөрсүх-ээ мод хагал! гэж өөртөө тушаал өглөө. Сүхгүй болохоор хэрчим бас хагарахгүй зүгээр л байх юм.

Дахиад би том сүхээ барьж аваад далайж далайж цохисон чинь хэрчим ан гарлаа. Том сүх, Төмөрсүх хоёулаа л түлээ хагалж байгаа юм байна. Ийм сонин юм мэдэж аваад том сүхээ далайж:

-Төмөрсүх-ээ, мод хагал! гэж өөртөө болон том сүхэндээ тушаал өгөөд далайтал баруун хашааны завсраар:

-Хи хи-хи! гэж хүүхэд инээх сонсодлоо.

-Эргэж хашааны завсраар хартал баруун хашааны Гонгор гэдэг жаал ам хамраа мурийлгаж, хэлээ гаргаад:

-Чи ганцаараа яриад галзуурч байгаа юм уу? хи-хи-хи гэж дооглож гарав.

Би эргэж нэг нарийхан хагадас аваад хашааны завсраар чичтэл Гонгор амжаад зайлчихлаа. Тэгэхлээр нь би хураалттай түлээн дээр гарч, хашаан дээгүүр өнөөх хагадсаараа шидсэн чинь жаал бултаж зайлаад хагадсыг минь авч хэлээ гарган дооглож:

-Чи онох уу даа. Чи онох уу даа! Дахиад модоор шид л дээ! гэж миний хорьг маажив. Модоор шидүүлж түлээнээс маань авах санаатай байгаагийг нь би мэдээд орхилоо. Тэгээд би үнээний саравч руу гүйлээ. Тэндээс үхрийн нойтон баас түмпэнд хийж ирээд хураалттай түлээн дээр гарч ирлээ.

Гонгор гэрийнхээ хаалганы цаагуур бултганан:

-Чи муу онох уу даа! Онох уу даа! гэж хэлээ гарган дооглосоор л байна. Би үхрийн нойтон баас бөөрөнхийлж бариад, тэр жаалыг онохыг хичээж, хэд хэд худлаа зангаж байгаад шидэж орхилоо.

Гай болж энэ үеэр Гонгорын өвөө нахиу Дондог гуай гэрээсээ гараад ирсэн юм байжээ. Түүний нахиу хамартай улцгар шар нүүрэн дээр үхрийн баас нялчихлаа. Би түргэн доошоо нуугдсан боловч Дондог гуай ч намайг харчихжээ.

-Янжингийн муу босоо ороолон! Чамайг даа! гэж занаад эргээд гэртээ орлоо. Бодвол нүүрээ угааж арчих гэсэн бололтой.

Гонгор одоо хашааны дэргэд ирээд:

-Өвөө чамайг ээжид чинь хэлээд зодуулна даа! Еэ болж, еэ болж гэж тавлаж байна. Би түүний үгэнд бат итгэж байлаа.

Энэ өвгөн үнэхээр манайд орж ирэх болгондоо “танай босоо ороолон тэнд тэгж ингэж үймүүлж явна!” гэж ээжид дандаа ховлож байдаг юм. Би түүний энэ илүү зантайг их л зэвүүцэн жигшдэг тулд нүүрий нь санамсаргүй баасадсандаа баярлаж байх боловч удаагүй манайд орж ирээд ээжид ховлоно гэж бодоод айж байлаа.

Хагалсан модоо ээжид оруулж өгөөд, ээжийг гэрээс гарах зуур гараад явчихсан хүн болж хаалгаа худлаа дуугаргаж тав хийлгээд, зүүн орон доогуур ороод нуугдаж орхилоо. Ээж орж ирээд намайг гараад явчихсан гэж санав бололтой, ийш тийш харснаа гаднаас оруулж ирсэн сүүгээрээ цайгаа сүлж байна.

Хаалга цохих дуулдлаа. “Дондог гуай намайг муулахаар ирлээ!” гэж би бодож хэвтэв. Ээж намайг гадаа байгаа гэж бодоод

-Төмөрсүх-ээ үүд тайлж өг! гэж хашхирч байна. “Дондог гуай намайг ховлох гэж ирж байхад би яалаа гэж үүд тайлж өгөх вэ дээ” гэж бодоод дуугүй л хэвтээд байлаа. Хаалга чанга чанга цохиод л байна.

Удалгүй ээж өөрөө гарч, хаалга тайлж өгөөд, Дондог гуайтай хоёулаа орж ирлээ. Тэр нахиу хамартай, чинжүү шиг зууван нүүртэй, улцгар шар өвгөн манайд орж ирэх бүрдээ суудаг зангаараа миний нуугдаж байгаа зүүн орны урд зуухны хүхээний дэрдэд ирээд, лаг хийтэл бохироод суучихлаа.

Ширдэг дээгүүр нэлмийн дэвссэн, хөвөнтэй дээлийн нь хормой дороос Монгол гутлын хоёр ул авдрын ивээс шиг цухуйж харагдана. Тэгэхдээ өсгийгөө өгзөг дороо нийлүүлээд, өлмийгөө хоёр тийш нь харуулаад ивээд суучихдаг гайхалтай өвгөн байгаа юм. Би нэг удаа энэ өвгөнийг дуурайж бохирч суух гээд золтой л шагайгаа мулталчаагүй билээ. Дондог гуайн ганцхан сонин эрдэм нь майга хөлөөрөө ингэж хачин бохирч сууж чаддаг нь юм.

Мөнгөн сэтгүүр төмөр цохилуур жингэнэх нь сонсодлоо. Дондог гуай том цагаан соруултай гансаа гаргаад тамхиа нэрж байгаа ажээ. Тэр өвгөн хацраа хонхолзуулан тамхиа татдаг юм. Ээж цай хийж өглөө.

-За Янжин минь, муу ах чинь танай энэ босоо ороолонгоос ч нэгмөсөн болох нь дээ гэж өвгөн намайг ховлож эхэллээ.

-Дондог гуай минь, цаад гайхал чинь бас яачсан бэ? гэж ээж зовнисон дуугаар асууж байна.

-Яах юу байх вэ! Өнөөдөр би сэрүүнд хэдэн боорцог шуу юм буцалгаад халуун тостой хувин бариад гэрээс гарч иртэл... байдаггүй шүү... Босоо ороолон чинь харин үхрийн нялцгай баасаар нүүрэн дундуур өгчилгөж орхилоо!

-Ишш яанаа? Нүүр амыг чинь булзалж орхио биз дээ! гэж ээж сандарч байна.

Би орон дороос “хар худалч!” гэж хашхирах шахсан боловч нуугдаж байгаагаа гэнэт санаад амаа алгаараа таглалаа.

-Булзарсан ч гайгүй л дээ. Тэгээд өнөө үхрийн баас чинь жаахан хашин тосыг минь бузарлаж орхилоо. Үгүй ер ийм ороолон гэж байх уу Янжин минь!

-Юу хэлэх вэ, юу хэлэх вэ! Манайд хашин тос бий. Та аваарай. Би цаад новшийг чинь өнөөдөр нэг турсгыг нь хуулчхъя! гэж ээж амлаж байна.

Дондог гуай:

-Ээ дээ турсгыг нь хуулж ханашгүй хүүхэд дээ! Ээ дээ, танай энэ хүн болохгүй шүү! Яасан ч хүн болохгүй, шоронгийн тав л болно! гэж байна.

“Шоронгийн тав” гэж юу байдаг юм бол? Нэг л аймаар юм байдаг байх! гэж би гайхан бодохын хамт Дондог гуайд гэнэт уур хүрээд явчлаа.

“Би ямар энэ өвгөнийг шидэх гэж шидсэн биш. Жаал нь дооглоод байхаар л шидсэн болохоос... Бас хувинтай тос бариад гарч ирсэн гэж хүн гүжирдээд байгаа юм. Яаж нэг энэ өвгөнийг чадъя даа!” гэж ийш тийшээ харлаа.

Ашгүй, орны ширгүүний тэндэх хөшигт зүү утас хатгаастай харагдлаа. Эгчийн захаа хаддаг утас зүү нь мөн байна.

Би орон доогуур сэмхэн мөлхөж гараа дээш явуулан, зүү утсыг аваад, өвгөний хормойг ширдэгтэй шидэж гарлаа. Зүрх түг түг түгшиж байна. Өвгөн тамхиа татаад цай уугаад суугаад л байна. Манайхаас боовны тос авах болсондоо тайтгарсан бололтой. Би хормойг нь ширдэгтэй шидэж дуусаад гарч зугтаахаар зэхээд байлаа.

Адаг сүүлд нь өвгөнийг:

-За харьж үзье гээд босохоор гараа газар тулахыг хармагц би орон дороос год үсрэн гарч зугтаалаа. Өвгөн ойчиж, ээж дуу алдах чимээ миний араас дуулдсан юм. Би хашааны хаалгаар сум шиг харван гартал эгчтэй мөргөлдөж орхив. Эгчийг гэдэс рүү нь мөргөж унагаачаад би цаашаа жирийлээ.

Дондог гуайг юм дайрчихлаа гэж ээж анх сандарсан юм санжээ. Дараа нь орны төмөрт дээлээ гогодож дээ гэж санажээ. Адаг сүүлд нь ширдэгтэй оёсон хормойгийг нь хараад, миний ажил гэж сая л мэдэж, миний төлөөнөөс ичиж “үхэх” шахсан гэж хүнд ярьж байхы нь би хожим сонссон юм.

Тэр үдэш ээж намайг барьж, үнээний саравчны шонгоос уяж байгаад нарийн сураар ороолгосон юм. Би хоёр хоног босож ч чадахгүй, сууж ч чадахгүй зовж билээ.

Ингэж би сэмхэн Гонгор гэдэг гайтай жаалаас болж “арьсаа хуулуулсан” юм.

Хорины улаан булан

Хорины улаан булан манай догол гудамжны мухарт зүүн тийшээ харсан том жижиг хоёр хаалгатай хашаанд байсан юм.

Улаан булан гээд цагаан байшин байдаг нь сонин шүү. Яагаад цагаан байшин байтал улаан гэж нэрлэж байгаа юм? гэж санагддаг сан.

Улаан булан бол том хүмүүсийн хуралддаг, төдий л сонирхолтой биш газар гэж би багадаа боддог байлаа. Тэр үед томцуулын хуралдах гэдэг их гайхмаар ажил шиг санагддаг сан. Манай хорины өвгөн эмгэн голдуу настай улс нэг их сонин хачин юм үзэх гэж байгаа юм шиг тал талаасаа цуглаад ирдэг юм. Тэгээд л нам чимээгүй сууцгаадаг юм. Нэг юм уу заримдаа хэдэн хүн урд нь гараад суучихна. Тэгснээ тэдний нэг нь босож ирээд нөгөө улсыг чинь загнаад байх шиг санагддаг сан. Мөн ч балчир байж дээ.

Гэвч улаан булан заримдаа хүүхэд бидний сэтгэлийг хамгийн их татсан сонин сайхан газар болж хувирдаг юм. Яагаад гэвэл тэнд хааяа кино гардаг юм. Кинонд хүүхдүүд хэчнээн дуртай байдгийг та нар мэднэ. Харин улаан булангийн эрхлэгч Лхам гуай үүнийг тун ойлгодоггүй хачин хүн сэн. Бүтэн сайн өдөр өдрийн цагаар кино гарвал биднийг оруулдаг юм. Харин бусад өдөр оройн цагаар кино гарвал биднийг яасан ч оруулдаггүй билээ. Үдэш кино гарах бүрд л тэр бүдүүн авгай улаан булангийн хаалган дээр баймгай хад шиг зогсчоод л богинохон бэлцгэр хуруутай гараараа биднийг зад түлхэж

-Та нар яасан задарсан дэггүй хүүхдүүд вэ. Шөнө болсон хойно кино үзэх гэж томцуултай цуг дайраад байхдаа ичихгүй юу? Шөнийн кинонд хүүхэд оруулахгүй гээд байна шүү! Явцгаа, харьж унтацгаа гээд хангинадаг сан.

Тэр авгай ер нь биднийг согтуу хүн шиг л их нойртой улс гэж боддог шиг байдаг юм. Кино гарч хөгжим хангинан буу пижигнэж байсан ч сэрэхгүй л хурхираад байх улс гэж боддог байх.

Томчуул кино үзэхдээ өврөө уудалж мөнгө гаргаад билет гэж нарийхан цаас худалдаж аваад ордог юм. Тэгсэн байтлаа кино гаргаад өнгөрөхөөр өнөөхийгөө шал хэрэггүй хог новш шиг хаа ч хамаагүй базаад хумхиад хаячихыг нь яана? Аав ээж маань тийм хэрэггүй цаас худалдаж авах мөнгө бидэнд тэр бүр өгөхгүй нь хясаатай. Өгсөн ч бидэнд өнөөх билетээ бас худалдахгүй. Бидний жигтэйхэн сонирхож байгаа юманд маань оруулахгүй болохоор бид бүр гайхаш барагддаг сан. Кинонд хамаагүй оруулах том хүн бушуухан болох сон гэж мөн ч их хүсдэг сэн.

Түрүүчийн сайн өдөр кино гарахад манай гудамжны хүүхдүүд кинонд орох маш сонин арга олсон байлаа. Үүнийг манай хамар хашааны өнөөх зэвүүн жаал Гонгор санаачилсан юм. Бодвол тэр том хүүхдүүдээс сэмхэн олж мэдсэн бололтой.

Бид гурав дөрвөн хүүхэд аанай л Лхам гуайн дэргэд тулж очоод хад мөргөсөн юм шиг зогсож байлаа. Тэгтэл сэмхэн Гонгор намайг араас угзчин дуудаж, хаалганаас холдуулан, цонхны дэргэд аваачив. Тэр жаал:

-Би кино үзэх ийм сонин билет хийсэн юм. Чи хараач! гэж нэг юм алган дээрээ тавьж цонхны гэрэлд харуулж байна. Харсан чинь сүлбээр зүүний үзүүрийг матаж хийсэн төмөр дэгээ байх бөгөөд түүний битүү гогцоотой талаас урт утас уяж, хэд нугалан зангидсан байна. Би ийм хачин билетээр яаж кинонд ордгийг бодож олж чадахгүй байтал Гонгор онигор нүдээ зальтайгаар инээмсэглэж дундаа зайтай үүдэн шүдээ гаргаж ярзайлгаад чихэнд шивнэж учрыг тайлбарлав.

-Найзаа тэгээд өнөөдөр чи энэ дэгээг бариад миний хэлснээр биднийг кинонд оруулчх. Дараагийн кино гарахад өвгөн чинь дэгээ бариад чамайг кинонд оруулна гэж намайг гуйж байна.

Би түүний энэ аргыг сонирхож туршиж үзэх сэн гэхээс гар хуруу загатнаж байсан тул түүний гайгаар “арьсаа хуулуулснаа” ч мартаж орхиод “Тэгье” гэж гар барин тохиролцлоо.

Би Гонгорын заасан ёсоор өнөөх дэгээг барьж утсыг тайлж сунгаад улаан булангийн гадагшаа нээгддэг хаалганы ард орж нуугдлаа. Гонгор нөхдийнхөө хамт Лхам гуайн урд хоригдож байна. Би хаалган доогуур сэмхэн

гараа явуулж Лхам гуайн дээлийн хормойноос дэгээгээр гогодож аваад утсыг сунган байшингийн ёроолоор гүйж нэлээд холдоод угзчиж гарлаа.

-Хүүе хэн бэ? Болиоч гэм! Хүний хормой хотноос угзчаад яаж байгаа юм гэж Лхам гуай гайхан хаалганы ар луу өнгийж харж байгаа нь харагдлаа. Би татахаа бользноод, эргэх гэхлээр нь дахиад татлаа.

-Үгүй энэ чинь одоо юу вэ? Та минь! гээд их гайхсан Лхам гуай хаалганы араар тойрч үзэж байгаа харагдав.

Үүдэнд тулаад Лхам гуайд хоригдож түлхүүлж байсан хүүхдүүд олон хүний дундуур сүлжээд хэдийн кинонд орчихсон байна. Би утсаа хаячаад сэмхэн очиж Лхам гуайн хормойноос дэгээгээ салгаж авлаа. Тэгээд намайг хаалганд хүрч очиход хүн бараг орж гүйцсэн байлаа.

Намайг Лхам гуай оруулсангүй.

-Өө зөндөө хүүхэд орсон шүү дээ. Намайг оруулч л даа гэсэнд

-Юу гэнээ чи? Байтлаа том хүнтэй хэрэлдэх нь үү? Яв, харьж унт гээд намайг хаалганы гадна гаргаж, үүдээ хаав.

Би урамгүй байлаа. Нөхөд маань өдийд кино үзэж байгаа даа гэхээс

-Хэрэггүй ч би дэгээ барилаа даа гэж харамсан бодлоо.

Тэр удаа би нөхдийнхөө төлөө осолтой ажил хийж киноноос өөрөө хасагдсан болохоор дахиад кино гарахыг тэсгэлгүй хүлээж байлаа. Хясаантай нь, дараачийн хагас бүтэн сайн өдөр нь кино гарсангүй. Октябрийн баяраар бидэнд өдрийн кино үзүүлж “Александр Невский” үзсэн боловч үүнд бүх хүүхдийг хориг саадгүй оруулсан болохоор өнөөх сэмхэн Гонгорын “Уран аргаар” кинонд орж үзээгүй надад нэг л хангалтгүй байлаа.

Түүнээс хойш бас хагас сар болоод ашгүй нэг томцуулын кино гарах болсонд би Гонгорт гүйж очоод:

-Чи намайг өнөөдөр кинонд оруулж өгнө биз дээ? гэв.

-За яах вэ, би дэгээ барих нь барья. Харин сүүлд нь намайг оруулахгүй бол яах вэ? гэж Гонгор дурамжхан хэлж байна.

-Яах вэ, тэгвэл чи над шиг л хариад унтаж орхиорой. Чиний ээлж юм чинь.

-Яршиг, би дэгээ ч барина. Кинонд ч орно. Эртээр бол чи өөрөө бүтэлгүй болоод орж чадаагүй болохоос... гэж хэлээд яваад өглөө.

Тэгээд бид хэдэн хүүхэд хаалганы дэргэд очиж Лхам гуайд тулаад загнуулж байтал Гонгор хэлсэн үгэндээ хүрч мөн л эрхлэгчийн хормойноос дэгээдэж аваад тул загас барьсан юм шиг угзчсанд

-Та нар юунд хормойноос угзчаад байгаа юм, болиоч! Яасан маягтай юм гэж тэр авгай гараа савчин хаалганы ар луу өнгийж байна.

Бид ч тэр хооронд нь амжаад орчлоо. Ингээд хамаг юм сайн сайхан бүтэж, “Мужийн намын хороон дарга” гэдэг онц сайхан кино гарч байлаа.

Тэгтэл гэнэт гэрэл унтарч асаж хэд анивчсанаа бүгд унтарчив. Томцуул багацуулгүй л цөм дуу алдаж “хясаантай юм” гэж харанхуйд шуугилдан хүлээв. Дахиад гэрэл асахгүй гэдэг нь тодорхой болсон хойно билетээ хадгалж байгаад дараа үзэхээр болж хүмүүс тарж эхлэв. Би хадгалж байгаад дахин орж үзэх билетгүй тул энэ хясаантай гэрлээс болоод сайхан кино үзэж чадсангүйгээ бүр урам хугаран харамсаж байлаа.

Тэгээд хүний сүүлд гадагшаа гарахаар тэмтрэн түгдэрч явтал “Энэ ер нь тагнуул хорлон сүйтгэсэн байх” гэж санагдав. Энэ бол “тагнуул” Гонгор кинонд орж чадаагүйдээ атаархаад биднийг бас кино үзүүлэхгүй гэж “хорлосноос” гарцаагүй гэж бодлоо. Өмхий санаатай өөдгүй хүүхэд юм даа! гэж түүнд уур хүрлээ. Гонгор гэрэл унтраах арга гэж элдэв бусын юм ярьж билээ. Тэгээд би улаан булангийн байшин хашаа хоёрын зүүн хойд цонжинд урт нарийхан хэдэн савх мод байсныг саналаа. Түүнийг байшин шавардахад хананд нь хадаж хэрэглэдэг юм. Энэ бүхнийг би сэргэлэн саналаа.

Тийшээ сэмхэн гүйж очоод нэг урт мод авч хашаа түшүүлэн тавимагц, хурдан шалмаг авирч хашаан дээр гарлаа. Дараа нь бөхийж өнөөх урт модоо авч хөндлөн бариад, хойд айлын цонхны гэрэлд бүдэгхэн гэрэлтсэн хашааны толгой дээгүүр дамжин явахад одоо би харин нарийхан тэнжээн дээгүүр дамжиж тоглож байгаа циркчин болсон юм шиг санагдав.

Ингэж дамжин явж, улаан булангийн хашааны бага хаалганд хүрч, түүний нуруу модыг зайдлан унаж саваад урт модоороо байшин руу орсон гэрлийн зэрэгцээ хоёр утсыг таширт нь дагуулан ширвэтэл улаан булангийн гэрэл мэлс гээд асчихлаа. Ингэхэд би өөрийгөө фронт дээр тасарсан утасны хоёр үзүүрүүдийг амандаа зууж залгасан баатар холбоочин болчихсон юм шиг саналаа.

Тэгээд “ура” хашхирах шахаж байтал, миний өрөөсөн хөл дээрээс нэг баравгар гар шүүрээд авлаа. Тэр гар намайг гуд татаж буулгахад нь харвал миний “дайсан” болсон Дондог өвгөн гуай мөн байв.

-Аа чи ингэж байдаг босоо ороолон бий! гэж тэр өвгөн зангад муу чихэн дээрээс минь атгаж аваад улаан булан тийш чирч аваачлаа.

Улаан булангийн мухрын жижиг өрөөнд эрхлэгч Лхам, хорины дарга Даш гуай хоёр их л ажилтай бололтой бичиг бичиж сууна. Гэрэл ассан байхад лаагаа унтраахаа ч мартчихсан байна.

-Та минь харав уу? Янжингийн энэ босоо ороолонг харж байна уу? Ийм төмөр утас шидээд гэрлийг чинь унтраагаад байдаг байна. Хашаан дээр суучихсан шидэж байхад нь би барьж авлаа! гэж Дондог гуай намайг муулж өрөөсөн талыг тахийлгасан зэс утас ширээн дээр тавьж байна.

Намайг урт модоор ширвэхэд гэрлийн утсанд Гонгорын шидсэн энэ зэс утас мултраад Дондог гуайн толгой дээр унасан бололтой. Ганцхан үзүүрийг нь тахийлгасан болоод тийм амархан унажээ. Дондог гуай хаанаас шидэв гэж өөдөө хараад намайг хашааны толгой дээр байхыг үзэж бариад авсан юм байжээ.

Би очиж очиж намайг нэг нүдээр үздэггүй Дондог гуайд баригдсан болохоор дайсанд баригдсан зоригт цэрэг шиг нэг ч үг дуугарахгүй байя гэж шийдлээ. Тийм болохоор хэдийгээр дотроо “Энэ утсыг нь танай Гонгор шидсэн юм мэдэв үү!” гэж энэ зэвүүн өвгөнтэй хэрэлдэх байсан боловч түүнээ гаргаж хэлсэнгүй. Дуугүй л урвайгаад зогсоод байлаа. Лхам гуай:

-Нээрэн энэ хүүхдүүд бүр хэтэрч байна. Одоо байчхаад бүр намайг үүдэнд билет шалгаж байхад хормой хотыг минь загасны дэгээ шиг юмаар сэнжилж аваад угзчиж дооглодог болж. Энийг хараа- гээд бидний кинонд ордог билет болсон дэгээг урт утсаар ороочихсон ширээнээсээ гаргаад ирлээ.

Бүтэлгүй хог чинь дэгээгээ авалгүй чиргүүлээд тавьчхаж! гэж би Гонгорыг зэмлэн бодлоо.

Хорины дарга Даш гуай намайг харж, дэгээг сонирхсоноо ширүүн барзгар улаан царайд нь инээмсэглэл тодроод:

-Юун ч сүрхий дэгээ билээ дээ. Хүүхдийн юм биш байлгүй дээ. Нэг хар хүн л томхон шиг тул барьж гэж бодож дээ. Ха-ха! гэж инээсэнд

-За яршиг даа. Дарга зүгээр дандаа хүн дооглож байх юм! Энэ хүүхдүүд ер нь даанч дэндүү дэггүй юм аа! гэж эрхлэгчийн хэлэхэд

-Тэр дундаа энэ бүр гаргуундаа хүүхэд байгаа юмаа. Гэрт нь орсон хүний дээлийн хормойг ширдэгтэй оёно. Энүүнд болохгүй зан бүхэн бий! гэхчлэн Дондог гуай намайг муулж гарлаа. Энэ өвгөний нүд нэг л зэвүүн сармагчингийн нүд шиг ёлтгонож харагдана.

Даш гуай гэнэт царайгаа хүрлийлгэж аймаар сүртэй болоод

-Хүүхээ яагаад албан газрын чийдэн унтрааж байдаг билээ? гэж аядуухан асуулаа. Би дуугүй л байлаа.

Даш гуай намайг загнаж зодоогүй боловч улаан булангийн чийдэн унтрааж өдий төдий хүний боловсорч гэгээрэхэд садаа болдог чинь бараг л хорлон сүйтгэх ажил гэж сүрхий учирлаад, үүнээс хойш ингэж зүгүүтдэгээ боль гэж хатуу сануулав.

Тэгээд би Гонгорын хийсэн хэргийн төлөөнөөс хатуу шийтгэл хүлээлээ. Юу гэвэл тэд намайг ээжийг ажлаас бууж иртэл дэргэдээ суулгасан юм. Сүүлдээ миний улны гижиг хүрч, гутал дотор минь арав хорин жаран хөлт орчихсон юм шиг арзганаж байлаа. Тэгтэл эрхлэгч, дарга хоёр мэдээ ч үгүй, юмаа хийгээд суугаад л байсан юм.

Ээжийг дуудуулж авчраад Даш гуай

-Янжин минь наад хүүхдээ олигтойхон сургаж бай! Зүггүйтээд тун болдоггүй хүүхэд гэж Дондог гуай ч хэлж байна. Лхам ч хэлж байна. Ер нь их ширүүн “эр” гэнэ! Харин зодож жанчаад хэрэггүй шүү! гэж намайг ээжид хүлээлгэж өгөв. Ээж гэртээ ормогц л:

-Ийм үр хүүхэдтэй хүн амьд явсны хэрэг алга! Айл амьтны нүүрийг ч харах аргагүй боллоо. Нэр нүүрий минь баасдаж гүйцлээ! гээд уйлахад нь би гайхаж, бас өрөвдлөө. Зодуулсан би уйлаагүй байхад ээж өөрөө ингэж уйлж бухимдаж байхыг үзэхэд би тун ч буруу хэрэг хийсэн шиг санагдлаа.

Харгалдаа хашааны жолооч ах

Маргааш нь бүтэн сайн өдөр байсан ч гэсэн би эрт бослоо. Ээжийг босоод цайгаа чанаж байх үеэр би сэрчихлээ. Би, сэрэхдээ л хойрго болохоос биш, сэрсэн байвал босохдоо залхуурдаггүй юм. Тэр зангаараа ухасхийн босож хувцаслав.

-Хүү минь жаахан унтахгүй яагаа вэ? Юу болоод чи ийм эрт босоод ирэв гэж ээж гайхан асууж байна.

-Зүгээр сэрчлээ! гэж би хариулсан боловч юу болоод ийм эрт сэрчихсэнээ өөрөө ч гайхлаа. Үдэш хэрэг тарьж ээжийг уйлуулсандаа сэтгэл зовоод ч тэр үү, эсвэл миний нойр гэнэт бага болж байгаа юм уу, бүү мэд.

Хөвөнтэй цамцаа өмсөөд гадаа гартал баахан жавартай боловч тунгалаг сайхан өдөр болох янзтай, их сайхан байна. Тэнгэр цэв цэлмэг. Нар удахгүй гарах гэж байгаа бололтой. Дорно зүгийн тэнгэрийн хаяа туждаа улаан шаргал

туяанд умбасан байна. Манай үнээний саравчийг гялбам сайхан гуулин царан дээр товойлгож хийсэн юм шиг их гоё харагдаж байна.

Би нар мандахыг харах гэж саравчин дээр гарч өвсөн дотор хэвтлээ. Тэгтэл бутны цаана нуугдаад дайсантай байлдаж байсан нэг цэрэг санаанд орлоо. Тэр цэрэг малгайгаа шарилжинд өлгөөд бутны цаанаас цухуйлгахад нь дайсны мэргэн буудагч түүний нь цоо буудаж орхисон юм. Үүнийг би нэг кинонд үзсэн шиг санагдана. Ер нь мэргэн буудагч тусгай шагайвартай нууцгай байран дотроос юм уу эсвэл өндөр модны оройд гарч өтгөн мөчир шилмүүс дотор нуугдаад бууддаг гэж Галдан ах ярьж байсан. Миний хэвтэж байгаа өвс хураасан саравч бол яг л мэргэн буучийн байр шиг санагдаад явчлаа. Яагаад гэвэл энд намайг хэн ч харахгүй, харин би бүх юмыг харж байна.

За тэр! Харалдаа хашаанаас жолооч ах гараад ирлээ. Арвын бидонтой юм барьж явна. Ачааны тэргэндээ суух нь дээ! Үгүй манайд орох нь. Энэ ах манай ээжид сүү авчирч өгөх нь дээ. Өчигдөр хөдөө яваад ирсэн юм байж.

Энэ жолооч ахыг Дагва гэдэг. Нэг нь дээшээ, нөгөө нь доошоо чиглэсэн хачин хөмсөгтэй, намхан, бор хүн байгаа юм. Их сайн хүн шүү. Бид хоёр их найз улс. Надаар тэргээ арчуулдаг юм. Дугуй нь хагарвал би хийлүүрий нь дарж өгнө. Энэ ах М-Пикап гэдэг машинтай. Бас албаны том тэрэг барьдаг юм. М-Пикапаа унавал намайг суулгадаг. Том тэрэгнийхээ кабинд бол харин суулгадаггүй юм. Манайд огт машин байхгүй байхад энэ ахад том жижиг хоёр машин байдаг. Хачин шүү!

За тэр ч яахав. Би бол одоо мэргэн бууч хүн. Даанч надад буу алга даа. Байз! гэж би хөвөнтэй цамцныхаа өвөрт гараа шургуулав. Еэ гялай! Миний улаан сундагаар хийсэн чавх ашгүй байж байна. Харин бууц хаяаны манааснаас хэдэн сум түүж авдаг юм бил үү? Би нөгөө халаасан өвөртөө гараа оруулж тэмтэрлээ. Хэдэн сум байна! Тэгнээ тэр! гурав... дөрөв, таван жижигхэн бөөрөнхий сум (чулуу) байна.

Одоо! Ёстой мэргэн буудагч шиг л нэг ч сум гарздахгүй онох юм шүү. Харин юу буудах вэ? Хаа ч юм бор шувуу жир жир дуугараад байна. Тэр дайсан хаана байна аа? Түүнийг л буудъя. Гэвч Гонгорыг хашаанаасаа гараад ирвэл нэг сум зориулж болох юм даа. Тэр ер нь хорлон сүйтгэгч хүүхэд байгаа юм. Гэвч түүнээс болж ямар ч хэрэг дэгдэж болно. Би тэр өөдгүй жаалаас болж өөрөө зодуулсан. Ээжийгээ уйлуулсан. Ер нь больдог юм уу?

Ингэж бодож байтал нэг харахнаа хэдэн бор шувуу ирээд улаан булангийн чийдэнгийн утсан дээр суучихсан жив жив гэж байна. Би бушуухан буу сумаа гаргаж шон дээр сууж байгаа нэгийг нь чиглүүлэв. Тархиндаа сум зоолгохоо мэдэхгүй яваа дайсны цэрэг шиг тэр бор шувуу ийш тийшээ гилбэлзэн жив жив гэж л байна. Би чиглүүлж чиглүүлж харваад тавьчихлаа!

Тэгтэл юу болсон гэж санана! Гайтай бор шувуунууд дэр гээд нисчихлээ. Миний сум оносонгүй. Тэгтэл цаана нь жолооч ах духаа алгаараа дараад машиныхаа дэргэд ийш тийшээ харж байна. Түүнийг оносон бололтой. Тэгээд хэн хаанаас чулуудав гэж хайж байгаа нь ил. Би айхдаа өвсөн дотор улам шигдэж доошоо хэвтэл саравчны дээврийн хавирга модон дээр тавьсан даранз цөм үсрээд пир пар доошоо уналаа. Манай үнээ бяруунууд саравчны дээвэр дээрээс чоно харайгаад орж ирлээ гэсэн бололтой босон харайцгаалаа.

Гай болоход манай хөгшин тарлан үнээ махир эврээрээ миний хөвөнтэй цамцны аравчнаас гогодож аваад толгойгоо гилжийлгэн, нүдээ цагаанаар эргэлдүүлээд намайг саравчин дундуур чирээд хурдаллаа.

Ингэж пажигнатал, ашгүй, хүрэмний минь аравч тасарч би үнээнээс салаад хашааны үүдэнд унатал намайг мөрөн дээрээс нэг хүн татаж босгов. Харвал жолооч ах ирчихсэн байна.

-За хампаан яаж хөглөж байгаа чинь энэ вэ? гар хөл чинь зүгээр биз? гэж байна. Би үхрийн эвэрт чирэгдэж айсандаа хамаг бие салганан өвдөг чичирч байлаа. Хөвөнтэй цамцны минь шороог гүвж байснаа Дагва гуай миний халаасан өврөөс цухуйж байсан чавхыг суга татаж аваад

-Аа хампаан, намайг чи л харваад байсан юм бий? Муу санаа эзнээ отно гэж энэ дээ гээд ха-ха-ха гэж инээв. Түүний духан дээр чигчий хурууны өндөг шиг овойчихсон байна. Дагва гуай миний эрүүн дээрээс өргөж өөр өөдөө харуулаад:

-За хампаан, чи яагаад намайг харвадаг билээ? гэж даажинтайгаар асууж байна.

-Ах аа, би бор шувуу харвасан чинь харин таныг оносон юм. Би таныг цаана нь байсан гэж мэдсэнгүй... Би мэргэн буудагч болж тоглож байсан юм... гэж дэмий л үнэнээ хэллээ. Жолооч ахыг энэ үгэнд минь үнэмшихгүй байх гэж бодож байлаа. Томцуул ер нь хүүхдийн үгэнд итгэх дургүй байдаг юм.

-За хампаан чи нээрэн мэргэн буудагч болж тоглож байсан бол ч тоогүй л байна даа. Онох гэсэн юмныхаа оронд хампаанаа онодог чинь дэндүү муу буудаж дээ! Ийм янзаар “мэргэн” буудвал чи хүний нүд сохлох нь байна шүү! Хампаанаа энэ удаа ч гэрийнхэнд чинь хэлэхээ больё доо. Үүнээс хойш харин хүн харвасан байвал сайхан мэдээрэй! гэж санууллаа.

Би түүнийг миний үгэнд итгэж, намайг уучилсанд нь мөн ч их баярлаж билээ.

-Би дахиад яасан ч хүнийг чавхаар харвахгүй. Бүүр яасан ч чавхдахгүй! гэж үнэн голоосоо батлан андгайлав.

Энэ үеэр ээж үхрээ гадагш гаргах гэж гэрээсээ гарч ирээд бид хоёрыг гайхан харж:

-Дагва минь, та хоёр чинь юу л болоод байна даа, энэ чинь? гэж асуув.

-Юу ч болоогүй ээ! Энэ хампаан маань саравчин дээрээс ойчиж үхрийн эвэрт чирэгдэж хөглөөд би салгаж авах гэж бужигналаа гэж жолооч ах ажиггүй хариулж байна.

-Юм болгонд дандаа ямаа шиг авирч байдаг хүн. Болжээ, болж! Юунд салгаж аваа вэ? гэж ээж тавлаж байна.

Дараа нь ээж жолооч ахын духан дээрх овгорыг харж:

-Дагва чи наад духаа яачаа вэ? Манай энэ гайхал цохичоо биз? гэж миний хийсэн хэргийг мэргэн юм шиг таачих шахлаа. Харин Дагва гуай над руу харж нүд ирмээд

-Аа энэ үү? гэж духаа илээд

-Би танай “аваргыг” үхрийн эврээс салгаж авах гэж байгаад үнээний эвэрт цохиулчихсан юм... гэж хэлдэг байна.

Энэ сайн ах миний төлөөнөөс ингэж ээжид худлаа хэлэхэд нь би түүний төлөөнөөс санаа зовлоо. Жолооч ахыг би тэгэхэд энэ хавьдаа хамгийн

ухаантай сайн хүн юм даа гэж бодлоо. Тийм сайн хүнийхээ толгойг чавхаар оночихдог их муухай юм боллоо. Би ч өөдгүй мэргэн буудагч юм даа. Мэргэн буудагч хүн онох гэснээ онохгүй, харин огт хамаагүй юм онох гэж байх уу. Ичгүүртэй юм. Муу чавх ер нь гайтай буу юм. Түүний тэнэсэн сум юуг ч онож магадгүй юм байна гэж би гэмшин гэмшин бодож билээ.

Манай сургууль

Түүний маргааш нэг дэх өдөр. Даваа гараг. Тэгэхээр эгч бид хоёр сургуульдаа явах ёстой байсан юм.

Би одоо ямар сурагч байснаа ярих болж байна. Ярихад жаахан ичмээр юм. Хорин жилийн өмнө надаас өөр тийм өөдгүй сурагч бараг байгаагүй гэж болно. Одоо бол та нарын дотор ийм сурагч лав байхгүй байх. Байж ч таарахгүй гэдгийг би урьдаас хэлье.

Юуны өмнө би үдэш унтаж өгдөггүй, өглөө босож өгдөггүй сурагч байсан юм. Намайг сэрээж босгох гэдэг өвөө, ээж, эгч гуравт минь амаргүй ажил байсан даг. Гэвч тэд намайг сэрээх өөр өөрийн аргыг бодож олдог байсан юм. Өвөө аягүй л бол халбага хүйтэн ус нүүр лүү минь палхийтэл цутгаад сэрээнэ. Унтаж байгаа хүнд үүнээс илүү аймаар юм байхгүй шүү дээ.

Ээж бол өглөө эрт үхэр малаа аялуулж яваад орж ирүүт хучлагыг минь хуу татаад мөс шиг хүйтэн гараараа нойрмог нүүрийг минь дарж намайг сэрээдэг сэн.

Тэгтэл тэр нэг өглөө эгч намайг шал хачин аргаар сэрээсэн юм. “Дүү минь босоорой, одоо хичээлээсээ хожимдлоо. За босоод ир, нүдээ нээ дээ” гэж чихэнд шивнээд долоовор хуруугаараа миний хэнхдэг гэдэс рүү энд тэнд хатгачиж, гижигдэж мурчигануулсаар байгаад сэрээчихсэн юм. Ийм зэвүүн аргаар сэрээсний нь хариуд би эгчийг нүдээ аньсан чигээрээ хэд цохиж авсан боловч тэр нойтон хамуу шиг салж өгөхгүй “За бос, бос! Эгчийгээ зодсон хүн ийм салга болно. Хараач ийм салга болдог юм” гэж салгалан маяглаж намайг шоолоод болохгүй болохоор би аргагүй нүдээ нээсэн билээ.

Би сэрмэгц орноосоо суга үсрэн босож маш түргэн хувцасласан юм. Өмд, цамц, хамаг юманд товч бараг байхгүй болохоор хурдан хувцаслахад юу байх вэ! Хөвөнтэй цамцаа гадуур нь өмсөж авлаа. Галоштай эсгий гутлаа углаж авлаа. Шалны өр дээр тараагаад хаячихсан ном дэвтрээ хамж аваад уранхай цүнхэндээ хийж сугандаа хавчууллаа.

Хоёр хуруундаа уяж чавх хийдэг утсан сундагаа ширдэг дороос сэмхэн авч өмднийхөө халаасанд хийлээ. Бас нэг чухал багажаа мартах шахжээ. Төлдөр ээжийн дэлгүүрийн ширээн дотроос дэгээдсэн хэдэн дардаг хадаастай чүдэнзний хайрцгаа хаа хийснээ санахгүй гайхширч байлаа. Тэгтэл орны ширгүүд хөшигний цаана ханын нүдэнд хавчуулснаа гэнэт саналаа. Түүнийгээ авахаар сэмхэн мяраалаа. Өөрөөр хэлбэл миний нүүр эгч, өвөө хоёрын зүг ээлжлэн хандаж, бөгсөөрөө ухран ширгүүд ойртоод гар минь хөшгийг сэмхэн сөхөж, чүдэнзний хайрцгаа тэмтрэн олж аваад өмднийхөө халаасанд хийлээ.

Энэ үед өвөө сэрүүн боловч нүдээ аниад хэвтдэг зангаараа хэвтэж байсан юм. Эгч баруун хатавчинд очоод угаагуурын дэргэд буруу хараад нүүр гараа угааж байсан юм. Энэ сайхан чөлөөнд би цүнхэнд байдаг ном дэвтрэ, үзэг ханадаа, баллуур бэхнээс бусад юмаа бүртгэж авсан юм.

Тэгээд ээжийн надад зориулж аяганд хийсэн идэх юмыг харлаа. Жижигхэн тал эзвэнгээс нь нэг өм хазаад үлдсэнийг нь алимтай нь хамт хөвөнтэй цамцныхаа халаасанд шургууллаа. Орой боссон болохоор одоо идэх зав алга. Ангидаа очоод идэхэд амттай юм шиг санагддагаас гадна алимны үрээр тоглоход ч бас аятайхан байдаг.

Тэгээд хамаг юм бүрдсэн тул гүйгээд гарах гэтэл эгч хөвөнтэй цамцны минь аравч дээрээс нойтон гараараа шүүрээд авчээ.

-Хүүе-ээ, чи нүүр гараа угаагаач! Дандаа л халтар ухна шиг юм сургууль дээр очоод намайг загнуулж байх юм. Ичдэггүй амьтан шүү. Чамайг ээжид хэлнэ шүү! гэж байна.

Би энэ яршигтай ажлыг мартчихсанаа гэнэт санаж, аргагүй нүүр гараа угаах болов. Эгчийн оронд угаагуурын дэргэд очиж буруу хараад усаар гар нүүрээ нэг нэг цавдаж аваад арчуур тийш эргэтэл

Яршиг-аа! Төмөрсүхээ! Чи олигтойхон угаа л даа гэнэ.

Эгч нүүрээ их нямбайлж угаадаг юм. Өглөө болгон ингэж сүрхий угаахад түүний нүүрний улбагар ягаан арьс зулгарчмаар санагддаг сан. Дараа нь эгч гэзгээ самнаж сүлждэг юм. Эгч энэ хар яршигтай олон ажлыг хичээлээс өмнө яаж амжуулдаг юм бол гэж би гайхдаг сан. Түүний нь хараад байхад залхуу хүрдэг юм. Эрэгтэй хүн болж төрсөн нь надад аз болжээ. Хоёр сард нэг удаа үсээ хусуулах ч бас амаргүй. Гэвч өглөө болгон гэзэг самнаснаас хаа зүйртэй юм.

Тэгтэл ээж бас ороод ирлээ.

-Ээж ээ, энэ дүү чинь нүүр гараа сайн угааж өгөхгүй юм. Хүзүү хоолойгий нь хараа. Пад хар. Нүүр нь энүүхэндээ цайраад баг өмссөн юм шиг. Хар аа! гэж ховлов. Би эгчийг дотроо хараах боловч ээж хүрч ирээд хөвөнтэй цамцы минь тайлж авах гээд өнөөх хичээлийн бүртгэлийг минь үзчих бий гэж айгаад бушуухан гадуур хүрмээ тайлж хаяад дахин угаагуурт очлоо.

-Угаагаад өг! Угаагаад өг! гэж эгчид даалгалаа. Бүр ч гайтай юм болох нь тэр. Эгч мөлүүлэх улаан гараараа миний хүзүү хоолойг савандаж угаагаад миний гижиг хүрч, бие арзганан, бас нүд минь аргаад хорсоод ч явчих шиг болов.

-Яршиг-аа, би... Би өөрөө... өө... яасан юм ус! суга руу ус... гэж миний дургүйцтэл ээж:

-Уухай! чи тэгээд эгчдээ ярдаглаад байгаарай гэж зандарлаа. Ээж өвөө хоёр эгчийг өргөмөл юм, бүсгүй амьтан гэж түүнд хир халдаахгүй, гар ч хүрэхгүй. Тэгсэн байтлаа намайг бол дандаа буруутгаж, зодно, загнана. Би ээжийн төрсөн үр нь болохоор намайг яаж ч гомдоосон хамаагүй юм шиг байдаг. Би үүнд их атаархаж “Би өргөмөл хүү нь, эгч төрсөн охин нь байсан болоосой!” гэж боддог байлаа.

Эгч яаж ч байсан хөдлөхгүй, урвайгаад дуугүй номой байдаг болохоор их хүндтэй байх шиг байдаг. Гэвч би тэр хамгийн амархан дуугүй номой байдлаар байж тун чаддаггүй болохоор намайг загнахдаа дандаа л эгчийг жишээ татаж “Чи энэ эгчийгээ хар, хэчнээн толгой сайн хүүхэд байна. Гэтэл чи яачихсан заяа нь хаясан хүүхэд вэ!” гэж зэмлэнэ. Иймд би эгчийн нурмагар номой зан, өргөмөл охин гэдэг хоёрт нь шал дургүй хүрдэг байсан юм.

Тэр өглөө би эгчийн гайгаар хичээлээсээ жаахан хоцорсон боловч харин нүүр, гар, хүзүү, хоолойгоо сайн угаасан болохоор ариун цэврийн комисс Нямаагаас айхгүй болсон нэг сайн талтай байв.

Адаг сүүлд нь эгч бид хоёр гэрээсээ гараад, халуун усны зүүн үзүүрээр тойрч төмөр замын далан огтлон сургуулийн гудамж руу орох үед миний нүүр өглөөний жаварт чимчигнэн хорслоо. Нүүрээ сайн угаачихсан болохоор арьс нь нимгэн болчихсон юм шиг санагдлаа. Тэгтэл нэг гайхмаар юм миний санаанд орлоо:

-Эгчээ, хүний нүүр гар хоёр ил явдаг мөртөө яагаад даардаггүй юм бэ гэж сонирхлоо.

-Яах вэ, сурчаад л тэр биз гэнэ.

-Хүн нүцгэн яваад байвал бас сурчхаад даарахгүй дээ, тийм ээ?

-Битгий солиор! Хөлдөж үхэхгүй юу! гэж эгч хэллээ.

“Эгч худлаа хэлчихлээ. Би нүцгэн явж сурах юмсан” гэж бодлоо. Ингэж яваад нэг мэдэхэд сургуулийн үүдэнд ирсэн байлаа.

Манай сургууль Тавын халуун усны хойд дэнж дээр нарийхан гудамжны хоёр талд байдаг юм. Байшингийн дундуур нь гудамж дайраад гарчихсан юм уу гэж та нар гайхаж байгаа байх. Тийм биш. Тэр үед манай сургууль одоогийнх шигээ дөрвөн давхар том байшинтай байгаагүй, харин гудамжны хоёр талд өөд өөдөөсөө харсан хаалгатай хоёр хашаанд байсан юм.

Зүүн хашаа нь цэлгэр. Өвөөгийн зандан хашлага шиг сайхан хүрэн өнгөтэй хоёр дүнзэн байшинтай. Түүний нэг нь гаднаасаа ил. Нөгөө нь хашаан дотроо байдаг юм. Тэр хашааны хаалган дээр гөлмөн төмөр жаазалж, хараар будаад “Нийслэлийн хоёрдугаар дунд сургууль” гэж цагаан тосон будгаар бичсэн гоё хаяг хадаастай байдаг сан. Энэ зүүн хашааны далд дүнзэн байшинд 76 гэдэг ангид эгч сурдаг юм.

Гэтэл би баруун хашааны айлын сууц шиг жижигхэн хоёр цагаан байшингийн баруун талынхад нь 3в ангид хичээл хийдэг юм. Энэ баруун хашаа хаяггүйгээр ч барахгүй, хаалга ч үгүй, зүгээр л нэг онгорхой хашаа. Энд бас сургуулийн түлээ нүүрсийг хураадаг болохоор зарим хүн үүнийг аж ахуйн хашаа гэж ярих дуртай. Ингэж ярихад би дургүй. Би сургуульд сурдаг биш, харин аж ахуйн хашаанд зүгээр л байдаг юм шиг хачин санагддаг. Тэнд хэрэв сургуулийн клубийн том цагаан байшин, захирал багшийн суудаг жижигхэн байшин хоёр байдаггүй сэн бол жирийн айлын хашаа байшингаас огт ялгаагүй болох сон.

Зүүн хашааны тэр хоёр сайхан дүнзэн байшинд намайг огт орж үзээгүй гэж санаж байна уу? Хашааны гадна талд өрөөсөн тал нь харагддаг дүнзэн байшинд багш, хичээлийн эрхлэгч, захирлын өрөө байдаг юм. Би тэнд үе үе дуудагдаж очоод, орж зогсож үзсэн юм. Нөгөө хашаан дотор далд байдаг дүнзэн байшинд бол би орж үзсэнээр барахгүй 1б ангид хоёр жил суралцаж үзсэн гээч!

Намайг нэг ангид хоёр жил сурлаа гэж томчуул, багш нар зэмлэдэг боловч би үнэндээ нэг ангид суугаад байгаагүй юм. Яагаад гэвэл миний улирч орсон нэгийн 6 бол миний анхны орсон 1б ангиас өөр хүүхдүүдтэй, өөр анги байсан юм. Би тэр дүнзэн байшингийн зүүн урд булангийн өрөөнд анх орсон бол улираад түүний харгалдаа баруун урд булангийн өрөөнд хичээл хийдэг

болсон. Ганцхан гайтай нь 16 гэсэн хаяг нь хэвээрээ байсан даа. Уранхай хуучин номынхоо оронд шинэ ном авсан боловч ганцхан доторх юм нь хуучин номтойгоо адилхан байсан болохоор надад нэг их сонин санагдаагүй.

Дараах хоёр жилд нь би хоёрдугаар ангид ороод энэ өөдгүй жижигхэн байшинд хичээл хийсэн юм. 26 гэдэг ангид нэг жил сураад төгсөх гэж байтал надад мухар олгой гэдэг өвчин гэдсэн дотор ургасан юм. Уржнан хавар би тэр гайтай өвчнөөс болоод гэдсээ хагалуулан хичээлдээ явж чадаагүй болохоор 2в гэдэг шинэ ангид орсон.

Хүүхдийн бөөрийг авдаг хүн байдаггүй юм. Харин мухар олгойгий нь авч хаяад гэдсийг нь утсаар оёчдог Хорлоо гэдэг алдарт эмч байдаг. Та нар тэр Хорлоо гуайгаар гэдсээ хагалуулж лав үзээгүй байх. Би бол Хорлоо гуайгаар гэдсээ хагалуулж үзсэнээр барахгүй олон дахин оёулж үзсэн хүн. Хагалахад нь уйлаагүй юм. Харин хэд дахин оёулахдаа л уйлах шахсан даа.

Би манай гэрийнхний хэлдгээр тун зүгээр сууж чаддаггүй жаал байсан болохоор мартаад бөмбөг өшиглөөд юм уу, эсвэл юман дээрээс дэвхрээд оёосоо задалчаад байсан юм. Гэдэсний оёос хөвөнтэй цамцны оёоноос шал ондоогоор урагддаг юм. Тэр оёос цамцны оёос шиг шар гээд ангайчихгүй мөртөө их өвдөөд шар шүүс гоожоод ирдэг юм. Хүний гэдсэн дотор ер нь тийм шар ус их байдаг байх!

Ингэхлээр 2в ангид миний хоёр жил суусанд чухамдаа би өөрөө буруутай биш, тэр муу мухар олгой минь буруутай. Олгойгоо авахуулаад эмнэлэгт найм ес хоног хэвтэхэд манайхнаас дандаа л баавгайтай чихэр, алим боов зөөж авчирч өгөөд байсан. Өвчтэй болохоор манайхан надад эрүүл байснаас минь илүү хайртай болчихсон байсан. Харин хөдөлж гүйж болохгүй нь их хэцүү юм билээ! Уйдаж үхэх шахсан би.

Мухар олгой юунаас ургадгийг та нар мэдэх үү? Самраас ургадаг юм. Би самар идэх дуртай байсан. Самарыг ястай нь идвэл тэр яс нь гэдсэнд ороод мухар олгой болоод ургачихдаг гэж томцуул ярьдаг юм. Тэр үнэн байх! Та нар самар идэхдээ болгоомжтой бай, эс тэгвэл ч аягүй л бол над шиг гэдсээ хагалуулж үзнэ дээ, хүүхдүүд ээ!

Одоо би 3 в ангид сурч байгаа юм. Нэг ангид хоёр жил суугаад байхаар залхуутай юм. Би энэ гуравдугаар ангид дахиад суухгүй гэж бодож байна.

Тэр өглөө эгч бид хоёр явсаар байгаад сургуулийн үүдэнд очиход эгч:

-За чи ангидаа оч! Өнөөдөр хичээл дээрээ томоотой суугаарай! Наад нусаа арилга гээд алчуураа гаргаж, миний хамрыг ханзалчх шахаад шударч арчиж өглөө. Би:

-За гэж эгчид томоотой сууна гэдгээ амласан боловч баруун хашааны задгайгаар орохоор юу болохыг бүү мэд.

Хичээл дээр

Тэр өдөр Даваа гараг болохоор манайх дөрвөн цагийн хичээлтэй байсан юм. Дөрвөн цагийн хичээл гэдэг чинь суугаад хийгээд ирэхээр их уддаг. Харин тоглож байхад бол дөрвөн цаг их амархан өнгөрчдөг юм.

Намайг ангидаа хүрч очиход багш орчихсон байна. Эгч маягласаар байгаад намайг хичээлээс хожимдуулж орхисон байна. Би очиж хаалганы завсраар чагнахад багшийн царгиа дуу хадаж

-За хүүхдүүд ээ тооныхоо дэвтрийг гарга! Гэрийн даалгавраа хийсэн биз дээ? гэж багш хэлж байна. Би даалгавраа хийсэн эсэхээ мэдэхгүй байна.

Азаар, манай ангийн хаалга багшийн ширээний харгалдаа биш, харин миний ширээний дэрдэд байсан юм. Би багшийг самбар дээр сар өдөр тавих гэж цаашаа харах зуур сэмхэн ороод суудалдаа суутал миний хажууд суудаг Нямаа гэдэг охин

-Багш аа, энэ Төмөрсүх хождоод зөвшөөрөлгүй орж ирээд суучлаа! гэж хашхирав.

Манай ангийн гучин гурван хүүхэд дотроос энэ охин миний бодоход хамгийн хачин, учир нь олддоггүй хүүхэд байсан. Түүний нэг нүд нь нүүртэйгээ хамт багшийн зүг харж байхад нөгөө нүд нь хажууд байгаа намайг дандаа л ширтээд ажиглаад байх шиг харагддаг сан. Тэгээд хүний хэрэгт хүртээлтэй юм шиг биднийг багшид ховлож байдаг юм. Тоо бодох юм уу, цээж бичиг бичихдээ дандаа гараараа надаас халхалж байдаг юм. Тэгсэн мөртөө өнөөх хачин харцтай өрөөсөн нүд нь миний бичиж байгаа дээр тусаад байх шиг байдаг. Би тоо, хэлбичиг хоёрын аль алинд муухан болохоор буруу бодсон, бичсэнээ түүнд зориуд харуулж будилуулах сан гэж огт нуулгүй бичдэг билээ.

Би Нямааг нударч:

-Чамд ямар хамаатай юм бэ? гэж шивнэв.

-Хараач ээ багш аа, энэ чинь хичээлээс хожигдож ирчхээд хэллээ гээд зодоод байх юм... гэж Нямаа хашхирлаа.

Багш эргэж намайг сая олж хараад

-Төмөрсүх чи яагаад хичээлээс хоцорч орж ирээд үймүүлээд байна гэж загналаа. Нямаа бах нь ханаж байгаа бололтой над руу ширтээд байдаг өрөөсөн нүд нь онийж инээмсэглэсэн харагдана.

Тэр хичээл төгсөх шахаж даалгавар бичүүлэх үеэр би Нямаагаас хариугаа авъя гэж бодлоо. Тэр үед бид цүнхтэй номоо ар нуруундаа сандлын түшлэг налуулж тавьдаг журамтай байсан юм. Би Нямаагийн гээгний туузыг номын савны нь бариулаас сэмхэн уялаа. Тэгээд гэрийн даалгавраа хичээнгүйлэн бичиж байгаа дүрэм үзүүлэв.

Тэгтэл ашгүй хонх дуугарч багш “Завсарлацгаа” гээд бидний дэргэдүүр гараад явлаа. Ангийн дарга “бос!” гэж хамаандлав. Нямаа ухасхийн босох гэснээ

-Ёо-ёо-ёо гээд суумагц эргээд

-Болиоч ээ чи! гээд арын ширээний Ёндонг цохиод авлаа. Түүнийг гээгнээс татчихлаа гэж бодсон аж.

Би ухасхийж гараад хаалганы цаанаас сэмхэн харж байлаа. Ёндон

-Аа муу сөлөр, чамайг би яасан юм гээд Нямааг эргүүлээд цохих гэж далайхад Нямаа ухасхийн боссоноо

-Ёо-ёо-ёо гэж ангиар нэг дуу нь хадаад уйллаа! Харин Ёндон инээлээ. Арын ширээний “анааш” Долгор гэдэг охин

-Найз аа, чиний гээгийг номын савнаас чинь уячиж гээд тайлж өгч байгаа харагдана.

-За муу “ийрэл саарлыг” даа, чамайг багшид хэлнэ дээ! гэж Нямаа уйлганан занаж байгаа дуулав.

Дараа нь хэлбичгийн хичээл байсан юм. Багш үзүүлэн таниулахаа самбарт хадах гээд

-Хүүхдүүд ээ, дардаг хадаастай хүн байна уу? гэж асууж байна.

Би өмднийхөө халаасанд гараа шургуулж, чүдэнзний хайрцагтайгаас гурав дөрвөн дардаг хадаас гаргаж атгаад

-Багш аа, надад, энэ байна гэж хашхирлаа.

-Өө юун сайн юм. Аваад ир гэж багш хэллээ.

-Чи үүгээр юу хийх гэсэн юм? гэж багшийн асуухад би сандрахдаа:

-Танд... хэрэг болж магадгүй гэж авчирсан юм гэж худлаа хэлэв. Чих халуу оргиод явчихсан, лав улайсан байх!

Багш: - сайн байна гэж намайг баахан гайхсан маягтай харж дардаг хадаасыг минь авав.

Үнэндээ би тэр хадаасаар Гонгорыг чадах гэж авчирсан юм. Тэр жортгор жаал намайг дандаа чадаж байдгийг та нар мэднэ. Би түүнийг үнэхээр хорон санаатай өөдгүй муу хүүхэд гэж боддог байсан. Тэр нэг л сэжигтэй юм шиг “зэвүүн” жаал байгаа юм. Дандаа сэлбэлзэж, хүний нүд хариулж байгаад, далдуур үймүүлчээд л гэмгүй царайлаад сууж байдаг. Багшийн ширээний дэргэд хамгийн нүүрэнд суучаад ангийн журналыг дандаа сэмхэн шагайж байдаг, ер нь нэг л сэжигтэй жаал байсан даа.

Би түүний хүний ул шагайдаг эсэхийг шалгах гэж энэ дардаг хадаас авчирсан юм.

Гонгор, багшийг орж ирэхийн өмнө ширээн дээр нь очиж суугаад багшийг дуурайж маяглаж байгаад үүдээр цухуймагц нь год үсрэн байрандаа очиж суудаг зантай жаал байсан юм.

Тэгээд тэр өдөр ангийн жижүүр биднийг гар гэж хөөх үеэр би хэлбичгийн даалгавраа бичиж авч амжаагүй хүн болоод ангидаа хоцорлоо. Жижүүр надаас бусдыг нь ангиас гаргачаад үүдэнд очиж хаалгаа онгойлгож зогсоод нэг охинтой юм ярьж байна.

Би бушуухан босож багшийн сандал дээр гурав дөрвөн дардаг хадаас зүүгий нь дээш харуулан тарааж тавиад гүйж гарлаа. Хичээлийн хонх дуугарахтай хамт хамгийн түрүүнд орж ирээд суудалдаа суув. Бүх хүүхэд бужигнан орж ирээд багшийг хүлээн шуугилдаж, пижигнэж байлаа.

Би “Гонгор одоо орж ирээд багшийг шоолох гээд багшийн сандал дээр очиж сууна. Огло үсрэх нь үү, үгүй юу, харж байя!” гэж бодон түүний орж ирэхийг тэсгэлгүй хүлээж байлаа.

Хясаантай нь өнөөх Гонгор орж ирээгүй л байна. Нэг харсан чинь, Гонгор багшийн яг урд орж ирээд гүйгээд суудалдаа суучлаа. Багш хойноос нь орж ирээд шулуухан явж суудалдаа сууснаа дуу алдан оглой харайлаа. Бүх хүүхдүүд юу болсныг мэдэхгүй гайхаж байна.

-Ёо-ёо-ёо! Энэ чинь юу болж байна аа? гээд багш эргэж сандал руугаа харахад нь түүний дээлэнд нь шивсэн хоёр гурван дардаг хадаасны тав гялтайн харагдлаа.

-Багш аа, багш аа! Таны дээлэнд дардаг хадаас шивчихсэн байна гэж ангийн нөхөд маань шуугилдлаа. Багш эргэж дээлэндээ шивсэн дардаг хадаасыг түүн аваад

-Хэн тань миний сандал дээр дардаг хадаас тавив? Та нар намайг шивж алах гээ юу? гэж багшийн загнахад Гонгор босож толгойгоо илээд:

-Багш аа, дардаг хадаас бидэнд байхгүй, ганцхан Төмөрсүхэд л байсан шүү дээ! гэж хэлэв.

Бүх хүүхдүүд над руу эргэж харах шиг боллоо. Би дуугүй л доошоо хараад нусаа татаад сууж байв. Багш над руу ирж мөрөн дээрээс минь шүүрч аваад:

-Чи ер нь ямар санаатай хүүхэд вэ? Чи ер нь хичээл хийх гэж ирсэн үү? Аль эсвэл үймүүлэх гэж ирсэн үү? гар чи! гэж хаалгаар бүлт түлхэн гаргалаа. Би тэр муу Гонгорыг шоглож чадсангүй, харин өөрөө санаатай этгээд болж хөөгдөж гарсан минь их гомдолтой юм боллоо. Бас номоо авч ч чадсангүй. Дэндүү болчимгүй явдал болжээ.

Ангийн хурал

Би хичээлээс хөөгдсөндөө нэг их зовсонгүй. Хичээл надад залхуутай, их удаан үргэлжлэх шиг санагддаг. Манай багш хичээл заахаасаа загнах нь их байдаг болохоор хичээл маань уйтгартай санагддаг байсан юм. Тэгсэн мөртөө багш намайг хичээлээс хөөгөөд гаргадаг нь сонин шүү. Надад бол хичээлд сууснаас хөөгдөж гараад гадуур нэг цаг сэлгүүцэж явахад харин ч зугаатай зүгээр юм шиг санагддаг юм. Хичээлээс хөөж байгаад багш намайг юугаар яаж хохироож байгааг тэр цагт ойлгодоггүй амьтан байжээ. Би тэнэг сурагч байсан болоод тэр байх!

Гэвч энэ удаа Гонгороос болж хөөгдсөн болохоор ер нь л гомдолтой байлаа. Бас номоо авч чадаагүй хөөгдөж гарсан болохоор явчиж болохгүй байв. Би номоо авъяа гэж хэлэх гээд хаалгаар хэд бултгасан боловч багш намайг харсангүй. Харин хүүхдүүд харж шоолсон юм уу, тавласан ч юм уу, жиг жуг инээлдэж байлаа. Нямаа бүр ч бах нь ханасан бололтой хэлээ бултайлган намайг тавлаж байна.

Тэгэхлээр би багшийг хаалган дээр ирүүлж байгаад номоо авъя гэж хэлэхээр шийдсэн юм. Багшийг хаалган дээр ирүүлэх аргыг би мэддэг. Тэр бол саарал шинелтэй цэргийн өндөр “ахын” хэрэглэдэг арга байгаа юм.

Тэр ах багштай уулзах гэхээр өөрөө анги руу шагайлгүй хаалга тогшоод эхэлдэг юм. Багш эхлээд “За!” гэж зөвшөөрдөг юм. “За!” гэж зөвшөөрснийг нь дуулаагүй юм шиг өнөөх цэргийн ах дахиад цохидог. Тэгэхээр манай багш “За ор ор!” гэж уцаарлангүй хашхирдаг боловч цэргийн өндөр ах “Би орох гээгүй, уулзъя гэж байна” гэсэн шиг хаалгыг аяархан тогшоод л байдаг юм. Адаг сүүлд нь багш өөрөө хаалган дээр хүрч очоод гадагш шагайж хармагц эргэж бидэнд:

-Хүүхдүүд ээ, та нар жаахан хүлээж байгаарай! гээд гараад явдаг сан. Тэгээд цэргийн ахтай байшингаас бүр гараад хашааны мухарт очоод яриад зогсчдог юм.

Цэргийн тэр ах манай багшид их л сонин үлгэр ярьдаг байх. Манай багш түүнийг ярьж байхад бидэнтэй байдгаасаа шал ондоо болоод онигор нүд нь сэргэж инээмсэглээд цагаан царай нь улаан ягаан болж гэрэлтээд их баяр хөөртэй болчихсон харагддаг сан. Багш тэр ахын яриаг сонсох их дуртай байх шиг байдаг. Жаахан духайж аманд нь чихээ наачих шахаад зогсоод л байдаг юм. Бас шинелийн нь таван хошуутай гоё алтан товчийг оролдоод байдаг юм.

Багш бидэнд “жаахан хүлээж байгаарай” гэснээ мартаад зөндөө их хүлээлгэдэг сэн.

Би хувьдаа бол багшийг тэгж их хүлээлгэхэд дуртай байдаг. Учир нь гэвэл би тэр хооронд хагалуулсан сорвитой гэдсээ нөхдөдөө гайхуулан үзүүлэх юм уу, эсвэл түүн дээрээ сурагч бэхээр зураг зуран харуулан нөхдийгөө инээлгэдэг юм.

Тэр ахыг ирээд явахлаар манай багшийн зан сайхан болчх шиг надад санагддаг юм. Харин цэргийн ахаас тэгтлээ их сонирхож чагнадаг үлгэрээ бидэнд ярьж өгдөггүй, манай багш хачин хүн байсан юм. Гэсэн ч заримдаа хичээл дээр залхуу хүрэхээр цэргийн өндөр ах ирээсэй гэж боддог байлаа.

Тэгээд би багшийг үүдэн дээр авчрах гэж тэр цэргийн ахын адил “За”, “Ор, ор” гэж багшийн хэлэхийг дуулаагүй юм шиг л хаалгаа тогшоод л байлаа. Тэгтэл багш яг миний санаснаар их баяртай сэвэлзтэл алхаж гарч ирээд намайг зогсож байхаар гайхсан боловч ийш тийш харснаа:

-Чи хаалга цохиод байгаа юм уу? гэж царай нь хувьсхийж ууртай асуулаа.

-Багш аа би номоо авъя, болох уу гэсэн минь

-Болохгүй гэж байна чамд. Яагаад надаар тоглоом хийгээд хичээл үймүүлээд байгаа юм. Холд! Зайл гэж учиргүй уурлаж загнаад хаалгаа тас хаагаад орж явчихлаа.

Би багшийг яагаад ингэж их уурлуулснаа мэдэхгүй гайхаж дэмий л гадаа гараад цонхны дор жаахан зогсож байтал даараад явчлаа. Хөвөнтэй цамцаа ангид өлгөж орхисондоо харамслаа. Одоо тэр цамцаа авч өмсөх сөн гэж саналаа. Түүний халаасанд тал ээвэн алим хоёр хийснээ ч саналаа. Үүнийг санахын хамт өлсөөд гол харлаад явчлаа.

Би яасан ч хөвөнтэй цамцаа олж өмсөе гэж шийдэн гүйн орж, ангийнхаа хаалганд хүрч цээжээ цухуйлгаж байгаад:

-Багш аа! би хөвөнтэй цамцаа авч өмсөе. Даараад байна! гэж хашхирлаа.

Багш дунд ширээнд нэг хүүхдийн дэргэд бөхийж бичсэнийг нь юм уу, уншиж байгаа номыг нь ч юм уу, харж байснаа гэнэт уур нь хүрсэн бололтой:

-Нөхөр минь чамайг цаашаа бай гэж байна шүү? Чи ер нь хичээл хийлгэх чинь үү, үгүй юу? гээд эргэж ухас хийв.

Яг тэр үеэр арын ширээний Ганзориг гэдэг хүүхэд миний хөвөнтэй цамцыг өлгүүрээс аваад над руу шидчихлээ. Би багшийг ирэхээс өмнө амжиж цамцаа шүүрч аваад эргээд, пижиг пажиг гүйчихлээ.

Ангид багшийн дуу хадаад л байна. Бодвол Ганзоригийг загнаж байгаа байх. Ганзориг ч ёстой зоригтой хүүхэд юм даа гэж надад хөвөнтэй цамц чулуудсаныг нь би талархан бодож суутал, би эндүүрсэнгүй, Ганзориг бас хөөгдөөд гарч ирлээ...

Аа ямар... би... гэж амандаа үглээд гарч ирлээ. Царай нь хүрлийчихсэн. Хөмсөг нь буучихсан, уруул нь унжиж орхисон нэлээд ууртай харагдана. Ганзориг намайг бодвол хичээлдээ сайн болохоор хичээлээс хөөгдсөндөө гомдож бухимдаж байгаа бололтой.

Би түүнийг надаас боллоо гэж бодоод өрөвдөв. Тэгээд хөвөнтэй цамцны халаасанд байсан тал ээвэнгээ хувааж идэв. Дараа нь алимаа гаргаж хоёул

хонгилын мухарт бөөрөнхий пийшингийн дэргэд зогсоод ээлж ээлжээр нэг хазаад идэж байлаа.

-Чи надаас боллоо гэж миний хэлэхэд тэр маань

-Аа энэ багш хачин... гэж амандаа бөвтнөв.

Тэгтэл цэргийн ах хүрээд ирлээ. Тэр өндөр хүн манай ангийн үүдэнд очоод бид хоёрыг нэг харснаа яг миний түрүүчийн хаалга цохисон шиг манай ангийн хаалгыг цохиод л байна. Зөөлхөн зөөлхөн тогшоод л байна. Багш гарч ирэхгүй л байна. Бид хоёр хараад алимаа хазаж л байна.

Гэнэт хаалга хүчтэй нээгдэхэд цэргийн ах хаалганд золтой л цохиулчихсангүй ухраад орхитол манай ангийн багш

-Яах гээд байгаа новшнууд вэ? гэж хашхиран минчгэр улаан царайтай, ухасхийн гарч ирэв.

Бид хоёрыг хаалга цохилоо гэж бодоод ингэж уурлаж гарч ирлээ гэж мэдээд бид хоёр ч хөхрөлдөн гүйж гарлаа. Удалгүй өндөр ах яаран гарч одлоо. Өнөөдөр манай багш ууртай байгаад өндөр ахаар үлгэр ч яриулсангүй бололтой. Бид хоёрын гайгаар ийм боллоо гэж бид ярилцав.

Хичээлийн хонх дуугармагц бид хоёр ангидаа гүйж ортол багш

-Та нарыг би зүгээр орхино байх аа! гэж занаад, одоо та нар сууж бай! Ангийн хурал хийнэ. Нэг ч хүн гарч явж болохгүй шүү! гэж бидэнд ууртай гэгч тушаагаад гарч явав.

Удалгүй багш нэг өндөр хөх хүн дагуулаад хүрээд ирлээ. Энэ багшийг сурагчдын зөвлөлийн багш гэж би дуулсан юм.

Багш ширээнийхээ дэргэд хоёр сандал тавиулан өнөөх багшийг нэгэнд нь суулгаад, бас ангийн даргыг дуудан дэргэдээ суулгав. Ангийн дарга Бат өндөр хүнийг айсан маягтай харж толгойгоо нэг илчхээд доошоо хараад сууж байна.

Багш босож:

-Цөмөөрөө байгаа биз! Хүүхэд гараад явчаагүй биз! гэж асуугаад юуны өмнө Ганзориг бид хоёрыг нүдээрээ харж бүртгэв. Ангийн жижүүр Дармаа босож:

-Бүрэн багш аа гэж мэдэгдэв. Багш:

-Одоо ингээд ангийн хурлыг хийе. Манай ангийн сурагчдын дотроос сүүлийн үед сахилгагүй явдал их гарч байгааг авч хэлэлцэнэ. Энэ гэж өндөр хүний зүг нүүрээрээ заагаад бага ангийн хичээл эрхлэгч Тайван багшийг зориуд урьж суулгаж байна. Тэгэхлээр та нар ангийнхаа дотор байгаа энэ сахилгагүй сурагчидтай эвлэрч болохгүй. Хүн бүхэн тэдний яаж үймүүлж, сахилга бат алдагдуулж байгааг хайр найргүй шүүмжлэх хэрэгтэй. Хүн болгон оролцоно шүү, мэдэв үү? гэхэд Ганзориг бид хоёроос бусад нь цөм:

-Мэдлээ! гэж нэг хүн шиг хашхирч байна.

Багш босож:

-За тэгэхлээр, манай ангийн сурагчдаас хэн болохгүй, сахилгагүйтээд байна вэ гэдэг бол тодорхой. Төмөрсүх бос! гэв. Би бослоо.

-Наашаа гараад ир! гэж байна. Би урвайгаад танихгүй багшаас айж доошоо харсаар явж багшийн ширээний дэргэд ирлээ. Хүүхдүүд нэг л сүрхий юм болох нь гэсэн байртай чив чимээгүй л байна.

-За чи яагаад манай ангийн дотор ганцаараа онц сахилгагүйтээд байна? гээд надаас асууж байна. Би юу гэж хариулахаа огт мэдэхгүй байлаа.

-Энэ хүүхэд ерөөсөө хичээл хийлгэхээ байгаад байна аа! Одоо зөвхөн өнөөдөр л гэхэд миний сандал дээр дардаг хадаас өөд нь харуулж тавиад өгзөгнөөс шивүүлчиж байгаа юм. Дараа нь хичээлээс хөөгөөд гаргачихлаар дахин дахин үүд хаалга балбаад үймүүлээд байгаа юм. Сурлага гэж юу ч байхгүй. Бүр тэг. Энэ одоо анги болгонд хоёр улирч новшроод одоо таван жил болоход дөнгөж гуравдугаар ангид сурч байгаа шүү ухаантай. Ийм сурагчийг чинь одоо яах ёстой байна аа? гэж багш маань өндөр хүнээс хариу авах гэсэн шиг түүн тийш харж хэлэв.

-Тэгэхлээр энэ нөхөр өөрөөр яаж үймүүлж байдгийг ангийн нөхөд нь шүүж, шүүмжилж, ярих хэрэгтэй. Одоо хэн ярих вэ? гэж асуув. Гонгор гараа өргөж босоод,

-Төмөрсүх ер нь болдоггүй хачин хүүхэд байгаа юмаа. Эртээ манай өвөөгийн нүүрэн дундуур үхрийн нойтон баасаар шидсэн. Өнөөдөр бас намайг хоёр хурууны чавхаар харваад нүд сохолч шахсан. Ер нь болдоггүй юм гэж намайг муулав. Би түүний зүг учиртайгаар хялалзлаа.

-За тэгсэн чинь үнэн үү? гэж багш асууж байна. Би:

-Үнэн. Гэхдээ бид зүгээр байхад нь... энэ чинь өөрөө намайг дандаа л өдөөд дарлаад байдаг юм гэж хэллээ. Дараа нь Нямаа босож байна. Тэр охин багшийн зүг хараад байгаа хэр нь өрөөсөн нүд нь хаалга руу хараад байгаа юм шиг харагдаж байна.

-Энэ Төмөрсүхийн дэргэд би суудаг. Хичээл дээр хагархай гэдсээ гаргаад, дээр нь зураг зураад үймүүлээд байдаг юм. Бас миний гэзгийг номын савнаас уяж намайг дандаа шоглоод байдаг. Тэгээд хичээлээ ердөө үздэггүй. Ариун цэврийн хувьд хамгийн адгийн хүүхэд байгаа юм. Нэг их урт хумстай, нүүр гараа ч угаахгүй балиартаад байдаг. Хүзүү толгой нь жигтэйхэн хиртэй, чихэн дотор нь цул хар хир байдаг юм! Манай ангийн нэрийг гутааж байгаа ганцхан хүүхэд энэ л байгаа юм гэв.

Танихгүй өндөр багш намайг харж, тэр хүүхдийг харж инээмсэглэн сууснаа:

-За хөө, чи наашаа яваад ир! гэж надад хэлэв. Тэр хүний нүд нэг их хурц хараатай, давхраатай, бас тэгээд нүдний шилний цаанаас галт шилээр төөнөж байгаа юм шиг айхавтар харцтай байв. Би дэргэд нь очиж зогсоход

-Гараа! гэв.

Би гараа үзүүлэв. Миний гар өчигдөр хумсаа аваад, өнөөдөр сайн угаачихсан болохоор тэр хүн гайхаж байх шиг байв. Дараа нь миний чихнээс татаж, чигчий хуруугаа оруулж арчиж үзэв. Азаар би өнөөдөр нүүр гараа угааж дээ гэж би дотроо баярлаж байв. Дараа нь захнаас минь татаж, хоолой хүзүүг харлаа. Тэгээд тэр багш гайхсан маягтай Нямаагийн зүг харлаа. Бас багшийн зүг харлаа. Ангийн багш

-Өнөөдөр ч харин бузгай байна л даа. Ер нь ариун цэврийн комиссын хэлдэг ч үнэн л дээ гэхэд хүүхдүүдийн зарим нь инээмсэглэж шивир авир хийв. Нямаа зовсон байдалтай доошоо харж сууна.

Тэр сүрхий нүдтэй багш санаандгүй инээмсэглээд:

-За хө, чи тэгэхлээр яагаад багшийнхаа суудалд дардаг хадаас тавьсан билээ? Ямар санаатай тавьсан бэ? гэж их дотно зөөлөн дуугаар надаас асууж байна.

-За чи ямар санаатай тавьсан бэ? Шууд хэлчх! гэж багш шаардаж байна.

-Би Гонгорыг чадах гэж тавьсан юм гэж арай чамай хэлэв.

-Гонгорыг чадах гэхдээ багшийн сандал дээр тавьдаг учир юу билээ? гэж өнөөх хүн асууж байна.

-Энэ Гонгор, багшийг орж ирэхээс өмнө дандаа багшийн сандал дээр сууж багш болж, багшийг дуурайж анги үймүүлж байдаг юм! гэж миний хэлэхэд ангийн зарим маань

-Нээрэн тэгдэг юм гэж энд тэндээс дуугарлаа. Багш маань гайхан тэднийг харж байна. Тэгснээ:

-Ер нь тэгээд сүүлийн үед Төмөрсүхийг дагалдах маягтай хүүхэд ч гарч байна. Жишээ нь өнөөдөр Ганзориг хичээл дээр зөвшөөрөлгүй босоод Төмөрсүхийн хөвөнтэй цамцыг аваад шидэж өгсөн байгаа юм гэж, гол нь танихгүй багшид ховлож байгаа юм шиг хэллээ.

Багш босож ангийг эргүүлэн тойруулан хараад

-За өөр хэн ярих вэ? гэв.

Манай ангийнхан дуугүй ширээ сандлаа шажигнуулаад суугаад байна. Ангийн дарга Бат босож толгойгоо нэг илээд, хариуцлагатай хүний ёсоор аргагүй ярих ёстой гэсэн маягтай хэлэв.

-Төмөрсүх ер нь жаахан зүггүйтээд байх нь зүггүйтээд л байдаг юм. Заримдаа ангийн жижүүр хийхгүй тасалж байсан ч удаа бий. Гэхдээ тэр ч яахав. Нөхөөд хийлгэж болох юм л даа. Одоо тэгээд ангийн хурлаар хэлэлцэгдлээ хойшдоо томоотой болж засарч чадах юм уу? үгүй юу, өөрөө хэлнэ биз дээ гэв.

-За, чамайг ангийн нөхөд чинь зөв шүүмжилж байна. Чи хойшдоо томоотой байж чадах уу, үгүй юу. Эс чадвал сурагчдын зөвлөлөөр оруулна. Дараа нь сургуулийн багш нарын зөвлөлгөөнөөр оруулж хэлэлцүүлээд сургуулиас хөөх болно. Тэгвэл чи л хохирно доо гэж танихгүй багш хэлж байна.

Ангийн хурлаас намайг гурав хоног дараалан жижүүр хийлгэхээр шийтгэсэн юм.

Би “засарна” гэж амлалаа. Хичээл эрхлэгч багш:

-Тэр ангийн жижүүр тасалсныг нь нөхөж маргааш хийлгэ. Хоёр гурав хоног ч арай юу юм. Ангийн жижүүрийг чи хариуцлагатай сайн хийх хэрэгтэй гэв. Би дуртай нь аргагүй “За” гэж хэллээ. Энэ шинэ багшийн үгнээс гарч болохгүй юм шиг надад санагдлаа. Энэ багш загнахгүй мөртөө нэг л айлгаад байх юм.

-За Тайван багш аа, энэ хүүхдийг дахиад нэг хэрэг дэгдээвэл шууд л танд шилжүүлж өгөөд сургуулиас хөөлгөнө шүү! гэж манай багш хэлж байна.

-Одоо тэгэхээс яахав. Төмөрсүх л өөрөө мэдэж гэж тэр багш инээмсэглэж намайг ширтлээ. Ингэж энэ өдрийн явдал төгслөө.

Жижүүр хийсэн минь

Ангийн жижүүрийг тэр багшийн хэлснээр би хариуцлагатай сайн хийе гэж бодлоо.

Ангийн жижүүр өглөө эрт хүрч ирээд, анги дотор баруун буланд байдаг бөөрөнхий пийшинг галлаж ангийг дулаахан болгох ёстой. Дараа нь самбарын арчуур норгож, бас ангийн ширээ сандлыг арчих ёстой. Завсарлагаанаар хүүхдүүдийг ангиас гаргаад салхивч онгойлгох ёстой юм. Энэ ч уг нь бидний хийж чадах л ажил даа.

Би тэр удаа хагас сайны өдөр өглөө унтаж хичээлээсээ хоцорчхоод, яаран сандран гүйж номоо үнээний саравчинд чулуудаж орхиод хичээлдээ очилгүй Маахуур толгой дээр гараад, нэг жалгаас хавтгай төмөр олж өдөржин гулгаад жижүүр тасалсан юм. Үнэндээ би жижүүр хийхээс хойш суудаггүй юм. Яагаад гэвэл жижүүр хийх өдөр жирийн хичээлд сууснаас ажилтай байдаг болохоор залхуу хүрч уйдах нь гайгүй байдаг.

Энэ удаа би жижүүр хийх бэлтгэлээ гайгүй сайн хийсэн юм. Манай ангийн пийшинг өглөө эрт галч нар галладаг боловч хичээл орох үеэр гал нь бараг унтрах шахсан, анги мөлүүхэн болчихсон байдаг юм. Дараа нь жижүүрүүд түлээ нүүрс авчирч хийх боловч хагалсан түлээ нь нойтон байх учраас асахгүй шад пад гээд л бид даараад бор шувуу шиг хугжийчихсан суудаг байсан юм.

Би, манай жолооч хампааныхаа бензинээс жижигхэн шилэнд хийгээд бөглөж авлаа. Гэрээсээ нэг чүдэнз нууж аваад өвөртөлчихсөн юм. Тэгээд гэрийн даалгавраа хагас дутуу хийгээд эртээ унтлаа.

-Энэ хүү яачхаа вэ? Хоолоо идчихээд л унтаад өгөх чив. Бие нь зүгээр байгаа даа гэж өвөө ээжээс сэтгэл түгшин асууж байсан юм.

Би жижүүртэй гэж өвөөд тайлбарлалгүй, дуугүй л хэвтэж байв. Өглөө эрт босоод би сургууль руугаа явлаа. Гадаа гармагц хацар дээр мөс авчраад наасан мэт Сэлбийн жавар нүүр хорсгон хайрч байлаа. Хотын дээгүүр цагаан уур манан, айл бүрийн гэрийн тоононоос утаа багсран битүү бүрхсэн боловч гэгээн тунгалаг өглөө байлаа.

Намайг ангидаа ирэхэд манай ангийнхнаас хэн ч ирээгүй байв. Гадаа аж ахуйн хашаанаас би тэвэр хагадас түлээ авчирвал хуруу чимчигнүүлэн хайрч байх бөгөөд хөлдүү улиас тул амархан асахгүй нь ил. Түүний дээрээс өглөө эрт галч нарын галласан гал аль хэдийн асаж дуусаад, дээр нь хийсэн нүүрс чандарт дарагдсан байна. Анги дөнгөж бүлээсэж байгаа боловч гадаа хүйтэн болохоор даруй мөлүүхэн болж улмаар хүйтэн болох нь гарцаагүй шиг санагдлаа.

Би зуухны амыг онгойлгож оруулж ирсэн хэдэн модоо чихээд дээрээс нь хогийн төмөр хувингаар баахан нүүрс авчирч пийшиндээ чихэж авлаа. Түүний дээрээс өнөөх шилтэй жаахан бензинээ цацав. Өөрөө пийшингийн амнаас их хол очиж байгаа нэг чүдэнз зураад зуухны ам руу шидэж орхилоо.

Бензин дүрхийн асахын хамт нүүрс бөөн хар утаа болон ангиар нэг савсав. Би дүрэлзэж байгаа дөлтэй хамт утаа савсаж байгаа пийшингийн аманд ойртохоосоо айж байлаа. Холоос нүүрс хутгадаг шилээгүүр лүү алхам алхмаар ойртсоор түүнийг аваад зуухны амыг хаасан боловч түгжээг түгжиж чадсангүй. Ангиар нэг утаа, асаж байгаа нүүрсний үнэр гаргахын тулд би бүх салхивчаа, тэр байтугай хаалгаа хүртэл жаахан онгойлголоо.

Ангиар гарсан нүүрсний үнэр утаа хоёр миний энэ арганд аргагүй жаахан багасгаж байтал манай ангийн зарим хүүхэд ирээд “Пөөх! паах!” гэж

гайхан хашхиралдав. Энэ нүүрсний утаа үнэр хоёр хичээл эхлэх үеэр бараг мэдэгдэхгүй болсон боловч харин энэ хүйтэн өдөр гурван цонхны салхивчийг цэлийгэл нээсэн болохоор ангид хүйт орчихжээ. Бидний амьсгаа амнаас гарахдаа манай өвөөгийн тамхины утаа шиг бөөн цагаан юм болж байлаа.

Би хичээл эхлэхийн өмнө шаламгайлан ангиа арчиж шүүрдэж, бас самбарын арчуурыг норгож, пийшингийнхээ амыг хаасан юм. Багш анх орж ирээд

-Ангийн жижүүр хэн бэ? гэхэд

-Би байна? гэж босож рапорт өглөө. Багш ангийг тойруулан харж байснаа:

-Чи ч бүр бузгай хариуцлагатай жижүүр хийж байх шив дээ. Сайн байна гэж намайг магтлаа.

Тэгтэл анги их хүйтэн байгааг удалгүй мэдээд багш:

-Анги чинь яасан хүйтэн байх юм. Нэмж галласан юм уу? гэж асуухад

-Галласан, багш аа гэж би хариултал миний яаж будилж галлаад ангийг ийм хүйтэн болгосныг мэдсэн нэг жаал арын ширээнээс

-Галлах гэж галдах шахаад, утаагаа гаргах гэж осгоох шахсан даа гэж аяархан хэлж, намайг дооглож байна.

Ингээд би завсарлагаа бүрээр хүүхдийг хөөж гаргаж байлаа. Бөөрөнхий пийшин удаан халдаг болохоор хоёр дахь цагийн хичээлийн сүүлчээс эхлээд анги их халуун боллоо. Гурав дахь цагийн хичээл ороход ангид байж суухын аргагүй халуун боллоо. Гадаа ч нар дээр гарч, жаахан дулаавтар болоод тэгсэн байж болох юм. Зузаан дээлтэй хүүхдүүдийн хөлс нь урсаж, зарим хүүхдийн нойр нь хүрч ширээн дээрээ бөхийн үүрэглэж байна.

-Энэ чинь одоо яасан халуун юм бэ? Хэн ингэж их гал өрдчихөө вэ? гэж багш гайхан асууж байна.

Би дуугүй байсан боловч хүүхдүүд

-Багш аа Төмөрсүх галласан юм. Төмөрсүх Төмөрсүх гэж хашхиралдав.

Би жижүүрийг их хариуцлагатай сайн хийх гээд ингэж сүрхий галласныхаа төлөө харин буруутан болж таарлаа. Юу гэвэл манай ангийн хоёр хүүхэд маргааш нь хичээлдээ ирээгүй бөгөөд тэр хоёр халууцаж хөлөрч байгаад нимгэн хувцастай гүйж гараад хатгалга өвчин туссан байжээ.

Ангийн жижүүрийг хийхэд үнэхээр хариуцлага байдаг юм байна гэдгийг би тэгж мэдсэн юм.

Өвөөг архианаас гаргах гэсэн минь

Энэ явдал Цагаан сараар болсон юм. Гэхдээ манай хашаанд ч биш, сургууль дээр ч биш, харин Умаа эгчийн хашаанд болсон хэрэг юм шүү. Тэр хашаа Төв эмнэлгийн зүүн урдхан баруун тийшээ харсан нэг доголд байсан юм. Андашгүй, тэр доголын урдах өнцөг дээр ба баруун тийшээ харсан архины мухлаг байдаг юм.

Умаа эгч над шиг үсээ хусуулчдаг, цул үрчлээ болсон нүүртэй намхан бөгтөр эмгэн байсан юм. Түүний нас нүүрийнхээ үрчлээ шиг л тун их байсан байх. Яагаад гэвэл манайхан цөмөөрөө “эгч” гэдэг. Тэр байтугай өндөр өвөө хүртэл түүнийг “эгчээ” гэдэг байсан юм. Тийм их настай хүн болохоор нь бид жил бүр очиж золгодог ёсоороо үдээс хойш тэднийд очсон юм.

Умаа эгч хашааны голд байшингийн дэргэд барьсан жижигхэн өмгөр гэртээ оруулж бидэнтэй золгоод хонины тарган ууц, идээ, битүүллэг тавьж дараа нь банш чанаж өгдөг юм. Тийм сайхан амттай банш өөр айлд ер идэж үзээгүй шиг санагддаг сан. Бас жаахан айраг халаагаад өгч байх ч магадгүй. Дараа нь эгч бид хоёрт чихэр боов, ээжид жаахан хоргой ч юм уу, гоё алчуур ч өгөх магадгүй. Өвөөг бол ахтай хамт шимийн архиар заавал дайлна.

Сэдэд ах бол ахмад цолтой дарга хүн. Гэхдээ Умаагийн хүү юм гэнэлээ. Намхан тагжгар бор хүн байдаг юм. Умаа эгчийнд дайлуулж бэлэг сэлт авсны дараа тэр ах биднийг гэртээ урьсан юм. Гэртээ ч гэж, үнэндээ эгчийн гэрийн зүүн талын урт нарийхан намхан цагаан байшинд урьсан. Ахын авгай элдэв ногоо пүнтүүтэй гоё хуургаар дайлсан юм. Өвөөг бол шимийн архиар биш, шилтэй гоё хүрэн архиар дайлсан шүү. Адаг сүүлд нь тэд гараад явахдаа намайг дүүгээ харж бай гэж үлдээлээ. Дүү охин сэрээд орон дээрээс мөлхөж уначих магадгүй тулд би түүнийг харахаар үлдсэн юм.

Би цэргийн ахын хувцсыг сонирхож, малгайг нь өмсөж толинд харж үзлээ. Надад их сайхан зохиж байх шиг байсан. Дарга малгай их сүртэй гоё байдаг юм. Дараа нь би ширээнд очиж суугаад өвөөгийн үлдээсэн хуурганаас нэг үмхлээ. Ширээн дээр өвөө ах хоёрын ууж байгаад үлдээсэн шилтэй архи байна. Бөглөөг аваад үнэртээд үзэхэд их сайхан хүж шиг үнэр гарч байна.

Архи ер нь их сайхан амттай байх. Тийм биш бол өвөө чихэрт дургүй мөртөө архинд юунд дуртай байх вэ? Энэ хүрэн архи лав тоорын компоод шиг их сайхан амттай байх. Эсвэл зөгийн бал шиг ч байж магадгүй.

Ингэж бодоод би энэ олон таван хошуутай архины шилийг ам руугаа тонгойлгож, нэг томхон балгаж орхилоо. Тэгтэл хамаг ам хэл, хоолой шатаачих шиг санагдаад хоёр нүднээс аяндаа нулимс асгаж, амьсгаа ч авах аргагүй боллоо. Би уйлах шахлаа.

Өвөө ийм хор шиг хачин муухай юманд яагаад дуртай байдаг юм бэ гэж жигтэйхэн их гайхлаа. Энэ лав уух юм биш, хор байх шүү! Хор идсэн чоно нохой үхэхгүй бол галзуурдаг гэж өвөөд нэг анчин хүн ярьж байсан юм. Өвөө ч бас энэ архиа уухаар галзуу нохой шиг хөл нь гуйваад ирдэг юм. Хор уучаад галзуурах шахаад байгаа нь тэр байх. Өвөөг одоо архи уулгаж байхаа байя гэж би хатуу шийдлээ.

Дүү сэрээд уйлахаар би пальтогий нь өмсүүлээд өргөж гэрт орлоо. Түүнийг эх нь авч намайг суутал өвөө архинд явах гэж байгаа бололтой.

-Ганцхан шил л хэрэгтэй. Шилий нь өгөөд би одоохон урд мухлаг хаачхаас өмнө ганц шил юм аваад ирье. Ах нь дүүтэйгээ ганц шил юм уулгүй яах вэ гэж байна.

Сэдэд ах над руу хараад:

-Миний дүү байшинд ороод хувцасны шүүгээний дэргэд ёроолд нэг хоосон лонх байгаа, аваад ир! гэж байна.

Би гүйж тэр шилийг нь өвөөд авчирч өглөө. Өвөөг мухлаг руу явахад би бушуухан байшинд орж, Сэдэд ахын шинел, дарга малгайг өмсөж аваад хашааны хаалганы дэргэд зогсож өвөөг харуулдаад байлаа. Өвөө мухлагт орчоод архи зардаг хужаатай яриад байх шиг байв. Одоо бүрэнхий болоод гудамжинд байгаа хүний царай бараг танигдахгүй болж байна.

Би өвөөгийн ганц шил архийг уулгахгүй булааж аваад хагалах гэж хүлээж байв. Өвөө одоо архи ууж болохгүй. Хороо уугаад галзуурдаг дээрээ л байх шиг байна. Одоо яасан ч архи уулгаж болохгүй гэж бодож байв.

Нэг хартал мухлагийн хаалга нээгдэж цаад гэрэлд нь манай өвөө өрөөсөн гараа өвөртөө хийчихсэн, нөгөө гартаа шилтэй юм бариад гарч ирэх нь хоромхон үзэгдээд хаалга хаагдмагц үзэгдэхгүй боллоо. Би хашаанд наалдаж хаалганы дэргэд ирмэгц барьж яваа шилтэйгээс нь шүүрээд авлаа. Өвөө гэнэт цочиж:

-Хө чи яаж байна, хүүхээ! Хүний юм булаах чинь үү? гэнгүүт ноцолдохын зуур бөхийж тасарч байгаа үдшийн гэгээнд намайг цэрэг хувцастай цэрэг малгайтай хүн болохыг хармагц:

-Хэн бэ чи? Цэрэг цагдаа хүн үү? Би согтуу хүлцүү ч хүн биш байна. Наадахаа тавь! гээд шилтэйгээ надаас угз татаад автал гараасаа нөгөөдөхөө мулт үсэргээд алдав. Архи нь гудамжны чулуун дээр унаад хагарч орхилоо. Миний санасан санаа ёсоороо боллоо. Би бушуухан харанхуй догол руу дув дуугүй зугтаалаа.

Өвөө хараал тавьж бөхийн, өнөөх шилтэйгээ хагарсныг мэдээд хаалгаар яваад орлоо. Би тэр хооронд цаашаа гүйж байшинд ороод Сэдэд ахын шинелийг шүүгээнд өлгөөд гэрт орж хатавчинд зогсов. Өвөө бүр гутарч гүйцсэн бололтой тамхиа баагиулан:

-Ээ дээ энэ жил ч би үхнэ ээ. Цаанаа л нэг яваагүй байна. Амны минь хишиг бүр нэг ар дээрээ гарч гүйцсэн шиг байна гэж үглэж байна.

-Ямар золиг нь танаас архи дээрэмдэж уух гэдэг юм бол? гэж Сэдэд ах гайхаж байна.

-Ямрыг бүү мэд. Нэг намхан салбаганасан юм хүрч ирээд ноцолдож байгаад хагалуулчихлаа. Хулгайч дээрэмчин юм уу гэтэл цэрэг цагдаа хувцастай хүн шиг харагдах юм гэж өвөө хэлж байна.

Би дотроо “Өвөө намайг таньсангүй!” гэж бодоод инээд хүрч байв.

-Үгүй энэ гайхал арай биш байгаа даа. Хараач гээд Сэдэд ах над руу харцаараа гэнэт зааж орхилоо. Би “Ах намайг яагаад таачхав?” гэж гайхахдаа хувцас руугаа харлаа.

-Аав минь, энэ гайхал тэгснээс гарцаагүй. Энэ малгайгий нь хараач гээд ээжийг над руу ухасхийх үеэр би гарч зугтах гэсэн боловч босгонд таварцаглаад баригдаж орхилоо. Умаа эгч бас намайг зэмлэж, миний “дэггүйг” гайхлаа.

Тэгвч би өвөөгийн уух гэсэн архийг санаатай санамсаргүй асгах, нууж чинжүү холих зэргээр өвөөгөө архианаас гарах тэмцлээ үргэлжлүүлж байлаа.

Японтой байлдсан минь

Эгчийн энэ хашаанд урьд нэг ирэхдээ би Японтой байлдсан юм. Та нар намайг худал хэлж байна гэж битгий санаарай. Би багадаа амьд Япон хүнийг нүдээрээ үзсэнээр барахгүй, нэг удаа тэдэнтэй тулалдаж ч үзсэн юм. Тэр бол жүжиг кинонд манай жүжигчдийн тоглосон “дуураймал” Япон биш шүү, харин 1945 оны дайнд манай Галдан ахтай буудалцаж явсан дайсны цэргээс олзлогдож ирсэн ёстой амьд Япон байсан юм. Тийм болохоор ёстой дайсны цэрэг Япон шүү.

Намайг сургуульд орсны намар билүү, дараах намар нь билүү, би сайн санахгүй юм. Би 1947 онд сургуульд орсон юм. Төв сувиллын хашааны зүүн урд булангийн нэг цонх хаалга нь битүү байдаг байшингийн баруун талд түр зуур босгосон намхан урт модон урц оромжинд хэдэн Япон сууж, газар шорооны ажил хийж байсан юм л даа.

Тэр өглөө би эгчийн хашаанаас гарч зам хөндлөн огтлоод Төв сувиллын хашааны урд гудамжаар баруун тийшээ орж Японы байшинг зүглэв. Хашааны гадагш хандсан цонхонд нь хүрээд сэмхэн шагайж харсан юм. Ингэж гаднаас нь сэмхэн тагнаж харахад өрөөнд хэн ч алга. Харин цонхны тавиур дээр жижигхэн танк, нисэх онгоц, их буу, янз бүрийн модон тоглоом өрөөстэй харагдаж байлаа.

Энэ хэдэн Япон дайнд ялагдаж олзлогдсон мөртөө бас хашрахгүй хүүхэд шиг “байлдаж тоглох” дуртай хэвээрээ юм шиг байна шүү дээ.

Харин би бол дайсны танк, их буу, онгоц, хамаг зэвсгийн байрыг илрүүлж олсон жинхэнэ тагнуулч хүн шиг тэр тоглоомыг их шохоорхон харж байлаа. Цонхны гялбааг хоёр гараараа таглаад нэг харсан чинь дайсан бас намайг илрүүлж харчихсан байна. Нэг бандгар хөвөнтэй зэгэл ногоон өмд цамцтай, намхан Япон хашхирч байгаа тарвага шиг дорсгой шүдээ ярзайлгаад, намайг харж, инээмсэглэн баруун талаар тойроод хашааны хаалгаар ороод ир, би чамд энэ тоглоомноос өгье гэж байгаа бололтой богинохон мөгжгор хуруугаараа зангаж дохиж байна.

Би Японыг дайсан гэж мэдэх тулд их л болгоомжлон, баруун талаар нь явж хашааны хаалгаар ороод өнөөх байшинд орлоо. Юухан ч гэсэн сэжигтэй юм болбол гараад зугтахад бэлхэн байдалтай явж тэр Японд хүрч очлоо. Тэр Япон намайг харж ярзайтал инээснээ цаашаа эргэж цонхон дээрээс модон танк авч надад өгөөд намайг буцаад гүйх гэтэл мөрөн дээрээс минь барьж аваад хэд алгадаж, эцэст нь өвдгөөрөө бөгс рүү минь нэг сайн түншиж аваад, түлхэж гаргаад агдганан инээж байна.

Миний хацар халуу оргиж, бөгс өвдөж байсан боловч “дайсанд баригдсан байлдагч уйлж урваж болохгүй” гэдгийг Галдан ахаас сонсож мэдсэн болохоор уйлсангүй. Харин ч уур хүрч, Японтой тулалдахаар шийдээд эгчийн хашаа руу гүйлээ.

Орж хөвөнтэй цамцаа яаран өмсөж аваад гарлаа. Түүний халаасанд миний мэргэн буу байсан юм. Өөрөө хэлбэл улаан сунадгаар хийсэн сүрхий чавх билээ. Дайснаас олзолж ирсэн жижигхэн модон танкаа би нөгөө талын халаасанд нь хийлээ. Дараа нь хашаанаас гарч фронт руу, өөрөөр хэлбэл Төв сувиллын урд гудамж руу гүйлээ.

Японы байшингийн эсрэг харгалдаад урд талдаа их бага хоёр хаалгатай нэг айлын хашаа байсан юм. Албан газрын байр ч юм уу, бүү мэд. Ар талд нь хоёр байшингийн хоорондуур хойшоо гардаг нэг онгорхой цонж байсан юм. Хоёрхон шургааг аваад хаячихсан зай байв. Би тэр завсраар энэ хашаанд орж түүний ёроол хавиас хэдэн сайхан сум (тэмээний хорголын чинээ бөөрөнхий чулуу) бэлтгэж авлаа.

Тэгээд тэр хашааны ард нуугдаж, өнөөх хоёр шургаагийн завсраар хөндлөн гудамжны эсрэг талд харгалдаа байгаа Японы байшингийн зүг харвал миний урд тэр байшин яг эгц эсрэг харагдаж байна. Эндээс хүн намайг авсаар

ажиглахгүй, харин надад дайсны хамаг юм ив илхэн байх тулд тулалдахад онц сайхан газар байна. Би өөрийгөө хоргодомж дотор бүгсэн мэргэн буудагч гэж саналаа. Тэгэхээр дайн тулаан өдөөн хатгасан Японы байшин руу юу ч болсон нэг сум шүнгэнүүлж туршлаа.

Өнөөх тоглоом өрөөстэй байсан цонх хага үсрээд явчихлаа. Үүнийг та нар харсан бол намайг ёстой л нэг мэргэн буудагч шиг онолоо оо гэх байсан даа. Хашааны завсраар өрөөсөн нүдээр зэрвэс харахад намайг өдөж зодсон өнөөх Япон цонхонд ойртоод ирчихсэн хагархайгаар нь гадагшаа харж байлаа. Би завдан нэг сум цэнэглэж (чавхны булигаарт чулуу хавчиж бэлдэхийг хэлж байна) аваад өнөөх Японы духан дээр чиглүүлж байгаад хашааны завсраар дахиад нэг сум явуултал тэр Япон шовос гээд алга болчихлоо.

Миний нүдэнд харагдаагүй боловч миний санаанд тэр Япон өдийд духан дээрээ хорголын чинээ булуутай болчихсон шалан дээрээ тэрийж унасан харагдаж байсан юм. Би түүнийг үхсэн гэж итгэж байлаа. Түүнийг хоёр Япон хүн гар дамнуурга дээр тавиад зүүхэнтэй нь байгаа битүү хар байшин тийш зөөж яваа байх ч гэж бодлоо.

Би энэ аятайхан хориглолт хоргодомж дотроосоо нүүрээ шургаагийн хажуугаар хагас цухуйлгаж өрөөсөн нүдээрээ нэг харахад байшингаас баруунтайгуур хашааны хаалган дээр хэдэн Япон ирчихсэн манаачтайгаа ярьж байгаа харагдав. Манаач нь тэднийг гадагш гаргахгүй нь лав. Ийм болохоор би тэр зүг жишүүхэн чиглүүлж байгаад хэдэн сум дараа дараагаар шүнгэнүүлж орхилоо. Тэд хэдийгээр тэрийгээд ойчих нь надад харагдаагүй боловч миний зарим сум тэдний нуруу, эгэм, мөр хаа нэгтэй нь оносон гэж тооцоолон бодлоо. Удалгүй тэр Япончууд цаашаа далд орчихсон байсан юм. Тэгэхлээр би Японы дайралт давшилтыг аргагүй л няцаасан шиг санагдаж байлаа.

Хашааны завсраар нэг харсан чинь Японы манаа намайг харчих шиг санагдлаа. Би нэгэнт Япончуудтай амжилттай тулалдсан тул одоо энэ ялгуусан тулалдаанаа түр зогсоох юм уу, наад зах нь дайсанд сэжиг авахуулсан байж магадгүй хоргодомжоо солих хэрэгтэй боллоо.

Иймд би хоёр байшингийн хоорондуур хашаан дундуур гүйж, урд нүүрний нь жижиг хаалгаар гарч тэр хашааны ёроолоор нуугдан зүүн тийш явлаа. Хашааны буланд хүрээд хар хурдаараа гудамж хөндлөн гарч эгчийн хашаанд орлоо.

Умаа эгч дүүг хараад гэртээ сууж байна. Эмгэн

-Чи хаашаа алга болчихоод байна? Юм идээч, өлсөхгүй байна уу? гэж асууж байна. Би:

-Гадаа жаахан тоглоод ирлээ. Юм идэхгүй ээ. Өлсөөгүй гэж хариу хэлээд дотроо “Тулалдааны үед байлдагч хүн, тэр дундаа мэргэн буудагч хүн юм идэж болохгүй” гэж бодож байлаа. Би энэ тулалдаанаа төгс ялалтаар дуусгахыг бодож байлаа. Одоо бол дайснаас олзолсон танкийг их буугаар галлаж шатаах хэрэгтэй байлаа.

Үүний тулд би эгчийн нүдийг хариулж байгаад дөрвөлж дотроос нь хэдэн зомгол авч гарлаа. Дараа нь ахын байшинд сэмхэн орж, хувцасны шүүгээн дээр тавьсан жаахан эмийн шилтэй бензинийг авав. Үүнийг Сэдэд ах асаагуурынхаа хөвөнд шингээж хийдэг юм. Бэргэн эгч бол харин пальтоныхоо

захын хавь газрын хирийг юм уу, толбыг аанай л хөвөнд юм уу, мааралд шингээж арчих дуртай байдаг юм. Би бол одоо үүнийг дайсны танкийг устгахад хэрэглэнэ. Бас аяга халбага хийдэг товхон шүүгээн дотроос хайрцагтай чүдэнз олж авлаа. Хэдхэн ширхэг галт сум (чүдэнз) байна.

Тэгээд сэмхэн гарч жижигхэн модон танкаа муу усны нүхний амсар дээр тавилаа. Дээрээс нь хэдэн зомголоо өрлөө. Дараа нь түүн дээрээ шилтэй бензинээс жаахан асгалаа. Тэгээд яльгүй холдож сууж байгаад галт сумаар танкийг галлаж гарлаа. Өөрөөр хэлбэл чүдэнз зураад танк руу шидсэн юм. Анхны галт сум замдаа унтарчив.

Дараах нь хажууханд нь туссан боловч дайсны танк түрс гээд аслаа.

Би сандраад хашааны буланд овоолттой байсан хугархай туйпуугаар нүүлгэж гарлаа. Энэ бол танкийг уулын цаанаас их буугаар буудаж байгаа юм. Хэд хэд шидээд оносонгүй. Би улам ойрхноос галладаг боллоо. Адаг сүүлд нь нэг сум ашгүй онож шатаж байгаа танкийг танк эсэргүүцэх шуудуунд унагалаа. Өөрөөр хэлбэл муу усны нүхэд унагасанд тэнд өнөөх танк бараг нүүрс болчихсон утаа баагьж байна. Энэ бол надад том ялалт байлаа. Дайсны танк үнэхээр шатаж байх шиг санагдаж байлаа.

Энэ үеэр Умаа эгч гарч ирээгүй нь яамай. Гараад ирсэн бол чи гал тавьж хашаа байшин шатаах нь гэж загнах байсан юм. Тэгсэн бол Японтой тулалдсан миний ялалтыг жаахан базаахгүй болгох байсан юм. Гэвч гал түймэр гаргалгүй дайсны танк устгаж чадсан болохоор ер нь азтай л өнгөрсөн юм.

Маргааш өглөө нь би мөн эрт босоод хураалттай түлээн дээр гарч хашаан дээгүүр толгойгоо цухуйлгаад дайсныг (өөрөөр хэлбэл Японыг) ажиглаж байлаа. Тэгтэл хүүрийн Лувсан гэдэг өвгөн морин тэргэнд юм ачаад дээгүүр нь юмаар бүтээчихсэн өөрөө мориныхоо хажууханд зэрэгцэн явж байна.

Би үүнийг өчигдөр миний тонилгосон Японы хүүрийг ачаад явж байгаа юм гэнэлээ гэж бодлоо. Тэгээд дайсныг бас нэг мэргэн сумаар үдэхээр шийдлээ. Сундаг улаанаар хийсэн мэргэн буугаа хөвөнтэй цамцныхаа халаасанд бэлэн авч явдаг газраасаа гаргаж ирээд сумлаж (чулуу тааруулж) Лувсан гуайн үнэт ачаа руу чиглүүлж байгаад харваад тавьчихлаа.

Тэгтэл гай бол энэ удаа би онох гэснээ оносонгүй. Харин морины ташаан толгой дээр оносон бололтой. Лувсан гуайн морь гэнэт ухасхийн үргэсэнд өвгөн юу болсныг мэдсэнгүй.

-Өө үхээрийн сөдрөг чинь яаж байгаа юм. Байтлаа зүгээр байгаад бусгаж туйлдаг болох чинь үү? гэж морио загнаж байгаа дуулдав. Энэ өвгөн ер нь морьтой ярьдаг зантай юм. Морь нь ч түүний хэлийг мэддэг юм уу гэж би боддог сон.

Би ингэж хэдэн жилийн өмнө сургуулийнхаа намрын амралтын үеэр Японтой тулалдсан юм даа.

Их эндэгдэл

Удалгүй нэг мэдэхэд Сүхбаатар жанжны төрсөн өдрийн ой болов.

Сүхбаатар надад нэг л танил дотно санагддаг юм. Яагаад гэвэл бидний нэр их ойролцоо. Хоёулаа л сүх гэсэн үгтэй. Сүх-баатар, Төмөр-сүх гээд

хэлээд үзэхээр би их жанжинтай төрөл садан юм шиг санагдаад явчихдаг юм. Би Сүхбаатарын хүү юм уу, эсвэл хүүгийн хүү нь ч байж болмоор санагддаг.

Би таван жил баатарчуудын гишүүн байлаа. Баатарчууд гэдэг нь бас Сүхбаатарын хүүхдүүд гэсэн утгатай байх.

Сүхбаатар жанжны мэндэлсэн ойгоор манай ангийнхныг пионерт элсүүлэх болов. Пионерийн удирдагч багш бидэнд яриа хийхдээ:

-Та нар бол жанжин Сүхбаатарын хойчийг залгамжлагчид юм. Ийм учраас их жанжны төрсөн өдрийн ойгоор цөмөөрөө пионер болж залуу Сүхбаатарчууд болох ёстой гэсэн юм.

Ийм болохоор пионер болно гэдэг Сүхбаатар жанжны хойчийг залгамжилж, залуу Сүхбаатар болно гэсэн үг юм. Би Сүхбаатар шиг баатар жанжин болохыг хүсэлгүй яахав. Харин тэр багш хамгийн сүүлд:

-Пионер хүн сайн сурдаг, сахилга батыг онц сайн сахидаг, ариун цэвэрч тэргүүний хүүхэд байх ёстой гэж хэлсэн юм. Манай ангийн багш:

-Та нар пионерийн гишүүнд элсэх гэвэл сайн, онцсайн сурах хэрэгтэй. Сахилга батыг хатуу сахих хэрэгтэй гэж байсан юм.

Би хагас жилийн шалгалтаар муугүй дүнтэй суралцсан боловч харин сайн сурсан эсэхийг мэдэхгүй. Бас тэр өдөр болтол томоотой байж чадах болов уу, яах бол? Аягүй бол намайг сайн сурдаггүй, сахилга батгүй гээд пионерт элсүүлэхгүй байх вий гэж айж байлаа.

Би пионерт элсэж улаан бүч зүүхийн тулд томоотой байхыг боддог боллоо. Бас хичээлдээ ч жаахан хичээж үзлээ. Харин дандаа л мартчихаад нэг мэдэхэд дахиад үймүүлчх гээд их хэцүү юм. Ер нь пионер болчихвол дараа нь сайн сурч, сахилга баттай сурагч болж чадмаар юм шиг санагдаж байлаа.

Хүсэн хүлээсэн жанжны төрсөн өдрий ой ч боллоо. Бид ч пионерт элсэх боллоо. Би пионерийн тангаргыг цээжээр уншвал жаахан алдах гээд байдаг боловч нөхдөө дагаад ер дажгүй уншихдаг юм.

Чингээд биднийг жагсааж байгаад манай бүлгийн удирдагч дээд ангийн эгч бидний хүзүүнд улаан бүч зүүж өглөө. Бас энгэрийн тэмдэг хадаж өглөө. Тэр тэмдэг зүүчихсэнийг харахад бид бултаараа Сүхбаатартай адилхан болсон байв. Сүхбаатарын зургийг би үзсэн юм. Сүхбаатар яг бидэн шиг ганцхан одон зүүсэн байдаг юм.

Тэгтэл надад нэг гай тохиолдлоо. Би гадаа жаахан зогсох юм уу даарахаар хамраас минь нус гараад ирдэг юм. Биднийг пионерт элсээд зогсож байтал миний тэр гайтай нус бас гараад ирсэн юм.

Пионерийн удирдагч багш миний дэргэд хүрч ирээд

-Наад нусаа арч! гэж тушаалаа. Би нусны алчуур тогтоодоггүй хүүхэд байсан юм. Нэг л мэдэхэд тэр хөөтэй алчуур өмдний халааснаас алга болчихсон байдаг юм. Энэ удаа би яаран өмднийхөө халаасанд гараа шургуулсан боловч алчуур байхгүй болохоор сандрахдаа улаан бүчнийхээ үзүүрээр шудраад тавьчихлаа.

Тэгтэл тэр уучилж болшгүй том алдаа болжээ.

-Пионерийн улаан бүчээр нусаа арчдаг ийм ухамсаргүй, сахилга батгүй сурагч пионер байж таарахгүй гэж манай удирдагч багш дангинаад намайг даруй пионерийн гишүүнээс хөөж орхилоо. Миний улаан бүчийг шувт татан

авч тэмдгийг минь ч хураалаа. Хүүхдүүдийн зарим нь жиг жуг инээлдэж байна.

Харин би уйлмаар санагдсан боловч зөвхөн миний хамар шархираад нүднээс нулимс гарах нь хамраас нус гардагтай адил бэлэнгүй юм. Тэгэхээр нүдэнд ус цийлгэнэмээр болоод больчив.

Би ингэж пионерийн гишүүнд хэдхэн минут байсан болохоор пионерт элсэх надад бүр ч гойд сайхан санагдах боллоо.

Хойтон жил л заавал залуу Сүхбаатарч больё. Тэр өдөр яасан ч нусныхаа алчуурыг мартаггүй дээ гэж би дотроо тангараг өргөх нь холгүй байлаа. Пионерийн гишүүн хүн улаан бүчээ цэвэр ариун авч явалгүй болдоггүй юм шүү.

Гэмшил

Пионерт элссэн даруйдаа хөөгдсөн явдал надад нэг л гомдолтой бөгөөд ичгүүртэй байлаа. Би ангийн нөхдийнхөө адил улаан бүч зүүгээгүй, энгэртээ тэмдэг хадаагүй болохоор нэг л хачин цулгүй сүргүй харагдаад байх шиг санагдаж байлаа.

Тэр орой гэртээ их л урамгүй харьж явтал миний хойноос зэвүүн жаал Гонгор гүйж ирэв. Түүний хүзүүнд улаан бүч намирч, энгэр дээр нь пионерийн тэмдэг гялалзан, энэ маань одоо баатар эр шиг сүртэй зоригтой алхаж явааг би мэдэж байсан боловч түүн тийш харахгүйг хичээн алхлав.

-Ийрэл саарал найз минь, чиний пионерт элсэхтэйгээ зэрэг хөөгддөг чинь ямар байна даа? гэж тэр намайг өдөн асууж байна.

Би үүнд харамсан гутарч яваагаа мэдэгдэхгүйг хичээж:

-Аа үхсэн, яадаг юм гэж ажиггүй царай гаргалаа.

-Яадаг юм гэнэ хи-хи-хи. Чи багшийн хэлдгээр ёстой сахилгагүй хүүхэд юм даа гэж Гонгор хэлж байна. Түүний шар лууван шиг гулжгар ягаан царайд намайг шоолсон инээмсэглэл тодорч байгааг мэдэж байсан боловч уруугаа харсан чигээрээ:

-Хуц! Чи өөрөө ёстой хулигаан! гэж хариуцан мэтгэв.

-Хи-хи-хи. Би хулигаан байсан бол яаж пионер болох юм. Чам шиг л хөөгдөж орхино биз гэж намайг Гонгор “дарлаж” гарлаа.

-Аа муу сэмхэн олгой чи юу гэж хүн өдөөд байгаа юм. Хохь чинь шүү гэж би хор хөдлөн сүрдүүлэв. Гонгор хажуу тийшээ огло үсэрч:

-Ий яадаг билээ. Би айж байна. Би пионер хүн шүү. Зодчихов мэдээрэй гээд дээрэлхэж гарлаа.

Миний уур гэнэт хүрч, хатгаж өдөгчийн шилэн хүзүүн дээрээс базаж аваад татаад орхисон чинь улаан бүчийн нь цуулаад хоёр хэсэг болгож орхилоо.

Намайг өөрийгөө зодно байх гэж бодож байсан Гонгор гэнэт улаан бүч нь арын хошуун талаараа цуураад хоёр хэсэг болж ойчихыг хармагц:

-Аа ямар онгироо илжиг вэ чи. Тоглож байхад... гэж хэлээд царай нь хөрзийж, хоёр нүдэнд нь ус цийлэлзээд ирэв.

Би ч бас ийм хорлолтой юм санаандгүй хийсэндээ эвгүй болсон боловч:

-Хохь чинь! Чи тэгвэл яах гэж намайг юунд дээрэлхээд байсан юм бэ гэж хэлчхээд халуун усны зүүн талаар ороод гүйв.

-Чи улаан бүчий минь төлж өгөөрэй! гэж араас хашхираад хоцров.

Энэ хэрэг бүр ч балагтай юм болов. Гонгор намайг улаан бүч цуулаад хаячихсан гэж багшид хэлсэн байна. Би өнөөх надад хэрэггүй болсон улаан бүчээрээ түүний нь төлж өгсөн боловч бас нэг сүрхий буруу надад оногджээ.

Би сургууль дээрээ “Сахилгагүй сурагч”, гэр орондоо “Эдлэхийн аргагүй жаал” гэж нэртэй цуутай болжээ. Зарим томцуулыг би их мартамгай улс гэж боддог байсан юм. Жишээ нь манай өвөө чүдэнзээ гартаа барьчаад эрээд байх ч магадгүй байдаг юм. Тэгвэл томцуул зарим юмыг ердөө мартдаггүй улс юм. Би, өөрийнхөө хийсэн хэргийг аль хэдийн мартчихсан байхад багш нар, томцуул тэр бүхнийг тун саяхан биеэрээ хийсэн юм шиг л нэгд нэгэнгүй санаад “Энэ ингэдэг жаал”, “Тэгдэг ч хүүхэд” гээд л яриад салахгүй юм. Ярих дурдах болгонд нь би тэр буруутай хэргийг дахин дахин хийгээд байгаа юм шиг надад нэг л эвгүй байх юм.

Осол эндэгдэл бүхний минь хүн мартаж уучлахгүй болохоор би зөндөө их хэрэг тарьсан, шийтгүүлээд барахгүй ялтай жаал болсон шиг санагдах юм. Дондог гуайн яриад байдаг “шоронгийн тав” гэдэг нь болох шахсан юм болов уу? гэлээ ч би гав ганцаараа байж тав болох нь хачин аа! Ер нь нэг л аймаар их л буруутай хүн болоод байх шиг. Томцуул, багш, ээж, өвөө цөмөөрөө л эвсээд намайг муулаад байх юм. Санаандгүй хийсэн бүхнийг минь санаатай гэж загнах юм. Ингэхлээр ер нь ингэж гүжирдүүлж явсны ч хэрэггүй шиг. Эсвэл тэр бүхнийг минь мэдэх дурсах хүн огт байхгүй, өөр газар ч оччихмоор.

Саяын хоёр дахь өдөр ангийн багш миний ээжийг дуудаж аваачаад хийсэн үймүүлсэн бүгдийг минь хэлээд сурагчдын зөвлөлөөр оруулж арга хэмжээ авахуулна гэж хэлсэн гэнэ. “Арга хэмжээ” гэж надаас юу авах гээд байгааг бүү мэд. Энэ хачин үг ер нь шийтгэнэ гэсэн үг шиг надад заримдаа санагддаг юм. Заримдаа болохоор энэ үг ажил хийлгэхийн нэр байдаг юм. Эртгээр манай захирал ангийн багшид маань “Ангиа тохижуулах арга хэмжээ ав” гэсэн юм. Тэгтэл багш биднээр цонхны хөшиг угаалгаж, ширээ сандал хадуулж зөндөө ажил хийлгэсэн юм.

Ээж болохоор намайг “Чи надад ёстой үйлийн үрээр учирсан үр. Намайг зовоох гэж төрсөн амьтан” гээд үглэж байх юм. Энэ юу гэсэн үг болохыг би сайн ойлгохгүй боловч тийм хачин юм бодож ээжээс төрөөгүй л баймаар юм. Би ер нь юу бодож яаж төрснөө огт мэдэхгүй юм. Тэнэг жаал болоод тэр юм болов уу?

Миний пионерийн гишүүнд элсээд хөөгдсөн, хүүхдийн улаан бүч цуу татсаныг өндөр өвөө маань бас дуулчихсан байна. Тэгээд манай өвөө их уурлавал юу барьснаараа цохих юм уу, шиддэг зантай хүн. Гэтэл энэ удаа тэгсэнгүй. Бага уурласан бол “Аа хүүхдийн зүггүй яах вэ. Тэгж байгаад томоожно биз. Миний ач хүү их томоотой сайн хүн болноо. Та нар харж л байгаарай” гэж намайг өмөөрдөг юм.

Энэ удаа өвөө маань тэгсэн ч гүй шал ондоо хүн болчихсон шиг намайг үзэгдээгүй хачин шийтгэж залхаалаа. Намайг аваачиж дэргэдээ цэргийн хүн шиг номхон зогсоож байгаад зөндөө удаан зэмлэсэн юм. Гэтэл надад хөдлөхгүй удаан зогсоно гэдэг бол хамгийн хатуу шийтгэл байсан юм. Тэгэхдээ бас ямар мартагын аргагүй хатуу үг хэлсэн гэж санана? Тийм айхавтар үгээр загнуулснаас суран бүсээр шалба ороолгуулбал хол дээр дээ. Юу гэвэл:

-Чи муу тэнэг, пионерийн гишүүнд элсэхтэйгээ зэрэг хөөгдөж миний нэр төрийг хугална гэнээ? Нэр хугарахаар яс хугар гэж үг ч байдаг. Ийм ач хүүтэй явахаа мэдсэн бол юунд ч партизан боллоо!

Би тэр цагт чамтай адилхан сургууль суялд (соёлд) явсангүй. Эрдэм ном заалгаж байсангүй. Хөдөөний харанхуй мунхаг ард байсан мөртөө олон түмэндээ тус болж, төр улс, эх орондоо зүтгээ гэх ухамсартай байж. Тэгээд ч сайн дураараа Сүхбаатар жанжны цэрэгт очиж, намд элсэж байсан юм.

Чи муу тэнэг намайг юуны төлөө тэгж явсан гэж санаж байна? Чамайг ийм өөдгүй новш болог гэж тэгж явсан гэж санаа юу? Холоо хэвтэнэ. Хойч үеийн та нарыг эрх чөлөөтэй, аз жаргалтай байг гэж, эрдэм номтой, үнэнч шударга улс болог гэж бид гадаад дотоодын дайсантай цусаа урсгаж, амиа хайрлалгүй тулж тэмцэж явсан юм.

Тэгэхэд чи партизан хүний ач байж, улаан бүчиндээ нусаа арчина гэнээ? Хүүхдийн бүч урж тасдана гэнээ. Хэрэв би тэр цагт туг сүлдэндээ нусаа арчих битгий хэл, шүлсээ үсэргэсэн бол жанжинд лав том гэмтэн болох байсан байх.

Би чамайг сайн сайхан хүн болно гэж итгээд, Сүхбаатар жанжны дурсгалыг бодож, Төмөрсүх гэдэг нэр өгсөн юм. Ийм ухамсаргүй, нэрээ гутааж нүүрээ баасадсан новш болохыг чинь мэдсэн бол чамд “илжиг” гэж нэр өгдөг байж... хуухайг! гэх мэтээр загнасан юм.

Сүхбаатарыг бодож Төмөрсүх нэр өгсөн гэдэг нь намайг их баярлуулсан юм. Миний нэр жанжны нэртэй даан ч төстэй байсан юм. Түлээний сүх хараад тийм нэр өгсөн байх гэж би шал дэмий юм бодож тэнэглэж байжээ. Өндөр өвөө бузар их уурлаад чухал нууцаа надад хэлчх шиг байна. Миний нэр Сүхбаатар жанжны нэртэй холбоотой сайхан нэр юм байна гэж би баярласан юм.

Тэгтэл тэр сайхан нэрээ балагтай муу нуснаас болж гутаачихдаг минь их харамсалтай юм болжээ. Сүхбаатар жанжны хойчийг залгамжлагч пионер болоод хөөгдөж орхидог маань их гэмшилтэй хэрэг болжээ.

“... Чамд илжиг гэж нэр өгдөг байж!” гэх өвөөгийн хангинасан үг намайг бузар гомдоож их айлгасан юм. Яагаад гэвэл өвөөг ингэж хэлэхтэй зэрэг би өөрөө ёстой илжиг болчх шиг санагдаад явчихсан юм.

Өвөөгийн ярьдаг үлгэрт нэг илбэчин, хүнийг илжиг болгож зовоосон гэж гардаг юм. Хүн илжиг болчхвол ямар сайн байх вэ. Би Төмөрсүх гэдэг сайхан нэрийн оронд Илжиг гэдэг муухай нэртэй болчхвол яана гэж бодоход аймаар байлаа. Тэгвэл дэлдэн гэж намайг шоолдог хүүхдүүд битгий хэл, багш маань ч намайг Илжиг ээ! гэж дуудаж байх болно.

Энэ бүхэн надад гэнэт их гомдолтой санагдаад би уйлж гарсан юм. Өвөөд юм уу, өөртөө ч юм уу, аль эсвэл алга болчхдог алчуурт ч юм уу, эгзэгтэй цагт гараад ирдэг нусандаа ч юм уу бүү мэд, ер нь надад нэг л их гомдолтой санагдаад би өөрийгөө өрөвдөж, пионерээс хөөгдсөн, өвөөд загнуулсандаа гомдож харамсаж уйлсан юм. Магадгүй, бас сайхан нэрээ муу болгосондоо харамсаад уйлсан ч байж болно.

Миний энэ бүтэлгүй хэрэг бас Галдан ахад ч дуулдсан байжээ. Тэр ахаас би их айдаг юм. Цэргийн дарга, хошууч цолтой хүн. Намхан шиг нуруутай, зузаан бор царайтай. Өтгөн өргөн хөмсөгтэй сүртэй хүн.

Галдан ах загнах нь байтугай барагтай бол дуу гардаггүй хүн. Хааяа л нэг муухай хардаг юм. Тэр харц нь их аймаар. Харж байгаа биш, сураар ороолгож байгаа юм шиг санагддаг харцтай хүн.

Нэг өдөр намайг хичээлээс ирэхэд Галдан ах манайд ирчихсэн өвөөтэй ярьж суулаа. Галдан ах:

-Та нар чадахгүй. Би л гар дээрээ аваад нэг үзэхээс... Дүү та хоёрыг элэг бариад цаадах чинь бүр хүнээ байлаа гэж хэлж байв.

Би анхандаа юуны тухай ярьж байгаагий нь ухаарсангүй.

-За за, Тэг ээ, тэг. Чиний гар дээр л нэг юм болдог юм уу, үгүй юм уу гэж хэлж байна.

Энэ миний тухай ярьж байжээ. Ярих ч гэж үнэндээ шийдэж байжээ.

Сургуульд очих замдаа

Би Галдан ахын гар дээр очлоо. Өөрөөр хэлбэл тэднийд байх боллоо.

Тэднийх зүүн Сэлбийн дунд гүүрийн зүүхэнтээ, засмал замын урдхан талд хоёр давхар өндөр цагаан байшинд байсан юм. Цэргийн дарга нарын байр л даа.

Гурван өрөөний томхонд нь Галдан ах эгч хоёр, жижигхэн дөрвөлжин өрөөнд дүү Солонго бид хоёр байдаг юм. Нөгөө гал тогооны мухрын хавчиг өрөөнд Мужаан гэдэг өвгөн луухаан суудаг юм.

Галдан ахынд ирээд би томоожиж байлаа. Би пионер орсон дороо хөөгдсөндөө их харамсаж байсан болохоор одоо томоотой байя гэж санах болсон юм. Бас баруун хашааны балагтай жаал Гонгороос холдоод ч тэр байж магадгүй. Энэ байшинд олон хүүхэд байх боловч миний таних хүүхэд цөөн. Таньдаг байсан ч Гонгортой адил хүүхэд алга. Гонгортой зэргэлдээ айл байхад их балагтай байдаг боловч түүнийг байхгүй болохоор бас уйтгартайхан байх юм.

Галдан ах орой хүрч ирж хоолоо идээд, жаахан байзнаснаа намайг дуудаж:

-За дүү хүү хичээлээ хийнэ ээ! Нааш ир. Энд суу гээд ширээний дэргэд суулгаж, эхлээд тэр өдөр миний авсан дүнг үзнэ. Хичээл дээр бичсэн бодсоныг минь үзнэ. Тэгээд ер аашлахгүй боловч их голдог юм. Дараа нь маргааш орох хичээлд юу юу даалгаварт өгснийг үзэж (эсвэл асууж) мэдээд, надаар заавал хийлгэж салдаг хүн. Нэг ч уурлаж загнахгүй мөртөө мэдэхгүй юмыг минь заагаад өгдөг юм.

Миний хичээлийг давтуулах гэхлээр нь урьд бол би эгчтэйгээ маргаж, муудалцаж, заримдаа бүр зодолдож ч болдог байсан юм. Тэгтэл Галдан ахтай тэгж болохгүй. Яагаад гэвэл Галдан ах эгчтэй адилхан надаас дөрөв тавхан насаар ах биш. Харин миний ээжээс ч ахмад хүн.

Энэ ахыг би ээжийг залилдаг шиг залилж ч болохгүй. Юу гэвэл энэ ах бичиг мэдэхээр барахгүй, миний үздэг хичээл бүхнийг бузар сайн мэддэг юм. Тэгэхлээр би суугаад л хичээлээ хийгээд байхаас өөр аргагүй.

Галдан ах надад бас жижигхэн ном авч өгч бас л дэргэдээ суулгаж байгаад заавал уншуулна. Анх би хачин их залхуу хүрч, заримдаа үүргэлж, мөрийг нь сольж унших гээд их зовдог байлаа. Гэвч яваандаа үүнд дасаж, ном овоо хурдан уншдаг болсон юм. Тэгэхлээр ном уншмаар ч юм шиг болж

ирлээ. Хичээлдээ ч бага сага сайжирч байлаа. Гуравдугаар улирлаар би муугүй гарсан юм.

Галдан ах нэг өдөр гаднаас ирсэн хоёр хүнд миний энэ дүү хичээл номондоо сайн, зүтгүйтэхээ байсан, ажилд сайн ёстой сайн хүн болно доо гэж яагаад ч юм магтахаар нь нүүр улайх шиг ч болж, баярламаар ч юм шиг болж билээ. Би ер нь ингэж магтуулдаг хүн больё гэж шийдсэн юм шүү.

Ер нь би Галдан ахын гар дээр жаал хүмүүжээд эхэлж байх шиг санагдаж байлаа. Энд хамт тоглох таних хүүхэд бараг байхгүй. Байлаа ч гэсэн тоглох зав гарахгүй. Завтай байвч тоглох дур хүрэхгүй болж байлаа. Тоглох гэхээр залхуу хүрээд ч байгаа юм шиг.

Танихаас энэ байшинд манай ангийн Ганзориг л байлаа. Энэ бол надад хөвөнтэй цамцы минь шидэж өгөөд хичээлээс хөөгдсөн жаал маань юм. Түүнийг би анх манай эгч шиг л дуугүй, унхайсан хүүхэд. Тоглохыг мэддэггүй байх гэж бодож байсан юм. Тийм хүүхэд надад уйтгартай. Хичээл дээр түүнийг хүүхэд өдөж, цохиод авахад “Болиоч ээ!” гээд хөдлөхгүй л суугаад байдаг юм.

Нэг удаа манай хичээл үдээс хойш орох болсон юм. Тэр өглөө Галдан ах, Норов эгч хоёр өглөө эрт ажилдаа явсан. Жаахан охин дүү цэцэрлэгтээ явчихсан байлаа. Мужаан бид хоёр л үлдээд байсан юм. Энэ завшааныг ашиглаж би хичээл эхлэхээс бараг цаг гаруйн өмнө гэрээсээ гарлаа.

Хаврын шинэ цас орчихсоны маргааш нь зэгсэн хүйтэн тунгалаг өдөр болж байлаа. Байшингийнхаа зүүн орцоор гараад булан тойрох гэтэл миний араас:

-Төмөрсүх ээ! Чи хаачих нь вэ? гэж хүүхэд дуудан асуув. Эргээд харсанд Ганзориг манай баруун хаалганы үүдэнд довжоон дээр гадуур хувцасгүй сууж байна.

-Сургуульдаа явлаа гэхэд тэр жаал гайхасхийж

-Ийм эрт үү? Нэг цагаас гээ биз дээ гэнэ.

-Яадаг юм, үхсэн, замдаа жаахан тоглоё гэв.

-Тэгвэл чи хүлээж бай! Хоёулаа хамт явъя! гээд Ганзориг гэртээ гүйж орлоо.

Удалгүй түүнийг номын саваа авч гадуур хувцас өмсөөд гарч ирэхэд бид хоёул болж сургууль руу зүглэв. Тэгээд замдаа хаана юугаар тоглохоо ярилцлаа. Ногооны хашааны зүүн дэвсгэр дээр очиж чаргаар гулгахаар шийдэв. Энэ нь сүүлчийн цас ч байж мэднэ гэж ярилцлаа.

Тэгээд баруун тийшээ гүүрээр гарахын оронд Сэлбийн зүүн эргээр хойшоо явсан юм. Ярилцсан газраа хүрч очоод жалга дотор овоолоостой байдаг эвдэрхий машины хог дотроос суудлын машины салаад ойчсон хаалга олж чарга хийв. Тэр хавтгай төмөртөө жаахан гүүпэр утас олж оосор хийв. Тэгээд дэвсгэр өөд авирч гараад өнөөх чарган дээрээ суугаад ээлж ээлжээр гулган бууж байлаа.

Тэр өдөр тэнгэр утаа суунагласан мэт үүлээр бүрхэгдсэн тул нар сайн халааж цас нялцайлгахгүй байсан болохоор гулгахад таатай байлаа. Бидний сууж гулгаж байгаа суудлын машины хаалга ямар сайд даргын машины хаалга байсан бол? Ямар нэг жанжны эдэлж байсан машины хаалга байж ч магадгүй гэж бид хоёр ярилцав.

Тэгтэл одоо түүгээр гулгаж байгаа бид хоёр ч машин унадаг том дарга хүн шиг санагдаад явчихлаа. Энэ санал Ганзоригт ч таашаагдлаа. Ингээд бид хоёрын хэн чарга дээр суусан маань жанжин болж, нөгөөх нь баярын жагсаал хамаандалсан дарга болж рапорт өгч тоглож байлаа. Чарган дээр суусан нөхөр маань жанжныг дуурайж ёслон,

-Нөхөд цэргүүд сайн байцгаана уу? гэж хашхирахад нөгөө нь тав хийтэл хөл хавсран ёсолж

-Сайн, урай, урай, урай гэж хашхирч байв. Ингэж хашхирахад Октябрийн баяраар төв талбай дээр болж байсан баярын жагсаал тэр чигээрээ харагдах шиг болж, машины хаалгаар аргалсан чарга маань Лхагвасүрэн жанжны унадаг урт хар тэрэг болоод хувирчих шиг их л сэтгэл хөдөлгөж байв.

Энэ удаа би рапорт өгөх болж, Ганзориг жанжин болж, жагсаал хүлээж авахаар чаргаа чирч дэнж өөд жалгын хажуугаар авирч байтал гэнэт жалгын эхнээс хэдэн (гурав, дөрвөн) ямаа тургиж майлсаар цовхрон орж ирлээ. Ямааг гялтганасан сэгсгэр үстэй хар нохой хөөж явна.

Үүнийг харж бид хоёр зог тусаад тэр даруй манай “бүх арми” халдан түрэмгийлсэн нохойноос хэлмэгдэн дүрвэж яваа ямаанд туслахаар хөдлөв. Жанжин маань “хурдан тэргээ” (машины хаалган чарга) хаяад том чулуу авч нохойг шидэн хөөв. Энэ чулуу нохойн хувьд бол аварга их бууны сум шиг байсан биз.

Би дайснаас зугтааж яваа дүрвэгсдийг тогтоож тайвшруулах гэж ямааны урдуур гүйсэн юм. Гэтэл тэр хулчгар ямаанууд миний тэр сайхан санааг ойлгосонгүй. Дэргэдүүр дэлбэ дайрч гарах төлөвтэй болов.

Гэнэт надад энэ хулчгар дүрвэгсдээс нэгийг нь барьж аваад чаргаа чирүүлэх гэсэн бодол төрсөн юм. Үүнийг “жанжинтайгаа” зөвлөх зав ч алга байлаа. Тэгээд юу ч болсон ямаар юмаар шидэж эргээе гэж ийш тийш хартал миний урд номын сав минь харагдав. Би түүнийг шүүрч аваад энэ цувааны эхэнд дайран ирсэн шоорон эвэртэй хөх ямаа руу шидэж орхитол номын сав минь түүний хоёр эвэрт оосроороо углагдав. Тэр ямаа аймшигт араатан хүзүүн дээр мордчихлоо гэсэн шиг майлсаар зулран зугтаахад би хойноос нь гүйгээд гүйцсэнгүй.

Тэр ямаа Сэлбийн хойд гүүрээр гарч, бусдыгаа дагуулан харайлгахад миний номын сав буруу зөв тал руу нь савчин ямаатай ноцолдож яваа юм шиг харагдав. Хэдэн ямаа нэг хашааны булангаар тойроод далд орлоо. Ганзориг миний хойноос гүйж ирээд

-Чи яав гэж асуулаа.

-Ямаа савтай номыг минь эвэртээ өлгөөд хурдалчихлаа гэж тайлбарлаад би ямааны хойноос дахин гүйлээ.

Галдан ахын надад авч өгсөн шинэ цүнхийг алдчих байх гэж би айгаад явчлаа. Бид хоёр тэр хавийн хашаа бүрийн завсраар харж ямааг эрсэн боловч олсонгүй. Нэг мэдэхэд хичээлээсээ хоцрох болсон шиг санагдлаа.

-За найз аа, хичээл орох болчсон байх. Одоо яах вэ? гэж Ганзориг гэнэт хэлэв.

-Чи хичээлдээ яв! Найз нь номгүй яаж хичээлдээ очих вэ гэж намайг хэлтэл

-Найз нь цуг эрэлцэх үү? гэж Ганзориг шийдвэргүйхэн асууж байна.

-Яа-ах юм. Чи хичээлдээ яв! Одоо хожигдлоо гэж би шийдвэртэй дургүйцлээ.

Ганзориг гүйгээд явлаа. Би хойноос нь гунигтайхан гэлдрэв. Би өдөржин хотоор тэнэж айл бүрийн хашааны завсраар харсан боловч тэр ямааг олсонгүй. Зарим хашааны завсраар харахаар цаанаас нь нохой шүдээ ярзайлган архирч дайрч байх юм. Би тийм нохойг элдвээр гааруулж байгаад эзэнд нь загнуулж ч явлаа. Бас нэг хашааны завсраар харж байтал нэг торгон дээлтэй эгч:

-Чи юугаа харсан юм бэ? Хулгай хийх чинь үү? гэж загнав.

-Би номын цүнхээ эрж байна гэж хэлтэл тэр эгч их зэвүүцэж хардсан байртай

-Чиний номын цүнх манай хашаанд байх ёстой юм уу? гэнэ.

-Танай ямаа авчсан байж магадгүй! гэж хэлсэн чинь тэр эгчийн нүд нь бүлтийж намайг хөлөөс минь толгой хүртэл хараад

-Яв, яв. Манайд ямаа байхгүй! гэж хэлээд хашаандаа орж хаалгаа түгжив. Намайг солиотой жаал гэж бодох шиг болов. Ингэж явсаар нэг мэдсэн чинь хашаандаа ирчихсэн байв. Үүдэндээ очоод орох уу байх уу гэж шийдэж ядан зогсож байтал гаднаас өвөө хүрч ирээд

-За миний зүггүй хүү хүрээд ирээ юу? Ор ор! гэж намайг үнсэв.

-Өө миний хүү хүрээд ирээ юу? гэрээ санаж байна уу? чи юунд ирээ вэ? Цаадуул чинь сайн биз гэж ээж асууж, намайг бас үнсэв.

-Би ээжийн асуултанд товчхон хариу хэлээд

-Ээж ээ би хуучин номын саваа авах гэж ирсэн гэж хэлэв.

-Тэрүүгээр яах нь вэ? Номын саваа яачихаа вэ? гэж ээж асуулаа.

-Номтой нь алдчихлаа.

-Юу? Хүүхэд булаагаад авчихаа юу? гэхэд

-Үгүй ямаанд булаалгачихсан.

-Яаж? Ямаанд булаалгана гэдэг чинь юу гэсэн үг вэ? гэж ээж өвөө хоёр зэрэг зэрэг асууж байна. Над руу том том харав.

Сургуульдаа очих замд ямааг нохой хөөж явахаар нь номоороо шидсэн чинь ямааны эвэрт углагдаад... гэж би үнэнээ хэлэв.

Өвөө ээж хоёр миний бүтэлгүй эдгүйг гайхаж зэмлээд надад хуучин номын савыг минь олж өгөв.

Энэ бол жижигхэн бөмбөгөн дотортой саарал даавуу цүнх бөгөөд ногоон даавуу элгэн дээр нь орос бичигтэй сав юм. Үүнийг цэргийн эмнэлгийн эмийн сав гэж ярилцдаг юм. Тэр орой Галдан ах:

-За, дүү хүү хичээлээ хийнээ! гээд эхэлтэл надад хийх хичээл, үзэх ном, бичих үзэг юу юу ч байсангүй. Би хоосон шалчийсан даавуу цүнхээ бариад хүрч очлоо.

Галдан ахад би бүх үнэнээ хэллээ. Энэ ах уурласангүй. Харин толгойгоо сэгсрэн:

-За чи мөн тусгүй сурагч юм аа. Өнөөдөр тэгээд бас хичээлээ тасалчхаа юу. Ингээд байвал ч чи бид хоёр горьгүй дээ. За тийм бол одоо яая гэх вэ? Үүнээс хойш номоороо битгий юм шидэж байгаарай! гэв.

Тэгээд тэр өдөр намайг хичээл давтуулж чадсангүй. Харин хоосон саванд минь хэдэн дэвтэр, үзэг, иш хийж өгөв.

Маргааш нь би хичээлдээ дөнгөж очтол манай багш:

-Чи яагаад хичээл таслав? Хичээлийн ном дэвтрээ яачихаа вэ? Одоо байтлаа ном дэвтэр ч гүй... хичээл таслаад байдаг болох чинь үү? гээд шууд уурлаж гарлаа.

-Савтай номоо алдчихсан! гэж би дуулдах төдий бөвтнөв.

-Аа тийм бий! Чи гадуур тэнэж хичээл таслах гээд ном дэвтрээ санаатай хаясан. Би мэдэж байна. Чи сургуульд явах дургүйдээ л тэр. Чам шиг муу жаалаар манай анги дутахгүй гээд Жавзмаа багш намайг загнав. Түүний онигор нүд нялалзаж үзүүрээс нь өөлчихсөн юм шиг мөгзгор хамар нь хүртэл минчийж улайгаад, сүүлдээ царай нь цав цагаан болов.

-Би мэдэж байна. Чи ном дэвтрээ санаатай хаясан. Сургуульд сурах дургүй бол чамайг хөөлгөөд өгч болно гээд загнаж байна. Би багшид гомдож “Өөрөө мэдэхгүй байж, санаатай санаатай гэх юм” гэж бухимдан бодож байлаа. Энэ цагийн хичээлийн ихэнхийг багш намайг загнаж харааж өнгөрөөлөө.

Хичээл тараад ангиас гарах гэж байтал ерөнхий жижүүр дээд ангийн эгч ирж

-Та нар хэддүгээр ангийнх билээ? гэж асуув.

-3 в гэж бид зэрэг зэрэг хариултал

-Хүүш тэгвэл Төмөрсүх гэж хүүхэд бий юу? гэв.

-Байна! гэсэнд

-Хичээл эрхлэгч дээр... гэв.

Би одоо л намайг сургуулиас хөөх нь дээ гэж айсаар дүнзэн байшингийн хаалгаар ормогц эсрэг харгалдаад нь байдаг “Багш нарын танхим” гэсэн хаягтай өрөөний үүдэнд очиж шагайв.

Ширээний ард сууж байсан үл таних багш намайг хармагц

-За ор ор! Чи хэн билээ? юу гэж явна? гэв. Би толгойгоо илээд

-Төмөрсүх... Намайг энд дуудсан юм гэсэнд

-Аа тийм, тийм. Аварга, чи яахлаараа ном дэвтрээ савтай нь хаячихдаг билээ? гэнэ.

-Би тоглож байгаад ямааны эвэрт алдчихсан юм гэсэнд тэр багш инээмсэглэж:

-Тэгвэл тэр ямаа номын савы чинь сэргийлэхэд аваачиж өгсөн байна даа. Энэ мөн үү? гээд миний номын савыг гаргаад ирлээ.

-Мөн гээд намайг авахад

-Ном дэвтрээ бүртгээд ав! Үүнээс хойш номоо ингэж хаясан байвал чамайг шийтгэнэ шүү. Мэдэв үү гэхэд би “За” гэж толгой дохиод гарлаа. Би номоо олж аваад хашааны хаалгаар бөөн баяртай гарч иртэл Ганзориг цуг явах гээд хүлээж байв.

-Найз аа чи номоо хаанаас олоо вэ? гэж түүний гайхан асуухад би

-Багш нарын өрөөнөөс. Нөгөө ямаа чинь номы минь сэргийлэхэд аваачиж өгсөн байна гэв.

-Юу-у? Сэргийлэхэд ий? (ха-ха-ха) Яасан их далан худалч вэ чи! Хэзээ ямаа сэргийлэхэд очиж байсан юм бэ.

-Худлаа гэвэл хичээл эрхлэгч багш хэлсэн юм. Тэр ямаа лав сэргийлэгч байсан байх! гэж би мэтгэлээ.

-Сэргийлэгч ямаа байдаг юм уу даа, ямар? гэж Ганзориг уцаарлаж зүтгэв.

-Байдаг юм байлгүй. Сэргийлэхийн нохой байдаг шүү дээ. Сургуультай нохой байхад сургуультай ямаа байдаг ч юм бил үү. Чи яаж мэдээ вэ? гэв.

Ганзориг эргэлзэж эхлээд,

-Тийм нь ч тийм л дээ. Сэргийлэгч ямаа байдаг гэж би дуулаагүй. Сонин юм даа. Тэгэхдээ тэр сэргийлэгч биш хулгайч ямаа байсан байх.

Магадгүй юм даа. Эсвэл...

Ямааны эвэрт алдаад миний өдөржин эрээд олоогүй номын савыг сэргийлэхийнхэн яаж олсон аргыг бид хоёр элдвээр тааж замын турш гайхан хэлэлцэж явлаа. Сэргийлэхийнхэн бидний хаясан юмыг маань олоод л яаж яаж зүггүйтсэний маань нэгд нэгэнгүй мэдэж аюул ослоос биднийг хамгаалж байдаг юм байна гэж санагдаж байлаа.

Мужааныг аварсан минь

Галдан ахын гал тогооны мухрын өрөөнд өвгөн луухаан суудаг гэж би дээр хэлсэн шүү дээ. Түүнийг бултаараа л “Мужаан” гэдэг. Үнэндээ бол тогооч хүн байсан юм.

Ямар сайхан амттай хоол хийдэг гэж санана. Өдөр болгон янз янзын хоол хийхийг нь яана. Түүний хийсэн хоолноос амсаж үзсэн бол та нар лав миний саналыг зөвшөөрч Тогооч гэж нэрлэх байсан. Би түүний хийсэн сайхан хоол, дотроо бурамтай чихэртэй мантууг идэх бүрдээ энэ өвгөнийг Тогооч гэхгүй юунд Мужаан гэдэг юм бол гэж гайхдаг байлаа.

Гэтэл тэр хүн тогоочоос гадна бас мужаан юмсанжээ. Сургууль тарахын өмнөхнөөс тэр өвгөн хавчиг өрөөндөө зузаан зузаан банз харуулдаж мужааныхаа ажлыг хийдэг боллоо. Гэтэл тэр луухаан нэг урт чингэлэг авдар шиг юм хийгээд байсан юм. Сүүлд нь нэг үзэхэд өнөөх нь нарийхан урт чингэлэг авдар биш, харин баймгай зузаан банзаар хийсэн асар том авс болсон байлаа. Түүнийгээ цонхны дор хөндлөн тавиад тагийг хажууд нь налуулсан байлаа.

-Та энийг хэнд хийгээ вэ? Хүн үхээ юу? гэж миний сонирхоход

-Хай чи юу мэдилээ? Би үүнийг өөртөө хийсээн байна аа шүү гэх нь тэр.

Би гайхаж өвгөнийг үхэх гэж байна уу? гэж нүүр өөд нь хартал царай нь зөв зүгээр, улам ч сайхан болчихсон шиг хөлс дааварлан малилзаж байв. Би луухааныг худлаа залчихлаа гэж бодтол тэр хөгшин:

-Ай чи харуваа. Энэ авдар надад таарсан уу, үгүй юу? Чи хэливаа! гээд авсан дотроо ороод гэдэргээ харж хэвтэв.

-Ай чи хэливаа. Ямар байна аа? гэж асуухад нь

-Мужаан гуай, томдсон байна шүү дээ гэж би хэлэв.

-Юу томоо? Борноо (болно) байхаа гэж өвгөн хэлэв.

Энэ авсыг нээрэн өөртөө хийжээ гэж би сая л үнэмшээд бүр гайхаж

-Мужаан гуай та хэзээ үхэх нь вэ? гэж асуутал

-Хай чи юу асуугаа-аад байна? Би их насаатай борсоон, хэзээ чигий үхэх магадгүй. Одоо чигий үхэж мэдинаа гэв.

Мужааныг авсан дотор орж хэвтээд ийм үг хэлэхлээр юу юугүй үхэх гэж байгаа юм болов уу гэж би айн сандарлаа.

-Тэгвэл би Галдан ахад утасдах уу гээд гараад гүйх гэтэл өвгөн авснаасаа өндөсхийж

-Ай чи юу яригаад байна? Галдааныг дуудаж яанаа? Танай ах намайг яахаа. Дуудаасаан чигий үхилаа. Дуудаагүй чигий үхилаа. Юу хийнаа? гэж хэлэхэд нь би бүр гайхаж

-Та үхэхдээ дуртай байна уу? гэж асуув.

-Хай, чи яасаан тэнэг байна аа? Үхихэд хэн дурутай. Дургүй чигий бас болувал авдараа хийнаа шүү, хай гээд эвшээв.

Би луухааныг үхэх болоогүй юм байна гэж бодлоо. Үхэх хүн эвшээдэггүй. Эвшээвэл үхэх болоогүй байдаг гэж ээж ярьж байсан шиг санагдана. Луухаан миний санааг батлах гэсэн шиг булан түшүүлж босгож тавьсан урт нарийхан сарампай мод авчраад өнөөх авсан дээрээ таглаж тавив.

-Ай одоо болсоон. Хэзээ чигий үхивал үхиваа. Санаа амар борсоон байна аа. Авдар бэлэн болсоон байна аа. Одоо яаха! гэж надад биш, харин үл үзэгдэх нэг юмтай ярьж байгаа юм шиг хэлж байв. Дараа нь над руу харж

За чи одоо мэдисаан. Ай одоо чи юу хийлаа. Одоо гаруваа? гэж намайг хөөж өрөөнөөсөө гаргаад, өөрөө ч бас гал тогооноос том тор бариад гадагшаа гарлаа.

Би өрөөнийхөө цонхоор харж байтал мужаан байшингийн ёроолоор лаалайгаад баруун тийшээ алхаж явна. Авсан дотор орж хэвтээд үхнэ хатна гээд маяглаад байсан нь шал худлаа юм байжээ.

Үхэх болоогүй байж авсаа хийдэг нь яаж байгаа юм бол? Авсаа хийчихсэн болохоор энэ хужаа удахгүй үхэх байх. Хүн үхэх ер нь ямар байдаг бол? гэж би сонин юм бодлоо. Тэгээд Мужааны авсан дотор орж хэвтэж үзмээр санагдлаа.

Гэрт надаас өөр хүн байсангүй. Мужаан ногоонд явсан. Мод ирэх болоогүй. Би гал тогооны газраар дамжин мухрын өрөөнд орж авсыг таглаж тавьсан сарампай модыг өргөж байгаад дотор нь орж хэвтлээ. Сарампай мод миний дээрээс таглахад авсан дотор таг харанхуй боллоо.

Хүн үхэхэд яадаг бол? Урьдаар лав их өвддөг байх! Надад өвдөж байгаа юм байна уу, үгүй юу гээд би биеэ чагнаж үзлээ. Тэгтэл сэрвээн дор нэг юм нухаад өвтгөж байх шиг санагдлаа.

-Ёо ёо ёо, би үхэх гэж байна гэж би ганцаараа харанхуй авсан дотор дуугарч үзлээ. Намайг үхвэл ээж минь яах бол? гэж бодлоо. Муу хүү минь үхчих гэж дээ гээд уйлна байх даа. Ээж надад хатуу боловч бас хайртай гэж саналаа.

Авсан дотор ингэж жаахан хэвттэл үхэх гэдэг ер нь шал дэмий юм шиг надад санагдлаа. Нүх шиг харанхуй юманд огт хөдлөхгүй хэвтээд байна гэдэг тэсэхийн аргагүй зовлонтой юм байна. Тэгэхлээр нь намайг үхсэн гээд оршуулах гэж байтал гэнэт авсныхаа тагийг өргөөд босоод ирвэл яах бол? гэж бодож үзлээ. Сарампай модыг өргөөд өндийж үзлээ. Тэгэхэд намайг оршуулах гэж байсан улсын нүд бүлтийгээд цөм дуу алдана байх. Харин ээж минь “Хүүе таминь, хүү минь босоод ирлээ, амьд байж шүү дээ. Хараач” гээд намайг тэврэн авч үнсэх байх. Үхээд босоод ирсэн хүү минь гээд намайг яаж ч байсан зодохгүй болно байх ч гэж бодогдож байна.

Дараа нь энэ авс нуугдаж тоглоход аятайхан газар шиг санагдлаа. Орой дүүтэй хамт нуугдаж тоглож байя гэж шийдлээ. Бас авсан дотор хэвтэж байгаа биш, харин нууц хоргодовч дотор хэвтэж байгаа цэрэг болж тоглож үзлээ. Тэгээд тэр авсан дотор дээшээ хараад хэвтэж байснаа эргэж доошоо хараад даранз модыг далаараа жаахан өргөж үзвэл түүний завсраар Мужааны өрөөний хаалга харагдаж байна. Тэр хаалгаар дайсан орж ирвэл ч би алдахгүй буудна даа гэж баруун гарынхаа долоовор хурууг урагш гозойлгож бусад хуруугаа атгаж гар буу болгоод ангалаар шагайж “ччих!” гэж гохыг дарж тоглоход дайсны нэг цэрэг яг хаалган дээр алдлаад унаж байгаа юм шиг санагдлаа.

Ингэж тоглож байтал хаалга дуугарах шиг болов. Би авснаас гарч чадалгүй хүн ирүүлчихсэндээ бантаад авсан дотроо нуугдсан чигээр чагналаа. Хөлийн чимээ ойртоод гал тогоонд хүн ороод ирэх шиг болов. Би даранз модыг жаахан өргөж завсар гаргаад хаалга руу харж байтал тэр хаалга нээгдээд, Мужаан орж ирэв. Би түрүүчийн тоглож байснаараа баруун гараар гар буу болгож “Кихх!” гээд буудаад орхитол Мужаан дуу алдан, дав хийж эргээд гал тогооны өрөөнд огло харайж оруутаа, юманд тээглэв үү, яав пид хийгээд уначих шиг.

Тэгээд чимээгүй болчход нь би гайхан авснаас гарч ирээд гал тогооны өрөөнд гүйж хүрвэл Мужаан яг надад буудуулаад уначихсан юм шиг түрүүлгээ харж тэрийн ойчоод хөдлөхгүй хэвтэж байна. Мужаан хэзээ хэзээгүй үхнэ гэж яриад байсан. Үхэж байгаа нь энэ юм байх гэж бодоод би айгаад явчихлаа. Сандраад мужааны хажуугаар сэмхэн тойрч гараад гадагшаа гүйх гэтэл ахын авгай гаднаас ирж явна.

-Норов эгч ээ, Мужаан үхчихлээ! гэхэд эгч цочих шиг болж

-Хүүе яанаа, Хаана? Яагаад...

-Гал тогооны өрөөнд гаднаас орж ирээд ойчих шиг болсон гэвэл эгч тийшээ гүйж оров. Би хойноос нь гүйж очлоо. Норов эгч өвгөнийг өндийлгөж тэврээд хөвөнтэй цамцны нь энгэрийг тайлж цээжин дээр нь гараа тавьж үзэж байна.

-Цаанаасаа, аяганд ус хийгээд, алчууртай аваад ир гэж надад хэлэв. Би тэр ёсоор авчирсанд нойтон алчуураар хэнхдэгийг нь шавшиж сэвж байна. Мужааныг гэнэт нүдээ нээхэд эгч

-Та яачихваа! гэж асуув. Өвгөн өндийж

-Ай муу байна аа. Энэ нэги солигийн авсаа байна аа... Хай юу хийнаа хагалж түливаа. Муу солиг амилсан ваа гэж хэлэв. Тэгээд босож өрөөнийхөө хаалга руу сэмхэн гэтэж очоод түлхүүрийн нүхээр шагайж харахад түүний шар шүд ярзайн харагдаж байв. Эгч ч айсан нүдээр тээр хаалганы зүг сортойн харж байна.

Хужаа хаалгаа аяархан нээж авсаа заагаад

-Ай эни солигоо... хөдөлсөөн шүү. Амилсан баа Хай юу хийлаа, Ай энэ солигоо байна аа. Эвдээд түливаа гэж хэлэв. Тэгснээ гэнэт над руу эргэж

-Хай чи намайг ирэхэд хаа байсаан гэж надаас асуулаа. Авсан дотор байсан гэвэл луухаан уурлана байх гэж бодоод би

-Би юу? Би гадаа тоглож байсан гэж хэллээ.

-Ай тиймээ байхаа даа. Эни солиг... амилсаан баа. Юу хийлаа хагалж түливаа! гэж үглэсээр байв.

Тэр орой мужаан хангинуур сүхээ авч өнөөх авсаа хэмх хэмх цохиод хагалаад түлчихсэн юм.

Энэ явдал Мужаанд сайн болох шиг боллоо. Хэзээ ч магадгүй үхнэ гээд байсан луухаан намайг гадаадад сургуульд яван явтал үхэлгүй л амьд яваад байсан юм. Би түүнийг үхлээс аварсан шиг байсан юм.

Түүний хэлдгээр авс нь амилсан биш, харин би дотор нь нуугдаж байсныг мэдсэн бол өвгөн луухаан авсаа хадгалж байгаад дотор нь орж хэвтээд аль эрт үхэх байсан байх.

Зуслан дээр

Жилийн эцсийн дүнгээр би дунд гарч анги дэвших боллоо. Үүнд манай гэрийнхэн цөм баяртай. Ээж өвөө хоёр намайг “Ахынхаа гар дээр очоод өөр болж байна, яамай даа. Хэл амгүй ингээд анги дэвшинэ гэдэг чинь аштай юу даа, хүү минь” гэж магтаж сайшаасан юм. Энэ тухай би найздаа ярьсанд Ганзориг маань гайхаж:

-Хө-өх! Ямар онгироо вэ? Манайхан бол намайг сайн сурлаа гээд зэмлээд байгаа юм. Хичээвэл чи онц гарч чадалгүй яахав. Өөрөө хичээхгүй байна гэж загнаад байгаа юм гэж гомдолтой хэлж байна. Нэг маань дунд сураад магтуулж байхад нөгөө маань сайн сураад зэмлүүлж байдаг, сонин шүү. Аав ээж нар ер нь учир нь олддоггүй хачин улс юм гэж би гайхаж байлаа.

Удалгүй Галдан ахынх зуслан гарах боллоо. Өндөр өвөө ээж хоёр намайг тэднийхээр хамт явуулахаар шийдлээ. Ахын гар дээр улам сайн томоожиж хүмүүжиг гэж бодсон юм байх.

Манай ахынх Сонгины буланд цэргийн дарга нарын зусланд гардаг юм. Туулын хоёр салааны хоорондох арал дээр бургасны чөлөөнд эгнүүлэн барьсан таван том цагаан гэр байсан юм. Зүүн захынх нь манай ахынх. Баруун үзүүрийнх нь хэнийх байсан гэж санана. Ганзоригийнх маань байсан юм.

Гэрээс урагш битүү бургасан дотор цэргийн нэг жижгэвтэр ногоон майхан байдаг юм. Түүнд хэдэн цэрэг суудаг. Энд зусаж байгаа дарга нарын жолооч цэргүүд тэр. Энд ирээд би томоотой байхыг бодож байсан юм.

Тэгтэл нэг хагас сайн өдөр ах эгч хоёр жаахан дүүг аваад юманд явж, харин би гэр сахих болов. Явахдаа Норов эгч:

-Төмөрсүх ээ. Дүү минь чи гэр сайн сахиж байгаарай! Шүүгээнд талх цөцгий бий. Идэх юм байгаа шүү. Өлсвөл идээрэй. Хаалга задгай хаячхаад гараад тэнээд явчхав. Цоож түлхүүр энэ шүү дээ гээд тэдгээрийг шалны өр дээр тавьж байна. Усанд хамаагүй орж үхэв. Осолтой шүү! гэж захив.

-Бид орой эргээд ирнэ. Томоотой байна шүү, чи мэдэв үү гэж Галдан ах сануулж байна.

Тэгж үлдээд би гэртээ томоотой сууж байлаа. Дүүг харна гэх юм алга. Ном унших гэтэл надад “Наймын нууц” гэдэг сонин сайхан ном байгаа боловч ах намайг дэргэдээ суулгаж уншуулсаар байгаад дуусгуулчихсан болохоор дахиад уншихад сонин биш шиг. Гэр орноо цэвэрлэдэг юм уу гэтэл Норов эгч өглөө эрт босоод нэгэнт янзлаад гялалзуулчихсан байлаа. Ингээд хийх юмгүй байхад томоотой суугаад байна гэдэг их хэцүү ажил шүү.

Би босож хоолны шүүгээнээс талх зүсэж аваад цөцгий түрхэж, дээр нь элсэн чихэр үрээд идэж байлаа. Унтаад босоход юм идэх дур хүрдэггүй ч энэ их амттайхан юм. Норов эгч идээрэй ч гэсэн юм.

Нар ханын элгэнд оччихсон байна. Нарны гэрэлд хэдэн ялаа бужигнаж байна. Эгч ах хоёр ялааг бузар амьтан гээд үздэггүй юм. Би бол түүнийг бузраас гадна хүнийг дандаа өдөж оролдож байдаг яршигтай зэвүүн амьтан гэж боддог. Ялаа ер нь унтаж байхад нүүрэн дээгүүр гүйж завжинд шавалдах, ажил хийж байхад нүдний зовхи булан дээр сууж, үргээгээд байхад тэгэхээс тэгэх гэсэн шиг дахин дахин сууж өдөөд байдаг юм.

Тэр удаа намайг цөцгийтэй талх идэж байхад нэг ялаа ирээд гар дээр минь суулаа. Би дарж авах санаатай хөдлөлгүй харж байв. Тэр ялаа миний арьснаас юм олж идэх гэсэн шиг өнөөх муу зангаараа нухуур хошуугаараа дарж үзээд гүйж байна. Тэгснээ элсэн чихрийн ганц ширхэг гарт наалдсаныг олоод хошуугаараа бөндөгнүүлж долоож байх шиг харагдана. Би нөгөө гараа сэмхэн явуулаад дараад авах хэсэн чинь ялаа өнөөх элсэн чихрийн ганц ширхийг хошуундаа наагаад нисэж орхилоо.

Гадаа шувуу дуугарч байна. Хойд ууланд хөхөө донгодож байна. Би гарч гэрийнхээ хаяанд түлээний цагаан хайрцаг дээр суув. Нартай сайхан өдөр болж байна.

Хаяанд хэдэн хар шоргоолж нүхнээсээ гараад тэнэж байна. Зарим нь нүхнээсээ шороог ширхэг ширхгээр зууж гаргаж ирээд хол аваачиж хаяж байна. Гэрээ цэвэрлэж хогоо хаяж байгаа юм байх. Би нэг шарилж авч тэнэж яваа нэг шоргоолжийг оролдон, явахад нь садаа хийв.

Тэр шоргоолж уурлаж байгаа юм уу, сандарч байгаа юм уу, ийш тийшээ тэвдэн гүйж байснаа нэг шоргоолжтой дайралдаад амаараа уулзан ширвүүлээ солиболзуулан үг ярих шиг болов. Тэгснээ цааш эргэж буцаж гүйж байгаад нүхэндээ орчихлоо.

Нүхнээс нь хэдэн шоргоолж сандарсан байртай гүйж гарч ирээд ийш тийшээ гүйлдэв. Өнөөх орсон шоргоолж гадаа аюултай дайсан ирлээ гэж мэдээлсэн бололтой. Шоргоолж ер нь манайхны томцуул шиг огт завгүй ажилтай тоглохыг мэддэггүй амьтан байдаг юм.

Ойрхон ургасан бургасан дээгүүр болжмор жиргэж байна. Тэд мөчир дээгүүр дүүлэлдэн, гэдгэ годго хийж, жив жив дуугаран, бие биентэйгээ хөөцөлдөн хичээлийн засварлагаар гадаа тоглож байгаа хүүхдүүд шиг үймэлцэн шуугилдаж байна. Болжмор, хөх цөцгий, алтан хараацай цөм хүүхэдтэй адилхан харагддаг. Газар буухаараа нэг ч зүгээр алхаж явахгүй, дандаа дэгдэж дэвхэрч явдаг юм. Тэгэхдээ хүүхэдтэй тоглох дургүй. Ойртохоор л дэр гээд нисчихдэг юм. Бид далавчгүй болохоор гүйцэх биш.

Энэ бүхнийг хараад би томоотой сууж л байлаа. Тэгтэл Ганзориг хүрч ирээд

-Явж хамт тоглох уу? гэв.

Намайг томоотой байгаарай гэснээс биш, тоглож болохгүй гэж хэлээгүй юм. Бас үүд хаалгаа битгий задгай хаяад явчхаарай гэж цоож түлхүүр өгсөн болохоор хаалгаа цоожлоод гараад явж болно гэсэн үг юм. Ийм болохоор би “тэгье” гэж зөвшөөрлөө.

Би үүдээ цоожлоод Ганзоригтой хамт тоглохоор явлаа. Бид хоёр цэргийн майхны хажуугаар гарч, бургасан дундуур явж, арлын урд хилийн элстэй хошуун дээр хүрч очлоо. Энд голын их бага хоёр салаа дахин нийлж цаашаа урсаад манай энэ зусланг далайн арал шиг болгожээ. Баруун эрэг нь бөөн бургастай, хүн амьтнаас далд, хүүхэд тоглоход сайхан газар юм. Харин зүүн урд хэсэг нь торгон элстэй, гүехэн устай, эрэггүй налуу хошуу болж төгсчээ.

Эхлээд бид хоёр усанд орж, шумбаж сэлж, усаар цацалцан байлдаж тоглов. “Усанд орж үхэв” гэсэн эгчийн захиасыг би мартаагүй болохоор эргийн дэргэд юм уу, эсвэл гүехэн устай, торгон элстэй газар усанд шумбаж байлаа. Ганзориг усанд шумбаад нүдээ харж усны ёроолын юмыг үзлээ гэж ярихаар нь би бас усан дотор харж үзлээ. Тэгэхэд нүд тороод эвгүй боловч ёроолын чулуу нарны гэрэлд олон алтан Цагариг мэт хачин үелзэн харагдаж байна.

Усанд орж, усан цэрэг болж тоглож ханаад бид хоёр бургасны ёроолд хөлөө усанд унжуулан эрэг сандайлан сууж байв. Тэгтэл биднээс холхон нэг загас пол хийж дэвхрэг шүүрэв. Эргийн хавийн замаг дотроос уртавтар могой жараахай жирэлзэн гүйж, бидний сууж байгаа эрэг дороос ч том жижиг загас үелзэн сүүтгэнэн гүйх нь үе үе үзэгдэж байв.

-Хоёулаа одоо загас барих уу? гэж Ганзориг асуухад

-Юугаар барих вэ? Дэгээ байхгүй! гэв.

Бид хоёр эхлээд загасыг усан дотроос гэнэдүүлэн гараараа шүүрэх гэж оролдов. Хоёулаа эрэг дээр түрүүлгээ харж хэвтээд гэнэн загас эрэг дороос гарч ирмэгц шүүрэх гэж оролдоод бүтсэнгүй. Харин гараа чулуунд тулгалах шахав.

Дараа нь Ганзориг гүйж хариад хоёр сэрээ олж ирээд, түүгээр усан доторх загасыг шувт хатгаж алах гэж оролдов. Бас л бүтсэнгүй. Усан дотроо байгаа загас биднээс заавал илүү шаламгай байх юм.

Адаг сүүлд нь Ганзориг маань залхуурсан бололтой хамар дээрх бурзайсан хөлсөө арчаад

-Тор байдаг болоосой. Тэгвэл кинонд гардаг шиг л зөндөө загас шүүгээд авна даа гэж мөрөөдөх мэт хэлэв.

Эгч ах хоёрын ороо бүтээдэг хээ хуартай тор миний санаанд орж:

-Орны тор болохгүй юу гэж асуулаа.

-Тийм нарийхан юм яаж болох вэ гэж Ганзориг урамгүй хэлж байна. Би түүнийг:

-Тэр биш ээ. Бүр ор бүтээдэг том тор! гэж тайлбарлав.

-Тийм тор ч болно л доо. Ганцхан хаанаас олох вэ? гэнэ. Тэгээд бид хоёр баахан эргэлзэж адаг сүүлд нь ах эгч хоёрын орны тороор загас жаахан шүүж байгаад дараа нь угааж хатаагаад эргүүлж тавихаар тогтсон юм. Би гүйж хариуд тэр торыг олж ирлээ.

Урд талын нь хоёр үзүүрийг зангидаж хүүдийрхүү юм болгоод усан дотор чулуугаар дарж тавиад нөгөө хоёр үзүүрийг би барьж усан дотор зогсоод Ганзориг маань дээрээс урсгал уруудуулан загас үргээж байв. Миний барьж байгаа торны нугалаасны зүг загас явахыг үзмэгц би чулуунд дарсан үзүүрийг бушуухан авч дөрвөн үзүүрийг баримагц эргийн зүг шиддэг байв.

Ийм аргаар бид хоёр загас шүүж хэдэн жараахай, могой загас, ганц хоёр томхон шиг загас бариад жигтэйхэн баяртай байлаа. Тэгээд тороо угааж, бургасны мөчирт нэг үзүүрээр нь өлгөж доош нь намируулан хатааж байсан юм. Загасаа нарийхан төмөр утсанд хэлхэж аваад харьж шарж идье гэж ярилцаж байв.

Гэтэл бидний ар талд,

-Та нар энд юу хийж байгаа юм. Аль вэ явцгаа! гэж зандрах эр хүний бүдүүн дуу гарахад эргэж харвал намхан пагдгар булиа цэрэг зогсож байна. Түүний дэргэд нимгэн дан дээлтэй нэг эгч биднийг сонирхон хараад зогсож байв.

-Бид загас барьж байна. Хүүхээ ах аа гэж Ганзориг танимгайрхан хэлэв.

Би тэр танихгүй ахыг, бас л загас барих гээд биднийг хажиглаад байна гэж бодсон юм. Тэгээд:

-Танихгүй ах аа? Та биднийг явуулж яах гээ вэ? Загасаа үргээнэ гээ юу? Бид саад хийхгүй ээ Та бургасны цаана очоод загасаа бариач гэж гуйлаа.

-Хүүе яанаа? Яасан доогтой жаал вэ, наадах чинь гэж танихгүй эгч дуу алдлаа. Цэргийн ах, яасныг бүү мэд, царай нь хувьс гээд:

-Яана гэнээ! Чи яасан их үгтэй жаал вэ. Давай, одоо эндээс зайл! гээд намайг түлхэж унагаав.

Би модны үзүүрт өлгөөтэй байсан торныхоо үзүүр дээр ойчтол тор минь хүү татагдаад уначихлаа.

-Аа яасан онгироо юм бэ. Хүний тор уруулчихлаа гэж би бараг уйлганан хэлэв.

-Та хүүхдийн тор төлж өгөөрэй гэж Ганзориг ч уурлан хэлээд хэлхээтэй загасаа шүүрч авав.

-Яасан их төлүүлдэг эд вэ? гэж тэр ах Ганзоригийн гараас загасыг шүүрч аваад усанд шидчихлээ.

-Аль вэ, бушуул. Холдоцгоо! Олон юм гон гон гээд байвал толгойгоор чинь усанд гударчихна шүү гэж тэр ах яахаас ч буцахгүй янзтай сүрдүүлсэнд бид хоёр нэгэнт түүнийг дийлэхгүй болохоор аргагүй уранхай тороо хумхиж аваад зайллаа.

-Энэ шал онгироо эд байгаа юм. Аавын тэргийг барьдаг юм. Ёстой зэрлэг хог байгаа юм гэж Ганзориг хэлэв.

Бид хоёр тэр цэргийн ахад нэн их гомдож уур хүрч явлаа. Би одоо орны тороо яахаа мэдэхгүй явлаа. Хүү татагдсаныг нь аятайхан эвлүүлээд орон дээр бүтээгээд тавихаас өөр мэхгүй болжээ. Одоо бодвол би өнөөдөр ахын хэлснээр томоотой байж чадсангүй. Аанай л хэрэг тарьчихжээ. Энэ гайтай цэргээс л боллоо доо.

-Хоёулаа энэ зэвүүн цэргийг нэг чадах уу? гэж Ганзориг маань гэнэт хэллээ.

-Тэгье! Харин яаж? гэж миний дуртай зөвшөөрөн асуухад

-Цаад хоёр зэвүүн амьтан чинь өдийд усанд орж байгаа. Хоёулаа хувцсыг нь нуучихъя гэнэ.

Бид хоёр эргээд сэмхэн явж бургасан дотроос харвал өнөөх ах эгч хоёр үнэхээр усанд орж байна. Нэг бургасны цаана усан дотроос хөгжилдөн инээх дуу сонсдож байна.

Тэр бургасны хойд ёроолд тэдний хувцас байгаа бололтой цагаан эрээн дан дээл харагдаж байна. Бид хоёр сэмхэн гэтэн очиж дан дээл, цэрэг ногоон өмд цамц гурвыг аваад буцаж бургасан дотор нуугдаад

-Хаана нуух вэ гэхэд минь Ганзориг,

-Модон дээр өлгөж орхиё гэж хэлээд богино өмднийхөө халааснаас нойлын утас гаргаж, гурван хувцсыг нямбайлан эвхэж утсаар баглав. Нөгөө үзүүрт нь гонзгой чулуу уяад нэг өндөр модны мөчир дээгүүр шидлээ. Тэгээд чулуутай утаснаас татаж баглаатайг өндөр мөчирт дүүжлээд үзүүрийг доод талын нэг гишүүнээс уяж орхив.

Бид хоёр сэмхэн зайлж цэргийн майхны хавьд очоод бургасан дотор нуугдаад харж байлаа.

Хувцсаа алга болсныг мэдээд тэр хоёр яаж сандран эрэх бол? гэж бодохоос бид хоёрын инээд хүрч байлаа. Би уранхай тороо ч бараг мартчихаад бургасны чөлөөгөөр нөгөө хоёр хүний гарч ирэхийг харах гэж харуулдаж байлаа. Тэгээд нэлээд удлаа. Тэр хоёр мэдээгүй л байгаа бололтой чимээ алга.

Цэргийн майхны тэнд нэг цэрэг гарч ирээд бүрээ үлээж байна. Үдийн хоолоо идэх болж байгаа юм байж гэж саналаа. Одоо л гарч ирнэ дээ гэж бид ярилцав. Удалгүй нээрэн цэргийн ах дотуур цагаан өмдтэй, бургасны чөлөөгөөр гараад ирлээ. Нөгөө эгч том алчуур цээжин биеэрээ ороочихсон сарафантай дагаж яваа харагдана. Бид хоёр тэсэлгүй жиг жуг инээж, бургасаар далдлан гүйж гэрийнхээ гадаа хүрлээ.

Цэргийн ах майхны ойрхон ирж дагуулж явсан хүнээ орхиод гүйж майхандаа орлоо. Тэгээд нэг юм бариад буцаад явж байгаа харагдана. Тэр хоёр буцаад явж байгаа нь бургасны чөлөөгөөр зэрвэс харагдаад далд орлоо. Өнөө хоёр хувцсаа баахан сандран эрж олоод буцаж яваа харагдана. Хэн нуусан юм бол гэсэн шиг ийш тийшээ харж зогссоноо цааш яваад өгөв.

-Энэ зэвүүн жолооч ахыг нүцгэн сандарч байхад нь түргэн жагсаалын бүрээ дуугарсан болоосой. Бид түүнийг сүрхий чадах байж дээ гэж бодоцгоолоо.

Бид хоёр ингэж тэр ууртай цэргийг сандраасан боловч өөрснөө ч бас түүнээс болоод багагүй зэм хүлээсэн юм. Орны торыг нь урснаас болоод би эгчид загнуулснаар барахгүй ах тэр хоёрыг хооронд нь хэрэлдүүлсэн юм.

Би биеэ засаж томоотой байя гээд байхад ялаанаас аваад хажиг цэргийг хүртэл элдэв юм намайг өдөөд тун болохгүй, нэг мэдэхэд л би зүггүйтчихсэн байх юм. Тэгэвч тэр зун Ганзориг бид хоёр цэцэг навч, эрвээхэйн хатаамал хийж, Сонгино хайрхны оройд гарч чулуу, сонгино эрж, чагчаахай барин, бас зурам агнан аятайхан сайхан амарсан юм.

Өөрчлөлт

Тэр намар намайг сургуульдаа очиход гайхалтай өөрчлөлт гарсан байна. Манай сургуулийн дүнзэн байшин, анги танхим цөм хуучин янзаараа боловч шал ондоо болчихсон байна.

Сургуулийн хашаан дотор нэг ч эмэгтэй хүүхэд харагдахгүй, тэдний үхэр хулгана шиг час час хийсэн орилоон чарлаан ч дуулдахгүй байлаа. Би бүх эмэгтэй хүүхдүүдийг сургуулиасаа нэгмөсөн гаргачихсан юм уу гэж гайхаад ангийн үүдэнд тааралдсан Гонгороос

-Найз аа манай эмэгтэй хүүхдүүд хаачаа вэ? гэж асуулаа. Тэр зэвүүн жаал жортгор нүдээ доогтой жоотойлгоод

-Хи-хи Салаад явчихсан... Чи Сө... Нямаагаа үгүйлж байна уу гэж намайг өдөж байна.

-Хуц, Тэр чинь миний Нямаа юм уу? гэж би хариултал,

-Тэгвэл чи ноднин хэнтэй сууж байлаа? гэж асууж байна.

Би, нэг ширээнд сууж байсан хүүхдийг минь асууж байна гэж бодоод

-Нямаатай сууж байсан гэж хариуллаа.

-Харин тэгээд яагаа вэ. Чамтай сууж байсан Нямаа чинь салаад явчихсан гэж байна гэж тэр эгдүүтэй жаал үг гуйвуулан далимдуулан холбож шоолж байна. Би түүнийг цохих гээд далайтал тэр ангидаа гүйгээд орчихлоо. Тэгтэл Ганзориг хүрч ирлээ.

-Найз аа хар аа! Нэг ч эмэгтэй хүүхэд алга. Цаадуул чинь яачхаа вэ? гэж асуулаа. Ганзориг:

-Чи мэдээгүй юм уу? Манай сургууль дан эрэгтэйчүүдийн сургууль болсон. Нэгдүгээр сургууль дан эмэгтэйчүүдийн сургууль болсон гэв.

Тэгээд бид хоёр гүйж ангидаа ороод нэг ширээнд суулаа. Ангид үнэхээр нэг ч эмэгтэй хүүхэд алга. Анааш Долгор ч алга. Ховч хар хочтой Нямаа ч алга. Одоо намайг өрөөсөн нүдээрээ ажаад ховлоод байх хүүхэд алга болжээ. Нямаагийн шилжсэн нь надад яамай санагдлаа. Одоо бол би Ганзориг сайн найзтайгаа хамт нэг ширээнд сууна.

Манай ангид зэргэлдээ ангийн маань хүүхдүүд орж ирээд суучихсан байна. Бас танихгүй хүүхдүүд ч ороод иржээ. Тэд ижил буруу мал шиг ангийн нэг буланд бөөнөөрөө суучихсан байна.

-Та нар юунд манай ангид ороод ирээ вэ? гэж би урдаа суусан зэргэлдээ ангийн жаалаас асуулаа.

-Танай манай хоёр анги нийлсэн шүү дээ гэж тэр жаал хэллээ.

Гуч гаруй эрэгтэй хүүхэд нэг ангид орж ирээд суучихсан болохоор эмнэг адуу хашчихсан юм шиг тэжигнэн шуугилдаж байлаа.

Одоо манай ангийн багш орж ирээд л яасан их уурлаж, хашхирах бол гэж бодож суутал нэг өндөр бор эрэгтэй багш ороод ирлээ. Харсан чинь ноднин жил манай ангийн хурал дээр суусан багш мөн байна.

Би хүүхдүүдийг дагалдан босохын хамт Ганзориг тийш гилжийж:

-Манай хуучин багш яасан бэ? гэж асуулаа.

-Орлио багш маань эмэгтэй хүүхдүүдтэйгээ хамт шилжсэн гэнээ гэж Ганзориг шивнэв. Багшийг мэндлэхэд бид мэндэлж Амар гэдэг жаал рапорт өглөө. Багш бидэнд “сууцгаа” гэж зөөлхөн хэлэв. Хүүхдүүд ширээ сандлаа тачигнуулан суутал тэр багшийн нүд бид бүхнийг гүйлгэн харснаа тэмдэглэл журналаас бидний нэрийг дуудаж ээлж дараалан босгож танилцлаа.

Багш дараа нь босож:

-За би бол танай ангийн багш. Миний нэр Тайван. Та нар харин Тайван гэхээр намайг элэг бариад үймүүлээд байна гэж санаж байгаа бол дэмий шүү. Манай сургууль дан эрэгтэй хүүхдийн сургууль боллоо. Эрэгтэй хүүхдүүд их ноцолддог. Зодоон цохион хийдэг. Тэгж болохгүй шүү. Нэг нэгнийгээ худлаа ховлодог, хүний нүд хуурч далдуур үймүүлдэг хүүхдэд би тун дургүй шүү.

Үнэн үгээ хэлдэг шударга сурагчид би хайртай. Цөмөөрөө та нар шударга, сахилга баттай суралцана шүү гэж хэлэхэд бид:

-За! гэж тангараг өргөж байгаа юм шиг нир хийтэл хашхиралдлаа.

Тэр багш манай хуучин багшийн адил үргэлж хашхичаад загнаад байдаггүй шууд л хичээлээ заагаад гардаг хүн юм. Заримдаа ямар нэг хүүхэд хичээл анхаарахгүй үймүүлж, ширээ сандал шажигнан чимээ хөдөлгөөн гарч эхлэхэд Тайван багш хичээл заасан чигээрээ мөртөө ширээ тогшиж эхлээд тунгалаг шилний цаанаас өрөмдөх адил ширтэх нүд нь хэдийн тэр хүүхэд дээр туссан байх юм.

Тэр нүдний харц “Чамайг ч аашилмаар хүүхэд байна. Даанч ам завгүй. Оронд нь би чамайг хатуу зэмлэж ирлээ дээ” гэж хэлж байх шиг санагддаг юм. Багшийн ширээ тогшиход үймүүлж байсан хүүхэд түүнийг сонсоод харцтай нь тулгармагц илбэнд орсон мэт томоотой болох бөгөөд багшийн харцаараа дуугүй зэмлэх нь амаараа загнахаас хавьгүй аймшигтай санагддаг байлаа.

Тайван багш хичээлээ их ойлгомжтой сонирхолтой заах юм. Тэгэхлээр хичээлийн цаг гялс гээд хэдийн дуусчихсан байх юм. Хичээл дундуур заримдаа сонин жаахан үлгэр юм уу зохиол, шог үг ярьж өгдөг юм. Сүүл сүүлдээ бид “Багшаа юм яриач!” гэж гуйдаг боллоо. Одоо ангийн багш нэгэнт ийм өөр хүн болсон болохоор манай хичээл бөөн баяр хөөр, кино жүжиг шиг юм болоод, хорины хуралтай огт адилгүй болжээ.

Сүүлчийн хичээл дээр харин миний улны гижиг л хааяа хүрэх гээд байдаг юм. Тэгэхээр нь би харандаагаа шалан дээр тавьж байгаад хөлөөрөө дэржигнэтэл нитгэрч эхэлсэн юм. Багш миний тэгж үймүүлж байгааг бас харчихсан боловч загнасангүй, харин “За хүүхдүүд ээ та нар ядарч байна уу?” гэж асуугаад “үгүй” гэж биднийг хариултал “Бос!” гэж хамаандлаад гимнастик хийлгээд суулгаж билээ.

Манай шинэ багш хичээлээ их намуухан мөртөө тод дуугаар заадаг юм. Түүний дуу “Та нар сонсвол зол чинь, эс сонсвол хохь чинь. Би ийм сонин юм ярьж байна” гэж шивнээд байх шиг санагддаг юм. Энэ дуу ер нь хүнийг аргадад үнсээд ч байгаа юм шиг нэг л хачин.

Сэмхэн Гонгор аанай л багшийн ширээний дэргэд суучхаад өнөөх л зангаараа багшийн журнал тэмдэглэлийг сэмхэн сэмхэн шагайж байдаг байв. Багш түүний нь хэдэн удаа ажаад нэг удаа Гонгорыг босгож

-Чи тагнуул хүн шиг дандаа хүүхдийн дүн рүү сэмхэн гэтэж байх юм. Юунд тэгдэг юм бэ? гэж зэмлээд түүнийг арын ширээний нь хүүхэдтэй сольж суулгасан юм.

Гонгорын улцгар шар царай энэ удаа газрын бөөс шиг час улаан болоод юу ч дугараагүй бөгөөд ер нь Гонгор нэг л уйтгартай байх болсон шиг надад санагдах болсон юм.

Ангийн багш солигдсон явдал манай ангид маш их өөрчлөлт гаргаж хамаг юмыг танигдахын аргагүй болгож билээ.

Буруу арга

Хоёрдугаар улирал эхлээд удаагүй байлаа.

Нэг өглөө намайг сургуульдаа явахаар гэрээсээ гарахад шинэ жилийн сүлд модны чимэглэлийн хөвөн шиг том том сэвсгэр ширхэгтэй нойтон цас лавсан орж байлаа. Би бушуухан буцаж гэртээ ороод (энэ жил намайг

хичээлдээ сайжирч нэлээд хүмүүжсэн гэж үзээд ахынд биш, гэртээ ээжийн гар дээр байлгаж байсан юм) эсгий гуталтай хөлдөө хоёр муу хуучин галоошаа углаж авлаа.

Нойтон цастайд галоошгүй бол эсгий гутал дороосоо нэвтэрч нурууд эвгүй байдгийг та нар мэднэ. Тийм болохоор миний галоош өмссөн минь хөлөө хамгаалах гэснээс өөр юмгүй.

Тэгтэл үд болоход тэнгэр цэлмэж, нар ээж, дулаараад, орсон цас хайлмагтан нал шал болж хавар болчихсон юм шиг хачин байв.

Үдийн (хорин минутын) завсарлагаагаар Ганзориг бид хоёр сургууль дээрээ үлдээд захирлын байшингийн урд талбай дээр тоглож байв. Хөл бөмбөг тоглож байсан юм. Ганцхан бөмбөг гэдэг маань ердөө л сүүний лааз төдий юм байсан юм. Захирлын байшин, манай ангийн байдаг цагаан байшин хоёрын хооронд бидний хөл бөмбөгийн талбай байлаа. Тэр нарийхан зайд бид, хоёр хоёр хугархай туйпуу тавьж хаалга гаргасан юм. Тэгээд ээлж ээлжээр хоёр хаалгандаа бөмбөг (лааз) оруулж л байлаа.

Тэгээд би захирлын байшингийн цонхоор санамсаргүй нэг шагайж харлаа. Тэгтэл манай сургуулийн захирал Дашням гэдэг хамар дороо жаахан сахалтай бүдүүн хүний оронд намхан бүдүүн халзан хүн өрөөний голд байгаа ширээний дэргэд цаашаа харж суугаад мах идэж байх шиг харагдана. Тэр хүний нугалуур шиг богинохон хүзүүн дээр хуруу зузаан нугалаа гарчихсан нь эгдүүтэй харагдав. Цааш нь ажиглавал манай захирлынх биш, өөр айл ирээд энэ байшинд орчихсон шиг харагдав.

Захирал маань солигджээ гэж би бодоод довжооноос бууж, бие засаад ирж байгаа Ганзоригоос:

-Найз аа, манай захирал солигдоод өөр хүн болоо юу гэж асуув.

-Үгүй байлгүй. Яаж байна? гэж сөргөөн асууж байна.

Захирлын байшинд огт танихгүй хүн мах идээд сууж байна.

-Аа энэ үү? Энэ чинь арван зургаагийн (16 дугаар сургуулийн) захирал байхгүй юу. Манай захирлыг хөөж гаргаад байранд нь ороо биз гэж Ганзориг хайхрамжгүй хариулж байна. Захирлыг хөөж гаргаж болдог юм байж дээ гэж би гайхав.

-Яагаад, манай захирлыг хөөж байгаа юм бэ? гэж асуухад

-Энэ захирал чинь захирлыг маань байтугай манай сургуулийг бүхлээр нь хөөгөөд явуулж байгаа юм байхгүй юу. Энэ чинь одоо манай сургууль биш. Арван зургаа болж байгаа шүү дээ. Чи бодооч, зүүн хашаанд манай сургуулийн хүүхэд нэг ч байхгүй шүү дээ. Цөмөөрөө л арван зургаагийн хүүхдүүд орчихсон. Хоёр гоё дүнзэн байшингий маань тэд эзлээд авчихсан. Одоо манай баруун хашааны анги, клубийг ч эднийх эзэлнэ. Манай анги ч удахгүй хөөгдөнө дөө гэж ярив.

Захирлын байшингийн цонхоор миний саяын харсан нугалаа гарсан хүзүүтэй бүдүүн хүн манай сургуулийн хамаг юмыг, өвөөгийн зандан хашлага шиг гоё өнгөтэй хүрэн дүнзэн байшинг ч цөмийг эзлээд, биднийг хөөж нэг тийш нь явуулж байгаа “гэмт” хүн шиг санагдаад явчихлаа. Тэгээд би

-Бид тэгээд энэ захиралд хөөгдөөд хаана очих юм бэ?

-Хойшоо л их сургуулийн тэр өөд явах юм гэнэ лээ гэнэ.

-Хүүш тэгвэл бүр баларсан юм болох нь. Манайхаас хамаагүй хол болох нь. Бид энэ арван зургаагийн захирлыг байшингаас нь хөөж гаргавал яасан юм бэ? гэж би санал гаргав.

Ганзориг бараг мэдэгддэггүй шар хөмсгөө өргөж урт сормуустай жоотгор нүдээ дүрлийлгэн:

-Яаж? гэж асууж байна.

Хүнийг ангиас юм уу байрнаас яаж хөөж гаргадаг билээ гэж би бодов. Манай ангийн хуучин эмэгтэй багш биднийг ангиас хөөж гаргахдаа цэрдээрээ юм уу харандаа, заагуур модоороо ч юм уу, хойноос шидээд гаргадаг байсан шиг санагдана.

-Яах вэ, хоёулаа энэ захирлыг цонхоор нь юмаар шидээд хөөж гаргая гэв.

-Аа үхсэн. Тэр яаж болдог юм. Харин сургуулиасаа хөөгдөж байгаагийн хариуд нэг юмаар шидээд үзсэн ч яах вэ. Лаазаараа цонхы нь хага шидэх үү? гэж найз маань уруулаа мушийлган гараа сарвагас хийлгэв.

-Үгүй тэгвэл санаатай хагалсан юм шиг болно. Чи миний энэ өрөөсөн галоошийг өлмийдөө углаад зугтааж яваад цонхны тушаа хаячих. Би очоод цонх руу нь өшиглөж орхиё гэж би “мэргэн” ухаан гаргав. Цонх нь хагарчихвал энэ багш нүүгээд явах ч магадгүй гэж би дотроо бодлоо.

Тэгээд би өрөөсөн галоошаа сугалаад орхитол Ганзориг өлмийдөө углаад догонцон гүйж захирлын цонхны тушаа хаяад цаашаа зугтаалаа. Би эрчээрээ гүйж очоод галоошаа захирлын цонх руу өшиглөөд тавьчихлаа. Галоош гарамгай хөл бөмбөгчний өшиглөсөн бөмбөг шиг харваад дотогшоо нээлттэй байсан салхивчаар шүнгэнэн ороод тар няр гээд явчихлаа. Бид хоёр хар хурдаараа гүйж ангийн байгаа байшингийн баруун булангаар тойрч ангидаа орлоо.

Би цонхны нь шилийг онож чадсангүй дэмий боллоо гэж дотроо харамсаж байв. Тэгтэл тэр галоош арван зургаагийн захирлын толгой дээр буучихжээ.

Бид хоёрын гүйж ангидаа орохыг захирлын охин харчихсан юм байж. Бидний хойноос нэг танихгүй багш орж ирээд ангид бид хоёроос өөр хүүхэд байгаагүй тул биднийг шууд барьж аваад, захирлын байранд аваад очих нь тэр. Биднийг ороход тэр намхан халзан хүн хамаг шүд нь цөмөөрөө өвдчихсэн юм шиг царай муутай сууж байлаа.

-За та хоёр яах гэж цонхоор галоош шийддэг билээ. Хэн багшийн сурагч вэ. Хэддүгээр ангийн хүүхдүүд вэ? гэж тэр захирал асууж байна.

Бид хоёр анги багш хоёроо хэлээд дуугүй зогсож байлаа.

Удалгүй манай ангийн багш бас ороод ирэв. Гадаа цонхоор хүүхдүүд шавалдаж байна. Бодвол бидний хийсэн хэргийг дуулчихсан бололтой.

-За танай ангийн энэ хоёр хүүхэд ч болдоггүй улс юм даа. Цонхоор галоош өшиглөөд сүйд хийчихлээ, нөхөр багш аа! Та энэ сахилгагүй сурагчдадаа нэг арга хэмжээ ав даа гэж тэр танихгүй захирал хэлэхэд багш бидний зүгт их л зэмлэсэн харцаар харж

-Тэгье. Ийм зүггүй гайхлууд гэж байх уу гэж багш маань жаахан айсан маягтай хэлж байна.

-Энэ сахилгагүй хүүхдүүдээ сургуулиас хөөлгөж байх нь яадаг юм. Юу гэсэн үг вэ, даан ч эдгүй задарсан юм гэж захирлын авгай шувуу шиг дув дугариг нүдтэй, туранхай цагаан царайтай эмэгтэй хангинан загнаж байна.

-Эд арай ч санаатай тэгээгүй байх л даа. Энэ хоёр хөл бөмбөг тоглож байсан юм байна. Тэгээд л галоошаа суга өшиглөсөн юм уу, хаашаа юм гэж захирал хэлэв.

Бид хоёр энэ царай нь барайсан намхан бүдүүн хүнийг гайхан харлаа. Түүний амнаас ийм элэгтэй зөөлөн, уучлангуй үг гарах юм гэж санаагүй байсан юм. Гэвч энэ хэрэг хичээл ангид хүрч улмаар бид хоёрыг сургуулиас хөөж зайлуулах сураг гарсан юм. Бид хоёр шинэ ирсэн сургуулийн захирлыг хөөж явуулах арга сэдсэн маань харин өөрснийгөө сургуулиас хөөлгөх арга байжээ гэж бодов.

Нэг өдөр манай багш бид хоёрыг ангид үлдээж бага ангийн хичээл эрхлэгчийн хамт асуусан юм. Тэр хичээл эрхлэгч багш:

-Эд эртээр бас сахилгагүйтээд сэргийлэхэд хүргэгдэж шийтгүүлсэн. Одоо бас энэ. Ерөөсөө болдоггүй хоёр юм аа. За та хоёр ямар санаатай галоош өшиглөв? гэж асуув.

Манай багш тунгалаг шилнийхээ цаанаас өнөөх шөвөгдөж байгаа юм шиг харцаараа бид хоёрыг ээлжлэн ширтээд

-Уул нь энэ хоёр бөмбөг тоглож байгаад санамсаргүй өшиглөсөн юм шиг байгаа юм. Гэхдээ энэ ч арай л дэндсэн хэрэг дээ гэв.

Манай багш бидэнд хэлэхдээ ямар ч нөхцөлд шударга байж хийсэн хэргээ нуудаггүй, үнэнээр нь хэлдэг хүн л хүмүүжиж сайн хүн болдог гэж сургадаг юм. Иймд би хэллээ:

-Би энэ хэргийг санаатай хийсэн юм гэж хэлэхэд манай багш намайг гайхан бүлтийж хараад хөмсгөө атируулав. Нөгөө багш:

-Уухай, за ямар санаатай хийсэн бэ? гэж шохоорхон асуув.

-Энэ захирлыг хөөж явуулах гэсэн юм гэж хэлэхэд манай багш бүр гайхаж байгаа бололтой

-За яаж байгаа нь тэр вэ? Энэ захирал чамд ямар гай болоо вэ? гэж асуулаа.

-Энэ захирал манай сургуулийг булааж аваад биднийг бас хөөж явуулах гээд байгаа юм гэж би дуулсан гэв.

Тэр хоёр багш гэнэт инээд алдав. Хичээл эрхлэгч:

-Аа тийм бий. Захирлыг тэгээд хөөчдөг юм бий. Арга чинь зөв дөө хө. Тэгж санаатай хийсэн юм бол одоо энэ захирлын оронд чамайг л сургуулиас бүрмөсөн хөөхөөс аргагүй болж дээ гэж хэлсэн юм.

Ингээд бид хоёр сургуулиас хөөгдөх туугдах дээрээ болж манай ээж уйлж, Галдан ах дээр очсон юм. Галдан ах манай шинэ сургууль дээгүүр явж миний төлөө хөөцөлдөж, ярилцсан гэж ээжид хэлж байв.

Ямар ч юманд буруу арга хэрэглэвэл өөртөө аюултай юм билээ.

Сургуулийн шинэ байшинд

Ганзориг бид хоёрыг сургуулиас хөөгдөж амжаагүй байтал манай баруун хашаанд үлдсэн хэдэн анги сургуулийн шинэ байшинд шилжлээ. Хөөгдчихсэн бол энэ сайхан байшинд хичээл хийж үзэхгүй, азгүй юм болох байжээ. Биднийг тэндээс хөөж, ийм сайхан байшинд оруулах гэж байсны нь

мэдсэн бол тэр захирлыг “хөөх” гэдэггүй л байж гэж Ганзориг бид хоёр гэмшин ярилцаж байлаа.

Манай сургуулийн шинэ байшин хуучин ганц дан хүрэн дүнзэн байшинтай маань хавьтах юмгүй, тэнгэрт тулсан дөрвөн давхар байшин байлаа. Өрөө анги нь цэлгэр, гурав гурван том саруулхан цонхтой. Гудам хонгил нь уудам. Дотуур нь хурдан гүйлтийн уралдаан явуулсан ч болмоор юм. Дулаахан гэдэг нь эсгий гуталтай байтугай, дүрэмт хувцастай ч хичээл хийхэд халууцмаар.

Хамаг юм нь цоо шинэхэн. Шал хана туурга нь нүүр харагдмаар цэвэрхэн, гялалзаж гялтганасан юм. Шинэхэн будгийн үнэр үнэртэй ус шиг гоё ханхалж байлаа.

Манай анги дөрөвдүгээр давхрын мухарт баруун тийшээ харсан өрөө байна. Тэгэхлээр хичээлд хожимдоод очвол найман удаа тахирласан шатаар гүйж гарах хэрэгтэй. Энэ бол их л зугаатай, саадтай уралдаан шиг санагдаад хөгжилтэй байдаг юм. Орой хичээл тараад шатны бариул дээгүүр хэвтээд гулгаж буухад, хөөх, ямар гоё гэж санана. Ямар ч өндөр уулнаас чаргаар бууснаас дутахгүй гээч. Ганцхан аюултай. Нэг хүүхэд тэгж гулгаж байгаад шатнаас унаад тархиа хөдөлгөчихсөн. Түүнээс хойш багш нар ч цэвэрлэгч нар ч биднийг харсан байвал загнаад гулгуулахаа байсан юм. Гэвч загнах хүнгүйд бол хааяа гулгаж болдог юм.

Шинэ байшингийн гудмаар хашхирахад их сонин. Манай хуучин ангийг бодвол яг хад шиг цуурайтна. Тэр сайхан уудам байранд орохоор л байдгаараа хашхирмаар санагддаг сан. Бид хашхиралдаад засварлагаанаар бужигнахаар манай сургууль бүхэлдээ олон шаазгай шахтанасан ой мод шиг их сүртэй чимээтэй болдог юм. Багш нар завсарлагаанаар дуулуулах дуртай байдаг юм. Дуулахад хашхирахаас доргүй шуугиан үүсдэг боловч энэ шуугианд багш нар дуртай.

Анги тэнхимийн дотор ч хөндий гудамд ч бас гүйж дэвхэрч цовхорч үзмээр санагддаг юм. Тэр сайхан шалан дээр гүйж харайхад бас их дүргээн гардаг юм. Манай шинэ байшинд хэдэн зуун эрэгтэй хүүхэд сурдаг болохоор завсарлагаар тэд гүйж харайхгүй думбайгаад зогсоод байх нь ховор. Нэг маань өдөөд нөгөөгийнхөө дал мөрөн дээр алгадаад зугтаана. Тэгэхлээр тэсэх арга алга. Түүний хойноос хөөцөлдөхөөс л аргагүй. Зугтаасан нөхөр маань олон хүүхдийн дундуур ороо морь шиг сүлжин зугтаана. Хөөж яваа хүүхэд өөр гүйж харайж байгаа хүүхэдтэй мөргөлдөнө. Хичээл дээр бүхэл дөчин таван минут гөлийтөл суусан биеийг ингэж гүйж харайж амраахгүй бол дараагийн хичээл дээр нойр хүрэх гээд байдаг юм.

Гэтэл гүйж харайхад манай давхрын цэвэрлэгч Цэгмид гуай тун дургүй. Тэр авгай өөрөө их бүдүүн, залхуу хүрмээр удаан хөдөлдөг болохоороо бидний гүйж харайхад дургүй байдаг байх. Цэгмид гуай хичээл тарсны дараа хонгил гудмаар гүйж яваа хүүхэдтэй тааралдвал:

-Аяар яваач! Адуу мал шиг тэчигнээд... Хичээл тарчихсан байхад юугаа хийж энд бужигнаад байгаа юм... гээд энэ ханагар том байшингийн ганц эзэн хүн шиг биднийг хөөгөөд болдоггүй юм.

Манай давхрын хонгилын хойд мухарт Цэгмид гуайн төмөр хувин, шүүр, шалны алчуур тэргүүтнээ хийдэг нэг шүүгээ байдаг. Тэр шүүгээ

ёроолгүй юм. Ёроол нь нэг муу сэмэрсэн даранз мод байж байгаад нүүхэд уначихсан юм байх. Түүнд нуугдаж хүүхэд цочоох ч сонин.

Ганзориг бид хоёр нэг өдөр хичээл тарснаас нэлээд хойно сургууль дээрээ очиж тоглоё гэж шийдсэн юм. Тэр өдөр Цэгмид гуай маань алга байсан юм. Жижүүрийг л аргалаад орчихвол хөөгөөд туугаад байх хүнгүй санагдсан юм.

Ганзориг бид хоёр дөрөвдүгээр давхрын хонгилоор гүйж хөөцөлдөж байтал гэнэт урд шатны аман дээр Цэгмид гуайтай халз мөргөлдөж орхисон юм. Цэвэрлэгч авгай маань цочиж

-Олгой чинь хагар. Олс шөрмөсөөр боолго гэж учир нь олдохгүй үг шүлэглэж дуу алдаад дараа нь биднийг таньж:

-Ёо ёо, хоёр чөтгөрөөс ингэж айх гэж. Үнхэлцэг хагарчих дөхлөө... Та нар юугаа хийж яваа юм? Хичээл тарчихсан байхад, одоо явцгаа, явцгаа гэж хөөв.

Бид хоёрыг чөтгөр гэж бодоод л үхтлээ айсан юм байх гэж бодоод би:

-Эгчээ та чөтгөрөөс их айдаг уу? гэж асуулаа.

-Юу? Чөтгөр байх биш, юунаас нь айх вэ дээ. Дэмий юм асууж шалгаалгүй явцгаа, явцгаа гэж байна.

Үүнд би эргэлзэн гайхлаа: нэг бол “айсан” гэдэг нь худлаа, эсвэл “айдаггүй” гэдэг нь худлаа баймаар санагдлаа.

Ганзориг юу бодсоныг бүү мэд.

Бид одоо явлаа явлаа гээд буух шат руу алхав.

Би хойноос нь гүйцэж очоод, тоглоно гэснээ болив уу? гэж түүнээс асуулаа.

-Хаанаас, тэгж хэлэхгүй бол цаад Цэгмид гуай чинь болохгүй. Хоёулаа гуравдугаар давхрын шатаар хойшоо эргээд клубийн үүдний тэнд очъё гэж байна.

Би түүний уран аргыг зөвшөөрч хоёул урд шатаар бууж гуравдугаар давхрын хонгилоор явж хойд шатны дэргэд очлоо.

Бид хоёр өөрсдийн хийсэн шинэ телефон утсаа шалгаж үзэх гэж ирсэн юм. Урьд бид хоёр түүнийг нойлын хар утасны хоёр үзүүрт чүдэнзний хоосон хайрцаг бэхэлж хайрцгийн нэг талыг бичгийн зүүгээр хэд шивж хийдэг байсан юм. Энэ удаа чүдэнзний хайрцгийн оронд гутлын тосны хоосон дугуй төмөр сав хэрэглэж хийсэн юм. Түрүүчийн телефон утсаар ангийн дотор хаанаас ч бие биетэйгээ ярьж болдог байсан юм. Энэ утсаар бол хоёр ангиас ч ярьж болмоор санагдаж байсан юм.

Бид хоёр зохион бүтээсэн шинэ зүйлээ туршиж шалгахаар энд ирсэн юм. Тэгтэл гай болоход Цэгмид гуай өдөр үзэгдэхгүй байснаа үдэш хүрээд ирсэн байх юм. Удахгүй яваад өгөх болов уу гэж бид хүлээж байгаа нь энэ. Сургууль дээр ер нь нуугдаж тоглоход ч их аятайхан таардаг газар байгаа юм. Дөрвөн давхар олон өрөөтэй болохоор нуугдаж тоглоогүй багш нар ч бие биеэ олохгүй биднийг гүйлгэх удаа байдаг юм.

Жаал азнаад бид хоёр дөрөвдүгээр давхарт гардаг хойт шатаар сэмхэн өгсөж гараад хонгил руу шагайж харлаа. Цэгмид гуай явчихсан бололтой, бараа нь харагдахгүй байв. Үүнд бид хоёр зориг орж, сэмхэн гүйж ангидаа орлоо.

Тэгээд утсаа шалгаж үзэх болоход Ганзориг ангидаа үлдэж, би утасны нөгөө үзүүрийг авч хонгилд гарч нөгөө ангид орох гэтэл дунд нь татсан нойлын хар утас арай хүрэхгүй юм. Богинодуулжээ. Тэгэхлээр нь цэвэрлэгчийн ёроолгүй шүүгээнд орлоо. Гудамжинд утасны ийм бүхээг зарим хотод байдаг юм. Би үүнийг киноноос олж мэдсэн юм.

Тэгээд бид хоёр ярьж гарлаа.

-Байна уу, байна уу? гэж аяархан шивнээд харилцуураа (гутлын тосны дугуй төмөр хайрцгаа) чихэндээ барихад Ганзориг бас

-Байна уу, байна уу? гэж асууж байгаа нь чихэнд шивнэсэн үг шиг боловч тодхон дуулдаж байна.

-Байна байна. Чи хэн бэ? Хэнтэй ярих вэ? гэж би асуулаа.

Тэгээд чагнасан чинь -Аа чи яасан балай эд вэ. Чи намайг танихгүй байна уу? Чамтай л ярихгүй хэнтэй ярих вэ гэж Ганзориг маань уцаарлан хэлж байх шиг. Би одоо юу хэлэхээ мэдэхгүй тулгамдлаа.

-Найз аа, утсаар өөр юу ярьдаг билээ? гэж би асуулаа.

-Аа чи битгий дэмий юм ярь л даа. Зүгээр л яриач, чи хаа байна? гэж асууж байна.

-Би хонгилын утасны бүхээгт байна.

-Юу, хаана утасны бүхээг байдаг билээ?

-Яагаа вэ, Цэгмид гуайн юмаа хийдэг шүүгээнд гэж хэлтэл

-Хүүш найз аа чи тэндээ байж бай. Би тэнд чинь очиж хамт ороод ярьж үзье гэнэ.

Миний хариу хэлж амжаагүй байтал Ганзориг сүр пар гээд над дээр орж ирээд шүүгээний хаалгыг хаав.

-Аа чи болиоч ээ. Ингэхлээр чинь утас чинь гогцоороод ярьж болохгүй шүү дээ гэж миний дургүйцэхэд

-Аа би эндээс ярья л даа. Ёстой утасны бүхээг шиг гоё юм. Чи ангидаа оч л доо гэнэ.

-Яршиг, чи оч.

Ингээд бид хоёр шүүгээн дотор маргалдаж байтал Ганзориг гэнэт

-Чишш-шш! гэж шүүгээний хаалганд нүүрээ нааснаа:

-Яанаа, Цэгмид гуай! гэж шивнэв.

Тэр шүүгээний сарампай модон хаалганд унасан ярны том нүх байсан юмсанж. Би тэр нүхэнд өрөөсөн нүдээ тааруулж нүүрээ наагаад харвал, Цэгмид гуай нээрэн яваагүй байжээ, хувин шүүр хоёроо бариад хонгилын нөгөө үзүүрээс наашаа маажигнан алхаж байна.

-Шүүр хувин хоёроо энд авчирч хийнэ дээ гэж миний шивнэхэд

-Тэгнэ ээ. Одоо яах вэ? гараад хойт шатаар зугтаах уу?

-Тэгэхлээр чинь таньчихна шүү дээ. Маргааш багшид хэлнэ.

-Тэгээд яах гэж?

-Шүүгээгээ өргөөд хоёулаа урдаас нь явах уу? Цэгмид гуай айгаад зугтаана байх. Тэгэхлээр нь хоёулаа хойт шатаар гараад зугтаах гэж миний хэлэхэд Ганзориг зөвшөөрлөө.

Ярны нүхээр дахиад нэг харсан чинь цэвэрлэгч бүдүүн авгай маань бидний байгаа шүүгээг хараад гөлөрчихсөн зогсож байна. Бидний шивнэлдэхийг дуулсан бололтой.

Тэгээд бид хоёр шүүгээгээ жаахан өргөөд урдаас нь алгуурхан хөдөллөө. Явуут нөгөө нүхээр нь харсан чинь тэр авгай нүдээ ирэмчин ирэмчин бүлтийж, уруул ам нь татганан хөдөлж ухарснаа гэнэт

-Еэ... Энэ чинь одоо юу вэ? гэж дуу алдан хувин шүүр хоёроо бидний өөдөөс шүнгэнэтэл шидэж орхиод

-Лхамсүрэн! гэж боож үхэх гэж байгаа юм шиг муухай бархираад эргэж бандганан гүйснээ хонгилын урд үүдний дэргэд, юманд тээглэсэн бололтой, тэрийгээд уначихлаа.

Бид хоёр шүүгээнээс санд мэнд гүйж гараад хойт шатаар харайн доошоо гүйж нэгдүгээр давхарт буугаад харвал нэг залуу цэвэрлэгч хүүхэнтэй хамт манаач өвгөн яаран сандран шатаар өгсөж яваа харагдав. Залуу цэвэрлэгч

-Яасныг бүү мэд. Ухаан алдаад уначихсан байна гэж ярьж явна.

Нэгдүгээр давхрын хонгилоор гүйж биднийг үүдэнд ирэхэд жижүүрийн ширээний дэргэд ашгүй хүн алга. Бид хоёр гараад гүйлээ.

Нөгөөдөр нь биднийг сургуульдаа ирэхэд үүдний жижүүрийн дэргэд хэдэн цэвэрлэгч авгай цуглаад ярилцаж байна.

-Тэгээд Цэгмид гуай гайгүй юу? гэж асуухад жижүүр өвгөн өндөг нь шарласан баравгар гараар хуруу бүдүүн тамхи ороож авах зуур

-Муу бүдүүн маань мажийх дөхсөн шүү. Зүрх муутай амьтан болоод толгой тархи нь эргээд нүдэнд нь хий юм харагдаад муужраад унасан юм уу, хэн мэдэх вэ. Үгүй тэгээд тэр муу ёроолгүй шүүгээ нь яахлаараа тээр наана ирчдэг юм. Тэр л хачин юм гэж хэлж байна.

“Мажийх дөхсөн” гэхлээр нь миний дотор пал хийгээд явчлаа. Би Ганзоригийг харвал тэр бас над руу айсан маягтай харж байна. Тэгтэл нэг цэвэрлэгч залуу хүүхэн:

-Сургуулийн энэ шинэ сайхан байранд юун элэнцгийн чөтгөр буг гарав гэж дээ. Энэ хүүхдүүд л үймүүлээ биз гэж бидний зүг дохих шиг болов.

Бид хоёр шатаар дээшээ гүйж гарахдаа

-Үүнээс хойш хүн айлгаж байхаа больё. Осолтой юм байна гэж ярилцлаа.

Энэ бол бидний сургууль дээрээ үймүүлсэн сүүлчийн хэрэг байжээ гэдгийг тэгэхэд бид мэдээгүй явсан юм.

Алсын аянд мордов

Тэр өдөр гуравдугаар хичээлийн завсарлагаагаар манай багш Ганзориг бид хоёрыг дуудаж:

-За та хоёр сургуульд явах дуртай юу? гэж асуух нь тэр.

Миний дотор пал гээд явчлаа. Одоо л бид хоёрыг сургуулиас хөөх нь дээ гэж бодов. Нүдэнд аяндаа нулимс бүрхээд ирлээ.

-Дуртай, багш аа гэж Ганзориг дуулдах төдий шивнээд уруулаа харж урвайн зогсоход түүний царай цав цагаан болсон харагдаж байв.

Би түүнийг дагалдаж:

-Дуртай, багш аа гэж шивнэлээ. Нүдэнд нулимс мэлмэрээд юу юугүй дуулах гэж байх шиг санагдаж байлаа. Ингээд л энэ сайхан сургуулиасаа хөөгддөг байж гэж бодохоор хоолой дээр нэг юм тээглэж орхих шиг боллоо.

-Та хоёр гүйж харайж, дэвхцэж цовхчих их дуртай байх аа? гэж асууж байна.

-Тийм байсаан, багш аа. Одоо бид хоёр яасан ч үймүүлэхгүй, томоотой сурч чадна гэж би уйлганан хэллээ.

-Сайн байна. Тэгвэл одоо ингээд та хоёрыг шалгалтад оруулна даа. Уйлдаг чинь яаж байгаа юм гэж багш хэлж байна.

Манай багш биднийг дагуулаад багш нарын өрөө рүү явлаа. Би дотроо “Багш нарын хурлаар оруулж, хийсэн хэргийг маань шалгаад л сургуулиас хөөх нь дээ” гэж бодлоо. Тэгж бодоход алхаж гишгэхэд хөл хоёр өвдгөөрөө сул болчихсон шиг санагдаж байлаа.

-За та хоёр наанаа хүлээж бай! гэж хэлээд манай багш, багш нарын өрөөнд орж явчлаа. Удалгүй манай багш:

-Хүүхэд бэлэн боллоо гэж хэн нэг хүнд илтгэж байх шиг хаалганы завсраар дуулдлаа. Тэгээд тэр дороо хэдэн хүн дагуулаад гарч ирсний дотор миний зүс үзсэнээс алдарт жүжигчин Оюумаа эгч байлаа. Бусад нь танихгүй улс юм. Сэргийлэхийн цагдаа нар байх гэж тэднийг харсан чинь энгийн хувцастай хоёр хүн байна.

Тэгээд бид хоёрыг багш дагуулаад эргээд явлаа. 16 ангид аваачив. Энэ энгийн ширээ сандлыг зайчилж, хойш нь хураасан байна. Хоосон тасалгаанд манай зэргэлдээ дөрөвдүгээр энгийн хэдэн хүүхэд бас байж байна.

Багш орж очоод самбарын урдуур хэдэн сандал тавьж өнөөх гурван хүнээ урьж суулгалаа. Биднийг шүүж шалгах хурлын тэргүүлэгчид шүүхийн улс юм байх гэж би тэднийг бодож байлаа. Багш бидэнд:

-За та нар одоо хувцсаа тайлцгаа гэж тушаалаа. Би хувцсаа тайлах зуур:

-Бид олуулаа хөөгдөх юм байна гэж Ганзоригт шивнэсэнд тэр дуугүй л толгой дохиж байна. Бид бүгдээр шуудаг өмд, дотуур цээживчтэй бараг нүцгэн үлдлээ. Сургуулиас хөөхдөө ингэж чармаа нүцгэлж хөөдөг юм болов уу гэж би гайхлаа.

-За та нар энд наашаа хараад жагс гэж манай багш бидэнд хэллээ.

“За жагсааж байгаад, баруун-тай-ший, алхаад марш!” гээд ангиас хөөгөөд гаргах нь дээ гэж бодож байлаа. Гэтэл тэгсэнгүй. Харин хоёр хөлөө тэгшхэн, өсгийгий нь нийлүүлээд зэрэгцээд зогс гэж тушааж байна.

Самбарын урдуур суусан улс бид арваад хүүхдийг удтал ширтэж хөлөөс толгой хүртэл дагуулан харж бидний хийсэн хэргийг маань нүцгэн биенээс минь эрж олох гэсэн юм шиг ажиглаад л байна.

-За алиныг гаргах вэ? гэж багш асууж байна. Тэгтэл Оюумаа эгч зургийн юм шиг тод давхраатай, сайхан алаг нүдээ жирвэлзүүлж инээмсэглээд

-Баруун талаасаа хоёр, гурав дахь хүүхдийг гаргаач гэж гуйлаа. Тэр нь Ганзориг бид хоёр байлаа. “Олон удаа зүггүйтсэн бид хоёрыг тэр эгч андахгүй мэдэж байна даа, яасан хачин юм бэ” гэж би сэтгэл түгшин бодлоо. Багш:

За Ганзориг, Төмөрсүх хоёр урагшаа алхаад! гэж хамаандлав.

Бид хоёр гарч зогслоо. Өөр нэг хүн Дөрвийн а-гийн нэг хүүхэд, дөрвийн б-гийн нэг жаалыг бас гаргуулав. Тэр хоёр хөөгдөхөө мэдэхгүй инээмсэглээд гарч зогслоо. Хамгийн баруун захад сууж байсан унжуу хамартай намхан шар хүн бас нэг хүүхдийг зааж бидэн дээр нэмэв.

-За энэ тавыг л шалгаж үзье дээ гэж Оюумаа эгч хэлж байна.

За бусад нь хувцсаа өмсөөд гарцгаа гэж манай багш зарлав.

Тэднийг хувцаслаад гарах зуур манай багш гурван хүнтэйгээ юм дүнгэр дүнгэр ярьж байна. Бид зогсоод л байлаа. Ганзориг бид хоёр ёстой томоотой зогсож байлаа.

Хүүхдүүдийг гарсны хойно бид тавыг гараа өргөөд нуруугаа хотойлго гэж тушаав. Дараа нь ер нь гимнастик хийлгэх гэж байгаа юм шиг элдвээр тэг ингэ гэж хөдөлгөв.

-Мост хийж чадах уу? гэнэ. Зарим нь чадна гэж байна.

Ганзориг бид хоёр:

-Чадахгүй гэлээ.

Дараа нь гүйлгэж харайлгаж, бас дэвхрүүлж цовхруулж үзлээ.

-За энэ тавыг юу ч болсон танай сургуулиас авбал яана? гэж зүүн захад нь сууж байсан хүн хэлж байна. Тэр ер нь сүртэй эр байна.

-За тэг тэг! Бид бол болно гэж бодож байна. Тэр хоёр дундаас хамгийн эхэнд гаргасан манай ангийн хоёр жаалыг би лав таарна гэж бодож байна. Энэ хоёр ер нь үсэрч цовхрох, харайж дүүлэхдээ янгир шиг, тэгээд ч гойд сэргэлэн авхаалжтай, харсан үзсэн болгоныхоо учрыг нь олох улс байгаа юм. Бодвол, авьяастай болоод тэр байлгүй гэж багш маань хэлж байна.

-Эцэг эх нь юу гэх юм. Эрүүл мэнд нь таарах юм уу, үгүй юу, үзүүлэх хэрэгтэй байна. Юу ч болсон энэ тавыг гэж шийдэх үү дээ? гэж өнөөх сүртэй хүн хэлж байна.

Би бүр учрыг олохгүй эргэж орхилоо. Багш хүүхэд бүрийг шинждэг хүн байх нээ. Зүггүй хүүхдүүдийг аваачдаг хүүхдийн колони гэдгийн нь багш нар юм болов уу ч гэж эргэлзэж байлаа.

Тэгээд бидний нэр овгийг тэнд бичиж авлаа. Тэгэхнээ нь биднийг Зөвлөлт улсад бүжгийн сургуульд явуулах гэж биеийг маань шалгаж авч байсан юм санжээ.

Удалгүй биднийг хичээлээс чөлөөлж, эрүүл мэндийн үзлэгт оруулж, бас хувцас хунар, бусад бэлтгэлийг хийлгэсэн юм. Ганзориг бид хоёр хамт явах болсондоо маш их баярлаж байлаа.

Харин манай ээж намайг явуулахгүй гэж зүтгэсэн юм. Ээжийн бие барагтайхан байсан тул амьд уулзаж чадахгүй гэж бодсон юм байх. Гэвч Галдан ах, Өвөө хоёр ээжийг хоёр талаас нь:

-Явуулахгүй яах юм. Хүүхдийнхээ ирээдүйг бодолгүй яаж болох вэ. Ийм зол завшаантай хэрэг тохиолдож байхад саад хийвэл ч... ёстой хэрэг алга гэж зад буруушаасан юм.

Оюумаа эгч, манай багш хоёр ч бас ээжийг аваачиж ятгасан юм байх. Ингээд бид арван хоёрдугаар сарын тэр нэгэн дурсгалт өдөр галт тэргэнд сууж алсын замд мордлоо.

Ингээд би хүн болох алсын аяндаа мордож билээ. Над шиг зүггүй хүүхдийг хүн болчихсоноор барахгүй, улсын гавьяат бүжигчин болчихсон гэхэд Дондог гуайн гайхдаг аргагүй байгаа биз дээ. Харин манай багш бол “Зүггүй гэдэг чинь хүүхдийн төрөлхийн цэвэр араншин. Зөнгөөрөө бол гэм дутагдал ч болж болно. Түүнийг нь зөв ойлгож, зөв залах л хэрэгтэй!” гэж дандаа хэлдэг сэн. Намайг хүн болгох алсын аяны жолоог минь Тайван гэдэг ачит багш минь ингэж залсаар явж билээ.

Төгсөв. 1972. 12. 05

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураингуйлан бичнэ үү?
2. Зохиолын гол дүрийн онцлогийг тодорхойлон бичнэ үү?

3. Зохиолоос өөрт таалагдсан бүлгийг цээжилж урнаар уншина уу?
4. “Миний багын явдал” сэдэвт дурсамж эсээ бичнэ үү? /үгийн тоо 250 хүртэл/

Усны эргүүлэг буюу борзооны явдал

Үүсгэл бүлэг

1944 он миний санаад гүн шингэжээ.

Сүүлийн хичээл дуусаж завсарлагааны хонх дуугарав.

Хичээл тармагц гадуур байрны хүүхдүүд гэр гэр лүүгээ явцгаана. Дотуур байрныхан ялгарч үлдээд, хичээл хийдэг намхан цагаан байшингийн ойролцоох их элсэн дээр цуглан тоглоцгооно.

Барилдана. Хөөцөлдөнө. Цүнхтэй номоороо бие биесийг цохиж үймэн хашхиралдана.

Хичээл тарсны дараах энэ шуугианд би эхлээд их дурлаж, хэнээс ч дутуугүй ноцолдож үймүүлдэг байснаа хожим нь яагаад ч юм, нэг л залхуутай санагдаж, зүгээр халуун элсэн дээр суух дуртай болов. Хичээл хийдэг байшингаас гарч ирээд, гутлаа тайлан хөл дээрээ халуун элс овоолж, наранд суух тун сайхан.

Энэ өдөр яльгүй салхитай ч тэнгэр цэлмэг, нарны илч хурц хэвээрээ, магнай халаан төөнөсөөр байлаа.

-Урьд шөнө манай гэрийн хошлонг хутгаар тас огтолчихсон байна билээ гэж миний хажууд суусан Нямжав гэдэг эмэгтэй хүүхэд ярив.

-Гэрийн хошлон огтолж байна гэнээ? гэж би лавлан асуугаад Нямжавын царай өөд харахад, тэр их л уйдсан янзтай хажуугаараа хоёр гардаж, элс атгаад, хөл рүүгээ ус шиг урсгаж суув.

- Нямжав шиг ийм жаахан хүүхэд ийм лут уйтгартай царай гаргаж, суухыг ерөөсөө үзсэнгүй тул их л шохоорхож

-Чи их айгаа юу гэж би асуув.

-Айлгүй яахав.

-Юунаас нь айх юм бэ?

-Шөнө гэрээс гартал хутга барьчихсан хүн зогсож байвал... !

-Чи их зориггүй юм. Би бол гэр муу Борзооныг чинь дор нь нам цохино гэж хэлэв.

Яагаад ийм үг хэлснээ би одоо болтол мэддэггүй. Намайг бүүр бага байхад манай нутагт Борзоон гэж нэг хүн байсан. Түүний нэр гэнэт санаанд ороод би ингэж хэлчхэв.

Нямжав, миний үгийг сонсоод гайхсан бололтой над руу харж:

-Борзоон гэж юу байдаг юм бэ? гэж асуув.

-Чи Борзооныг үзээгүй юу? Яагаав, хөл нүцгэн явдаг нэг хүн. Үс нь их ургачихсан. Бас хөлийнхөө уланд үстэй. Уландаа үстэй юм болохоор ямар ч хурдан мориор хөөхөд гүйцэгддэггүй юм.

Чи юу гэж санана. Манай сургуулийн хашаа шиг ийм шургааган хашаан дээгүүр чинь авиралгүй үсрээд давдаг хүн байхгүй юу! Борзооныг чи гэрийн хошлон огтолдог гэж санаж байна уу? Тийм биш! Зүгээр шүдээрээ л тас хазчихдаг юм. Ган шүдтэй гэж амьтан ярьдаг юм.

-Ямар аймаар юм бэ!

-Айх юм байхгүй. Хурдан л болохоос биш өөр айх юм байхгүй. Зэр зэвсэг хэрэглэхгүй, хэрэглэхийг ч мэдэхгүй. Тийм болохоор чи шөнө гарч яваад дайралдвал чулуугаар л цохичих хэрэггүй.

-Болж үхье дээ чи минь! Өөдөөс бариад авбал яах юм бэ? Ёстой аймаар юм байна. Өнөө шөнө би лав тэр Борзооныг чинь зүүдлэнэ байх. Бүр айчихлаа.

Нямжавтай миний ингэж, дэмий ярьж байгаа маань хоолны дун дуугарахыг хүлээж, цаг нөхцөөж, суугаа хэрэг. Би огт худал яриагаар Нямжавыг сонирхуулж, чадсандаа бахархаж, улам цаашлуулан

-Энэ аймгийн төвийн Борзоон яахав, харин дүү нь манай суманд байдаг юм. Махчин болчихсон юм гэж ярилаа.

Нямжавын сонирхож байгаа гэдэг учиргүй. Эмэгтэй хүүхэд ийм гэнэн. Намайг бүр үнэн юм яриад байна гэж санаж байгаа бололтой.

-Махчин гэж юу юм бэ?

-Хүний мах иддэг хүн. Би нэг удаа бараагий нь харсан. Манай нугагт Хөшиг гэж уул байдаг юм. Тэр уулын өвөрт хүн нутаглуулдаг юм. Тэнд л хүний хүүр эрээд явж байна билээ. Саарал дээлтэй явж байхаар нь би махчин байна гэж таниад, ааваараа буудуулчихсан.

Тэгсэн чинь яасан гэж санана? Бууны сум биендээ хүргэлгүй өөдөөс нь шүүрч аваад буцаагаад бидэн рүү шидэж, сүйдлэх шахсан.

Буудаж болохгүй юм байна гэж мэдчихээд аав бид хоёр мориороо хөөсөн чинь том том жалга гуун дээгүүр шувт харайгаад л зугтаасан. Гүйцэгдэхийн аргагүй юм билээ. Заримдаа утасны модны хэртэй газар нисээд бууж байгаа харагдсан шүү. Жаахан далавчтай юм даг уу, гэж би санаж явсан.

-Энэ мөн хачин юм даа. Одоо тэр амьд яваа бол уу?

-Ах нь амьд байхыг бодоход дүү нь амьд л яваа байлгүй.

Манай сумаас ч яваад өгсөн л дөө. Ноднин Хүрээмаралд явна гэж нэг дуулдсан. Одоо танай суманд л яваа байх гэж амьтан ярьдаг юм. Чи гэр лүүгээ захиа бичвэл саарал хувцастай махчин манай сумаар явж байна уу? гэж сураглаарай. Одоо яг танай суманд л явах учиртай.

Бид хоёрыг ярилцаж дуусаагүй байтал хоолны дун дуугарав.

Хоолны дун дуугараагүй бол би хөдөө байхдаа хөгшдөөс сонссон өч төчнөөн юм ярих байв. Ер нь яриад байвал надад сонссон юм их бий. Зарим нь аймаар, зарим нь хүн огт үнэмшмээргүй өч төчнөөн юм бий. Жишээ нь би галзуу чонын тухай зөндөө ярьж чадах байв. Намайг бага байхад манай нугагт галзуу чоно тун элбэг байсан юм. Хаврын сард хаанаас ч хамаагүй галзуу чоно гүйж ирээд хүн, мал юу дайралдсантайгаа ноцолдоно. Тэр ч байтугай нэг шөнө манай гэрт орж ирэх шахсан.

Тэр шөнө аав гэртээ байгаагүй бол манайд чоно орж ирээд, биднийг хааш ч гаргалгүй баллах байсан даг. Харин аав гэртээ байсны ачаар бидэнд гэм болоогүй. Хаяа сөхөгдөж, ханын шийрэн доогуур чонын хоншоор орж ирээд, сэнгэнэтэл шинжлэхээр нь аав сүх барьж очоод хамры нь бараг хавтгай болтол цохьчихсон. Чонын хар хамрыг модоор цохьчихсон ч үхдэг гэж хөдөөнийхөн ярьдаг. Худлаа. Хамраа хавтгай болтол цохиулчихсан тэр галзуу чоно үхэх нь байтугай, уур нь хүрч, манай гэрийн баруун урд хатавчны туургыг салбартал урж, хаячхаад явчихсан.

“Одоо манай гэрийн эсгий галзуурна байх даа. Яана” гэж аавыг ярихаар эсгий галзуурдаг юм байх даа гэж би их гайхаж байсан чинь нээрэн л манай гэрийн эсгий галзуурсан даа. Чухам яаж галзуурч байсныг мартчихаж. Эсгий галзуурахаараа бөөн бөөнөөрөө тасарч, огт салхигүй байхад ч гэсэн атиралдан өнхөрч, бие биетэйгээ ноцолдоод л, ноололдоод л байдаг юм билээ гэхчилэн яривал Нямжав үнэмших л байсан.

Бас Бөгтөр хүрэн гэдэг нэгэн сайн эрийн тухай би зөндөөн юм мэднэ. Цахиур буугаар буудахад арьсы нь сум даадаггүй байсан гэж амьтан ярьдаг. Ямар ч бярттай эр түүнийг дийлдэггүй байсан мөртөө нэг хөгшин чавганц тэр сайхан эрийг гэрийн баганаар цохиод унагачихсан, тэгээд баривчлагдсан гэж бүр худлаа хэлмээргүй улс ярьж байхыг би сонссон.

Мөн намайг бага байхад Далангийн нуруунд нэг жаахан эрэгтэй хүүхэд зэрлэгшээд чоно уначихсан явна гэдэг яриа гарав аа. Тэр хүүхдэд унуулсан чоно, ямар айлын хонийг ямар хүн хариулж явааг тун андахгүй мэдээд, биендээ зэвсэггүй хүн юм уу, жаахан хүүхдийн хариулж яваа хониноос тарганы нь шилж бариад, эзний нь харсаар байтал тайван гэгч нь хүүхэдтэйгээ хувааж идчихээд, ууландаа гардаг юм гэнэ. Чононд яав ч тийм ухаан байхгүй. Тэр жаахан хүүхэд л чоноо газарчлаад явдаг юм шиг байна гэх зэргээр элдвийг ярилцана. Иймэрхүү юм түүгээд яривал би Нямжавт олон сонин юм ярих байв.

Нямжавт ярих нь ч яахав, сургууль дээр гарч байгаа хулгай зэлгийн элдэв явдлаас болж, надад иймэрхүү хачин юм тун их бодогддог боллоо.

Бусад сумын хүүхдүүдийг бодвол манай сумын хүүхдүүд сургуульдаа нэлээд хожимдож ирсэн билээ. Биднийг ирэхэд:

-За та нар сая ирж байгаа улс. Идэж уух юмаа л сайн хямгадаарай! Хулгайд дэлсүүлнэ шүү гэж надад нэг танихгүй хүүхэд хэлж байсан юм. Түүнийг сонсоод очиж очиж идэх юм хулгайлна гэдэг чинь юу гэсэн үг вэ, ёстой шившиг байгаа даа гэж бодож байлаа. Харин сургуулийн байранд ороод бүтэн хоёр цаг болоогүй байхад миний богцон дотор байсан ууттай эзэгийг алга болчихсон байв.

Гэтэл Намжилсамбуу:

-Хулгайчид түнгийтэл өвөртлүүчихсэнээс өөрөө түнгийтэл өвөртөлчихье! гээд дээлээ шууж, ааруул эзэгийг зүссэн бяслаг хатаасан өрмийг ар өвөр энгэртээ дүүрэн чихэж байгаад яг ташаагаа тулсан “ф” шиг амьтан босож ирсэнд бид их зугаа болгон инээлдлээ.

Биднийг ингэж инээлдэж шуугьж байхад Мягмар дуугүй суугаад байв. Мягмар нэг л юм бодож байгааг олсонгүй. Гэтэл Мягмарын юу бодож байсан нь дороо мэдэгдлээ. Тэр, өдөржин богцтой юмаа сахиж суув.

Гэхдээ зүгээр суусангүй, богцныхоо үдээсийг тайлж амы нь задгайлаад, гар дороо тавьжээ. Тэгээд нүднийхээ булангаар бидэн рүү үе үе сэжигтэй хялайн суув. Хааяа амандаа наалдсан ааруулын үйрдсийг арчина. Санаа алдана. Миний ажигласнаар тэр лав бүгэн гурван цаг хөдөлгөөнгүй, чимээгүй суув. Юм идэхдээ хөөр уруулаа огт нээхгүй өмөр өмөр идэх тул юм зажилж байгаа чимээ нь ч дуулдахгүй, хааяа завж нь чилдэг бололтой, богцтой юмаа дэрлэж, гэрийн унь тоолох янзтай жаал хэвтсэнээ, өндийн сууж нэг санаа алдаад, дахин ам нь чимээгүй хөдөлж эхэлнэ.

Гэтэл Сэмбэн:

-Нөхөд минь бид хамаг юмаа идэхий нь идээд худалдахы нь худалдаад, өнөөдөр дуусгачихъя гэдэг санал гаргалаа.

-Бидний юмыг худалдаж авах хүн олдох бол уу? гэж би асуутал Сэмбэн,

-Зөндөөн олдоно. Би гараад олоод ирье! гэв.

Сэмбэн гэрээс гараад ер удсангүй арваад хүүхэд дагуулсаар орж ирлээ. Гэр дүүрэн худалдаа гүйлгээ боллоо.

Сэмбэнгийн зальтайг би энэ үед л ухаарлаа. Юмаа худалдъя гэж санал гаргаж, зөндөө хүүхэд дагуулж ирчхээд, өөрөө юмаа худалдалгүй үлддэг байна шүү.

Ингэж бид хамаг юмаа худалдаж гүйцээд, үлдээсэн юмаа дэрлэн унтав. Би ч гэсэн тосоо дэрнийхээ хажууд тавиад унтлаа.

Энэ шөнө миний нойр удтал хүрсэнгүй, чимээ чагнаж, шөнө дунд хүртэл хэвтэв.

Өнөөх хулгайч нь ороод ирэв гээд л сарны гэрэлд ажигласан чинь мань Мягмар гарч байгаа харагдав. Мягмар тун олон дахин гарч гүйлээ.

Би сүүлдээ Мягмарыг их өрөвдлөө. Орондоо ороод тэр уйлж байгаа дуулдав. Гэвч сэтгэл нь зовох бол уу гэж бодоод юм асууж чадсангүй. Нэг л мэдэхэд би нам унтаад урт шилбүүр барьсан шалдан хүнд хөөгдөж явна гэж зүүдэлж байв. Мягмар л миний зүүдэнд оров бололтой. Зүүднээсээ айж сэрчхээд галзуу чоно, говийн махчин хүн зэрэг элдэв аймаар юм бодлоо. Ийм юм бодохгүй байя гэж бодсон хэр нь л нүдэнд харагдаж, унтахаар хар дараад тун болсонгүй.

Айсандаа хамаг биений хөлс гарчихсан шиг санагдав. Нүүрээ илээд үзсэн чинь шал нойтон. Нүүр байтугай хүзүү, цээж хүртэл шал нойтон болсон байв. Яагаад ингэж их нордог билээ гэж гайхаад орноосоо өндийж гараараа хамаг юмаа тэмтэрч үзлээ. Гэтэл би өнөөх олгойтой шар тосоо оноод дэрлэхсэн юмсанж.

Өглөө миний тос болсон үс толгойг манай байрныхан сонирхон, ар өврөөс минь тойрон харж, бахаа ханатал инээлдэцгээв. Толгой ч яахав, бүс малгай хоёртоо л би их харамсаж байлаа. Аавын минь өгсөн цоохор даавуу малгай сургууль дотроо ижилгүй сонин малгай байсан юмсан. Тосны гүзээ шиг бор юм болоод, толгой дээр тавих байтугай харахаас инээд хүрмээр юм болж, хүүхдүүд бие бие рүүгээ дамжуулан шидэлж байлаа.

Борзоон амилж эхлэв

Анх байр хуваарилахад манай сумын 18 хүүхдийг нэг гэрт суулгав. Бид сургуулийн эд аж ахуйн агуулахаас нэг нэг гудас, хөнжил, хоёр хоёр цагаан даавуу, бас дэрний уут авлаа. Дэрний уут гэдгийг тэр цагт мэддэггүй байснаа, энэ уутаар юу хийх юм бэ? гэж Сэмбэнгээс би асуув.

Сэмбэн бол тэр үед хамгийн сэхээ самбаатай, мэдэхгүй юм гэж үгүй, хүнд хамгийн чухал юмыг хэлж өгдөг, дээд зэргийн ухаантай хүүхэд гэж надад санагддаг байлаа. Тийм болохоор би мэдэхгүй юм л гарвал түүнээс асууна.

-Дэр хийхгүй юу! гэж тэр хэлэв.

-Ийм ганц шалчгар уутаар уу даа? гэж асуутал,

-Дотор нь тэрлэгээ чихээд дэрлэдэг юм даа. Хонгор минь! гэж тэр хэллээ.

Ингээд би орныхоо хэрэгслийг барьсаар байрандаа орж ирлээ.

Сургуулийн байр гэдгийг би арай ч нэг хоосон гэр байна гэж бодсонгүй.

Бид суух ч газар байхгүй, баахан гайхацгааж байснаа Сэмбэн л самбаатайгаараа хамгийн түрүүн хөх тоосгон шалан дээр гудсаа хуйлаастай чигээр нь тавьж дээр нь унан суулаа.

-За та нар өнөөдөртөө ингэсгээд байж бай! Танай байранд орой тийшээ ор дэвсгэр тавьж өгнө. Одоо хөнжлөө гудсан дотроо хуйлаад, гэрийнхээ ханыг дагуулж хураагаарай! гэж Ядам багшийг хэлээд гарахад бид орныхоо хэрэгслийг цөм Ядам багшийн зааснаар хураав.

Хөнжил, гудсыг ингэж хураасанд гэр дотор зөндөөн зай гарч, бид гэрийнхээ хаяаг даган дутуйрч суугаад хос хосоороо барилдаж эхлэв. Гэтэл Ядам багш гэнэт орж ирээд, манай сумынхны сахилгагүйг гайхаж, бараг цаг шахам загнаад гардаг байна.

Баянбулагийнхан сахилгагүй гэдэг нэрийг бид чухам эндээс эхэлж авсан байх аа.

Энэ шөнө бид унтахын өмнө нэг хэргийг тун их маргаж байж шийдлээ. Шөнө унгахдаа толгойгоо хаяа руу харуулах уу, голомт руу харуулах уу гэж бид маргасан юм.

Сэмбэн, Гомбосүрэн нарын зургаан хүүхэд гэрийн хоймор эзэлж авчхаад, шөнө хаяа руугаа харж унтана гэж зүтгэв. Бусад нь

-Бид та хэдийн шиврийг үнэрлэж хэвтэж чадахгүй! гэж маргав. Мягмар мэтийн хэдэн хүүхэд дуртай дуртай зүгтээ харж, унтана гэв.

Гэтэл Сэмбэн:

-За тэгтэл би та нарын хэлснээр хөлөө хаяа руу хандуулж унтъя. Уг нь гэрийн үүд рүү толгой хандуулж, унтана гэдэг нүгэл байдаг юм. Яахав би та нарын үгэнд оръё! Та нар оронд нь надад нэг нэг дэвтэр өг! гэв.

-Би тэгж, Сэмбэнд дэвгэр өгч луйвардуулж чадахгүй! гэж Мягмар шууд эсэргүүцлээ.

Бие биендээ хорон үг хэлж, Сэмбэнг “Дээрэлхдэгээ боль!” гэлцэж баахан маргаж байгаад цөм хаяа руугаа хөлөө жийж, унтахаар шийдлээ. Ингэж унтах бидэнд үнэхээр тохиромжтой болж, орондоо ороод ярилцаж шуугилдаж байхад бидний толгой хоорондоо ойр аятайхан байдаг байв.

Гэтэл нэг шөнө том Жамсрангийн гутлыг хаяагаар хулгай аваад явчихжээ. Тэгээд тэр өдөр хичээлдээ гуталгүй суугаад үдэш нь надад ярихдаа:

-Миний гутлыг Борзоон л аваад явчихлаа. Уг нь хөл нүцгэн явдаг амьтан гэсэн. Одоо гуталтай болчихлоо. Даарсан юм байхдаа? гэв.

Би бүр мэл гайхаж:

-Борзоон гэж хэн бэ? гэж асуув.

-Энэ аймагт Борзоон гэж нэг лут хулгайч бий гэнэ!

-Хэн чамд тэгж ярьж байна.

-Хүүхдүүд. Зарим нь үзсэн байна билээ. Манай сургуулийн хашаан дотор нэг шөнө, бүр чармай нүцгэн гүйж явсан гэнэ!

-Худлаа байлгүй. Аягүй бол! Мягмарыг л нэг хараа биз.

-Хаанаас! Мягмараас бүр хамаагүй өндөр, хөлийнхөө уланд үстэй хүн байдаг юм гэнэ.

-Борзоон гэдэг нэртэйгий нь чи яаж мэдсэн юм бэ?

-Эндхийн хүүхдүүд бүр сайн мэдэх юм. Мандалын Бибиш надад ярьсан.

-Худлаа даа. Би л тоглоомоор Нямжавт ярьж байсан юм. Бууцагааны Нямжав гэж нэг годгор үстэй хүүхэд бий шүү дээ. Тэрэнд чинь би ярьж байсан юм.

Намайг ингэж хэлэхэд Жамсран огт тоосонгүй:

Тэгэхээр нь би ярьснаа улам тодотгож:

-Манай суманд Борзоон гэж хүн байсныг чи санаж байгаа биз. Бор царайтай, үс нь их ургачихсан, нэг залуухан хүн айл хэсэж, ажил хийгээд явдаг байснаа даа! Би түүний чинь бодож байгаад ярьчихсан юм гэв. Гэтэл Жамсран над руу ойртож суугаад:

-Тэр манай сумын Борзоон чинь ёстой гэмгүй хөөрхий амьтан байхгүй юу? Харин эндхийн Борзоон чинь биднийг бүр баллах гээд байна. Энэ шинэ барьсан гэрүүдийн чинь цагаан бүрээсийг Борзоон л шөнөөр ирж урчаад байгаа гэнэ. Урд эгнээний баруун захын гэрийн бүрээсийг хүүхдүүд унтаагүй байхад ирээд ширжгэнэтэл нь урсан гэнэ. Тэгэхэд нь хүүхдүүд “Хүүе хэн бэ?” гэж хашхирсан чинь “Борзоон” байна аа! гэж хэлчхээд зугтаагаад явчихсан гэнэ. Хүүхдүүд “үзье” гээд гараад харсан чинь хашаан дээгүүр даваад явчихсан байна гэж ярих.

-Худлаа даа. Шал худлаа! гэж хэлээд, би байрнаасаа гарч, урд эгнээний баруун гэрт орлоо. Тэнд хоёр хүүхэд орон дээрээ номоо дэлгэчхээд, хуруу гаргаж суув.

-Танай гэрийн цагаан бүрээсийг шөнө урчихсан гэв үү? гэж би асуув.

-Тэгсэн юмаа гэж шар дээлтэй хүүхэд хариулаад, намайг их хардсан янзтай өөдөөс ширтэн харав.

-Хэн урсан юм бэ? гэж би асуулаа.

-Борзоон гуай л нэрээ хэлж байгаад урсан даа. Энэ үгийг сонсоод, би учрыг тайлбарлах санаатай

-Борзоон гэж хүн байхгүй, нөхөд минь! Би зохиогоод ярьчихсан юм гэтэл шар дээлт нь:

-Нөхөр минь чи аль сумынх вэ? гэж надаас асуув.

-Баянбулагийнх.

-Аяа, мэдэж авлаа. Хэдүүлээ багш дээр очъё! гээд шар дээлт миний ханцуйнаас шууд шүүрч авлаа.

-Байз л даа би учир ярь!

-Учир ярих юу байсан юм бэ? Чамд тэгж сангийн гэр хорлон сүйтгэж байх хэрэг юу байна.

-Үгүй ээ? Би сүйтгээгүй юм даа. Борзоон гэж манай нутагт нэг гэмгүй хүн байсан юм. Би түүнийг бодож байгаад...

-Чи тэгээд гэмгүй хүний нэр барьж хорлон сүйтгэж яваа юм уу?

-Би сүйтгээгүй! гэж байна шүү. Энэ чинь хаашаа тэнэг нөхөр вэ?

-Тэгээд хэн сүйтгэсэн юм бэ?

-Би сүйтгээгүй гэж байна шүү

-Тэгвэл танай сумынхан л сүйтгэсэн дээ,

-Боль нөхөр минь!

-Харин чи боль!

Шар дээлт бид хоёрын ингэж, хэрүүл дэгдээх дээр тулж байтал, шар дээлттэй хамт байсан жижиг нүүртэй доожоогүй нөхөр:

-Баасансүрэн! Наадхыгаа чирж, аваачаад захиралд өгчих! Баянбулагийнхан яах гээд байгаа юм бэ? гэж сүрхий омогтой дуугарав.

-Танай сумынхан л гэж би хэлчхэв.

Тэгтэл тэр хоёр намайг хоёр талаас минь барьж аваад, үүдээр гартал түлхлээ. Би босгонд тээглэж хаалганы гадна унаад, унасан дороо босон харайж, тасаг руугаа зугтлаа.

Хоолны дун дуугарах бас л болоогүй, гадаа гаръя гэхэд бороотой, гэрт сууя гэхэд суух ч газар олдохгүй энэ өдөр тун тавгүй байлаа.

-Хашбат, чи явж хоол “тагнаад” ирээч! гэж Жамсран надад хэллээ. Энэ өдөр хоол тагнах миний ээлж байлаа. Би дуртай дургүй гарч гал тогооны байшин руу явав.

Хоол тагнана гэдэг тун хариуцлагатай ажил. Хоол тагнах хүн, аль болохоор мэдэгдэлгүй гал тогооны цагаан байшингийн хананд хүрээд, цонхоор толгойгоо харагдуулахгүйн тул цонхнуудын доогуур бөхийн явсаар яг галын өрөөний цонхон дор очиж эхлээд чимээ чагнана.

Тэгээд галч нарын ярианаас, хоол болж байгаа нь илт мэдэгдвэл буцаад ирнэ. Мэдэгдэхгүй бол гэнэт цонхоор өнгийж юу болж байгааг маш түргэн мэдэж аваад буцаж зугтаана. Намайг гал тогооны байшингийн урд ирэхэд, өөр нэг байрны тагнуул мөн ирчихсэн цонхны тушаа түгдийгээд сууж байлаа.

-Юу болж байх шиг байна? гэж би асуув.

-Удахгүй байх. Ширээн дээр тавагнууд өрчихсөн байна гэж тэр шивнэв.

-Чи **Намид** галчийн өрөө рүү хараагүй юу? гэж би асуулаа.

-Одоо л санаатай... гээд тэр дээшээ өлийн харав.

Галын өрөөнд юу болж байгааг би чимээгээр нь мэдчих санаатай чагнасанд хүмүүс ч ярилцаж, нэг хувингийн таг хангинан дуугарсан боловч тодорхой юм юу ч мэдэгдсэнгүй.

-Чиний нэр хэн гэдэг вэ? гэж би хажуу дахь хүүхдээсээ асуувал

-Миний нэр Сэдхүү гэв.

Бид хоёр гал тогооны цонхон доогуур бөхийсөөр гүйж баруун үзүүрт нь хүрээд тэндээсээ хэд харайж хичээлийн байрны урдуур гараад, хураалтгай тоосгон дотуур аажуухан ярилцаж явлаа.

Баянбулагийнхан бүлэглэж, манай сумынхныг зодох гэсэн байна гэж, Сэдхүүг ярихаар нь, би учрыг үл мэдэгч болж:

-Яагаад зодох гэсэн юм бол? гэж асуулаа.

-Баянбулагийнхан Борзооны нэрийг барьж, нэг нь хулгай хийсэн юм шиг байна билээ. Түүний нь хэллээ гэж л зодох гэсэн юм байх гэв.

-Борзоон гэж хэн юм бэ? гэж би Сэдхүүгээс асуулаа.

-Эндхийн ёстой нэг Босоо ороолон байдаг юмаа. Баянбулагийнхан түүний нэрийг барьж, манай гэрийн цагаан бүрээснээс урсан байна билээ гэж тэр ярив.

-Борзоон гэж үнэхээр тийм хүн байдаг юм уу? гэж би асуулаа.

-Байдаг юм гэнэ билээ. Би ч үзээгүй. Манай сумын нэг хүүхэд бараагийг нь халт хараад алдчихаж. Бидэн шиг юманд гүйцэгдэх аргагүй хурдан амьтан юм байх аа гэж тэр ярив.

Борзоон гэж үл бүтэх амьтан энд “үнэхээр байдаг юм болов уу?” гэж би гайхаж, явлаа.

Борзоон уршиг тарьж эхлэв

Анх Нямжавт ярьсан миний дэмий яриа сургууль даяар тарж “Борзоон” гэж нэг амьтан үүслээ гэж би бат итгэж байлаа. Гэтэл хүн бүхэн, Борзооны тухай бүр үнэмшмээр юм яриад байхаар би өөрөө ч заримдаа итгэх шахаад байв. Гэвч хараахан гүйцэд итгээгүй, миний дэмий ярианаас л ийм хэрэг гарлаа, хамаг буруут нь би боллоо, гэж дотроо гэмшсээр явлаа. Гэтэл яван явсаар Борзоон бидэнд ч гай тарьж, эхэллээ.

Нэг өдөр хичээл тараад, байрандаа орох гэж явтал, Сэмбэн та хоёрыг захирлын өрөөнд дуудаж байна гэсэн хэл ирлээ.

Би ямар хэрэг хийснээ эхлээд бодлоо. Захирал дуудахыг бодоход заавал нэг сүрхий хэрэг дэгдсэн байж таарна. Аягүй бол Бибиш, Хорлоо хоёр шиг шийтгүүлнэ байх гэж бодлоо. Тэр хоёрын шийтгүүлж байхыг би нүдээрээ үзсэн юм. Чухам ямар хэргээр тэд шийтгүүлснийг мэдэхгүй.

Сэмбэн бид хоёр дулаан дээл өмсөөд, захирлын өрөөнд орж ирлээ. Тэнд Цэвэгдорж багш, Ядам багш хоёр байв.

Бид хоёр ороод зуухны хажууд номхон зогслоо. Цэвэгдорж багш суудлаасаа босож, миний өмнө ирээд:

-Чи томоотой царайлсан, бас нэг хачин нөхөр өө дөө! Наашаа хар! гэв.

-Наад нөхөр чинь сургуульд ирсэн анхны өдрөөс “тар нь танигдсан юмаа!” гэж Ядам багш хажуунаас нь хэлэв.

Яагаад Ядам багш намайг ингэж хэлж байгааг би мэдэж байлаа.

Энэ бол сургуульд ирсний маргааш өглөө болсон хэрэг. Би тэгэхэд өглөө бүрэн дуунаар яаралтай босож, хоолны дун дуугармагц гал тогооны байшингийн ард очиж жагсдаг журамтай байсныг мэдээгүй байсан юм. Тиймээс яаралгүйхэн босож, нүүр гараа угаагаад хоолны дун дуугарахад мөн яаралгүй явсаар очиж, жагсаалын эцэст орж зогссон билээ.

Ядам багш энэ өдөр жижүүртэй байсан тул жагсаалын өмнө дун барьж зогсоод, хоолонд хамгийн сүүлд ирсэн намайг их л анхааралтай ажиглаж байлаа. Уг нь би хоолны дун дуугармагц, турж үхэх гэж байгаа амьтан шиг гал зуух руу яаран гүйх ичгэвтэр юм уу даа гэж дотроо бодож явсан юм.

-Та нар талхаар шидэлцсэн үү? гэж асуухад нь би түрүүлж

-Тэгсэн багш аа гэв.

Ядам багш бидний царайг хэсүүлж хараад:

-Танай Баянбулагийнхан сахилгагүй байна, талхаар шидэлцэнэ гэнээ! Та нарын үдийн хоолыг хаслаа. Дахиад талхаар шидэлцвэл хатуу ярина шүү. Дайны цаг байна, одоо дайны хуулиар л ярина. Ялангуяа чи нөхөр... гээд над руу харснаа:

-Нэр чинь хэн билээ гэв.

-Хашбат! гэтэл

-Нөхөр Хашбат өглөө жагсаалд хожигдоод бас талхаар шидэлцэнэ гэнээ!

гэв.

Сургуульд ирсэн анхны өдрөөсөө “тар нь танигдсан” гэдэг Ядам багшийн үгийг сонсмогц энэ өнгөрсөн явдал миний санаад зурсхийн бодогдоод өнгөрөв.

-Чи Бууцагааныхны цагаан бүрээсийг яах санаатай урсан бэ? гэж Цэвэгдорж багш надаас асуулаа

-Би ураагүй, багш аа

-Тэгээд хэн урсан юм? Цэвэгдорж багшийг ингэж асуухад, Сэмбэн хажуунаас:

-Наадах чинь ураагүй байх аа, багш аа! гэж хэлэв.

Ядам багш ч Сэмбэнг дагуулан гарав.

Цэвэгдорж багш бид хоёр л үлдлээ. Надад маш аймшигтай санагдана. Цэвэгдорж багш надтай цаг гаруй яриу.

“Борзоон гэж огт байхгүй. Би тоглоомоор Нямжавт дэмий юм ярьсан маань сургуулиар тарж ийм хэрэг боллоо. Миний буруу. Би ямар ч хулгай хийгээгүй. Гэрийн бүрээс ч ураагүй” гэж би бүх явдлыг нарийвчлан яриу. Цэвэгдорж багш нэг ч үг дуугаралгүй миний яриаг чагнаж аваад:

-Чиний ярьж байгаа цөм үнэн үү гэв.

Миний дотор онгойх шиг санагдлаа. Гэтэл Цэвэгдорж багш дэргэдээ сандал тавьж намайг суулгаад:

-Чиний ярьж байгаа цөм үнэн. Одоо чи сургуулийн байранд хэн хулгай хийж, гэрийн бүрээс урж, хошлон огтолж байгааг надад хэлж өг дөө. Чи өөрөө хулгай хийдэггүй чинь үнэн. Би чамд итгэж байна.

-Би мэдэхгүй.

-Чамаас өөр сайн мэдэх хүн байхгүй шүү дээ.

-Би мэдэхгүй багш аа!

-Яагаад?

Би үг хэлж чадсангүй. Гэтэл Цэвэгдорж багш:

-Чи бүгдийг мэдэх ёстой.

-Яагаад?

-Учры нь би чамд ярья! Уг нь чи өөрөө ярих ёстой байсан юм даа. Яахав би ярья. Чи сонс. Сурагчдын хоол хувцас хулгайлдаг, тэгээд ч зогсохгүй сургуулийн шинэ гэрүүдийн цагаан бүрээсийг хүртэл урж, аминдаа ашигладаг тийм хүмүүс манай сургууль дотор бий. Үнэн үү гэв.

-Үнэн!

-За тийм. Үнэн. Тэр үл бүтэх этгээдийг чи сайн мэднэ. Үнэн үү!

-Худлаа. Би мэдэхгүй багш аа!

-Чи худлаа ярьж байна. Чи сайн мэднэ.

-Мэдэхгүй, багш аа.

-Сайн сонс чи! Чи бүгдийг сайн мэднэ. Мэдэхээр барахгүй тэр үл бүтэх этгээд чиний дотно хүн байгаа. Тэр хүн гэмт хэрэг хийгээд баригдахгүй байхын тулд... чи сонсож байна уу? баригдахгүйн тулд... бас өөрийгөө нуухын тулд, хүүхдийг айлгахын тулд, “Борзоон” гэж нэг аймшигтай хүн байдаг гэсэн цуурхал тараахыг чамд даалгасан байна.

Чи тэр даалгавар ёсоор Нямжавт тийм юм зохиож ярьсан. Нямжав ч цааш нь тараасан. Нэгэнт тийм цуурхал тарсан болохоор хүүхдүүд юм л алга

болбол “Борзоон авсан” гэж ярьдаг болсон. Гэрийн бүрээс урсан ч “Борзоон урсан” гэдэг л болсон.

Борзоон гэдэгт чинь хууртаад хүүхдүүд жинхэнэ хулгайчийг барих гэж бодохоо ч больсон. Ингэж “Борзоон” гэдэг нэрээр халхавч хийгээд нэг нөхөр манай сургуулийг санаа амар сүйтгэж байна. Тэр хулгайчид санаа амар хулгай дээрэм хийж явах бүх бололцоо, үүд хаалгы нь чи ингэж нээж өгсөн... .

-Үгүй ээ, багш аа. Тийм юм байхгүй.

-Дуугай бай, нөхөр минь! Чи Борзооныг зүгээр нэг хүн ч биш, хөлийнхөө уланд үстэй, ямар ч хурдан моринд гүйцэгддэггүй гэхчилэн ярьсан чинь хүүхдүүдийг айлгахад бүр ч сайн шалтаг болсон. Энэ бүхнийг чи өөрөө ч зохиож яриагүй. Цаад хүн чинь ингэж яриарай гэж чамд зааж өгсөн. Ийм л байна. Чи тэр хулгайчийг л авчирч аль! Чамтай өөр юм ярихгүй гэв.

Надад хэлэх үг олдсонгүй. Баахан дуугүй сууж байгаад

-Би мэдэхгүй ээ, багш аа гэж дахин нэг хэллээ.

-Мэдэх л болно доо чи. Хэлэх л болно доо чи! гэж хэлээд Цэвэгдорж багш ширээн дээрээ ном дэлгэн юм бичиж эхэллээ.

Намайг хайхрахаа болилоо. Би харанхуй болтол суув. Цэвэгдорж, багш шүүгээ уудлан лаа гаргаж асаагаад, над руу нэг харж:

-Чи хэлэх болоогүй л байна уу? гэв.

-Надад хэлэх юм алга, багш аа.

-Хэлэх л болно доо. Яахав сууж л бай.

Ингээд асаасан лаагаа өмнөө тавьж дахин юм бичиж эхэллээ.

Оройн хоолны дун дуугарч хүүхдүүд хоолондоо орлоо.

Хоол идээд дууслаа. Нэг хэсэг хүүхэд хашаан дотор хашхиралдан шуугина. Галч нар түлээгээ хагалаад дууслаа. Энэ бүхнийг би чимээгээр нь таамаглан мэдэж суув.

Харанхуй боллоо. Бодвол одод гараа байх. Хүүхдүүдийн чимээ намдаж, ноход шуугилдана. Тооно өөд харахад хав харанхуй. Гадаа их л хүйтэрч байгаа янзтай, гэрт суухад ч бие жихүүцэж байлаа.

-Чи гурав хоногийн дотор хэлнэ үү? Шоронд сууна уу? гэж Цэвэгдорж багш над руу харснаа босоод ирлээ. Тэгээд намайг дуугарч амжаагүй байтал, доошоо тонгойж шүүгээний нүдийг уудлав. Авдарны түрхүүр эрж байх бололтой.

-Багш аа гурав хоног бодъё гэж би хэлэв.

-Ингээд намайг байрандаа ирэхэд хүүхдүүд унтчихсан байлаа. Хүүхдүүдийн хөл дээгүүр алхлан, гэрийн баруун хойморт гараар тэмтрэн үзвэл Сэмбэн бид хоёрын гудас хуйлаастайгаа хаяанд байв. Би хоёр ороо засаад орондоо орж хэвтлээ.

Гэрээ санаж байх гэдэг учиргүй. Гэрээ санахын дээр гэдэс өлсөөд, огт унтаж болсонгүй. Хөнжлөө толгой дээгүүрээ нөмрөөд баахан уyllлаа. Ядаж Сэмбэн байрандаа ирдэггүй.

Би хөдөө гэртээ байх цагийн аль сайхан зүйлийг түүж бодохыг хичээллээ.

Үертийн голд манай зуслан бий. Зуны өглөө би унтаж унтаж босоод, нүдээ нухсаар гэрээсээ нүцгэн гарч ирэхэд өглөөний наранд нүд гялбаад л. Бас ээж маань зэлэн дээр үнээгээ сааж суудаг сан.

Би Үертийн гол дагуу зуны өглөөг жаахан ажиглаад, гэртээ орно. Тэгэхэд ээж маань өрөм хусам хоёр холиод, аяганд хийчихсэн байна. Би эхэлж хусмы нь идчихээд, дараа нь өрмийг алган дээрээ дэлгэн тавьж, цөцгийгий нь долоож эхэлнэ.

Өрмийг давхраар нь биш дангаар нь алган дээрээ цөцгийгий нь дээш нь харуулж дэлгээд, баахан долооход нимгэрсээр байгаад цоохор хальс үлдэнэ. Тэгэхэд нь хуйлж байгаад ганцхан үмхэнэ. Заримдаа манайх сүүн дотор цагаан будаа хийгээд хөөрүүлдэг байсан. Тэгээд өглөө нь сүүний ёроолын будааг аягалж өрөмтэй холиод идэхэд хамгийн сайхан хоол гэж л санагдахаар байдаг юм билээ. Энэ бол миний багад л ингэж иддэг байснаас биш, дайн эхэлж намайг сургуульд орсон цагаас хойш ер нь ингэж идээгүй санагдана.

Хаврын өглөө Баянбулагийн говьд байдаг хамгийн сайхан юм ер нь Тампуулин багшийн бүрээний дуу л гэж би санадаг.

Тампуулин багш бүрээг яагаад тэгж сайхан дуугаргадаг байв аа!

Хаврын өглөөний нар тусаж, Бүрдийн уужим хөндий нэлдээ шаргалтан туяарч байхад л Тампуулин багшийн бүрээн дуу хангинаж эхэлнэ. Энэ дуунаар бид ч цүнхтэй номоо бариад, гэр гэрээсээ гарна. Тампуулин багшийн бүрээн дууг чагнах тусам сургууль руугаа яарах мөртлөө сургууль хүрэх замдаа дандаа ноцолдож явдаг сан.

Хавар гэдэг яасан ч сайхан улирал билээ. Өвлийн туршид сураг алдарч, говь руу нүүгээд явчихсан ах дүү гэр орон маань хангайдаа гарах гэж зэрэглээ мяралзсан бүрдийн хөндийг өгсөн өглөө оройгүй нүүдэл цувна. Бүрдийн хөндий нэлдээ хүн малаар дүүрнэ. Усны шувууд ирнэ. Энэ хөндийн зэрэглээ нь бүр ч гоё. Сургуулийн хашаанаас гүйн гараад, үдийн хэрд ийш тийшээ харахад хол ойрын баримжаа, хүн малын дүрс нэлдээ долгион дотор манарч хөвөлзөөд, нэг их ногоон алаг далай юм уу, үлгэрийн орон дотор л энэ ертөнц найгаж байгаа юм шиг санагдана.

Ийм дулаан тунгалаг өдөр халуун салхины өөдөөс харж, элгээ газар наагаад хэвтэхэд долгион үелзсэн гоо нарийн зэрэглээ бараг маажгаад авч болохоор нүдний өмнүүр жирвэлзээд, морьтой хүн явж байгаа нь эсхүл тэнгэрт тулсан гозгор хар юм, эсхүл газраар нүүгэлтэж хөвсөн нүсэр бараан дүрс болж харагдана.

Бүрдний хөндий хаврын улиралд ингэж хоёр хөлтэй, дөрвөн хөлтэй, өд жигүүргэй өч төчнөөн амьтны жаргалын орон болж байдаг ч Тампуулин багшийн бүрээн дуу байхгүй бол бас л нэг их жавхлан дутагдах юм шиг надад санагддаг байсан даа. Энэ бүрээн дуунд бид байтугай, нуурын шувууд, бэлчээрийн мал, Далан Хайрхан, Баянбулагийн сархиа нэлдээ баярлаж, энэ бүрээн дуугаар л хаврын жаргал ирснийг ертөнцийн чих сонсож тарвага хүртэл нүхнийхээ аман дээр гарч чагнадаг байсан байх.

Баатар гуайн хөгшин хүртэл биеэ муу байхад гэрийнхээ хаяанд гудас дэвсэж суугаад бүрээний дуу чагнахаараа уйлдаг байсан юм. Миний тэнэг гэдэг нь! Энэ ертөнцөд наслах хугацаа нь гүйцэж байгаа хүн, ирж байгаа улирлын сайханд сэтгэл нь шаналж гонсойсондоо л уйлдаг байгаа биз. Тэгэхэд энэ бүрээн дуу чинь манай сургуулийн бүрээн дуу, биднийг дуудаж байгаа дуу, танд ямар хамаа байна гэсэн шиг бодол бодож би сэтгэлдээ тэр хөгшинд их л дээрэлхүү, номоо зүүж, дуу дуулсаар хаяагаар нь гардаг сан. Тампуулин

багшийн бүрэн дуу одоо ч миний чихэнд хадаастай л явна. Хэдхэн сарын өмнө, сонсож байсан юм чинь яаж тийм амархан мартагдахав дээ. Бодохоос л нулимс гарах гээд байна.

Хүүхдүүд энд тэндгүй хурхирч хаяагаар хүйтэн салхи сийгэнэ. Сэмбэн бас л ирдэггүй. Би гутлаа өмсөж, дээлээ нөмрөөд сэмхэн гарлаа.

Гадаа бүдэгхэн саарал туяатай, эргэн тойронд нам гүм, мярайж яваа хүний хөлийн чимээ ч тээр хол дуулдахаар аймшигтай байв. Би гэрээс гараад хашааны ёроол даган явах гэтэл хашааны ёроолд нэг хүн зогсоод байх шиг санагдав. Буцаад гүйчих юм уу гэснээ, нүдээ дасгах хэрэгтэй гэж бодоод дороо жаал зогслоо.

Өнөөх Борзоон дахин бодогдов. Энэ хашааны ёроолд нээрэн л нэг өндөр хар хүн зогсоод байх шиг. Хоолойгоо засаж чангахан чимээ гаргалаа. Багш нарын хашаан дотор хүн ярьж байгаа дуулдана. Би өнөөх хар юм руу ойртож, зориггойхон хоёр алхаад тонгойж ажиглав. Ер хөдлөх биш. Хажуугаар нь алхсаар өнгөрч, агуулах байшингийн ёроолд байгаа урт цагаан авдрын дэргэд очоод Сэмбэн гэж аяархан дуудлаа. Чимээ алга. Чулуу аваад хажуу талынх нь бөөр лүү тогштол, бүх сургууль даяар дуулдмаар түн түн хийж дуугарлаа. Дотор нь хүн байх шинжгүй.

Би их чимээ гаргачихсанаасаа, айж хэдхэн том харайгаад гэр лүүгээ орлоо.

Намайг орондоо ороод амьсгаагаа дөнгөж дарж байтал үүд зөөлөн нээгдэж нэгэн сүүтгэнэсэн юм орж ирсэн нь Сэмбэн байв.

Сэмбэн харанхуй дундуур явж миний дэргэд хүрч ирээд,

-Чи унтаагүй байна уу? гэж асуув.

-Унтаагүй.

-Гэдэс чинь хэр хөлсөж байна? Оройн хоолонд ороогүй биз?

-Ороогүй. Гэдэс их өлсөж байна.

-Алив амаа ангай!

Би харанхуй дундуур таамаглан Сэмбэнгийн өгснийг зажлаад үзтэл хонины сүүл байсанд

-Чи үүнийг хаанаас олоо вэ? гэв. Тэр маань:

-Чи дуугүй л ид! гэж байна.

Сэмбэн ч өөрөө тун ховдог идэв бололтой. Гэвч дан өөх тул төдий л идэж болсонгүй дорхноо бялуурав. Бид хоёрт хоорондоо ярилцах юм их байсан тул хоёулаа өвөртөө орж хэвтлээ.

Орон дотроо орсон хойноо Сэмбэн надаас

-Чамайг юу гэж байна? гэв.

Цэвэгдорж багш юу юу асуусан. Би юу юу гэж ярьснаа Сэмбэнд нэгд нэгдгүй ярилаа.

-Чи их буруу юм хийсэн байна. Гурван хоног юугаа бодож, ярих гээ вэ чи? Мэдэхгүйгээ хэлээд л суугаад байхгүй. Өөрийгөө хэрэгт хийх чинь энэ дээ гэв.

Борзоон дахин уршиг тарив

Цэвэгдорж багшийн хэлсэн үг миний бодож байсантай яг таарав. Би анхандаа “Борзоон гэдэг хүн байхгүй, миний ярианаас л гарсан юм” гэж бодож байснаа дараа нь олон хүүхэд яриад байхаар “Борзоон” гэж энэ аймагт

үнэхээр нэг хүн байгаа юм болов уу гэж эргэлзэж байсан юм. Гэтэл Цэвэгдорж багшийн ярианаас хойш, энд “Борзоон” гэдэг хүн байхгүй, харин Борзооны нэрийг барьсан нэг этгээд заавал байгаа гэж баттай боддог боллоо. Тэр хүнийг гурван хоногийн дотор олж өгнө гэж Цэвэгдорж багшид ам алдсанаас хойш, миний сэтгэлд тэр хүнээс өөр бодогдох юмгүй боллоо.

“Ямархуу зүс царатай, ямар янзын амьтан хаана яваа бол? Муу цусыг яг хулгай хийж байхад нь пал хийтэл барьж аваад шүүхэд өгөх юмсан. Эсхүл авдранд хийлгэх юмсан гэж хорсон бодож, бодох тоолондоо уур хүрч явав.

Сүүддээ бүр хичээл дээр сууж байхад хүртэл бодогдоод байдаг боллоо.

Нэг өдөр Жанцан багшийн хичээл дээр бүр их бодов. Жандан багш тоо заадаг байсан юм. Би үнэнээ хэлэхэд тооны хичээлд сайн л даа. Гэрийн ажил хийлгүй ирж, эсхүл тоо буруу бодож Жанцан багшийг уурлуулж байсан удаа огт байхгүй. Миний ганц шамдаж, гартаа үзэг барьж, өвөр дээрээ цаас ном дэлгэж оролддог хичээл тоо л байсан юм. Бусад хичээлийг би цаг зарцуулалгүй давтдаг байсан.

Харин тооны хичээл огт өөр. Тоог давтахад заавал суух хэрэгтэй. Суух суухдаа гартаа үзэг цаастай ганцаараа суух хэрэгтэй. Тооны хичээл давтах болохоороо л би байр луугаа номоо аваад гүйдэг байлаа. Манай сургууль ирээдүйд чухам хэзээ ч юм бүү мэд, нэг барилга барина гэж сургуулийн хашааны гадна талд баахан газар ухаж баахан тоосго овоолсон байв.

Энэ овоолсон тоосгон дотор нэгэн нөмөртэй хөндийд орж, би тоогоо давтдаг байлаа. Энд ганц би ч биш, хураасан тоосгонуудын нөмөрт ирж суудаг хүүхэд олон байв. Ялангуяа дулаавтар өдөр бол хураасан тоосго бүрийн ёроолд л хүүхдүүд нэг хоёроороо, заримдаа гурваараа нийлээд номоо дэлгэж, зэвхий царайлан сууцгаана.

Үүнийгээ бид хичээл давтаж байна гэдэг юм. Яагаад ч юм, энэ байрандаа ирээд л суухад, тоо бодоход миний ухаан гоц сэргэнэ. Тоо зөв бодох шиг урамтай юм үнэндээ ховор. Тоо сайн бодлогоороо би Жанцан багшийн хайртай шавь нь болсон юм.

Тоонд муу хүүхдүүд Жанцан багшийн уурыг тун их хүргэнэ.

Арга нь олддог бол Жанцан багшийг уурлуулж болохгүй л байгаа юм. Зүрх муутай хүн. Урьд өдөр нь Борзооны уршгаар Цэвэгдорж багшид байцаагдсанаас би анх удаа гэрийн даалгавар хийлгүй ирж, түүндээ бантаад Жанцан багшийн нүүр лүү ч эгц харж чадахгүй суулаа.

Сэтгэл ингэж донголзохын хажуугаар Борзооны тухай бодол намайг хэдгэнэ шиг ээрч байв. Ашгүй Жанцан багш гэрийн ажлыг энэ өдөр нийтэд нь шалгалгүй, хүүхдүүдийг нэг нэгээр нь босгож, самбарт тоо бодуулж байлаа.

Тэр хооронд нь би Борзооныг баривчлах тухайгаа бодож суув. Борзооныг би шөнө л барина гэж бодов.

“Би хашааны ёроолд зузаан дээл өмсөөд суулаа. Тэнгэрт од ч үгүй, сар ч үгүй, хав харанхуй. Гэхдээ чимээ л чагнаад байлаа.

Гэтэл нэг хүн хашаан дээгүүр сэвхийтэл харайж хашаан дотор орж ирээд, ийш тийшээ ажиглаж байгаа бололтой хэсэг зогслоо. Би хөдлөхгүй суугаад л байв. Гэтэл хашаан дотор орж ирсэн хүн сэмээрхэн алхсаар Бууцагааныхны гэрийн гадна ирээд, өврөөсөө хайч гаргаж гэрийн бүрээснээс өмлөн хайчилж эхэллээ.

Би араас нь ойртож очлоо. Намайг огт мэдэхгүй байна. Би ханцуйгаа шамлаж мяраасаар бүр дэргэд нь бараг гар хүрмээр ойртлоо. Гэтэл тэр хүн гэнэт эргээд намайг бариад авлаа.

Би хөлий нь хавсарлаа. Тэр хүн миний нүүр лүү гал бутартал цохилоо. Би нүүр лүү нь нэг хий дэлсээд алдлаа. Гэтэл тэр хүн намайг чирээд гар нь гозгонон хашаа руу гүйлээ. Би үхсэн ч тавихгүй гэж бодоод чирэгдэж явах зуур “Сэмбээн!” гэж маш чанга хашхирлаа.

-Аан! гэж миний хажууд суусан Сэмбэн над руу том харав.

Хоёр хүүхэд самбарын өмнө тоо бодоод зогсож байлаа.

-Борзооныг барих тухай бодож байгаад чиний нэрийг дуудчихлаа гэж Сэмбэнд би үнэнээ хэлэв. Сэмбэн юу ч хэлсэнгүй. Би Борзооны тухай дахиад бодлоо. Ер нь Борзооныг яаж барья даа гэж элдэв арга бодов. Хашбат! гэж Жанцан багшийн дуу гэнэт тасхийв. Юу асууж байгааг би ойлгоогүй ч гэсэн босож, номхон зогслоо.

-192 дугаар дасгалын хариу хэд гарсан бэ? гэж Жанцан багш асуув. Гэрийн ажил хийгээгүй болохоор би дуугүй зогссоор байлаа. Гэтэл багш босож, миний дэргэд ирээд, дэвтэр лүү маань тонгойн харж:

-Гэрийн ажил чинь хаана байна? гэж асуув.

-Бодоогүй? гэтэл их л уур нь хүрч байгаа бололтой, үг ч хэлэлгүй миний нүд рүү эгц ширтэж, нэг хэсэг зогсов.

Жанцан багш хүүхдүүдийг яаж ч шийтгэлээ гэсэн хүүхдүүд хожим нь инээлдэж ярина уу гэхээс биш, гомддоггүй нь сонин.

Нэгэнт гэрийн ажил хийгээгүй ирсэн болохоор би ч гомдсонгүй, дотроо “Борзоонд” уур хүрч суулаа. Борзооны уршгаар би анх удаагаа ингэж тооны хичээл дээр муу дүн авлаа.

Очиж очиж тооны хичээлд, хамгийн дуртай хичээлдээ муу авсанд уур хүрч, тэр Борзооныг гарт баригдвал тэр дор нь “баллах юм шүү” гэж бодож суув.

Жанцан багшийн дараа Чойдог багш ороогүй бол би бас л Борзооныг юм уу, ямар нэг дэмий юм бодож, чилэх байлаа. Чойдог багш бол намхан гэдгэрдүү нуруутай, махлаг өргөн биетэй, сайхан дугариг хар хөмсөгтэй, инээмсэглэсэн дулаахан бор нүдгэй, алхах, ярих, инээх юм бүхэн нь цовоо, бас хөгжим тоглодог, хүүхдүүдэд сайхан юм ярьж өгдөг хүн билээ. Бидэнд Орос хэл заана. Чойдог багшийн хичээл биднийг ганц цагт бүрмөсөн сэргээдэг байлаа. Чойдог багшийг ороод ирэхэд хүүхдүүд цөм өөдөөс нь инээмсэглэн харцгаана. Юм бичиж байхдаа ч инээмсэглэн бичицгээнэ. Хэн юу дуртайгаа асууна.

Манай ангид Батнасан гэж инээхээ мартчихсан юм шиг нэг хүүхэд байсан юм. Юмнаас сэжиглэнэ, цээрлэнэ гэж байхгүй, Сайн өдөр болохоор өглөө эрт босоод аймгийн гуанз руу явна.

Түүнийг уйлуулахад тун амархан. “Хөдөө гэртээ байх мөн ч сайхан сан. Батнасан чи гэрээ санаж байна уу?” гээд асуухад л уйлчихна. “Ээж чинь мөд чамайг эргэж ирэх гэнэ. Одоо наашаа тэмээ уначхаад л явж байгаа даа” гээд ярихад л уйлна. “Аав, ээж чинь чамайг тоохоо байсан” гэж хэлэхэд хүртэл уйлна. Гадуур явж байхы нь харахад гараа ханцуй дотроо зөрүүлж, бариад ямагт бодол бодож, доошоо газар ширтэж явна.

Гэтэл Чойдог багшийн хичээлийг ороход энэ Батнасан хүртэл нүд нь тормолзоод, инээх шахаж суудаг билээ. Заримдаа багшаас юм асууна. “Уулын савдаг гэж байдаг юм уу, багш аа?” гэж нэг асууж байхы нь би сонссон. Бусад багшийн хичээл дээр бол ямагт гэдэс нь базалж байх маягтай, царайгаа ярвайлгаж, амаа жимийж сууна. Багш аашилбал чимээгүй уйлчихна.

Энэ өдрийн хичээл дээр Чойдог багш:

-Та нарын дотроос лав л гурван хүүхэд Зөвлөлтөд, Ленинград хотод сургуульд явах юм байна. Одоо мөдхөн дайн дуусна.

Ленинград бол дайнд их зовлон үзэж байгаа хот гэсэн ч та нар дайнгүй Ленинград хотод их л жаргалтай суралцах болно доо. Тэгээд та нар багшдаа захиа бичиж байгаарай гэж хэлэв.

-Хэн хэн явах юм бэ багш аа? гэж өнөөх уйлхай Батнасан асуув.

-Чи ч явах магадгүй гэж Чойдог багш хэлтэл Батнасан суудлаасаа өндийж ирээд, үг дуугүй нэг их том ангайж инээв.

Тэгэхэд нь би түүний шар шүдтэйг анх харлаа. Манай сургуульд ер нь шүдээ угаадаг хүүхэд ховор. Шүдний оо ч олдох биш. Би хувьдаа бол долоовор хуруугаараа л шүдээ угаачихдаг. Ээжээс сурсан арга. Батнасан ядаж хуруугаараа ч болов шүдээ угааж байгууштай санагдлаа.

-Хэзээ явуулах юм бэ багш аа? гэж нэг хүүхэд асуув.

Чойдог багш гялалзсан хар өнгөтэй цэрэг өмд ногоон цамц өмсөж, шар аралтай өргөн суран бүс бүсэлж явна. Тэгээд хэзээний заншсанаараа суран бүснийхээ арал дээр гараа тавьж, байшингийн тааз өөд нүдээ нарийсган ажиглаж, жаал инээмсэглэн зогссоноо.

-Мөд л явах байх даа. Долоодугаар анги төгсөөд юм уу, эсхүл аравдугаар анги төгсгөөд явна байх гэв. Бид инээлдэв.

-Инээх юм байхгүй Орос хэлээ л сайн сурч бай! Сургуулийн жил хурдан өнгөрдөг юм. Та нар мөдхөн л долоодугаар анги төгсөнө. Та нар их азтай хүүхдүүд. Манай Баянхонгорын дунд сургуулийн анхны төсгөлтийг та нар хийнэ гэж Чойдог багш яриад, миний нүүр лүү эгцлэн харав.

Чойдог багшийн хичээл орох тоолонд би заасан хичээлээс гадна нэг шинэ юм сурна. Энэ хичээл дээр би “СССР” улс гэж ярьдгийн учрыг ойлгож “Союз Советских Социалистических Республик” гэдэг дөрвөн хийморьтой сайхан үг тогтоож авав. Хожим нь би энэ дөрвөн үгээрээ их л гайхуулж “СССР” гэдэг чинь юу юу гэсэн үг билээ гэж хүүхдүүдийг асуухад тогтоосон дөрвөн үгээ дуржигнатал хэлчхээд, түүндээ их л баярладаг байсан билээ.

Завсарлагааны хонх дуугармагц суудлаасаа яаран босов.

Гэтэл манай ангийн дарга, бас сурагчдын зөвлөлийн дарга Баатар “Хөөе, Сэмбэн Хашбат хоёр намайг хүлээж байгаарай” гэж дуудлаа

Бас л хэрэг гарлаа гэдгийг би гадарлаж, суудалдаа урам муутайхан буцаж суугаад хүлээж байтал гаднаас Ядам багш орж ирэв.

Ядам багш Баатарыг дагуулж манай байранд очоод, Сэмбэн бид хоёрын хамаг юмыг нэгжив. Нэгжилтээс юу юу гарсныг бүгдий нь Баатар данслан бичиж байлаа.

Хоолны дараа Сэмбэн, захирлын өрөөнд очиж гурван цаг хэртэй байгаад бүрэнхий болж байхад байрандаа ирэв. Энэ өдөр манай байранд хөх даалимбаар өнгөлсөн шалавч дэвсэж өгсөн тул байр маань дулаахан ч

болчихсон юм шиг бас цэвэрхэн, нэг л аятайхан санагдаад. “Байр маань тохижиж эхэллээ” гэж бид хоорондоо их баяртай ярилцаж суусан юм.

Сэмбэн угийн шар царайтай хүүхэд. Энэ удаа царай нь зэвхий цагаан болчихсон орж ирээд:

-Одоо энэ сургуульд гараад байгаа хулгайчийг илрүүлж нэрээ цэвэрлэж, авах хэрэгтэй байна. Хулгай илрүүлэх ажлыг сумаараа хийнэ гэж Сэмбэн хэлэв.

Борзооныг баривчлах отряд

Энэ орой бид манаанд гарахаар хэлэлцэж тохирлоо. Бидэнтэй нийлэхгүй гэснээр нь Жамсранг, бие нь өвчтэй байгаа болохоор Мягмарыг байрандаа үлдээж, бусад нь манаанд гарахаар болов.

-За бид хамаг нарийн ажлаа ярилцана. Бидний яриа бол цэргийн нууц. Тийм болохоор хүнд сонсгохгүй. Одоо харуулд гаргаж, гадаа үүдэнд зогсооно. Намжил харуулд гар! Биднийг ярилцаж байхад гэрт нэг ч хүн оруулж болохгүй. Оруулах байтугай хавьтуулж ч болохгүй гэж Сэмбэн зааварлав.

Намжил дээлээ өмсөөд, харуулд гарч гадаа үүдэнд зогсов.

-Та нар бүгдээрээ сууцгаа! Бид чухал ажил хийх гэж байна.

Зохион байгуулалт сайтай байх хэрэгтэй. Бид өөрсдийгөө “Борзооныг баривчлах отряд” гэж нэрлэнэ. Би бол отрядын дарга. Миний орлогч Хашбат, Намжилсамбуу бол холбоочин, Бэгзжав, Дашпунцаг хоёр их буучин, бусад нь байлдагчид. Та нар надад юм хэлэхдээ, миний өмнө ингэж ёслоод “Нөхөр даргад болох уу?” гэж зөвшөөрөл авна. Миний хэлсэн үг бол хууль байх ёстой! гэж Сэмбэн хэлэв.

Би босож Сэмбэнгийн өмнө ёслоод:

-Нөхөр даргад болох уу? гэж асуув.

-Болноо нөхөр орлогч оо. Харин чи инээж болохгүй шүү гэв.

-Бид байлдах зэр зэвсэг байхгүй яана? гэж би асуулаа. Бид гардан байлдаан хийх учраас гараараа л байлдана. Зэвсэг хэрэгтэй бол чулуугаар байлдана. Харин нөхөр орлогч та сургуулийн хашааны зургийг түргэн зураад ир! Бид тактик хийнэ.

-Ёсоор гүйцэтгэе! гэж хэлээд би сууж дэвтрийн гол цаасан дээр сургуулийн хашаа, гэрийг тоймчлон зурав. Бүгдээрээ энэ зургийг лааны дэргэд дэлгэн тавиад, отрядын дарга, хүн хүнд үүрэг өглөө.

-Холбоочин Намжилсамбуу, их буучин Бэгзжав, Дашпунцаг нар байрандаа үлдэнэ. Гэхдээ унтаж болохгүй, бэлэн хувцасгайгаа чимээ чагнаад байж бай! Сургуулийн хашааны баруун хойт булангаас зүүн үзүүр хүртэлх зайг Гомбо, бага Жамсран, Банзрагч гурав хариуцаж манана. Дарга нь Банзрагч, Сургуулийн хашааны урьд хэсэг, хичээлийн байр орчныг Намжил, Лодойсамбуу хоёр даана. Манааны байр нь хичээлийн байрны баруун урд талын хонхор, гал зуухны орчмыг Лийсэн манана. Лийсэнгийн байр бол гал тогооны хойд галын хураалттай түлээ. Хашааны зүүн галын овоолсон тоосгонуудын тэнд хамгийн сэжигтэй ширүүн байлдаан болж магадгүй газар. Тэнд Хашбат бид хоёр гарна. Үлдсэн бусад таван нөхөд байрандаа зүгээр унтана.

Гэхдээ холбоочноор хэл ирээд, яаралтай дуудвал түргэн босож байлдаанд орно. Манаанд гарах нөхөд манаанд гарч байгаагаа хэнд ч

мэдэгдэж болохгүй. Хүүхдүүд унтаад гүйцэхээр барагцаалбал 11 цагийн үед ганц ганцаараа сэмхэн гарч, манааныхаа байрыг эзэлнэ. Дэргэдээ чулуун “зэвсэг” бэлдэж авах хэрэгтэй.

Өнөө шөнө сар байхгүй. Чимээ маш сайн чагна! Борзоон явж байгаа сэжиг мэдэгдвэл юуны өмнө өөртөө аль ойр байгаа манаанд мэдэгдээд хоёул юм уу, гурвуулаа гэнэт дайрах хэрэгтэй. Тэгээд эсэргүүцэхгүй бууж өгвөл гары нь ард нь хүлээд, надад хүргэж ирнэ. Эсэргүүцэх юм бол цусныхаа эцсийн дуслыг хүртэл тэмцэхийн хамт тун дийлмээргүй бол “Туслаарай” гэж чанга хашхирна.

-Бид хэдэн цаг хүртэл манах юм бэ?

-Үүр цайтал манана. Үүр цайтал суугаад Борзооныг барихгүй юм бол маргааш дахиад манана. Бүрэн ялалтад хүрсэн цагт л бид амарна.

Отрядын дарга яриагаа дуусаад:

-Асуулт байна уу?

-Тэр Борзоон үстэй юм болов уу, толгойдоо?

-Үстэй ч байж болно, үсгүй ч байж болно.

-Үстэй бол үснээс нь зуурчихвал амархан даа

-Борзооныг барьсан хүнийг шагнах уу?

-Шагналгүй яахав. Баатар цол хүртэл олгоно.

-Бидэнд баригдах нь ч гайгүй биз дээ.

-Тэгж итгэл алдаж болохгүй шүү. Нэг л мэдэхэд Баянбулагийнхны нэр сургууль даяар алдарших болно.

-Бид нарын аз л мэдэж дээ.

-Аа, нэг юм мартсан байна. Борзооныг баривал манай байрныханд сургуулийн захиргаанаас аягүй бол торгон хөнжил ч өгч магадгүй.

-Торгон хөнжил нөмрөх нь ч яамай юу даа.

-За одоо хүүхдүүд унтаж гүйцтэл цөмөөрөө орондоо ороод, яг унтчихсан юм шиг хэвтэцгээнэ шүү. Бидний яриа дууслаа. Намжилыг оруул:

Том Жамсран бидний яриаг чангаж ярвайн сууснаа:

-Би ч гэсэн манаанд гарнаа гэж дуу алдав.

-Өнөө шөнөдөө Жамсранг манаанд гаргахгүй ээ.

Дур байвал маргааш гаргамз. Өнөөдөр манай хүч хангалттай гэж “Отрядын” дарга хэллээ.

Ингээд бид ор орондоо орж, чимээгүй хэвтэцгээв. Цаг тун удаан өнгөрч байлаа. Хүүхдүүд унтах яагаа ч үгүй бололтой, манай байрны хаяагаар ийш тийшээ үймэлдсээр л байна.

Одоо бодоход манай сургуулийн хүүхдүүд анх цуглаж байснаасаа өөр болжээ.

-Би гэртээ байхдаа энэ зун дүүтэйгээ цуг аргалд явж байгаад гэхчилэнгээр нэг нь түүхээ ярьж эхлэхэд:

-Аав намайг дагуулаад ноднин зун хөгшин аавынд айлчилж очсон. Тэгэхэд би халиун морио унаж явсан.

Хоёр хүүхэд ингэж ярилцаж эхэлсэн бол мөдхөн ярианд оролцох хүүхэд нэмэгдсээр дөрвүүл, тавуул, зургуул болоод хоёр гурван цагаар ч хамаагүй ярьцгаана.

Бидний ингэж ядрахын хажуугаар энэ муу хулгай зэлгийн явдал биднийг шарлааж байв.

Идэшний зүйлийг бол яаж ч хадгаллаа гэсэн хулгайд заавал алдана. Хүүхдүүд өлссөндөө л бие биенийхээ юмыг хулгайлж байна гэдгийг би мэдэж байлаа. Харин гэрийн бүрээс урж авдаг, хошлон огтолдог, хүүхдүүдийн хувцас хунарыг хорлодог нь ойлгомжгүй.

Нэг өдөр хүүхдүүдийн хичээлд орчихсон хойгуур байрны хүүхдийн бүх дээл тэрлэгийг гэрийнх нь голд овоолж байгаад гал тавьсан явдал гарсан юм. Энэ бол чухам л үл мэдэгдэх нэг амьтан, жишээлэхэд “Борзооны” хийсэн хэрэг болохоос биш хүүхдүүдийн хийх хэрэг огт биш байв. Яав ч энэ манай сургуулийн хүүхэд биш. Гаднын л хүн. Бид л энэ “Борзооныг” барих хэрэгтэй байлаа. Түүнийг барихгүй бол би ч энэ яршигтай хэргээс гарахгүй гэдгийг Цэвэгдорж багшийн ярианаас мэдсэн билээ. Бодоод байхад үнэхээр би, Сэмбэнгийн хэлдгээр, өөрийгөө хэрэгт оруулсан байна.

Энэ Борзооныг барихгүй бол дахиад Цэвэгдорж багшид юу гэж хэлнэ гэж бодохоос айдас хүрч хэвтлээ.

-Чамайг захирлын өрөөнд аваачаад өнөөдөр юу ярьсан бэ? гэж Сэмбэнгээс би шивнэн асуув.

-Хашбат та хоёр хулгайч нараа илрүүлж өг л гэж байна билээ. Би “илрүүлж өгнө өө. Илрүүлж өгч нэрээ цэвэрлэж авна” гэсэн.

Сэмбэн чимээгүй хэвтсэнээ:

-За босоцгооё! Одоо Борзоон ирж яваа! гэлээ. Энд тэнд түжигнэсэн чимээ гарч хүүхдүүд харанхуй дунд хувцсаа яаран өмсөцгөөв.

-Нэг нэгээрээ цуварч гараарай. Хаалгаа чанга дуугаргаж болохгүй! гэж “Отрядын дарга” заавар өглөө.

-Сэмбэн бид хоёр хамгийн сүүлд гарч, үүдээ чимээгүй сайн хаагаад, бараг мяраах шахуу зөөлөн явсаар сургуулийн хашаагаар гарч тоосгон дотор очив. Үдшийн харанхуй өнгөрч, гадаа бүдэг саарал гэрэлтэй болсон тул хэсэг хэсэг хураалттай тоосго, ухсан шуудуу нүх, энэ тэндгүй хаялсан цаасны өөдсүүд, цахилдгийн бутнууд цөм харагдаж байв.

Сургуулийн хашаагаар гарч, баруун тийш тавиад алхам явах зайд пин байна. Сэмбэн бид хоёр сургуулийн хашааны хаалга пин хоёрын дунд хэртэй зайд, гэхдээ нэлээд урагшаа байх хэсэг тоосгоны хамгийн хойд захад ухсан шуудуун дотор орж хойшоо харж суулаа. Нэлээд суулаа. Гэтэл бидний араар бөөрөнхий бөөрөнхий хар юмнууд чимээ гаргалгүй яваад байх шиг болж, надад нэг л аймшигтай байв. Сэмбэн ер айсан шинжгүй шуудууны амсар дээр өрөөсөн гараа тавьж, үнэхээр нэг юмны бараа харсан янзтай, хүзүүгээ сунган ширтсээр байлаа.

“Одоо шөнө болсон ч гэсэн Зөвлөлт, Германы цэргүүд байлдаж л байгаа. Буудалцаад л их цус урсаж байгаа... Тэгэхэд би ямар байлдаж яваа биш дээ” гэж дотроо бодсон чинь овоо айхгүй болов.

Сэмбэн бид хоёр чимээгүй нэлээд ажиглалаа. Сургуулийн баруун талаар байдаг айлуудын ноход дуу дуугаа авалцан хуцаж, бас нэлээд ойрхон морь тургих чимээ гарч, эмийн сангийн байшингийн хана бүдэгхэн цайрч харагдана.

Бидний баруун талаас том хар нохой ийш тийшээ шинжлэн шогшсоор яг Сэмбэн бид хоёрыг чиглээд ирлээ. “Идэш ууш ховордсон энэ дайн байлдааны цагт ийм тарган том нохой бас байдгаа!” гэж гайхмаар амьтан харагдсанд би дотроо сүрдэж, “Тэнэт бид хоёр луу архираад дайрвал яана!” гэж бодож суусан боловч тэр нохой, бидэн рүү дайрсангүй, “Та хоёр юу хийж суугаа юм бэ?” гэсэн янзтай биднийг хараад буцаж шогшлоо. Гэтэл хоёр эмэгтэй хүүхэд ярилцсаар гарч ирээд, хоорондоо:

-Анхнаасаа л чи надтай нэг ширээнд суухгүй.

-Харин тэгдэг л байж

-Миний хажууд суудаг тэр дэрчгэр чинь их сахилгагүй.

-Би савтай ширнээлээ дандаа гартаа атгаж суудаг шүү. (Тэр үед бид черниль гэж ярьдаггүй байсан) Тэгэхгүй бол дүрчих гээд байдаг юм. Ховдог дүрнэ гэдэг нь! Үзэгнийхээ үзүүрийг хугартал ч хамаагүй дүрнэ гээч! Ингэж ярилцаад хоёул буцаж байр луугаа явлаа.

“Ширнээлээ дандаа гартаа атгаж” суудаг нь Одон байна гэж би танилаа. Нөгөөхий нь таньсангүй. Энэ хоёрыг буцаж ороод, арваад минут хэртэй болсны дараа бас хоёр хүүхэд гарч ирэв.

Тэр хоёр хашааны хаалгаар гарч ирээд, ганц ч үг солилгүй хэдэн алхам явснаа зогсож хоорондоо шивнэлдэв.

Эрэгтэй хүүхдүүд бололтой. Хоёул жаал шивнэлдсэнээ, хүүхдүүдийн замаас зайлж урагшаа хэд алхаад, Сэмбэн бид хоёрын зүүхэн талд ирж, хэсэг тоосгоны ёроолд суув.

-Цаад хоёроо их сайн ажиглаарай! гэж Сэмбэн надад шивнэв. Тэр хоёр хоорондоо огт юм ярихгүй буюу эсхүл маш аяархан шивнэлдэж байгаа бололтой.

Гэхдээ их бие нь, гар нь байн байн хөдөлж, нэлээд удаан суулаа.

-Юм идэж байх шиг байна гэж Сэмбэн надад шивнээд, гараа миний мөрөн дээр тавин, тэр хоёрыг хөдөлгөөнгүй ширтэв. Сэмбэнгийн халуун амьсгал миний хүзүү рүү төөнөж, чихний араас үлээж байв. Би биенийхээ дулааныг алдахгүйн тулд өвдгөө тэврээд, бөхийн сууж байлаа.

-Энэ хоёр ч “Борзоон мөн дөг шүү. Том Борзоон уу, бага борзоон уу, одоо мэдэгднээ” гэж Сэмбэн мөн шивнэн хэллээ.

“Борзоон ийм байдаг юм бий!” гэж би дотроо баяртай бодож:

-Одоо дайраад орвол яадаг юм бэ? гэж Сэмбэнгээс асуухад:

-Болоогүй, хонгор минь! Болоогүй! гэж толгойгоо сэгсрэв. Би Борзоонуудыг шалавхан барих гэхээс тун яараад байлаа.

-Болоогүй. Сайн ажиглана! гэж Сэмбэн давтан хэллээ.

Гэтэл миний хамар дотор ирвэгнээд яаж ч болсонгүй. Би гэнэт найтаалгачхав. Сэмбэн миний сүвээ рүү нэг хүчтэй нудраад, үснээс минь атгаж доош нь дарав. “Тонгой!” гэж байгаа бололтой.

Бид хоёр бараг амьсгаа авалгүй нугдайн суулаа.

Нөгөө хоёр ч чимээ чагнаж байгаа бололтой огт хөдлөхгүй болчхов. Тэгж хэсэг сууснаа нэлээд чангаар шивнэлдээд хоёулаа босож тоосго дуугарган, бөгтөлзөж нэг юм хийж эхлэв.

-Юм нууж байна! гэж Сэмбэнд хэллээ.

Тэр хоёр шалавхан нэг юм тоосгоор дарчхаад босож, хашааны хаалга руу цувралдан алхацгаахад:

-Би явлаа. Энэ хоёрыг дагана. Чи тэр тоосгон дотор нуусан юмыг аваад байрандаа шалавхан оч! гэсээр Сэмбэн босож, тэр хоёрын хойноос дагав.

Би тоосгон догроос жижиг даавуун ууттай ааруул олоод олсондоо их л баярлаж байрандаа инээд алдан чичирсээр орж ирэхэд манайхан цөм ирсэн байлаа.

“Борзооныг баривчлах отрядын” анхны шөнө ингэж талаар өнгөрөөгүй нь бидний урмыг их сэргээв. Манай отрядын баривчилж ирсэн “Хоёр Борзооныг” (Би тийм нэр өгсөн юм) Маргааш нь оройн тоо бүртгэлийн дараа сурагчдын жагсаалын урд хөтлөн үзүүлж, шийтгэсэн билээ.

“Хоёр жижиг Борзооныг” баривчилсны маргааш өглөө нь бидний анхны ялалтыг тэмдэглэх ёстой боллоо.

-Манай отряд урьд шөнө үүргээ сайн биелүүлж хоёр жижиг Борзоон баривчилсан боловч, жинхэнэ том Борзооныг баривчилж чадсангүй. Том Борзооныг заавал олж баривчилна. Бид манаагаа үргэлжлэн хийнэ гэж отрядын дарга яриад,

“Урьд шөнийн манаанд оролцсон нөхдийг шагнана. Та нар алга ташаарай!” гэв.

Би ч алга ташлаа.

Гэтэл Сэмбэн ор дээрээ уудлан боодолтой юм гаргаж ирээд, манаанд гарсан хүн бүрд нэг нэг атта боорцог, таван хүний дунд нэг нэг хортой харандаа өгөв.

-Чи хаанаас ийм юм олоо вэ? гэж би гайхан асуусанд Сэмбэн.

-Энэ бол цэргийн нууц гэв.

Энэ өдрөөс эхэлж бид хэд “барагчингийн баас” гэдэг зэвхий бор бэхээр биш, харандааны бал уусгаж хийсэн тунгалаг цэнхэр ширнээлээр хичээлээ бичиж, бусдаасаа их л ялгарч тодорсон улс мэт бахархаж суулаа.

Борзооны чимээ түр намдав

Хоёр жижиг Борзооныг баривчилсны маргааш орой нь манай сумынхан байрандаа цуглачхаад, ер нь үүнээс илүү шуугиантай байж болохгүй болов уу гэмээр их шуугилдацгааж байлаа.

Тэдний яриаг чагнаад байвал жинхэнэ том Борзооныг өнөө шөнө заавал барих бололтой.

Хамгийн урдаар би хамар луу нь нэг сайн цохино гэж бага Жамсран хэлж байна. Энэ нь хэрэв л үнэн бол том Борзоон өнөө шөнө Баянбулагийнхны гарт баривчлагдаад, хамгийн эхлээд хамар луугаа нэг цохиулах болж байна. Гэтэл:

-Хүлж аваад сэргийлэхэд л өгвөл таарна. Тэгээд хамгийн хатуу шоронд хүлээстэй нь арван сар юм уу, насаар нь ч цоожилно биз гэж Намжилсамбуу яриад хамраа ухаж суув.

Анх, хулгайд юм алдагдвал л Борзоон аваад явчихсан гэж хүүхдүүд ярьдаг байснаа Янжирмаа гэдэг охиныг өвчилснөөс хойш, муу юм бүхнийг “Борзооны гай” гэж хүүхдүүд ярьдаг боллоо.

Хүүхдийн яриаг сонсоход тэр Янжирмаа шөнө гарч яваад, Борзоонтой хашааны гадаа дайралджээ. Тэгээд Борзоон түүнийг барьж аваад, хацар дээр

нь хэд үнсчихсэн чинь тэр шөнөө халуурч, маргааш нь эмнэлэгт хэвтсэн гэлцэнэ.

Тэр ч байтугай Борзооныг шөнө биш, өдөр зүсий нь үзсэн хүүхэд гарч ирлээ. Энэ нь Гурванбулагийн Дэндэв гэдэг хүүхэд байв. Дэндэв ярихдаа:

-Хүүхдүүд хичээлдээ орчихсон, байр эзгүй байхад Борзоон сургуулийн хашаан дотор хар даалимбан тэрлэгтэй, толгойдоо цагаан алчуур зангидчихаад, хөл нүцгэн гүйж явсан, Борзоон мөн. Байр луу орж хулгай хийх санаатай явснаа намайг хараад зугтаачихсан. Их түргэн гүйдэг юм билээ. Гүйж байхад нь харахад хөлийнх нь ул хар өнгөтэй харагдсан. Одоо бодоход тэр үстэй байсан санагдаж байна. Царайгий нь хальт харсан. Ер нь их том толгойтой амьтан билээ. Нүүр нь бүтэн хар талхны хэртэй бөөрөнхий бор юм харагдсан гэв.

Борзоон гэж тийм амьтан байхгүйг энэ сургууль дээр, энэ аймаг дээр, ер нь ертөнц дээр хамгийн сайн мэдэх ганц хүн нь би байсан хэрнээ л хүүхдүүдийн энэ элдэв яриаг сонсохоороо “Нээрэн л нэг хачин амьтан байгаа юм болов уу! Барьж үзэх юмсан. Болж гэмээ нь барьж үзэхээр барахгүй түүнийг багш нартаа харуулж, нэрээ цэвэрлэж авах юмсан” гэж хорхой хүрээд байв.

Би энэ оройн турш хэвтсэн юм. Босох гэхээс дургүй хүрээд, нэг их залхуу жижигхэн амьтан юм уу, өвчтэй хөгшин хүн шиг бүхэл оройжин хөрвөн, гэдэргээ харж яраглан, хүүхдийн шуугианыг чагнаж хэвтсэн билээ.

Гадаа цагаан гэгээ тасарч, хаяагаар хүйтэн салхи сэм сэм сэнгэнэж, гэрийн хөшигний хормой зөөлөн дэрвэж хийссээр байлаа. Ингэж байтал манай их дуутай хаалга тар ярхийн нээгдэж, Довдон цагаан ууттай юм барьсаар орж ирлээ. Энэ нь шинэ жилийн цагаан өвгөн биш, нэг муу жижиг хар гэрт ээжгэйгээ хоёулхнаа байдаг залуу байсан юм. Эднийх хэдэн үнээтэй. Чухам хэдэн үнээтэйг яг мэдэхгүй. Бас аймгийн төвөөр унаж давхидаг туранхай цагаан морьтой. Хөгшин, туранхай цагаан морио унаад, нэг харахад аймгийн баруун захад явж байснаа ахиад нэг харахад л аймгийн зүүн захад гарчихсан. Худаг толгойн шилээр давж яваа харагдана. Цагаан морио унаад давхиж явахдаа Довдонгийн өөрийнх нь сүртэй харагдана гэдэг жигтэйхэн. Цагаан мориныхоо нуруун дээр гарахад тэгж их халууцдаг юм уу, хэчнээн сэрүүн байсан ч Довдон цээжээ ярж цагаан хэнхдэг гаргаад, эмээл дээрээ шовойтол зогсож, халимаг нэртэй хэдэн үсээ зүг бүр лүү өрвөлзүүлэн, ташуураа дээр дээр гозолзуулж давхина. Ер нь л хийморьтой доо.

-За чи юу авчраав! Юмаа задал! гэсээр Довдонг манай байрныхан тойрон овооролдоно.

Довдон манай байраар ирэхдээ нойтон ааруул, шинэхэн бяслаг, боорцог, чанасан мах, шаргал эззгий, ер нь юу ч авчирч мэднэ. Анх Довдон манай байраар бараг орой бүр ирдэг байснаа нэг орой манай байранд ааруул зарж байж Цоодол багштай дайралдаад аашлуулснаас хойш хааяа нэг, гэхдээ голдуу үдшийн цагаар сэмхэн ирээд, шалавхан буцдаг болсон юм.

Жаахан цагаан идээ л авчирлаа гэж Довдон хэлээд, үүд рүү харан:

-Хаалгаа түгжээрэй! Багш нар ороод ирвэл яршиг гэв.

-Наад ууттай юмныхаа амыг тайлж бай! Би нэг сайн тамхи татаад авъя! гэж Довдонг хэлэхэд ууттай юмны ам тайлах гэж хэдэн хүүхэд өрсөлдөн

булаалдлаа. Довдон яаралгүй тамхиа татаж аваад, ууттай юмыг урдаа дэлгэж, өөрөө завилан суув.

Худалдаа эхэллээ. Довдонгийн өвөр дээр мөнгө цугларч энд тэндгүй хүүхдүүдийн ам хөдлөн хоорондоо шивнэлдэн инээлдэж, түгжээтэй хаалга руу сэргэлэн нүдээр байн байн харж, чимээ чагнаж баясалдан сууцгаав.

Биднийг ингэж жаргаж суутал гэнэт хаалга балбав. Бид сандран хамаг юмаа нуулаа. Хаалга дахиад тогшлоо. Тогшиж байгаа байдлыг чангахад бараг жижүүрийн багш байх гэж танигдаад ирлээ.

Ингээд хаалга нээгдэл тэр өдрийн жижүүрийн багш Дорж яг дүрээрээ орж ирлээ. Бид юу ч дуугарч чадалгүй хааяа Дорж багшийн нүүр лүү, хааяа бие биенийхээ нүд рүү харан зогсож байтал Дорж багш том Жамсрангийн мөрөн дээр гараа тавиад:

-Юунд сандраав? гэж асуулаа

-Бидний хэн нь ч дуугарч чадсангүй.

Гомбо шүрхийсэн чимээ гаргаж нусаа татав.

-Энэ хэвтэж байгаа хэн бэ? гэж Дорж багш Мягмар луу заалаа. Мягмар хэвтэр дотроо нэг зөөлөн хөдлөх шиг болов.

-Мягмар өвчтэй байгаа юм гэж би хэлээд, багшийн өөдөөс хартал Сэмбэн хажуунаас:

-Манай байрны хоёр хүүхэд бие нь өвдөөд байна гэж хэлэв.

-Дорж багш хучаастай хэвтэж байгаа Довдон руу ажигласнаа:

-Гутал хувцсаа тайлаад тохьтой хэвтэхгүй. Та нар эмч, ангийн багш нартаа хэлж байна уу? гэж асуув. Гэтэл Мягмар толгойгоо гаргаж ирээд:

-Багш аа ерөөсөө эм олдохгүй байна. Би халуунтай байна гэж хэллээ.

Дорж багш Мягмарын дэргэд очоод явган сууж, магнай дээр нь гарынхаа араар дарж жаал байснаа толгой сэгсэрч:

-Халуунтай л байна даа. Энэ бас халуунтай байгаа юу? гэж асуугаад босов.

Багшийн байдлыг ажиглахад яриангүй Довдонгийн хучлагыг сөхөж үзэх янзтай боссон тул Сэмбэн:

-Багш аа үүнийг хараач! гэж Дорж багшийн тохойноос барьж амаа ангайв. Тэгээд:

-Миний хоолой өвдөх гээд байх шиг байна. Та нэг хар даа гэж хэлэв.

-Дорж багш Сэмбэнгийн хоолой руу ч харсангүй, харин өнөө шөнө эмч дуудахаар амлаад гарав.

-За одоо айх юм байхгүй болсон Довдон ч яв! Бид ч манаандаа гарна гэж Сэмбэн хэллээ.

-Юун манаа? гэж Довдон сонирхон асуусанд “бид энэ шөнө том Борзоон барих” гэж байгаагаа бахархан ярьж, бас жаал юм идэж аваад манаандаа гарахаар дулаан хувцсаа өмсөцгөөв.

Энэ шөнийн манааны ажил ямар ч үр дүнгүй болохыг мэдсэн юм шиг миний залхуу хүрч, манаанд гарна гэхээс толгойтой үс маань үс үс өндийж ирээд байх шиг санагдаж байлаа.

Гэвч “Баатар болох хүний чанар бага юман дээр танигддаг юм. Манаанд гарах л хэрэггүй. Манаанд гарахгүй бол чамайг нөхдөөсөө урвасан гэж үзнэ” гэж Сэмбэнгийн хэлсэн үгийг сонсоод, арга буюу гарлаа.

Энэ шөнийн манаанаас миний мэдэж үзсэн ганц сонин явдал бол багш нарын хурал байв.

Би хүн болсоор ийм урт хурал хаана ч үзээгүй. Үдэш манаанд гарахад л багш нарын конторт лааны гэрэл харагдаж байсан.

Мярааж очоод гаднаас нь чагнах юм уу гэснээ “Багш нарын конторт Борзоон орж ирээд сууж байгаа биш биз дээ” гэж санагдаад би түүгээр хавьтсангүй. Энэ хурал лав л шөнө дундаас бүр өнгөрч, унтахсан гэхээс арга барагдаж “Ингэж их хуралдахад яасан олон лаа урсгаа бол” гэж надад бодогдож байхад л гарсан юм даг.

Маргааш нь манай сургуульд болсон нэг том явдлыг лав энэ хурлаар хэлэлцсэн байх гэдгийг би эргэлзээгүй мэдэж байна.

Энэ бол манай сургуулийн түүхэнд сонин явдал байсан юм. Энэ өдөр бид хичээлээ дуусгаад, урьдынхаа янзаар тарах гэж байтал “Сүүлчийн хичээлийн дараа тавдугаар ангийнхан гадаа жагсаж, тоо бүртгэл хийнэ” гэж гэнэт зарлалаа. Урьд нь бид тоо бүртгэлийг орой хийж дараа нь “Интернационал” дуулаад тардаг байсан юм.

Хашаан дотор манай сургуулийн тавдугаар ангийн бүх хүүхэд ганцхан эгнээ болж жагсаад байхад сургуулийн захирал, бас хэсэг багш нар жагсаалын өмнө ирж, бөөгнөрөн зогсоод, биднийг ажиглан хоорондоо ярилцаж байна.

Юу хийх гэж байгаа нь мэдэгдэхгүй хэсэг байсны дараа сургуулийн захирал Төрбат:

-За хүүхдүүд ээ, чимээгүй! Одоо бид нэр дуудна. Нэр гарсан хүүхэд урагшаа арав алхаад байгаарай! гэж хэлээд, нэр дуудаж эхэллээ.

Нэр гарсан хүүхдүүд захирлын хэлснээр урагшаа арав алхаж зогсож байсан байрныхаа харалдаа урд гарч нэг эгнээ болон жагсав. Маш олон хүүхдийн нэр гарсан учир бүх хүүхэд бараг тэнцүү хоёр эгнээ боллоо. Хэчнээн чагнасан боловч миний нэр гарсангүй. Манай сумынхнаас найман хүүхдийн нэр гарав.

Ингээд бусад нь арын эгнээнд үлдлээ. Нэр дуудаж гүйцсэний дараа:

-Арын эгнээ, сонсоорой! Баруун гийш! Алхаад марш! гэж цэрэгжлийн багш Шагдар командалж, манай эгнээг дагуулан явлаа.

Ингээд биднийг жагсаалаар нь аваачиж, хашааны ёроолд суулгаад, Цоодол багш бидэнд яриа хийлээ.

Цоодол багшийн ярианаас миний ойлгосон зүйл гэвэл бид энэ сургуулийн тэргүүний сайн хүүхдүүд гэнэ. Бас манай сургууль мөдхөн тохижиж их сайхан болоод бид байр, ор дэвсгэр, хоол унд юм бүхнээр элбэг сайхан болох гэнэ. Цоодол багш нэлээд ярьсныхаа дараа хүн бүр заавал онц юм уу, сайн суралцах хэрэгтэй гэж бидэнд үүрэг өгөөд, бидний үе насны хүүхдүүд Зөвлөлтөд яаж баатарлагаар байлдаж байгаа тухай олон сайхан юм ярив. Бид хааяа хоорондоо ганц нэг үг сольж инээлдэж, Цоодол багшийн яриаг овоо л анхааралтай чагнацгааж байлаа. Нөгөө нэр дуудагдаж үлдсэн урд эгнээний хүүхдүүдийг мөн л хичээлийн байрны баруун талд модон морины урд суулгачаад, захирал яриа хийж байгаа харагдлаа.

Цоодол багш хэзээ ч яриагаараа хүний урам сэтгэлийг хөгжөөж чаддаг хүн болохоор бидний сэтгэлийг сэргээж ярианыхаа эцэст:

-Та нар сахилга бат сайтай, хичээл номдоо шамдлагатайхан оролцож байгаад онц юм уу, сайн суралцацгааж чадмаар байна уу? гэж асуухад нь бид “чаднаа!” гэж бараг нэг зэрэг чанга дуугаар хариулцгаалаа.

Гэтэл гэнэт хүүхдүүд хашхиралдан нижигнэх чимээ гарч хичээлийн байрны баруун талд цутларсан хүүхдүүд тарцгаав.

Тэдний тарж байгааг харахад “Энэ ер нь юу болов оо!” гэж гайхмаар харагдав. Цөм бие биеэ дуудан, чанга чанга хашхирч, үргэсэн зээр адил пижигнэлдэн бидэн рүү гүйлдэцгээв.

-Үймэлдэхгүй байцгааж байгаарай! гэв. Цоодол багш бидэнд хэлсэн тул бид суусан байрнаасаа хөдлөлгүй тэднийг ажиглаж байлаа. Түрүүчийн хүүхэд гүйж ирээд, бидний хамгийн захын эмэгтэйтэй уулзлаа. Тэр эмэгтэй ухасхийн боссоноо гараараа нүүрээ дараад уйлж эхэллээ.

Ажиглаад байхад гүйж ирсэн хүүхэд бүр нэг л сонин юм сонсгоод байх шиг харагдана.

“Нутаг буцах боллоо” гэж нэг хүүхэд хашхирч байгаа нь тодхон дуулдлаа.

-Нутаг буцаах гэнэ үү? гэж би хажуудаа суусан хүүхдээс гайхан асуулаа. Цоодол багшийн яриаг чагнаж байсан хүүхдийн анхаарал сарниж, цөм мэл гайхсан царай гарган түр хүлээнээ, нутаг буцах хүүхдүүдийн гүйлдэн ирэхэд босох нь босож, уйлах нь уйлж бүр үймэлдэж гүйцэхийн хажуугаар шуурга хөдөлж, хашааны ёроолын шороо бужигнаж эхэллээ.

-Чи надад эмээлээ өгөөрэй!

-Маргааш өглөө өртөөгөөр гарна.

-Би хазаараа зарчихсан юмсан. Одоо яана!?

-Захидал явуулна шүү гэхчилэн яриа шуугиан болж байтат Цоодол багш:

-Нутаг буцах хүүхдүүд явцгаа! Байрандаа очицгоо! гэж тэднийг явуулаад, бидэнд яриагаа үргэлжлүүлэв.

-Сургуулийн бэлтгэл хангалтгүйгээс сурагчдын нэг хэсгийг нутагт нь буцааж байна. Тэд уйлж унжиж, сүйд болж л байна. Одоо яая гэхэв. Тэр хүүхдүүдийг хойтон сургуульд нь дахиад суралцуулна. Харин та нар нэг жил алдаагүйдээ баярлаж хичээлдээ шамдаж сурцгаах хэрэгтэй гэхчилэн Цоодол багшийг ярьж байхад яриа чагнаж суугаа хүүхдийн ихэнх нь инээцгээж суув. Бас нэг хэд нь уйлж харагдав.

-Одоо тарцгаа! гэж Цоодол багш хэлэв.

Нутаг буцах хүүхдүүд ганцхан өдрийн дотор багтаж өртөөгөөр өөр өөрийн сум руу гарцгаалаа. “Аав ээж хоёрын нэг нь заавал ир!” гэж би гэртээ захиа бичив.

Том борзоон баригдав

Хэсэг хүүхэд нутаг буцсанаас хойш сургуулийн байр байдал, бүх юм чухамхүү Цоодол багшийн хэлснээр огт өөр болоод явчихлаа.

Манай сумын арав гаруй хүүхэд дотроо хоёр хуваагдаж, бидний хуучин байсныг бодвол үнэхээр байр гэж хэлж болохоор ортой, дэвсгэртэй, зуух яндантай, хоёр том гэрт орж, зарим маань орныхоо харалдаа арын хөшгөн дээр элдвийн зураг хадаж, дэвсгэр хучлаганыхаа тоосыг гүвж, тохижих янз ороод ирлээ. Өнөөх Борзоон гайхлын чимээ ч хоёр хоногтоо дуулдсангүй.

Цоодол багш хичээл заахаар орж ирлээ. Ингээд хичээл эхлэх гэж байтал урьд нь огт үзээгүй, гаднах байдлы нь харвал яриангүй дарга бололтой гурван хүн манай ангид орж ирлээ.

Бид зэрэг босож ёслов.

-Энэ бол шалгалтаар яваа улс. Ярьж хэлмээр юм байвал энэ улсад ярьж болно. Асуух юм байвал бас асууж болно гээд Цоодол багш гэр гурван хүний нэрийг хэллээ.

Манай ангийнхан таг чимээгүй болоод, гэр гурван хүнийг ээлжлэн ажиглацгааж суув. Миний ажигласнаар бол Биндэрьяа гэдэг нэртэй, өндөр нуруутай, гялалзсан хар товчнууд хадсан цэрэг ногоон цамцтай хүн хамгийн том тушаалтай юм уу, эсхүл их ширүүн догшин хүн шиг санагдав. Тэр хүн “Цоодол, хичээлээ явуул!” гэж хэлээд, анги дотуур түрүүлэн явж, хүүхдүүдийн дэвтэр ном руу өнгийн харж, зарим хүүхдийн дэвтрийг авч үзэж, заримаас нь сэмээрхэн юм асууж байлаа. Тэгж явсаар миний арын ширээнд сууж байсан Тогтох гэдэг эмэгтэй хүүхдээс:

-Тэр хэний зураг вэ? гэж сэмээрхэн асуув.

Ямар зураг асууж байгааг сонирхон би эргэж харвал манай ангийн хананд хадаастай байсан нэг зургийг зааж суужээ. Тогтох хариулж чадсангүй.

“Шалгалт ирээд байхад мөн ч баларч байна даа!” гэж Тогтохын өмнөөс би хүртэл, сэтгэл зовж, “Дахиад л олон юм бүү асуугаасай! Бид ч өнгөрлөө шүү” гэж бодож урагшаа яльгүй бөхийгөөд, хичээл дээр жирийн суудгаасаа нэлээд намхан сууж байлаа.

Биндэрьяа гуай тэр Тогтох гэдэг эмэгтэйг бараг “ангиас гар” гэнэ байх гэж надад санагдсан боловч Биндэрьяа гуай тэгэх нь байтугай, харин ч Тогтоход “Хайр нь хүрнэ үү” гэмээр янзтай, мөрөн дээр нь гараа тавиад, хамт явсан хоёр хүн рүүгээ харж инээмсэглэв.

Цоодол багш ч инээж байгаа харагдана.

Багш, дарга нарын инээж байгааг хараад, надад огт айх юмгүй болж дотор минь уужран, би нуруугаа тэнийлгэж, өндөрхөн суулаа. “Надаас юм асуувал ч асууг!” гэж бас бодогдоод байв.

Цоодол багш журнаалаа дэлгэж ширээнийхээ ард суугаад,

-Бадамгарав! гэж нэр дуудлаа.

Бадамгарав босож номхон зогсов.

Чи пелопоннесийн дайны тухай нэг сайхан яриад орхи! гэв. Шалгалтынхан манай ангиас гарч явахынхаа өмнө:

-Нөгөө “Борзооныг” үзсэн хүүхэд танай ангид байна уу? гэж нэг нь асуув.

“Гайхалтай юм. Миний зохиогоод ярьчихсан Борзооныг манай сургуулийнхан төдийгүй энэ шалгалтаар яваа улс хүртэл мэдчихсэн байдаг. Ер нь энэ шалгалтаар яваа улсад үнэнийг яривал яадаг юм” гэсэн шиг бодогдож миний сэтгэл тэмүүлээд байв.

-Яримаар юм байвал энэ улсад ярьж болно гэж Цоодол багшийн хэлснийг саналаа. Тэгээд гараа нэг өргөх юм уу гэснээ Биндэрьяа гуайн нүүр лүү ажиглалаа. Бидний юу ярих бол гэсэн янзтай над руу ч хараад байх шиг санагдана. Тэгэхээр нь гараа ч өргөсөнгүй шууд босоод:

- “Борзоон” гэж тийм хүн байхгүй гэж би шалгалтын улс руу харж хэллээ.

-Юу гэнээ? гэж Биндэрьяа гуай асуугаад над руу ойртож ирлээ.

-Борзоон гэж тийм хүн байхгүй! Би худлаа ярьсан юм.

-Тэгээд хүүхдүүдийн юмыг хэн хулгайлаад байна гэж бодож байна?

-Мэдэхгүй. Харин Борзоон гэж хүн байхгүйг л би лав мэдэж байна. Өөр нэртэй хулгайч байх. Тэр хулгайчийг бид нар олно.

-Бид нар гэж чи хэнийг хэлж байгаа юм бэ?

- Манай сумынхан.

-Чи тийм амархан олчихно гэж бодож байна уу?

-Тийм.

-За тэгвэл сайн л байна. Олох л хэрэгтэй. Харин чи Борзооны тухай хэнд юу гэж худлаа ярьсан юм?

-Одоо нутагтаа буцаад явчихсан. Нямжав гэдэг хүүхдэд ярьсан юм. Борзоон гэж хөлийнхөө уланд үстэй хүн байдаг гэж тоглоомоор худлаа ярьж байсан юм.

-Яах гэж тэгж ярьсан юм бэ?

-Миний буруу, багш аа!

-За тийм байж... тэр хулгайчийг олох хэрэгтэй гэв.

Ингээд шалгалтынхан гарч явлаа.

-Бид сургуульд ирсэн шалгалтыг тун муу өнгөрөөснөө ярилцаад, тэр өдрийн орой байрандаа сууцгааж байтал намайг захирлын конторт дуудлаа. Конторт миний огт танихгүй нэг залуухан хүн. Цоодол багш, Сэмбэн, Цэвэгжав багш дөрөв сууж байна. Сэмбэнгийн царайг харахад тун баяртай, нүүрнээс нь бараг гэрэл цацран алдаж, инээмсэглэн суув.

-Суу Хашбат аа гэж Цоодол багш дэргэдээ байсан мухар сандлыг над руу ойртуулаад

-Өнөө шөнө манаанд гарна даа. Борзооныг чи барина. Чадах уу? гэж асуулаа.

-Чадна аа багш аа! гэж зогсоогоороо хариуллаа.

-Хүүхдүүдэд ярьж хэлсний хэрэггүй. Хэдэн хүүхэд гараад, нэг шөнө нэг цаг хүртэл л манаа хийнэ. Харин дулаан хувцсаа өмсөх хэрэгтэй. Чухам ямар янзтай манахыг энэ хүн нарийн хэлж өгнө гээд Цоодол багш миний үл таних хүн рүү заав.

Тэр хүн Сэмбэн бид хоёрт нарийн заавар өгөөд,

-Миний ярьсныг та хоёр сайн ойлгов уу? гэж асуулаа. Сэмбэн бид хоёр

-Ойлголоо гэж хариулахад

-За юу гэж ойлгосноо нэг яриад орхи! гэв. Бид хоёр ойлгосноо ярилаа.

-Та хоёр ойлгосон байна. Би ч гэсэн та нартай манаанд гарна. Хэрвээ та нарын хүч чадал дутагдаад, намайг дуудах хэрэг гарвал үүнийг амандаа хийж байгаад ингэж үлээнэ дээ.

Харж бай! гээд өврөөсөө шүгэл гарган, бидэнд үлээж үзүүллээ. Дараа нь бид хоёр мөн нэг нэг үлээж үзэв. Бид хоёрын шүгэл үлээж чадах эсхийг шалгасны дараа тэр хүн бид хоёрт нэг нэг шүгэл өгөөд:

-Үүнийг хүүхдүүдэд үзүүлж болохгүй. Хамаагүй үлээж бас болохгүй. Ажил дуусмагц би хурааж авах юм шүү! гэж хэлэв.

Ингээд Сэмбэн бид хоёр байр луугаа явлаа.

-Энэ танихгүй хүн манай сургуулийн багш болсон юм уу? гэж би Сэмбэнээс асуулаа.

-Энэ гаднын хүн. Харин чи үүнийг хүнд хэлж болохгүй шүү. Энэ бол “цэргийн нууц” гэж хэлэв. Борзооны чимээ сураг дуулдахаа больсон хойно ингэж гэнэт манаанд гарах болсон нь надад хачин санагдахын хажуугаар энэ сургуулийн олон хүүхдээс зөвхөн Сэмбэн бид хоёрыг ялгаж, манаанд гаргах болсон нь миний сэтгэлийг тун их түгшүүргэй болгож, би өвөртөө гараа хийгээд өнөөх танихгүй хүний өгсөн шүгэлийг янз янзаар барьж, үзэж явлаа.

Хэд хоногийн өмнө бидний манаад гарч байсныг бодвол шөнө их хүйтэрч, үстэй дээл өмсчихөөд байхад хүртэл даармаар болсон байв. Би яг авсан зааврынхаа ёсоор Сэмбэнгээс түрүүлж, байрнаасаа сэм гараад, сургуулийн гал зуухны байшингийн урд дахь хоёр том бөөрөнхий модныг хооронд орж, түрүүлгээ харан хэвтлээ.

Надад сургуулийн хашааны урд булан, гал зуухны байшингийн цонх, хаалга, хашааны араар хаясан хэсэг жижиг цаас хүртэл харагдаж, аймгийн төвийн ноход хуцаж, бас нэлээд хол бололтой хүн дуулж байгаа нь бүдэгхэн сонсогдож байлаа.

Энэ шөнө саргүй, үүлгүй, зөөлөвтөр, гэхдээ хүйтэн салхитай байв. “Сайн дулаалаарай!” гэж Цоодол багш захиад байхаар нь би үнэгэн лоовууз өмсөөд байрнаасаа гарсан гом. Гэтэл хол ойрын чимээ чагнахад саад болоод байхаар нь малгайгаа авч урдаа тавив.

Ингээд нэлээд чагнаж хэвтсэн боловч эргэн тойрон ер чимээ аниргүй, салхи л байн байн сэвэлзэж, хашааны шургааг гиншин шуугина. Өдийд чинь манай суманд ч гэсэн шөнө болчихсон, хонь маань хотон дотроо, үхэр маань зэлэн дээрээ, манай гэрийнхэн ид нойрон дундаа байгаа даа. Манайд хоноцтой байгаа болов уу, үгүй болов уу? гэж би дотроо таамаглан бодлоо.

Хөдөө байхад хонуудаар хол ойрын хүн ирэх тун сайхан.

Манайд нэг өвөл, Далангийн өвөрт байхад бөгтөр Дагва гуай ирж хоносныг би огт мартдаггүй юм. Их л хүйтэн цаг байсан юм даг. Гаднаас оруулж ирсэн үхрийн гуя тэс хөлдүү, тулганд түлсэн задгай гал бараг тоононд хүртэл дүрэлзэж байхад Дагва гуай бидний ажилд тус болж, тэр хөлдүү гуянаас хутгаараа зороод, бидэнд үлгэр ярьж суусан билээ. Тэр үлгэрийг хүртэл би одоо мартаагүй.

“Эртээ урьд цагт нэг хүн голд ойчоод усан дээгүүр хөвж явж гэнэ. “Богд минь, богд минь!” гээд л хөвөөд явж. Тэгж явсан чинь голын эргэн дээр ургасан ганц бут дайралдаад тэр бутнаас барьж амь аврагдах болж гэнэ. Өнөө хүн эрэг өөд авирч байх зуураа баярлаад “Богдоос түрүүнд нэг муу бут тус боллоо” гээд хэлчихсэн чинь өнөөх бут нь тас үсрээд, ус руугаа буцаад орчхож гэнээ. Тэгсэн чинь өнөө хүн “Тоглосон юм Богд минь! Тоглосон юм Богд минь!” гээд л хөвөөд явж гэнэ! Тэгээд амар сайхан жаргажээ”

-Энэ үлгэрийг чагнаад бид их л инээлдэж:

-Тэгээд тэр хүн уснаас яаж гарсан бол? гэж Дагва гуайгаас асуухад

-Гүйгээд л гарчхаа биз гэсэн билээ.

Усан дээгүүр яаж гүйдэг юм бол гэж би их гайхаж:

-Гүйгээд гарчхаж болдог юм уу, Дагва гуай? гэж асуухад тэр:

-Би хувцсаа тайлж толгой дээрээ тавиад л гүйгээд гарчихдаг байсан гэж ярих.

Одоо бодоход худлаа ч ярьж байж.

Дагва гуайн үлгэрийг бодож хэвтсэнээс би цээжээ өндийлгөж ийш тийшээ харлаа. Өнөөх Борзооны чимээ ч байдаггүй, манаа хийж байгаа нөхөд ч харагддаггүй, эргэн тойрон сүүмийн харанхуйлаад би бүр их ганцаардаж байх шиг санагдав. Харин миний гэдэс л үе үе өвдөөд байх шиг санагддаа. Ингэж дэмий хэвтэж байснаас босоод түлээ мод өнхрүүлсэн ч дээр баймаар санагдав. Гэсэн ч бид байр байрнаасаа огт хөдөлж мэдэгдэлгүй, ямар боловч шөнийн нэг цаг өнгөртөл манаа манах даалгавартай тул би босож юм оролдох байтугай, өндийгөөд сууж ч болохгүй байлаа. “Хэвтэх л хэрэгтэй!” гэж би өөртөө хэллээ. Хэвтээд байлаа.

Хэрэв энэ нохдын хуцан улин шуугилдаж байгаа чимээ “Борзоон гэж бидний нэр өгөөд байгаа тэр муу хулгайчийг барьж авахаар барахгүй, буудаж албал таарна. Яг дух руу нь буудвал таарна” гэж бодсон чинь сайхан санагдаад, дээшээ харахад тэнгэрт зөндөө олон сайхан од гялалзаж, бие маань түр өвдөхөө болилоо.

Энэ шөнө заавал манаа хийж байгаа ийм чухал цагт, миний нойр ингэж их хүрч, бие маань ингэж айхавтар өвдөөд байгааг бодохоос хэнд ч юм их л гомдож, би хацар, шанаа, хамрынхаа үзүүрээс хүртэл хэд хэд дахин өвдтөл чимхэв.

Тэгээд дотор овоо уужрах шиг болж цээжээ өндийлгөж ирээд чимээ чангаж байтал, сургуулийн баруун хаалганы тэнд бололтой гэнэт шүгэл тасхийлээ. Ахиулаад чагнаж байтал шүгэл дахин дуугараад хүмүүс шуугилдаж эхэллээ. Би босож, тэр зүг рүү хар хурдаараа гүйв. Очоод үзтэл Сэмбэн бид хоёроос гадна зөндөө олон хүн манаа хийж байсан юмсанж. “Том Борзооныг” барьж аваад урдаа туучихсан шуугилдаж явлаа.

Өч төчнөөн хоног бодож, санаархаж, манаа хийж яваад “Том Борзооныг” яг барихад өөрөө оролцож чадаагүйдээ миний урам хугарч, бас тэр том Борзооны гараас хүртэл хоол идэж, зэрэгцээд сууж байснаа бодохоос уур хүрч, түүнийг бүр нам цохиод унагачихмаар байв.

Би орондоо ороод нэг хэсэг уйллаа. Хор хөдөлсөндөө уйлсан юм.

Бас л Борзооны гай

“Энэ Борзооны гай дуусах цаг арай хийж нэг ирлээ дээ” гэж бодсон чинь бас байдаггүй. Горьдсон сэтгэлийн гарз болов. Нэг юмыг одоо л нэг дуусна байх гэж дэндүү горьдоод байхаар дуусдаггүй юм байна гэж мэдээд, би эмнэлэгт ирсэн хойноо “Борзооны гай дуусах яагаа ч үгүй” гэж дотроо бодож, бодсондоо бат итгэж байлаа. Том Борзооныг баривчилсны маргааш өглөө нь би хэвтрээсээ босож чадсангүй. Надад өвчин туссанаас болж л тэр шөнийн манаан дээр тэгж их нойр хүрч, бие чичрээд байсан юмсанж. Манай сургуулиас олон хүүхэд өвдөж эмнэлэгт хэвтжээ.

Намайг эмнэлэгт ирсний маргааш орой нь гэрийн үүдэнд хоёр хүн ирээд ингэж ярилцав.

Одоо манай муу гэрийг авчирч барихаас даа

Чи тэгээд өөрөө хаачих вэ? гэж байна. Энэ яриаг сонсоод би эмнэлэг байргүй их тэвдэж байгааг ойлгов. Байр хүрэлцээгүйгээс болж, янз бүрийн

өвчтэй хүүхдийг нэг байранд хутгалдуулж, нэгний нь өвчин нөгөөдөө түргэн халдаж байлаа. Анх намайг эмнэлэгт ирэхэд “Цусан суулгатай” хүүхэд гэж эмч нар хоорондоо ярьдаг байснаа “коор” гэж нэг шинэ нэр яригдах болж, миний бүх бие улаан гувруу татан туурлаа.

Ийм хоёр өвчтэй болоод байтал бас нэг яльгүй нэмэр өгч орхиё гэсэн шиг нүд өвдөв. Намайг ингэж өвчнөө бүрдүүлж байх хугацаанд (энэ бол маш богино хугацаанд, жишээлээд хэлэхэд уулын оройгоос бэл рүү нь гүйгээд буухын хэртэй шахам түргэн хугацаанд болж байгаа хэрэг) эмч нар ч амжиж, эмнэлгийн хашаан дотор хоёр гэр нэмж бариад, ялгаж хэвтүүлээ.

Энэ ялгалтаар манай сургуулийн нөгөөх уйлхай Батнасан, Бууцагаан сумын Одон гэдэг нэртэй, ширнээлээ дандаа гартаа атгаж суудаг эмэгтэй хүүхэд, аль сумынхныг мэдэхгүй Галсандорж гэдэг эрэгтэй хүүхэд бид дөрөв эмнэлгийн хашааны баруун урд буланд, хамгийн онцгой барьсан жижиг бор гэрт оров.

Хүнд ер нь биендээ өвчин халдааж авахын уран чадвар гэж байдаг юм бол тэр чадварыг би энэ эмнэлэгт ирээд, үлгэр жишээ болохоор үзүүлсэн гэж өөрийгөө санадаг юм.

Тэр үед миний байдлыг харвал, эцэж турахын туйлд хүрч, арьс маань улаан цоохор болтлоо туурч, бас хоёр нүдний зовхи хавдсаны улмаас хааяа юм харах хэрэг болбол нүднийхээ зовхийг хоёр гараараа дээш доош нь салган татаж хардаг, хүн аймаар амьтан болоод, биеэ харахаас хүн байтугай би өөрөө айдаг байв.

Надтай хамт тусгаарлагдсан гурван хүүхэд ч мөн надаас доор уу гэхээс биш, дээр юм байхгүй. Манай гэрт эмч, сувилагчаас өөр хүн эс орно. Нэг өглөө уйлхай Батнасан,

-Би ч мөдхөн үхэх байх аа даа! гэж хэлээд, хөнжил дотроо бүр чангаар дуу алдан уйлав. Энэ нь надад тун эвгүй санагдаж, орноосоо өндийгөөд би нүднийхээ зовхийг дээш доош нь татаж Галсандоржийг харав. Галсандорж ч тун муу байгаа бололтой, царай нь дун цайгаад нүдээ тас аньж, үг хэлэхгүй мөртөө ам нь хий ангалзаж нэг хээг болов. Тэгэхдээ шүдээ чанга зуугаад байгаа бололтой шанааны нь булчин таталдаж, магнайны нь хөлс бурзайж байлаа. Батнасан уйлсаар л байлаа. Гэтэл Галсандорж гэнэт дуу орж:

-Гэдэс базлаад алахаа шахаж байна. Би “Аавын хүү” тулдаа л тэслээ, гэснээ Батнасангийн уйлж байгааг ажиглав бололтой.

-Батнасанг Ленинградд сургуульд явуулна гэж Чойдог багш хэлсэн байх аа, Хашбат аа? гэж Галсандорж надаас асуув.

-Тэгсэн шүү гэж би хэллээ.

-Манай Батнасан үнэндээ лут ухаантай даа. Манай аймгийг мандуулах хүн бидний дунд Батнасан л байгаа юм. Ганцхан гэм нь л уйлдаг. Би уйлхай хүнд бас дургүй. Батнасан том болоод ер нь тооны л багш болох хүн байх. Би яг мэдэж байна. Тийм үү. Батаа? гэж Галсандорж асуув.

Батнасан уйлж байснаа больчихоод:

-Энэ эмнэлгээс л нэг гарвал юуны ч багш болсон яахав! гэж аяархан хэллээ.

-Би чамайг багш болно гэж мэдээд байгаа юм аа. Ганцхан уйлдгаа л болих хэрэггүй. Гадаадад Ленинградд төгссөн багш хүн хүүхдүүдэд хичээл

заах гэж ангид орж ирэнгүүг Чойдог багш шиг “Здравствуйте!” гэж хэлчхээд, дараа нь уйлаад унавал юу нь сайхан байхав гэж Галсандорж ярив. Батнасан уйлахаа болиод. Галсандоржийн хэлсэн үгийг дотроо эргэцүүлж байгаа бололтой, нэг хэсэгтээ огт чимээгүй болчхов.

Хотоос эмч нар иржээ. Тэгээд нэг орой манай гэрт дөрвөн эмч цуглан, биднийг цөмийг нарийвчлан үзэж, хоорондоо Оросоор баахан ярилцаад, ууж байсан эмнүүдий маань сольж, Одон, Батнасан хоёрт тариа хийлээ. Гэтэл энэ орой Одон хоол юу ч идэж чадсангүй. Түүний бие тун муу байгаа бололтой, эмч сувилагчид ойр ойрхон эргэж, түүний биеийн байдлыг асууж судсы нь барьж үзэж байв. Унтах болтол түүнд гурав дахин тариа хийлээ. Одон өөрөө үг дуугүй хэвтэж, шөнө унтахынхаа өмнөхөн:

- Би гэртээ харих юмсан! гэж муухан хэлээд шургаж хэвтлээ.

Шөнө нэг сэрэхнээ цагаан халаадтай хоёр хүн “Ганцаараа ч гэсэн хамаагүй сургуульдаа үлдэхэд яадаг юм бэ?” гэсэн янзтай уйлахгүй байдаг бяцхан охин Одонг даавуугаар бүтээгээд дамжлан гарч харагдав.

Одон өнгөрсний маргааш нь би арайхийн зүтгэж байж орноосоо босоод, гадаа нөмгөн гарч суулаа. Намрын уйтгартай шаргал өдөр болж байх бололтой, нүүр лүү нар төөнөж, хатсан шарилж үнэртээд, хашааны гадуур явж өнгөрөх хүмүүсийн хөлийн чимээ, зарим яриа байн байн сонсогдоно. Эргэн тойрны байдлыг нэг харах юм уу гэснээ гэрэл орохоор нүдний минь уг руу хатгадаг тул түүнээс айж нүдээ аниастай, чигээрээ жаал чагнаж суув.

Эрүүл байсан цагийн юм бүхэн сайхан байжээ. Хэдхэн хоногийн өмнө л бид өглөө босохоос амиа гартал шахам айдаг байсан. Түүнийг одоо бодоход бүр тоглоом шиг санагдаж, багшийгаа юунд тэгж унь бариулж гүйлгэдэг байв даа гэж би харамсан бодлоо.

Манай байрныхан бүрэн дуунаар зэрэг босно гэж ер нь байхгүй. Жижүүрийн багш өглөө бүрээ татаж, босох дохио өгчхөөд, байруудаар ороход унтаж л хэвтэнэ.

-Хүүе босоорой! Бушуулаарай! Нүүрээ угаагаарай! гэж багш нар хэд дахин явж байж арайхийж биднийг босгож гүйцээнэ. Харин Жанцан багш бол жижүүртэй өдрөө бүрээ нэг татаад, дараа нь гартаа унь барьж, байр байр луу шагайж харна. Тэгээд босоогүй хүүхэд байвал шууд барьж явсан униараа хөнжлий нь өлгөн шидэж, унтаж байгаа хүүхдүүдийг нүцгэлж сандаргадаг аргатай.

Жанцан багшийг униа бариад ирэхэд хүүхдүүд үнэхээр сандарч нүд нь аниастай нойрмог чигээрээ ухасхийн босоод, өмдөө толгойдоо углаж суусан ч хүүхэд бий. Орныхоо хажуу руу ойчиж байсан ч хүүхэд бий. Энэ бүхэн цөм л жаргал байж.

Бие минь эрүүл бол одоо бүрэн дуунаар зэрэг ухасхийж босоод, шалдан ч хамаагүй байрнаасаа гүйн гарч, хашаан доогуур хашхирч цовхчиж гүймээр санагдаж байна. Энэ бол ёстой жаргал байсан сан.

Галсандорж Батнасан бид гурвын хувьд гэвэл биднийг халдварт өвчтэй улс гэж хатуу тусгаарласан учир хол ойрын байдал, хичээл сургуулийн бүх сонин, хань нөхдийн тухай юу ч сонсохгүй, эмнэлэгт байгаа олон өвчтөн ч бидэнд хавьтахгүй, гэр орныхон, ах дүү гэж эргэх ч хүнгүй их л ганцаардмал байдалтай хоног өнгөрөөцгөөж байлаа.

Энэ гэрт ялгаж оруулснаас хойш манай хоёр багш л цагаан халаад өмсөж, нэг орж ирснээс өөр хэн ч биднийг эргэсэнгүй. Хааяа ганц нэг хүүхдээс захиа ирнэ. Тэр нь сонин юм юу ч байхгүй, бие чинь ямар байна, бид хичээлээ хийж байна гэхчилэн бичсэн зурвас төдий. Намайг баярлуулж байсан зүйл бол нүд маань юм харахтай болж, бид нэг үеэ бодвол хоолонд овоо орж, эмнэлгийн өгсөн хоолыг бүгдийг идчихдэг болсон билээ.

Гэтэл нэг орой хоолны дараа Батнасан маань

-Юм идэж чадахгүй боллоо. Би үхэх байх! гээд бас л уйллаа. Галсандорж орон дээрээ өндийж, “юу болж байна аа” гэсэн янзтай Батнасангийн царай руу жаал ажиглаад.

Чи юу гэж уйлаад байсан юм бэ? гэж бүр аашлах маягтай дуугарснаа:

-Хүн чамайг Ленинградд сургуульд явуулж өгнө гэсээр байхад ёнхийтол уйлж байх юм. Алив би толгойгий чинь бариад үзье гэсээр Галсандорж орноосоо босов. Тэгээд Батнасангийн толгойг барьж жаал сууснаа нэг том мэргэжилтэн хүн шиг бас судсы нь барьж үзэв.

Судас бариад юу гэж хэлэх бол гэсэн янзтай Батнасан Галсандоржийн нүүр лүү очгүй болсон жижиг нүдээрээ талимааран ажиглаж хэвтлээ.

-Чи үүний судсыг бариад үзээч! гэж Галсандорж надад хэлэхэд би мөн орноосоо босож, түүний судсыг барьж үзэв. Надад мэдэгдэх юм юу ч байсангүй. Түүний судас цохих нь л цохиж байв.

-Үхнэ гэж ярих болоогүй байна. Харин ч нөгөөдрөөс бие чинь эдгэрэх тийшээ болох янзтай байна гэж Галсандорж хэлснээ.

-Тийм байгаа биз? гэж надаас асуулаа.

Би юу ч мэдээгүй боловч:

-Харин тийм байна гэж хэлэв. Галсандорж:

-Зүгээр, зүгээр, одоо хоолоо ид! гэж Батнасанд хэллээ. Батнасан идэхгүй гэж хэлээд санаа алдахад түүний нулимс шанаа руугаа дахин урсаж эхэллээ.

-Ингээд л уйлаад байх юм. Хаашаа амьтан бэ? Уйлсаар байгаад эцэгтэйгээ ч уулзаж чадахгүй сэтгэлээр үхэх байх аа, энэ ерөөсөө. Муу эцэг нь уржигдар л нутгаасаа наашаа тэмээгээр гарсан гэнэ билээ. Хүүгийнхээ бие муу байгааг дуулсан хүн чинь өдөр шөнөгүй явж байгаа даа. Маргааш юм уу, нөгөөдөр л ирнэ биз. Чи эцгийгээ иртэл ядаж битгий уйлаач! Чамаас гуйя! гэж Галсандорж хэлэв.

-Аавыг наашаа гарсан гэж хэн хэлж байна?

-Би чамд нэг захиа үзүүлэе гэсээр Галсандорж босож, өөрийнхөө ор дэрийг бусниулан уудаллаа.

Батнасан дуугүй нэг хэсэг хэвтсэнээ.

-Нөгөө захидал чинь юу болов? гэж нүд нь аниастай чигээр асуулаа. Жаахан хүлээж бай! би одоохон үзүүлнэ гэсээр Галсандорж ор дээрээ дахин онгичсоноо:

-Аа, энэ байна. Чи сонсож бай! гээд Батнасангийн өмнө сөхрөн суув. Тэгээд уншлаа.

- “Бие чинь ямар байна? Мэд эмнэлгээс гарах уу? Бидэнд онц сонин юмгүй. Батнасангийн аав хүүтэйгээ уулзах гэж өчигдөр наашаа тэмээгээр гарсан гэнэ. Ёслогч Чимид” гэж уншихад

-Алив, тэр захиагий чинь үзье дээ тэж Батнасан гараа сарвайв.
Галсандорж

-Бас хүнд итэхгүй санаатай... гэсээр Батнасанд захидлаа өгөөд, над руу харж өрөөсөн нүдээ ирмэлээ.

Энэ бол жинхэнэ захидал биш. Батнасанг хуурахын тул Галсандоржийн бичсэн хуурмаг захидал боловч түүнийг үзээд Батнасан уйлахаа больчхов. Түүний аав гэж ямар хүн хаана байдгийг би мэдэхгүй. Бодвол малчин л байх. Манай хүү аймгийн дунд сургуульд сурч байгаа гэж сэтгэл нь баяссан цагаан тоорцогтой ч юм уу, толгой нүцгэн ч юм уу, нэг л хүн өдийд нутагтаа санаа амар явж байгаа.

Гэтэл Батнасангийн сэтгэлд бол аав нь өдийд тэмээ уначихсан, богцтой юм тохчихсон “Муу уйлхай хүүгийн минь бие ямар байгаа бол гэж яараад л хээрийн шар замаар алхуулж яваа байх даа” гэж би дотроо бодож байлаа. Түүний улмаас “Аав минь юм уу ээж минь нэг хүрээд ирж чаддаггүй л юм байх даа” гэж надад ч гэсэн бодогдлоо. Үнэндээ яаж ч ирэхэв дээ. Манай нутаг чинь зургаан өртөө газрын цаана байгаа. Бас миний өвчтэй байгааг ч мэдээгүй. “Нэг нь ирмээр байна” гэсэн миний захидлыг аваад “муу хүү минь гэрээ санаж” гэж л бодоо байх.

Батнасан захидал уншаад уйлахаа больж нэг хэсэгтээ нам унтав. Эмч орж ирж бидний биеийн байдлыг лавлаад гарлаа.

Манай гэрт асааж орхисон ганц лааны гэрэл үе үе дальдчин, нэг тодорч, нэг бүдгэрч байлаа. Гадаа чимээгүй болсны хажуугаар манай гэрт бүр ч аймшигтай чимээгүй болж, үргэлж ярьж байдаг Галсандорж ч үг дуугүй, хөнжил дотроо цаашаа харж хэвтчихээд аяархан амьсгалаад байгаа нь надад эвгүй санагдаж, би тэссэнгүй. Галсандоржийг дуудлаа.

-Галсандоржоо!

-Аан

-Чи наашаа харж унтаач!

-Яагаад, чи айгаа юу?

-Надад эвгүй байна.

Галсандорж ороо шажигнуулан эргэж, над руу харж хэвтээд:

-Одоо би Одонг огт эргэж ирэхгүй гэхэд нэг л итгэхгүй юм. Шөнө сэрэхэд орон дотроо л унтаж хэвтэх шиг санагдаад... Одоо тэр хаана байгаа бол? Сүнс нь байраараа ирж биднийг хардаг болов уу?

-Ирдэг бол харанхуйд л ирдэг байх даа гэж би хэлэв.

-Сүнс гэж байдаг юм уу?

-Байхгүй юм бол чи яах гэж ярьсан юм?

-Нээрэн сүнс гэж байдаг болов уу?

Бид хоёр иймэрхүү юм ярьж хэвтэв. Нэг мэдэхнээ лаа дуусах дөхсөн байна.

Батнасангийн бие ямар байгаа бол? Лаа дуусахаас өмнө эмий нь уулгая! гээд Галсандорж бослоо. Би ч бослоо.

-Насаан! гэж дуулаад бид хоёр хучлаганаас нь хэд хэд татаж үзлээ. Их дорджээ. Дуугарах ч сөгөөгүй байгаа бололтой тул Галсандорж хоёр гараараа нүүрээ дарж байгаад уйлав.

Борзооны сураг тасрав

Галсандорж бид хоёрыг уйлаад сууж байтал сувилагчид шприц барьсаар орж ирээд, биднийг тайтгаруулах гэж аргаа барав. Ямар ч үг хэлээд хэрэгцээгүй болсон улс шиг Галсандорж бид хоёр түүний үгийг ч хайхрахгүй, хамаг нулимс тамир хоёроо барагдтал уйлцгаав.

-Эш, дүү нар минь өдий зэрэгтэй тогтсон нь их юм. Энэ их хурц өвчин гэнэт дэлгэрч сүйрэхэд хүрч байхад бараг цөм мэнд үлдсэндээ баярлах хэрэгтэй юм. Хүүхдүүд минь! Амьд үлдсэндээ баярла! Нам засагтаа баярла! Бас нэг сайн Орос эмч өнөө өглөө ирсэн. Батнасанг тусгай барьсан гэрт ганцаарангий нь хэвтүүлж эмчилнэ. Битгий уйлцгаа! гэж нэг сувилагч өөрийнхөө нулимсыг арчин ярьж байв. Бид хоёр уйлсаар л суув.

-Эм хэрэгсэл, байр сууц хүрэлцээгүй бид хэчнээн сандрав. Цаана чинь их дайн болж байгаа шүү дээ, хүүхдүүд минь, юм бүхэн ховор байна. Харин ч төрийн минь сүлд! Аюул багатай өнгөрлөө. Одоо битгий уйлцгаа! Бие чинь муудна. Та хоёр их сайхан эдгэрч байгаа шүү. Битгий уйл! Мөдхөн та хоёрыг сургуулийн чинь хүүхдүүдтэй уулзуулна. Бие сайн болж эдгэрч байна гэж гэр орондоо захиа зангаа бичигцгээ! Алив Дуламжав, халуун цай аваад ир! Хүүхдүүд цай ууг! гэж гэр сувилагч тасралтгүй үглэв.

Сүүлдээ Галсандорж бид хоёр уйлахаа больж, зүгээр л нусаа татаж, шал руу гөлөрч суулаа.

-Төрийн минь сүлд! Хүүхдүүд минь, ийм цагт шөнө уйлдаггүй юм. Одоо орондоо орцгоо! Та хоёр даарч ер болохгүй.

Бие нь муудна. Халуун цай уугаад орондоо орцгоо! За тэг, эгчийнхээ үгэнд ор! Май, цай уухаар дотор нь уужирдаг юм.

Бид хоёр сувилагчийн өгсөн цайнаас жаахан жаахан уугаад санаа алдаж орондоо орцгоов. Миний нойр хүрсэнгүй. “Амьд явах шиг сайхан юм юу байхав. Амьд үлдсэндээ баярлацгаа!” гэж хэлсэн сувилагчийн үгний улмаас “ер нь амьд явах гэгч хаашаа юм бэ? гэсэн урьд нь надад огт бодогдоогүй нэг хачин юм баахан бодогдов.

Сургуульд ирээд байсан, орон байргүй тохигүй байсан, орон гэрээ, эцэг эхээ санаж байсан, одоо ч их санаж байна. Ядам багш, Цэвэгдорж багш хоёрт аашлуулж байсан маань бүгд л сайхан байж. Жаргал гэдэг чинь эрүүл байхыг л хэлдэг байна. Эрүүл хүн дуртай цагтаа ухасхийж, гэрээсээ гүйгээд гарч болно. Хамаагүй чанга хашхирч болно. Тэр ч байтугай ямар ч хэрэггүй баруун, зүүн тийшээ гүйж гүйж, гэнэт өвс ногоон дээр гэдрэг харж, нүдээ аньж хэвтээд, хүйтэн агаараар цээжээ тэлтэл амьсгалж болно. Хичээл дээр тав байтугай арван цаг сууж болно. Их л бодож бие чилнэ биз. Тэр ч байтугай өөхөн дэнгийн бүр бүдэгхэн гэрэлд, үсэг харагдах төдий байхад ч ном уншаад сууж болно.

Эрүүл болоод эмнэлгээс гарахаараа хамгийн урдаар ээж аавдаа захидал бичиж “Би сургуульдаа жаргалтай сайхан сууж байна” гэж бичээд, цааш нь “Эндээс очсон хүүхдүүд сургуулийн талаар элдэв юм яривал битгий үнэмшээрэй! Би сургуулийнхаа хашааны гадуур дотуур хар хурдаараа гүйж чадаж байна. Номоо бариад хичээлдээ явж байна. Дуу дуулж байна” гэж бичнэ.

Энэ бүхнийг бодож хэвтэл бас нэг юм бодогдов.

“Нэг өглөө зориуд босолгүй орондоо хэвтэж байгаад Жанцан багшийн униар хучлагаа хуу татуулах юм уу, эсхүл нэг хүүхдийн орон дээр баахан дээл хөнжил овоолж, яг унтаж байгаа хүн шиг болгоод Жанцан багшид униар хатгуулж элгээ хөштөл инээх юмсан” гэж бодов.

Заримдаа надад хачин хачин юм бодогддог юм.

Хот, хөдөө аль ч газар намар оройхон болоод, хүйтэн салхи цохилзон үлээж байхад хүн, хүн байтугай мал хүртэл сэтгэлийн тав алддаг болов уу гэмээр байдаг. Яг л тийм нэг өдөр, үдээс хойхно Галсандорж бид хоёр, хамаг дулаан хувцсаа өмсөж малгайгаа хүртэл бүчлээд, хоёр жижигхэн чавганц юм уу, хүүхдээ саяхан гаргасан хоёр жаахан хүүхэн шиг хэлбэр байдалтай улс эмнэлгээс гарцгаав. Замд тааралдсан хүн бүхэн ажиглаад байсныг бодоход бид хоёрын царай ер нь өөдтэй байгаагүй бол уу. Гэхдээ бид хоёр дотроо их баяртай явсан юм. Энэ өдөр хүйтэн шуургатай ч гэсэн тэнгэр цэлмэг, нарны өнгө дун цагаан, хаашаа л харвал нүд гялбаж, Балдангийн дэлгүүрт юм гарч байгаа бололтой үүдээр нь морьтой явган зөндөө хүн үймэлдэж байв.

-Энэ муу бор шувуунд өвчин тусна гэж байдаг бол уу? гэж би Галсандоржоос асуув.

-Өвчин туслаа ч гэсэн больницод хэвтэнэ гэж байх юм биш, тэнэж яваад нэг л хонхорт үхдэг биз.

-Би ерөөсөө үхсэн шувуу үзээгүй шүү. Алагдсан шувуу л үзсэн.

-Би шувуу их алдаг байсан. Одоо өрөвддөг болчихож.

-Би ч гэсэн шувуу алдаг л байсан.

-Чи одоо гэртээ захиа бичих үү? гэж Галсандорж асуув.

-Бичилгүй яахав. Өвдөж эмнэлэгт хэвтээд гарсан гэж бичнэ. Аав ээж хоёрын нэг хүйтэн болохоор намайг эргэж ирнэ гэсэн. Бодвол одоо удахгүй л ирэх байх.

-Би ч захиа бичихгүй. Манайхаас хүн ирж ч чадахгүй.

-Бид хоёр ч одоо хичээлээсээ бүр хоцорч гүйцлээ. Бусдыгаа яаж гүйцнэ?

Галсандорж хариу хэлсэнгүй, чимээгүй явснаа

-Энэ сургуульд суралцаад бид хоёрт ер нь хэрэг байна уу? гэж асуув.

-Сургуульд суралцахгүй юу хийх юм бэ?

-Мал маллахгүй юу.

-Урьдаар сургуулиа төгсөөд л, дараа нь болно биз.

-Сургууль төгсөх хэрэг юу байна?

-Хэрэгтэй болоод л биднийг сургах гэж ингэж чармайгаад байгаа биз гэж би хэллээ.

-Тэр чармайгаад байгаа чинь хэн юм бэ?

-Нам засаг л байхгүй юу?

-Тэр нам засаг чинь хаана байгаа юм?

-Улаанбаатарт

-Би ерөөсөө тийм юм байгаа гэж...

-Байдаг болоод л бид хоёрыг эмнэлэгт байхад эмч нар ирүүлээ биз?

- Чи бид хоёрыг өвдсөн гэж Улаанбаатар мэдэж байсан хэрэг үү? Улаанбаатар байтугай, аав, ээж маань мэдээгүй байхад! гэж Галсандорж намайг дооглох маягтай хэлэв.

-Чи бид хоёрыг гэж мэдээгүй ч гэсэн хүүхдүүд өвдөөд байгаа гэдгийг мэдээд л эмч нар явуулаа биз дээ.

-Улаанбаатар гэж ер нь хаашаа газар байгаа бол? Очиж нэг үзэх юмсан. Чи машин дээр сууж үзсэн үү?

-Үзээгүй.

-Би ч чамайг бодвол их хүн юмаа. Би машин дээр гурав дахин сууж үзсэн. Хойшоо хараад ч сууж байсан. Урагшаа хараад ч сууж байсан.

Бид хоёр иймэрхүү юм ярилцсаар байрандаа ирлээ. Байрныхан маань намайг очиход гэр дотор амьд тарвага ороод ирсэнтэй ялгаагүй сонирхон элдвийг асууж зарим нь “Алив наашаа хараач!” гэж миний эрүүнээс татаад:

-Царайгий чинь нэг хараадахъя! гэж байв.

Би сургуулийнхаа тухай өч төчнөөн сонин дууллаа. Урьд нь эрүүл байхад сургууль дотор огт сонин явдал байхгүй шиг санагддаг байсан мөртөө эмнэлэгт нэг сар болох хойгуур зөндөө сонин явдал болжээ. Сургуулийн маань өндөр захирал солигдож, сахалтай хүн захирал болсон гэнэ. Манай нутагт одоо хүртэл хүйтрээгүй халуун намраараа, зарим айл гүүгээ тавиагүй байгаа гэдгийг Банзрагчийн ах нутгаас ирж яриад, хэсэг хүүхдийн гэрээс захидал, заримынх нь гэрээс идээ, цагаа авчирсан гэнэ.

Хүүхдүүдийг халуун усанд оруулдаг болж, халуун усанд орох далимаар бие биеэ усаар шүршин сахилгагүйтэж байж Жамсран Сэмбэн хоёр Шагдар багшид шалдан бөгсөн дээрээ алгадуулсан гэнэ.

Энэ мэт элдвийг бодож байснаа би:

-Нөгөө том Борзоон юу болсон бэ? гэж асуулаа.

-Том Борзоон ялд орсон гэнэ билээ. Довдонг баривчлаад л бид гэнэт хулгай алга болчих юм шиг санаад байсан чинь ер нь жижиг Борзоон олон байх шиг байна аа. Хүүхдүүд энд тэндгүй л жаал зугаа идэх юмаа борзоондуулчихлаа гэж ярьж байх юм. Борзоонддог хүн ч олон байх шиг байна гэж Сэмбэн ярив.

-Манаа хийж Борзоон барьдгаа болсон уу?

-Манаа хийгээд байхаар том дорвитой Борзоон ч алга болж л дээ. Харин жижиг хулгана шиг Борзоон л олон байна. Тийм юмны чинь манаа хийгээд яаж барихав. Бидний дотор л байна. Одоо манаа хийхээ ч байсан.

-Мартсанаас, анх манаа хийхэд чи тэр боорцог, хортой харандааг хаанаас олж биднийг шагнасан бэ? гэж би Сэмбэнгээс асуулаа.

-Түүний чинь Цоодол багш өгсөн юм. Та нарыг манаанд гаргах бүх ажлыг Цоодол багш надад зааж өгдөг байсан. Тэр ч байтугай өөрсдийгөө “Борзооныг баривчлах отряд” гэж нэрлэхийг ч би Цоодол багшаас асууж зөвшөөрүүлсэн юм шүү дээ, хонгор минь.

“Цэргийн нууц” гэдэг чинь тийм нарийн байдаг юм гэж Сэмбэн надад гайхуулан ярьснаа,

Одоо дорвитойхон Борзоон байхгүй болчихоод, манаанд гаръя гэсэн ч Цоодол багш дэмжихээ больсон гэж харамссан янзтай ярив.

Энэ ярианаас үзэхэд, анх эхэлж миний худал ярианаас үүссэн Борзоон (Миний худал ярианаас үүссэн гэж би эргэлзээгүй мэдэж байна) сураг тасарч, миний сэтгэл амрах цаг арайхийж иржээ.

Чи хулгайчид бололцоо олгох гэж санаатайгаар цуурхал тараасан. Чи тэр хулгайчаа одоо олж өг! гэж Цэвэгдорж багш хэзээ л байцааж шалах бол гэдгээс би ямагт айж явсан. Тэр айдас одоо ч дуусаагүй байж мэдэх юм. Тиймээс Борзоон гэдэг үг чихэнд дуулдмагц миний уур хүрч явдаг байсан. Одоо ч уур хүрч байна.

Энэ үг чихэнд бүр мөсөн дуулдахгүй болох цагийг би тэсэж ядан хүлээвч бас л болоогүй байжээ.

Борзоон гэж ярихын оронд “Борзоондох” гэдэг үг гарсан байна. Энэ үг хэзээ алга болохыг би мэдэхгүй. Алга болох нь болох л байх. Амьд байсан хүүхэд үхэж, үхлүүт байсан би эдгэрч, ногоон өнгөтэй байсан газар шарлаж, юм бүхэн өөр болоод байхад тэр “Борзоон”, “Борзоондох” гэдэг үгнүүд алга болох л байлгүй.

Би эмнэлэгт байхдаа, эмнэлгээс л нэг гарсан дороо хөлөө эцтэл ч хамаагүй гүймээр санагддаг байсан боловч гүйж харайх байтугай хичээлээ хийх ч тэнхэлгүй гарав. Намайг эмнэлгээс гарахад арван дөрвөн хоног хичээлдээ оролгүй байрандаа байж, сайн хоол идэж, биеэ тэнхрүүлэх хэрэгтэй гэсэн тул би хичээлдээ орж чадалгүй хэд хоног байрандаа хэвтэв.

Сургуулиас бид мэтийн хэдэн хүүхдэд тусгай хоол өгч, манай хүүхдүүдийн ярьдгаар хэд хоног жаргуулав. “Та нар ч ёстой жаргаж байна аа. Бинтэй хар шөл идээд л, сүүтэй цай уугаад л” гэж хүүхдүүд ярьдаг байсан боловч миний хувьд энэ бол жаргал биш зовлон гээч болж шалавхан хичээлдээ орох сон гэхээс хоног өнгөрөхгүй байв.

Ингэж хэд хоног уйдан байхдаа би гэртээ захидал бичлээ.

“Би эмнэлэгт хэвтэж хэд хоног эмчлүүлээд гарлаа. Одоо бие минь засарч сайн болж байна. Та нар намайг эргэж мөд ирэх үү? Би гэрээ их санаж байна” гэж захидалдаа бичлээ.

Гэвч захидал хүргэх хүн олдохгүй тул гэртээ бичсэн захидлыг өдөр бүр уншиж, бараг өдөр бүр засдаг байлаа.

Надад хамгийн уйтгартай санагддаг үе бол хүүхдүүд хичээлд ордог өдрийн цаг байв. Бүх хүүхэд хичээлдээ орж, хөл үймээн тасрахад эмнэлгээс гарсан хэдхэн хүүхэд байранд үлдээд, аргаа ядахад хэдүүлээ нэг байранд цугларч, эмнэлэгт байсан түүхээ, хэн яаж өвдөж байснаа, нутаг орныхоо сониныг ярьцгаана.

Манай байрныхнаас би ганцаараа хичээлд ордоггүй байлаа. Тийм болохоор зарим үед хэвтэртээ ороод, өдөржин унтана. Бас юм бодно. Аймгийн сургуулийн сурагч болно гэдэг надад анх их амархан санагддаг байсан юм. Хөдөө байхдаа миний бодож байснаар бол аймагт очоод, нэг их шилэн байшинд ном дэвтэр барьж ороход урдаас багш нар угтаж аваад л хичээл заана. Тэгээд л аймгийн сургуулийн сурагч болно. Ердөө сурагч болно гэдэг шиг амархан юм байхгүй. Ингэж л санагддаг байсан. Гэтэл аймгийн дунд сургуулийн сурагч болно гэдэг, мөн аймгийн дунд сургуулийн сурагч байна гэдэг миний санасан шиг амархан юм биш байжээ.

Үнэнийг хэлэхэд би одоо хүртэл аймгийн дунд сургуулийн сурагч болж чадаагүй л байна. Хоёр гурван өдөр бодож байгаад би гэртээ бичсэн захидлыг өөрчилж бичлээ.

“Би хэд хоног өвдөж аймгийн эмнэлэгт хэвтээд, одоо бие зүгээр болж, хичээлдээ орох гэж байна. Та нар намайг эргэж ирэх гэж байгаа бол яарсны хэрэггүй. Өвөл болохоор л ирнэ биз.

Одоохондоо надад дутагдаж гачигдсан юм алга. Үеийн нөхдийнхөө хамт би сайн сууж байна” гэж бичлээ. Гэвч явуулах хүн олдохгүй, тэр захидал миний дэрэн дор хэвтсээр байв.

Би өөрийгөө ажиглахад миний бие түргэн засарч, амархан тэнхэрч байлаа. Одоо ингээд хичээлд орно гэхэд ер болохгүй юм байхгүй шиг санагдана. Иймээс хичээлдээ орохоор бэлдэж хүүхдүүдийн хуулж өгсөн хичээлийг уншиж, тоо боддог болов. Эмнэлэгт хэвтээд гарснаа хойш миний ухаан бүр сэргэлэн болчихсон юм шиг санагдаад, намайг амарч сувилуул гэж эмнэлгийн тогтоож өгсөн хоногийг заавал гүйцээх гэлгүй хичээлдээ заавал орьё. Багш нар урдаас хөөсөн ч намайг эмч нар хичээлдээ ор! гэсэн гэж худлаа хэлэхээр шийдлээ.

Хүүхдүүд удахгүй Октябрийн баяр болно гэж хоног тоолон хүлээж байсан боловч миний хувьд хичээлдээ л орвол Октябрийн баяраас илүү том баяр болох байв. Иймээс би хичээлийнхээ хуваарийг харж, дэвтэр ном, үзэг шөрнээл, өмсөх хувцас, улаан бүчээ хүртэл бэлэн болгож, тавиад нэг үдэш хамгийн түрүүн орондоо орж хэвтлээ.

Энэ шөнө бол анх аймгийн сургуульд маргааш өглөө мордоно гэж бодоод, гэртээ унтаж байсан хөдөөгийн тэр нэг баяртай шөнө шиг л сайхан, амгалан шөнө байв.

Төгсгөл бүлэг

Ёроолынх нь чулуу алаглаж харагдсан гүехэн устай, ус нь жирэлзсэн тув тунгалаг тийм гол дотор хавтгай цагаан чулуун дээр суугаад хөлөө угааж байна гэж би зүүдэллээ.

Миний толгой дээгүүр хөх цөцгий нисээд, чихэнд голын урсгал шуугин сонсогдож байтал бүрээ дуугарав. Энэ дуу нойрон дунд ихээ хол юм шиг сонсогдож байснаа хөнжил дотроос толгойгоо гаргаад чагнахад бүр ойрхон, зүүн гэрийн цаахны дуугарч байв. Бүрээ нэг бүдгэвтэр дуугараад чимээ нь түр намдаж, дахин урт нарийхнаар чанга уянгалан дуугарлаа. Тэгэхэд нь би орноосоо өндийж байрныхаа хүүхдүүдийг харсанд сэргэж байгаа хүн байхгүй юм уу, байсан ч тоохгүй байгаа бололтой цөм хөдөлгөөнгүй хэвтэцгээж байв.

Би яаруухан босож хувцсаа өмсөөд, гадаа гарч, бүрээ татаж байгаа жижүүрийн багш руу ойртон харлаа. Энэ өдөр Дорж багш жижүүртэй байна. Энэ багш биднийг сумаас минь анх дагуулж авчирсан юм. Ирэх замдаа тэр “Дуу гаргаад!” гэж байн байн команд өгч, түүний команд өгөх бүрт бид өөр дуу мэддэггүй юм шиг “Баатар эгнээг” дуулж явснаас гадна “Яндаж болдоггүй далай шиг” гэж бидэнд замдаа шинэ дуу зааж явсан билээ. Түүний улмаас би Дорж багшийн хоолой, түүний заасан дуу хоёрын сайхныг мэдэж “Яндаж болдоггүй далай шиг, Яасан баян нутаг вэ!” гээд дуулж явахдаа энэ хүн шиг гоё сайхан хүн ертөнцөд байж болмооргүй юм шиг санагдаж явсан юм. Гэтэл сайхан дуулдгаар барахгүй, бүрээг бас сайхан үлээдэг хүн байх юм. Энэ бүрээний дуу Баянбулагийн минь сургууль, Тампуулин багшийн минь бүрээн дуу, Бүрдийн хөндийн зэрэглээ, аль сайхан санагддаг хамаг юмы минь сэтгэлд ургатал бодогдуулав.

Би Дорж багшийн бүр дэргэд нь очоод ам руу нь ажиглан зогслоо. Тампуулин багшийг бүрээ сайхан үлээж байхад би холоос дуугий нь сонсож байснаас биш, дэргэд нь очиж ажиглаж байгаагүй. “Аль ч сургуульд бүрээ сайхан үлээдэг нэг хүн заавал байх ёстой юм байлгүй. Хүн хэчнээн том болоод, хол ойр хаана ч явсан сурагч байхдаа хаана, ямар багшийн бүрээн дуу сонсож явснаа үүрд дурсаж яваг гэж багш нарт бүрээ сайхан үлээх сургууль зориуд хийлгэдэг ч байж болох юм” гэж надад бодогдов.

Дорж багш цагаан саарал даавуун тэрлэг дээр ногоон дурдан бүс бүсэлж, саравчтай хар малгай хэлтгийвтэр тавиад, баруун гараараа бүрээгээ дээш нь өргөн үлээж байх нь яагаад ч юм “Хоршооноос саяхан авсан юм шиг” цоо шинэ хүн харагдаад байв.

Бүрээгээ үлээж дуусаад бурзангий нь арчсанаа “Бүрээ татаж чадах уу?” гэж надаас асуусанд би бүрээ үлээх байтугай гартаа ч барьж үзээгүй гэж үнэнээ хэлээд, харин сумынхаа артелийн дунг хааяа үлээж байснаа ярилаа. “Бүрээ татахыг зааж өгье” гэж хэлэх магадгүй гэж би бодсон боловч тэр юу ч хэлсэнгүй.

Намайг нүүр гараа угааж, бас сургуулийн шинэ барилгын суурь тавих гэж ухаж байгаа нүх, тэнд буулгасан тоосго, хураалтгай чулуу, дүнзэн моднуудыг үзээд ирсэн хойно хүүхдүүд босоцгоолоо.

Намайг хичээлд орохоор багш нар урдаас хөөх магадгүй гэж айж байсан нь дэмий зүйл байжээ. Энэ өглөөний анхны хичээлд Жанцан багш журнаалаа барьсаар орж ирээд “Сайн байцгаана уу?” гэж мэндлэхэд би багшаас айсандаа “сайн” гэж чангахан ч хэлж чадалгүй хүний араар нуугдасхийж байв. Гэтэл тэр, намайг олж үзчихээд:

-За бие чинь их сайн болоо юу! Тоо бод! Тос ид! гэдэг үг мэднэ биз? гэж хошуугаа цорвойлгон инээв.

Жанцан багшаас хойш орсон багш нар ч намайг зэмлэсэнгүй.

Хичээлийн орох, завсарлах хонх түргэн түргэн дуугарч, нэг хичээл хийгээд бараг дуусаагүй байхад завсарлагаа болж, завсарлагаа бараг дуусаагүй байхад дараагийн багш орж ирээд байх шиг, бас самбар дээр багш нарын юм бичиж байгаа нь хүүхдүүдийн тоо бодож байгаа нь цөм хачин хурдан болчихсон юм шиг харагдаад байв.

Хичээлийн байранд галласан болохоор дулаан, цонхоор тусаж байгаа нарны гэрэл, тэнгэрийн өнгийг харахад зунаараа ч байгаа юм шиг. Гэсэн мөртөө завсарлаад гарахад хүйтэн салхитай уулын оройг харахад мөд цас орох нь уу ч гэмээр юм шиг. Мөн хүүхдүүдийн нүүр царайг ажиглахад хичээл анх цуглах үеийнхийг бодвол нэлдээ цайрч, гоё болчихсон санагдаад, энэ өдрийн юм бүхэн сэтгэлд минь хачин сонин байв.

Хичээлийн байрны цагаан ханан дээр сурагчдын дүрэм, пионерийн тангаргийг алтан үсгээр хичээнгүйлж бичээд, улаан хүрээтэй жаазанд хийж хадсан байна. Бас ангийн самбарыг хар хөх будгаар будаж, их сайхан болгосон боловч тэр будган дээр шохой цэрдээр заримдаа бичиж болохгүй юм уу, бичиж боловч их бүдэг харагдаж хуучнаасаа дордсон байлаа. Самбарын дээд талд Лениний зургийг хадаж дор нь “Сур, сур бас дахин сур” гэж хооронд нь том, том таслал тавин бичжээ.

Би хичээлийнхээ дэвтэр бүрийн хавтсан дээр “Баянхонгор аймгийн дунд сургуулийн 5-ын А ангийн сурагч П. Хашбат” гэж бичиж байснаа, хэл бичгийнхээ дэвтрийн хавтсан дээр андуураад, “5-ын А анхны сурагч Хашбат” гээд биччихсэн байлаа. “Анхны” гэдэг үгийг ангийн болгож засах юм уу гэснээ болилоо.

Энэ өдрийн сүүлчийн хичээлийн дараа биднийг ангид үлдээв. Чойдог багш шар товчнуудаа гялалзуулан инээмсэглэсээр орж ирээд:

-Здравствуйте! гэж мэндэлснээ намайг харж:

-Здравствуй, Хашбат аа! Ну как... гэснээр миний дэргэд ирж тонгойгоод, инээмсэглэсэн нүдээрээ миний нүүр лүү тун анхааралтай харлаа. Би өөдөөс нь их сайхан инээмсэглэх гэсэн боловч чадсангүй, тааруухан нэг инээмсэглэж,

-Хорошо гэж хэлэв.

Бие эрүүлжиж хичээлдээ ороод их сайхан байна гэдгийг төлөөлүүлж хэлсэн энэ ганц “хорошо”-г Чойдог багш ч гүйцэд ойлгож.

-Сайн байна. Сайн байна. Одоо биеэ сайн гамнаж байж, хичээлээ гүйцэж авах хэрэгтэй. Та нар ч гэсэн Хашбатад сайн туслаарай гэж бүснийхээ арлаас барин алхалсаар багшийн ширээнээ очиж суулаа.

Чойдог багшийг орж ирэхэд хүн бүхэн дуртай юмаа асууж шалгаадаг. Чойдог багш ч асуусан бүхнийг түвэгшээлгүй хариулдаг зантай болохоор ингэж ярьж байгаа маань бидний жирийн л нэг хичээл байлаа.

Чойдог багшийн хичээл дээр хамгийн дуугүй хүүхэд хүртэл дуу ордог болохоор амьд байсан бол Одон ч өдийд бас нэг юм асуух л байсан гэдгийг баттай мэдэж байна.

-Багш аа цагаан хувцас угааж өгөх үү?

-Мөд угааж өгнөө. Одоохондоо саван олдохгүй байна. Дайн болж, юм бүхэн ховордсон цаг гэдгийг та нар хааяа бодож л байгаарай! гэж Чойдог багш тайван хэлэв.

-Хувцас угааж өгөхгүй болохоор хэцүү байна гэж нэг нь хэллээ.

-Хэцүү байлгүй яахав. Үүнээс хэцүү юм ч бас бий. Жинхэнэ дайн болж байгаа газар өнөөдөр юу болж байгаа гэж та нар санана? Түүнийг бодох юм бол бид ч жаргалаараа л байна.

Бидний дотор жинхэнэ хэцүү юм үзсэн хүн байхгүй шүү гэж Чойдог багшийг ярихад надад гомдолтой санагдав. Тэгээд би тэсэж чадсангүй.

-Жинхэнэ хэцүү юмыг би үзсэн, багш аа! гээд хэлчихлээ.

Чойдог багш над руу хараад “Юу гэж хэлье дээ” гэсэн янзтай инээмсэглэснээ босоод ирлээ. Би хэлсэн үгнээсээ огт айхгүй байв. Тийм болохоор Чойдог багш

-Чи хэцүү юм юу үзэв. Хашбат аа? гэж асуухад нь

-Би өвдсөн. Бас үхэх шахсан гэж хэллээ.

-Одоо бие чинь бүр зүгээр болоо юу?

-Зүгээр болсон.

-Чи өнөөдөр бие чинь эрүүл болчихсон хичээлээ хийгээд сууж байна. Тэгэхэд фронт дээр дайн дуусаагүй л байна. Өнөөдөр ч хүн үхэж л байгаа, өнчирч л байгаа. Хүн үхэхийн хажуугаар бас байшин нурж, хүн амьдаараа тамлуулж, гал түймэр дүрэлзэж ямар ч гэмгүй нялх хүүхэд хүртэл гал руу шидүүлж байгаа цаг. Дайн гэдгийг нүдээр үзээгүй хүн ойлгох арга байхгүй. Ер

нь л хүнд учрах гай зовлонгийн хамгийн дээд нь дайн гэж л бодоцгоо! Биднийг тэр дайны хязгааргүй аюулаас зөвлөлтийн улаан арми амь биеэрээ тулалдан хамгаалж байна.

Ингэж хэлээд Чойдог багш над руу харж:

-Тийм үү, үгүй юу? гэж мөн инээмсэглэн асуув. Би дайн гэдгийг үзээгүй болохоор юу ч хариулж чадсангүй. Гэхдээ дайн гэдэг үнэхээр хэцүү байх гэсэн бодол надад байв.

Чойдог багш дайны хэцүүг надад юм уу, ер нь манай ангийнханд баттай ойлгуулахаар шийдсэн бололтой, суудлаа орхиж бидэн рүү бүр тулж ирээд:

-Одоо бид хоол унд, хувцас хунар, цай даалимба, юм бүхнээр дутагдаж гачигдаад байгаа маань тэр л холын дайны дөнгөж үнэр нь үнэртэж байгаа хэрэг. Хүүхдүүд өлсөж, өвдөж байна. Энэ чинь бас л тэр дайн байлдааны холын үнэр гарч байгаа нь тэр. Та нар муу л юм бол “Борзоон” гэж ярих дуртай улс. “Жинхэнэ том Борзоон чинь” тэр дайн л байгаа юм. За тэгээд хажуугаар энэ сургууль маань шинэ тутам, бэлтгэл бага байлаа. Энэ бүхэн нийлээд сургууль маань цугларсан дороо баахан тав алдах шиг боллоо гэж ярьснаа

-Усны эргүүлэг гэж юу байдгийг та нар мэдэх үү? гэж гэнэт асуув.

Бид онох онохгүй хариулт хэлж, хоорондоо цэц булаалдах шахаж шуугилдав. Би бол “цүнхээл” гэж мэдэхээс биш “эргүүлэг” гэж мэдэхгүй учир:

-Манай нугагт л тийм юм байхгүй гэж хэллээ.

-Жижиг гол усанд байдаггүй юм гэж хэлээд, Чойдог багш цааш нь ярилаа

-Зүгээр тунгалагхан урсаж байсан голын ус зарим газар урсаж чадахгүй тогтчихоод шавар, элстэй элдэв бохир хутгалдаж эргэлддэг газрыг усны эргүүлэг гэдэг юм. Манай сургууль энэ намар нэг хэсэгтээ тэр бохир эргүүлгэд орчихсон юм шиг өлсгөлөн, хулгай, зэлгий, өвчин зовлонтой хутгалдаж бужигналаа. Одооноос аюулт эргүүлэгээс гарах гэж байна. Энэ бүхнээс манай нам засаг аварч байна. Асран халамжилж байна.

Дайн дуусаж, сургууль эмнэлэг, юм бүхэн тохижиж, тэр булингартай эргүүлэгээс бүрмөсөн гарах цаг мөдхөн ирнэ. Тэр цагт та нар жаргана. Том голд эргүүлэг заавал байдаг юм.

Харин гэр эргүүлэгний яг голд нь орж жинхэнэ дайны аюулд нэрвэгдэж үзээгүйгээ аз боллоо гэж бодож, ертөнцийн их аюулаас биднийг аварч байгаа зөвлөлт улсад л бид үүрд баярлаж явах ёстой юм гэв.

Энэ ярианаас би төдий л базаалтай юм ойлгож аваагүй ч гэсэн хичээлийн дараа байрандаа ирээд бодож байхад, гэрээ санах маань ч гайгүй болчихсон шиг, бас өөрийгөө нэг их хэцүү юм үзсэн гэж бодоод баймааргүй ч юм шиг санагдав.

Ингээд гэр лүүгээ явуулж амжаагүй байсан захиаг дахин засаж бичлээ. Түүндээ “Миний бие муудаж эмнэлэгт хэвтээд, гарсан. Одоо бие сайн. Үеийнхээ олон нөхөдтэй хичээлээ хийж, сургуульдаа сайн явж байна. Миний төлөө сэтгэл зовох хэрэггүй. Би анх ирснийгээ бодвол одоо ёстой сурагч болжээ. Харин захиа явуулж байгаарай. Би аавынхаа захиснаар их эрдэмтэй болоод хойтон зун очно” гэлээ.

Захиагаа бичиж дуусаад, анх намайг энэ аймгийн сургуульд явахад аав минь үнэхээр “Миний хүү их эрдэм сураад ирээрэй!” гэж захиж байсныг саналаа. Бас гэрээсээ анх гарч байсныг саналаа.

Аймгийн дунд сургуульд явна гэдгийг бодохоос сэтгэл яараад, энэ зуны амралтыг би бараг өдөр өнжилгүй хоног тоолж өнгөрөөсөн билээ. Шөнө орондоо ороод, хуруугаа дарж тоолно.

Өглөө нар хараад “За одоо ч төд хоног үлдлээ” гэж тооцоо бодно. Хоног тоолохын хажуугаар “Намайг явахад ээж минь уйлна даа” гэсэн нэг бодол надаас салдаггүй байлаа. Энэ бол яг үнэн бодол.

Манай ээжийн амархан уйлна гэдэг жигтэйхэн. Өдөр зүгээр юм оёод сууж байснаа, гаднаас нэг хүн ороод ирвэл л:

-Муу хүү минь алс хол аймгийн сургуульд... гээд л үгээ дуусгаж чадахгүй л уйлж гарна. Уйлахаараа нулимсаа арчина гэдгийг мэдэхгүй, зүгээр л хацар луугаа урсгачих нь тэр. Түүнээс нь би бас их ичнэ. Гайхахдаа:

-Би ч сургуульд явмааргүй л байна. Даанч сумын захиргаа заавал явуулна л даа гэж хэлдэг байв.

Энэ бол ээжийг тайтгаруулах гэсэн арга. Түүнээс биш би дотроо “Сургуульд явна даа. Явахдаа л нэг явна. Заавал явна” гэж боддог байсан юм. Ээжийг бодвол аав минь харин эр хүн болохоор ер уйлалгүй, гадуур дотуур ажлаа хийгээд хэнэггүй явдаг байв. Тэгдэгт нь би их баярладаг байв.

Яг сургуульд явах өглөө би эрт бослоо. Өглөө босоод, гэрээсээ гарч ирэхэд Үертийн гол дагасан хэдэн хотын гадуур үхэр, адуу үймэлдээд, хонь бэлчээртээ гарчихсан. Сэрвэнгийн ард тарвага хашхижиж байгаа дуулдав.

Үхрийн зэлний хажуугаар гарч явтал хар бяруу маань цаашаа хараад хэвтэж байна. Энэ бол жижиг биетэй, духны нь үс их ургаж бараг нүдээ таглачихсан, хажуугаас нь харсан хүнд бол нүд нь юу ч үздэггүй байх гэж бодогдмоор бяруу. Хүнээр бол их л хөмсөгтэй юм даа гэж би санадаг юм. Харахад ийм жижиг, муу царайтай мөртөө догшин гэдэг нь жигтэйхэн. Бас их чадалтай. Би унах санаатай хэд хэд бугуйлдаад тогтоож чадаагүй юм.

Нэг өдөр Бэгзжав ахаар бариулж байж мордоод, бас тэсэж чадаагүй үнсэн дотор ойчсон билээ. Гэсэн мөртөө би түүнийг унаж номхруулах сан гэж их хорхойтно. Яагаад ч юм нэг болмоор л санагдаад байдаг. Гэсэн мөртөө болдоггүй юм. Энэ өглөө их сэжиггүй хэвтээд байхаар нь мярааж ухасхийн мордлоо. Гэтэл намайг тас гэдрэг нь харуулж тархиар минь унагачхаад, сэтгэл нь амарсан янзтай нуруугаа хотойлгож нэг сунячхаад явчхав. Ингээд би хар бярууг дахин оролдсонгүй.

Намайг явах гэж байгаа гэж манай айлынхан энэ өглөө надад бэлэг барьсаар орж ирэв. Бэлгийн ихэнх нь идэх юм. Ээж маань анхандаа их ховдоглон, хүний өгсөн юм бүхнийг миний богц руу хийж байснаа сүүлд нь богц багтахдаа болив. Тэгэхээр нь би:

-Энэ их юмаар яах юм бэ? Аймгийн сургууль чинь тогоо шанагатай газар байлгүй гэж хэлсэн юм.

Намайг яг мориндоо мордох гээд гарахад гадаа үүдэнд манай хотынхон цуглараад, намайг үнсэх гэж шавав. Миний дориун үерхдэг, Цэрэнхүү гэдэг надтай үе насны нэг охиноос бусад нь намайг бараг үнсэв. Хацар нүд, дух шанаа, хаа хамаагүй, аль л хошуундаа ойртсон газарт үнсэж байв.

Ээж маань миний дөрөөн дээр сүү дусааж өгөөд, намайг мордуулахад олны үймээнд сэтгэл нь хөдөлсөн юм дагуу, аав бид хоёрыг манай хар нохой дагаад, “Сумын төв оръё байз” гэсэн янзтай түрүүнд орж шогшлоо.

-Нохойгоо дуудаач ээ! гэж аав хашхирлаа.

Эргээд харахад ээж минь өрөөсөн гартаа хувинтай сүү, нөгөө гартаа цацал бариад, миний хойноос сүү өргөхийн хажуугаар “Аслаан, Аслаан!” гэж нохойгоо дуудаж байлаа.

Би голын захын сайр луу орж яваад:

-Аав аа! гэж дуудав.

-Юу гэв миний хүү гэсээр аав морио давиран, надтай зэрэгцэж ирлээ.

Би аавд хар бяруугаа захих гэсэн юм. Гэвч энэ өндөр, том биетэй настай хүнийг бяруу сургаад байж байгаарай гэлтэй нь биш тул:

-Хойтон намайг ирэхэд манай хар бяруу их л том болчих байх даа! гэж хэлэв.

-Тэгэлгүй яахав гэснээс өөр үг аав хэлсэнгүй.

Ингээд бид хоёр ширүүхэн хатиргасаар Улаан үзүүр тойрч сумын төв харагдмагц бууж, мориныхоо олмыг чангалцгаасан юм.

Тэгэхэд аав минь.

-За, миний хүү хүний газар очоод, олон аавын хүүхэдтэй эвтэй, хичээл номдоо шамдлагатай байгаарай! Багш нарынхаа үгэнд сайн орж байгаарай. Аав нь чадвал өвөл нэг эргэж очно. Цас зуд болбол амжихгүй ч байж магадгүй. Тэгвэл миний хүү их эрдэм ном сураад хойтон хүрээд ирээрэй гэж захисан юм.

Гэрээсээ ингээд гарч байснаас хойш зөндөө удчих шиг санагдсан боловч өнөөдөр тоолоод үзэхэд бүтэн гурван сар ч болоогүй байна. Гэвч би одоо өөрийгөө Баянхонгорын дунд сургуулийн сурагч гэж баттай хэлж чадахаар боллоо. Мөртөө ч үгүй би энэ сургуулийн анхны сурагч гэж өөрийгөө хэлнэ. Аливаа юманд анхдагч болно, анхдагч байж чадна гэдэг бас ч хэн бүхэнд олддог аз биш ээ.

1971-4-23 Улаанбаатар

Асуулт даалгавар:

1. Зохиолчын намтар, уран бүтээлийг судлан тэмдэглээрэй.
2. “Дамын үг дамжигтай” сэдэвт эсээ бичнэ үү? /250 хүртэл үгтэй/
3. Зохиолд зохиомжийн задлал хийнэ үү?
4. Борзоон гэж хэн бэ? түүнд өөрийнхөөрөө хариулна уу?
5. Д.Гармаагийн “Зудын жил” зохиолтой харьцуулан ярилцаарай.

Манай сургуулийнхан

Ч. Лодойдамба

Манай оронд олонтой тохиолддог зуны улирлын эгэл өдрүүдийн нэг 1950 оны 6 дугаар сарын 10-ны бямба гараг.

Тэнгэрийн гүнд энд тэнд харагдах бут, бут цагаан үүлс дэлгэсэн цэнхэр магнигийн дээр тархагдан хаягдсан хөвөн шиг харагдаж хөдлөн нүүсээр сэвсийн сарнин замхарч ор сураггүй алга болоход зөөлөн хилэнгийн өнгөтэй тунгалаг тэнгэр улам ч гоо сайхан болон харагдаж байлаа.

Энэ жирийн нэгэн сайхан өдөр, надад жирийн бус явдал тохиолдов.

Өнөөдөр Дулмаа бид хоёрын амьдралд үлэмжийн эрхэм баяр болох гэж байна.

Бид хоёр эртний танил бөгөөд бас сүүлийн таван жилийн турш сууна гэж ярилцсан юм. Гэвч би Зөвлөлт улсад сурч байгаад энэ жил ирж, их сургуульд багшилж байна. Дулмаа маань их сургуулийг хоёр жилийн өмнө төгсөж, хөдөө ажиллаад, одоо хотод ажиллаж байгаа юм.

Ингээд л одоо хуримаа хийх болж, хоёрхон өдрийн өмнө иргэний гэр бүлийн хэрэг эрхлэх товчоонд очиж бүртгүүлсэн. Тэгэхэд тэнд ажилладаг миний үерхдэг нөхөр Идэр албан ёсны асуултаа дуусаад: - Чамайг эхнэр авахгүй нь гэж зовж явсан юм сан. Ашгүй ингэх л ёстой гээд инээсэн.

Энэ ч хэлдэг л үг. Би одоо 33 настай, ингэхээр зарим хүн, ялангуяа үерхэж тоглодог хүн ингэж хэлэх нь зөв л биз. За тэр ч яахав! Нэгэнт би өнөөдөр хуримаа хийх болсон болохоор бага хэрэг.

Гэтэл хурим хийж, миний эхнэр болох хүн маань 9 цагт ирнэ гээд одоо өдрийн нэг цаг болтол ирдэггүй байна шүү.

Дулмааг ирээгүй байтал зочид ирвэл яах билээ?

Хурим хийнэ гэж шуугиан гаргачхаад зочид ирэхэд ганцаараа зогсож байвал ёозгүй юм болно гэж бодоход ичмээр ч юм шиг, аймаар ч юм шиг санагдаж байлаа.

Ер нь нэг бүдрэхэд долоо бүдэрнэ гэдэг шиг болж байна. Дүү минь эхнэртэйгээ ирж зочид урьчхаад, гэргий болох хүнээ эрж сураглаж явна гэдэг ичгэвтэр хэрэг тул болив.

Тэгээд л хийх юмаа олж ядан, эхлээд ширээн дээрх архи зуушийг элдвээр янзлан өрж үзлээ.

Дараа нь тасалгаан дотуураа ийш тийш хөрөөдөн явлаа. Гэвч сэтгэлийн догдлол бага болсонгүй, харин улам их болж байв. Арга барагдахдаа цонхоо түшиж гудамж тийш харж баахан зогсов. Гудамжаар машинтай, морьтой, явган хүн тасралтгүй зөрөлдөн, гудамжны нөгөө талын өндөр цагаан барилга нарны гэрэлд улам ч цайран, цонхонд нь туссан нарны гэрэлд цацран дүрэлзэж байгаа гал шиг зүг бүхэндээ алтан шар туяаг гаргаж байлаа.

Гурав дахь давхрын нэгэн давцан дээр хүүхдээ тэвэрсэн эмэгтэй зогсоод орчин тойрноо ажиглан ширтэж байна. Хүүхдээ үнсээд түүнд ямар нэгэн юм тайлбарлан зааж байгаа бололтой.

Би тэр хоёрыг, цонхны минь тушаа ургасан өтгөн навчит улиасны дэлгэсэн навчны завсраар харж байна. Зөөлөн салхинд улиасны навч үл мэдэг хөдөлж байхад, цаад талд нь харагдах эх хүү хоёр өтгөн навны дундаас ургаж гарсан цэцэг мэт надад харагдаж байв.

Би инээж, баярлаж, хайрлаж байгаа эх хүү хоёрыг харж байхад тэр хоёрын энх тайван жаргал нь надад сэтгэгдэж байна.

Удахгүй Дулмаа ингэж хүүхэдтэйгээ хамт инээн зогсоно. Удахгүй Дулмаа минь эх гэдэг ертөнцийг чимэглэсэн бөгөөд амьдрал ба бүтээл, сайн сайхны шингэл болсон эрхэм нэртэй болно шүү дээ. Эх бол хүн төрөлхтний хаан, амьдралын гоо сайхны бүрдэл юм.

Үүд дуугарав. Дулмаа маань ирлээ гэж би бодоод нөгөө сэтгэлийн догдлол маань муухай зүүд сэрэхэд сарнин үгүй болохын адил, сураггүй алга болов. Би түргэн хөдөлж ширээн доогуур орж нуугдав.

Гэтэл Дулмаа биш, дүү минь эхнэртэйгээ орж ирлээ. Тэд хүүхдийн тоглоом, савтай юм барьжээ. Тэгээд өглөөний нарнаар нүхнээсээ цухалзан гарч байгаа тарвага шиг ширээн доороосоо шоволзон гарч байгаа намайг сонирхсонгүй, харин засаж бэлтгэсэн ширээний зүг гайхан харснаа,

- Ах аа! Хуримаа өнөөдөр хийх хэвээрээ гэж үү? гэж хачин юм асуугаад, гайхан инээмсэглэж, над руу харахад нь уур минь хүрч

- Хэлсэн цагтаа ирж болсонгүй юу? гэж их л айлган хэгжүүн асууж, хүйтнээр инээмсэглэв. Тэр хоёр бие биенээ ширтэж гайхан харснаа эхнэр нь,

- Дулмаа гуай хөдөө явчихсан юм биш үү гэж миний асуултыг асуултаар хариулав.

Хожимдож ирснээ баллах гэж оролдож байна уу гээд ажиглан харвал, тийм шинж огт үгүй бөгөөд, харин гайхан гэмшсэн шинж тодорхой тул эгдүү минь гайхалтай солигдож

Юу гэнээ. Хэн тэгж байна? гэж бачимдан асуув.

- Дулмаа гуайтай хамт ажилладаг Төгс гуай л Өмнөговь аймагт хүнд өвчтэй хүнд мэс засал хийхээр явсан гэж хэлсэн шүү дээ. Тэгээд л бид хоёр та хоёрыг чинь хуримаа өнөөдөр хийхээ больсон юм байх гэж бодоод, хоршоогоор очиж хүүдээ тоглоом, бас талх тариа аваад явж байгаа юм гэж дүү минь хэлээд зассан ширээ, намайг, бас эхнэрээ ээлжилж гайхан харж байлаа.

Тэр хоёрын байдалд намайг мэхлэх гэсэн бодлын өчүүхэн мөр ч үгүй, хариу учраа алдсан ээдрээг тайлах гэж цөхрөнгөө бараад учрыг нь олж ядан мухардсан хүний гайхсан шинж илэрхий байлаа. Би юу хэлэх, яахаа мэдэхгүй, хожигдсон шатрын ноён шиг гонсойж гайхаш тасрав.

Ийм үед гонсойж гайхахгүй, эргэлзэхгүй хүн яахан байх билээ. Таван цагт зочид ирж, зургаан цагт хурим эхлэх болоод байхад хуримын гол хүний нэг нь Өмнөговь аймаг явчихсан байна гэдэг чинь юу гэсэн үг вэ? Ер нь эрхэм уншигч та өөрөө бодоод үз л дээ. Хэзээ, хаана, хэн хуримаа хийе гэж яг таг ярилцаад хамаг юмаа бэлтгэж зочдоо урьчаад, хол газар хэл мэдээгүй явчиж байсан юм бэ?

Танилцсаныхаа дараа өдөр юм уу, сайн бол долоо хоногийн дараа толгой холбон, чухам зүү л шивэх зайгүй наалдан гэр бүлийн товчоонд очоод, бид хоёр үүрдийн хань болохоор чин сэтгэлээсээ эргэлтгүй шийдэж, суух болов гэж бүртгүүлээд, сүүлд нь хэдэн сар, сайн л бол хэдэн жил болоод, бид хоёр яавч тохирохгүй нь салахаас өөр аргагүй боллоо гэж нүүр нь улсхийх ч үгүй нүд нь цавчих ч үгүй хэлж очдог зарим хүмүүс байдаг билээ.

Тийм хүмүүсийн хувьд хурим хийнэ гээд хийхээ болих нь ялимгүй хэрэг биз.

Гэвч Дулмаа бол өөрийн болон хүний амьдралаар тоглох тийм адгийн санаа сэтгэлтэй шаар биш, тиймэрхүү хүн дүрстэй боловч хүний агуулгагүй амьтан биш гэж би итгэсэн учраас ч Дулмаатай амьдралаа холбож, амьдралд минь ганцхан удаа тохиолдох эрхэм баяр, хуримаа түүнтэй хийх болсон.

Хэдийгээр тийм боловч ингээд ирэхгүй байхад нь би догдлохгүй байж хэрхэн болох билээ. Үнэндээ би гэж итгэж, боддог учраас ч догдолж байгаа юм.

Хананд өлгөсөн цагийг харвал гурван цаг болох гэж байна. Энэ муу цаг эвдрээд түрүүлж байна. Саяхан нэг цаг болж байсан шүү дээ гэж бодоод цагаа харвал яг л адил байлаа. Би санаа алдаад, нөгөө хоёрыгоо харлаа. Тэр хоёр хөдөлсөн ч үгүй зогссоор л байлаа.

Дулмаа яагаад надад хэлсэнгүй вэ? Магтагдсан хүүхэн хуриман дээрээ гэгчээр юу болж байна даа. Надад эртхэн хэлсэн бол би урьсан зочиддоо хэл хүргэж амжихгүй юу. Яасан сонин хэрэг вэ? гэж эргэлзэн бодож байтал утас жингэнэн дуугарав. Би түргэн очиж харилцуураа авбал, бас л Дулмаа биш, харин доргисон бүдүүн хоолойтой эрэгтэй хүн,

-Та өршөөгөөрэй. Би утасны чинь дугаарыг бичиж авсан боловч хаяхчаад бас гэрийг чинь мэдэхгүй сандарлаа шүү. Тэгээд танд Дулмаагийн түргэн хэлээрэй гэсэн юмыг хэлж чадсангүй, өршөөгөөрэй. Дулмаа Өмнөговь аймагт мэс засал хийхээр урд шөнө гэнэт явсан. За тэгээд та ямар мэдэхгүй биш, үхлээс хүний амийг булааж авахад секунд ч хожигдож болдоггүй шүү дээ. Эмч нарын ажил бол дийлэх дийлдэх нь секундээр хэмжигдсэн аварга тулалдаан гэж таны бичсэнийг би голыг нь олсон гэж бодсон шүү. Ингэхээр Дулмаа их яаруу явсан. Тэгээд намайг тантай заавал яриарай гэж утасны чинь...Юу! За, за... гээд дуу нь тасарснаа...

Та хүлээж байгаарай... За би очлоо... өршөөгөөрэй, энд чухал ажил гарлаа гэж хэлээд юм асуухын завдал өгөлгүй харилцуураа дан хийтэл тавих нь надад тодорхой сонсогдов.

Тэр хүний дуу тасарснаас хойш би “Байна уу, байна уу?” гэж байдаг тэнхээгээрээ хэд дахин хашхирсан авч хариу сонсогдсонгүй.

Надад асуух юм их байв. Гэвч нэгийг нь ч асууж чадсангүй тул харилцуураа барин хэсэг гайхан мэлэрч зогссоноо арга барагдан буцааж тавив.

Бүх биед минь хөлс дааварлан, цамцны зах хоолойг минь шахан боож байв. Захныхаа товчийг тайлж магнайдаа чийхарсан хүйтэн хөлсийг арчив.

Тасалгааны дотор цагийн жигд цохилт, бидний амьсгалахаас өөр чимээгүй нам гүм байв. Гэвч энэ бол сэтгэлийг донсолгох их салхины өмнөх гаднаа чимээгүй тайван авч дотроо бужигнан оволзож байгаа догшин байдал байлаа.

Миний үгийг гэсвэрлэн хүлээж ядсан дүү минь,

- Ах аа тэгээд яахав? гэж асуув.

Юу? Үгүй та хоёр чинь юу гэж хөшөө шиг зогсоод байгаа юм бэ? гэж яахаа мэдэхгүй боловч уцаарлан хэлэв. Энэ бол үнэндээ миний бухимдлын дэлбэрэлт байсан биз.

- Ирэх нь үү? За юмаа бэлтгэе! гэж дүүгийн минь эхнэр баярлан хэлээд бараг л алгаа таших шахав.

Дүү минь үг дуугүй барьж, байсан тоглоомоо ширээн дээр хам хум тавив.

“Та хоёр юу гэж хөшөө шиг зогсоод байгаа юм бэ?” гэж уцаарлан хэлсэн бухимдлын минь үгийг “Хурим хийнэ. Дулмаа ирнэ. Та хоёр юмаа хийхгүй юунд зогсоод байгаа юм бэ?” гэж ойлгоод тоглоом үзсэн хүүхэд шиг баярлаж байгаа тэр хоёрын байдлыг хараад би өөрийн эрхгүй өрөвдөв.

- Жаахан хүлээ дээ, энэ хүн дахиад ярих байх гээд би утсаар сонссон бүх зүйлээ ярих.

Дүүгийн минь эхнэр шаазан дүүрэн хүйтэн цай хийж надад өгөхөд би дор нь залгилаад, хоосон аягаа буцааж өгөөд зөөлөн сандал дээр хөгшин тэмээ хэвтэж байгаа юм шиг яг хийтэл суув. Ингээд бид гурав өмнө өмнөөсөө харалцан хэн хэн маань юу бодож байгааг таа гэсэн юм шиг, юм ч ярилгүй хэсэг суув. Заримдаа аль нэгэн маань ширээн дээр ямар ч хөдөлгөөнгүй байгаа утас руу хялалзан харж байв.

Ашгүй утас минь тачигнан дуугарч бид гурвын багтарсан тайван байдлыг эвдэв. Гурвуулаа зэрэг ухасхийн босов. Тэгээд би утсаа авлаа.

-Байна уу? Та намайг их хүлээв үү? Надад битгий аягүйцээрэй. Би заавал ирнэ гэж Дулмаа хэлээрэй гэсэн... гэхэд нь, би асуух юмаа бушуухан асууж авья гэж бодоод яриагий нь таслан,

-Өмнөговь яваад уу даа гэж асуув

-Тийм ээ, Таньд гэр бүлийн амьдралд шилжих гэж байгаад чинь баяр хүргэе.

Бат бэх гэр бүл гэдэг бол улс нийгмийн онц чухал асуудал болохоор таны баярыг бид бүхэн хуваалцах хэрэгтэй гэж бодож байна. За тэр ч яахав. Бүх юмаа бэлтгээд зочдоо хүлээн авч байгаарай гэж Дулмаа хэлсэн шүү... гэхэд нь би бас л тасалж,

-Өнөөдөр ирж амжих юм уу? гэж хашхиран асуухад, тэр хүн инээх шиг болоод,

-Амжихгүй яахав, ямар үхэр тэргээр явсан биш дээ гээд хоолойгоо зассанаа үргэлжлүүлэн

-Дулмаа заавал өнөөдөр ирнэ шүү гэв.

Чухам л ингэж хэлээсэй гэж би горьдож байсан тул энэ үгэнд чин сэтгэлээсээ итгэн баярлаад,

-Таныг урья, манайд ирээрэй гэсэнд,

-Баярлалаа, Дулмаа ч намайг урьсан, би Дулмааг ирэхэд угтаж аваад хамт очъё. Харин чухал мэдээ саатуулсанд өршөөгөөрэй гэхэд нь, шүүгээд бараг л олдож баригдахгүй мах гурилтай жугдайгаас хүүхдүүд нэг нэг аяга хийж аваад, дараа нь харахад хувингийн ёроол нь гялалзаж байдаг шиг.

-Зүгээр, зүгээр гээд би инээмсэглэв.

-Дулмаа хэл сураггүй хайчив гэж та сандрав уу? Би, таны утасны чинь дугаарыг хаяхчаад л сандарлаа шүү... гээд дуу нь бас л тасарснаа бас л ажил гарлаа, за баяртай гэж тэр хүн хэлээд харилцуураа тавив.

Би харилцуураа атгасан хэвээр нөгөө хоёрыгоо харвал тэд маань амаа ангайн нүдээрээ инээмсэглэж, над руу харж байлаа.

-За бушуухан шиг юмаа бэлтгэе гээд би харилцуураа буцааж тавих зуур, өглөөнөөс хойш агаар орж гарахгүй юм шиг боогдоод байсан уушгиндаа ханатал агаар татаж авлаа.

-Тэгээд Дулмаа гуай ирэх нээ гэж дүү минь баярлан асуухад,

-Тэгэлгүй чахав. Ямар үхэр тэргээр явсан юм биш гэж би инээмсэглэн хошигнож хэлбэл

-Түргэн тусламжийн эмч үхэр тэргээр явж байхыг та үзсэн юм уу? гэж дүү минь намайг мохоож асуугаад инээмсэглэхэд эхнэр нь бүр ч тачигнатал инээв.

Гэвч би инээсэнгүй, миний сэтгэлд үүнээс олон жилийн өмнө болсон нэг явдал санагдаж, яг л тэр үеийнх шиг бүлээхэн жижигхэн, зөөлөн цагаан гар магнай дээр минь илэх шиг болоход сэтгэл минь хөдөлж тэр хоёр луу удаан ажиглаж байгаад,

-Үхэр тэргээр явж байсан түргэн тусламжийн эмч байсан юм шүү гэж бараг шивнэн хэлэв.

* * *

Дутмаг хоолтой, нимгэн хувцастайгаар хатуу өвлийг давах гэдэг тийм амархан хэрэг биш. Гэвч бид арай чарай давж, хаврын урьхан улиралтай золгов.

Соёолон гарч байгаа шинэхэн ногооны анхилам үнэр хаврын бүлээн зөөлөн салхи, ногоорон эхэлж байгаа ой, айлчлан ирсэн нүүдэлчин шувуу, цөм хатуу өвөл ард үлдэж дэлгэр зун өмнө ойртсоныг мэдэгдэж байлаа.

Гэтэл манай сургуульд өвчин гарч, маш их гай тохиолдов. Энэ бол 1927 оны хавар билээ. Тэр үед манай нам, засаг түмэн бэрхшээл, мянган тулалдаануудыг давж анхны сургуулиудыг байгуулж байв.

Тэгэхэд манай оронд одоотой адил олон зуун сургууль ч байгаагүй, ард түмний дотроос бойжиж гарсан эрдэмтэй багш нар ч олноор төрж амжаагүй байсан билээ.

Манай сургууль бол арав гаруй сумын дунд байгуулагдсан гуч орчим сурагчидтай, тав зургаан бор гэртэй, хоёр анги, хоёр багштай бага сургууль байлаа. Бид дөрвөн аргын тоо, Монгол бичиг, мэгзэмээс өөр зүйл заалгадаггүй байж билээ.

“Зүрх уулын танхим” гэж олонд нэрлэгдсэн манай сургууль бол “Арын хүрээ” гэдэг том хийдийн ойролцоо байсан тул бид үргэлжлэн хүрээний лам нартай холилдож байдгаар барахгүй, тэдний гэрээр очиж түлээ хөрөөдөх, хагалах, хашааны хог арилгах, ус авч өгөх зэрэг хар бор ажил хийж, дугуйн хэлтэрхий, боорцог ааруул, тос зэрэг юм олж иддэг байлаа.

Гэвч хүрээ рүү нэг хоёроороо явж болдоггүй байв.

Учир нь хүрээ ба манай сургууль хоёрын хооронд олон жилийн турш дараалан хуралдаад томхон хөтөл шиг болсон мундаг хог хөндөлдөн байдаг тул, тэр хог дээр үймж байдаг өлөн золбин ноход барьж идчих гээд болдоггүй мөн хүрээний омогтой банди нар хавсайдан зодох гээд болдоггүй байлаа.

Тэд, бид нараас тоогоор олон бас зодолдож дадсан байдаг авч, танхимын хүүхэд гэдэг нэрээс баахан айж сүрддэг байснаар барахгүй, танхимын хүүхдүүдийг их зодвол, олны олон нэгэндээ гэгчээр мухар

толгойтны буутай цэрэг нь ирж бариад хар гэрт хийчихнэ гэж хүртэл тэд ярьдаг болсныг бид сонссон.

Бодвол энэ яриаг хийдийн лам нар банди нарыг сургуулийн хүүхэдтэй холилдуулахгүйн тул зохиосон биз ээ.

Нэгэн удаа бид, нэгэн омогтой бандийг барьж аваад, шоронд хийнэ гээд чирсэнд, тэр сандран айж, бид нараас өршөөл гуйснаар барахгүй, дахин бидэнд халдахгүй гэдэг ам шүдээ өгсөн билээ.

Гэвч бид нарыг ганц нэгээрээ явахад зодож шоглох гэж өдөх нь зогсоогүй. Нэгэн өдөр би хүрээ орж хоол эргүүлэхээр явах гээд хань эрсэн чинь олдсонгүй. Тэр өдөр өглөөнөөс эхлэн хүчтэй цасан шуурга зогсолтгүй тавьж байсан тул хүүхдүүд явсангүй.

Миний хувьд бол юу ч гэсэн цасан шуурга байтугай мөсөн шуурга шуурч байсан ч эрхгүй явж, боовны хэлтэрхий олж идэх хэрэгтэй байв.

Би өглөө тунхуутай цай булаалдаж, байгаад асгачихсан тул захирал багш, миний нэг өдрийн хоолыг хасаж шийтгэв.

Ядахдаа тэр өдрийн хоол урьд урьдаас улам ч муу байлаа. Шүүгээд яасан билээ. Найз нар минь, өөрсдөдөө оногдсон өчүүхэн хоолноос бага сагыг нууж далдлан өгсөн боловч уулаас дутмаг хоолтой өлөн гэдэс ханаж цадсангүй, харин идэх хүсэл улам нэмэгдэв.

Миний найз нар надад нууж далдлан өчүүхэн боловч хоол өгч байгаа явдал бол тэдний хувьд баатарлаг үйл байсан юм. Хэрэв надад хоол өгснийг захирал багш мэдвэл бүдүүн хуруугаараа магнай дээр нь булуу болтол няслахаас гадна, дөрвөн хуруу хүж шатаж дуустал зогсох, бас нэг өдрийн хоолыг хасах байсан билээ.

За тэгээд би аргагүй л хийд рүү явах хэрэгтэй. Би банди нар, хогийн ноход, цасан шуургаас айж халшравч өлсгөлөн гэдэс минь огт айхгүй харин түргэн явахыг шаардаж байв.

Ингээд би эрэгтэй хүүхдийн гэрээс хамт явах хүүхэд олдсонгүй тул эмэгтэй хүүхдийн гэрт орж хамт явах хүүхэд сураглавал, Бурантаг гэдэг бяцхан хүүхэд хамт явъя гэлээ.

Бурантаг бол бидний дотор хамгийн бие бялдар багатай нь юм. Тэр өөрөө арван настай гэдэг авч нутгийн хүүхдүүд түүнийг долоон настай гэж баталдаг байлаа.

Гэвч Бурантаг түүнийг зөвшөөрдөггүйгээр барахгүй чи долоон настай гэвэл маш их доромжлол мэт үздэг юмсан.

Бурантаг бол уранхай улаан шалдан дээлтэй, хоншоор нь гэдэргээ эргэж шантайсан эсгий гуталтай, олон хоногийн хур хиртэй нүүрнээс нь ялгарч харагддаг саарьтсан бор хацартай, бас нус нь үргэлж уруулы нь давж урсан байдаг юм. Ийм учраас Бурантаг гэж хоч авсан билээ.

Бурантаг бэтэгтэй тул ажилд муу, бас жаахан учир чадал тамираар дорой байсан. Би түүнийг хань гэж үзсэнгүйгээр барахгүй хамт явахыг тагталзав. Гэтэл Бурантаг өдрийнхөө хоолыг хүүхдэд булаалгасан учир шалтгаан тоочин авч явахыг гуйв. Ер нь зүгээр унтахаар мануухай босго гэж үг байдаг тул ганцаар явснаас муу ч гэсэн хүний бараа хань гэж бодоод хамт явах болов.

Бурантаг хүүхдүүдээс дээл, гутал, малгай гуйж заримд нь боов боорцог авчирж өгөхөөр хөлслөн авч өмсөв. Нэлээд том дээл олоод, хүлхийлгэн шууж, өмссөн нь холоос харахад овоо том хүүхэд шиг харагдаж байв. Тэгээд бид хоёр эмэгтэйчүүдийн гэрийн унинаас нэгийг авч бариад, хүрээний зүг цасан шуургыг хөндлөн огтолож хүчлэн явлаа.

Тэнгэрийг нимгэн цагаан үүл жигд бүрхээд, бүх юм бүдэг цайвар гэрэлд мэлтийн шуурга дүлийрч исгэрэн цасан манан бужигнаж, өөдөс нь эгцлэн харахын аргагүй байв.

Бужигнан урсаж байгаа цасан шуургыг дагаж харахад, их мөрний хүчит урсгал салхинд улам ч омогтой давлан байгаа юм шиг байв. Явахад үнэхээр хэцүү байв. Шуурганаас буй болсон хунгарт гэнэт цүл хийтэл ороод түүнээс гарах гэж хамаг хүчээ шавхаж байв.

Энд тэндээ цоорхой, илчгүй хуучин нэхий дээл нэвт хөрснөөс гадна бас тал бүхнээрээ сийгэж, бид хоёр сугандаа униа хавчуулан элгээ тас тэврэн, шогшиж байв. Царай нь цайрч, хошуу нь улайн, нус нь унжсан Бурантаг, миний нөмөрт хорогдон, борооны хонь шиг шуухинан шогшиж байв.

- Бид хоёрыг түлээ хөрөөд гэвэл, энэ хүйтэнд яадаг билээ. Ямар ажил олж хийх вэ? гэж эрүү нь дагжин чичирч гүйх зуур Бурантагийн хэлэхэд,

- Чи түлээ хөрөөдөх дургүй бол боов идэх дургүй юм шив дээ гэж би хариулав.

- Би боовонд ч их дуртай л даа. Бидэнд их боов өгөх болов уу? Би олсон боовоо цөмийг нь идэхгүй, хасасыг нь хадгалж маргааш иднэ гэж Бурантаг бүр боов олоод буцаж яваа юм шиг ярьснаа,

- Хоёулаа олсон боовоо яг адилхан хуваана шүү гэхэд нь

- Чи сайн л ажил хийгээрэй гэж би хэлээд цааш бид хоёр юм ярьсангүй явсаар хогийн дэргэд ирэхэд арваад нохой шуугьж ирлээ.

Бид хоёр тал бүхнээ униар хамгаалан, заримыг нь цохиж гасалган нэлээд хөдөлгөөнтэй явсаар дулаацан хогийг өнгөрөөв.

- Арай гэж нэг даваа давлаа гэж би хэлэхэд

- Одоо банди нарыг яаж давна даа гэж Бурантаг маань санаа алдан хэлэв.

Явсаар хүрээний гудамжинд орж ирвэл шуурга ч нам болж бид хоёр аль хашаанд хэнийд орж ажил хийвэл боов их олдох бол гэж ярьж байтал, гудамжны нөгөө үзүүрээс дөрвөн банди гарч ирээд биднийг хармагц “еэ, еэ өвөө өвөө гүйгээд ирэхийн гүзээ байна уу? Дайраад ирэхийн давсаг байна уу?” гэж шуугилдан хашхирсаар гүйлдэн ирлээ.

Бид хоёр буцаж зугтаах гэж эргэвэл бас зургаа долоон банди өөдөөс гүйлдэн гарч ирлээ.

Уйдсан ч үгүй бид хоёрыг арваад банди хүрээлж аваад хамар хацар луу чичиж, хажуу талаас түлхэж эхлэв. Сэгсгэр үстэй лоовууз хөндлөн тавьсан банди ханцуйгаараа хамраа шудран арчсанаа мөрөө түрэн ханхалзаж ирээд Бурантагийн малгайг авч шидэв. Бурантаг малгайгаа авахыг ч оролдсонгүй надад наалдан хярсан туулай шиг бүлтгэнэж байв.

- Энэ муу нусгай хүүхэн юунд энд ирж хийж бузарлаж байгаа юм бэ?

Нүцгэлээд цасан дээр суулгаж тэмээн тавхайн мөр гаргая гэж тас тас инээн хэлэхэд банди нар зөвшөөрөн давшилж ирлээ.

Бурантаг уйлан, улам над руу шигдэн налж байв. Нэг биерхүү банди давшлан ирээд Бурантагийн мөрөн дээрээс шүүрэн авч гуд татав. Бурантаг цасан дээр харуулдан унав.

Түүнийг банди нар тойрон хүрээлээд авлаа. Бурантаг босоод зүг бүхнээ хялалзан олон нохойд бүслүүлсэн муур шиг биеэ хурааж байв.

Би униараа цохилон оръё гэж бодов. Гэтэл банди нарын тоо даанч олон, бас тэгээд Бурантаг шиг жаахан хүүхдийг энэ хүйтэнд арай ч цасан дээр суулгахгүй байх гэж горьдоод хүлээж байв.

Энэ бол Бурантагаас гарамгүй их зориг шүү.

Бурантагийн нүд гялалзан үсчиж, сэгсгэр үстэй лоовуузтай бандийн шилэн дундуур нь цохисонд тэр урагшаа шургачин цас үмхэж унав.

Бурантагийн энэ байдалд би ч бас зоригжин униа эргүүлэн тохиолдсоныг цохиж эхлэв. Гэтэл банди нар тархан зугтав. Бид хоёр заримыг нь хөөж сүрдүүлэв. Банди нар тал бүр рүүгээ сарнин зугтсаны дараа Бурантаг маань униа цасан дээр хаяад учир тоймгүй уйлав. Би түүнийг аргадаж баймаажин арайхийж уйлахыг нь зогсоогоод нэгэн ламынд очиж гурван цаг гаруй түлээ хөрөөдөөд жижигхэн дугуй хоёр хоёрыг олоод буцсан билээ.

Бурантаг ярьж байснаараа олсон дугуйнаасаа хадгалж ч чадсангүй. Харин дээлийг нь авч өмссөн хүүхдэд хэлэлцээ ёсоор өгөх гэж өчүүхэн хэлтэрхий үлдээснээ буцах замдаа байн байн гаргаж үзэвч шүлсээ лав гэгч залгиад буцааж өвөртлөн явлаа.

Энэ явдалд Бурантаг маань хацраа хөлдөөж, би чихээ хөлдөөчихсөн билээ.

Иймэрхүү амьдралтайгаар бид өвлийг өнгөрөөж хавартай уулзсан билээ.

Хавар! Богинохон мөртлөө ямар сайхан үг бэ? Ялангуяа хүнд өвлийг арайхийж давсан бидэнд улам ч сайхан байлаа.

Хавар! Энэ бол амьдрал, энэ бол амьдралын гоо сайхан билээ. Өдөр бүр гийгүүлдэг нар, улирч эргэн гийгүүлдэг хавар амьдралд хэчнээн хүчин бэ?

Хавар болж, нар дулаан илчээр жигнэж, өмнөх хөндий цэнхэртэн униартаж, зэргэлээ жирэлзэн өвөөлж дуугаран, Зүрх хайрханы орой нь хүртэл алаг тарлан болоод ирэхэд бид нар бөөгнөрөн сууцгааж, гэр орон аав, ээж ах, дүү нарынхаа тухай буюу үлгэр домог ярилцдаг байв.

Манай сургуулийн захирал бол зангирсан хөмсөгтэй, хурц нүдтэй үргэлж шүдээ зууж явдаг, Ням гүн гэдэг ханхар цээжтэй, өргөн бүстэй, явахдаа бага зэрэг бөхийн хоёр тийшээ найгаж явдаг хүн байлаа. Түүнийг сурагчид инээж байхыг нь огт үзээгүй бөгөөд аягүйхэн хөдөлбөл хүрэн суман шугамаар алган дээр шугамдах буюу бүдүүн хүрэн хуруугаар магнай дээр нясалдаг тул ууртай багш гэдэг байлаа.

Бид Ням багшаас ухаангүй айдаг байсан. Ням багшийг урьд гүн зэрэгтэй явсан гэж ярилцдаг тул түүнийг Ням гүн гэж нэрлэдэг байсан юм сан.

Ням захирал бол манай ангид хичээл заадаг бөгөөд үргэлж л тийм ч ажилтай ийм ч ажилтай гэж бид нарыг хичээлээс чөлөөлж байдаг байв. Ням багш хичээл заахдаа үржүүлэхийн хүрд, цагаан толгойн холбосон үсэглэлийг ая дантай үргэлж уншуулдаг ба өөрөө бүдүүн хоолойгоор А, На, Ха... Агуу, Нагуу, Багуу, Хагуу, Ануу, Нануу, Бануу, Хануу гэх юм уу эсвэл нэгэн нэгийн нэг, нэгэн хоёрын хоёр, нэгэн гурвын гурав, гэж аялуулан эхэлж өгөөд бид

нарыг залгаж авахаар “За та нар ингээд үргэлжлүүлэн уншиж байгаарай” гээд гарч явдаг байлаа.

Манай ангийнхан “юу хэцүү вэ?” гэхэд “Ням багшийн хоёр хүрэн хэцүү”, “юу сайхан бэ” гэхэд “Ням багшийн ажилтай болох сайхан “ гэдэг байв.

Нөгөө ангид хичээл заадаг багш маань бол өнгөрсөн жил оюутны сургууль төгсөж ирсэн Далхаанямбуу багш ирээд жил болоогүй боловч, бидэнд үргэлж сайхан юм ярьж өгөх, бас бид нараар үлгэр домог яриулах зэргээр бидэнтэй ойр дотно байдаг тул түүнд бид их хайртай байж билээ.

Хэдийгээр Далхаанямбуу багш тоглодог, хэдийгээр бид нарыг загнадаггүй, зогсоож хоол хасаж шийтгэдэггүй боловч бид түүний өмнө гэмтэн болохыг хүсдэггүй байж билээ.

Далхаанямбуу багш манай сургуульд анх ирсний дараах өглөө болсон явдал санаанаас минь гардаггүй юм.

Тэр өглөө Чулуун, Эрдэнэ бид гурав гал тогооны гэрээс нэлээд том мах олж аваад, байрандаа ирж гал түлээд их л эвтэй шарж эхлэв. Тэгээд хувааж идэх болсон чинь тохирсонгүй, эв минь муна болон хувирч, хэсэг мах булаалцалдан зодолдов.

Мах бидний гарыг дамжин, бид дээр дороо оролцон гурвалжин зодоон болж байтал гаднаас ногоон даавуу дээл дээр мөрөвчтэй суран бүс бүсэлсэн нэг хүүхэд орж ирлээ.

Энэ үед би улигт махыг арай хийж буаан аваад амандаа чихсэн чинь, Эрдэнэ завьжийг минь шахаж, амаар минь бултайн гарсан махыг Чулуун утган авлаа.

Гэтэл орж ирсэн хүүхэд Чулууны гараас махыг булаав.

Бид тэр үл таних хүний гарт байгаа мах руу ширтэн, шинэ ирсэн сурагч, бидэнд хувааж өгөх болов уу гэж горьдохын хамт бидний тэр олсон махыг амандаа л хийвэл юунаас ч буцахгүй дайран орж, байдаг чадлаараа тэмцэлдэхэд бэлхэн байсан билээ.

- Та нар чинь нохой биш хүн. Хүн эвээр морь хурдаар гэдэг юм шүү гэж тэр хүн хэлээд эргэж, галтай зуухны амыг нээгээд махыг минь түүн рүү ажиг ч үгүй хийчив.

Гал дүрэлзэж байгаа зууханд махны шатаж байгаа нь шаржганан сонсогдож, шарагдан шатаж байгаа махны үнэр хамар луу цоргиж байв.

Тэгээд тэр хүнийг гарахад бид дуугарсан ч үгүй хөдөлсөн ч үгүй хоцорч билээ.

Бид хэсэг дуугүй зогсож байгаад, бие биеэ харалцан гэмшилтэйгээр инээмсэглэсэн билээ. Тэгээд хүн мөртөө нохой шиг өчүүхэн махнаас болж хэрэлдэн “амь наана там цаана” гэгчээр зодолдсоноо бодоход үнэхээр ичгэвтэр санагдаж гэмшсэн билээ.

Тэр хүнийг гарахад араас нь харвал шинэ сурагч гэж болмоор тийм бага биетэй хүн байж билээ.

Ер нь бидний эх, эцэг ч гэсэн бид нарыг эргэж ирээд Далхаанямбуу багштай сүрхий дотно болдгоор барахгүй өвөл Эрдэнийн эцэг ирээд сургууль дээр хэд хоносны дараа Ням багштай, гүн зүнд нь хүрч зад хэрэлдэж байгаад хүүгээ Ням багшийн ангиас гаргаж, Далхаанямбуу багшийн ангид оруулаад,

- За хүү минь, эзэн хичээвэл заяа хичээнэ гэдэг юм шүү. Далхаанямбуу багш чинь юм сургаж чадмаар хүн байна. Хичээж үзээрэй. Хэдэн үеэрээ ч харанхуй тэнэг явах юм билээ дээ гэж Эрдэнэд хэлээд явсан билээ.

Ингээд өвчин гарсан тул, даруй арга хэмжээ авах хэрэгтэй болсон бололтой. Бас ямар арга хэмжээ авах тухайд хоёр багш минь зөрөлдсөн бололтой.

Гэрийн хажуугаар нааш цааш өнгөрөхөд, чанга чанга дуугаран хэрэлдэж байхыг нь олон хүүхэд сонсжээ.

Ер нь манай хоёр багш хоорондоо эв муутай бөгөөд үргэлж хэрэлдэхээр барахгүй зодолддог удаа олонтой байлаа. Далхаанямбуу багш анх ирээд сургуулийг хийдийн дэргэдээс нүүлгэх, хүүхдийг хоёр ээлжийн хувцастай болгох зэрэг олон яриа гаргаад хоёр багш маань зодолдож эхэлснээр барахгүй уг хэргээс болж хошуу орж, заргалдаад Далхаанямбуу багш маань дийлэглэж буруутсан бололтой. Хошууны дарга Гүржав гэж ширвэгэр хар сахалтай пагдгар бүдүүн биетэй, хүзүү толгойны зааг нь мэдэгдэхгүй ёстой л нэг тарган хонины ходоодны нугалуур шиг хүн ирж сурагчдыг жагсааж байгаад Далхаанямбуу багшийг бидний өмнө зогсоон тархи түрүүгүй загнасан бөгөөд Далхаанямбуу багшийг хэрэлдээд байхад нь “Чамайг сургуулиас зайлуулж шоронд хийнэ” гэж нүдээ дугариг болгон хашхиран хэлээд, жороо хүрэн мориндоо ууртай багшаар сугадуулан мордож явсан билээ.

- Шоронд хийнэ ээ! Би оюутны сургууль төгсөж, энд ирэхдээ чам шиг юмны дураар шоронд орох гэж ирээгүй юм шүү гэж Далхаанямбуу багш Гүржав даргын араас хэлэхэд, Гүржав дарга эргэж ч харсангүй, харин бүдүүн тэнзэн ташуураар хүрэн мориныхоо гуян дундуур пидхийтэл цохив.

Тэр өвөл ууртай багш Далхаанямбуу багшийг хэд хэдэн удаа айхавтар алгасаныг бид мэднэ.

Нэгэн өглөө бид шөнө орсон шинэ цасаар бие биеэ шидэлцэн тоглож байлаа. Дорж намайг гэнэдүүлж байгаад бөөн цасаар шил рүү нь цохиод багш нарын гэрийн цаагуур зугтааж орлоо. Би Доржийг гэнэт цохих гэж багш нарын гэрийг тойрон мяраан гэтэж явтал гэр дотор чи-би дээ тулсан өндөр дуу гарлаа. Би юу болж байгааг сонирхон чагнавал чи энэ хүүхдүүдийг өлсгөж байхдаа сэтгэл чинь зовохгүй байна уу? Би үүнийг чинь хүлээхгүй гэж Далхаанямбуу багшийн дуу гарсанд, чи хүлээхгүй гэж Далхаанямбуу багшийн дуу гарсанд, чи хүлээхгүй гэнэ ээ яадаг юм билээ дээ. За тэгээд явж сур! Норгож долоо! гэж хэлдэг юм билүү дээ гэж ууртай багшийн ёжтой хэлэх нь сонсогдов. Далхаанямбуу багш сурах цагтаа сурна. Улсаас энэ хүүхдүүдэд зориулсан зардлыг чи хэрэгтэй юманд зарахгүй яах гээд байгаа юм бэ? Аль эсвэл өөрөө цуслах гээд байгаа юм уу? гэхэд чи юу гэнэ ээ? гэж ууртай багш гэр дүүрэн хашхирав. Чи зодох нь уу? гэж Далхаанямбуу багшийн хэлэхэд чамайг зодсон ч яадаг юм. Чамд эртүүдийн хичээл чинь бага санагдаад байна уу? гэж ууртай багш хэлээд удсан ч үгүй гэрийн дотор их чимээ гарч ууртай багш Далхаанямбуу багшийн шилэн дээрээс чирэн гэрээс гаргаж ирээд түлхэн унагаав.

- Муу харгис золиг чи, хүн зодно гэнэ ээ. Бид маргааш чам шиг юмыг зайлуулж чадна гэж шүдээ зуун хорсолтойгоор хэлэв.

- Одоо зайлуулаад аль л даа гэж ууртай багш ихэмсэг хэлээд энгэрийнхээ товчийг тайлж шуусан ханцуйгаа улам гэдрэг нь шамлаж байв.

Дайран шуугих заан цолтой ууртай багшийн дэргэд Далхаанямбуу багш маш жижигхэн хүүхэд шиг харагдаж байв. Ууртай багш, ханцуйгаа шамлан, хөмсгөө зангидаж байхыг бид хараад өөрсдөө айхын хамт Далхаанямбуу багш бушуухан зайлаасай даа гэж догдлон бодож байлаа. Гэтэл Далхаанямбуу багш зайлах нь битгий хэл улам ойртож очоод!

- Чам шиг юмыг хүссэн ч зайлуулна, хүсээгүй ч зайлуулна гэж хэлээд ууртай багш руу нүдээ ч цавчилгүй ширтэн, хүйтнээр инээмсэглэв.

- Чам зэргийн нусгай хүүхэд үү дээ, ямаа туйлаад янгиа эвдэхгүй, тэмээ туйлаад тэнгэрт гарахгүй гэж цэцэн үг байдгийг мэдэх үү. Мэдэхгүй бол цээжилж аваарай. Чамд хэрэг болно шүү гэж ууртай багш ханхалзан хэлээд цог шиг гялалзаж байгаа Далхаанямбуу багшийн нүд рүү хялайн харснаа хэнэг ч үгүй эргэж исгэрэн гэрт ороход нь

- Чи энэ үгээ олон хэлж чадахгүй. Оюутны сургуулиас ирэх жил олон хүн төгсөнө шүү! Чи ойлгож байна уу гэж Далхаанямбуу багш хэлээд өврөөсөө тамхи гаргаж татлаа.

Иймэрхүү юм болдог л байсан. Гэвч өвчин дэлгэрснээс хойш болсон тэр хоёрын хэрүүл бол урьд урьдахаас илүү юм болж байгаа мэт бидэнд санагдаж байлаа.

Тэгээд Далхаанямбуу багш маань алс юманд явах болов. Чухам хайчих гэж яваа, бас эргэж ирэх эсэхийг бид мэдсэнгүй.

Далхаанямбуу багшийг явахад, бид ойрхон зогсож байсан тул хоёр багшийн яриаг хагас дутуу сонссон билээ.

- Олонд гайхагдсан оточ хүн шүү. Бас тэгээд энэ сургуулийн захирал би болохоос чи биш, чи ер нь эрхэнд минь барагтай халдаад байгаарай гэж ууртай багш хашхиран хэлэхэд,

- Тэр зальтай этгээдийн гарт энэ олон хүүхдүүдийн амийг өгч чадахгүй гэж Далхаанямбуу багш хэлээд уяанаас морио тайлж авлаа.

Төрийн төлөө оготно гэгчээр, гайгүй ч болж дээ гэж гэж хэлээд ууртай багш ха ха гэж даржигнуулан инээсэн боловч тэр инээдмээс нь цочиж аймаар байв.

- Чамд тийм л дээ, гэвч та нарын хэдэн зуун жилийн хувхай балгасан дээр чинь бойжуулж тарьсан цэцгээ чам шиг юманд сүйтгүүлэхгүй арчилж авъя гэж бодож байна гэж Далхаанямбуу багш ширүүн хэлэхэд ууртай багш ханцуйгаа шамлан давшилж очив.

- Далхаанямбуу баш урт тэнзэн ташуураа хөндлөн барьж эргэн зогсоод, хар өтгөн хөмсгөө эрчлүүлэн гялалзсан нүдээр ширтэн,

- Зодох нь уу гэж хэлэв.

Бид ууртай багш одоо л “гуйсныг байтугай, татгалзсаныг зоддог юм” гэж хашхиран хэлээд л Далхаанямбуу багшийг минь барьж аваад нүүр нүдгүй жанчина даа гэж зүрх цохилон айж байтал ууртай багш шамалсан ханцуйгаа сэгсэрч зогсоод,

- Ер нь эцэст нь сургууль хаяж явсан чамтай зохих газар очиж ярих юм их бий! гэж хэлэхэд нь Далхаанямбуу багш толгойгоо сэжлэн хүйтэн инээмсэглэж

- Надад ч ярих юм овоо бий! Чиний түшиг Гүржав занги хошуу захиргаанаас зайлуулагдсаныг чи сонссон биз, чамд сугадаж мордуулах хүн байхгүй болсон гэж хэлээд тайван гэгч нь мордож хөдлөв Гэтэл ууртай багш, Далхаанямбуу багшийн хойноос хөдөлж,

- Далхаанямбуу, хоёулаа эвээр ярья л даа гэж хэлэв.

- Би чамтай эвээр ярих гэж их оролдсон. Одоо ч надад чамтай ярих юм байхгүй. Бас зав алга гэж явдал дундаа эргэж хараад хэлэв.

Ууртай багш хатируулан яваа Далхаанямбуу багшийн хойноос цөхөрсөн нүдээр ажиглан харж хэсэг зогсов. Тэгээд удаан гэгч нь эргэж гэр лүүгээ юм бодон явлаа.

Бид баруун хөтлөөд гарсан замаар алслан холдож байгаа Далхаанямбуу багшийн хойноос гөлрөн ширтэж зогсон байлаа.

Тэнгэрт хар үлүүд мушгиралдан нүүж, бүхнийг бараан болгон сүүдэрлээд баруун хөтлийн цаанаас бөөн хар үүл манаран гарч ирэх нь бид бүхнийг юутай хүүтэй нь дарж аваад хумхин базах гэж байгаа юм шиг байв.

Хаврын бүрхэг өдрийн жихүүн салхи хацар луу үлээж сэтгэл минь тэр салхины аясаар чичрэн хийсэж байгаа юм шиг догдолж байв. Зэрэгцээд зогсож байсан бидний дундаас Бат гэж нэгдүгээр ангийн жижигхэн жаал урагшаа хэд алхсанаа Далхаанямбуу багш аа гэж уянгалуулан хашхираад, баруун хөтлийн бараг орой дээр нь гарч байсан багшийн хойноос гүйв. Бид ч дагалдан гүйв. Далхаанямбуу багш хөтлийн орой дээр гарч, эргэж зогсоод бидэн рүү харж байснаа, өмнөөс минь хатируулан ирлээ. Бид зогсов. Далхаанямбуу багш бидний дэргэд ирж мориноосоо буугаад,

- Би удахгүй эргээд ирнэ. Та нар минь сайн байж байгаарай. Өвчин гараад байна шүү дээ. Хүүхдүүд минь өвчтэй нөхдөө сайн өргөж байгаарай гэж хэлэхэд нь хоолой нь зангиран нүдэнд нь хулимс цийлэгнэж байв.

Багш түргэн гэгч нь эргэж мориндоо мордоод бид нар луу харж урт гэгч нь санаа алдсанаа морио эргүүлж цааш хөдлөв. Бид хэсэг дуугүй зогсож байснаа бас л хойноос нь уралдан гүйцгээв.

Багш хөтөл дээр гарч эргэж зогсоод, бид нар луу малгайгаараа даллаж хэдэн минут зогссоноо “би түргэн ирнэ” гэж хашхираад мориныхоо амыг алгуур эргүүлээд хөтлийн цаад руу далд оров. Бид зогсолтгүй гүйсээр хөтлийн орой дээр гарч ирээд харвал Далхаанямбуу багшийн бараа харагдахгүй болоод, сүүдэртсэн бараан толгой бидний нүдийг зориуд таглах гэсэн юм шиг бүхнийг цаад талдаа нуун хөндөлсөж байв.

Бидний ард “та нар минь намайг хүлээж байгаарай” гэж нарийхан дуу хангинан дуугарах шиг болоход нь бид эргэж харвал Бурантаг гутлаа тайлж сугавчлаад байдаг чадлаараа гүйж байлаа.

* * *

Үүний дараа сургуулийн хэдэн бор гэрээс нэлээд зайтай газар ёстой л үлгэрт гардаг оосор бүчгүй орог цагаан өргөө гэдэг шиг гэр барьж, сургуулийн хүүхдийг ойр байдаг хийдээс залагдаж ирсэн Лувсан оточ суув.

Бас тэр цагаан гэрийн хажууд нь гал тогооны гэр гэж нэг гэр байлаа.

Эмчийн гэрээс хайрч байгаа хуушуур, шарж байгаа мах, жигнэж байгаа буузны, ходоод нэвтэлсэн сайхан үнэр ханхалж дутмаг хоолтой бид нарыг цаламдан чирэх болов.

Гэвч бидэнд тэр гэрт орох байтугай, ойртох эрх байсангүй. Би нэг өдөр аз болж хоёр хүүхдийн хамт, эмчийн гэрт очиж эм боогоод хоёр бууз олж идсэн ба эмч ламтай шатар тавиад л их л хөгжилтэй инээж байсан ууртай багшийг харж “манай багш инээдэг юм аа” гэж маш ихээр сонирхож билээ.

Үүнээс гадна Зүрх хайрханаас бид цэцэг ногоо зулгааснаас болж, лус савдаг хилэгнүүлснээс өвчин дэлгэрэв гэж хүрээнээс арваад лам залж гүрэм хийлгэв.

Далхаанямбуу багш, Зүрх хайрхны хаврын ургамал гэдэг үзэсгэлэн байгуулна гэж бид нарыг дагуулан, Зүрх хайрхан өөд гарч, өдий төдий цэцэг ногоо цуглуулсан бөгөөд, түүнээ ном дэвтрийн завсар хавчуулан хатааж, дараа нь хатуу том цаасан дээр нааж, хичээлийн гэртээ тавьсан билээ. Гэтэл гүрэм хийсэн өдөр тэр үзэсгэлэн минь гайд гаргаж маш хол аваачин, эвдэж хаяв.

Бид түүндээ нэг талаар харамсаж байсан боловч нөгөө талаар хэрэв үүнээс болж өвчин дэлгэрсэн бол хаях нь зөв гэж бодсон билээ.

Далхаанямбуу багш явсны оройгоос эхлэн Бурантаг халуурч хэвтлээ. Дараа өдөр нь бас Бат хэвтлээ.

Ингээд хэдэн өдөр өнгөрвөл өвчин улам бүр дэлгэрч арав гаруй хүүхэд өвчлөв.

Тэдний дотор бас би оролцов. Хүүхдүүдийг нэг гэрт нийлүүлж хэвтүүлэв.

Миний хойд орон дээр Балданг хэвтүүлэв. Балдан бол бидний дотор хамгийн ахмад, хамгийн чадалтай хүүхэд байсан юм. Гэвч Балдан өөрийн чадал хүчинд эрдэж, бусдад дээрэнгүй зан гаргадаг хүүхэд биш байв.

Балдан жижиг хүүхдүүдэд хайртай бөгөөд түүнийг үргэлж хамгаалж, өмгөөлж байдаг тул жижиг хүүхдүүд Балданг ах гэдэг байв. Балдан хүүхэд зоддоггүй гэвч аль нэгэн хүүхэд жижиг хүүхдийг доромжлох буюу шогловол жижиг хүүхдэд учруулсан хороор нь эргүүлж шийтгэдэг байж билээ.

Өнгөрсөн өвөл, Бурантагийн хоолыг булаасныг хараад Балдан шуугин ирж булааж авсан хоолыг нь эргүүлж аваад зогсохгүй, бас миний өөрийн минь хоолыг авч хүүхдэд хувааж өгөөд “Жижиг хүүхдийг дарлавал, ийм байдаг юм ойлгов уу?” гэж хэлсэн билээ.

Балдан ширүүн цагтаа хэцүү авч, гэмгүй хүнд хоргүй гэдгийг би сайн мэдэх бөгөөд Балдантай халдаж нөхөрлөвөл сайн хүн гэж сурагчид ярьдаг тул, дэргэд хэвтсэн минь аятайхан санагдаж байлаа.

Харин миний урд талын зэрэгцээ орон дээр нөгөө Бурантаг хэвтсэн нь яршигтай хэрэг байлаа. Бурантаг гэр орон аав, ээжийнхээ тухай зогсолтгүй ярьж заримдаа уйлаад болдоггүй тул, бие муу байхад түүнтэй зэрэгцэн хэвтэнэ гэдэг нажидтай зүйл юм.

Гэвч Батаас хол хэвтсэн явдал, над их л завшаан мэт санагдаж билээ.

Бидэн дээр зүгээр огт байдаггүй ба сэрүүн байвал ярьж, дуулж, унтаж байвал зүүдэлж хашхирч, босож харайж байдаг яршигтай хүүхэд байлаа.

Бидэн дээр эрүүл хүүхэд орж ирдэг ба болж байгаа сонин зүйлийг ярьж өгдөг байв. Тэд нар босож чадахгүй байгаа Балдан зэрэг хүүхдүүдийг өргөж сувилдаг байв.

Манай сургууль хичээл хийхээ больтол, эрүүл хүүхдүүд өдөр турш тоглох буюу хийдэд очиж, лам нарын ажил хийдэг байв. Ингээд тэд нар олсон боов, ётонгоосоо хүртэл бидэнд илүүчлэн өгдөг байлаа. Заримдаа бидэн дээр Лувсан оточ, ууртай багшийн хамт орж ирээд бэлцийж цулцайсан хуруугаараа судсыг барин зузаан зовхитой онигор нүдээ анивчлан чагнаж байгаад явдаг байлаа.

Лувсан оточ ингэж ирэхдээ, хиазтай улаан торгон дээлтэй, өргөн шар гяраг бүстэй, жижигхэн шар шовгортой орж ирдэг бөгөөд баруун гартаа том ширхэгтэй хүрэн модон эрх барьж шажигнуулан явдаг байлаа.

Нэгэн өдөр тэр хоёрыг орж ирэхэд, хүнд байсан Балдан хүчлэн өндийж, Эмч ээ! Би эмээ шамдаж уух юмсан гэж дорой дуугаар хэлэв.

- Болохгүй хүү минь, оточ маналын рашааныг сүсэглэн хүртэж чадвал багадахгүй, зурсан тавилан үйлийн үр үнэхээр заяагдаагүй юм бол оточ, маналын рашаан багадахгүй, ганцхан сүсэглэж хүртэх хэрэгтэй гэж Лувсан оточ хэлэв.

- Далхаанямбуу доктор авчирч гийгүүлнэ гээд явсан шүү дээ гээд ууртай багш хүйтнээр инээмсэглэв.

- Ээ бурхан минь довтор гэдэг чинь огтлох, хагалахаас л өөр юм хийдэггүй юм. Миний танил нэг хүн толгойн хий шар өвчтэй байсан юмсан. Тэгээд надаар эмнүүлж овоо болсон юм. Гэтэл мэнгэ нь голлож хүрээ ороод довторт үзүүлсэн чинь гэдсийг нь хагалаад түүнийгээ даалгүй талийгаач болсон гэдэг. Ум мааний бадь ми хум. Хүний амь гэдэг мөн бөх зүйл. Гэдсийг нь хагалчхаад байхад нүд нь гялалзаж ам нь ангалзаж байсан гэнэ билээ. Бурхан минь довтор ирвэл энэ хэдэн хүүхдүүдийг минь зовоочих л байгаа даа. Засаг ийм болсон хойно, яая гэхэв. Үйлийн үр зурсан зураг нь л мэдэж дээ гээд Лувсан оточ гялалзуулан залбирав.

Ууртай багш хөмсгөө зангируулан биднийг харж ажиглан байснаа отчид гараа өгөхөд, оточ алгуур эргэж урьд адил цувралдан гарч явсан билээ.

Тэр хоёрыг гарснаас хойш бид хэсэг дуугүй байцгаав.

- Доктор ирвэл яадаг билээ дээ гэж хэлсэн

Чулууны дуу хүн бүхний бодлыг хөдөлгөсөн нам гүм байдлыг эвдэв.

- Би яасан ч үзүүлэхгүй. Үзэх гэвэл тэр доктортой зодолдоно. Яадаг юм бэ заавал зодолдоно гэж Бурантаг, хөнжлөө засаж нөмрөөд цааш хөрвөлдөн эргэж үүд рүү харлаа.

- Би хагалсан ч хамаагүй үзүүлнэ гэж Балдан зүүдэлж байгаа ярьж байгаагийн аль нь ч мэдэгдэхгүй бүдэг хэлэв. Балдангийн энэ үгэнд Бурантаг цочин эргэж,

- Балдан ах аа, чи битгий үзүүл. Би чамайг үзүүлэхгүй гэж уйлав. Балдан хариу дуугарсангүй.

- Би ч хагалахгүй бол үзүүлнэ гэж Дорж хэллээ.

- Заавал хагална гэж байна шүү дээ. Чи оточ гуайн хэлснийг сонссонгүй юу? Би л үзүүлэхгүй гэж Чулуун хэлэв.

- Доктор гэж ямар хүн байдаг бол? Би үзэж байгаад сайн хүн бол үзүүлнэ муу хүн бол үзүүлэхгүй гэж Бат хэлэв.

Бид цөм доторт үзүүлнэ, үзүүлэхгүй гэж удаан ярилцав. Тэгээд яваандаа яриа маань хувирч докторын тухай маргацгаав.

Тэр орой эрүүл хүүхдүүд бидэн дээр удтал орж ирсэнгүй. Шөнө орой орж ирсэн хүүхэд, өнгөрсөн орой ууртай багш, бүх эрүүл хүүхдийг дагуулан уул хадаар явж их л юм ярьсан тухай бидэнд сонирхуулав.

Ууртай багш Далхаанямбуу багшийг эрдэм номтой сайн хүн гэж магтаад, бага балчраас болсон юм уу, аль эсвэл хүүхэд өвдөөд байхад доктор залахгүй, оточ юу ч л гэсэн доктор авчрахаар явсан. Ер нь доктор ирвэл, та нарын хэнийг ч хагалж, огтолж магад. Тэр үед би хэдий та нарт хайртай авч, та нарыгаа хамгаалж чадахгүй. Та нар хагалуулах эсэхээ өөрсдөө мэдэх хэрэг. Бас та нар ч үнэндээ эрүүл улс болохоор ядахдаа гүйж зугтаагаад тарчхаж чадна. Харин өвчтэй нөхөд чинь хөөрхий байна гэж ярьсан ажээ.

Энэ үгийг ярьж байхдаа, ууртай багш маань нүдэнд нь нулимс цийлэгнэж байсан гэж зарим хүүхэд ярив. Зарим хүүхэд ууртай багшийн нүдэнд нулимс байгаагүй зүгээр арчиж байсан гэж ярив.

- Доктор ирвэл сайн. Манай ахын эхнэрийн авга ах дөрвөн жилийн хугацаанд сохор байгаад, докторт очоод хараатай болоод ирсэн. Тэгээд одоо хонио хариулдаг юм гэж Эрдэнийн хэлсэн үгэнд олонх хүүхэд итгээгүй гэж ярив.

Хэсэг хүүхдүүд ярилцаж байгаад докторт үзүүлэхгүй албаар үзэх гэвэл гэрээ буулгаж, уриа бариад нутагтаа харина гэж тогтсон тухай ярив.

* * *

Миний халуун их болж, ухаан минь орж гаран дэмийрдэг болов бас бусад өвдсөн хүүхэд ч дэмийрч аав ээж ах, дүүгээ нэрлэх буюу элдэв холбоо утгагүй юм хэлэн хашхирдаг байв.

Нэгэн өглөө сэрээд харвал, ууртай багш оточ хоёр орж ирээд, Балдангийн орны дэргэд шивнэнгүй ярилцаж байснаа хөдлөлгүй, шүдээ зуун ярзайгаад, унтаж байгаа Балданг хөнжилд нь боож, аваад явлаа.

Би юу болж байгаагийн учрыг нь олж чадалгүй байтал Балдангийн цаад талд нь хэвтэж байсан Дорж эхэр татан уйлж байхыг нь сонсов.

Би өндийж чадсангүй, гэвч толгойгоо тэр зүг эргүүлж хараад,

- Чи гэрээ санаа юу гэж асуув. Дорж нусаа дотогш татсанаа:

- Чи мэдэхгүй байна уу? Балдан, Балдан маань үхчихсэн. Сая аваад гарсаныг нь харсангүй гэж үү? гээд бүр енгэнэтэл уйлав.

- Хаанаас Балдан үхдэг юм бэ? Хүн үхэхээр чинь гэрийн өрхийг бүтээдэг юм байхгүй юу? Манай өвгөн аавын гэрийн өрхийг нэг бүтээчихсэн байсан. Тэгээд дараа нь өвгөн аав чинь бурхан болчихсон гэж хэлсэн. Манай гэрийн өрхийг бүтээгээгүй байна. Тэгэхлээр Балдан маань үхээгүй шүү дээ гэж Бат хэлэв.

- Хөгшин хүн ч үхдэг л юм л даа. Харин Балдан шиг хүүхэд үхэхгүй байхаа. Би л үзээгүй юм байна гэж Батын хажуугийн орон дээр хэвтэж байсан Сүрэн хэлэхэд,

- Хүүхэд ч бас үхдэг юм. Манай дүү үхчихсэн. Харин Балдан маань үхээгүй байх аа, үхсэн бол ууртай багш оточ гуай хоёр бидэнд хэлнэ шүү дээ гэж Чулуун хэлэв.

- Балдан ах үхээгүй, ердөө үхээгүй. Би та нарыг Балдан ахыг үхсэн гэж нүгэлтэй юм ярьсан гэж багшид хэлнэ. Бас Балдан ахад ч хэлнэ гэж Бурантаг хэлээд, дэрэн дороосоо хатсан боорцог авч, тачигнуулан идэж байв.

- Та нар чинь ямар тэнэг юм бэ? Би үхсэн хүн үзсэн. Балдан минь Балдан минь гээд Дорж үргэлжлэн уйлав.

- Үхсэн хүн чинь буцаж ирдэггүй юм. Өвгөн аав минь буцаж ирээгүй. Та нар харж л байгаарай. Балдан маань буцаж ирнэ гэж Бат хэлээд, хэсэг дуугүй болсноо,

- Надад жаахан өгөөч дээ гэж хэлэв.

- Чи дандаа гуйж байх юм. Би одоо дахин өгөхгүй шүү гэж Сүрэнгийн уцаарлан хэлэх нь сонсдов. Гэвч Сүрэн гуйсан юмыг нь Батад өгөв бололтой. Би юу өгснийг харж чадсангүй. Харин удалгүй тэдний амтархан зажлах чимээ надад сонсогдсон тул, би идэх юм өгснийг мэдэв.

Бид Балданг үхсэн, үхээгүй гэж нэлээд ярилцав. Зарим маань Балданг үхээгүй гэж итгэж байв. Зарим маань эргэлзэж байв.

Миний хувьд бол хэлэх юм олдохгүй байв. Учир нь би түүнийг үхэж байхыг харсангүй, бас юу болоод түүнийг хөнжилд нь боож аваад гарсныг мэдсэнгүй билээ.

Зөвхөн аваад гарснаас үхсэн гэж хэлж боломгүй байв. Гэтэл хөнжилд нь боогоод авч гарахад хөдлөхгүйг бодоход үхсэн байж магад санагдана. Ингэж эргэлзэж байхад Дорж зогсолтгүй уйлж байв.

- Балдан ахыг үхсэн гээд уйлаад байгаа юм уу даа? Ямар нүгэлтэй юм бэ гэж Бурантаг зэмлэснээ өөрөө уйлав.

- Ингэж байгаад бид үхвэл яах билээ гэж Чулууны хэлэхэд

- Үгүй, яршиг, би үхэхгүй гэж Бат хэлээд уйлахад нь бид цөм уйлалдав.

Нэг хэсэг эхэр татан уйлсан дуу гэрийн дотор хөг нийлэлдэн үргэлжлүүлж байв.

- Миний ээж уйлах бол муу ёр гэж хэлсэн. Миний ээж сайн хүн шүү... тийм ээ, өвөл намайг эргэж ирээд, та нарт их сайн байсан шүү дээ. Ээж маань чихэртэй сайхан уураг хийгээд миний бөндгөр хүүхэн хэзээ ирэх бол лав удахгүй ирэх байх, энэ уургаа муу бор охиндоо тавъя гэж байгаа даа... Хүүе та нар битий уйлаад байгаач дээ. Та нар чихэртэй уураг идэх дуртай юу, би их дуртай. Бас аав маань надад үнээний хальсаар хэнгэрэг хийж өгдөг, та нарт хийж өгдөг үү гэж Бурантагийн ярих чимээ эхэр татан уйлах чимээг дарсаар, сүүлдээ уйлах дуу тасарч, бид үнээний хальсаар хэнгэрэг, буу хийх тухай ярилцав.

Бидэн дээр эрүүл хүүхдүүд орж ирээд гарав. Гэвч тэд Балдангийн үхсэн буюу үхээгүйг мэдэх байтугай хаачсаныг нь ч мэдсэнгүй аж.

Үүнээс хойш хоёр хонов. Гэтэл Балдан эргэж ирсэнгүйгээр барахгүй, Балдангийн эцэг ирээд, түүний хэвтэж байсан орон дээр нүүрээ даран сууж байснаа гэнэт хөдөлж, хоёр гараараа толгой руугаа зогсоо жолоогүй шаав.

Балдангийн аав өнгөрсөн өвөл хүүгээ эргэж ирээд хүүтэйгээ зэрэгцэн сууж гэр орныхоо байдлыг ярьж байснаа өврөөсөө хир болсон бичиг гаргаж ирээд

- Нөгөө авга ахаас чинь ирсэн ном. Бичээч Равдан гуайгаар уншуулья гэсэн чинь нутаг холдоод явж чадсангүй.

Миний хүү уншиж чадах уу гэж асуугаад бичгээ өгөв. Балдан тэр бичгийг аваад шууд дэлгэснээ:

“Туйлын дотно эрхэм ачит ах Ёндон таны түмэн амгаланг өндөр уул өргөн тал, гүн усны цаанаас алгын чинээ цаасаар бие болгож, алтан үсгээр хэл болгож, мунхаг муу дүү би чинь, мянгантаа лавлаж түмэнтээ сөгдөө!...” гээд л үргэлжлүүлэн өндөр дуугаар эцэгтээ уншиж өгсөнд тэр өвгөн анхандаа итгээгүй харж байснаа сүүлдээ инээмсэглэн, нүдэнд нь баяр тодорч,

- Миний хүү! Саяхан Доной тайжийн хамжлага байж хорвоог хоёр давааны дундах газар гэж бодож байсан муу Ёндонгийн хүү бичиг уншиж байна гэнэ гээд Балданг тэврэн авч магнай дээр нь үнссэнээ “Аль вэ хүүгээ би харъя” гэж босож, инээмсэглэн зогсож байгаа Балданг тал бүрээс нь баяртайгаар харж байгаад

- Одоо манай нутгийнхан миний хүүг бичээч Балдан гэж нэрлээд л бичиг номоо уншуулах гэж олон олноор ирнэ дээ гээд учир тоймгүй инээснээ бид нар луу харж

- Та нар бас уншиж чадах уу? гэж асуув

Бид зэрэг зэрэг, “уншиж чадна” гэж хэлснээр барахгүй зарим маань өндөр дуугаар ном уншиж өгсөн өвгөн гайхан сэтгэл татсан сайхан инээмсэглэлээр инээмсэглэн зогсож байснаа.

- Ийм олон бичээч гэж мөн байдаг аа гэж хашхиран бид бүхнийг ширүүн сахалтай хошуугаараа үнссэнээ

- Одоо бид чинь захиа уншуулах гэж хэдэн өртөө газар явахаа болих цаг болсон шиг байна гэж хэлэв.

Дараа нь бид үздэг хичээл уншдаг номоо ам булаалдан ярьсанд Ёндон гуай ямар нэгэн ер бусын боловч итгэхээс аргагүй зүйл сонсож байгаа мэт заримдаа гайхан толгойгоо сэжлэн, заримдаа итгэл гэрэлтсэн гэнэн сэтгэлээр инээмсэглэж байв.

Балдангийн эцэг явахдаа хүүгээ, хацар дээр нь үнэртэн үнсээд,

- Сэлэм жад адгийн зэвсэг, цэцэн мэргэн дээд зэвсэг, эдээр баян адгийн баян, эрдмээр баян дээд баян гэдэг юм шүү. Миний хүү их эрдэм сураарай! гэж хэлээд мориндоо мордон сүүл хөдөлгөн шогшиж явахад нь бид хойноос нь харан удтал зогссон билээ.

Гэтэл Ёндон гуай хүүгийнхээ хоосон орон дээр суугаад толгой руугаа хайр найргүй цохиж байхад нь нөгөө сэтгэл татсан сайхан инээмсэглэлийн өчүүхэн туяа ч харагдсангүй. Харин олон оны ширүүн салхи, хурж наранд гандаж борлосон хүрэн царай нь хөрзийн цайвартаж, хацрыг нь дагаж тунгалаг нулимс жирвэлзэн урсаж байгаа булгийн ус шиг тасралтгүй урсан зарим дусал нь дээлий нь энгэр лүү дусалж, зарим нь өтгөн сахалтай уруулы нь давж ам руу нь ороход түүнээ шимэн залгиж байв. Тэгээд түргэн босож гүйж гараад гэрийн хаяанд эвий хөөрхий үр минь ингэж сална гэж хэн мэдлээ. Хайран хүү минь би эхэд чинь юу гэж хэлдэг билээ, талийгаач минь, хүү минь би чинь яадаг билээ гэх зэрэг үглэн уйлан гашуудан байх нь бидэнд сонсогдов.

Талийгаач! Үүнийг сонсоод бид Балдангийн үхсэнтэй аргагүй эвлэрсэн билээ. Балдан талийгаач болсон, Балдан үхсэн гэдэг нь бидний сэтгэлийг эрс өөрчлөв.

Бурантаг “Балдан ах минь” гэж хашхиран уйлаад бүр босон харайсныг галч гуай орж ирээд арай гэж хэвтүүлэв.

Хүүхдүүд цөм уйлалдав. Ганцхан Бат, Балдан үхсэн, Балдан үхээгүй гэдэг хоёр бодлын хооронд эргэн заримдаа уйлавч, заримдаа Балдан үхээгүй байх аа гэсэн асуултыг тавьж байлаа.

“Үхчихсэн! Хамт ном үзэж, хамт хоол идэж инээлдэж тоглож байсан Балдан маань үхчихсэн! Дэргэдэх орон дээр минь хэвтэж байсан Балдан минь үхчихсэн!” гэж бодоход нүдний минь нулимс аяндаа асгарч байв.

- Би үхэхгүй, би ээжтэйгээ хоёулаа байдаг. Би том болоод Далхаанямбуу шиг эрдэмтэй хүн болж, ээжээ тэжээнэ гэж Чулуун уйлах зуураа хашхиран хэлэв.

- Та нар битгий үхэл яриад байгаач дээ би айж байна гэж Бат хэлээд босон гүйж Доржийн өвөрт орлоо.

Бидний хэн ч үхэх дургүй байсан билээ. Ер нь хүүхэд өсөж дэвжиж байгаа зүйл болохоор үхэл гэдгийг сэтгэлдээ бүхэлд нь тусган авч чаддаггүй. Хүүхдэд үхэл гэж сүрхий юм ойлгогддог боловч, өөрийн хувьд хүлээж авдаггүй юм.

Хоног өнгөрөх тутам Балдангийн тухай яриа цөөн болж байв. Бас биеийн байдал улам муудаж, чадал тамир улам доройтож байв.

Биеийн байдал улам муудах тутам босох сон, тоглох сон гэж бодогдоод, амьдрахын оргилсон шунал оволзож, арчаагүй байгаадаа бачимдан уйлж байв.

Хажуудаа хэвтэж байгаа Бурантагийг харахад аймаар амьтан болоод байлаа.

Саарьтсан бор хацартай болж гэсэн махлаг Бурантагийн царай нь цайвар цагаан болж, нүд нь цааш ширгэн үс нь ширэлдэж турах тусам нь битэгтэй гэдэс нь улам том болж байсан тул харахад нүд хальтардаг байв.

* * *

Нэг өглөө унтсан, унтаагүй хоёрын хооронд хэвтэж байтал Чулуун,

- Би хагалуулахгүй, Далхаанямбуу багш минь үгүй, үгүй гэж гэр дүүрэн хашхиран хэлэв.

Би анхандаа түүнийг дэмийрч байна гэж бодов.

Гэтэл толгой дээр минь хүмүүс ярилцах шиг болов. Би толгойгоо хүчлэн хөдөлгөж хараад, цочин өндийв. Гэрт гурван хүн орж ирээд зогсож байв. Тэдний нэг нь Далхаанямбуу багш нөгөө хоёр нь үл таних хүн байлаа. Хоёулаа яг адилхан цагаан хувцастай бөгөөд нэг нь эрэгтэй Монгол хүн, нөгөө нь эмэгтэй Орос хүн байв.

Хүүхдүүдийн босож чадах нь босож, өндийж чадах нь өндийв. Чулуун хөнжлөө нөмрөн гарч зугтаах гэснийг Далхаанямбуу багш барьж аргадан орон дээр нь суулгав. Харин Бурантаг хөдлөх ч үгүй дээш харан хэвтэж байлаа.

Цагаан хувцастай Орос хүүхэн бид нарыг гайхан харж байснаа инээмсэглээд хэдэн үг хэлэв. Би юу хэлснийг ойлгосонгүй.

- Та нарыг доктор гуай сайн байна уу гэж цагаан хувцастай хүн хэлэв. Бидний хэн нь ч дуугарсангүй. Тэр доктор хөдөлж, миний толгойг илсэнд, би цочин давхийв. Доктор давхийснийг мэдээд над руу харан толгойгоо сэжлэн инээмсэглэж

- Ай, я яа я гэж хэлээд Доржийн орны дэргэд очив.

- Та нар хагалахгүй юу? Аль хагалах уу? гэж Бат асуусныг докторт нөгөө цагаан хувцастай хүн оросоор хэлж өглөө.

Доктор тачигнатал инээснээ шууд явж Батын дэргэд очоод түүний толгойг илэн оросоор нэлээд олон үг хэлэв. Чамайг ийм том хүн байж орон дээрээ нүцгэн сууж байдаг ямар ичгэвэртэй юм бэ? Одоо бушуухан орондоо ороод хэвт гэж доктор хэлж байна гэж Батад нөгөө цагаан хувцастай эрэгтэй хүн хэлэв. Докторын энэ үгэнд Бат баахан зовсон бололтой, хөнжлөө нөмрөн хэвтэв. Бас бидний зарим маань хэвтэцгээв. Гэвч бидний нүд доктороос салсангүй. Доктор өврөөсөө хоёр талдаа бүдүүн оосортой тоглоом шиг хөөрхөн гялгар төмөр гаргаж ирээд, түүнээ Батад үзүүлэн дохиж байгаад юм хэлэв.

- Доктор чамайг үүгээрээ чагнаж үзээд дараа нь хагалахгүй юу? Аль хагалах уу гэдгээ хэлж өгнө гэж байна гэж бас нөгөө цагаан хувцастай эрэгтэй хүн хэлэв.

Бат инээмсэглэн тэр гялгар юмыг барьж үзэв. Доктор бас инээмсэглэн Батыг ажиглан харж байв. Тэгээд дараа нь Батыг үзэж эхлэв. Харин хагалсан ч үгүй, огтолсон ч үгүй Батыг үзэж дуусаад Доржийг үзэхэд Дорж эсэргүүцсэнгүй.

Гэтэл гадна шуугиан болон унины мод тачигнан хавиралдах чимээ гараад хүүхдүүд бие биесээ дуудалцан байх нь бидэнд тодорхой сонсогдов.

Үүд дуугарч Эрдэнэ сандран орж ирээд багшийн дэргэд очсоноо,

- Багшаа, хүүхдүүд гэртээ харих гэж байна, гэрээ нураагаад нэг нэг унь бариад явах гэж байна гэж амьсгаадан хэлэхэд Далхаанямбуу багш хариу үг хэлсэнгүй гүйн гарлаа.

- Та нар чинь юу болж байгаа юм бэ? гэж Далхаанямбуу багшийн хашхиран хэлэх дуу бидэнд сонсогдов.

“Бид докторт үзүүлэхгүй”, “Багш минь докторыг буцаагаач! гэж хүүхдүүд ам амандаа хашхирах дуу бидэнд сонсогдож байв.”

Хүүхдүүд ярьж байснаараа тарж явах болсон бололтой. Бас тэд нар гэрээ буулгаж, тус бүр нэг унь авсан бололтой.

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураингуйлан бичнэ үү?
2. Зохиолын түүхэн үндэс, агуулга, үзэл санааны онцлогийг тайлбарлана уу?
3. Зохиолын гол дүрийн онцлогийг тодорхойлон бичнэ үү?
4. Зохиолд өгүүлэн буй цаг үеийн хүүхдийн дүрийг өнөөдрийн хүүхэдтэй харьцуулан ярина уу?

V бүлэг. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол -орчин үеийн үлгэрүүд

Өчүүхэн дөрвөн үлгэр

Ц. Дамдинсүрэн

1. Өвгөн хулганы сургаалыг сонсмуу

Эрт урдын нэгэн уудам газар холбогдсон хоёр өндөр уул байв. Тэр ууланд нэгэн арслан үүрд оршиж насан бага цагаас эхлэн хоёр уулын үзүүрт үсрэн харайж наадан тоглодог байжээ.

Мөн хоёр уулын хоорондох гуу жалганд нэгэн хэсэг олон хулгана үүрлэн оршиж байсны дотор нэгэн өвгөн хулгана байжээ. Тэрбээр нэгэн өдөр хулгана бүрийг цуглуулж хэлсэн нь.

“Энэ хоёр уулын орой дээр ээлжлэн үсрэн гарч нааддаг энэ арслан одоо нас хөгширсөн нь лав биз ээ. Тийм мул мөн түүний хуч тамир доройтсон болох нь идэр залуутай адил санаж үсэрсээр нэгэн цагт эндэгдэн энэ гуу жалганд унаж бид нарыг дарж алж магадгүй учир эндээс зайлж өөр газар үүр засан нутаг сольё” гэв.

Олон хулгана өвгөн хулганын үгийг үл зөвшөөрөн “Энэ маань нас өвгөржөөд дэмий үг чалчх болжээ. Арслан уулын хавцалд унаж дарж алахаас айн зугтаж болно. Хэрэв дээд хөх тэнгэр хөхөрч харагдсаар олон он болсон нь одоо хөгширсөн биз ээ. Тэр бас дэлхийд унаж үхэх магадгүй тул түүнээс зайлан хаа зугтах билээ” гэх хөгшин хулганыг наадаж үгий нь эс хайхрав. Иймд өвгөн хулгана өөрийн ганц хүүгээ дагуулж өөр газарт очоод нэгэн үүр засаж нутаглаж суув.

Өнө удалгүй нэгэн цагт мөнөө арслан нь нэгэн уулын үзүүрээс үсрэн харайхдаа тэнхэл муудсаны хар гайгаар нөгөө уулын оргилын тэгш газар хүрч чадалгүй хажуу этгээдийн элгэн хаданд хүрч хөл алдан доош бөмбөрсөөр олон хулганын оршдог гууд нэгэн баахан хад чулууны хамтаар түжигнэн унахад олон хулгана хэчнээн сандравч зайлж чадалгүй ихэнх нь дарагдаж үхэв.

Тэр уулын ойр зуур нутаглах нэгэн хэсэг аймаг улс байсны дотор ан агнаж огт үзээгүй нэгэн тэнэг хүү нэгэн өдөр анд мордоход Арьяа нэртэй нэгэн саваагүй хүн хэлэв. “Чамайг гурав хоногийн дотор оготно хулганаас бус олзтой ан агнаж ирвэл хувхай модноос жимс ургахад хүрнэ” гэхэд тэнэг хэлжээ: “Хэрэв агнавал чи надад гэрээ өгнө үү?” Нөгөө хүн “Тийн болтугай” хэмээн зөвшөөрөв. Тийнхүү тэнэг хүү анд зүүх нэг нум авч яваад тэрхүү арсланы үхдэлийг үзэж нумаа сайтар хөвчилж, дэргэд нь тавьж эргэж ирээд л учраа хэлэхэд Арьяа наадаж өгүүлүүн:

“Чи нумаа ан агнах ёсоор зүүхгүй зүгээр хөвчлөн тавьсан нь тэр хэрхэн амьтныг хорлох вэ? Бас цагаан арсланы үхдэлийг ямар амьтан идэх гэж халдаж очих вэ?” гэхэд, тэнэг хүү цөхөрч нумаа маргааш авирья гэж шийдэв. Тэр шөнө нэгэн үнэг нөгөө үхэдлийг үзэж баярлаад ийн сэтгүүн “Энэ их мах хэзээд ч миний болов. Ийм их хоолонд учрах юун их заяа билээ. Өөр хоол эрэлгүй түүнийг идэж амьдарч болно биз. “Баран идэхээр мэрэн ид” гэсэн хуучин үг бий тул үүнийг зүй нь урьдаар хатуу хүтүүгээс нь идэж, хожим аль сайхныг аажмаар идье хэмээн санаж хөвчлөн тавьсан нумын хөвчийг мэрж хэмлэсээр байтал хөвч нь тасармагц нумын гижирт өлгөгдөн тийрэгдэж үхэв.

Маргааш тэнэг хүү нумаа очиж авах гэж урамгүй явсаар иртэл нэгэн үхсэн үнэг байхыг үзэж ихэд баярлавч, тэрхүү үхсэн үнэгэнд гар хүрч болох эсэхийг мэдэхгүй аюумшиглан хардаж нумны хөвчийг гүймэгц горхилон уяж үнэгний хүзүүгээр оосорлон чирсээр харьж явах замын зуур ийн бодруун: “Би энэ үнэгээ худалдаж хувцас хунар авна. Бас Арьяагийн гэрийг аваад хэнээс ч дутуугүй гэр оронтой, баян чинээлэг хүү болно” гэж баярлан гүйж хариад Арьяагийн гэрийг авна гэж түүнтэй ноцолдон гэрээс нь зууралдан чангаасаар байгаад гэрийг эвдэж хэрэггүй болов. Тэгээд тэнэг хүү хоосон хоцорч, үнэгээ худалдах гэсэнд чирч явсаар үсийг халцгай болгосон тул хэн ч хэрэглэсэнгүй. Үүнд бусад хүмүүс ингэж хэлэлцлээ: “Эрийг бүү бас, далайг бүү янд гэдэг хуучны сургаал Арьяад хэрэгтэй байсан байна. Шунал ихэдвэл олз зайлна гэдэг үлгэр тэнэг хүүд боллоо. Мэлзээ хэлэлцсэн Арьяагийн гэр эвдэрч хэрэггүй боллоо. Мэхийж чирсэн үнэгний үс зулгарч өртөггүй боллоо “ гэлцвэй.

Тэр үед бус нэгэн газар арван хулгайч хамтаар бүлэглэн хол ойроос юм хулгайлж амьдарч байжээ. Нэг цагт хулгайлах юм олдохгүй болоод өлсөж ундаасахын зовлонг эдэлж, олз эрэн явсаар өнөөх арсланы үхдэлийг үзэж төсөр газар буудаллаж, тав нь арсланы махнаас авчрахаар очлоо. Нөгөө тав нь унд цай бэлтгэх ажлыг үйлдэхээр хоцров. Явсан тав нь хоорондоо ийн хэлэлцрүүн: “Энэ үхсэн арслан их боловч бид бүгдээр идсээр барагдах нь бэрхгүй. Хэрэв энэ барагдвал бид урьд адил мөн л өлсгөлөн болно. “Иймд хувааж нөхдөдөө өгөх маханд хор шингээгээд өөрийн идэх махыг тусгай авч ирвэй. Бас үлдсэн тавд мөн адил хорт сэтгэл төрж, нөгөө тавын уух цайнд хор хольжээ. Ингээд бүгдээр нийлэлдэж хоолоо идэж цайгаа уугаад цөмөөр үхжээ. Энэ явдлыг хулгана хянан мэдээд хүүдээ ингэж сургавай.” Өвгөд хөгшдийнхөө үгэнд эс орвол

Олон хулгана шиг болно.

Өтөлсөн мөртлөө залуу мэт маяглавал

Залуу арслан мэт болно.

Өөр бусдыг хэтэрхий басамжилбал

Саваагүй Арьяа шиг болно.

Өтөл мунхаар хэтэрхий шунавал

Тэнэг хүү мэт болно.

Үнэхээр хунашгүй шунахай загнавал

Өнөөх үнэг шиг болно.

Өст хорт сэтгэлийг агуулбал

Олон хулгайч шиг болно.

Өвөрмөц учир иймийн тулд хүү минь

Өвгөн миний үгийг сайтар бодож

Өөрийн биеийн хэрийг мэдэж

Өнөд зүйд олж явахыг хичээтүгэй “ гэжээ.

2. Аргат Тайв алагдсан нь

Урьд нэгэн мунхаг хүн хөсрөөс нэгэн хэсэг алт олоод энэ нь ямар үнэтэй, ямар хэрэгтэй эд болохыг үл мэдэхийн тулд ихэнхийг хөдөө газар нууж, өчүүхэн төдийг аваад итгэлтэй нөхөр Тайв гэдэг хүнд үзүүлсэнд “Энэ нь алт бөгөөд их үнэтэй юм” гэхэд “Дахин бас ийм юм үлэмжхэн бий тул

хоёул хуваан эдэе” гэвэл Тайв зөвшөөрч уул нуусан алтыг хоёул өөр нэгэн модны ёроолд булж түүнээс хоёул авч эдэлж байтал Тайв муу санааг гаргаж уул алтыг бус газар нууж, дараа нь мжнхаг хүнийг “Чи алтаа хулгайлж авав” гэж хаанд заалдаж мэдүүлрүүн: “Бид хоёрын дундын алтыг энэ мунхаг ганцаараа эдлэхийн төлөөнөө хулгайлж авав. Хаан эс итгэвэл анх алтыг ёроолд нь нуусан модны тэнгэр мэднэ. Түүнээс асууя” гэхэд хаан зөвшөөрч модны тэнгэрээс асуухын тулд өдөр болзжээ.

Тэр болзооны урьдхан Тайв модны доторх хөндийд өвгөн эцгээ суулгаж ийн захирав: “Энд хаан тэргүүлэн, түшмэд ирж урьд булсан алтыг хэн авсан болохыг модны тэнгэр хэлж айлдана уу хэмээнэ. Хариуд нь тэр тэнэг хүн авсан гэж та өгүүлэх хэрэгтэй” гэж суулгажээ.

Хаан олноор ирж урьчилан асуухад өвгөн хүүгээ сургасны ёсоор хаан үнэмшиж “Тэр алтыг энэ тэнэг хүн авсан мөний тул, үүнийг алах хэрэгтэй” гэхэд тэнэг хүн уурлаж, “Энэ модны тэнгэр юун худалч вэ? Би авсан зүйл огт үгүй байтал тас гүжирдэв. Үүнийг би шатаана” гэж модны үртэс зомгол цуглуулахад Тайв “Энэ нь тул түүнийг шаваавал чамд муу болно” гэж тэнэгийг хэчнээн аргадан сургавч тэнэг “Би одоо үхэх ял олсон нь үхэхээс илүү муу болох гэж бас байх уу?” гэж мөнөө модонд гал оруулж шатаавал Тайвын эцэг амьсгал давхцаж түлэгдэж “Үхлээ” гэж бахиран гарч ирэхэд хаан сая учрыг байцаан мэдэж Тайвыг алах ял шийтгээд өвгөн эцгийг гэмгүйгээр өнгөрөөж алтыг тэнэгт олгуулжээ.

3. Хаадын байлдаан

Урьд хоёр их хаан байлдаж тэмцээд нэгэн нь цөхөрч найрамдахыг хүсэж байтал, өөр нэгэн хаан Лажин тэр цөхөрсөн талд хүчин зүтгэж хавсран нөгөө талыг дийлэхэд хүрвэл тэрхүү дийлэгдсэн этгээдийн тэргүүн жанжин И хооронд нь оролцсон хаан Лажинд ийн захидал илгээв.

“Балбын хаанд: Та хүчин тусалж тэтгэсээр арслан мэт зүрх оруулж баатар хүчтэй болгов. Бид хэчнээн үхэн зүтгэн махчилдавч үнэхээр тэсэхгүй шантрах нь хол бус болжээ. Хүний гол ёсыг бодвол хоёр хүн хэрэлдэвч салгах нь зүй биз ээ. Гэтэл хоёр улсын байлдааныг үл барам, түймрийн гал мэт хорт түүгээр салхин мэт тусламж үзүүлэн өвсөн мэт гэмгүй би ба манай улсын өчнөөн түмэн ардыг зовлонгоор гаслах нь ямар жигтэй. Та хэдийгээр энэ удаа чоно дагасан хэрээ мэт зовлонгүй олз хайж байгаа боловч зүйгүй явсан ялыг тэнгэр соёрхох балзошгүй тул аймшиглан бодож өршөөвөл байлдааныг зогсоон найрамдуулж болно уу?” гэж илгээхэд Лажин хаан үзэж эргэлзэн гайхаж байтал шадар түшмэл Алган дээл өгүүлрүүн: “Хаан аа Энэ бичгийг нарийвчлан, бодвол муу үгээр дайрсан нь хэтэрхий тул даруй байлдан тэдгээрийг сөнөөвөл зохино” гэвэл хаан зовшөөрч ийн бичиг явуулав.

“И гэдэг хулганыг хэчнээн мэхийн гуйвч идэт баатар харцгай хүнслэн завшина. Харьат олны зол тохиолдох нь ойр болов. Чи ба таны хаан болбол над мэт цэргийн сүрийг бадруулан олон эрчүүдийг баатар цэрэг болгохгүй, олны хөрөнгийг сургууль бичиг гэж энэхэн тэрхэнд зарахаар үл барам, хөвгүүд охидыг найман нас хүрвэл эцэг эхийн өврөөс салгаж зовоох учир таны, харьяат ардууд жигшин гомдож байгаа тул чи ба чиний хааны хүүр булшин дээр баярын хурим хийх болно. Тиймийн тулд бид таны олныг туслах санаа төрж сая гар хөдөлгөсөн хэрэг. Зүй нь нэгэнт шийдсэн ёроор даруй

чамайг баривчлан авч махбодийг чинь шалгана” гэжээ. И жанжин үзээд бодож байтал урьд тэдний хоёр этгээдийн цэргийн байдлыг тагнуулахаар явуулсан хэдэн хүн Лажин хааны нэгэн элчийг барьж ирэв. Түүнийг байцаавал мэдүүлэх нь:

“Би Лажин хаанаас зарагдаж Балбын хаанд бичиг хүргэхээр явтал танай хүнд баригдаж ирэв” гэж амиа гуйж бичгээ гаргаж өгснийг үзвэл хэлсэн нь:

“Дайсан И-гийн цэргийн хүчин мохож байгаа байдалтай тул нэгмөсөн хүчин шавхаж хоёр этгээдээс бүхий л цэргээ хөдөлгөн гаргаж дайсан этгээдийг даруйхнаа үнсэн товрог болгож тэдний нутагт довтолж. Маргааш өглөө нар үзэгдэхтэй сацуу би бүхий цэргээ хөдөлгөн өмнөд Пурабаш гэдэг газраар дайран орно” гэжээ. Үүнийг “И жанжин хүчин мохсоны тул таны цэрэг хань хэрэглэлгүй билээ. Гэтэл жанжин И үлэмжхэн цэрэг хуралдуулж Пурабаш гэдэг газар нууцлан байгаа нь гэнэт хөдөлж манай хязгаарын цэргийг сөнөөн дарж зэвсэг ба хувцсыг цөмийг олзолсноор үл барам, манай цэргийн туг мэт үйлдэж, басхүү манай цэрэг мэт хувцас хэрэглэл бэлтгэж байгаа нь нэгмөсөн хөдөлж алгуураар таны цэрэгт Лажин миний цэрэг мэт ойртоод гэнэт хөдөлж таны цэргийг дарсугай гэж байгаа гэнэ. Эл учрыг эрхэм Балба танаа сонсгоё. Би одоо цэрэг тусалъя гэвч хот хязгаарыг хамгаалах цэрэггүй мэт байна. Та хичээнгүйлэн шамдаж бүх цэргээ хөдөлгөн Пурабаш гэдэг газар үүрлэн байгаа дайсан И-гийн цэргийг дарах ажаамуу” гэж хуурамч захидал бичиж тэр цэргийн хувцсыг өөр хүнд өмсгөн элчийг сольж томлон явуулав. Бас нэгэнтээгүүр Лажинд ийн худалч захиа бичив.

“Дайсан И-гийн цэргийг мохож гэж та бодсон нь тийн бус, басаж үл болно. Харин хойдоос өдий төдий цэрэг зэвсэг нэмэгдүүлэн ирж, Пурабашийн хойт этгээдийн ууланд хоргодон байгаа гэнэ. Юуны урьд та өмнөдөөс хүчтэй байлдаж, хүчийг мохоосон хойно, Балба би хамаг цэргээ хөдөлгөж сая сайхан хурим болгоё” гэж Балбын хааны нэрээр хуурамч захиа бичиж илгээн, жич өөрийн нэрээр ийн захиа бичив:

Лажин хааны цог заль улмаар мандах болтугай
Балба нарыг, дийлэхэд би үнэндээ баясна
Хутгаж, манай татар хаан намайг зарцалсан боловч
Чадвал өөрийн хааны зарлигаас зайлна
Харин би, золоор таны амгаланг эрсэн нь баршгүй
Завшаан тул, даруйхнаа бөхийн дагаж таны соёлыг
Эдэлж дагахыг хүсэх бөгөөд та зөвшөөрвөл

Таны хамаг хэрэгт хүчин зүтгэж Лажин Балба нарын хотыг хамгаална. Гэвч эрх биш дайчлан Эзэлсүгэй” гэж манай хаан тушаасан тул шударга ёсыг илэрхийлж энэ нэгэн удаа цэрэг хөдөлгөн байлдсугай. Дахин мохвол даруй танд дагаж гэдрэг хаанаа довтлохыг баталъя” гэж бичиг явуулаад нэгэнтээгүүр зайлан одож зэвсгээ базааж байв. И-гийн бичгийг Лажин үзээд И жанжин омог буурч надад дагаж орохыг хүсэх боловч өөрийн хааны зарлагийг дагаж нэгэн удаа байлдъя гэжээ гэж ухаж байтал нэгэн шадар түшмэлийн өчүүхэн хүү үзээд хэлжээ:

“Энэ бичгийг үзвэл хааны ухсан зөв мэт боловч нарийвчлан толгой хөндөлдөж уншвал “Лажин, Балба нарыг хутгаж чадвал завшааныг И эдэлж таны хотыг эзэлсүгэй” хэмээсэн үг болох нь юун жигтэй гэвэл хаан эс хайхарч

болзооны ёсоор маргааш өдөр инжин И-гийн цэрэг гэж өөрсдийг эндүүрч Лажин, Балба нарын цэрэг хоорондоо хүчтэйгээ байлдсаар хүчнийг дуусгаж хэд хоног байлдах завсар И жанжин үлэмхэн цэрэг зэвсэг бэлтгээд Лажин, Балба нарын хотыг эзлэн улсын эрхийг гартаа бариад хөөрхий хууртаж хоорондоо байлдаж хүчнээ барсан цэргийг сүрдүүлэн номхотгож цэрэг ба ардыг цөм өөрийн харьяат болгон захирав гэнэ.

4. Аргаар эдлэв.

Аугаа хүчит гарди шувуу ба арга зальт хөхөө шувуу хоёр үл тохиролцож хоорондоо ноцолдвол хөхөө нь хүч багатай тул ялагдаж өгүүлрүүн: “Гарди аа. Та намайг ялсан тул би баясав. Та надаас юу хүсвэл би өгье” гэвэл Гарди омог төрж хэлэв: “Муу чамаас аугаа хүчит тэнгэрийн шувуу би гуйх юм юу байх билээ? Харин ядуу чи надаас хүсэх гуйх юм байвал би өршөөж өгнө” гэхэд хөхөө “Надаас юун гуйх вэ?” гэж хэд хэд асуувч гарди тул хөхөө хэлэв. “Та бол дээд их хүчтэн бөгөөд хурдан, би бол дорд ядуу амьтан тул алс явж үл чадна. Өчүүхэн би таны толгой дээр суувч нэгэн гайхамшиг өд сөдөөс хүндгүй тул миний биеийг үргэлжид нуруун дээрээ суулгаж миний хүссэн газар одож байх ажаамуу. Их төрөлхтөн нэг үгт бөгөөд бат шударга тул таны үг нь түүнчлэн бат болно за” гэвэл гарди нэгэнт хэлснээ цуцрахаас ичингүүрч “Тийн болсугай” гэж зөвшөөрсөн учир цаг үргэлжид хөхөө шувууг нуруун дээрээ суулгаж түүний дураар явах болов гэж

Бусдаас сонсож сэтгэлд тогтоосон зүйл хийгээд

Бус бас санаачлан бодож хэдэн утга олоод

Бүрхэг санааны хирээр найруулан

Бүдүүлэг дөрвөн үлгэр бичиж

Өсөх залуу нөхдийн үзэх явдалд

Өчуухэн төдий нэмэр болохыг зорьж,

Цэндийн хүү ёслов.

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хурайнгуйлан бичнэ үү?
2. Орчин үеийн үлгэрийн онцлог, ач холбогдлыг тодорхойлон бичнэ үү
3. Ц. Дамдинсүрэнгийн “Өчүүхэн дөрвөн үлгэр” зохиолын үлгэр тус бүрийн гол санааг жагсаан бичнэ үү?
4. Зохиолч яагаад “Өчүүхэн дөрвөн үлгэр” гэж нэрлэсэн бэ?
5. “Ц. Дамдинсүрэн “Өчүүхэн дөрвөн үлгэр” зохиол орчин үеийн үлгэр мөн” сэдэвт эсээ бичнэ үү? /үгийн тоо 250 хүртэл/

Унага

Л. Бадарч

- | | | |
|----------------------|---------------------|---------------------|
| Буурал унагатай | Үнэрлэж хөдөлгөж | Унгалдаж хэлсэн нь: |
| Саарал гүү байж | Олон янзаар | - Ухаант ах гуай |
| Буурал унагандаа | Оролдож үзлээ | Уутанд ороод |
| Саарал гүү: | Ууттай тэр юм | Уяулж боолгосны |
| - Ээжээсээ бүү хоцор | Урваж хөрвөөд | Учир юу билээ гэв |
| Ижлээсээ бүү тасар! | Уран үгээр | Урваж хөрвөөд |
| Чогчого аюулгүй | Уянгалж хэлсэн нь: | Уут хэлсэн нь: |
| Чоно аюултай | - Санаагаар ирдэг | - Уутан дотор |
| Бор чононоос | Сайн амьтан | Унтахад тавтай |
| Болгоомжил! гэжээ. | Хэн гэдэг вэ? | Уяулж боолговол |
| Энхрийлж хэлсэн | Хэлээч нэрээ, | Улам ч тавтай |
| Эхийнхээ үгэнд | Унага хариуд | Уутын үгэнд |
| Унаган буурал | Унгалдаж хэлсэн нь: | Унага үнэмшээд |
| Ухаарсангүй яваад, | - Унага би байна! | Уяаг тайлаад |
| Ээжээсээ хоцроод, | Уутанд хэн байна? | Уутыг нээтэл |
| Ижлээсээ тасраад | гэв. | Жартайсан нүдтэй |
| Ойд ганцаараа | Урваж хөрвөөд | Жарвайсан амтай |
| Орхигдож гэнэ дээ | Уут хэлсэн нь: | Соотойсон чихтэй |
| Буурал унага | - Ахын чинь нэр | Солбисон нүдтэй |
| Бухимдан сандарч | Ачит-Бор! | Уурласан бор чоно |
| Уйлж гэнэ. | Унага дүү минь | Уутнаас гарч гэнэ |
| Уулын цуурай | Ууланд ганцаараа | Унага айгаад |
| Элэглэж гэнэ | Яах гэж ингэж | Ухаан алдаад |
| Хайрт ээжийнхээ | Яваа билээ гэв | Хөдөлж чадалгүй |
| Халамжит үгийг | Унага хариуд нь | Хөшиж зогсжээ |
| Хайхарсан бол | Унгалдаж хэлсэн нь: | Уутат чоно гуай |
| Хаанаас ингэх вэ? | - Ээжээсээ хөдрөөд | Урхирч хэлсэн нь: |
| Унага гэмээ | Ижлээсээ тасраад | - Унтсан намайг |
| Ухаарч гэмээ | Ойд ганцаараа | Учиргүй сэрээдэг |
| Уйлаад яах вэ? | Орхигдож төөрлөө | Унага чамайг |
| Уулын шившиг | Адуун сүрэг | Урж иднэ хө |
| Орилоод яах вэ? | Аль руу явсныг | Унага хариуд нь |
| Ойн шившиг | Ах гуай та | Унгалдаж хэлсэн нь: |
| Ээжээ эрье гээд | Анхаарч мэдэв үү | - Уу ах гуай |
| Ижлээ ольё гээд | гэхэд | Уучилж үзээд |
| Уулын жимээр | Урваж хөрвөөд | Уутнаас гарсан |
| Унага давхилаа | Уут хэлсэн нь: | Ачийг санаач |
| Хадан дундуур | - Адуу хаачсаныг | Уурт чоно гуай |
| Харайж гарлаа | Ах чинь андахгүй | Ульж хэлсэн нь |
| Унага замдаа | Урьдаар дүү минь | - Ачий чинь би |
| Ууттай юмтай | Уяаг тайлаад | Бачаар хариулна |
| Учран золголоо. | Ухаант ахаа | Тусы чинь би |
| Учры нь сонирхлоо | Уутнаас гаргаач | Усаар хариулна |
| Үргэж бусгаж | Унага хариуд нь | Ходоод хоосон |

Хоолоо нэхсэн	Урхирч хэлсэн нь	Үзүүлээд өгье гээд
Олон үтгүй	Унага намайг	Сүүлээ шарваад
Одоо иднэ гээд	- Уутнаас гаргасан	Шүлсээ залгиад
Уурт чоно гуай	Уутнаас гаргаад	Уутанд орж гэнэ
Унагыг дайрлаа.	Ундлах ёстой	Унага ухасхийгээд
Дэрсэн дотор	Дараа нь бас	Уутыг боож гэнэ
Чимээ гарлаа.	Дайлах ёстой	Ухаант туулайг
Дэлдэн туулай	Ийм ч учраас би	Тэврээд үнсэж гэнэ
Дэгдээд ирлээ.	Идэх нь зөв гэв	Ууттай чоно гуай
Унаган буурал	Ухаант туулай	Урваж хөрвөөжээ.
Унгалдаж хэлсэн нь	Учирлаж хэлсэн нь:	Ууртай чоно гуай
- Ухаант туулай	- Эрхэм чоно та	Ульж гасалжээ.
Учрыг ялгаач	Энэ муу уутанд	Дэлдэн туулай
Унага би чинь	Багтсан гэдэг	Дэгдэн бүжиглэжээ.
Ухаангүйгээд	Башир үг биз	Унаган буурал
Уутнаас чоныг	Хэрэв та уутанд	Унгалдан дүүлжээ.
Уучилж гаргалаа	Хээвнэг багтвал	Ууталсан чоныг
Амь насы нь	Наад муу унагаа	Өвчих гээд
Аварч өглөө.	Идэх чинь зөв.	Анчин ч ирж гэнэ
Тэгэхэд чоно гуай	Намайг дээр нь	Унаган буурлыг
Тэр ачий минь	Идээрэй гэв.	Аваачих гээд
Бачаар хариулж	Ховдог чоно гуай	Адуучин ч ирж гэнэ
Барьж идэх нь	Хосгүй баярлаад	
Уурт чоно гуай	Үгээ буцахгүй биз	

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураингуйлан бичнэ үү?
2. Зохиолын агуулга, үзэл санаа, уран дүр, дүрслэлийн онцлогийг тайлбарлана уу?
3. Зохиолын хэсгээс цээжилж урнаар уншина уу?
4. ХУЗ –ын дүр, түүний онцлогийн талаар тодорхойлон бичнэ үү?

Хамгийн хэцүү нь юу вэ?

Д. Даржаа

- | | |
|------------------------------|--------------------------------|
| - За би, нэг үлгэр ярья | Шонтгор хамраа шалбалчхаж |
| Жаалаа чи сонсож бай | Хатуу мөс чамайг би нэг |
| - Өвөл цаг хэдийн болж | Хариу үгээр чадъя гээд |
| Өргөн мөрөн хөлджээ. | - “Ямар айхавтар мөс вэ чи? |
| Өглөө эрт хоол эрж | Яагаад намайг унагачхав?” |
| Өчүүхэн оготно явж гарчээ | Мөснөөс оготно асууж гэнэ |
| Муухай хумсаараа базна гээд, | - “Мөс би хэцүү шүү хэцүү |
| Шилэн тунгалаг мөсөн дээр | Мөргөж унавал хатуу шүү” гэхэд |
| Ширүүхэн гүйх гээд уначхаж, | - “Надаас илүү юм бол чи |
| Шороотой мөс мөргөөд | Наранд юунд хайлдаг вэ?” гэхэд |

Оготно ихэд цэцэн үгээр
 Онгирч бардам хэлэв гэнэ
 - “Халуун наран хэцүү шүү” гэж
 Хатуу мөсний хариу хэлэхэд
 - “Үнэн хэцүү юм бол нарыг
 Үүл яагаад халхалдаг юм бэ?” гэж
 Нарнаас оготно лавлан асуухад
 Наран ингэж түүнд хариулсан нь
 - “Үүл надаас хэцүү шүү” гэхэд
 Үүлэнд оготно ойртож очоод
 - “Сайхан үүл та, хэцүү юм бол
 Салхинд юунд хөөгддөг вэ?” гэв
 - “Салхи надаас хэцүү шүү” гэж
 Сайхан үүл хүнгэнэн хэлэхэд
 - “Түргэн салхи хэцүү юм бол
 Түймрийг юунд унтраадаггүй вэ?”
 гэхэд
 - “Түймэр надаас хэцүү шүү
 Түүнийг дийлэх аргагүй” гэв
 - “Улаан гал та хэцүү юм бол
 Усанд юунд унтардаг вэ?” гэж
 Бадарсан түймрийн галыг харж
 Бачит оготно асууж гэнэ дээ
 - “Ууртай гал надаас бүр
 Усны үер хэцүү шүү” гэв
 - “Аймшигт үер та, хэцүү юм бол
 Арын хонхорт шуугьж ороод
 Гарч чадахгүй байдаг чинь
 Гайхалтай юм даа” гэхэд нь
 - “Арын хонхор чинь харин надаас
 Арай хэцүү чадалтай шүү” гэв
 - “Та ийм хэцүү юм бол
 Тарвага, зурманд нүхлүүлж,
 Эрүүл биеэ сүлбүүлж, сийчүүлэн
 Энгийн байдаг нь юу вэ?” гэв

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураингуйлан бичнэ үү?
2. Зохиолын туурвилзүйн онцлогийг тодорхойлон бичнэ үү?
3. Зохиолын агуулгын ач холбогдлыг тайлбарлана бичнэ үү?
4. Ардын аман зохиолын үлгэр, орчин үеийн үлгэр хоёрын ялга юу вэ?

- “Тарвага, зурам хэцүү шүү” гэв
 Арын хонхор хариу хэлэв гэнэ
 - “Тарвага, зурам хэцүү юм бол
 Анчинд яагаад алагддаг юм бэ?” гэв
 - Тарвага, зурам хоёр гарч
 Тавгүй байдал үзүүлэн байж:
 - “Хүн гэдэг амьтнаас
 Хүчтэй юм үгүй шүү” гэв
 - “Хатуу мөсийг ч болов тэд
 Хайлуулаад уучихдаг юм
 Халуун нар шаравч тэд
 Халхавч бариад сүүдэрлэгдэг юм
 Үүл манан бүрхэвч тэд
 Зүгээ олоод гардаг юм
 Аюулт хэцүү салхинд ч тэд
 Аргаа олоод явдаг юм
 Түймрийн гал гаравч тэд
 Түргэн унтрааж чаддаг юм
 Үерийн ус шуугивч тэд
 Өндөр хаалтаар зогсоодог юм
 Хонхор хотгор тохиолдовч
 Хоригдохгүй давдаг юм тэд
 Ан авыг хийгээд тэд
 Тарвага, зурамнаас эхлээд,
 Баавгай, чоныг ч алдаг
 Бар, ирвэсийг ч барьдаг.
 Аюултай юуг ч байсан
 Атгандаа оруулж чаддаг
 Хүн бол бүгдээс хэцүү
 Хүрээд ирвэл аймшигтай” гээд
 Хар нүхэндээ сандран шургаж
 Харагдахгүй нуугдахаар нь
 Өчүүхэн тэр оготно ч гэсэн
 Үзэгдэхгүй байхыг бодож гэнэ.

Сүүлэнхүүд тохиолдсон адал явдал

Ч. Арьяасүрэн

Боов яаж төрөв

Сүүлэнхүү гэгч хэн бэ

Манай дэлхий дээр юм гэнэ. Эзэрхэг урьдын цагт биш энэ төрийн үед юм гэнэ. Өвөл, хавар, зун, намар юу болдгийг зөвхөн ганцхан өдөр үзсэн хүн байсан гэнэ. Тэр хүнд ийм явдал тохиолджээ.

Зургаадугаар ангийн “А” бүлгийн сурагч Борхүү элдэв сонин явдалтай учирсан хөгжилтэй модон хүний тухай уншаад нэг тийм хүн хийх юмсан гэхээс нойр нь хүрэхээ байжээ. Борхүү нөгөө хүнээ чухам юугаар хийдэг билээ гэж удтал бодоод, эцэст нь эргүүлгэн дээр байгаа хонины сүүлээр хийхээр шийдэв гэнэ. Борхүү хониныхоо сүүлийг хичээнгүйлэн зорж гарлаа. Эхлээд толгойгий нь дараа нь их биеий нь зорчихсон чинь ийм нэг хүн болчихжээ.

Миний өөхөн хүн ч Буратиногоос дутахгүй хөөрхөн боллоо доо. За байз, хэн гэж нэрлэдэг юм билээ бай. Зүйтэй зүйтэй. Сүүлэнхүү гэж нэрлэе гэж Борхүү амандаа үглэснээ бүүр чанга хашхирч орхилоо.

Миний нэр Сүүлэнхүү юм уу? Энэ чинь дандаа сүүлдэж явдаг гэсэн үг шүү дээ гэж өөхөн хүн часхийн нь дуугарав. Борхүү үнэндээ өөхөн хүнийг ярина гэж санаагүй болохоор давхийн цочлоо. Борхүүгийн цочоо аажмаар гарч “Гайхах юм алга. Энэ маань Буратино шиг л ярьдаг болчхож” гэж бодоод.

Хаанаас даа, Сүүлэнхүү гэдэг нэр чамд ёстой таарна. Чамайг хонины сүүлээр хийсэн шүү дээ гэж учирлав.

Аа тийм бол ч яахав. Гэдэс өлсөөд байна. Идэх юм өгөөч гэж Сүүлэнхүүг нэхэхэд Борхүү сандарч онгорхой сав болгоныг онгичин өглөө дэлгүүрээс авсан нэг төгрөгийн үнэтэй, алаг өнгийн амттай боовоо өглөө. Сүүлэнхүү боовыг бувар бувар зажилна. Сүүлэнхүү идэж дуусаад дэвсгэр дээр унасан үйрмэгийг авах гэж тонгойж байхыг Борхүү харснаа:

“Шороотой боов иддэггүй юм. Гэдэс чинь өвдөнө” гээд унагасан үйрмэгийг нь цуглуулж хогийн саванд хийв.

Би анх удаагаа л ийм сайхан амттай боов идэж үзлээ. Энэ боов яаж төрдөг бол үзэх юмсан гэж Сүүлэнхүү маань Борхүүгээс гуйлаа. Боов яаж төрдгийг үзэхэд бүтэн жил хэрэгтэй. Би чамд заавал үзүүлэмз. Жаахан хүлээнэ гэж Борхүү үнэн сэтгэлээсээ хэлэхэд Сүүлэнхүү “Борхүүг хүлээвэл мөн ч удах нь. Хөлгүй биш дээ, өөрөө явж үздэг хэрэг ээ” гэж шийдээд нэг хоёр алхалсаар үүд рүү шулуухан явж босго даваад хар гүйхээрээ явж одов.

Хүүе Сүүлэнхүү, хаачих нь вэ? Төөрчихнө. Буцаад ир! гэж Борхүү дуудав.

Сүүлэнхүү Борхүүгийн дуудахыг нэг чихээрээ оруулж, нөгөө чихээрээ гаргаад замд дайралдсан чулуунд торж, Ойчих шахсанаа улам хурдлан гүйв.

Гудамжинд хөл бөмбөг тоглож байсан жаалууд Сүүлэнхүүг чарлуулан барьж аваагүйсэн бол Борхүү амьсгаадталаа хөөгөөд ч гүйцэхгүй байх байсан юм.

Үл таних амьтан

Хэдийнээ шөнө болжээ. Сүүлэнхүүг унтаж байтал ямар нэг амьтан өрөөсөн хөлий нь мэрэв. Түүнийг нойрон дундаа өшиглөвөл өнөөх амьтан хоромхон зуур алга болсноо төдөлгүй дахиж ирээд өрөөсөн хөлнөөс өм хазлаа. Сүүлэнхүү энэ удаа сэрж өнөө амьтны хүзүүн дээрээс барьж аваад багалзуурыг нь шахав.

- ЁО ёо ёо үхлээ. Намайг тавиач дээ, би дахиад таныг яасан ч мэрэхгүй, үүнээс хойш түүнээс цааш больё гэж дорой дуугаар өгүүлэв.
- Одоо хашрав уу?
- Хаширлаа, хаширлаа! Би танд муу явдал насандаа үйлдэхгүй, тавиач дээ!
- Зөвхөн надад л муу явдал насандаа үйлдэхгүй, бусдад үйлдэх юм, биз дээ?
- Үгүй ээ, үгүй! Бүтэж үхлээ. Өршөөгөөч дээ
- Чиний нэр хэн бэ?
- Оготно
- Чамайг хаана суудгийг чинь мэдэж л байж тавина даа
- Нүхэнд суудаг, жаахан сулхан бариач дээ!
- ЁО- ёо-ёо - Нүхэнд гэнэ ээ. Тэгээд чи яаж энд орж ирэв?
- Авдрын доор байдаг нүхээр би шөнө дандаа гарч ирдэг юм.
- Тэр нүхээр чинь гадаа гарч болох уу?
- Бололгүй яахав. Гарсан хойноо мөрөө баллахгүй бол Борхүү мэдээд биднийг сүйдэлнэ шүү:

Сүүлэнхүү түүнийг тавилаа. Оготно дөрвөн хөл дээрээ суниаж амаа ангайж эвшээв.

- Борхүү та нарыг яагаад тэгж үзэн яддаг болчихсон юм бэ?
- Бид Борхүүгийн унших номоос урж ноохой хийж өвөлжсөн. Саяхан бас гурилын шуудай цоолоод гурилаас нь зөндөө зөөчихсөн. Зөвхөн энэ ч биш, Борхүүгийнхийг эзгүйд нь юм уу унтсан хойно нь хоол унднаас нь хулгайлж идэж аваад авдар сав, аяга таваггүй өвчний нян тараагаад хаячихдаг юм гэж бардмаар өгүүлэв.
- Өө, та нар чинь тэгвэл хүнд хор учруулдаг муухай амьтан юм шив дээ: Та нар олуул уу?
- Бид олуулаа. Бидний нөгөө нэг овгийнхон талд амьдардаг. Тэд бэлчээр идэж малыг тураадаг амьтан байгаа юм. Тэд маань одоо цөөрч байна гэж

дуулдсан. Химийн ухаан гэдэг гайтай хөөтэй юм оготны сүргийг хүйс тэмтэрч байгаа гэнэ.

Бид чинь жаал амсхийгээд урах мэрэх ажлаа үргэлжлүүлэхэд нөхөд минь үхэж эхэлдэг. Хожим бид энэ учрыг мэдсэн юм. Бидний хоолонд хор хийдэг юм байна лээ. Бид нар ийм хоолноос болгоомжилж явдаг боловч өлсөхийн эрхэнд идчихээд шүдээ ярзайлган тэрийж ойчдог. Өөр нэг айхавтар үнэртэй хорыг оготны замд цацсан байхад дороо л үхэж байгаа юм. Бидний дунд Зэгэл гэдэг овжин зальт оготно байсан. Зэгэл бидэнд хураалттай барааг давхраар нь цоолж хэнд ч хэрэггүй болгох арга зааж өгсөн. Зэгэл шинэ жилээр чанасан банш идэх гэж яваад замдаа Борхүүгийн тавьсан занганд орж биднээсээ салан одсон юм гээд санаа алдав. Оготно хүүгийн ярианд уярсан Сүүлэнхүү санаа алдаж.

- Та нар маргаашнаас эхэлж өвс идэж, ус уу! Хүний хувцас хунар битгий урж тасдаж бай! гэв. Зовлонгоо ярьж уйлганасан оготно хүү, овгийнхоо муу зуршилд гомдон дахин юу ч хэлсэнгүй явж одлоо.

Шидэт таяг

- Гэрээс гарах арга олсон Сүүлэнхүү унтаж байгаа хүмүүсийг сэрээхгүй гэж их л сэрэмжлэн оготно хүүгийн мөрөөр гэтэн гэтэн мөлхсөөр хойд авдрын доогуур шургавал том нүх дайралджээ. Сүүлэнхүү тэр нүхээр гулсан тас харанхуйн дунд тэмтэрч явав. Хааяа хатуу газар ёрдойсон чулуу биеийг нь хатгаж учиргүй өвтгөнө. Тэгж ахисаар нэгэн нугачааг өнгөртөл том жижиг долоон бор оготно тал талаас нь дайрч зарим нь хөлнөөс нь, зарим нь нуруунаас нь чангааж золтой л зулгаачихсангүй. Нэг бүдүүн бие гүйцсэн бор оготно арай л нүүрнийх нь арьсыг хуу татчихсангүй. Сүүлэнхүү хойноос довтолсныг өшиглөж урдаас дайрсныг цохин унагаасаар нүхнээс арай чамай гарав. Гадаа тас харанхуй, салхи исгэрч, газар тэнгэр хоёрыг цасан шуурга холбож нүүр нүдгүй шавхчиж байв. Гэнэт хүчтэй цасан шуурга Сүүлэнхүүг агаарт хөөргөлөө. Цааш юу болсныг Сүүлэнхүү огт мэдсэнгүй. Нэг сэрвэл цас мөсөөр бүрхэгдсэн мөсөн гэрт, янз бүрийн мөсөн чихэр боов өрөөтэй таваг тавьсан ширээний дэргэд сууж байлаа. Мөсөн тооноор уур савсаж мөсөн унинаас усан дусал тог тог хийн мөсөн тосгуурт дусалж байв. Гэрийн дотор тавигдсан эд хэрэглэл цөм цас мөсөөр бүтжээ. Сүүлэнхүүгийн хамаг бие тэс хөлдөөд усан цэврүү гүйж туйлын ихээр өвтгөхөд хоёр нүднээс нь нулимс бороо орж байгаа мэт урсав. Гэрийн хоймор мөсөн олбог дээр суусан цасан өвгөн Сүүлэнхүүг ажин харснаа.

- Битгий уйл хүү минь! Чи яаж байгаад цас мөсний оронд ирэв ээ? Сүүлэнхүү амандаа дүүрэн юмтай болохоор бас л хариу хэлсэнгүй. Тэгсээр сая чихрээ идэж дуусмагцаа:

- Боов яаж төрдгийг үзэхээр гартал гэнэтийн учралаар танайд ирэв. Борхүү, надад “Түүнийг үзэхэд, нэг жил хэрэгтэй гэв. Яаж нэг жилийг хүлээх билээ. Нэг л өдөр үзвэл сайн сан гэж Сүүлэнхүү хушуугаа цорвойлгон хэлэв.

- Боов яаж төрдгийг нэг “өдөр үзнэ гэнэ үү? Даанч сэтгэшгүй санаа санаж дээ. Гэвч би чамд нэг удаа тусалъя” гэж цас мөсний өвгөн айлдлаа. Тэр өвгөний гэрт чүдэнзний хэртэй мөнгөн таяг тооноор туссан нарны гэрэлд гялалзаж байв.

- Энэ бол жинхэнэ үлгэрийн шидэт таяг даа! Хүү минь! “Санасан газар минь саадгүй хүргэ” гээд таягаараа гурав дохиорой гэв. Сүүлэнхүү учиргүй баярлан гэрээс гартал цасан хуй түүнийг мэлийсэн цагаан талд авчрав. Цаг алдаад яах вэ? гэж Сүүлэнхүү бодоод,

- Санасан газар минь саадгүй хүргээрэй! Одоохон би машин тракторын засварын газар очсон байх болтугай гээд өнөө таягаараа гурав дохив.

Гэнэт алга болсон нь

Сүүлэнхүүг машин тракторын засварын газрын хаалгаар ортол халуун агаар урдаас нь төөнөв. Цас мөсний орноос ирсэн Сүүлэнхүүд тасалгааны жирийн дулаан тэгж санагдсан байжээ.

Тэндхийн чих дүлийрэм дуу чимээнээс тэр золтой л ухаан алдчихсангүй. Хэдэн арван суурь машин нүргэлэн дуугарч байгаа ажээ. Машин бүрийн дэргэд нэг нэг хүн ажиллана. Хүн суурь машины товчийг дарахад түүний бул эргэлдэн хутганд ойртож ямар нэг юм зорж байв.

Сүүлэнхүүгийн дөжрөө аажмаар гарч энэ тэр юм ажиглаж эхлэв. Гэтэл халуун хайлмал зоргодос эрчлэн харвах мэт унахдаа түүний баруун чихийг сэт авав.

Хорсож өвдөхийн эрхэнд дуу алдан хашхирснаа токарьч залуу бариад авчхаж юу магад, цаашдын аялалд минь саад болж болзошгүй гэж бодоод бушуухан суурь машины хажуу өнцөгт нуугдав.

Халуун гэдэг нь жигтэйхэн, харин гадаа бол хамаг юмс, тэс хөлдүү бөгөөд цан хүүрэгт хучигджээ. Сүүлэнхүүгийн хөлс гоожиж бараг бүтэж үхэх шахав. Ингэж хэсэг зуур хоргодож байтал тэнгэр нижигнэх шиг дуу гарах нь тэр. Нөгөө талын асар том хаалга алгуур нээгдэж трактор яндангаараа цэнхэр утаа олгойдуулсаар ирж явав. Энэхүү аварга биет оньсон хөдөлгүүрийг алмайран харж байхад нь өргөн палигар гинж гулссаар Сүүлэнхүүд мэдэгдэлгүй дөхөв. Аз болж хажуу тийш бултахад саваа төмөрт тээглэн хоёр гинжний хооронд ойчсонд трактор түүнд ямар ч гэм хэргэлгүй дээгүүр нь өнгөрөв. Тэр трактор ч араагаа хэдэн угсраа гялгар төмрүүд зүүжээ. Сүүлэнхүү гялгар төмөрт ойртож нүүрээ харлаа. Чихээ хулгар болсон тэр харамсаж дургүй хүүхдүүд намайг “хулгар чихт Сүүлэнхүү” гэж хочилно доо гэхээс нүүр нь улайв. Гэвч өчигдөрхөн нүүрээ шинэхэн улаан будгаар будсан болохоор хэнд ч анзаарагдахгүй ажээ.

- Чи битгий чихээ бариад байгаач. Наадах чинь яачихсан юм бэ? гэх дуу гарахад Сүүлэнхүү цочиж ийш тийшээ харсан боловч юу ч олж үзсэнгүй.

- Энэ чинь өмнөө байгаа юм хардаггүй сохор юм уу? гэж ахиад даажигнав. Сүүлэнхүү сая, өнөөх гялгар төмөр ярьж байгааг ухаарав.

- Намайг анжис гэдэг. Би төмөр морь трактортайгаа хоёул хаврын тариалалтад гарахаар бэлтгэж байна. Би газар хагалж чадна. Чи юу хийж чадах вэ? Боов л идэж биз дээ гэж даажигналаа. Сүүлэнхүү доромжлуулсандаа гомдож анжисыг цохиод автал гараа хурц ирэнд нь эсгэчхэв. Өвдсөндөө нэг гараа, нөгөө гараараа барив.

- Яав, гараа эсгэчхэв үү? Намайг өнөөдөр ирлэсэн болохоор хурц байгаа шүү. Надтай болгоомжтой харилцахгүй бол болохгүй гэж хэлээд анжис Сүүлэнхүүг нүднээсээ бөөн бөөн нулимс дуслуулж байгааг харав. За битгий уйл, Эр хүн зоригтой байдаг юм. Би чулуутай зодолдож хэчнээн удаа биеэ эмтлэвч, эзнийг ирлэж эмчилж өттөл ер уйлахгүй байдаг юм. Тэсвэрлэж үз! гэж анжис аргадав. Энэ үед Сүүлэнхүүг хүчтэй салхин хуй газраас хийдүүлэн өргөж тэнгэрт аваачих шиг боллоо. Энэ нь тракторын жолооч хоёр хуруугаараа бүслэхээр нь өргөөд сайн ажиж харахын тул нүдэндээ ойртуулсан хэрэг байжээ.

- Ямар догь хүүхэлдэй вэ? Сүүлээр хийж шүү. Та нарын хэн чинь урлаа вэ? гэж хашхираад,

- Охиндоо аваачиж өгье. Охин минь хүүхэлдэйн баярт хэрэглэг гээд өвөртлөх гэтэл Сүүлэнхүү,

- Би хүүхэлдэй биш шүү! Үлгэрийн баатар Сүүлэнхүү байна гэж подхийсэн хариулт өгөв. Олон суурь машины байшин доргим чимээнд тракторч залуу. Сүүлэнхүүгийн энэ үгийг дуулаагүй бололтой. Харин нөхөд нь Сүүлэнхүүг дамжуулан үзэж байхдаа гараараа барьж хоёр удаагийн шархыг нь хөндөж өвтгөхөд салахын мөн болж,

- Санасан газар минь саадгүй хүргээрэй гэж хэлээд таягаараа гурав дохиод одов. Гартаа барьж байсан хүүхэлдэй илбийн үзэгдэл лугаа адил гэнэт алга болсонд өнөөх залуус гайхахын ихээр гайхаж эрэвч олсонгүй. Сураглавч сураг гарсангүй.

Гурван зуун наян нөхөд

Сүүлэнхүү үр ургуулах тасалгаанд ирсэн байжээ. Энд бас л хаврын тариалалтад бэлтгэж байх ажээ. Эмч шиг цагаан хувцастай хүн үр соёолох, ургах хүчийг шалгахаар дөрвөн зуун ширхэг үр авч түүнийгээ зуу зуугаар нь дөрөв хуваагаад шороотой хайрцагт ижил хэмжээтэйгээр бие биеэс нь зайдуу суулгав.

Тасалгааны дулаан хэвийн байна гэдгийг Сүүлэнхүү халуун хүйтнийг хэмжигч хэмжүүрийг хараад мэдлээ. Үр ургахыг хүлээсэн арван дөрөв хоног Сүүлэнхүүд хамгийн зовлонтой үе шиг санагджээ. Сүүлэнхүү төрснөөсөө хойш нэг ч удаа тухтай унтаж үзээгүй болохоор энд ёстой ханатлаа нойрсож тэр зовлонг гэтлэхээр шийдсэн гэнэ. Тэгтэл түүнийг нойрон дунд нь бөөн уйлаан майлаан сэрээчхэв.

“Үр ургуулах тасалгаанд юу байдаг сан билээ. Надаас өөр хэн байх билээ? Хачин юм даа. Ямар золиг нь хаана уйлж байна вэ?” гэж Сүүлэнхүү бодоод эргэн тойрон эрээд олсонгүй. Ингээд гайхшаа баран дэмий л зогсоод чагнавал уйлах дуу үр ургуулах хайрцагнаас осолгүй гарч байв. Соёолсон үрнүүд уйлж байдаг. Эдэнд ямар зовлон тохиолдоо юм бол гэж Сүүлэнхүү өрөвдөөд:

- Үрнүүд минь та нарт ямар золгүй явдал учрав? гэж асуувал соёолсон үрнүүд нэгэн дуугаар:

- Бид анх дөрвөн зуу байсныг чи мэднэ шүү дээ. Одоо тэгэхэд хорь маань аюулт харуу өвчнөөр өвчилж үхжээ. Бид тэднийхээ хойноос минутын гашуудал зарлаад уйлалдаж байна гэв. Сүүлэнхүү бас нас барсан хорин нөхдийг хүндэтгэж малгайгаа авч зогсов.

- Нөгөө цагаан хувцастай агрономич дөрвөн зууч үрнээс гурван зуун наа нь соёолж, бусад нь харуу өвчнөөр үхэж гэдгийг мэдээд тариалах үрнүүдээ хордуулж өвчнийг устгах арга хэмжээ авчээ. Агрономичийн удирдлагаар хамгаалалтын хувцастай хүмүүс формалин хэмээх хороор тариалах үрийг хордуулж бөөгнүүлэн брезентээр хучив. Сүүлэнхүү хамгаалалтын хувцасгүй учир хордож үрнүүдтэй хамт хутгалдан дарагдчихжээ. Хучлагыг авч сэврээхэд нар салхи үзэж сая нэг юм ухаан орж сэргэжээ. Тэгээд буудайн үрнүүдтэй тариалангний талбайд уулзахаар тохиролцоод салах ёс гүйцэтгэн:

- Санасан газар минь саадгүй хүргээрэй гэж хэлээд шидэт таягаараа гурав дохиод үүлтэй тэнгэрээс доохнуур үзүүртэй модноос дээхнүүр нисэж явав.

Тал дахь хотхон

Өчигдөрхөн хоосон байсан талд өнөөдөр бяцхан хот боссон байлаа. Сүүлэнхүүд энэ хот таалагджээ. Дөрвөн дугуйтай тэргэн дээр байрлуулсан байшингуудын яндангаар утаа савсана.

Сүүлэнхүү нэг тийш байшингийн шатаар өгстөл гишгүүр нь хоорондоо хол хол зайтай тул гурав дахь гишгүүрээс дөрөв дэх гишгүүр лүү үсэрч дүүжигнэхдээ барьц алдаж доош нисэв. Тэгэхдээ шатны доогуур хийсэн орж, ширүүн салхинаас амь хоргодож байсан хамхуул дээр унаж амьд мэнд бие бүтэн үлджээ. Сүүлэнхүү саяны аймшигт явдлаас хашралгүй ахиад шат өөд урьдынхаас улам эрэмгий мацав. Тэгтэл хаалга нээгдэж нэгэн бадриун эр гарч ирэв. Сүүлэнхүү тэр хүнийг машин тракторын засварын газарт дайралдсан тракторч залуу гэж танив. Энэ залуу энд ирсэн хойно миний гарыг эсгэдэг “хад мөргөгч анжис ч лав ирсэн дээ, аяар очиж уулзъя” гэж бодов. Байшин дотор зуухан дээр гурилтай хоол буцалж байв.

- Маргааш өглөө тариалалтад тракторууд маань, хэдэн цагт хөдлөх вэ? гэж хоол хутгаж суугаа эмэгтэйг асуухад номноос хараагаа салгахгүй сууж байсан хархүү:

- Яг 8 цагт гэв. Байшингууд дугуйн дээр суурилагдсан учир Сүүлэнхүү тэдгээрийг өөрөө явж иржээ гэж ойлголоо.

Шороонд булуулав

Үүр манхайтал цайж, чогчиг шогшрон тал дахь хотод өглөө болсныг тунхаглав. Удалгүй хэдэн арван тракторын дуу нижигнэлээ. Нүргээнтэй тэр дуу чихний хэнгэрэг хагалмаар тийм чанга дуугарав. Тракторууд анжисуудаа чирэн цуварсаар тариалангийн талбайд орж очив. Анжсууд газрыг хагалж сэвсгэр зөөлөн болгоно. Сүүлэнхүү нөхдийнхөө дунд “хад мөргөгч” хэмээх хочтой танил анжсаа дагаж явж байлаа. “Хад мөргөгч” анжис Сүүлэнхүүд:

- Энд үр тарианы ургамлын үр суулгах гэж байгаа болохоор зургаа долоохон сантиметр гүн хагалж байгаа юм гэж тайлбарлажээ. Энэ ярианаас Сүүлэнхүү нэг зүйлийг ойлгоогүй учир ахин лавламаар санагдаад:

- Ямар үр тарианы ... гэтэл

- Яагаав улаан буудай, арвай, овьёос ... гэж “Хад мөргөгч” хариуллаа. Тэдний араас үр цацах машин явж байлаа. Үр цацах машины үр гоожуулах хоолойноос улаан буудайн үр талбайд жигд гоожиж байв. Сүүлэнхүү үүнийг сонирхон харж яваад анжис хагалж өнгөрсөн шуудуу дотор хатуу шороонд бүдэрч унав.

Сүүлэнхүүг босож амжаагүй байтал шороо нурж амьсгаа авах чадалгүй болтол битүү булжээ. Түүний дээгүүр борной явж өнгөрхдөө шороогоор бүр хучиж орхив.

Чийгийн улаан хорхойтой танилцав

Сүүлэнхүүг шороонд булуулаад хөдөлж ядан хэвтэж байхад хөлийн нь хажуугаар нэг юм гулсан өнгөрөх шиг болов.

Сүүлэнхүү тэр юмны явсан газраар шороо нурахыг сонсоод ямар амьтан байгаа юм бол гэж бодон “Авраарай”. “Туслаарай” гэж дуудах гэсэн боловч шороо ам руу нь ороод чадсангүй.

- “Түр зуурын бороо ороод өнгөрчээ. Газар их чийгтэй байна. Цэвэр агаар амьсгалъя” гэх дуун гарав. Сүүлэнхүү бүхий л чадлаа шавхаж дээрээсээ дарсан шороог унаган өндийж харвал хоёр нарийхан амьтан гулалзан мөлхөж явав.

- Та нар чинь хаанаас гараад ирэв? Нэр алдар хэн гэдэг билээ? гэж Сүүлэнхүү асуув.

- Биднийг чийгийн улаан хорхой гэдэг гэв.

- Чийгийн улаан хорхойн бие цагариг булчингаас тоггжээ. Цагариг булчингийн агшихад чийгийн улаан хорхойн бие нарийсаж урт болж байхыг Сүүлэнхүү ажив.

- Би Сүүлэнхүү гэгч байна. Боов яаж төрдгийг үзэхээр явж байна гэв. Тэгтэл үүлний завсраар нар шагайж газар ээв.

- Ямар бүтэж үхмээр халуун юм бэ? буцъя гэж нөгөө нэг чийгийн улаан хорхой хэлэв.

- Таануусын гэр чинь хаана байдаг юм бэ? гэж Сүүлэнхүү асуухад чийгийн улаан хорхой:

- Бидний гэр тэр харагдаж байна гэж газар доогуур шургасан савхны хэртэй нүхийг заалаа.

- Одоо бид гэр оронгүй болчихсон. Саяны анжис бидний орон гэрийг эвдэж, шороо чулуугаар таглаж орхилоо. Түүгээр ч барахгүй ганц биеийг минь хувааж хоёр болгосон. Гэсэн ч бид хоёр болсондоо муудах юм алга. Ёстой хөгжилтэй байна гэлээ. Сүүлэнхүү тэдний нүдийг олж харах гэж хичээгээд ололгүй:

- Хүүе, чийгийн улаан хорхой, чиний нүд хаана байна? гэв. Бид төрөлхөөсөө нүдгүй боловч гэрэлтэй, гэрэлгүй хоёрыг чамаас дутахгүй ялгана шүү гэж хариулав.

- Та нар хоолоо яаж олж иддэг юм бэ? гэж Сүүлэнхүү угийн сониуч зангаараа бас шалгаав.

- Иддэг ургамлаа навчны нь үнэрээр ялгаж мэд дэг. Бидний хамар ч тэргүүн зэргийн үнэрч шүү. Харин бид чамайг үнэрлээд жинхэнэ хүн биш гэдгийг мэдсэн. Яагаад гэвэл чамаас хонины сүүл үнэртэж байна. Чи бол жирийн өөхөн хүн л юм. Харин чи “боов яаж төрдгийг” үзэхээр яваа чинь сайшаалтай байна. Бид юм мэдэж авахын төлөө ннгэж махран мэрийдэг хүмүүст дуртай.

Чийгийн улаан хорхой бид ч гэсэн тэр боовыг чинь төрүүлэхэд тус хүргэдэг юм шүү дээ гэлээ.

- Та нар овоо зөв ярьж байснаа сүүлд нь ичихгүй дэгсдүүлж орхилоо. Ийм турь муутай өчүүхэн амьтан байж боов төрөхөд яаж тус хүргэдэг юм бэ

- Чамд ч бүтэн цагийн ном заахаас, болохгүй юм байна. Анжис чийгийн улаан хорхой хоёр чинь адилхан газар боловсруулдаг юм шүү дээ. Чийгийн улаан хорхой биднийг байгаль эх төрүүлсэн. Анжсыг хүн төрүүлсэн. Анжис биднийг бодоход агуу их хүчтэй юм. Гэхдээ анжис бол хүнгүйгээр юуг ч бүтээж чадахгүй зүгээр л нэг төмөр юм. Харим чийгийн улаан хорхой бид газар унасан навчийг нүхэндээ зөөж хөрсөн дэх ялзмагийг ихэсгэж хар хөрсийг бий болгоход хүмүүст тусалдаг.

- Аа тийм байж. Өөр яадаг вэ? гэж Сүүлэнхүү лавлав.

- Чийгийн улаан хорхой бидний явсан нүхээр ус, чийг, агаар хөрсөнд амархан нэвтэрч ордог гэж хэлэв.

Энэ үед тэнгэр цэлмэж, бөөн бөөн үүл өмнийг чиглэн нүүж үүлэн чөлөөний нар хурцаар шарж эхлэв. Чийгийн улаан хорхой, халууныг тэсвэрлэдэггүй болохоороо сийрэг хөрсөнд хурц хошуугаараа өрөмдөж өөртөө нүх гарган гүн рүү шургаж одох нь тэр.

Баяртай хүндэт чийгийн улаан хорхой минь. Бид дахиад уулзаж мэднэ гэж хэлээд Сүүлэнхүү түүнийг үдэж хоцров.

Чийгийн улаан хорхойн өмнө нягт хөрс дайралдсанд тэрээр хөрс шороо идэж байгаа юм шиг түүний хэсгүүдийг амаараа залгиж гэдсээрээ дамжуулан гаргаж байв.

Сүүлэнхүү чийгийн улаан хорхойг өөртөө савх модны хэрийн нүх гарган газрын гүнд далд ортол үдэж зогсов. Сүүлэнхүү хорлогчидтой тэмцэлдэж байгаад онгоц хүнгэнэхийг сонсмогц ухаан алдав.

Тарьсан үр соёолж, тариалангийн талбай ногооров. Ногоон соёонууд наранд баяр, хүргэж байлаа. Нар инээвхийлж, тэднийг халуун илчээрээ хайрлана. Сүүлэнхүү ногоон соёонуудыг нартай тийм дотно байхыг үзээд атаархав. Нар улбар шар туяагаа тусгасаар уулын цаагуур далд орохдоо ногоон соёонуудад хандаж:

Баяртай хүүхдүүд минь! Баяртай! Маргааш болтол баяртай! Сар эгчийнхээ дэргэд тавтай нойрсоорой! гэж хэлэв.

Ногоон соёонууд хэзээ нарны хүүхэд болчихсон юм бэ? гэж бодов. Тэгээд Сүүлэнхүү:

- Ногоон соёонууд аа! Нар та нарын ээж юм уу? гэж асуулаа.

- Тийм ээ. Нар бидний бас нэг ээж байгаа юм, Нар, ус, агаар гурав биднийг газрын хөрсөнд булаатай байхад минь ургууллаа. Нар бидний дээлийг ийм гоё ногооноор будаж өгсөн юм.

Сүүлэнхүү энэ үгсийн учрыг бүрэн гүйцэд ойлгож барсангүй. Учир нь түүнийг сайн мэдэхийн тулд эрдэм сурах хэрэгтэй.

Сүүлэнхүү эрдэмд суралцаагүй болохоор түүний ухаан одоохондоо дэмийгээс дэмий байлаа.

Аажимдаа ногоон соёонуудад гай учирсныг Сүүлэнхүү мэдэв. Ногоод соёонуудын зарим нь хорчийн хатаж, өсөлт нь муудав. Өвсний бясаа гэдэг ховдог шавьж ногоон соёонуудын шим шүүсийг сорон хооллож байжээ. Эмэгчин бясаа нь иш дотор үүр засаж өндөглөжээ.

Сүүлэнхүү хэд хэдэн өвсний бясааг цохиж алсан боловч тэд цөөрсөн шинжгүй, харин ч язганалдан гүйлдэж улам даврах ажээ. Агрономич, өвсний бясааны хорлолыг үзээд машинаар сүрэг тахиа авчруулав. Тахианууд:

- Хаана байна, Энд байна. Амттайхан хоол гэлцэн өвсний бясааг идэж дуусгав. Ногоон соёонуудад учирсан гай үүгээр төгсгөл болсонгүй. Сүүлэнхүү бас нэг өдөр амандаа тариа зууж яваа шар хулганатай дайралдав.

- Чи яагаад тариа идэж байгаа юм. Тавь! гэхэд шар хулгана үг дуугарсангүй. Сүүлэнхүү, түүний хойноос хөөж гүйцэхгүй болохоороо газраас чулуу авч шидээд зүүн хөлийг нь онов. Энэ хулганыг шар чицүүл гэдэг ажээ. Зуны цагт шар чицүүлүүд ургамлын ногоон хэсгээр хооллодог. Шар чицүүлүүдийн идсэн ногоон соёонууд энд тэндээ гялгар толбо авчээ. Сүүлэнхүүд хөлөө өвдтөл цохиулсан саяны шар чицүүл Сүүлэнхүүг ямар амьтан болохыг нь тагнаж мэдээд:

- Тэр гайхал чинь хүн биш юм. Жирийн л нэг сүүлээр хийсэн хүүхэлдэй байна гэж даргадаа мэдээлэхэд дарга, шар чицүүлүүдийг түргэн жагсаах тушаал гаргаж,

- За хөдөлцгөөе!. Хоёр цуваа болж жагсаад! Нэгдүгээр цуваа нь зүүн жигүүрээр, хоёрдугаар цуваа нь баруун жигүүрээр хөдөлнө. Заавал амьдаар нь барь! Сүүл ямар амттай байдгийг үзье. Дандаа ногоо идсээр байгаад уйдаж үхлээ гэжээ.

Дарга өөрөө шилдэг таван цэргээр биеэ хамгаалуулаад жуузан дотор суув. Жууз гэдэг нь хоёр шар чицүүлийн нуруун дээр тэгнэн ачсан морин

шарилжны хэдэн бүдүүн иш ажээ. Бүрээч нарыг довтолгооны бүрээ үлээсний дараа таван минут болоход Сүүлэнхүү шар чицүүлийн бүхэл армид бүслэгдсэн байв.

Сүүлэнхүү самбаатай хөдөлж хэсэг шавар ховхолж аваад хэдэн шар чицүүлийг цохин унагаахад бүслэлт сэт үсэрч арми замбараагүй ухарч эхэллээ.

Сүүлэнхүү энэ чөлөөг ашиглаж дараагийн довтолгооноос хамгаалах бэхлэлт яаралтай байгуулж, шавар бөөрөнхийлж хатаагаад шидэх сумнууд хийв.

Тэгтэл шар чицүүлүүд довтолгооноо үргэлжлүүлсэнгүй. Тэд зуур замдаа, тариачдын хаясан, хордуулсан өгөөш идэцгээтэл үхжээ. Харин ногоон соёонуудад “дэвхрэг” гэдэг өөр нэг дайсан бий болов.

Дэвхрэгүүд олон арваараа нисэлдэж, ногоон соёонуудыг идэж сүйтгэснээр барахгүй, Сүүлэнхүүд хүртэл халджээ. Сүүлэнхүү дэвхрэгүүдийг хөөгөөд гүйцэхгүй байв. Энэ үед Сүүлэнхүү шидэт таягаа санаж:

- За гайгүй дэвхрэг та нарыг уу! Надад шидэт таяг байсан цагт гүйцэхдээ л гүйцнэ гэж хэлээд өвөр түрийгээ тэмтрэн үзвэл Шидэт таяг алга болжээ.

- Хайран таяг Санасан газар минь саадгүй хүргэдэг ачтай таяг минь! гэж Сүүлэнхүү гашуудан байхад агрономичийн заавраар дэвхрэгүүдийг устгахаар тариалангийн талбайд онгоц хор шүршиж өнгөрөв.

Сүүлэнхүү онгоцны дуу сонсмогц ухаан алдан унажээ. Сүүлэнхүү хамгаалалтын хувцасгүй болохоор шүршсэн хоронд хордогджээ.

Халуун салхи, цангаагаа гаргав. Юун ой билээ.

Аюулт дэвхрэгнээс салсандаа улаан буудайн ногоон түрүүнүүд баярлалдавч сайн санаат Сүүлэнхүүг хордож унахад харамсан гашуудлаа. Салхины аясыг дагаж найган ганхахдаа дуртай “Ганхалзуур” нэрт нэг улаан буудайн ногоон түрүү мэргэн арга олж:

- Нөхөд өө! Сүүлэнхүүг би амархан сэхээж чадна гэж шуугиан дэгдээв.

- Сэхээвэл ямар сайн бэ? Тэр чинь естой тусч жаал шүү гэж нэг түрүү бөхөлзөв.

- Наадах чийн дэмий юм ярих юм. Агрономич шиг эрдэм чадалтай биш. Яаж чадах вэ. Ямар нэг цуу үг тарааж байна гэж “Ганхалзуур” нэрт өнөө ногоон түрүүтэй саявтархан үндсээрээ газрын гүнээс ус булаацалдсан өөр нэг түрүү цэцэрхэв.

- Ээ, чи намайг юу ч чадахгүй чалчаа амьтан гэж бодно уу. За яахав үзнэ дээ. Бидний түрүүнүүд жинхэнэ улаан буудай болтлоо боловсорч гүйцээгүй байхдаа сүү байдгийг чи мэдэхгүй байх. Энэ сүүнээс Сүүлэнхүүгийн ам руу цутгаж өгвөл сэхнэ гэхэд:

- Тэнэг амьтан! Чам шиг тэнэг манайхны улаан буудайн овгийнхонд байхгүй гэж ус шорооны хаан миний хүндэт өвөг хоёрдугаар буудайныхаа нэрээр тангараглая. Хэн өөрийн биенээс өрөөл бусдад өгч байсан юм бэ? Чиний ухаан шүү юм чинь лооль, шарилжны ухаан болохоос улаан буудайнх биш гэв. Тэгэхэд бусад түрүүнүүд саяны үгийг эрс няцааж:

- Сүүлэнхүүд туслах нь зөв. Тэр бидний төлөө бясааг алж, шар чицүүлтэй тулалдаж, дэвхрэгнүүдийг үзэн ядаж байсан. Чи ёстой хар амиа

бодсон амьтан гэж өнөө улаан буудайн түрүүг тал талаас нь зэмлэж, зарим нь үүнийг улаан буудайн орноос хөөе ч гэж санал гаргав.

Улаан буудайн ногоон түрүүнээс гарсан сүү Сүүлэнхүүг үхлээс аварлаа. Сүүлэнхүү эртний үлгэрийн баатруудын заншлаар:

- Ямар их унтаа вэ? гэсээр босож ирлээ. Түрүүнүүд:

- Чи унтсан биш, дэвхрэгийг устгадаг хоронд хорлогдож ойчсон гэж хэлэв. Энэ үгийг хэлж дуусаагүй байтал баруун өмнө зүгээс хуурай халуун салхи салхилж хээр талын өвс ногоо гандан хур бороо огт орохгүй боллоо.

Чийггүй болсон ой мод хатсан навчаа унжийлган уйтгартай харагдана. Ургамал, амьтныг халуун салхиар түлтэл халааж, сэрүүн амьсгал үл өгөгч аймшигт ган иржээ. Улаан буудайн ногоон түрүүнүүд ундаар дутагдаж өсөж өндийхөө болив. Тэд өдөржин халуун салхины аясаар эцтэлээ найгана.

Сүүлэнхүүгийн ам цангаж арга ядахдаа ногооны газар очиж байцааны гол мэргэ байтал өнөөх байцаа Сүүлэнхүүг дэлбээтэйгээ хамт хумьж орхив. Сүүлэнхүү халуун өдөр толгой дээгүүрээ дээл нөмөрсөн мэт байцааны дотор бүгчимдэж:

- Хүүе, байцаа минь, чи яаж байна аа? Би бүтэж үхлээ гэж дорой дуугаар өгүүлэв.

- Би ч бас хэцүүдлээ. Хамаг ундаагий минь хуурай халуун салхи булааж авлаа. Үлдсэн ундаагаа алдахгүйн тулд дэлбээгээ хумьж хамгаалахаас өөр нөхцөлгүй боллоо гэв.

Тэглээ ч гэсэн дээ. Дэлбээгээ ганцхан минутын хэртэй нээгээч дээ? Би гаръя! гэж Сүүлэнхүү байцаанаас гуйв.

Сүүлэнхүүг байцаанаас гарч ирэхэд халуун нар хурцаар шарж хамаг биеээс нь хөлс дуслууллаа.

Энэ үед шуудуугаар ус урсаж ирээд Сүүлэнхүү тэр лүү харайж ороогүй бол цасан охин шиг хайлж алга болох байв.

Сүүлэнхүү шуудууны уснаас ханатлаа ууж аваад шуудууны хоёр хөвөөгөөр ургасан зурвас ойн сүүдэрт сууж амарлаа. Зурвас ойг хүмүүс тариалангаа хамгаалж тарьжээ. Өөр нэг газарт нартай бороо орж байх ажээ. Тэнгэрт ер үүлгүй цэлмэг байхад бороо ордгийг Сүүлэнхүү амьдралдаа үзээгүй учир сонирхон гүйж хүрвэл эргэлдэх шүршүүрийн цоргонуудаас усан дусал тал тал цийш цацагдаж байв. Цангаж, хатсан газар цацагдсан усыг ховдгоор ууна.

Улаан буудайн түрүү үндсээрээ залгилж, ишээрээ дамжуулан ус ууж цангаагаа гаргалаа. Ингэж хатаж цангасан бүхэн сэргэж, хатингар мангас болох гангийн эзнийг хөөсөнд Сүүлэнхүү баярлав.

Сүүлэнхүү тариан талбайд

Хаагуур нь ч нэвтэрч болмооргүй битүү ширэнгэ ойд орчихсон юм шиг Сүүлэнхүүд санагдана. Энэ сэтгэгдэл Сүүлэнхүүг “Ойгоор явж байгаа биш, улаан буудайн тариалан дундуур явж байгаа юм шүү дээ” гэж зориуд бодуулахад хүргэх аж. Долоодугаар сараас хойш улаан буудайн өнгө шаргалтаж эхлэв.

Нэг өдөр нартай байтал гэнэт их үүл гарч, тэнгэр нижигнэн дуугарч зурвас гэрэл хоромхон гялсхийн, Сүүлэнхүүгийн толгойг үрэл шиг бөөрөнхий мөндөр цохилгов. Сүүлэнхүү өвдөхийн эрхэнд толгойгоо барин газар

шургачиж унав. Улаан буудайнууд энд тэнд орилолдож, зарим нь түрүүгээ даахгүй газарт налан унаж байв. “Тэнгэрийн үүл биднийг бөмбөгдөв” гэж хашхиралдаж байх нь улаан буудайн хэлээр “Мөндөр цохиж байна” гэсэн үг байжээ.

Ширүүн мөндөр өнгөрсний дараа агрономич хүрч ирээд:

- Айхавтар аюул дайрлаа. Тарианы үр мөндөртэй бороонд цохиулж амархан муудна гэж ярихыг сонсоод Сүүлэнхүү тариа хураах цаг ойртжээ гэж ойлголоо. Удалгүй намар болж, комбайнууд тариалангийн талбайд орж ирэв. Комбайны өмнө аварга том сэнс газраар эргэлдэж байв. Сүүлэнхүү:

- Сэнс минь сайн байна уу? гэж мэндлэхэд тэд,

- Хи, хи, хи гэж доогтойгоор инээлдэж,

- Сэнс байна уу? юу байна? Чамд үзүүлье л дээ гэж хэлээд Сүүлэнхүүг хаман авч агшин зуур хурц хутганд ойртууллаа. Тэгээд:

- Одоо биднийг юу гэж нэрлэдгийг ойлгов уу? гэж асуув. Сүүлэнхүү айснаасаа болж царай нь зэвхий цайгаад арай ядан нэг үг дуугарчээ. Сүүлэнхүүгийн чухам юу гэж хэлсэн нь комбайны моторын дуунд сонсогдсонгүй.

Сүүлэнхүү чи болгоомжгүйгээс болж техникийн аюулгүй байдлыг сахиж чадалгүй хар толгойгоо хурц хутганд хяргуулах дөхлөө. Биднийг хамуур гэдэг юм гээд Сүүлэнхүүг эргэлт дундаа комбайны тэвш рүү шидэж орхилоо. Тэнд Сүүлэнхүү хөлөө хугалах буюу ер ямар нэг гэмтэлд учралгүй эсэн мэнд буув. Яагаад гэвэл цайруулсан тарианы дээр шигдтэлээ ойчиж, зөвхөн толгой нь цухуйж байхад шигшүүрээс гөвсөн тариа урсан ирж Сүүлэнхүүг тариан далайд улам бүр живүүлээд улмаар автомашины тэвш рүү урсгачихжээ.

Сүүлэнхүү самбаатай тулдаа авто машины тэвш рүү гоожих үед харайж тэвшийн ирмэгээс барьж аваад тарианд ахин дарагдаж бүтэж үхэхээс аврагдав. Сүүлэнхүү ингэж самгардаж байхдаа сэнс гэж андуурч байсан хамуур нь улаан буудайн шилбийг хутганд ойртуулан хамж, хутга нь улаан буудайг хяргахад түрүү нь комбайны бул руу очиж цайруулагдаад, шигшүүрээс гөвөгдөж тэвш рүү орж байхыг харж амжжээ. Тэвшнээс Сүүлэнхүү улаан буудайтай хамт авто машин дээр буусныг бид мэдэх билээ,

Харин улаан буудайн шилбэ комбайны голоор явж эх газартаа үлдэж байв. Ингээд Сүүлэнхүү авто машинаар тарианы хамт “Гурилын тээрэм” гэсэн хаягтай байшингийн зүг давхижээ.

Гурил

Сүүлэнхүүг гурилын тээрмийн гадаа ирэхэд жигд түжгэнэн дуугарах чимээ сонсогдов. Энэ лав моторын дуу бололтой. Сүүлэнхүү өнөө байшингийн хаалгыг татвал битүү цагаан манан түүнийг угтан авлаа. Манан бол нойтон уур амьсгалтай байхад энд шороон шуурга дэгдсэн мэт бүгчим бөгөөд цагаан тоос хамар амаар орж байх аж. Сүүлэнхүү нэг ажилчны бүх юм нь цагаан тоосонд хучигдсан үзэгдлээ.

Гэнэт тэртээ дээр комбайны тэвш шиг модон хайрцаг харагдав. Сүүлэнхүү тэр хайрцагт улаан буудай бий байх тээд орж очвол нээрээ нэгэн цоорхойгоор улаан буудайнууд гоожиж байв. Доор нь хоёр дугуй чулуу эргэлдэн хоорондоо хавиралдахад улаан буудайнууд няцлагдан нунтаг цагаан

юм болж шуудайлагдахыг Сүүлэнхүү харлаа. Энэ нунтаг цагаан юм бургин агаарт цагаан тоос дэгдээж байгаа юм санжээ.

Сүүлэнхүү модон хайрцагны доод ёроолын улаан буудай гоождог нүхээр саяны явдлыг харсан тул доош унаж, няцлагдахаас үхтлээ айж хайрцагнаас хурдан холдов. “Шуудайлагдсан нунтаг цагаан юм маань гурил байна” гэдгийг Сүүлэнхүү нэг ажилчныг атга гурил аваад,

- Дээд гурил, дээд гурил гэж хоер дахин хэлэхээс мэдэв.

Амттай боов

Сүүлэнхүү намрын салхинд намиран хийсэж байгаа өнгө бүрийн далбаагаар чимэглэсэн гоёмсог асар байхыг харлаа.

Асрын гадаа морин хуур, шударга, хөгжим эгшиглэж, эрэгтэй, эмэгтэй залуус бүжиглэнэ. Үүдэн талд нь нэг тарган авгай инээмсэглэн хоол аягалж байлаа.

Асрын зүүн талын самбарт хөвүүд, охид, цэргүүд, комбайнч, шуудан зөөгч гэх мэт үй олон хүн зогсож, “Ургацын баярт урья” гэсэн том зарлал уншицгаана.

Сүүлэнхүү асарт орж амттан өрсөн ширээний дэргэд очин суув. Тэгтэл тавагнаас нэг боорцог тонгорцоглон өнхөрсөөр Сүүлэнхүүгийн алган дээр унав. Тэр боорцог Сүүлэнхүүд ийнхүү өгүүлсэн нь:

- Намайг таньж байиа уу? Би “Танхалзуур” нэрт улаан буудайны гурилаар хийгдсэн боов шүү дээ. Сүүлэнхүү минь би чамтай уулзана гэж итгэж байсан юм. Чамайг тээрмийн хоёр дугуйны хооронд няцлагдаж үхнэ байх гэж миний айсныг яана. Чи тэгтэл ашгүй огло үсрээд модон тэвшнээс гарчихлаа гэлээ. Тэгэхлээр нь Сүүлэнхүү:

- Тэр үед чи хаа байсан юм бэ? гэж асуув.

- Модон хайрцагны доорх цоорхойгоор тээрмийн чулуун дээр унаж байсан.

- Тэгээд чи хайчсан бэ?

- Би тэнд гурил болоод хэсэг нөхдийн хамт “Чихэр боовны үйлдвэрт” очив. Хагас зарим маань шууд “Хүнсний барааны дэлгүүр” лүү явсан. Чихэр боовны дэлгүүрт бидний нэг хэсэг гурил, шар тос, чихэртэй хольж зуурагдаад тос мэлтгэнэсэн тогоонд шаржигнатал чанагдаж боорцог биеийг оллоо. Зарим маань пийшинд жигнэгдэж талх ч боллоо гэж “Танхалзуур” нэрт улаан буудайн гурилаар хийгдсэн боорцог баяртай хэлэв.

Хөгжмийн эгшиг улам нүргэлэн цуурайтаж эрэгтэй, эмэгтэй олон залуус Монгол үндэсний тойрон бүжиг бүжиглэнэ. Тэдний дотор алтан тариагаар өвч биеэ чимэглэсэн хүн олон байлаа.

Арвин ургац аваад,

Амттай боов хийлээ

Ургацын баяр хөгжилтэй

Улс орон минь жаргалтай гэдэг дуу Сүүлэнхүүд анхандаа улам тод сонсогдож байснаа алгуур намдан тэртээ алсад цуурайтах шиг болон чихэнд нь хоногшиж үлдлээ.

Гэрт, цагны чаг чаг цохихоос өөр анир чимээгүй бөгөөд Сүүлэнхүүг алга болсны маргааш Борхүү хичээлээсээ тарж ирээд түүнийг шөнө болтол

эцэж ядартлаа эрсэн учир гэрийн даалгавраа хийж байгаад нойрондоо дийлдэж номоо дэрлэн хурхирч байх ажээ.

“Ургацын баяр”-аас Сүүлэнхүү хэдийд буцаж ирсэн, түүний замд адал явдал тохиолдсоныг хэн мэдэх вэ? Сүүлэнхүү гэртээ ирэхэд лав өнөө цас мөсний өвгөн тусалсан биз.

Харин Сүүлэнхүү маань асар их тэсвэр гаргаж “Боов яаж төрөв” үлгэрийн гол баатар болж тоглосон тухай та нар уншлаа. Үүгээр Сүүлэнхүүгийн түүх дуусаагүй.

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураингуйлан бичнэ үү?
2. Сүүлэнхүүгийн дүрийг онцлогийг тайлбарлан бичнэ үү?
3. Сүүлэнхүү цуврал үлгэрийн танин мэдэхүйн ач холбогдлыг зохиолын жишээн дээр тайлбарлана уу?
4. Сүүлэнхүү цуврал үлгэрийг гүйцээж уншаад товч агуулгыг бичнэ үү?

Хар үрээ, саарал чоно, хундан төлөг, жаалхүү дөрвийн тууж

3. Түмэнжаргал

Оршил

Яасан хэцүү юм бэ дээ? Хүн байна гэдэг чинь шал дэмий юм. Яах гэж би хүн болж төрөв дөө... гэж бодохоос Жаалхүүгийн гол харлана. Ээж “Чи чинь ямар мал шиг хүүхэд вэ? Хүний үг авна гэж ер байхгүй. Амьтны хүүхэд хичээл номдоо сайн сурч эцэг эхээ баярлуулаад л, гэрийнхээ ажил төрөлд нэмэр болоод л, хэл үг удаж чихнээс хонх уяхгүй сайхан байх юм. Манай энэ л гэж яачихсан хүн бэ? Нүүр царайных нь байж байгааг хараач. Газар доороос гараад ирсэн юм шиг... Хаалгаар шагайж, цүнхтэй номоо чулуудчихаад л бараа сураггүй арилаад өгнө. Ёстой нэг тэнгэр нь хаясан хүүхэд” гэж баахан яншлаа.

Хичээл дээр ангийн багш бас зөндөө зэмлэсэн. “Ганцхан чиний чихийг бөглөж байгаад би хичээл заагаа юу?” ч... гэх шиг. Бас цэцэрлэгч авгай юу гэлээ? “Энэ олон зуун хүүхдийн бүгдийнх нь гутлын шавхай нийлээд ганцхан чинийхэд хүрэхгүй. Дэндүү заваан жаал юм...” гэж загнасан.

Айлын хүүхдүүд зүгээр л инээд алдаад гүйж ямах юм. Яасан сайхан юм бэ? Би л гэж дайралдсан болгонд нүд үзүүрлэгдэж явах... Эмээгээс ондоо өмөөрөх хүн ч байх биш. Яах ч гэж хүн болж төрөв дөө? Тэрний оронд нэг сайхан морь болоод төрчихгүй. Хэрэв би морь болж төрсөн бол хэн ч намайг хичээл давтсангүй, гэрийн бараа харсангүй, шавхай чирлээ, энээ тэрээ гэж үглэхгүй сэн.

Ер нь ингэж байхаар гэв гэнэтхэн л морь болчих юм сан гэж бодов.

Нэг

Яг тэгж бодтол...

Яг тэгж бодтол жаалхүү морь болчхов. Үнэхээр морь шүү.

... Жавхалзсан сайхан хар үрээ болчихоод явж байхад нь хэн ч түүн рүү “Хүүе, сургуульдаа орооч. Бас л хожимдчихлоо” гэж хашхирсангүй.

Өдөржингөө тэнэлээ. Ганцхан гэм нь хүүхдүүд шиг бөмбөг өшиглөж тоглохгүй нь... Гэвч тэр морь байрныхаа хүүхдүүдийн тоглохыг харж баахан зогслоо. Өөрийнхөө багийг хожигддогийн даваан дээр л бөмбөгийг нь булааж

аваад нөгөө талын хаалга руу хурдалчихмаар санагдаад болдоггүй. Гэвч морь хэзээ л хүүхдүүдтэй бөмбөг өшиглөж байлаа даа?

Тэгж байтал ээж нь тэнд хүрээд ирэв. Морь ч үхтлээ айлаа. “Одоо харь! Аяга шаазан угаа. Хог шүүрд...” гэх байх даа гэж зүрхшээн бодтол дэргэдүүр нь ажигч үгүй өнгөрөөд явчхав.

Одоо тэр жаалхүү биш морь юм чинь.

... Орой болохын алдад нөгөө хар үрээг нэг өвгөн барьж аваад явлаа.

Санаандгүй байтал шүү. Мэдсэн бол тэр баригдахгүй хулжчих байсан юм. Гэтэл одоо хазаарлуулаад хөтлүүлж явна. Өвгөн хашаанд орж өвс тавьж өгч байна. Өвсийг үнэрлэхээс өөр яах билээ? Харин ус нь зүгээр юм. Морийг түүхий усуулаа, хоолой чинь өвдөнө гэж загнахгүй нь сайхан.

Гэтэл маргааш нь хэрэг биш болов.

Хар үрээг тэргэнд хөллөлөө.

Өнөөх өвгөн тэрэгний арал дээр сандайлаад урт сураар шар хийтэл ороолгож байна.

Хэцүү шүү. Тэгээд өдөржин түлээ зөөлөө. Сүүлдээ ч бүр эцэж цуцахын туйлыг үзлээ. Хашигнахаар ташуурдана.

Морийг тэгэлгүй ч яахав дээ.

Орой, бүр ч аймаар юм болов.

Түүний уруулыг цоровдон боож байгаад хөлд нь тах хадав.

Яг ул руу нь хадаас шаана гэдэг аймар биз? Хар үрээ зөндөө уйллаа. Жаалхүү чигээрээ байсан бол ч орилоод, гуйгаад хэлэх сэн. Даанч морь болчихсон болохоор яахав дээ. Ямар ярьж чадах биш.

Тэгээд зогсоогүй ээ. Бас час улайтгасан төмөр тамгаар ташаан дээр нь хэншүү хярвас ханхлуулан дарлаа. Ямар аймар гэж санана...

Хүн байх ч хэцүү юм. Морь байх бүр ч хэцүү юм. Яая даа? Яасан азгүй юм бэ? Ингэж байхын оронд чоно... Нээрэн чоно болсон бол хамаагүй дээр. Яршиг зүгээр чоно болчих юм сан...

Хоёр

Яг тэгж бодтол...

Яг тэгж бодтол, хар үрээ биш чоно болчхов. Сэрвээ нь боссон зэгзгэр саарал чоно болчихоод уул талаар явж байхад хэн ч түүнийг энээ тэрээ гэсэнгүй...

Барьж авч хазаарласангүй. Уясангүй. Тэргэнд хөллөсөнгүй. Бас хөлд нь тах хадсангүй. Ташаан дээр нь тамга дарсангүй.

Ой тайгаар өдөржин тэнэлээ. Харин хот орж хүүхдийн паркаар явж болдоггүй нь гонсоймоор. Гэлээ ч яахав. Яг явсаар нэг их бөөн моносон дотор орчихлоо. Бөнжгөнөсөн хар хар мойл багсайгаад даанч гоё. Мойлыг амаараа шувт шувт татан идлээ. Гар байхгүй юм чинь.

Гэдсээ дүүртэл идээд модны захад гарав. Гэтэл... гэтэл яасан гэж бодно оо.

Чихнийх нь хажуугаар сум шунгинан өнгөрөв. Яана аа? Хар эрчээрээ зугтлаа. Гэтэл өмнөөс нь хоёр улаан халтар нохой дүүлэн айсуй. Эзэн нь ард нь алаг морьтой давхиж харагдана. Хартал тэр алаг морьтой хүн жаалхүүгийн өөрийнх нь өвөө байлаа. Тэр өвөөгөө таниад гүйгээд очмоор санагдсан ч чоно болчихсон юм чинь яах билээ дээ. Яаж ойлгуулах билээ дээ? Буцаад зугтлаа.

Балар ширэнгэн дундуур бултаж арай гэж амь мултрав.
Өлсөж байгаа гэж хачин. Нэгэн хадны харанхуй хонгилд орж хэвтээд тэр юм бодлоо. Чоно байх ч, хүн байх ч, аль аль нь шал дэмий юм. Ялангуяа чоно байна гэдэг бүр ч зовлонтой юм. Яасан азгүй юм бэ. Би юу болох вэ? Хорвоод хамгийн жаргалтай амьтан юу вэ?

Хашаа хотондоо амар хэвтээд л хивж байдаг хонь ч сайхан юм уу даа? Ер нь хонь болбол дээр байх. Хонь л болчих юм сан.

Гурав

Яг тэгж бодтол...

Яг тэгж бодтол саарал чоно биш махир эвэртэй хундан төлөг болчхов. Бөмбийсөн хөөрхөн хундан төлөг болоход нохой ч хөөсөнгүй. Бууны сум ч шунгинасангүй. Хүн биш, морь биш, чоно биш, хонь юм чинь ёстой л сайхан байна. Шөнө хашаанд хэвтэнэ. Өдөр бэлчинэ. Ус ууна. Хааяа гэрийн боорцог моорцогхон олоод идчихнэ. Харин компьютерээр тоглож, бөмбөг өшиглөж, уул руу самарт явж болохгүй нь хэцүү. Овоо аятайхан байж байтал бас л нэг өдөр болохоо болив. Ойрхон газар бэлчээгээд л орой нь аваачаад хашчихдаг хоньчин өвгөн тэр өдөр бүр хол туугаад явчихлаа. Эцэж туйлдтал туув. “Энэ одоо хашаа аваачих гэж ийм хол туугаад байна аа? Ямар балай юм бэ. “ гэж төлөг бодов. Бусад муу сайн хонинууд юу ч болоогүй юм шиг л явах юм. Урьд нь хүн байж үзээгүй болоод тэр дээ гэж бас бодов. Яваад л байлаа, яваад л байлаа. Тэгсэн чинь харин мах комбинат дээр ирдэг юм байна. Мах комбинатын сараалжин хашаа руу түрүүчийг нь оруулж эхэллээ. Хонинууд үхэх гэж байгаагаа мэдэхгүй тэнэг царайлаад л дув дуугүй ороод байна. Эргэж зугтаая гэтэл ямар ч арга алга. Одоо би хүн ч биш, морь ч биш, чоно ч биш, хонь ч биш элэгний нухаш юм уу, аяны зууш болно. Яана аа. Лаазлуулаад дэлгүүрт очно. Өнгөрлөө. . ? Ээж ээ, аав аа? Намайг аваач? гэж хашхирмаар. Гэтэл хонь юм чинь яах билээ? Жаахан хундан төлөг мах комбинатын хаалганд ойртсоор л... Баларлаа, баларлаа. “Хүн болох юм сан... Хамаагүй ээ бүр муу, тэнэг ч хамаагүй хүн болох юм сан... “ гэж бодно. Болдоггүй шүү. Хүн болдоггүй...

Морь больё, чоно больё, хонь больё гэхэд тэр дорхноо л, бодмогц болоод байсан. Гэтэл яг хүн больё гэхээр болдоггүй. Яасан заяагүй юм бэ? Заяа нь хая даа? Би хүн чигээрээ байж л байхгүй яав аа? Яана аа? гэж цухалдав. Хонинуудаас сугараад үлдчих санаатай хоцортол шилбүүр тасхийлээ. Хашаа руу орлоо.

Ингээд дууслаа...

Хундан төлөг нулимс цувуулан уйллаа. Хашаагаар оронгуут... Ура. Яасан их аз вэ? Өвдөг нь цоорхой жийнсэн өмдтэй, халтар нүүртэй сөөсийсөн жаал болоод хувирчих нь тэр ээ.

Хагартлаа баярлаад толгой өргөн харвал түрүүчийн шилбүүрдээд байсан хоньчин өвгөн гэнэт түүнийг олж үзээд,

-Хүүе, чи энд юу хийж яваа юм бэ? гэртээ харь, миний хүү. Энэ муухай шавхай дотор яаж яваа юм бэ? гар, гар гэлээ.

Төгсгөл

Бөөн баяр. Үхээд боссон хүн л ингэж баярлах байх даа. Жаалхүү ганц ухасхийгээд хашаа даваад гүйчихлээ. Тэр “Хүн байх яасан сайхан юм бэ? Хүн бүхнийг дийлдэг. Хүн болж төрнө гэдэг ямар их аз вэ? Би хичээл номоо сайн давтаад, аав ээжийнхээ үгэнд ороод байхад зэмлүүлэх ч үгүй шүү дээ. Зэмлүүлсэн ч яахав. Одоо ёстой жинхэнэ сайн хүн болно. Аав аа, ээж ээ, багш аа, цэвэрлэгч эгч ээ? Та нар намайг хараарай гэж баярлан бодлоо.”

Тэгээд ижий аавдаа очихоор хар эрчээрээ гүйн одов.

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураангуйлж бинэ үү?
2. Туурвил зүйн онцлогийг тодорхойлно уу?
3. Зохиолын дүр, дүрслэлийн онцлогийг жишээгээр тайлбарлана уу?
4. Зохиолд дүр нэмж, үйл явдлыг үргэлжлүүлэн бичнэ үү?

Ёгт үлгэрүүд

Д. Давааням

Бодол

Хулгана амбаар дотор тэнэж яваад занга болгож тавьсан түмпэнд хөмрөгдөв. Тас харанхуй дотор аймшигтайгаас гадна гарах үүд эрээд олоогүй ажээ. Түмпэнг хэчнээн мэрг үзээд ашиг байсангүй цөхрөв. Хэсэг зуур чимээгүйхэн суусанаа:

- Муужгайнаас айлтгүй харин ч зүгээр юмуу даа гэж боджээ.

Зөндөө их чихэр

Нэгэн өдөр баавгай томоо гэгчийн мөсөн чихэр олоод, амсаж үзсэнээ дахин юу магад. Амьтан хүнээс өрсөөд олоод авъя гээд цааш нь эрж гарчээ. Бүрий болтол гүйгээд юу ч олсонгүй бүр ядарч хоцороод, газар шагайн урамгүй буцаж явтал дүй муутай гар нь барьж явсан чихэрээ чулуун дээр алдчихжээ. Харин баавгай учиргүй баярлан:

- Юутай их аз вэ? Зөндөө их чихэртэй боллоо! гэж ой тайгыг нижгэнэтэл хүрхэрж нөгөө бяцарч унасан чихрээ түүж аван, цааш одов гэнэ.

Хөрөг

Сүүлгүй хулгана, муужгайтай зургаа хамт авхуулсан тухай сонин яриа амьтдын дунд тарав. Тэр зоригт хулганатай уулзсан бүхэн:

- Та муужгайтай хамт зургаа авхуулахдаа айгаагүй юм уу? гэхэд

- “Ерөөсөө айгаагүй. Ер бусын явдал ганц надад тохиолдож байгаад би баяртай байна” хэмээн омог бардам хариулдаг болжээ. Сүүлгүй хулганыг амьтан бүхэн зоригтод тооцох болов. Хулгана, муужгай хоёрын зургийг татсан согоо:

- Сүүлгүй хулгана муужгайн том хөрөгний дэргэд зургаа авахуулснаас биш муужгайтай хамт авхуулаагүй гэж ярьсанаас хойш хулганы эр зоригийг магтсан яриа нам гүм болжээ.

Маргаан

Ойн цоорхойд амьтад цуглаж “Хэний хошуу ашигтай вэ?” гэж маргалдав. Энэ маргаанд тэмээ, гахай, тогоруу, илжиг оролцжээ. Гахай:

- Тэмээний хошуу яасан болхи юм бэ? бас сэтэрхийг нь яана гэв. Тэмээ:
- Гахайн хошуу хамгийн болхи шүү дээ. Түүнийгээ мэдэхгүй хэвтэж... гэлээ. Илжиг:

- Тэр яахав. Тогорууны хошуу ямар хэрэгтэй юм бэ? Би ийм хошуутай бол ичиж үхнээ гэв. Тогоруу:

- Илжиг чамд хошуу гэхээр юм юу байгаа юм бэ? Тийм болохоороо атаархаж байна гэв. Эдний маргааныг хэрэм сонсоод:

- Юунд дэмий маргана вэ? Та нарын хошуу өөр өөрсдөдөө ашигтайгаар зохицсон шүү дээ гэж маргааныг таслав.

Замд тааралдсан хоёр

Хулгана амьсгаадан харайлгаж явтал майга хөлт тааралдав.

- За хулгана минь юунд ингэглээ сандраа вэ? гэж баавгай сонирхов.
- Цаана чинь аюултай дайсан ирж явна. Би одоо хаачих билээ. Та намайг хамгаалж үз! хулгана чичрэв.

- Тэр ирж яваа чинь тийм аюултай юм уу? гэж баавгай гайхав.
- Аюултайгаар барах уу! Амь насанд хүрч мэднээ гэж хулгана учирлав.
- Тийм дайсанаас чамайг бүү хэл өөрийгөө яаж хамгаалах вэ? гэж баавгай хүрхрэв.

- Майга минь тэгвэл эртхэн зугтахыг бод! Би явлаа гэж хулгана хэлэв.
Хамт явъя гэж баавгай гуйв. Хулгана, баавгай хоёр дайсанаас хүч мэдэн зугтав.

Орой болохын хэрд горхины дэргэд ирцгээв. Маш их ядарсанаас болж, баавгай хөл дээрээ арай ядан зогсохдоо.

- Бид ямар дайсанаас зугтаж байгаа юм бэ? гэж сэхээрэн асуув.
- Муужгайнаас гэж хулгана бөөрөө түнхэлзүүлэв. Баавгай учрыг нь анх олоогүйдээ гасалж, намайг амьтад муужгайнаас айсан гэж шоолох бий гэхээс уур хүрч дэргэдэх хулганаа дэвсэх гэснээ энэ мууд ямар буруу байх билээ гэж ухаарчээ.

Жодоо

Салхи үлээнэ. Их ойн гүнд хар мод, хус, хуш, нарс, царс, жодоо эгнэн ургажээ. Ой шуугихыг чагнавал:

- Би хамгийн өндөр ургадаг шүү дээ гэж моднууд өөр хоорондоо маргалдах ажээ. Харин Жодоо л огт дуугүй байлаа.

- Яагаад жодоо энэ маргаанд оролцохгүй байна вэ? гэж Бөжинг асуухад эх туулай нь:

- Жодоо чинь ой дотроо хамгийн өндөр нь билээ. Их мөрөн дөлгөөн гэдэг үгний учир энэ дээ гэв.

Үндэс

Тэр өдөр үндэс өөрийн учир зовлонгоо гарган:

- Мөчир минь чи туслаач... Би тун их ядарч байна. Эзэнд хэлж услуулаач тэхгүй бол хатаж үхлээ гэв. Мөчир огт тоосонгүй өнгөрчээ. Удсан ч үгүй үндэс үхэв. Мөчир ч бас амь хэлтэрээгүй ажээ.

Эвэргүй үхэр

Хот айлынхан хургаа гүүргийлэн хашиж нэг гэртээ цугларчээ. Нанзад өвөө гэрийн хоймор сууж тулганд дүрэлзэх галаас тамхиа асааж аваад үлгэрээ эхлэв.

- Энэ дэлхийн тэртээ өнцөгт нэгэн эвэргүй үхэр байж гэнээ. Мөргөх эвэргүй учир мөчөөрөхсөн бүхэнд дээрэлхүүлдэг байжээ. Тэгээд нэгэн удаа алаг бяруунд арьсаа хэгз мөргүүлчхээд ингэж хэн нэгний зугаа болж байхаар боож үхье гэж шийдэв. Учрыг мэдсэн Сэрх түүнд хандаж:

- Чи юунд нь ингэтлээ бухамдана вэ? Чамд хосгүй ховорхон эвэр бий шүү дээ гэжээ. Мухар үхэр гайхасхийн:

- Надад эвэр бий гэж үү?

- Чамд хосгүй сайхан эрдэм гэж эвэр бий. Ийм агуу эрдэм ном сурсан байж юундаа бухимдана вэ? гэж Сэрх үнэн сэтгэлээсээ хэлжээ.

Ойн чөлөөнд

Аяс намуун дэлгэр сайхан цаг. Хөх уулын их ойн чөлөөнд аньс, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ, нохойн хошуу, мойл, нэрс, хад, үхрийн нүд, цангис, чацаргана жимснүүд цуглаад:

- Би амттай... би л амттай гэж ам амандаа шуугилдав. Говийн хармаг дув дуугүй сууж байсанаа:

- Бид амттай гэж бахархан хэллээ. Энэ үгээ говийн хармаг дахин давтан хэлээсэй гэх шиг ой тайга чимээгүй дунд налайж байлаа.

Хус, гол хоёр

Гантай зуны халуунаар халгих голын ус маш их татарч, зарим газраа урсгал нь тасарчээ. Эргийн хажууд хус мөчрөө хөдөлгөн:

- Бороо орохгүй бол гол чи ширгэхнээ гэж шүүрс алдав. Хөгжилтэйхэн гол газрын үндэс хаван:

- Эх нутгийнхаа хөрсөнд шингэхэд гомдох юм алга даа гэж түүний дуу бүдгэрэв.

Асуулт, даалгавар:

1. Зохиолчийн намтар, уран бүтээлийг хураингуйлан бичнэ үү?
2. Үлгэр тус бүрийн агуулга, үзэл санаа, дүр дүрслэлийн онцлогийг бичнэ үү?
3. Эдгээр үлгэрүүдээс санаа авч үлгэр зохион бичнэ үү?
4. Уран зохиолын дүрслэх ба яруу хэрэглүүрийн хэрэглээний талаар жишээ татан тайлбарлаарай.

Гарчиг

I бүлэг. Монголын эртний уран зохиол

1. “Алун гуа эхийн домог”
2. “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний цэцэлсэн шастир”
3. “Чингисийн эр хоёр загалын тууж оршив”
4. “Оюун түлхүүр”
5. “Чингисийн билиг сургаал”
6. “Мандухай цэцэн хатны домог”
7. “Хув Нагваралын тууж”
8. “Монголын Убаши хун тайжийн тууж”
9. “Цогт тайжийн хадны бичиг”
10. Д.Равжаа “Цагийн жамын тодруулагч Цаасан шувууны сургаал”

II бүлэг. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол

Яруу найраг

1. Д.Нацагдорж “Миний ээж”
“Хэнз хурга”
2. Д.Содномдорж “Жигмэд, Тогмид хоёр”
“Норовын намтар”
3. Ж.Дашдондог “Аав”
“Ээж”
“Би”
“Аранзал зээрд”
4. Д.Батжаргал “Хаан хуруу”
5. Ч.Лхамсүрэн “Хүрэн морь”
6. С.Дашдооров “Дайны жилийн алим буюу сургуулийн зээрд”

III бүлэг. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол

Уран сайхны болон танин мэдэхүйн өгүүллэгүүд

1. С.Буяннэмэх “Бор бор болжмор”
2. П.Хорлоо “Алт, Мөнгө хоёр”
3. Д.Цэвэгмид “Хос тогоруу”
4. Ц.Уламбаяр “Номын сангийн ном”
5. З.Түмэнжаргал “Голын жараахай”
6. С.Надмид “Бордоотой бороо”
7. О.Сундуй “Шарга даага”
8. Н.Мандал “Хүн чанарын инээд”

IV бүлэг. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол

Уран сайхны болон баримтат тууж

1. Л.Түдэв “Хорвоотой танилцсан түүх”
2. Д.Гармаа “Зудын жил”
3. Ц.Уламбаяр “Энх тайвны манаа”
4. Ш.Гаадамба “Багын явдал”

5. П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг буюу борзооны явдал”
6. Ч.Лодойдамба “Манай сургуулийнхан”

V бүлэг. Монголын орчин үеийн хүүхдийн уран зохиол
Орчин үеийн үлгэрүүд

1. Ц.Дамдинсүрэн “Өчүүхэн дөрвөн үлгэр”
2. Л.Бадарч “Унага”
3. Д.Даржаа “Хамгийн хэцүү нь юу вэ?”
4. Ч.Арьяасүрэн “Сүүлэнхүүд тохиолдсон адал явдал”
5. З.Түмэнжаргал “Хар үрээ, саарал чоно, хундан төлөг, жаалхүү дөрвийн тууж”
6. Д.Давааням “Ёгт үлгэрүүд”